



ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүл

Цуврал 4 (90)

Улаанбаатар хот  
2022 он

Сэтгүүлд нийтэлсэн бүтээл нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх Сэтгүүлийн редакц болон зохиогчид хадгалагдана.

Эх бэлтгэгч, дизайнер: З.Эрдэнэтөгс

Хэвлэсэн газар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хэвлэх үйлдвэр

Улсын бүртгэлийн дугаар: 279  
ISSN:2226-9185  
Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс  
эрхлэн гаргав. Жилд 5 дугаар гарна.

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,  
4 дүгээр хороо, Бага тойруу /15160/,  
Хуульчдын гудамж 1,  
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр  
Утас: +(976)-11-315735  
Факс: 315735  
Вэб хуудас: [www.nli.gov.mn](http://www.nli.gov.mn)  
Цахим хаяг: [lawjournal@legalinstitute.mn](mailto:lawjournal@legalinstitute.mn)

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

- Ерөнхий эрхлэгч:** **Х.Эрдэм-Ундрах** Хууль зүйн ухааны доктор (*Dr.jur.*),  
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
- Эрхлэгч:** **С.Сүхбаатар** Хууль зүйн ухааны доктор (*LL.D.*),  
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга
- Гишүүд:** **С.Нарангэрэл** Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (*Sc.D.*),  
МУИС-ийн эмерит профессор
- Ц.Сарантуяа** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (*Sc.D.*),  
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор
- Д.Зүмбэрэлхам** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), профессор,  
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга
- Сарпеков Р.К.** БНКаЗУ-ын Хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн  
хүрээлэнгийн захирал, БНКаЗУ-ын Гавьяат ажилтан
- Анна Тумурова** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), ОХУ-ын Буриадын  
Улсын их сургуулийн Төр, эрх зүйн онол, түүхийн тэнхимийн профессор
- Пак Жеон Вон** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), БНСУ-ын Кукмины  
их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор
- Том Гинсбург** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), АНУ-ын  
Чикагогийн их сургуулийн профессор
- Ж.Эрхэсхулан** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), дэд профессор,  
МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- Д.Сүнжид** Хууль зүйн ухааны доктор (*Dr.jur.*), дэд профессор  
Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн.
- Накамура Масаки** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), Япон Улсын  
Нагоягийн их сургуулийн Эдийн засгийн сургуулийн дэд профессор
- Ц.Цогт** Хууль зүйн ухааны доктор (*LL.D.*), Улсын дээд шүүхийн шүүгч
- М.Уянга** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), МУИС-ийн ХЗС-ийн  
Эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор
- Б.Улаанбаатар** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), дэд профессор,  
МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- Ц.Давхарбаяр** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), дэд профессор,  
Шүүхийн сахилгын хорооны гишүүн
- Хариуцлагатай нарийн  
бичгийн дарга:** **А.Намуунаа** Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн  
Эрдэм шинжилгээний ажилтан

## EDITORIAL BOARD

### EDITOR-IN-CHIEF

Khurelbaatar **ERDEM-UNDRAKH**

*Doctor of Jurisprudence (Dr.jur.), Director,  
The National Legal Institute of Mongolia*

### MANAGING EDITOR

Sumiya **SUKHBAATAR**

*Doctor of law (LL.D.), Academic Secretary,  
The National Legal Institute of Mongolia*

### MEMBERS

Sodovsuren **NARANGEREL**

*Academician, Science doctor of law (Sc.D.),  
Emeritus Professor, National University of Mongolia*

Tserenbaltav **SARANTUYA**

*Science doctor of law (Sc.D.), Professor,  
School of Law, National University of Mongolia*

Dorjdamba **ZUMBERELLKHAM**

*Doctor of law (Ph.D.), Chairman, The Judicial  
General Council of Mongolia*

Ramazan Kumarbekovich **SARPEKOV**

*Doctor of law (Ph.D.), Director, The Institute of  
Legislation and Legal Information,  
Republic of Kazakhstan*

Anna **TUMUROVA**

*Doctor of law (Ph.D.), Professor, Buryat State  
University, Russian Federation*

Park **JEON WONG**

*Doctor of law (Ph.D.), Professor, College of Law,  
Kookmin University, Republic of Korea*

Tom **GINSBURG**

*Doctor of law (Ph.D.), Professor,  
The University of Chicago, USA*

Jambaajultem **ERKHESKHULAN**

*Doctor of law (Ph.D.), Head of the Public  
Law Department, School of Law,  
National University of Mongolia*

Dugar **SUNJID**

*Doctor of Jurisprudence (Dr.jur.), Member, The  
National Human Rights Commission of Mongolia*

Masaki **NAKAMURA**

*Doctor of law (Ph.D.), Professor,  
Nagoya University of Economics, Japan*

Tsend **TSOGT**

*Doctor of law (LL.D.), Justice,  
The Supreme Court of Mongolia*

Myagmar **UYANGA**

*Doctor of law (Ph.D.), Academic Secretary, School of  
Law, National University of Mongolia*

Byambajav **ULAANBAATAR**

*Doctor of law (Ph.D.), Head of the Private Law  
Department, School of Law, National University of  
Mongolia*

Tseveensuren **DAVKHARBAYAR**

*Doctor of Law (Ph.D.), Member, The Judicial  
Disciplinary Committee of Mongolia*

### STAFF

Amarsanaa **NAMUUNAA**

*Researcher, The National Legal Institute of Mongolia*

State Registration Number:279  
ISSN: 2226-9185  
The National Legal Institute publishes  
Mongolian Journal of Law five times  
per year.

Address: 4th Khoroo, Chingeltei District,  
Lawyer's Street-1, Ulaanbaatar-15160, Mongolia  
Phone:+(976)-11-315735  
Fax: 315735  
Website: [www.nli.gov.mn](http://www.nli.gov.mn)  
E-mail: [lawjournal@legalinstitute.mn](mailto:lawjournal@legalinstitute.mn)

# АГУУЛГА

## ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

**Дэлхий дахины эрүүгийн процессын тогтолцооны харьцуулалт, хэв маяг, онцлог**  
*Монгол Улсын Гавьяат багш, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн зөвлөх профессор Д.Баярсайхан*

**Шүүхийн шийдвэрт хуулийн төсөөтэй хэрэглэх, хэм хэмжээг зорилгын дагуу тайлбарлах арагчлалыг хэрэглэх нь**  
*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, Хууль зүйн ухааны доктор Б.Тэмүүлэн*

**Хөрөнгө оруулалтыг тодорхойлох нь**  
*Арбитрч, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант Т.Алтангэрэл*

**Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, түүний түүхэн хөгжил, ардчилсан нийгэмд гүйцэтгэж буй үүрэг**  
*Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэгийн судлаач, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант Д.Оросоо*

**Арилжааны эрх зүйн антропологи: Хууль зүйн нэр томъёоны асуудал**  
*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн докторант, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант С.Номынбаясгалан*

**Яагаад яаралтай арбитрч Монголд хэрэгтэй вэ?**  
*БНТУ-ын Энергийн маргааны арбитрын Япон улс дахь төлөөлөгч, Нагояа их сургуулийн Хууль зүйн сургуулийн докторант М.Мөнхнаран*

**Худалдааны арбитр lex mercatoria-г хэрэглэх нь: Онолын зарим асуудал**  
*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирлын туслах М.Нямжаргал*

**Улсын дээд шүүхийн эрх зүйн хөгжилд үр нөлөө бүхий шийдвэр гаргах чиг үүрэг ба түүний учир холбогдол, үндсэн хуулийн үзэл баримтлал**  
*Судлаач Р.Оюундэлгэр*

## ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

**Прокурорын даалгаврын хууль зүйн ач холбогдол, мөн чанар, төрөл, хэлбэр, онцлог**  
*Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль зүйн магистр Т. Батсүх*

**Монголын олон улсын арбитрын гадаад гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, дотоодын аж ахуйн нэгжийн маргаан шийдвэрлүүлэх эрхийг хангах арга зам**  
*“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хуульч, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант Б.Дэлгэржаргал*

**Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаах зохицуулалт**  
*Өмгөөллийн Эм Жэй Эл Адторнейс ХХН-ийн гишүүн, өмгөөлөгч, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант Б.Эрдэнэмөнх*

**Өмгөөлөгчдийн холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэлдэхүүний талаарх тулгамдсан асуудал**

*Хууль зүйн үндэсний хүрээлэгийн Эрдэм шинжилгээний ажилтан, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант С.Мягмарсүрэн*

**2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт ба Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн зохицуулалт**

*ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант Р.Хатансайхан*

**ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ , ҮР ДҮН**

**Цэргийн анги, байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлд хийсэн дүн шинжилгээ (эрүүгийн хэрэг, баримтын шинжилгээ)**

*Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор, Хууль зүйн ухааны доктор Ц.Мөнхбат*

*Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор, ДХИС-ийн докторант Д.Нямбат*

**Үл хөдлөх эд хөрөнгийг давхар худалдсан тохиолдлын талаар эргэцүүлэх нь: Шүүхийн практик ба харьцуулсан судалгаа**

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн магистр Р.Пүрэвбаатар*

**Монгол Улс ба ХБНГУ, Япон улс, Тайвань орны насанд хүрсэн этгээдийн асран хамгаалах тогтолцооны талаарх харьцуулсан судалгаа**

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант Б.Бөхөө*

**Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал кримнологи асуудал**

*ДХИС-ийн Эрх зүйн нийгмийн ухааны сургуулийн магистрант Р.Жамбалсүрэн*

**Nullum crimen sine lege зарчмын Эрүүгийн хуульд тусгагдсан байдал, шүүхийн практик: харьцуулсан судалгаа**

*Улсын дээд шүүхийн дэргэдэх ШССМХ-ийн Эрүүгийн эрх зүйн секторын судлаач Б.Батбаяр*

**МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ**

Шинэ бүтээлийн танилцуулга

# CONTENT

---

---

## LEGAL THINKING: VIEWS AND REFLECTIONS

### **A Global Comparison of Criminal Justice Systems: Main Types and Features**

*D.Bayarsaikhan, Ph.D., Professor at the Public Law Department, School of Law, NUM*

### **The Use of Analogies and Purposive Interpretation Methods in Deciding Cases**

*B.Temuulen, Ph.D., Associate professor at the Private Law Department of School of Law, NUM*

### **The Definition of Investment**

*T.Altangerel, Arbitrator, Ph.D. candidate of School of Law, NUM*

### **The Right to Freedom of Speech or Expression: Its History and Role in a Democratic Society**

*D.Orosoo, Legal Information and Research Activities Society researcher, Ph.D. candidate of School of Law, NUM*

### **Anthropology of Commercial Law: Terminological Issues**

*S.Nomynbayasgalan, Ph.D. candidate at the National University of Mongolia*

### **Why Mongolia Needs Emergency Arbitrators?**

*M.Munkhnaran, Regional Representative for Japan at Energy Disputes Arbitration Center Turkey, Ph.D. candidate of School of Law, Nagoya University*

### **Application of Lex Mercatoria in Commercial Arbitration: Some Theoretical Issues**

*M.Nyamjargal, Assistant of the dean of School of Law, NUM*

### **The Supreme Court's Function to Adjudicate with Consequences for Legal Development: Its Significance and Constitutional Origins**

*R.Oyundelger, Researcher*

## IMPLEMENTATION AND EFFICIENCY OF LAW

### **The Significance, Nature, Types, Forms, and Features of Prosecutorial Instructions**

*T.Batsukh, LL.M., Chief Prosecutor of the District Prosecutor's Office in Kharkhorin Sum, Uvurkhangai Province*

### **Improved Dispute Resolution through Arbitration in Contract Cases Involving Foreigners and Realization of the Right of Domestic Enterprises to Dispute Resolution**

*B.Delgerjargal, Lawyer at "Erdenes Tavantolgoi" JSC, LL.M candidate of School of Law, NUM*

### **Rules Governing Appellate Court's Striking Lower Court Judgements and Remanding Cases for Retrial in Administrative Disputes**

*B.Erdenemunkh, Attorney and partner of MJL Attorneys LLP, LL.M. candidate of School of law, NUM*

### **Composition of the Disciplinary Committee of the Association of Attorneys: Pressing Issues**

*S.Myagmarsuren, Researcher at the National Legal Institute of Mongolia, LL.M. candidate of School of Law, NUM*

### **2019 Constitutional Amendments and Cities of National or Local Significance**

*R.Khatansaikhan, Researcher at the National Legal Institute of Mongolia, LL.M. candidate of School of Law, NUM*

## LEGAL RESEARCH OVERVIEW

### **Causes and Circumstances of Crimes Committed within the Confines of Military Divisions or Authorities: An Analysis (of Cases and Facts)**

*Ts.Munkhbat, Ph.D., Public prosecutor for Training and research institute under The Prosecutor General's office of Mongolia*

*D.Nyambat, Public prosecutor for Training and research institute under The Prosecutor General's office of Mongolia, Ph.D. candidate of University of Internal Affairs*

### **Reflections on Double Sale of Immovable Property: Courts and Comparisons**

*R.Purevbaatar, LL.M., Lecturer of Private Law Department, School of Law, NUM*

### **A Comparative Study into Adult Guardianship Systems in Mongolia, Germany, Japan, and Taiwan**

*BaoBuhe, Ph.D. candidate of School of Law, NUM*

### **Illegal Circulation of Narcotic Drugs and Psychotropic Substances: A Criminological Perspective**

*R.Jambalsuren, LL.M. candidate of, School of Legal and Social Sciences, University of Internal Affairs of Mongolia*

### **Nullum Crimen Sine Lege as Enshrined in the Criminal Code and as Applied by the Courts: A Comparison**

*B.Batbayar, Researcher, Criminal law sector, Judicial Training, Research, and Information Institute under the Supreme Court of Mongolia*

## NOTES

News

Recent publications



## ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Хууль зүйн үндэсний хүрээлэн 2022 онд 20 жилийн ойтоогоо золгосон билээ. Тус хүрээлэн байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын хууль тогтоомжийн тогтолцоо, хэрэгжилт, уялдаа, үр нөлөөг шинжлэх ухааны үндэстэй судалж, холбогдох асуудлаар төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн бүртгэл, системчлэл, хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг тасралтгүй амжилттай явуулсаар байна. Бид мэргэжлийн эрдэм шинжилгээний

сэтгүүлийг хөгжүүлэх, олон улсын стандартад нийцүүлэх зорилготойгоор эрхлэн гаргадаг “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийнхээ 90 дахь цувралаа Эрхэм уншигч танд өргөн барьж байгаадаа баяртай байна.

Энэ удаагийн дугаараар та бүхэндээ Монгол Улсын гавьяат багш Д.Баярсайхан профессорын “Дэлхий дахины эрүүгийн процессын тогтолцооны харьцуулалт, хэв маяг, онцлог” хэмээх бүтээлийн хамт нийт 17 судлаачдын оюун бодол, сэтгэл зүрхээ зориулан бичсэн эрдэм шинжилгээний өгүүллүүд, судалгааг хүргэж байна. Тухайлбал, үндсэн хуулийн эрх зүйн холбогдолтой 4, эрүүгийн эрх зүйн холбогдолтой 4, олон улсын эрх зүйн холбогдолтой 4, захиргааны эрх зүйн холбогдолтой 2 бүтээлүүд нийтлэгджээ. Уг бүтээлүүд нь хууль зүйн салбарын тулгамдсан олон асуудлыг шинжлэх ухааны болон практик судалгааны эргэлтэд оруулахад хувь нэмэр болно гэдэгт гүнээ итгэлтэй байна.

Хууль зүйн шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэхэд дотоодын нэр хүнд бүхий, өндөр түвшинд мэргэшсэн эрдэмтэн, судлаачдын санал, хувь нэмэр нэн чухал билээ. “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн зөвлөлийн гишүүнээр ажиллаж, үнэт цаг зав, мэдлэг оюунаа зориулсан үе үеийн эрдэмтэн, багш нартаа ч мөн гүнээ талархаж буйг хүлээн авна уу.

Төгсгөлд нь, “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн эрхэм уншигч, захиалагчид төдийгүй Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд хувь нэмрээ оруулж, эрх зүйт төрийг төлөвшүүлэн хөгжүүлэх их үйлсэд оюун бодол, сэтгэл зүрхээ зориулж ирсэн эрдэмтэн, судлаачид болон сэтгүүлийн зөвлөлийн үе үеийн гишүүд Та бүхэнд ирж буй 2023 оны мэндийг дэвшүүлж, эрдмийн их үйлсэд тань өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе!

*Угтах ондоо бүтээлээр дүүрэн  
Урам тэтгэсэн амжилтаар баян  
Гэгээн гэрлээр гэр тань гийж  
Гэрэлт оюунаар ухаан тань тэлэх болтугай!*

Та бүхнийг хүндэтгэсэн,  
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,  
хууль зүйн ухааны доктор

Х.ЭРДЭМ-УНДРАХ



## ДЭЛХИЙ ДАХИНЫ ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ТОГТОЛЦООНЫ ХАРЬЦУУЛАЛТ, ХЭВ МАЯГ, ОНЦЛОГ



*Д.Баярсайхан*

*Монгол Улсын Гавьяат багш, МУИС-ийн  
Хууль зүйн сургуулийн нийтийн эрх зүйн  
тэнхимийн зөвлөх профессор,  
Хууль зүйн ухааны доктор*

### **ТОВЧЛОЛ:**

Орчин үед дэлхий дахиныг хамарсан глобалчлалын үйл явц, түүний үр дагавар эрх зүйн уламжлалт тогтолцооны хэв шинж, хандлагад хүчтэй нөлөөлөх болсны дээр ялангуяа эрүүгийн процессын онол, системийг өөрчлөн шинэчлэх хүчин зүйл болж байна.

Олон улс орнууд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны арга хэлбэрээ өөрчилж, хууль тогтоомждоо өөрчлөлт оруулах болсны зэрэгцээ эрүүгийн процессын эрх зүйн салбарт олон улсын гэрээ, конвенцын зарчим гүнзгий нэвтэрч, эрх зүйн рецепц, интеграцчлалын үр нөлөө өсөн нэмэгдэх хандлагатай болов.

Эрүүгийн процесст хүний эрхийн үнэт зүйлсийг хамгаалах шаардлага бий болж, Аккусацийн ба Инквизицийн системийн хоорондын эрс ялгаа багасаж, харин тэдгээрийн нийтлэг шинж илүү тод илрэх болсон ба хосолсон болон холимог загварын тогтолцооны шинэчлэл хийгдэх болжээ.

Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэх, эрүүгийн хэргийг түргэн шуурхай илрүүлэх явдал тулгамдсан асуудал болж буй өнөө үед дэлхий дахинд өрнөж буй эрүүгийн процессын тогтолцооны хувьсал, өөрчлөлт чиг хандлагыг танин мэдэж, эрүүгийн процессын эрх зүйн орчноо эрс шинэчлэхэд дээрх нөхцөл байдлыг харгалзах нь онцгой ач холбогдолтой юм.

Иймд эдгээр бодит хүчин зүйл, чиг хандлагыг тодруулж, таниулах, эрүүгийн процессын тогтолцооны дэлхий дахины чиг хандлага, үзэл баримтлалыг хөндөж, судлаачийн хувьд өөрийн харьцуулалт, санал, дүгнэлтийг дэвшүүлэхийг зорьсон болно.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Эрүүгийн процессын тогтолцоо, Эрх зүйн рецепц, Аккусацийн ба Инквизицийн процесс, Хосолсон систем, Мэтгэлцээний зарчим, Хялбаршуулсан ажиллагаа, Нийтлэг жишиг, түгээмэл хандлага, Эрүүгийн процессын суурь зарчмууд

## ОРШИЛ

Эдүгээ дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцоонд процессын эрх зүйн гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж, хуулийг хэрэглэх үйл явц илүү шуурхай, улам бүр оновчтой байх шаардлага бий болсоор байгаа билээ.

Эрүүгийн процесс бол хууль зөрчсөн аливаа үйлдэл нь гэмт хэрэг мөн эсэхийг мөрдөн шалгаж илрүүлэх, хянан шийдвэрлэхэд чиглэгдсэн эрх зүйн үйл явц тул энэ салбар эрх зүй нь дэлхий дахины эрх зүйн системийн хөгжил, зүй тогтлыг тусган оршдог. Эрүүгийн процесс нь аливаа этгээд гэмт хэрэг үйлдсэн эсэхийг шалган тогтоох зорилго, агуулга бүхий маш нарийн үйл ажиллагаа бөгөөд төрийн оролцооны императив чиг үүрэг бүхий харилцаа юм. Эрүүгийн процессын хэв маяг онцлогийг авч үзэхийн өмнө түүний танин мэдэхүйн эх үндэс, онолын суурь үзэл баримтлал хаанаас эхлэлтэй, яаж хөгжсөнийг дурдах нь чухал ач холбогдолтой.

Эрүүгийн процесс нь тодорхой үе шаттайгаар, хэлбэршүүлсэн журмын дагуу хэрэгжих зүй тогтолтойг чухамхүү Ромын эрх зүйгээс уламжлан авсан билээ.

Ромын сонгодог эрх зүйн хөгжлийн оргил үед гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийн гэм бурууг шүүх шалган тогтоохын тулд нотлох ажиллагааны бүхий л процессыг шүүхийн эрх бүхий субъект гардан хийж, хөндлөнгийн нотлох баримтыг шүүх дээр гарган илтгэх журмыг тогтоож байв.

Ромын эрх зүйн уламжлалд тулгуурлан Герман, Франц, Италийн эрх зүйн соёл, хөгжлөөр баяжиж, Баруун Европт Квестр гэх энэхүү субъект нь шүүхээс тусгайлан томилогдсон итгэмжлэгдсэн түшмэл бөгөөд урьдчилсан ажиллагаа бүхий шүүхийн зарга үүсгэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй байв. Хэдийгээр тухайн үед мөрдөн байцаалт ба шүүхийн үе шат гэсэн нарийн зааг байгаагүй боловч дээрх хоёр ажиллагааны чиг үүрэг ялгагдаж байснаас гадна шүүхэд эрүүгийн хэргийг шийдэхээс өмнө мөрдөн шалгах ажиллагаа явагдах нөхцөлийг жишиг болгон тогтоосон байдаг.<sup>1</sup>

Инквизици бол *“Inquisitio adere processus”* буюу шүүхээр шийдэх хэргийг заавал мөрдөн шалгах зүй тогтолт нөхцөлийг урьдчилан тодорхойлох чиг хандлагыг бий болгоход түүхэн үүрэг гүйцэтгэжээ.

Энэхүү нэршил нь Ромын эрүүгийн процессын түүхэн хэв маягийн сүүлчийн хэлбэршил болж гарч ирэхдээ Баруун Европт өргөн тархсан мөрдөн шалгах тогтолцооны эх үндэс нь болж хөгжсөн байна.

Аккусацийн хувьд нэгэнт нотлогдсон хэргийг түргэвчилсэн нөхцөлөөр шуурхай шийдэх, мэтгэлцээний зарчим, процедурыг хангах шаардлагын дагуу бий болж хөгжсөн бөгөөд Английн шүүхийн жишиг бүхий процессын урт удаан хөгжлийн явцад бүрэлдэн тогтсон юм.

Өнөөгийн орчин үеийн түүхэн хөгжлийн явцад инквизици ба аккусацийн системийн хоорондын интеграцлал рецепцийн хүчин зүйлийн нөлөөн дор хосолсон ба холимог хэв шинж бүхий тогтолцоог хүлээн зөвшөөрч, нутагшуулах хандлага нэгэнт бий болоод байгаа билээ.

## ҮНДСЭН ХЭСЭГ

Дэлхийн хэмжээнд судалгаа хийдэг олон улс орны эрдэмтэн судлаачдын нэлээд хэсэг нь эрүүгийн процессын тогтолцооны хэв маягийг харьцуулж, дараах ангилал, чиг хандлагыг хүлээн зөвшөөрөх болсон байна.<sup>2</sup>

Үүнд :

- 1) **Инквизици процесс** (*Inquisitorial procedure*)
- 2) **Аккусаци процесс** (*Accusatory procedure*)
- 3) **Хосолсон процесс** (*Equivocal and mixed procedure*)

<sup>1</sup> МУИС-ийн ХЗС, УЕПГ, МХХолбоо, “Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулах нь” (онол, практикийн хурлын илтгэлийн эмхэтгэл) УБ, 2019, 7 дахь тал.

<sup>2</sup> Criminal procedure. A World study. ED. Craig Bradley. Carolina 2007 p 9-10.

Дээрх ангиллыг гаргахдаа дараах шалгуурыг гол үндэслэл болгон авч үздэг байна:

1. Нотлох ажиллагааны арга,
2. Онолын үзэл баримтлал,
3. Процессын зарчим,
4. Эрх зүйн эх сурвалж, хууль зүйн техник,
5. Шүүхээр хэрэг шийдвэрлэх жишиг, практик.

Дурдсан үндсэн хоёр тогтолцооны мөн чанар, онцлогийг тухайлан тодруулж авч үзэх нь чухал.

### ***Нэг. Инквизицийн эрүүгийн процессын тогтолцоо<sup>2</sup>:***

Инквизицийн процесс нь нэг талаас хэргийг бүх талаас бүрэн бодиттойгоор тогтооход чиглэгддэг бол нөгөө талаас гэм бурууг зөвхөн шүүх тогтоох шаардлагад нийцсэн эрх зүйт төрийн хуульд захирагдах зарчимтай салшгүй холбоотой. Энэхүү процесс нь ямар ч эрүүгийн хэргийг заавал мөрдөн шалгах замаар гэм бурууг тогтооход чиглэгдсэн *De jure process* бөгөөд харьцангуй нейтраль зохицуулалт бүхий формулярийн нөхцөлөөр хуульчлагдсан позитив үйл явц юм.

Инквизицийн процессын онолын үндэслэл нь:

1. Бодит үнэнийг тогтоох онол (*Neutral theory*)
2. Мөрдөн шалгах тогтолцоонд тулгуурлах үзэл (*Crime control*)
3. Объектив нотолгоонд формаль ба материаллаг чиг үүргийг зааглан ялгах баримтлал (*Formal and objective evidence*)

Баруун Европын буюу Инквизицийн тогтолцоо бүхий орнуудын эрүүгийн процессын суурь зарчмууд нь:

- 1) Хуульд үндэслэгдэх буюу хуулийн дагуу байх зарчим,
- 2) Процессын чиг үүргийн хуваарилалтын зарчим,
- 3) Хэргийг үе шаттайгаар хянан шийдвэрлэх зарчим.

Инквизицийн эрүүгийн процессын мөн чанар, шинж, онцлогийн тухайд<sup>3</sup> :

1. Эрүүгийн процессын эрх зүйн эх сурвалж нь төрөлжсөн хууль тогтоомжоор зохицуулагдсан байх бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх журмын тухай ерөнхий ба зэрэгцсэн хуулиудаар тодорхойлогдсон. (*Parallel codification*)
2. Хэргийн хувь заяа мөрдөн байцаалтын үр дүнгээс ихээхэн хамаарах ба прокуророос шилжүүлсэн хавтаст хэргийн хэмжээнд шүүн таслах ажиллагаа явагддаг. (*Inquisitorial procedure*)
3. Эрүүгийн процесс нь мөрдөн байцаалтын буюу шүүхийн өмнөх үе, шүүн таслах ажиллагааны буюу шүүхийн шатны гэсэн хатуу зааглагдсан хоёр үе шаттай байдаг. Түүнчлэн шүүхийн өмнөх шат нь хойшлуулшгүй мөрдөн мөшгөх болон мөрдөн шалгах, яллах ажиллагааны гэсэн тус тусдаа процесс үеийг хамардаг бол шүүхийн шат нь урьдчилсан процессын, шүүх хуралдааны болон дараалал бүхий үе шаттай байдаг. (*Identification procedure, Interrogation court procedure: pretrial and trial*)
4. Прокурор нь мөрдөн байцаалтын ажиллагааг мэргэжлийн үүднээс чиглүүлэн удирдаж, процессын хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд яллах чиг үүргийг хариуцна.
5. Хэргийн ангилал, категоричлолоос хамаарч түргэвчилсэн болон ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл, журмыг нарийвчлан хуульчилсан.
6. “*Judicial investigation*” буюу шүүхийн мөрдөн байцаалтын ажиллагааг хэрэгжүүлэх субъект мөрдөн байцаалтын шүүгчийн статус, бүрэн эрх, бүтцийг олон жил хуульчлан зохицуулж ирснийг өөрчилж буй боловч зарим оронд хэвээр хадгалагдаж үлдсэн (*Франц, Испани г.м*)

<sup>3</sup> Энэхүү тогтолцоонд Баруун Европын болон тэдгээрийг баримжаа болгон хөгжиж буй 120 шахам орон багтдаг. (Д.Б).

7. Шүүхийн өмнөх шатны процессын ажиллагаанд прокурор харьцангуй давуу эрхтэй байх ба өмгөөлөгчийн оролцоо зарим талаар хязгаарлагдмал шинжтэй байдаг.
8. Шүүгч хавтаст хэргийн материалд тулгуурлан өөрөө байцаалтыг явуулах замаар нотлох үүргийг хүлээнэ.
9. Мөрдөн байцаалт явуулах эрх бүхий субъектийн хэргийн харьяалал болон эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх хугацааг хуулийн нарийвчилсан тодорхой нөхцөл, журмын дагуу тогтоож зохицуулсан.
10. Шүүхийн хуралдаан нь мөрдөн байцаалтын шатанд авагдсан мэдүүлгэн тэмдэглэлийг нотлох баримт болгон ашигладаг ба яллах зарчимд тулгуурласан мэтгэлцээний хязгаарлалт бүхий процессын хэлбэртэй байдаг.
11. Шүүхийн өмнөх шатанд хөнгөн болон зарим хүнд биш ердийн хэргийн хувьд хэрэв яллагдагч гэм буруугаа хүлээж хохирлыг арилгахаа илэрхийлж өмгөөлөгч, прокурорт хүсэлт гаргасан тохиолдолд хялбаршуулсан буюу түргэвчилсэн журмаар (*Францад альтернатив процесс*) хянан шийдвэрлэх боломжийг хуулиар зөвшөөрсөн байдаг.
12. Мөрдөн байцаалтын үр дүнд цугларсан нотлох баримтыг нягтлан шалгасны үндсэн дээр прокурор яллах акт үйлдэн хэргийг шүүхэд шилжүүлэх бөгөөд энэхүү хавтаст хэргийн хэмжээнд шүүх хуралдаан явагдана.
13. Шүүхээс хэргийг хянан хэлэлцээд яллах буюу цагаатгах эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл яллахгүйгээр ял бус албадлагын арга хэмжээ авах шийдвэрийн аль нэгийг гаргана. Мөрдөн байцаалтад буцаах зохицуулалтыг хуулиар хязгаарлахад чиглэгддэг.
14. Нотлох ажиллагааны бүрэн цогц байдлын бодит шаардлагыг хангахын тулд бүх төрлийн хэрэгт мөрдөн байцаалтыг заавал явуулах бөгөөд аливаа эрүүгийн хэрэг зөвхөн шүүх дээр эцэслэн шийдвэрлэх ёстой гэсэн чиг шугамыг баримталж ирсэн.

#### ***Хоёр. Аккусацийн эрүүгийн процессын тогтолцоо:***

Энэхүү систем нь Англи-Америкийн эрх зүйн бүлийн ихэнх оронд өргөн тархсан бөгөөд эрүүгийн процессын харьцангуй нээлттэй, уян хатан шинжийг тусгасан байдаг.

Аккусац процесс нь зөвхөн хүнд ноцтой эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, хүнд биш хөнгөн хэргийг хялбаршуулж түргэвчилсэн нөхцөлөөр шийдвэрлэх замаар гэм бурууг хүлээн зөвшөөрөх эсхийг тогтоон зохицуулахад чиглэгдсэн *De facto process* бөгөөд нейтраль бус, легисакцийн нөхцөл бүхий жишгийн дагуу үйл явц юм.

Аккусацийн процессын онолын үндэслэл нь:

1. Ял тохиролцох буюу түргэвчилсэн процессын онол, (*Doctrine of Plea bargaining and Summary procedure*)
2. Мэтгэлцүүлэн шүүх тогтолцоонд тулгуурлах үзэл, (*Theory of Adversarial procedure*)
3. Субъектив нотолгоонд формаль ба процессын чиг үүргийг зааглан ялгах баримтлал (*Formal and subjective evidence*).

Энэхүү процессын суурь зарчмуудад:

1. Шударга, эрх зүйт ёсонд үндэслэгдэх зарчим
2. Процессын чиг үүргийг шилжүүлэн зохицуулах зарчим
3. Яллах ба цагаатгах талын тэнцвэрт байдлыг хангах зарчим
4. Хэргийг хялбаршуулсан буюу нөхцөлт процедурын дагуу явуулах зарчим
5. Нотолгооны мэтгэлцэх зарчим
6. Гэм бурууг хүлгэлцах ба хүлээн зөвшөөрөх зарчим (*Шүүхийн ба шүүхийн өмнөх шат*)

7. Процесс нээлттэй бөгөөд хариуцлага хуваарилах зарчим
8. Шүүхийн хараат бус, шуурхай байдлын зарчим

Аккусацийн эрүүгийн процессын гол онцлог шинж, мөн чанарыг авч үзвэл <sup>4</sup>:

1. Хэрэг үйлдсэн этгээд гэм буруугаа хүлээж хохирол, үр дагавраа бүрэн арилгасан буюу тийнхүү арилгах баталгааг бүрдүүлсэн нөхцөлд ял тохиролцох болон хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэдэг;
2. Хэргийг шүүх дээр нотлох ажиллагаа яллах болон цагаатгах талыг төлөөлсөн субъектийн харилцан мэтгэлцэх зарчимд тулгуурлан явагдах ба хэргийг хувь заяаг шүүгч бус, мэтгэлцэгч талууд тодорхойлно;
3. Хэргийг мэтгэлцүүлэн шүүхэд шүүгч зохицуулах, хяналт тавих, төвийг сахисан идэвхгүй байр суурьтай байхын дээр хавтаст хэргийн материалд хөтлөгдөхгүй, түүний хэмжээ, нөхцөлөөр хязгаарлагдахгүй;
4. Хэргийг ял тохиролцох нөхцөлөөр шийдвэрлэх тохиолдолд гэм буруугийн шүүхийн хэлэлцүүлгийг хийхгүйгээр шууд ялын хэмжээ, нөхцөлийг түргэвчилсэн журмаар шийддэг;
5. Эрүүгийн процессын журам, хугацаа, нөхцөл нь ихэнхдээ шүүхийн жишиг, зарчимд тулгуурлаж явагдана г.м

Дэлхий дахины эрүүгийн процессын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход ач холбогдол бүхий голлох баримт бичиг, эх сурвалжуудаас дурдвал:

1. Дэлхийн улсуудын Эрүүгийн процессын загвар хууль. 2008; (НҮБ) *Англи хэл дээр*;
2. НҮБ-аас баталсан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох конвенцүүд (90/50);
3. Хөгжингүй орнуудын эрүүгийн процессын хуулиуд (20);
4. Европын Холбооны хүний эрхийн конвенц, Европын Холбооны хууль тогтоомжууд (1950-2022);
5. Хүний эрхийн Олон улсын байгууллагуудаас эрүү шүүлттэй тэмцэх талаар гаргасан тайлан, зөвлөмжүүд (2001-2022);
6. Эрүүгийн процессын шинэтгэл, реформын чиглэлээр зохион байгуулагдсан Олон Улсын хэмжээний хурал, зөвлөгөөний дүгнэлт, зөвлөмжүүд (2001-2022).

Эрүүгийн процессын загвар хууль болон НҮБ-ын гэрээ, конвенцуудад тусгагдсан эрүүгийн процессын гол үзэл баримтлал, чиг хандлагыг тоймлон илэрхийлбэл:

1. Хүнд биш хэргийг аль болох хүндрэлгүйгээр түргэн шуурхай шийдвэрлэх / *Шүүхийн өмнөх шатанд шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх*/;
2. Баривчлах, цагдан хорих явдлыг нийтлэг журам болгон түгээмэл хэрэглэхгүй байх;
3. Насанд хүрээгүй этгээдийн эрүүгийн процесс тусдаа бөгөөд ялгавартай хуульчлагдсан байх;
4. Эрүүгийн хэргийг мөрдөн мөшгөх, мөрдөн шалгах болон яллах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд прокурор голлох үүрэгтэй оролцох;
5. Эрүүгийн хэргийн нотлох баримтыг шалгах, үнэлэх ажиллагаа шүүхийн хяналт дор явагдах;
6. Шүүн таслах ажиллагаа мэтгэлцээний зарчимд нийцсэн, шударга, тэнцвэртэй, бодитой бөгөөд хараат бусаар явагдах.

<sup>4</sup> Д.Баярсайхан Гадаад орнуудын эрүүгийн процесс. УБ., 2015, 33 дахь тал.



## ДҮГНЭЛТ

- I. Дэлхийн хөгжингүй орнууд эрүүгийн процессын хууль тогтоомжийн төрөлжүүлэлтийг өндөр түвшинд хөгжүүлж ирсэн үнэт зүйлсээ улам баяжуулж, дэлгэрүүлэхийн зэрэгцээ Европын Холбооны эрх зүйн баримт бичиг, гэрээ, конвенцын агуулгад тухайн уламжлалт кодификациллын бодлогыг тусган хэрэгжүүлэхийг зорих болсон.
- II. Хэдийгээр ихэнх оронд Эх газрын эрх зүйн нэгдмэл тогтолцооны мөн чанарыг тодорхой хэмжээнд алдалгүй хөгжиж буй боловч орчин үеийн эдүгээгийн цаг үед Францын, Германы, Скандиновын, Итали-иберийн гэсэн дөрвөн үндсэн хэв маяг ялгаран гарч дифференциалчиллын хандлага илт мэдэгдэж, эрүүгийн процессын суурь зарчим адил боловч процедурын нөхцөл, зохицуулалтаараа нэлээд ялгагдан гарч эрх зүйн орчны чиг хандлага нь өөрчлөгдөж байна.
- III. Европын Холбооны зөвлөлөөс 1987 онд батлан гаргасан **(R(87)18)** “ Эрүүгийн шүүхийн хялбаршуулсан журмын тухай зөвлөмж”-д заасны дагуу хэт нүсэр, чирэгдэл хүндрэл бүхий уламжлалт процесс ажиллагаанаас аль болох зайлсхийж, ил тодорхой нотлогдсон буюу гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн шийдвэрлэх боломж бүхий хэргүүдийг түргэвчилсэн буюу хурдавчилсан журмаар хялбаршуулж формал процессын аргаар шийддэг байх чиг хандлагыг цөөнгүй улс орон хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлж хэвшжээ.
- IV. Эрүүгийн процессын эрх зүйн эх сурвалжийн хүрээ өргөжиж байгаагийн дээр зэрэгцсэн хуулиудын зохицуулалтын уялдаа холбоог хангах, нарийвчилсан деталь хэм хэмжээнүүдийг шууд хэрэглэх боломжтой байх нөхцөлөөр илүү боловсронгуй болгох чиглэлээр хөгжиж байна.
- V. Эрүүгийн процессын албадлага хэрэглэх ажиллагаанд хүний эрхийг хангах зарчим шаардлагыг илүү тодорхой тусган хуульчлах болсон ба НҮБ-ын болон Европын Хүний Эрхийн Олон улсын гэрээ, конвенцын заалт, зарчмуудыг эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хэрэглэх нөхцөл, журмыг тогтоон хэрэгжүүлж байгаа нь анхаарал татах болов.
- VI. Эрүүгийн хэргийн шүүхийн процесс ажиллагаанд эрх зүйн орчныг өөрчлөн шинэчлэх, мэтгэлцэх зарчмыг илүү нээлттэй сонгодог байдлаар нэвтрүүлэх, хавтаст хэргийг уншиж, мөрдөн байцаалтын үр дүнд хэт найдаж шүүх хуралд ордог уламжлалт хандлагаас зайлсхийж, “*Charge statement and only*” зарчмын дагуу шүүх хуралдааны процессыг илүү шударга, бодитой, зохистой, оновчтой хэрэгжүүлэх арга, механизмыг идэвхитэй эрэлхийлж байна.

## ЭХ СУРВАЛЖ

1. Д.Баярсайхан, Гадаад орнуудын эрүүгийн процесс, УБ., 2015.
2. Д.Баярсайхан, Т.Золбоо, Эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн салбар дахь Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл УБ., 2012.
3. Н.Г.Стойко, Уголовный процесс М., 2014.
4. В.В.Вандышев Уголовный процесс М., 2010.
5. Criminal procedure. Joel Samaha. Wadworth., 2012.
6. Kamisar, La Fave, I King. Modern Criminal procedure W., 2015.
7. Model Code of Criminal Procedure. Vivienne O'Connor and Collette Raush editors, Pease building and Rule of law W., 2008.
8. Criminal procedure. A World study. Ed. Craig M. Bradley C.N.C 2007.
9. Stephen. C.Taman. Comparative Criminal procedure N.C 2002.



## **A GLOBAL COMPARISON OF CRIMINAL JUSTICE SYSTEMS: MAIN TYPES AND FEATURES**

*Bayarsaikhan D. (Ph.D.)*

*Professor at the Public Law Department, School of Law, NUM*

### **ABSTRACT:**

Globalization has profoundly affected countries' legal systems and the criminal procedural system is undergoing development and reformation. The mixed criminal procedural system principle is being implemented with the progress of reception and integration in accusatorial and inquisitorial criminal procedural systems.

It has become critically important for a criminal procedure to be efficient, quick, flexible, and just.

### **KEYWORDS:**

Criminal procedural system, Accusatorial and inquisitorial criminal procedure, Principle to have a legal debate, Plea bargain, Summary trial, Fundamental principles of criminal procedure

## ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХУУЛИЙН ТӨСӨӨТЭЙ ХЭРЭГЛЭХ, ХЭМ ХЭМЖЭЭГ ЗОРИЛГЫН ДАГУУ ТАЙЛБАРЛАХ АРАГЧЛАЛЫГ ХЭРЭГЛЭХ НЬ



*Б.Тэмүүлэн  
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх  
зүйн тэнхимийн дэд профессор,  
Хууль зүйн ухааны доктор*

### **ТОВЧЛОЛ:**

Нийгмийн бүхий л харилцааг хуулиар зохицуулах боломжгүйгээс гадна тодорхой тохиолдлуудад хуулийн хийдэл үүсэх эрсдэл байдаг нь гарцаагүй. Энэ тохиолдолд тодорхой маргааныг холбогдох хуулийг хэрэглэн шийдвэрлэх ээдрээтэй асуудалтай шүүх тулгарах нь шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байх асуудлын талаар шүүмж дагуулах нь маргаангүй.

Тулгамдсан асуудлаас гарах гарц нь шүүхээс хууль хэрэглээний өндөр чадвар, мэдлэг шаардана. Үүнд нэмэр болох үүднээс энэхүү өгүүллийг толилуульж буй бөгөөд өгүүллийн хүрээнд тодорхой нэгэн шүүхийн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр, хэм хэмжээг телеологийн редукцийн аргаар тайлбарлах, хуулийн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлалын талаар жишээн дээр хэрэглэн үзүүлэхийг зорьсон болно.

Хуулийн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлалын талаар урьд өмнө дэлгэрэнгүй толилуульж байсан билээ.<sup>1</sup> Энэ өгүүллийн хүрээнд хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлалыг тодорхой шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт хэрхэн хэрэглэж болохыг харуулахыг зорьсон. Ингэхдээ, иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийг хэм хэмжээний хэрэглээний аргачлал, хэрэглэх шаардлагатай байсан хуулийн хэм хэмжээг хэрэглэсэн эсэх, улмаар итгэл үнэмшил төрүүлэхүйц болсон эсэхийг шүүмжилж дүгнэсний үндсэн дээр тухайн тохиолдолд хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлалыг хэрхэн хэрэглэн шийдвэрийг үндэслэж болох байсныг тайлбарласан болно.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Телеологийн редукци, Төсөөтэй хэрэглэх, Төөрөгдөл оруулах, Оноосон нэр

<sup>1</sup> Төсөөтэй хэрэглэх аргачлалын талаар дэлгэрэнгүй байдлаар “Иргэний эрх зүйн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлал” өгүүллэл “Эрх зүй” сэтгүүлийн 2019 оны дугаар 3-т хэвлэгдсэн болно.

## ҮНДСЭН ХЭСЭГ

### 1. Маргааны нөхцөл байдал

Нэхэмжлэгч иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ хариуцагч этгээдэд гаргаж буй нэхэмжлэлээ дараах байдлаар үндэслэн тайлбарласан байдаг:

“Боловсрол, шинжлэх ухааны сайд ..... өдөр Монголын Үндэсний их сургууль болон Монгол Улсын их сургууль гэсэн хоёр нэрсийн маргааны хувьд ямар байр суурьтай байгаа тухай сурвалжлагчийн зүгээс тавьсан асуултад “... Энэ бол луйвар. Бид... гэдэг нэрээ буцааж авна.... Хөдөө орон нутгийн оюутнууд хотод ирэхэд Монгол Улсын Их сургуульд ороод байгаа юм уу, Монголын Үндэсний Их сургуульд ороод байгаа юм уу гэдэг их төөрөгдөл үүсгэж байгаа. Тийм учраас бид энэ нэрээ буцааж авнаа., энэ бол Монголын төрийн өмч, Монгол ард түмний өмч...” – гэх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулж Монголын Үндэсний Их сургуулийн оноосон нэрийн асуудлаар олон нийтэд илт худал, гүтгэлгийн шинжтэй мэдээлэл тараасан гэж үзэж байна.

Нэхэмжлэгч байгууллага нь Гэгээрлийн сайдын 1998 оны 07 дугаар сарын 09 өдрийн 154 дүгээр тушаалаар зэрэглэл баталгаажсан, Соёл Шинжлэх Ухааны сайдын 2002 оны 02 дугаар сарын 06 өдрийн 39 дүгээр тушаалаар “Монголын Үндэсний коллеж”, Соёл Шинжлэх ухааны сайдын 2012 оны 08 дугаар сарын 26 өдрийн А/454 дүгээр тушаалаар их сургуулийн зэрэг авч “Монгол Үндэсний Их сургууль” нэртэй болж өргөжин тэлсэн. Анх удаа байгуулагдахдаа “Монголын Үндэсний” гэх оноосон нэрийг улсын бүртгэлийн байгууллагаас авснаас өөр луйвар хийгээгүй.

Улмаар, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсэг, 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт заасны дагуу Боловсрол, Шинжлэх ухааны сайдын хэлсэн үг гүтгэлгийн шинжтэй худал мэдээлэл болохыг тогтоолгох, Монголын Үндэсний Их сургуулийн нэр төр, алдар хүндийг сэргээж нэхэмжлэгчээс уучлал гуйхыг хариуцагчид даалгах шаардлагыг нэхэмжлэлдээ гаргажээ.

Хариуцагчийн зүгээс нэхэмжлэлийн шаардлага үндэслэлгүй болох тухай хариу тайлбар, холбогдох нотлох баримтыг гаргаж, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгөхийг хүсчээ.<sup>2</sup>

### 2. Шүүхийн шийдвэрийн үндэслэл

Шүүх нэхэмжлэгчийн гаргасан шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Ингэхдээ өөрийн шийдвэрийг дараах байдлаар үндэслэсэн байна:

Монгол Үндэсний Их сургууль гэх нэртэй төрийн бус байгууллагын хэлбэртэй, боловсролын үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй хуулийн этгээд 2013 оны 12 дугаар сарын 26 өдөр регистрийн .... дугаарт бүртгэгдэж, Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан нь нотлогдож байна. Түүнчлэн Монгол Улсын Соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 08 дугаар сарын 06 өдрийн А/454 дүгээр тушаалаар “... их сургуулийн ангилалд хамааруулсан байна”. Монгол Улсын Төрийн хэлний зөвлөлөөс 2013 оны 10 дугаар сарын 23 өдрийн 28 дугаартай Хэл шинжлэлийн дүгнэлтэнд “ тус сургуулиудын хэллэгүүдийн үгийн бүрэлдэхүүн болон дуудлага ижил үгсийн байрлал өөр тул авиа зүйн талаар төөрөгдөлд оруулах боломжгүй. Тус бүрийн бэлгэ тэмдэг логонууд эрс өөр байна.” Хэмээн дүгнэсэн байна.

Улмаар, дээрх дүгнэлтэнд үндэслэн Монгол Үндэсний Их сургуулийн нэр нь “Өрсөлдөөний тухай хуулийн” “Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагаа” гэсэн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсгийн “Бусдын барааны тэмдэг, шошго, аж ахуй эрхлэгчийн нэр барааны чанарын баталгааг дур мэдэн хэрэглэх, барааны оноосон нэр, баглаа боодлыг хуулбарлахыг” зөрчөөгүй байна гэсэн дүгнэлт гарсан байна.

<sup>2</sup> Сүхбаатар үүргийн иргэний хэргийн анхан шатны 2022 оны 9 дүгээр сарын 30 өдрийн шийдвэр.

Дээрх дүгнэлт, нотлох баримтуудын үндсэн дээр Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2., 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэгч болох Монголын Үндэсний Их сургуулийн нэр хүндийг сэргээж, нэхэмжлэгчээс уучлалт гуйх, мэдээлэл тараасан хэлбэрээр няцаалт хийхийг хариуцагчид даалгах шийдвэр гаргажээ.

### 3. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

Шүүхийн шийдвэр үндэслэлтэй, зөв гарсан эсэхийг дүгнэх аргачлал бол шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт шүүх нотлох баримт ба хэрэглэгдэх ёстой хуулийн зохицуулалтыг оновчтой зөв хэрэглэж, субсумци зөв хийсэн эсэхэд дүн шинжилгээ хийхэд оршдог.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийг дараах үндэслэлээр хангалттай үндэслэгдээгүй, хэрэглэх ёстой байсан холбогдох хуулийн зохицуулалт, заалтыг оновчтой хэрэглээгүй хэмээн шүүмжлэх нь үндэслэлтэй байна:

Нэгдүгээрт, шийдвэрийн үндэслэх хэсгийн логик уялдаа холбоо, хэрэглэсэн хуулийн заалтуудын хэрэглэх шаардлагатай дэс дараалал нь алдаатай байна. Иргэний маргааныг шийдвэрлэхэд холбогдох хэм хэмжээг хэрэглэхдээ ерөнхийгөөс тусгай заалт руу шилжиж хэрэглэх ёстой байдаг.<sup>3</sup> Гэтэл, дээрх шийдвэрт ерөнхийгөөс тусгай заалт руу шилжих дэс дараалал алдагдаж, эхлээд тусгай заалт буюу хэм хэмжээг хэрэглэн, дараа нь шаардах эрхийн үндэслэл рүү шилжиж, үүний дараа өөр шаардах эрх рүү шилжин шалгасан байдал тогтоогдож байна. Үүнийг тодруулбал, шүүх юуны өмнө шинжээчдийн дүгнэлтийг дурдаж, улмаар дүгнэлтүүд дээр үндэслэн Өрсөлдөөний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсгийн “Бусдын барааны тэмдэг, шошго аж ахуйн нэр, барааны чанарын баталгааг дур мэдэн хэрэглэх, барааны оноосон нэр, баглаа боодлыг хуулбарлах” гэх заалтыг зөрчөөгүй байна гэж дүгнэсэн байна. Хэдийгээр шүүх энэхүү дүгнэлтийг хэргийн хавтаст ирүүлсэн дүгнэлт хэмээн дурдсан боловч, шүүх дүгнэлтийг шийдвэртээ дурдаж байгаа нь энэ заалтыг өөрөө хэрэгдэж байна гэдгийг нотолж байна. Гэтэл Өрсөлдөөний хуулийн тус заалтыг маргааныг шийдвэрлэхэд хэрэглэх шаардлагагүй, учир нь, МУИС гэсэн нэрийг МҮИС шууд хуулбарлан аваагүй, гагцхүү төсөөтэй учир төөрөгдөлд оруулах боломжтой хэмээн үзэж буй нь маргааны байдлаас тодорхой байна. Хэрэглэх шаардлагагүй хэм хэмжээ, заалтыг маргааныг шийдвэрлэхэд хэрэглэх нь шүүхийн шийдвэрийн үндэслэлд эргэлзэх нөхцөл байдлыг бий болгож, маргааныг шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварт эргэлзэх үр дагаварт хүргэх эрсдэлтэй. Үүнээс гадна, Өрсөлдөөний тухай хуулийн тус заалтыг авч хэрэглэхдээ “бусдын ..... нэр.... шошго ....- г хуулбарлана” гэх ойлголтыг буюу энэхүү заалтыг авч хэрэглэх урьдчилсан нөхцөлийг юуны өмнө тайлбарлаад, дараа нь хэрэглэх эсэхээ шийдэх ёстой байсан. Учир нь, “хуулбарлана” гэдэг нь үгийн утгаар тайлбарлавал, бусдын нэр, шошгыг байгаа байдлаар нь авч хэрэглэхийг ойлгох уу, эсхүл дууриалган төсөөтэй нэр, шошгыг авч хэрэглэхийг ойлгох уу гэдэг нь маргаантай асуудал болох нь эргэлзээгүй. Гэтэл шүүх тус заалтыг авч хэрэглэхдээ урьдчилсан нөхцөлийг тодруулах үүднээс хийх ёстой тайлбарыг хийгээгүй орхисон байна.

Хоёрдугаарт, нэхэмжлэгч өөрийн шаардлага нь Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дугаар заалтыг үндэслэж гаргасан байна. Улмаар, шүүх маргааныг шийдвэрлэхдээ шаардах эрхээс шалгаж эхлэх ёстой байдаг. Гэтэл шаардах эрхийн үндэслэл болж буй энэ заалтыг шүүхийн шийдвэрийн үндэслэлийн төгсгөл хэсэгт дурдсан нь хэм хэмжээг логик системчлэлийн дагуу, ерөнхий шаардлагаас эхлэн шалгах дэс дарааллыг алдагдуулсан байна.

Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэг болон 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь хэсгийг ямар үндэслэлээр дурдаж шалгасан нь ойлгомжгүй байна. Түүнчлэн, энэ заалтуудыг Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгтэй хэрхэн системчлэл,

<sup>3</sup> Иргэний эрх зүйн буюу хувийн эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд хэм хэмжээ, заалтын хэрэглээний аргачлалыг иргэний эрх зүйн сурах бичгүүдэд болон бодлого бодох гарын авлагуудад тайлбарласан. Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхшиг, Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2012 он, 156 дахь тал.

хэрэглээний хувьд уялдуулан холбож буй талаар огт тайлбарлаагүй. Хэрэв эдгээр заалтыг үндэслэл хэсэгт дурдаж байгаа бол шийдвэрийн тогтоох хэсэгт энэхүү заалт нь мөн дурдагдах ёстой байсан болов уу. Гэтэл шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт зөвхөн Иргэний хуулийн 21.2 дахь хэсэг болон 515 дугаар зүйлийн 511.1 дэх хэсгийг үндэслэсэн байгаа нь Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 ба 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь хэсгүүд юуны учир үндэслэх хэсэгт шалгагдсан нь тодорхойгүй байна. Иргэний хуулийн 497 дугаар зүйл нь өөрөө тусдаа бие даасан шаардах эрх болдог гэдгийг тэмдэглэх шаардлагатай.

Гуравдугаарт, шүүх шийдвэрээ үндэслэхдээ холбогдох эрх бүхий шинжээчдийн дүгнэлтийг үндэслэсэн байна. Тухайлбал, Монгол улсын Төрийн хэлийн зөвлөлөөс 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 28 дугаартай гаргасан дүгнэлтийн “Монгол Улсын Их сургуулийн нэрийн товчлол нь МУИС, Монголын Үндэсний Их сургуулийн нэрийн товчлол нь МҮИС тул бусдыг төөрөгдүүлэх үндэслэлгүй” гэх үзэл баримтлалыг шүүх үндэслэн тус сургуулиудын нэр нь өөр өөр тул төөрөгдөх үндэслэл алга хэмээн дүгнэсэн нь итгэл үнэмшлийг төрүүлэхгүй байна. Учир нь дээрх дүгнэлт 2013 онд гарч байсан бөгөөд тэр үеэс хойш нийгмийн харилцаа, хүмүүсийн сэтгэлгээ, асуудлыг тусгаж хүлээн авах ойлголт зэрэгт нь өөрчлөлт гарсан нь маргаангүй. Түүнчлэн, МУИС ба МҮИС гэх хоёр товчлолыг хооронд нь андуурч, буруу ойлгох боломж бий эсэхэд юуны учир тус зөвлөл дүгнэлт гаргасан болох нь ойлгомжгүй байна. Дээрх хоёр товчлолыг олон нийт буюу хүмүүс, харилцагчид, оюутнууд, залуучууд, хэрэглэгчид, бүүр тодруулбал эрүүл саруул ухаантай Монгол Улсын дундаж иргэдэд хэрхэн ойлгогдож байна, төөрөгдөлд оруулах эрсдэл байгаа эсэхийг жирийн иргэдийн үүднээс хандаж, дүгнэх шаардлагатай байсан болов уу.

Улмаар, шүүхийн шийдвэрийн үндэслэл нь итгэл үнэмшил төрүүлэхгүй, хэм хэмжээний хэрэглээн дээр алдаа байгаагүй гарсан хэмээн дүгнэх нь үндэслэлтэй байна.

Өгүүллийн дараагийн хэсгүүдэд хэм хэмжээний хэрэглээний талаар өөрийн үзэл баримтлалаа илэрхийлэн, үндэслэхийг оролдсон болно.

#### **4. Шүүхийн шийдвэрийн үндэслэлийн талаар санал болгож буй зохиогчийн үзэл баримтлал**

МУИС болон МҮИС гэх нэрийн маргаантай асуудлыг шийдвэрлэх эрх зүйн нэг боломж нь Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт хуульчилсан компанийн нэрийн тухай зохицуулалт байж болох юм. Тус заалтад дараах зохицуулалтыг тусгасан байна: *“Компанийн оноосон нэр нь бусад компани, өөр хуулийн этгээдийн оноосон нэртэй давхардаагүй байх бөгөөд компани оноосон нэрээ бүртгэх байгууллагад бүртгүүлснээр түүнийг хэрэглэх онцгой эрхтэй болно”*.

Үүнд, дээрх зохицуулалтыг хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлалыг хэрэглэх арга замаар МУИС болон МҮИС гэх нэрийн маргаантай асуудлыг шийдвэрлэх эрх зүйн үндэслэлийг гаргах боломжтой байж болно.

Үүний тулд юуны өмнө хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлалын талаар товч дурдъя.

##### **4.1. Хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлал**

Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-т хуульчилсны дагуу “Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төстэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ”.

Хуулийг буюу хуульд агуулагдаж буй хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлал нь тодорхой нэг харилцаа буюу урьдчилсан нөхцөл практик амьдралд бий болсон байхад түүнийг зохицуулсан холбогдох эрх зүйн зохицуулалт үгүй бол түүнийг зохицуулах зохицуулалтыг буюу эрх зүйн үр дагаврыг тухайн нөхцөл байдалтай төстэй харилцааны хувьд шилжүүлэн хэрэглэж буй процесс юм.<sup>4</sup>

<sup>4</sup> Diederichsen, AcP 1998., 198, S. 176f.

Хуулийг төсөөтэй хэрэглэж буй аргачлал нь адил төстэй харилцааг буюу ашиг сонирхлын байдлыг адил төстэй байдлаар зохицуулна гэх “тэгш байдлын зарчмын” илрэл гэж тооцогддог.<sup>5</sup>

Улмаар, хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлалыг хэрэглэх буюу шалгах урьдчилсан нөхцөлийн талаар толилуулах нь зүйтэй болов уу.<sup>6</sup>

#### *4.1.1. Хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх урьдчилсан нөхцөл*

Хуулийн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэхэд дараах аргачлалыг хэрэглэдэг байна:

- Хуулиар зохицуулагдаагүй харилцаа болон төсөөтэй хэрэглэх гэж буй хэм хэмжээгээр зохицуулагдсан харилцааны адил, төсөөтэй, нийтлэг талыг олж тогтоох;
- Хуулиар зохицуулаагүй харилцаа болон төсөөтэй хэрэглэх гэж буй хэм хэмжээгээр зохицуулагдсан харилцааны ялгаатай шинж, талыг тодорхойлон тогтоох;
- Хуулиар зохицуулагдаагүй харилцаа болон төсөөтэй хэрэглэх гэж буй хэм хэмжээгээр зохицуулагдсан харилцааны ялгаатай шинж нь төсөөтэй хэрэглэхэд саад болж болох талаарх дүгнэлт гаргах.<sup>7</sup>

#### **4.2. Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтыг төсөөтэй хэрэглэх нь**

Юуны өмнө аж ахуйн нэгж болох компани болон төрийн өмчит их сургууль, хувийн хэвшлийн их сургууль буюу төрийн бус байгууллагын нийтлэг талуудыг тодорхойлон гаргах шаардлагатай.

##### *- Нийтлэг тал*

Аж ахуйн нэгж гэдэг нь сайн дурын үндсэн дээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн буюу бизнесийн үйл ажиллагаа эрхэлж, ашиг орлого олоход чиглэгдсэн ашгийн төлөө хуулийн этгээдийг ойлгодог.

Төрийн өмчит их сургууль гэдэг нь төрийн өмч дээр суурилсан, үйл ажиллагаа нь төрийн өмчийн холбогдох хуулиудаар зохицуулагддаг, дээд боловсрол олгоход чиглэгдсэн боловсролын байгууллагаа бөгөөд хуулийн этгээд болох нь маргаангүй. Үүнтэй харьцуулбал хувийн хэвшлийн их дээд сургуулиуд мөн адил дээд боловсрол олгоход чиглэгдсэн хувийн өмч дээр суурилан үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд. Боловсролын хуульд орсон өөрчлөлтийн дагуу ашгийн төлөө хуулийн этгээд байх боломжтой.

Тухайлбал, Боловсролын тухай хуулийн 3.1.17 зүйлд заасны дагуу “ашгийн төлөө боловсролын байгууллага гэдэг нь оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, ашиг олох зорилгоор сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд” -ийг ойлгодог байна. Улмаар, боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн төлөө хуулийн этгээд нь компанитай төстэй шинж агуулж байна.

Үүнээс дүгнэвэл, компани болон төрийн ба хувийн хэвшлийн их дээд сургуулиуд тодорхой үйл ажиллагаа эрхлэх зорилгоор байгуулагдсан нэгдэл буюу тодруулбал хуулийн этгээд болж буй нь нийтлэг тал нь байна.

##### *- Ялгаатай тал*

Төрийн болон хувийн хэвшлийн их дээд сургууль болон компанийн ялгаатай тал нь юуны өмнө эдгээр хуулийн этгээдийн эрхэлж буй үйл ажиллагаагаар илэрдэг гэж хэлж болно.

Төрийн өмчит болон хувийн хэвшлийн их дээд сургуулиуд нь зөвхөн дээд боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа эрхлэх бөгөөд энэхүү үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тодорхой нөхцөл хангагдсанаар олж авах боломжтой.

<sup>5</sup> Zippelius, Methodenlehre, S.62.

<sup>6</sup> Төсөөтэй хэрэглэх аргачлалын талаар дэлгэрэнгүй байдлаар “Иргэний эрх зүйн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлал” өгүүллэл “Эрх зүй” сэтгүүлийн 2019 оны дугаар 3-т хэвлэгдсэн болно.

<sup>7</sup> Zippelius, Juristische Methodenlehre, S.62, Canaris, Methodenlehre, S.203.

Харин аж ахуйн нэгж болох компани нь өөрийн үйл ажиллагааны хүрээг дээд боловсрол олгоход биш, харин хуулиар хориглоогүй аж ахуйн дурын үйл ажиллагаа, үйлчилгээ эрхлэх боломжтой салбарт явуулдгаараа боловсролын байгууллагаас ялгагддаг. Ингэхдээ юуны өмнө ашиг олох үндсэн зорилгод чиглэгдсэн байх нь тодорхой.

- *Ялгаатай тал нь хуулийг төсөөтэй хэрэглэхэд саад болох эсэх*

Төрийн болон хувийн өмчит их дээд сургуулиуд ба компанийн ялгаатай шинж нь Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг төсөөтэй хэрэглэхэд саад болохгүй гэж үзэх үндэслэлтэй. Учир нь сургалт, дээд боловсрол олгох үйл ажиллагаа эрхэлж байгаа эсхүл ашгийн төлөө дурын өөр салбарт үйл ажиллагаа эрхэлж буй асуудал нь их дээд сургууль, компанийн өөрийн нэртэй байх, өөрийн нэрээрээ олонд танигдах, өөрийн үйл ажиллагаа үйлчилгээг бусад хуулийн этгээдээс ялгах зорилго нь адил байх бөгөөд адил төстэй зохицуулалттай байх нь маргаангүй.

**4.3. Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн зохицуулалтыг тайлбарлах нь**

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг төрийн болон хувийн өмчит их дээд сургуулиудын хувьд төсөөтэй хэрэглэж болно гэж дүгнэсэн боловч, тус зохицуулалтын хамрагдах хүрээ буюу тодорхой ямар асуудлыг зохицуулсан талаар маргаан, эргэлзээ үүсч болох юм. Тухайлбал, тус зүйлд *“Компанийн оноосон нэр нь бусад компани, өөр хуулийн этгээдийн оноосон нэртэй давхардаагүй байх бөгөөд компани оноосон нэрээ бүртгэх байгууллагад бүртгүүлснээр түүнийг хэрэглэх онцгой эрхтэй болно.”* гэж хуульчилсан байна.

Үүнд, “давхардсан байна” гэх ойлголтын агуулгын талаар маргаан үүсэх боломжтой. Давхардана гэдэг нь нэг буюу хоёр үг адил байхыг, эсхүл нэрийг бүрэн эхээр нь авсан байхыг ойлгох уу гэх асуудал зүй ёсоор тавигдана. Энэхүү эргэлзээг тайлахын тулд хэм хэмжээг буюу тус заалтыг түүний зорилгынх нь дагуу тайлбарлах буюу “телеологийн редукцийн аргыг”<sup>8</sup> хэрэглэх боломжтой юм.

Телеологийн редукцийн аргын дагуу Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн гол зорилго нь хоорондоо хамааралгүй компани, хуулийн этгээдийг оноосон нэрээр нь хооронд нь хамааралтай болгох, хольж хугтах, төөрөгдөлд оруулах эрсдэл буюу аюулаас хамгаалахад чиглэгдсэн гэж хэлж болно. Хуулийн этгээд өөрийн оноосон нэртэй байна гэдэг нь энэхүү нэрээрээ бусад хуулийн этгээдээс өөрийгөө ялгах зорилготой байдаг. Харин энэ нэр нь бусад нэртэй адил, төстэй байх нь энэхүү эрсдэлийг бий болгож буй нь гарцаагүй. Иймд, тус заалтын агуулгыг өргөн утгаар тайлбарлаж, хуулийн этгээдийг хооронд нь хольж эндүүрэх төөрөгдөлд оруулахаас урьдчилан сэргийлж хамгаалсан зохицуулалт байна гэж тайлбарлах бүрэн боломжтой.

Энэ тохиолдолд, хэдийгээр Монгол Улсын Их сургууль ба Монгол Үндэсний Их сургууль нь авиа зүйн дуудлагаараа өөр байгаа боловч, нэрийн товчлол нь МУИС ба МҮИС хоёр нь иргэдийг төөрөгдөлд оруулах эрсдэлтэй нь гарцаагүй.

## ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэр үндэслэлтэй байх гэх шаардлагыг хангах үүднээс тухайн харилцааг зохицуулсан хууль, хэм хэмжээ байхгүй тохиолдолд хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлалыг хэрэглэх бүрэн боломжтой байна. Үүний тулд хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлалыг ойлгож, бүрэн эзэмшсэн байх нь хангалттай.

Ингэснээр шүүхийн шийдвэр үндэслэлтэй байх гэх шаардлагыг хангах гол урьдчилсан нөхцөл буюу хөшүүрэг нь иргэний эрх зүйд үйлчилдэг “адил төстэй харилцааг адил байдлаар зохицуулна” гэх зарчим болж буй юм.

<sup>8</sup> B.Ruethers, Rechtstheorie, S. 509., Creifelds, Rechtswoerterbuch, S.1302



**ЭХ СУРВАЛЖ**

1. Canaris, Methodenlehre der Rechtswissenschaft, Verlag Springer, 1995.
2. Zippelius, Juristische Methodenlehre, Verlag C.H. Beck, 2012.
3. В. Ruethers, Rechtstheorie, 4. Auflage, 2009
4. Creifelds, Rechtswoerterbuch, 20. Auflage, 2006
5. Diederichsen, Асп, 1998, 198.
6. Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхишиг, Иргэний эрх зүй ерөнхий анги, 2012.
7. Б.Тэмүүлэн, Иргэний эрх зүйн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлал, “Эрх зүй” сэтгүүл №3(2019).

**THE USE OF ANALOGIES AND PURPOSIVE INTERPRETATION  
METHODS IN DECIDING CASES**

*Temuulen B. (Ph.D.)*

*Associate professor at the Private Law Department of School of Law, NUM*

**ABSTRACT:**

Without a doubt, it is impossible to regulate all social relations with the help of laws. There is a lack of legal regulation of certain issues. In such cases, the substantiated part of court decisions undoubtedly causes a lot of criticism. In order to decide on litigation in the absence of legal regulation, requires highly qualified skills in the application of laws from the judge. In order to make a certain contribution to the solution of this problem, this article is directed, in which, based on a critical analysis of a certain court decision, an example of the application of the method of teleological reduction, and the analogy of the application of a legal norm is shown.

**KEYWORDS:**

Teleological reduction, Analogy of the application of a legal norm, Title, Confusion



## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ



*Т.Алтангэрэл  
Арбитрч, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн  
докторант*

### **ТОВЧЛОЛ:**

Энэхүү товч өгүүллээр Монгол Улсын дотоодын болон олон улсын эрх зүйн эх сурвалжид хөрөнгө оруулалтыг хэрхэн тодорхойлж буй талаар хөндөхийг зорилоо. Хөрөнгө оруулалтыг хэрхэн ямар шалгуураар, ямар хүрээгээр тодорхойлохоос хамааран олон улсын болон дотоодын эрх зүйн эх сурвалжийн хамгаалалтад багтах эсэх, хөрөнгө оруулалтын маргааны арбитрын харьяаллыг тогтоох зэрэгт чухал ач холбогдолтой байдаг. Хөрөнгө оруулалтын талаарх ойлголтыг манайд нэгдмэл болгох нийтлэг хэрэгцээ шаардлага байгааг харгалзан түүнийг хэрхэн зөв тодорхойлох талаар тус өгүүллээр хөндөхийг хичээлээ.

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хууль болон ихэнх олон улсын гэрээ конвенцид хөрөнгө оруулалтыг өргөн агуулгаар, хөрөнгөд суурилсан, ямар нэг хязгаарлалтгүй байдлаар тодорхойлсон байна. Харин 2016 онд байгуулсан Канад-Монгол Улс хоорондын хоёр талт хэлэлцээрээр хөрөнгө оруулалтад аж ахуйн нэгжид суурилсан хөрөнгө оруулалтыг хамруулахаар заасан. Ингэснээр үндсэндээ Монгол Улсад байгуулсан аж ахуйн нэгжээр дамжуулан хэрэгжих шууд хөрөнгө оруулалтыг дэмжих зорилготой гэж харагдаж байна. Түүнчлэн дээрх хоёр талт хэлэлцээрт хөрөнгө оруулалтад хамаарахгүй богино хугацааны арилжааны гэрээ, зээлийг тусгаж өгсөн нь хэт өргөн агуулгатай хөрөнгө оруулалтын хамгаалалтад оруулж буй зүй ёсны хязгаарлалт юм.

Монгол Улсын Засгийн газрын хариуцагчаар оролцсон арбитрын практикийг харвал хөрөнгө оруулалт бодитойгоор хийгдсэн эсэх, зээл мөн эсэх, гэрээ болон хоёр талт олон улсын хэлэлцээрийн арбитрын хэлэлцээрийн хамрах хүрээ зэргийг нарийвчлан хянаж үзсэний үндсэн дээр тухайн хөрөнгө оруулалтын маргааныг хянах эсэх (*ratione materiae*) арбитрын харьяаллын тогтоож байсан туршлага байна.

Хөрөнгө оруулалтын тодорхойлолтыг орчин үеийн чиг хандлагатай уялдуулан өргөн хүрээний, олон төрлийн хөрөнгийг тоочих байдлаар бус харин түүний объектив шинжээр нь илүү тодорхой байдлаар хуульд тусгах асуудлыг хөндөв.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Гадаадын шууд хөрөнгө оруулалт, Хөрөнгө оруулалтын хоёр талт хэлэлцээр, Хөрөнгө оруулалтын тухай хууль

## ҮНДСЭН ХЭСЭГ

Хөрөнгө оруулагчид эрх зүйн тогтвортой орчныг хүсдэг. Тэр дундаа Монгол Улсад хууль эрх зүйн орчин тогтворгүй, байнга өөрчлөгддөг, хуулийн хэрэглээ төрийн байгууллага болон шүүхэд нэгдмэл байж чаддаггүй гэсэн шүүмжлэл их гардаг. Тиймээс хөрөнгө оруулалтын талаарх ойлголтыг манайд нэгдмэл болгох нийтлэг хэрэгцээ шаардлага байгааг харгалзан түүнийг хэрхэн зөв тодорхойлох талаар тус өгүүллээр хөндөхийг хичээлээ.

### 1. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай товч ойлголт

Юуны өмнө хөрөнгө оруулалтын тухай ойлголт, гадаадын хөрөнгө оруулалтын хэлбэр, сул болон давуу талуудыг товч авч үзэх бөгөөд ингэснээр хууль зүйн асуудлыг эдийн засгийн суурь ойлголттой нь уялдуулж, илүү сайн ойлгох, дүгнэхэд ач холбогдолтой юм.

Гадаадын хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, мэдлэг болон технологийг нутагшуулах, хүний нөөцийг чадавхжуулах, бизнес эрхлэлт болон бизнесийн өрсөлдөөн, соёлыг хөгжүүлэх зэрэг олон, судалгаагаар нотлогдсон давуу талуудыг тухайн улс оронд авчирдаг<sup>1</sup>. Дэлхийн ихэнх улс орнууд гадаадын чанартай хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрдөг учир хөрөнгө оруулалтыг татах аль болох таатай, нээлттэй бодлогыг хэрэгжүүлэхийг зорьдог. Монгол Улс ч гадаадын хөрөнгө оруулалтыг татах талаар өөрийн нөхцөл байдалд таарсан, боломжоороо чөлөөтэй, нээлттэй байж ирсэн<sup>2</sup>.

Гадаадын хөрөнгө оруулалт нь эергээс гадна мөн сөрөг үр дагавартай байх талтай бөгөөд үүнд тухайлбал, тухайн хүлээн авагч улсад хүний эрх зөрчигдөх, байгаль орчин сүйдэх, ажиллах хүчний хямд мөлжлөг гэх асуудлууд түгээмэл гардаг.

Орчин үеийн түүхээс харвал Германы томоохон химийн үйлдвэр болох Байер (Bayer) компани нь АНУ-д анх салбараа байгуулахад хэрэглэгчид дотоодын бүтээгдэхүүнийг илүүд үзэж, гадаадын бүтээгдэхүүнийг хураах ажиллагаа явагдсан учир тус компани цаашид хөрөнгө оруулалт хийх боломжгүй байдалд хүрч байжээ. 20-р зууны технологийн дэвшил, тухайлбал холбоо харилцаа, тээвэрлэлтийн хөгжил нь хил дамнасан хөрөнгө оруулалтыг өргөжихөд чухал ач холбогдолтой байсан. Дэлхийн 1-р дайнаас өмнө ихэнх хөрөнгө оруулалт ихэвчлэн АНУ, Их Британи, Франц, Герман зэрэг улсаас хийгддэг, тэдний хувьд байгалийн баялгийг ашиглах нь гол сонирхол байсан<sup>3</sup>.

Орчин үеийн гадаадын хөрөнгө оруулалтын түүх нь ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилго бүхий үндэстэн дамнасан томоохон корпорацуудын хөгжилтэй холбогддог. Тухайлбал, 2016 онд 60,000 гаруй үндэстэн дамнасан компаниуд дэлхийн бусад улс оронд 500,000 салбар нээж байсан гэсэн тооцоолол байдаг<sup>4</sup>. Дээрх томоохон корпорацуудын хувьд гадаадын зах зээлд чөлөөтэй нэвтрэх, хүлээн авагч улсын гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, дотоодын хямд ажиллах хүч болон байгалийн баялаг зэрэг нь чухал байдаг. Зах зээлийг нь эзлэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулах, хямд ажиллах хүчийн ачаар зардлаа хэмнэх, өөрийн улс дахь хатуу хууль дүрмээс зугатах гэх зэрэг янз бүрийн ашиг сонирхлууд корпорацуудад байдаг. Дээрхээс харвал, бизнес эрхлэгчдийн хувьд эдийн засгийн нөхцөлүүд нь хууль эрх зүйн хүчин зүйлээсээ илүү хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахад нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хүчин зүйлс болох байгалийн баялаг, хүний нөөцийн чадвар, зах зээлийн багтаамж, логистик тээвэрлэлт буюу дэд бүтэц зэрэг нь тухайн улсад хөрөнгө оруулалт хийх үү үгүй юу гэдэг шийдвэр гаргахад голлох үүрэг гүйцэтгэдэг гэсэн үг.

Монгол Улсын жишээн дээр ч энэ байдал харагдсан нь хэдийгээр тус улсын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин *de jure* буюу хууль зүйн хувьд харьцангуй таатай, нээлттэй хэдий ч хөрөнгө оруулалт татахад хангалтгүй байна. Учир нь нийт эдийн засгийн агуулгаараа хөрөнгө оруулалтын бодит орчин, уур амьсгал төдийлөн таатай бус байдаг

<sup>1</sup> C.Wren, J.Jones, Foreign Direct Investment and the Regional Economy (Ashgate Publishing 2012) p71.

<sup>2</sup> Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны шинэчлэл, Дэлхийн банк, 2018, 2 дахь тал.

<sup>3</sup> C.Wren, J.Jones, Foreign Direct Investment and the Regional Economy (Ashgate Publishing 2012); S.D.Cohen, Multinational Corporations and Foreign Direct Investment: Avoiding Simplicity, Embracing Complexity (OUP 2007) 45

<sup>4</sup> <https://espace-mondial-atlas.sciencespo.fr/en/topic-strategies-of-transnational-actors/article-3A11-EN-multinational-corporations.html#:~:text=At%20the%20present%20time%2C%20there,controlling%20more%20than%20500%2C000%20subsidiaries.>

нь хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэхгүй, буурах хандлагатай байгаагийн шалтгаан гэж дүгнэсэн байдаг<sup>5</sup>. Тухайлбал, үүнд Монгол Улсын өрсөлдөх чадвар, бизнесийн орчин<sup>6</sup> үзүүлэлтээр, эсвэл төрийн болон компанийн сайн засаглал, хууль эрх зүйн тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой байдал, хуулийн нэг мөр хэрэглээ зэргийг гол асуудалд дурдсан байдаг.

Гадаадын хөрөнгө оруулалт нь босоо болон хэвтээ хэлбэртэй, компани байгуулах, хувьцаа болон үнэт цаас худалдан авах (portfolio), компанийг нэгтгэх нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийгдэх боломжтой байдаг.

Хөрөнгө оруулалтын хэлбэрт хувьцаа эзэмших замаар шууд хөрөнгө оруулах эсхүл зөвхөн хувьцаа, үнэт цаас худалдан авах замаар портфолио хөрөнгө оруулалт хийх, хүлээн авагч улсад өмч хөрөнгө өмчлөх, эзэмших эрхтэй байх зэрэг мөн багтана. Портфолио буюу үнэт цаасны хөрөнгө оруулалт нь биет болон биет бус хөрөнгийг шилжүүлэхэд сул тал ихтэй, учир нь бодит хөрөнгө оруулалт хийгдэхгүй, зөвхөн хувьцаа үнэт цаас худалдан авдаг, мэдлэг технологи дамжуулах байдал нь учир дутагдалтай, иймээс ч эдийн засаг дахь бодитой нөлөөлөл багатайд тооцогддог. Хувьцаа эзэмшигч гадаадын хөрөнгө оруулагч бол илүү мөнгөн буюу ногдол ашиг орлого авах сонирхолтой байдаг. Тиймээс Монгол Улсад энэ төрлийн хөрөнгө оруулалт төдийлөн ач холбогдолтой биш юм.

Харин гадаадын шууд хөрөнгө оруулагч нь урт хугацааны ашиг сонирхолтой байдаг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулж буй улсад байгуулсан аж ахуйн нэгжид багагүй хэмжээний хувьцаа эзэмшин бизнесийн үйл ажиллагаагаа шууд удирдан явуулах явдал юм. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулагчийн эзэмших хувь эзэмшлийг 25% ба түүнээс дээш гэж хуульчилсан байгаа нь энэхүү урт хугацааны хөрөнгө оруулагчийн ашиг сонирхлыг илтгэж байна<sup>7</sup>.

Ийнхүү багагүй хувьцаа эзэмшсэнээр хөрөнгө оруулагч компанийн үйл ажиллагаанд илүү бодитой оролцох сонирхолтой байхаас гадна мэдлэг болон технологийг дамжуулдаг. Шууд хөрөнгө оруулагч нь нөхцөл байдал өөрчлөгдөхөд портфолио хөрөнгө оруулагч шиг шууд хувьцаагаа худалдаад тухайн улсаас шууд гарчихгүй зэрэг байдлаараа эдийн засгийн урт хугацааны үр өгөөж сайтай тул гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих нь илүү тохиромжтой байдаг. Хөрөнгө оруулагч өөрийн бизнесээ гадаад улсад шууд удирдах, хянах боломжтой шинж байдлаар нь гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж тодорхойлдог бөгөөд үүгээрээ шууд бус, үнэт цаасны портфолио хөрөнгө оруулалтаасаа эрс ялгардаг. Нөгөө талаар хөрөнгийн зах зээл сайн хөгжөөгүй, эрх зүйн зохицуулалт султай улсад хувьцааны хөрөнгө оруулагчийн ач холбогдол багатай учир хэдийгээр хувьцааны хөрөнгө оруулагч байхыг хуулиараа хязгаарлахгүй ч шууд хөрөнгө оруулалтыг бодлогын хувьд илүү дэмжих нь Монгол Улсын хувьд оновчтой байна.

Цаашлаад, компани нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх нь тухайн улсад үйл ажиллагаагаа явуулж буй компанийг худалдаж авах, нэгтгэх замаар хөрөнгө, үнэт цаас, эрх үүрэг шилжиж, шинэ хувьцаа эзэмшигчтэй болохыг хэлнэ. Тухайн улсын хуулиар хувьцааг худалдан авахад зөвшөөрсөн байх шаардлагатай. Хэдийгээр ийм хэлбэрийн хөрөнгө оруулалт нь мэдлэг, технологи дамжуулахад ихээхэн давуу талтай гэж үздэг ч дотоодын компанийг хямдаар худалдан авах, дотоодын ажлын байр багасгах, өрсөлдөөнийг хязгаарлах эрсдэл гэх зэрэг сул тал ихтэй.

Гадаадын хөрөнгө оруулалт нь мөн сөрөг болон сул талуудтай бөгөөд үүнд хөрөнгө оруулагч өөрийн ашиг орлогоо өөрийн улс руу шилжүүлэх, ийнхүү орлогоо шилжүүлснээр, мөн эдэлж буй татварын хөнгөлөлтүүдийн үр дүнд хөрөнгө хүлээн авагч улсад төвлөрөх төлөх татварын орлого буурах эрсдэл байдаг.

Томоохон компаниуд ашиг орлогод анхаарахаас тухайн улсын хөгжлийг чухалчлахгүй. Нийтийн эрх ашиг, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг үндсэн үүргээ болгосон төр ашиг орлого хайхад чиглэсэн хөрөнгө оруулагч хоёр өөр өөр зорилго чиглэлтэй гэдгийг байнга санах учиртай. Тийм ч учраас гадаадын хөрөнгө оруулалтыг сөрөг үр дагавар авчрах эрсдэлтэй тухай Ж.Стиглиц “ардчилсан дүрэм журамгүй улс оронд худалдаа бизнесийн

<sup>5</sup> Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны шинэчлэл, Дэлхийн банк, 2018, 2 дахь тал.

<sup>6</sup> Дэлхийн банкны Doing Business 2020, Монгол Улсын индекс

<sup>7</sup> Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.5 дахь заалт.

орчин нь шударга биш, хууль бодлого нь улс орны нийтлэг гэхээсээ илүү хүчирхэг компаниудын эрх ашгийг төлөөлөх болсон”<sup>8</sup> гэж дүгнэжээ.

Ялангуяа дотоодын эрх зүйн тогтолцоо нь сул хөгжсөн, авилгал, тэгш бус байдал газар авсан Монгол Улс шиг улсад нэг томоохон хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалахын тулд улс орон өөрөө хохирох эрсдэл байна. Тухайлбал, том хөрөнгө оруулагч таатай татварын орчныг лоббидох, өөртөө ашигтай таатай хууль батлуулах, авилгалыг өөгшүүлэх, нэр нөлөөгөө ашиглах байдал буурай улс орнуудад гарсаар байна. Хүний эрх ч зөрчигдөж, нутгийн иргэдийн бослого тэмцлийг дарсан үйл явдал тохиож байсан.

Гадаадын хөрөнгө оруулалтын бодлого нь гагцхүү олон улсын эрх зүйн эсхүл дан ганц үндэсний бус харин нэгдмэл, тэнцвэртэй харилцаа юм. Үүнд Монгол Улсын хувьд өөрийн эдийн засгаа өөрөө тодорхойлох эрх (гадаад эрх зүйгээс хамааралгүйгээр), олон улсын зах зээлд оролцох эрхийг хангах нь олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн ач холбогдол оршиж байна.

## 2. Хөрөнгө оруулалтын тухай ойлголт

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай ойлголт нь юуны өмнө эдийн засгийн ойлголтоос эхтэй. НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн зөвлөлдөх байгууллагаас (UNCTAD) гаргасан тодорхойлолтыг харвал гадаадын хөрөнгө оруулалт нь “урт хугацааны харилцаа бөгөөд уг харилцаа нь нэг улсын этгээдээс өөр улсын аж ахуй нэгжид бий болгож буй урт хугацааны, эрх мэдлийн, удирдлагын ашиг сонирхлыг илэрхийлдэг”<sup>9</sup>. Өөрөөр хэлбэл, гадаадын хөрөнгө оруулалт нь хил дамнан хувьцаа эзэмших явдал буюу аж ахуйн үйл ажиллагаагаа удирдан явуулах засаглал юм. Хувьцаа эзэмшиж, хөрөнгө оруулснаар урт хугацааны төслөөс ашиг орлого олох зорилготой бизнесийн үйл ажиллагаа гэж хэлж болно.

Хөрөнгө оруулалт нь эдийн засгийн ба хууль зүйн тодорхойлолтыг дотроо агуулдаг онцлогтой. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар эдийн засгийн тодорхойлолт нь дараах шинжийг багтаадаг а) хөрөнгө шилжүүлэх, б) урт хугацааны төсөл байх, в) тогтмол орлого олох зорилготой, г) хөрөнгө оруулагчийн менежментийн ямар нэг оролцоо, үүрэг е) бизнесийн эрсдэл бүхий гэсэн байна.

Харин хууль зүйн тодорхойлолтын хувьд хөрөнгө оруулалтыг хэрхэн тодорхойлж, хүрээ хязгаарыг нь хэрхэн тайлбарлахаас хамаарч түүнтэй холбоотой үүсэх маргаан нь шүүх, арбитрын харьяаллыг тогтооход чухал ач холбогдолтой байдаг. Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйд маргааны зүйл нь хөрөнгө оруулалт байх шалгуурыг *ratione materiae* гэж нэрлэдэг. Хөрөнгө оруулалт мөн эсэх, түүний шинж байдал, бодитроо хийгдсэн эсэхээс хамааран маргааны зүйлийг тодорхойлох бөгөөд хэрвээ хөрөнгө оруулалт биш бол холбогдох хөрөнгө олон улсын гэрээ конвенцын хамгаалалтад багтахгүй байх эрх зүйн үр дагавар үүсдэг. Хөрөнгө оруулалтын арбитрын практикт арбитрын харьяаллын талаар маргаан үүсгэх нь хариуцагч болох төрийн хувьд хамгийн эхэнд хэрэглэгдэж болох эрх зүйн хамгаалал болдог.

Хөрөнгө оруулалтын талаар дэлхий даяар олон талт олон улсын гэрээ конвенцууд болон хоёр талт хэлэлцээрт тодорхойлсон зүйл заалтууд олон бий ч нэгдмэл тодорхойлолтод хүрээгүй байдаг<sup>10</sup>. Ийм учраас олон улсын арбитрын шүүхийн практикаас харвал, *Salini v. Morocco*<sup>11</sup> хэрэгт хөрөнгө оруулалтыг тодорхойлох дөрвөн үндсэн шинжийг нэрлэсэн нь өнөөдөр хамгийн хүлээн зөвшөөрөгдсөн, нийтлэг иш татдаг Салини тестийн тодорхойлолт юм.

Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенцын (цаашид “ICSID конвенц” гэх) 25 дугаар зүйлд заасан “хөрөнгө оруулалт нь” дараах шинжийг агуулсан байхаар тус арбитрын хэрэгт шийдвэрлэсэн байна.

Үүнд,

- Урт хугацааны үйл ажиллагаа байх;
- Хөрөнгө (эсхүл өөр бусад нөөц, мэдлэг, ноу хау гэх мэт) оруулах, шилжүүлэх үүрэг;

<sup>8</sup> J.Stiglitz, Globalization and Development”, Taming the Globalization: frontiers of governance, (Polity 2003) p55.

<sup>9</sup> UNCTAD, Definitions and Sources, 2007, p245-249.

<sup>10</sup> Schreuer and Dolzer, Principles of International Investment Law p74.

<sup>11</sup> Salini v. Morocco, Decision on Jurisdiction, 23.07.2001

- Эрсдэлийг хүлээх;
- Хөрөнгө хүлээн авагч улсын эдийн засгийн хөгжилд ач холбогдол бүхий байх.

гэсэн шинжүүдийг багтаахыг хүлээн зөвшөөрдөг бол тогтмол ашиг орлого олох шинжийг төдийлөн ач холбогдолтой гэж үзэхгүй болсон байна<sup>12</sup>. Хөрөнгө оруулалтын уг объектив шинжүүд нь хөрөнгө оруулалтын суурь шинж болохыг хөрөнгө оруулалтын арбитрын хэргүүдэд хүлээн зөвшөөрсөн байдаг. Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хууль нь хөрөнгө оруулалтын шинжийн талаар дээрх байдлаар тусгагдсан эсэхийг доор харья.

Хөрөнгө оруулалтын тухай тодорхойлолтыг ямар эрх зүйн эх сурвалжид (хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээр, олон талт гэрээ конвенц гм) үндэслэхээс шууд хамаарч болохыг олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйд хүлээн зөвшөөрсөн гэж үзэж болно.

Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин нь гурван үндсэн үе шат, арга хэлбэрээр дэмжих, хамгаалах бодлого хэрэгжиж байгаа нь:

- Хөрөнгө оруулалтын тухай бие даасан үндэсний хууль тогтоомж<sup>13</sup>
- Хөрөнгө оруулалтын гэрээ<sup>14</sup>
- Олон улсын гэрээ конвенц<sup>15</sup> зэрэг юм.

Монгол Улсын хөрөнгө оруулалтын олон улсын эрх зүйн хэм хэмжээнд Засгийн газар хоорондын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хоёр талт хэлэлцээр (BIT), давхар татвараас чөлөөлөх гэрээ, олон талт гэрээ конвенцууд болох ICSID Конвенц, Эрчим Хүчний Харти (ЕСТ) гэх зэрэг хэд хэдэн конвенцууд орж байна.

Харин үндэсний хууль тогтоомжийн хувьд буюу дотоодын хөрөнгө оруулагчдад Хөрөнгө оруулалтын тухай хууль голлох үүрэгтэй билээ. Эдгээрт өөр өөр эх сурвалжид хөрөнгө оруулалтын талаар хэрхэн туссаныг доор авч үзье. Учир нь хөрөнгө оруулалтын маргаанд хөрөнгө оруулалтыг тодорхойлохдоо эдгээр эх сурвалжид үндэслэнэ.

### **2.1 Дотоодын хууль тогтоомжид хөрөнгө оруулалтыг тодорхойлсон байдал**

Монгол Улс нь 1990 онд чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэнээсээ хойш дэлхийн бусад улс орнуудын адилаар өөрийн хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах гэж сүүлийн гуч гаруй жил хүчин чармайлт гаргаж ирлээ. Энэ нь олон талт болон хоёр талт хөрөнгө оруулалтыг дэмжих олон улсын гэрээнүүдэд нэгдсэн орохоос эхлээд хөрөнгө оруулалт хийхэд дотооддоо таатай, нээлттэй эрх зүйн орчныг бүрдүүлэх гэсэн байдлаас илт харагдана.

Монгол Улс нь өнөөгийн байдлаар Улсын Их Хурлаас 2013 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр баталсан Хөрөнгө оруулалтын хуулийг дагаж мөрдөж байна<sup>16</sup>. Тус хуульд хөрөнгө оруулагчийн эрх үүргийг тусгаж өгсөн, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд хөрөнгө оруулагчдад нийтлэг эрх зүйн баталгаанууд олгосон бөгөөд үүнд, хөрөнгө оруулагчийн эрх, эд хөрөнгийг хамгаалах, албадан хураахгүй байх, ялгаварлахгүй байх, дэмжих, татварын орчныг тогтворжуулах, төрийн үйлчилгээ, бүртгэл хяналтыг хөнгөвчлөх зохицуулалтууд тусгалаа олжээ. Хөрөнгө оруулалтын хуулиар хөрөнгө оруулагчдыг гадаад, дотоод гэж ялгахгүйгээр ижил тэгш байхаар хуульчилсан нь анхаарал татаж байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 9-д “Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулагч нь төрийн байгууллагатай байгуулсан гэрээний харилцаанаас үүсэх маргааныг талууд харилцан тохиролцсоны дагуу гадаадын, эсхүл дотоодын арбитрыг томилон шийдвэрлүүлэх эрхтэй” гэсэн нь хөрөнгө оруулалт маргааны зүйл байхыг заасан байна. Төр болон хөрөнгө оруулагч хоорондын байгуулсан гэрээний маргаан гэж заасан нь хөрөнгө оруулалтын гэрээнд хамаарахаар харагдаж байна. Уг гэрээ нь тус хуулийн 20-р зүйлд заасан 500 тэрбум төгрөгөөс дээш дээш хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээнд хамаарах заалт байх боломжтой.

Тэгвэл хөрөнгө оруулалт гэдэгт юу хамаарах, ямар эд хөрөнгө байх талаар тус хуулийн 3.1.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн

<sup>12</sup> Schreuer and Dolzer, Principles of International Investment Law, p66.

<sup>13</sup> Хөрөнгө оруулалтын хууль (2013)

<sup>14</sup> Тухайлбал, Оюу Толгой ХХК -тай Монгол Улсын Засгийн газрын байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, бусад төстэй гэрээнүүд

<sup>15</sup> Үүнд, ICSID, BIT хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээ гэх зэрэг.

<sup>16</sup> Дэлхийн Банкны тусламжтайгаар боловсруулсан хууль.



хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг” хэлэхээр заажээ.

Үүнийг харвал хөрөнгө оруулалтын зорилго нь ашгийн төлөө байх талаас нь тайлбарлах боломжтой тодорхойлолт харагдаж байна. Түүнчлэн хөрөнгө оруулалтад шууд болон эд хөрөнгийн буюу шууд бус хөрөнгө оруулалтыг ойлгохоор тодорхойлсон байна.

Шууд хөрөнгө оруулалт нь түүхэн явцдаа эхлээд бодитоор, биет байдлаар оруулсан хөрөнгөөр хязгаарладаг байсан бол сүүлдээ мөн биет бус хөрөнгө, эрх, оюуны өмчийг хамааруулах болсон. Тухайлбал, барьцааны эрх, түрээсийн эрх гэх зэрэг нь мөн хөрөнгө оруулалтад хамааруулах болсон<sup>17</sup>.

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хууль дахь хөрөнгө оруулалтын тодорхойлолтыг харвал тус улсад гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгуулахыг Хөрөнгө оруулалтын хуулийн 3.1.5-т шаардаж байгаа ч хөрөнгө оруулалтыг шууд эд хөрөнгөд суурилсан шинжээр нь тодорхойлсон, хувьцаа худалдан авах портфолио хөрөнгө оруулалтын хэлбэрийг мөн хуулийн 5.1.2-д зөвшөөрсөн байна (энэ нь Монгол Улсын байгуулсан хуулийн этгээдийн хувьцаа). Үүнээс харвал хөрөнгө оруулалтын шууд буюу аж ахуйн нэгжид суурилсан (enterprise based) болон шууд бус буюу эд хөрөнгөд суурилсан (asset based) хөрөнгө оруулалтыг аль алиныг нь хамруулсан өргөн агуулгаар тодорхойлсон харагдаж байна.

Мөн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25% буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг хэлэхээр заажээ. Монгол Улсад хөрөнгө оруулагч дөнгөж нэвтрэхэд тавьж буй босго хөрөнгө оруулалтын хэмжээ шаардаж байгаа нь хөрөнгө оруулалтын хуулийн хамгаалалт шууд үйлчлэхгүй, харин дээрх шалгуурыг хангасан тохиолдолд хамаарахаар байна. Тиймээс хөрөнгө оруулалтын өмнөх үе шат хууль зүйн хамгаалалтын зүйл болох уу гэдэг нь асуудал хэвээр юм.

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын хуульд ашгийн төлөө этгээдийн үйл ажиллагаа гэж заасан нь олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн чиг хандлагаас зөрүүтэй байна. Өөрөөр хэлбэл, тухайн хөрөнгө оруулалт нь ашиг орлоготой байх, эсхүл тийм зорилгод нийцэх ёстой гэсэн зайлшгүй шаардлага болгож хуульчилж оруулснаараа шууд хөрөнгө оруулалтын дээр дурдсан үндсэн дөрвөн шинжээс илүү хөрөнгө тоочих байдлаар, өргөн агуулгаар зохицуулсан гэж үзэхээр байна.

## **2.2 Олон улсын эрх зүйн эх сурвалжид хөрөнгө оруулалтыг тодорхойлсон байдал**

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын эх сурвалжууд болох хөрөнгө оруулалтын хоёр талт хэлэлцээр болон Эрчим Хүчний Харти, ICSID Конвенц зэрэгт хөрөнгө оруулалтын талаар тодорхойлолтууд бий.

Эрчим Хүчний Хартийн 1(6)-д “хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулагчийн шууд болон шууд бус өмчлөл, эзэмшил, эсхүл хяналтад байгаа эд хөрөнгө<sup>18</sup>” багтаж байна. Цаг хугацааны хувьд тус гэрээ конвенц хүчин төгөлдөр болсноос хойшхи хөрөнгө оруулалтад хамаарахаар зохицуулалттай.

ICSID конвенцын 25.1-д гишүүн улс болон хөрөнгө оруулагч хоорондын “хөрөнгө оруулалттай холбоотой шууд үүсэх аливаа эрх зүйн маргаан”-ыг тус төв харьяалан шийдвэрлэхээр заасан байдаг. Дээр өгүүлсэнчлэн, Салини шалгуур нь тус конвенцид заасан “хөрөнгө оруулалтын” шинжүүдийг тодорхойлсон байна.

Тэгвэл Монгол Улсын байгуулсан хөрөнгө оруулалтын хоёр талт хэлэлцээр бүрт хөрөнгө оруулалтыг тодорхойлсон байх бөгөөд хамгийн сүүлд 2016 онд байгуулагдсан Монгол-Канадын хэлэлцээрт хөрөнгө оруулалтад зөвхөн аж ахуйн нэгжээр дамжуулан хийх (enterprise based) хөрөнгө оруулалтад хамруулахаар заасан байна. Тус гэрээний 1

<sup>17</sup> M.Sornarajah, International Foreign Investment Law, p18.

<sup>18</sup> Үүнд, биет болон биет бус, хөдлөх болон үл хөдлөх өмч, түрээс, үл хөдлөх өмчийн баталгаа, дэнчин, барьцаа зэрэг өмчийн аливаа эрх; компани, ахуйн нэгж, хувьцаа, компани буюу аж ахуйн нэгжид оролцох бусад хэлбэр, бонд болон аж ахуйн нэгжийн өрийн бусад хэлбэр; мөнгөн нэхэмжлэл, хөрөнгө оруулалттай холбогдолтой эдийн засгийн хувьд үнэ бүхий гэрээ, хэлцлийн гүйцэтгэлийн шаардлага; оюуны өмч, орлого, үйл ажиллагаа явуулах лиценз, зөвшөөрөл багтана.

дүгээр зүйлийн “хөрөнгө оруулалт” гэх тодорхойлолтод аж ахуйн нэгж, аж ахуйн нэгжийн хувьцаа, өрийн бичиг, зээл, ногдол ашиг, концесс, оюуны өмч, эдийн засгийн үр ашиг олох зорилгоор авсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө хамаарахаар, харин арилжааны гэрээ, арилжааны зээл хамаарахгүй байхаар зохицуулсан нь бусад хэлэлцээрийг харвал илүү тодорхой, хамрах хүрээ нь нарийвчилсан байна.

Энэхүү аж ахуйн нэгжид суурилсан хөрөнгө оруулалт нь уламжлалт, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг орлон шинээр гарч ирсэн олон улсын тодорхойлолт бөгөөд хөрөнгө оруулалтыг нарийвчилсан агуулгаар тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, тухайн улсад байгуулсан эсхүл худалдаж авсан аж ахуйн нэгжээр дамжуулан хийх хөрөнгө оруулалтыг шууд хөрөнгө оруулалт гэж тодорхойлдог. Харин өргөн агуулгаар тодорхойлох хөрөнгө оруулалт нь хувьцааны буюу портфолио хөрөнгө оруулалт, уламжлалт байдлаар эд хөрөнгөд суурилсан, биет болон биет бус эд хөрөнгө гэсэн өргөн хүрээний хөрөнгө оруулалтыг хамардаг. Гадаадын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж гэдэгт өөрийн улсаас өөр улсад бүртгэлтэй эсхүл байршилтай байх үндсэн шалгуур тавьдгаас гадна хөрөнгө оруулагч аж ахуйн үйл ажиллагаагаа удирдах, хяналт тавих байдлаар оролцохыг зөвшөөрдөг. Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуулиар тус улсад хуулийн этгээд байгуулах замаар гадаадын хөрөнгө оруулагч болохыг шаардаж байгаа ч эдгээр компанийн удирдлага, хяналтыг гадаадын хуулийн этгээд хэрэгжүүлж байвал түүнийг гадаадын хөрөнгө оруулагчид мөн адил тооцдог<sup>19</sup>.

Нидерланд-Монгол Улсын хоорондын хоёр талт хэлэлцээрийн 8-р зүйлд “гишүүн орны нутаг дэвсгэр дээр хөрөнгө оруулагчийн хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой үүсэх эрх зүйн маргаан” гэсэн байдаг. Хөрөнгө оруулалт нь шинжийнхээ хувьд хөрөнгө оруулалтад нийцэж байвал тус маргаан нь олон улсын арбитрын харьяаллын маргаан болдог.

Хөрөнгө оруулалт нь өөрөө аль улсаас эх үүсвэртэй байх нь шийдвэрлэх хүчин зүйл бус харин хөрөнгө оруулагч иргэн, эсвэл аж ахуйн нэгж нь гадаадын иргэншилтэй эсвэл бүртгэлтэй (байршилтай) байх нь чухал гэж үзсэн арбитрын шийдвэр байдаг<sup>20</sup>.

Түүнчлэн хөрөнгө оруулалтад ямар эд хөрөнгө хамаарахыг гэрээ конвенц, хууль тогтоомжид заахаас гадна түүнд хамаарахгүй зүйлийг мөн дурдах нь чухал ач холбогдолтой байдаг. Тухайлбал, хөрөнгө оруулалтад ердийн зээл, худалдаа, арилжааны гэрээ зэргийг хамаарахгүй байхаар зааж болох юм. Үүний нэг жишээ гэвэл Канад - Монгол Улсын хөрөнгө оруулалтын хоёр талт хэлэлцээрт богино хугацааны арилжааны гэрээ, зээл зэрэг хөрөнгө оруулалтад хамаарахгүй байхаар зохицуулсан байна.

Хөрөнгө оруулалтыг биет хөрөнгөөр хязгаарлах нь нарийн агуулгаар тодорхойлсон гэж тооцогддог бол өргөн агуулгаар биет бус хөрөнгө, үүнд ямар төрлийн хөрөнгө багтах талаар гэрээ болон олон улсын гэрээнд заасан байдаг. Жишээ нь, хувьцаа, гэрээний үүрэг, зээл, захиргааны үүрэг гм хөрөнгөд хамаарах эсэх талаар тодорхой заах шаардлагатай байна. Монгол Улсын хөрөнгө оруулалтын талаарх тодорхойлолт өргөн агуулгатай, ямар нэг хязгаарлалтгүй, хөрөнгөд суурилсан байгааг аж ахуйн нэгжид суурилсан, тодорхой хязгаарлалт бүхий байхаар тодорхойлох нь шууд хөрөнгө оруулалтыг дэмжих, эдийн засгийн төрөлжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх талаасаа илүү ач холбогдолтой байна.

### **2.3 Хөрөнгө оруулалтыг тодорхойлсон олон улсын арбитрын практик**

Монгол Улсын Засгийн газрын хариуцагчаар орсон олон улсын арбитрын хэргүүдийн практикийг харвал ОХУ-н хөрөнгө оруулагч С.В.Паушоктой холбоотой хэрэгт ОХУ-Монгол хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн 1-д хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулагчийн оруулсан хөрөнгийг хамрахаар заасан. Тиймээс хариуцагч хөрөнгө оруулалтад аж ахуйн нэгж шууд хамаарахгүй, зөвхөн хөрөнгө оруулагчийн хөрөнгө хамаарна гэж маргасан байдаг. Учир нь, хөрөнгө оруулагч Монгол Улсад цаасан дээрх хэд хэдэн компани үүсгэн байгуулж бүртгүүлсэн, хувьцааг нь эзэмшиж байгаа нь хөрөнгө оруулсан гэдгийг нотлоход хангалтгүй юм. Шууд хөрөнгө оруулсан гэх мөнгө нь зээл, эх үүсвэр нь тодорхойгүй гэж хариуцагч маргасан бол нэхэмжлэгчийн зүгээс хувьцаа эзэмшил бол хөрөнгө оруулалтын

<sup>19</sup> ICSID 25 (2)(b)

<sup>20</sup> *Tradex v Albania*, Арбитрын шийдвэр, 29.04.1999

хоёр талт гэрээний 1(б)-д шууд заасан, хамгаалагдсан хөрөнгө оруулалт мөн гэж маргасан. Арбитрын бүрэлдэхүүн Монгол Улс, ОХУ хоорондын хоёр талт хэлэлцээрийн 1(б)-д хөрөнгө оруулалтыг өргөн агуулгаар тодорхойлсон болохыг хүлээн зөвшөөрч, хөрөнгө оруулагчийн хөрөнгө төдийгүй түүний байгуулсан компани, хувьцаа эзэмшилд хамаарч байна гэж үзсэн. Мөн зээлийн хувьд зээлдүүлэгч гуравдагч этгээдийн зүгээс ямар нэг нэхэмжлэл гаргаагүй, хөрөнгө оруулагч зээлийг бүрэн эргүүлэн төлсөн тул зээлтэй холбоотой хариуцагчийн гомдлыг хэрэгсэхгүй орхисон<sup>21</sup>.

Харин Канадын хөрөнгө оруулагч Хан Ресорсес болон Засгийн газар хоорондын арбитрын хэрэгт хөрөнгө оруулагч болон төр хоорондын байгуулсан үүсгэн байгуулах гэрээг үндэслэн гэрээнээс үүдэх аливаа маргааныг арбитр харьяалахаар заажээ. Ингэхдээ хөрөнгө оруулагчийн зүгээс хөрөнгө хураан авсан, итгэлцлийн үүрэг зөрчсөн, олон улсын гэрээ зөрчсөн гэдгээр нэхэмжлэл гаргасан<sup>22</sup>.

Тэгвэл Төмөртэй ордыг ашиглахтай холбоотой хөрөнгө оруулалтын маргаантай холбоотойгоор Хятадын хөрөнгө оруулагч, Монгол Улсын Засгийн газар хооронд үүссэн маргаанд Монгол Улс, БНХАУ хооронд байгуулсан хоёр талт хэлэлцээрийг үндэслэн хөрөнгө оруулалтын маргаан мөн эсэхийг арбитр хянасан байдаг. Хөрөнгө оруулалтын хоёр талт хэлэлцээрийн 1(1)-д хөрөнгө оруулагчийн хуулийн дагуу хөрөнгө оруулсан бүх төрлийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад тооцохоор заасан. Тухайлбал, хувьцаа, үнэт цаас, хуулиар олгосон тусгай зөвшөөрөл, байгалийн баялгийг ашиглах эрх багтахаар тусгасан байна. Хөрөнгө оруулагч нь компанийн хувьцаа эзэмшлээ “шууд хөрөнгө” оруулалт хийсэн гэж, мөн Төмөртэй ордыг эзэмших ашигт малтмалын тусгай зөвшөөрлөө “шууд бус хөрөнгө оруулалтад” тооцон Хөрөнгө оруулалтын хоёрт талт гэрээгээр шууд болон шууд бус хөрөнгө оруулалтыг хамгаалахаар байна гэж маргасан байдаг. Харин Монгол Улсын Засгийн газар буюу хариуцагчийн зүгээс хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалт нь залилан, хулгайн замаар бий болсон, хөрөнгө оруулалтын хоёр талт хэлэлцээрийн 8(3)-т заасан арбитрын хэлэлцээр нь нэхэмжлэгчийн маргааны зүйлд хамаарахгүй, мөн Хятадын компаниуд нь хөрөнгө оруулагчид биш, хэлэлцээрийн 1(2) дагуу эдийн засгийн хуулийн этгээдэд хамаарахгүй гэж маргасан байдаг. Хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалт хийгээгүй учир нь түүний хөрөнгө оруулалтад ямар нэг хөрөнгө оруулалтын эрсдэл учраагүй гэсэн тайлбар нь хөрөнгө оруулалтын талаарх тодорхойлолтын агуулгад нийцүүлсэн харагдаж байна. Уг хэрэг нь Монгол Улс, БНХАУ хоорондын хөрөнгө оруулалтын хоёр талт хэлэлцээрээр *ratione materiae* нь хөрөнгө хураан авахтай холбоотой үүссэн нөхөн төлбөрийн хэмжээтэй холбоотой маргааныг арбитр харьяалахаар байгааг тогтоосноороо чухал ач холбогдолтой шийдвэр болсон гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газар хариуцагчаар оролцсон дээрх арбитрын хэргүүдийг харвал маргааны зүйл болох хөрөнгө оруулалтын талаарх хоёр талт гэрээний тодорхойлолтыг хэрэг тус бүрээр нарийвчлан үйл баримт (хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтаа нотлох байдлаар) болон олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн арбитрын практикт үндэслэн шийдвэрлэж байна. Монгол Улсын байгуулсан хоёр талт хэлэлцээр хоорондыг харьцуулбал хөрөнгө оруулалтыг нийтлэг байдлаар ч, ялгаатай байдлаар ч тодорхойлсон харагдаж байна. Хөрөнгө оруулалттай холбогдон гардаг хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрхийг хамгаалахад шүүхийн маргаан, олон улсын арбитрын ажиллагаа нь шударга шүүх, нийгэмд хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг.

### 3. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хөрөнгө оруулалтын талаарх олон улсын эрх зүйн тогтсон, нэгдмэл тодорхойлолт байхгүйгээс улс орнууд уг ойлголтын хүрээг хязгаарлах буюу зарим төрлийн хөрөнгийг хасах, үндэсний хууль тогтоомжийн дагуу тодорхойлох гэж оролдож ирсэн байдаг. Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хууль болон ихэнх хоёр талт олон улсын хэлэлцээрүүдэд хөрөнгө оруулалтыг өргөн агуулгаар буюу бүхий л төрлийн хөрөнгийг хамруулсан нь нэг

<sup>21</sup> Арбитрын шийдвэр С.В.Паушок v. Монгол Улсын Засгийн газар, 40 дэх тал.

<sup>22</sup> Арбитрын шийдвэр Хан Ресорсес v. Монгол Улсын Засгийн газар, 89 дэх тал.



талаасаа хөрөнгө оруулалтыг дэмжих сайн талтай ч нөгөө талаасаа төрийн хүлээх үүрэг нэмэгдэн хөрөнгө оруулалтын арбитрын маргаанд татагдах эрсдэлийг ихэсгэх боломжтой байна. Харин сүүлийн үеийн буюу 2017 онд байгуулсан Канад-Монгол Улс хооронд байгуулсан хоёр талт хэлэлцээрээр хөрөнгө оруулалтыг илүү тодорхой, илүү нарийвчилсан хүрээгээр тогтоосон, өөрөөр хэлбэл Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтыг хамгаалаахаар заасан. Хөрөнгө оруулалтыг тодорхойлохдоо зөвхөн хөрөнгийн хэлбэрийг тоочих байдлаар бус харин түүний объектив шинжээр буюу Салини тестийн дагуу үндэсний хууль тогтоомждоо тусгах нь хөрөнгө оруулалтын эдийн засгийн зориулалт, үр өгөөж, хугацаа, оруулах хөрөнгийн хэмжээ зэрэг хүчин зүйлсийн үр ашгийг нэмэгдүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж дүгнэж байна.

### **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:**

*Монгол хэлээр:*

ГХО - гадаадын хөрөнгө оруулалт

АНУ- Америкийн Нэгдсэн Улс

ОХУ- Оросын Холбооны Улс

БНАУ – Бүгд Найрамдах Австри Улс

БНХАУ-Бүгд Найрамдах Хятад Улс

БНСУ- Бүгд Найрамдах Солонгос Улс

ОУХОМШТ- Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Маргаан Шийдвэрлэх Төв

ОУХОМШ Конвенц

*Англи хэлээр:*

BIT- Bilateral Investment Treaty

ECT – Energy Charter Treaty

ICSID – International Center for Settlement of Investment Disputes

UNCTAD – United National Conference on Trade and Development

### **THE DEFINITION OF INVESTMENT**

*Altangerel T.*

*Arbitrator, Ph.D. candidate of School of Law, NUM*

#### **ABSTRACT:**

This paper discusses how investment is determined in international and national legal sources. Depending on the investment characteristics and scope determined by law, it can be identified what kind of protection exists and what is the jurisdiction of the dispute. Investment under Mongolian law is defined as a broad concept without clear limitations and is asset-based, whereas under Mongolia-Canada BIT it is defined as enterprise based, in favor of foreign direct investment. The investment arbitration cases involving Mongolia are different case by case.

#### **KEYWORDS:**

Investment, Foreign direct investment, Bilateral investment treaty, Investment law

**ЭХ СУРВАЛЖ**

1. Christoph Schreuer and Rudolf Dolzer Principles of International Investment Law, Second edition, 2012.
2. M.Sornarajah, The International Law Foreign Investment, Fifth Edition, 2021.
3. Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны шинэчлэл, Дэлхийн банк, 2018.
4. Дэлхийн банкны Doing Business 2020, Монгол Улсын индекс
5. C.Wren, J.Jones, Foreign Direct Investment and the Regional Economy (Ashgate Publishing 2012)
6. Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны шинэчлэл, Дэлхийн банк, 2018.
7. <https://espace-mondial-atlas.sciencespo.fr/en/topic-strategies-of-transnational-actors/article-3A11-EN-multinational-corporations.html#:~:text=At%20the%20present%20time%2C%20there,controlling%20more%20than%20500%2C000%20subsidiaries>.
8. J.Stiglitz, Globalization and Development” Taming the Globalization: frontiers of governance, (Polity 2003)
9. UNCTAD, Definitions and Sources, 2007.

*Арбитрын шийдвэрүүд:*

1. Арбитрын шийдвэр С.В.Паушок Монгол Улсын Засгийн газар
2. Арбитрын шийдвэр Хан Ресорсес Монгол Улсын Засгийн газар
3. *Tradex v Albania*, Арбитрын шийдвэр, 29.04.1999
4. *Salini v. Morocco*, Decision on Jurisdiction, 23.07.2001

*Хоёр талт хэлэлцээрүүд*

1. Монгол Улс болон Канад улс хоорондын хэлэлцээр, 2016.
2. Монгол Улс болон БНХАУ хоорондын хэлэлцээр, 1993.
3. Монгол Улс болон Нидерландын Вант Улс хоорондын хэлэлцээр, 1996.
4. Монгол Улс ОХУ хоорондын хэлэлцээр, 2006.

## ҮГ ХЭЛЭХ, ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ, ТҮҮНИЙ ТҮҮХЭН ХӨГЖИЛ, АРДЧИЛСАН НИЙГЭМД ГҮЙЦЭТГЭЖ БУЙ ҮҮРЭГ



*Д.Оросоо*

*Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын  
ажиллагааны нийгэмлэгийн судлаач,  
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант*

### **ТОВЧЛОЛ:**

Монгол Улсын Үндсэн хуульд үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан бөгөөд уг эрхийн хөгжлийн хандлага, ардчилсан нийгэмд гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдлын талаар авч үзэв. Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь тайван арга, хэлбэртэй, хүчирхийлэл, албадлагын арга хэрэгсэл биш, харин хүн өөрийн үзэл бодол, байр сууриа түгээх, илэрхийлэх замаар эрх баригч, олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлөх, дэмжлэг авах, хүлээн зөвшөөрөгдөх, зөвшилцөх арга зам, боломж юм. Орчин үеийн нээлттэй, иргэний нийгмийн үндэс суурь бол олон янзын чөлөөт үзэл бодол, итгэл үнэмшил бөгөөд нийгэмд нээлттэй мэтгэлцээн, үзэл бодлын чөлөөт өрсөлдөөн, солилцоо, бодож сэтгэх, сэтгэлгээний эрх чөлөө байх шаардлагатай талаар дүгнэж, иргэний нийгэмд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн гүйцэтгэж буй үүргийн талаар дүгнэв. Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь эрх мэдэлд хяналт тавих, эрх баригчаас ардчилсан хариуцлага нэхэх, хамтын шийдвэр гаргах, олон ургалч үзлийг хөгжүүлэх, нийгэмд ажил хэрэгч хандлага, ил тод байдал, эрүүл саруул, шүүмжлэлт орчин бий болгох, иргэдээс зөрчигдсөн эрхийнхээ төлөө тэмцэх, эсэргүүцэл үзүүлэх зэргээр ардчилсан нийгмийг төгөлдөржүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Үзэл бодлоо илэрхийлэх, Итгэл үнэмшил, Иргэний нийгэм, Үндсэн эрх

### **ОРШИЛ**

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрхийг заасан бөгөөд уг зүйлийн 16 дахь хэсэгт “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй”, 17 дахь хэсэгт “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй...”

гэж заасан байдаг.

Академич Ж.Амарсанаа “*Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө бол түүнгүйгээр хүн хэвийн амьдарч чадахгүй, нийгэм эрүүл саруул оршин тогтнож, үйл ажиллагаагаа явуулж чадахгүй тийм орчин юм*”<sup>1</sup> гэж уг эрхийн агуулга, мөн чанарыг илэрхийлжээ. Хувийн үзэл бодолтой байх эрх чөлөө нь чөлөөт нийгмийг байгуулах урьдчилсан нөхцөл юм.”<sup>2</sup> гэсэн дүгнэлтийг дэмжих үндэслэлтэй. Хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн явцад хүнд өөрийгөө илэрхийлэх дотоод ухамсар, оюун санааны хэрэгцээ шаардлага байсаар ирсэн, энэ бол хүний төрөлхийн, жам ёсны зүйл юм. Гэвч түүхийн туршид хүний итгэл үнэмшил, үзэл бодол, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх асуудал нь хамгийн хүнд хэцүү, дарамт, шахалт, ялгаварлан гадуурхалт, хэлмэгдүүлэлтийн замыг туулсан байдаг. Монголын түүхийн XX зуунд хүнийг итгэл үнэмшил, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэн гадуурхах, егүүтгэх, ял шийтгэх зэргээр хүний жам ёсны эрхийг хязгаарлаж байв. Түүхийн хөгжлийн хандлагаас харахад ихэнх цаг үед хүний оюун санааны эрх чөлөө, үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх Үндсэн хуулийн хамгаалалт баталгаагүй явж ирсэн байдаг. Оюун санааны чөлөөт байдал, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эрх баригчид хүлээн зөвшөөрдөггүй үе олон зуун жилийн турш үргэлжилсэн юм.

Энгийн иргэн улс төр, шашин, нийгмийн асуудлаар үг хэлэх, шүүмжлэх, үзэл бодлоо илэрхийлэх харилцааг хүний үндсэн эрх гэж хүлээн зөвшөөрөх онолын сэтгэлгээний үзэл санаа XVII зууны үеэс Европ тивд эхэлсэн бөгөөд өрнө дахинд үг хэлэх эрхийг цаашид хүний эрхийн онолын сэтгэлгээний түвшинд хүлээн зөвшөөрч баталгаажуулахад 1215 онд Английн “Магна Харти”, 1689 оны Эрхийн тухай билл, 1766 онд хэвлэлийн эрх чөлөөг Швед улсад хүлээн зөвшөөрсөн явдал чухал нөлөө үзүүлсэн бөгөөд 1776 оны Виржиний Үндсэн хууль, 1787 оны АНУ-ын Үндсэн хууль (анхны нэмэлт), 1788 оны Францын эрэгтэйчүүдийн эрхийн тунхаглал, 1789 оны Францын Хүний болон Иргэний эрхийн тунхаг, 1898 оны Францын Хүний эрхийн Лига, АНУ-ын 1866 оны Иргэний эрхийн тухай хууль зэрэг баримт бичигт түүхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Харин Чингис хааны 1206 оны “Их засаг” хууль нь Монголын эзэнт гүрэн, бусад улс орнуудад бүх талаар нөлөөлж, хууль цааз, улс төр, эрх зүйн соёлын үүргийг гүйцэтгэж байв. “Их засаг” хуульд аль ч шашныг эн тэнцүү үзэх, шашны эрх чөлөөг анх баталгаажуулсан юм.

Харилцан бие биенээ хүндэтгэх, хүлээцтэй тэвчээртэй байх, эрх тэгш байдлыг хүн төрөлхтөн түүхэнд аль дээр үеэс хүсэн мөрөөдөж ирсэн бөгөөд манай нийгэм техник технологи, улс төр, нийгэм, эдийн засгийн салбарт асар том алхам хийсэн боловч хэдэн зуу, бүр хэдэн мянган жилийн тэртээ байсан асуудлууд өнөөдөр ч хэвээр байсаар байгааг энд тэмдэглэх нь зүйтэй. Дэлхийн Нэгдүгээр болон Хоёрдугаар дайны сүйрэл, ган гамшиг амссан гашуун туршлагаас ухамсарлан Төрийн эрх мэдлийг дур зоргоор ашиглахаас хувь хүнийг хамгаалах, нийгмийн хөгжил дэвшил, илүү эрх чөлөөтэй нөхцөлд сайн сайхан амьдралыг хангах нь тулгамдсан зорилт болсон байна. “Хүний эрх”-ийн тухай үзэл баримтлалын онцлог бол хүн болж төрсний хувьд эрх эдэлнэ, ямар ч тохиолдолд хүний эдлэх эрхийг хасаж үл болно гэсэн утгатай. Иймд эдгээр эрхүүд нь хүний нөхцөл байдалтай салшгүй холбоотой байна. Энэхүү ёс зүйн язгуур үндсийг Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын Оршил хэсгийн эхний зүйлд “хүн төрөлхтний гэр бүлийн бүх гишүүнд угаас заяасан нэр төр, тэдний тэгш салшгүй эрхийг” хүлээн зөвшөөрнө гэж зааснаар илэрхийлсэн байна. Хүний эрх нь хүн төрөлхтний бүх гишүүдийн байгалиас заяасан эрх юм. Иймд хүний эрх нь бүх хүний

<sup>1</sup> Ж.Амарсанаа, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, Ханнс Зайделын сан, “Эргэцүүлэл”, №7, 2000 он.

<sup>2</sup> Натаниел Смит, Чөлөөт нийгмийн зарчмууд, УБ., 2016 он, 32-33 дахь тал.

түгээмэл бөгөөд салшгүй эрх юм. Хүний эрхийн үндсэн агуулгыг (салшгүй) хасч үл болно. Гагцхүү тодорхой нөхцөл байдалд л хүний эрхийн зарчмыг нь хэрэгжүүлэхийг хязгаарлаж болно. Хүний эрх нь хүний ер бусын, цорын ганц мөн чанараас гаралтай тул эдгээр эрхийг үндэсний болон олон улсын түвшинд хуулиар үр дүнтэй хамгаалах ёстой.<sup>3</sup>

## ҮНДСЭН ХЭСЭГ

Үг хэлэх, шашин шүтэх, байр суурь, үзэл бодлоо илэрхийлэх, сэтгэх, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх гэдэг бол хүний оюун санааны хэрэгцээ шаардлагатай холбогдож байдаг. Хүн юуны өмнө өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй байж өөрөөр хэлбэл ямар нэг зүйлд итгэх, эс итгэхээ шийдвэрлэхдээ аль нэг үзэл суртлын хяналт болон бусад дарамт шахалтаас гадуур байхад оршино. Итгэл үнэмшилтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн арга нь үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө бөгөөд энэ нь хүний салшгүй эрх юм. Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө бол хувь хүний болон нийгмийн чөлөөт байдлын илэрхийлэл юм.<sup>4</sup> Хүн угаасаа шинэ үзэл санаа, мэдээллийг байнга эрэлхийлж, өөрийн гэсэн итгэл үнэмшил, үзэл бодлыг тээж байдаг онцлогтой, энэ шинж нь хүнийг оюун ухаант хүн болгож хөгжүүлсэн, энэ бол хүний жам ёсны эрх юм. Үүнийг хааж хязгаарлах боломжгүй, харин баталгаажуулж хамгаалах ёстой болно. Монгол Улсын Үндсэн хуульд үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан бөгөөд уг эрхийн агуулга, үзэл санааг зөв тайлбарлах, тодруулах асуудал чухал юм. Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн агуулга, мөн чанар, арга хэлбэр, үзэл баримтлалыг ардчиллын үзэл санааны үүднээс дэлгэрүүлэн авч үзье.

### А. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн агуулга

Хүний үзэл бодол, өөрийн санал, сэтгэгдлээ хэлэх боломжийг олгодог учраас уг эрх нь суурь жам ёсны зүйл юм. Тиймээс үг хэлэх эрх чөлөө нь хувийн үзэл бодолтой байх эрхийн тусгай хэсэг нь болдог. Мэдээж амьдрал дээр хүн өөрийн санал, үзэл бодлоо чөлөөтэй, найдвартай илэрхийлэх боломжийг бий болгох зорилгоор үг хэлэх эрх нь өргөн хүрээнд хэрэгжинэ. Хүний үзэл бодол гэдэг нь аливаа зүйлийг зөв, буруу гэж дүгнэх оюуны бүрдлийг хэлнэ. Өөрийн үзэл бодолтой байх эрх чөлөөний хүрээнд хувь хүн нь өөрийн бодлоор үйлдлээ хийх буюу харин албадлага сүрдүүлэгт автан зөв үйлдлийг хийхээс татгалзах, буруу үйлдлийг хийх зэрэг нөхцөлөөс хамгаалагдана.<sup>5</sup>

Доктор Б.Чимид: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн агуулгыг дараах хэдэн шинжээр илэрхийлж болно. Тухайлбал эл эрх нь:

- Хүний өөрийн итгэл үнэмшилд суурилдаг,
- Хүний өөрийн буюу бие даасан байр суурийг нь илэрхийлдэг,
- Нийгэм-төр, түүний байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж цэгнэх, ариусгахад болон хүний ашиг сонирхлыг хамгаалахад чиглэдэг,
- Нийгмийг жолоодох, хянахад иргэний нийгмийн оролцох арга зам болдог,
- Үг хэлэх, хэвлэн нийтлэх, жагсаал цуглаан хийх, мэдээлэл хайх, олох, түгээх зэрэг бусад эрх, эрх чөлөөгөөр дамжин илэрдэг гээд түүнд байх өөр чухал уг шинжийг дурдаж болно.<sup>6</sup>

Доктор Б.Чимид: хүний эрх гэгч яг л нэмэх, хасах цэнэгийн таталцал, “ижил цэнэг”-ийн түлхэлцэл мэт нэгдэж, сөргөлдөж байдаг түвэгтэй үзэгдэл мөн. Тэр дундаас “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх”, түүний гол хэрэглүүр болсон хэвлэл мэдээллийн эрх

<sup>3</sup> НУБ, Шүүн таслах ажиллагаанд хүний эрхийг хангах нь, шүүгч, прокурор, өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага, УБ., 2005 он, 4-5 дахь тал.

<sup>4</sup> Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2009 он, 98 дахь тал.

<sup>5</sup> Натаниел Смит, Чөлөөт нийгмийн зарчмууд, УБ., 2016 он, 32-33 дахь тал.

<sup>6</sup> Б.Чимид, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө, “Сэтгүүлч ба хууль” цуврал, №03.

чөлөө нь тэрхүү тэмцэл сөргөлдөөний тэргүүн шугамд байсаар ирсэн <sup>7</sup> гэж дүгнэжээ. Мөн судлаач Томас Эмерсон “үг хэлэх эрх чөлөө нь тогтвортой байдал, өөрчлөлтийн тэнцвэрийг хангахад тусалж байдаг, тогтворгүй байдалд олон нийтийн уур бухимдлыг гадагшлуулах “аюулгүй хавхалга”-ын үүрэг гүйцэтгэж, нийгэмд шаардлагатай тэнцвэрийг хадгалах, доройтол, хямралыг засах, хэвийн болгох арга”<sup>8</sup> гэж үзсэн. Доктор Д.Гангабаатар “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах нь нийгмийн тогтвортой байдал, өөрчлөлт хоёрын тэнцвэрт байдлыг хангадаг. Үг хэлэх эрхийг чөлөөтэй олгосноор хүмүүс хуримтлуулсан бухимдлаа гадагшлуулж, ингэснээр хувьсгал, зөрчилдөөн, мөргөлдөөн дэгдэхээс сэргийлдэг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нээлттэй байлгаснаар тогтвортой, дасан зохицох чадвар бүхий нийгмийг төлөвшүүлдэг”<sup>9</sup> гэжээ.

### **Б. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх арга хэлбэр**

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх хэмээх энэхүү иргэний эрхийн анхдагч суурь бол үзэл бодлын эрх, эрх чөлөө юм. Үзэл бодлын эрх чөлөө болох хүн итгэл үнэмшил, үзэл бодолтой байх, үзэл бодлоо өөрчлөх, үзэл бодлоо чөлөөтэй баримтлах эрх нь шууд хэрэгжих шинж чанартай (*self-executing*) юм. Энэ нь эрх зүйн тулгуур зарчим, мөрдлөг болох заалт гэсэн үг болно. Үзэл бодлын эрх, эрх чөлөө нь дараах харилцан хамаарал бүхий багц эрх болох 1.Итгэл үнэмшилтэй байх эрх<sup>10</sup>, 2.Үзэл бодолтой байх эрх<sup>11</sup>, 3.Чөлөөтэй бодож сэтгэх эрх<sup>12</sup>, 4.Үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах эрх<sup>13</sup>, 5.Үзэл бодлоо өөрчлөх<sup>14</sup>, 6.Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө<sup>15</sup> зэрэг эрхүүдээс бүрддэг.

Харин үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх <sup>16</sup> нь 1.Мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар болон бичгээр хүлээн авах<sup>17</sup>, 2.Уран сайхны хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх<sup>18</sup>, 3.Өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо илэрхийлэх эрх<sup>19</sup>, 5.Эрж хайх (мэдээлэл хайх)<sup>20</sup>, 6.Хүлээн авах (мэдээлэл хүлээн авах)<sup>21</sup>, 7.Түгээх эрх<sup>22</sup>, 8.Тайван жагсаал, цуглаан хийх эрх<sup>23</sup>, 9.Эвлэлдэн нэгдэх эрх<sup>24</sup>, 10.Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх<sup>25</sup>, 11.Ажил хаях<sup>26</sup>, 12. Өлсгөлөн зарлах, 13.Зохиомол нэр хэрэглэх, нэрээ нууцлах эрх, 14.Интернэт ашиглах эрх зэрэг харилцан уялдаатай, хамаарал бүхий багц эрх, эрх чөлөөний бүрдэл юм. Хүн бүр өөрийн хувийн шинж, нөхцөл байдал, бусдын үнэлэмжээс үл хамааран үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь онлайн (online) болон офлайн (offline) орчинд аль алинд нь хамаарна.

Үзэл бодлын эрх чөлөө бол үл хязгаарлагдах заяагдмал эрх бөгөөд хүн өөрийн үзэл бодол, сүсэг бишрэл, итгэл үнэмшил, мөн мэдээлэл, мэдлэгтэй байх, түүнийгээ хөгжүүлэх, бодож сэтгэх эрх, шашин шүтэх, эс шүтэх, үзэн ядах, мөн үзэл бодолгүй байх, мэдээлэлтэй

<sup>7</sup> Б.Чимид, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, УБ., 2001 он.

<sup>8</sup> [https://en.wikipedia.org/wiki/Freedom\\_of\\_speech](https://en.wikipedia.org/wiki/Freedom_of_speech)

<sup>9</sup> Д.Гангабаатар, Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Үндсэн хуулиар хамгаалах нь, УБ., 2015 он, 7 дахь тал.

<sup>10</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэг

<sup>11</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19, ИУТЭОУП-ын 19.2, МуҮХ-ийн 16.16

<sup>12</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 18, ИУТЭОУП-ын 18.1

<sup>13</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19, ИУТЭОУП-ын 19.1

<sup>14</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 18, ИУТЭОУП-ын 18.2

<sup>15</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 15 дахь хэсэг

<sup>16</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19, ИУТЭОУП-ын 19.2, МуҮХ-ийн 16.16

<sup>17</sup> МУҮХ-ийн 16.16

<sup>18</sup> ИУТЭОУП-ын 19.2

<sup>19</sup> ИУТЭОУП-ын 19.2

<sup>20</sup> МУҮХ-ын 16 дугаар зүйлийн 17

<sup>21</sup> МУҮХ-ын 16 дугаар зүйлийн 17

<sup>22</sup> ХЭТТ-ын 19, ИУТЭОУП-ын 19.2

<sup>23</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20, ИУТЭОУП-ын 21, МуҮХ-ийн 16.16

<sup>24</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20, ИУТЭОУП-ын 21, МуҮХ-ийн 16.10

<sup>25</sup> МУҮХ-ын 16.12

<sup>26</sup> Монгол Улсын хөдөлмөрийн тухай хуулийн 119, 120 дугаар зүйл

байх хийгээд мэдээллээс ангид байх, сүсэг бишрэл, итгэл үнэмшилгүй ч байх, худал, хуурамч үзэл бодол, мэдээллийг таньж мэдэх, судлах боломж, эрхтэй байх, ийм мэдээлэл, үзэл бодлыг хүлээн авахаас татгалзах зэрэг оюун санааны өргөн хүрээг хамрах бөгөөд уг эрхээ чөлөөтэй баримтлах, түүнийгээ өөрчлөх эрх, эрхээ хөндлөнгийн оролцоогүй, хязгаарлалтгүй, саадгүй баримтлах, эдлэх, цаг хугацаа, орон зай, хил хязгаарын хувьд чөлөөтэй байх, уг эрхээ эдэлсний төлөө хувь хүн, түүний гэр бүл, хамт олон, хуулийн этгээд, нийгэм, үндэстэн аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, хариуцлага, хүчирхийлэл, хязгаарлалт, дарамтад өртөхгүй байх, санаатай боловсруулсан худал, хуурамч мэдээлэлд төөрөгдөхгүй байх, шашин, улс төрийн харгис үзэл суртлын хохирогч болохгүй байх, уг эрхийнхээ төлөө баривчлагдах, цагдан хоригдох, зорчих эрхээ хасуулах, шоронд хоригдох, ажлаас халагдах, хэвлэн нийтлэх эрхээ хасуулах, албадлага, дарамт шахалтад өртөхгүй байх, эдийн засаг, нийгэм, соёл, эрүүл мэндийн хязгаарлалт, ялгаварлалтад өртөхгүй байх зэрэг эрхийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт юм.

НҮБ-ын Хүний эрхийн хороо үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг өргөн хүрээнд авч үзсэн байна. Тухайлбал, Үүнд улс төрийн мэтгэлцээн, хүний хувийн болон төрийн үйл хэргийн асуудлаарх тайлбар, ухуулга, хүний эрхийн талаарх хэлэлцүүлэг, сэтгүүл зүй, соёл, уран сайхны илэрхийлэл, номлол, шашны мэтгэлцээн багтана. Үүнд арилжааны зар сурталчилгааг хамруулж болно. 19-р зүйлийн 3 дахь хэсэг, 20-р зүйлээр хязгаарлаж болох хэдий ч гүн гүнзгий гомдоосон гэж үзэхүйц илэрхийллийг ч 2 дахь зүйлийн хүрээнд хүлээн зөвшөөрдөг. Илэрхийллийн бүхий л хэлбэр, түүнийг дэлгэрүүлэх арга хэрэгслийг хамгаална. Эдгээрт яриа, бичиг, дохионы хэл, дүрс, урлагийн бүтээл гэх мэт аман бус хэлбэр багтана. Ном, сонин, товхимол, зурагт хуудас, баннер, хувцас болон хуулийн дагуу гомдол гаргах нь илэрхийллийн арга хэрэгсэлд орно. Эдгээрт дуу, дүрс, электрон, интернэтэд суурилсан илэрхийлэл багтана.<sup>27</sup> гэжээ.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх бол үзэл бодол, итгэл үнэмшил, мэдээлэл түгээх, олж авах, хүлээн авах эрх, бусадтай хуваалцах, дамжуулах, эсхүл хуваалцахгүй, дамжуулахгүй байх, хүлээн авахгүй байх, өөрийн сонгосон аргаар илэрхийлэх, түгээх, бусдын үзэл бодлыг дэмжих, эс дэмжих, эсэргүүцэл үзүүлэх, илэрхийлэх, үзэн ядалтаа илэрхийлэх, үл хүндлэлд хариу өгөх, үл хүндлэлийг эсэргүүцэх, гүтгэлэг, доромжлолыг эсэргүүцэх, мэдэгдэл гаргах, хов ярих, шог зураг, фото эвлүүлэг, өөрийн сонголтоор амьдрах, хувцаслах, урлагийн бүтээл туурвих, улс төрийн нам, хөдөлгөөнд эвлэлдэн нэгдэх, гишүүнээр элсэх, гишүүнээс гаргах, өөр нам, эвсэлд нэгдэх, элсэх, шашны байгууллагын үйл ажиллагаанд оролцох, дэмжих, эсхүл дэмжихгүй байх, дургүйцэл, амьдралын хэв маяг, уламжлал, ёс заншил, соёл иргэншлийн илэрхийлэл, шашны зан үйл, эсэргүүцэл, гомдол илэрхийлэх, хэвлэлийн бага хурал хийх, ярилцлага өгөх, туг далбаа намируулах, эсэргүүцлээ илэрхийлж өөрийн сонголтоор хувцаслах, бүжиг, хөгжим, лаа, зул асаах, нэвтрүүлэгт оролцох, хийх, өөрчлөлт хийхийг уриалах, эрх баригч, засаглалын алдаа, дутагдлыг илчлэх, шийдвэр гаргагчийг эрх мэдлээсээ татгалзахыг уриалах, шаардах, огцрох, албан тушаалаа хүлээлгэж өгөхийг шаардах, ардчилсан хариуцлага тооцох, нийтийн эрх ашгийн өмнөөс шүүх, хяналтын байгууллагад гомдол, нэхэмжлэл гаргах, нийтийн эрх ашгийн өмгөөлөл хийх, олон нийтийн өмнө хариуцлага нэхэх, сэтгүүлчийн үйл ажиллагаа, олон нийтийн сүлжээ ашиглах, шууд дамжуулалт хийх, номын сан, номын дэлгүүр, хэвлэлийн үйлдвэр, офиссын ажлын байр, гэр орон, компьютер, ажлын тоног төхөөрөмж, түүнд хадгалагдаж буй мэдээлэл, мэдлэг, баримт ч хамаарах өргөн хүрээтэй ойлголт болно.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь төрийн эрх мэдэл, хяналт, цензур болон нийгмийн зүй бус дарамт, гадуурхалтаас “чөлөөтэй” байх зарчимтай. Энэ нь оюун санаа, ухамсрын хувьд хувь хүн бие даасан, бусдаас хараат бус байх баталгаа юм. Үзэл бодлоо илэрхийлэх

<sup>27</sup> <https://www.globeinter.org.mn/images/upld/Article19commentsMong21dec2015.pdf>



эрх нь тайван арга, хэлбэртэй байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх бол хүчирхийлэл, албадлагын арга хэрэгсэл биш юм. Хүн өөрийн үзэл бодол, итгэл үнэмшилтэй байх эрхийн хамт түүнийгээ түгээх, илэрхийлэх замаар олон нийт, эрх баригч, бусдын оюун санаа, сэтгэл зүйд нөлөөлөх, дэмжлэг авах, хүлээн зөвшөөрөгдөх арга зам, боломж юм. Хүн өөрийн үзэл бодлоо илэрхийлэхдээ Үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн хязгаарлалтаас бусад хязгаарлалтгүй, хөндлөнгийн оролцоогүй, хязгаарлалтгүй, албадлага, хүчирхийллээс ангид саадгүй эдлэх, цаг хугацаа, орон зай, хил хязгаарын хувьд чөлөөтэй байх эрхтэй.

### **В. Олон нийтийн үзэл бодлын илэрхийллийн систем**

Иргэний нийгмийн зүгээс эрх, ашиг сонирхлоо илэрхийлэх арга, механизм нь үзэл бодлоо илэрхийлэх багц эрх чөлөө юм. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь ганц эрхээс бүрдэхгүй, харин харилцан уялдаа холбоотой, бие биеэ дэмждэг олон эрхээс бүрдсэн багц эрхийн тогтолцоо юм. Энэхүү бие биеэ харилцан дэмждэг, салшгүй уялдаа холбоо бүхий эдгээр эрх нь нийгмийн оюун санаа, итгэл үнэмшил, үзэл бодол, мэдлэг, мэдээллийн тогтолцоо, түүний чөлөөт урсгал, солилцоо, олон нийтийн үзэл бодлын ухамсар, соёл, зан үйл, хандлагыг бүрдүүлэх, ардчилал, улс төрийн тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Иймд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх багц эрхийг иргэний нийгмийн олон нийтийн үзэл бодлын илэрхийллийн “систем” (тогтолцоо, арга механизм) гэж үзэж болно. Уг олон нийтийн үзэл бодлын илэрхийллийн арга, механизм нь зөвхөн орчин үед үүсч бий болоогүй, харин анх иргэний нийгэм бий болсон цаг үеэс эхлэн хөгжиж, иргэний нийгмийн байр суурь, орон зайг тэлсээр ирэв. Уг систем нь өөрийн үүсэл, хөгжлийн үе шатыг туулж ирсэн бөгөөд харин тухайн нийгэмд олон нийтийн үзэл бодлын илэрхийллийн систем нь хэрхэн ажиллаж байгаагаас тухайн нийгмийн шинж чанар, агуулга хамаардаг.

Үзэл бодлоо илэрхийлэх багц эрх бол бодит үнэнг таньж мэдэх боломжийг олгодог давуу талтай. Ямар нэгэн ноцтой асуудлын цаад бодит үнэнийг ард түмнээс нуун дарагдуулж, олон нийтийг төөрөгдүүлэхийг оролдох үйл явдал болдог нь маргаангүй юм. Гагцхүү нуусан үнэнг энэ эрхийн тусалцаатайгаар л олж мэдэх боломжтой. Харин эрх баригчид эсэргүүцэл илэрхийлэх эрхийг эрсдэл гэж үзэж зөвшөөрөл олгохоос тагталзах, хязгаарлах хандлага гаргадаг байна.

Ардчиллын суурь үзэл санаа бол эрх чөлөө билээ. Эрх чөлөөг шийдвэр гаргах үйл явцад оролцох улс төрийн эрх, хүлээх үүргийн аль алинаар ойлгох бөгөөд түүнчлэн хэн нэгнээс илүү сайн эсхүл илүү муу амьдрах тухай хувийн эрх чөлөөг хамаатуулан ойлгоно. Хамгийн чухал эрх чөлөө бол хамтын сайн сайхны төлөө нийтийн ассамблей дээр үг хэлэх мөн түүнчлэн, өөрийнхөө тааллаар гэртээ эсвэл гадаа, олон нийтийн газар, тэр бүү хэл эрэгтэй хүнтэй адил сэтгэх, ярих эрх чөлөө юм.<sup>28</sup>

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх бол нийгэмд оршиж байгаа дутагдал, хүний эрхийн зөрчил, эрх баригчийн алдаатай бодлого, шийдвэр, үйл ажиллагааг олон нийтийн өмнө шүүмжлэн ил болгох, эсэргүүцэл илэрхийлэх “нийгмийн сэрүүлэг”-ийн үүргийг гүйцэтгэдэг. Ардчилсан нийгэмд ийм механизм байхгүй бол олон нийтэд ямар ч мэдээлэл очихгүй, эрх баригч, шийдвэр гаргагчийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх ямар ч боломжгүй юм.

Нийгмийн харилцаа хөгжил гэдэг бол амьд харилцаа бөгөөд заримдаа нийгмийн хөгжил хоцрогдох, буруу үзэл санаа, мэдээлэл түгэх, автах зэрэг гажуудал гарч ирдэг. Үзэл бодлын чөлөөт илэрхийлэл, эсэргүүцэл, дургүйцлээ илэрхийлэх нь сул, хязгаарлагдсан нийгэмд буруу хандлага, ёс суртахуунгүй, хууль бус явдал бугшиж, нийгэмд шударга ёс алдагдах хөрс суурь болдог. Аль ч нийгэмд эрүүл саруул, ажил хэрэгч, шүүмжлэлт байр суурь шаардлагатай, энэ нь нийгэмд үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр дамжин оюун санаа, үзэл бодлын солилцоо явагдаж, нийгэмд шинэ мэдлэг, мэдээлэл, үзэл санааг түгээх, нийгмийг шинэчлэх, өөрчлөх боломжийг бүрдүүлж байдаг.

<sup>28</sup> Бернард Крик, Ардчиллын тухай, товч танилцуулга, УБ., 2019 он, 30 дахь тал.



Конрад-Аденауэр сангаас эрхлэн гаргасан “Илүү сайн ардчилал” бүтээлд “Ардчилал нь эрх чөлөө, шударга ёс, чинээлэг амьдралын эх сурвалж тул иргэддээ сайхан амьдрах хамгийн сайн нөхцөлийг бүрдүүлдэг. Ардчилал хувь хүний эрх чөлөөг нийгмийн хүсэл эрмэлзэлтэй уялдуулж, иргэдэд нийтийн сайн сайхны төлөө байх хүслийг төрүүлдэг. Ардчилалд засгийн газар ард түмний хүсэл зоригт захирагддаг. Ингэснээр ардчилал иргэдэд хүлээн зөвшөөрөгдөж, тогтвортой байдлыг бий болгодог. Хүний нэр төр, оршихуйг дээдлэх нь төрийн бодлогын цөм юм. Хүн төрийн объект биш. Ардчилсан төр ард түмний төлөө оршдог. Төрийн бүхий л үйл ажиллагаа хүний үндсэн эрхээр хязгаарлагдана. Хүний үндсэн эрх биднийг хамгаалж, бидний эрх чөлөөг баталгаажуулдаг. Хүний үндсэн эрхэд: хүний халдашгүй дархан байдал, хуулийн өмнө эрх тэгш байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, жагсаал, цуглаан хийх, шашин шүтэх эрх чөлөө, орон гэрийн халдашгүй байдал, өмчтэй байх, хүйсийн эрх тэгш байдал, чөлөөтэй зорчих эрх зэрэг багтана. Хүний үндсэн эрх байхгүйгээр ардчилал оршихгүй. Орчин үеийн нийгэм олон өнгөтэй. Олон төрлийн үзэл бодол, амьдралын хэв маяг бидний хамтын амьдралыг тодорхойлдог. Ардчилал иргэдэд өөрсдийн хүсэл зоригийг чөлөөтэй илэрхийлэх боломж олгодог. Улс төр, эдийн засаг, нийгмийн шийдвэрүүд хүн бүрт хамаатай. Гиймээс шийдвэр гаргалтад нухацтай хандах шаардлагатай. Улс төрийн мэтгэлцээн ардчиллын нэг хэсэг бөгөөд энэ нь ч зүйн хэрэг. Хэн ч үнэмлэхүй үнэнг тээдэггүй. Ардчилсан мэтгэлцээнээр л олон нийтэд тустай хамгийн сайн шийдэл гардаг. Хүн бүр үг хэлэх эрхтэй. Иргэд засгийн газрын шийдвэр бүртэй санал нэгдэх албагүй.”<sup>29</sup> гэж ардчиллын үндсэн зарчим, ойлголтыг илүү тодорхой тайлбарласан байна.

Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний нийгэмд гүйцэтгэх нэг гол чиг үүрэг бол нийгмийн оюун санаа, үзэл санааны урсгал, хөгжлийг чиглүүлж байдагт оршино. Уг эрх чөлөө хаагдаж хумигдах аваас нийгэмд эрүүл саруул, шүүмжлэлт уур амьсгал алга болж, шинэ мэдлэг, мэдээллийн урсгал тасарч, нийгмийн оюун санаа, үзэл бодол явцуу, баригдмал, хоцрогдмол болдог. Харин уг эрх чөлөөг дэмжиж, чөлөөтэй байх аваас нийгмийн оюун санааг “идэвхжүүлэгч”-ийн үүргийг гүйцэтгэж эхэлдэг.

Орчин үеийн нийгмийн хөгжлийн үндсэн нөхцөл нь шинэ мэдлэг, түүний үрээр үүсдэг бүтээлч шүүмжлэл, шүүмжлэлийн дагуу хийгдэх шинэчлэл, уг шинэчлэлийн өөрийнх нь тасралтгүй төгөлдөршил болно. Энэ бол нийгмийг тасралтгүй хөгжүүлэхэд ашиглагдах ёстой уламжлалт технологи юм. Эл технологийг сахиж чадах аваас нийгэм өөрийн хүчээр хөгжиж, дэвшиж байх болно. Дурдсан технологи хэрэгжих нэг үндсэн нөхцөл бол шинэчлэлийг хүсэгч цөөнхийн үгийг байнга сонсож, тэднийг олонхын урсгал дарамтаас хамгаалж, санаснаа хэрэгжүүлэхэд нь бүх талын тусламж, дэмжлэг үзүүлэх явдал юм.<sup>30</sup>

### **Г. Иргэний нийгэм ба үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх**

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд “Монголын ард түмэн бид хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” хэмээн тунхагласан. Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д “*Монгол Улсад Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгон байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.*” гэж заасан болно.

Иргэний нийгэм гэдгийг Үндсэн хуулийн эх баригч, Хууль зүйн доктор Б.Чимид “иргэний нийгэм бол амьдралын гүнд байсаар ирсэн, төр нийгмийн зөв оршихуйн үндэс аж ... иргэний нийгэм нь засаг төрийн байгууллын эх үүсвэр байж үйл ажиллагаанд нь хяналт тавьж, түүнийг өөрсдөдөө үйлчилдэг зарц болгож чадсан тийм ардчилсан тогтолцоо болгон төлөвшүүлж бэхжүүлэхийг л “цогцлуулан хөгжүүлэх” гэсэн томъёоллоор ард түмэн

<sup>29</sup> Конрад-Аденауэр сан, Илүү сайн ардчилал. Төлөөллийн ардчиллын үндсэн зарчмууд, 2017 он, 7-9 дэх тал.

<sup>30</sup> Д.Чулуунжав, Нийгмийн философи, онол туршилт сургамж шүүмж, ШУА, УБ., 2014 он, 201-202 дахь тал.

эрхэм зорилгоо болгожээ”<sup>31</sup> гэж тодорхойлсон бол нийгэмд төрийн зохион байгуулалтын зэрэгцээ иргэдийн идэвхтэй амьдралын хэв маяг оршиж байдаг тухай эртний Грек, Ромын сэтгэгчид тэмдэглэсэн байдаг. Гэвч “иргэний нийгэм” гэсэн нэр томъёог онцлон хэрэглэж байсангүй. Энэ тухай АНУ-ын Колумбын их сургуулийн профессор *Jean L. Cohen, Andrew Aroto* нар “иргэний нийгмийн тухай ойлголт Аристотелийн бүтээлд анх илэрсэн” гэж тэмдэглээд түүнийг “*societes civilis*” гэсэн Латин нэршлээр бус, харин “*politike koinonia*” (улс төрийн нийтлэг) хэмээн нэрлэж, мөн чанарыг нь хууль бүхий удирдлагын тогтолцоонд үндэслэсэн чөлөөт, эрх тэгш иргэдийн ёс зүй-улс төрийн нийтлэг” гэж тодорхойлжээ.<sup>32</sup>

Нийгмийн гэрээний онол нь төр, хууль цааз, эрхийн гарал үүсэл, мөн чанарыг хүмүүсийн хоорондоо байгуулсан ухамсартай гэрээний үр дүн хэмээн тайлбарладаг нийгмийн ба улс төрийн философиин сургаал билээ. Нийгмийн гэрээний онол, ард түмний бүрэн эрхийн тухай үзэл санаа XVIII-XIX зууны үеийн Европ ба Америкийн нийгэм-улс төрийн хөгжил, Англи, Франц дахь хэмжээгүй эрхт хаант засгийг түлхэн унагаах, Хойд Америкт Үндсэн хуульт бүгд найрамдах засаг бүрэлдэн байгуулагдахад үндэслэл болсон төдийгүй төр засаг бол бурхан буюу эрхт тэнгэрээс гаралтай гэсэн дундад зууны үеийн шашны номлолд цохилт болж, төр, иргэний нийгэм, хууль цааз, эрхийн тухай сургаалын хөгжилд багагүй нөлөөлсөн юм.<sup>33</sup>

Академич С.Нарангэрэл “Иргэний нийгэм (англ. *civil society*; ор.гражданское общество) - эл нэр томъёо дэлхийн олон улс оронд нэлээд эрт, харин манай улсын хувьд 1990-ээд оноос хойш хэрэглэж буй, нийгмийн томоохон үзэгдлийг тэмдэглэдэг нэр томъёо хэмээн судлаачид үздэг. Төрөөс ангид, хараат бусаар ардчилсан нийгмийн хэмжээнд оршин хөгжиж байгаа эдийн засаг, соёл ба бусад хүрээний харилцааны нийлбэр цогц. Төрийн болон төрийн хяналтад байдаг институтээс ангид, өөрийн сонирхол, мөн чанар, зорилгоо тунхаглан хамгаалах зорилго бүхий, хувийн секторыг бүрдүүлдэг хувь хүн, хөдөлгөөн, ашгийн төлөө бус, сонирхлын бүлгийн, оон нутгийн, үндэсний ба олон улсын сүлжээ. Энэ сүлжээ нь төрийн секторт нөлөө үзүүлэх зорилгоор байгуулагддаг. Иргэдийн сайн дураараа эвлэлдэн нэгдэж, өөрсдөө ажилладаг зохион байгуулалтын том, жижиг алив нэгдэл нь иргэний нийгмийн илрэх хэлбэр. Төрийн бус байгууллагын статустай бүхэн иргэний нийгэмд хамаарна гэж үздэг” хэмээн тодорхойлсон.<sup>34</sup>

Улс үндэстэн нэг бүрийн үүсэл, хөгжлийн аль ч шатанд иргэний нийгмийн эх элементүүд заавал байдаг. Гэвч иргэний нийгмийн тухайн нэг хэлбэржсэн хэв шинж, үндэсний өвөрмөц хувилбар, загвар нь заавал ч үгүй үндэсний төр улсын үүсэлтэй зэрэгцэж буюу Гегелийнхээр бол бүр төрийн үүслийн дараагаар л буй болдог ажээ. Ингэхлээр иргэний нийгэм нь бүдүүлэг, доод хэв шинжээс боловсронгуй дээд хэв шинжид хувьсан шилжих зүй тогтолтойгоор хөгжиж байдаг. Иргэний нийгмийн хөгжлийн явцад хугарал, нугарал, ухралт ч гарч болдог нь манай орны жишээн дээрээс ч тодорхой байна. Жам ёсоороо оршин хувьсаж буй иргэний нийгэм нь хөгжингүй, боловсронгуй хэв шинждээ дөтлөхийн хэрээр улам бүр хүмүүнлэг, улам бүр ардчилсан шинжтэй болдог нь дэлхийн олон улс орны практик амьдралаар нотлогджээ.<sup>35</sup>

Иргэний нийгмийн суурь зарчмыг илэрхийлдэг ойлголт бол олон ургалч үзэл. Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичигт “Ургалч үзэл лат. (лат. *pluralis*; англи. *pluralism*) - 1.улс төр-эрх зүйн онолд иргэний нийгэм ба эрх зүйт төрийн байгууллын суурь зарчмыг илэрхийлсэн ухагдахуун. Эл ухагдахууны дагуу эдийн засаг, улс төрийн ба соёлын амьдралын хэлбэр ба субъект олон янз байна; 2. олон улсын эрх зүйд үндэс угсаа, арьсны

<sup>31</sup> Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс, УБ., 2006 он, 133-134 дэх тал.

<sup>32</sup> Н.Лүндэндорж, Төрийн онол, УБ., 2020 он, 213 дахь тал.

<sup>33</sup> Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг, УБ., 2020 он, 198 дахь тал.

<sup>34</sup> С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, УБ., 2008 он, 235 дахь тал.

<sup>35</sup> Ж.Амарсанаа, Монгол Улс дахь иргэний нийгмийн судалгааны тойм, Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, УБ., 2013 он, 10-11 дэх тал.

өнгө, шашин шүтлэгээр ялгаатай нийгмийн бүлгүүдийн гишүүд бие даан уламжлалт соёл болон өвөрмөц ашиг сонирхлоо дэлхийн соёл иргэншлийн хүрээнд хөгжүүлэх”<sup>36</sup> гэжээ.

Орчин үеийн нээлттэй нийгмийн оюун санааны үндэс суурь бол олон янзын чөлөөт үзэл бодол, итгэл үнэмшил зэрэгцэн орших, нээлттэй мэтгэлцээн, үзэл бодлын чөлөөт өрсөлдөөн, солилцоо, бодож сэтгэх, сэтгэлгээний эрх чөлөө, сонголт хийх, харилцан буулт хийх зарчим дээр тулгуурлаж байдаг. Энэ ардчилсан зарчим нь хувь хүн үзэл бодол, итгэл үнэмшлийн хувьд эрх мэдлийн дарамт, шахалтгүйгээр өөрийнхөөрөө чөлөөтэй оршин амьдрах боломж, нөхцөл болдог. Иймд ардчилсан улс орон нь нээлттэй, чөлөөт мэтгэлцээн, олон ургалч үзэл бодлыг хүлээн зөвшөөрч баталгаажуулдаг. Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх бол улс төрийн эрх, боломжоо эдлэх, шаардах арга зам юм. Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол хохирох, хөндөгдөх тохиолдолд иргэд өөрсдийн эрхээ хамгаалан үзэл бодлоо илэрхийлэх замаар тэмцэж эсэргүүцэл илэрхийлдэг, энэ утгаараа үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хүний эрх, иргэний эрхийн төлөөх тэмцлийн гол арга, баталгаа юм.

Эрх мэдэлтнүүд илүү их эрх мэдэл, хүч чадлыг өөртөө олж авч эрх мэдлийг төвлөрүүлэх сонирхолтой байдаг бөгөөд харин үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь эрх мэдэлд хяналт тавих, саармагжуулах, тэнцвэржүүлэх, шийдвэр гаргагчийг үнэлж дүгнэх, эрх баригчаас ардчилсан хариуцлага нэхэх, хүний хөгжих эрх, хамтын шийдвэр гаргах, олон ургалч үзлийг хөгжүүлэх, үзэл бодол, соёлын олон төрөл зүйл хөгжүүлэх, нийгэмд ажил хэрэгч хандлага, ил тод байдал, эрүүл саруул, шүүмжлэлт орчин бий болгох, шийдвэр гаргагчийн үзэл бодол, оюун санааны нөлөө үзүүлэх, иргэдээс зөрчигдсэн эрхийнхээ төлөө тэмцэх, эсэргүүцэл үзүүлэх зэрэг шинжээрээ иргэний нийгмийг төгөлдөржүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ шинж чанараараа ард түмэн төрийг удирдах үйл хэрэгт оролцох эрхтэй шууд холбогдоно.

Аливаа үзэл бодол нь баттай хөдөлшгүй үнэн мэдээлэл биш бөгөөд хэрвээ бид хүсвэл түүнийг өөрсдийн төсөөлсөн байдлаар буруу ойлгодог. Хувийн үзэл бодолтой байх эрх чөлөө нь чөлөөт нийгмийг байгуулах урьдчилсан нөхцөл юм.”<sup>37</sup> гэсэн дүгнэлтийг дэмжих үндэслэлтэй.

Монтескье “иргэний нийгэм нь хувь хүмүүс ба гишүүд нь хүмүүний хамгийн дээд чанарыг олж эзэмшсэн хамт олны холбоо юм.” гэж сургажээ. Т.Пэйн “Иргэний нийгэм нь эрхэм сайн зүйл бол төр зайлшгүй үүсдэг хорт муу зүйл тул иргэний нийгэм төгс төгөлдөр болох тусам төр хэрэггүй болно.” гэж хэлжээ. Европ соёл иргэншлийн хөрснөөс үүссэн эдгээр эш онолууд цаашдаа иргэний нийгмийн тухай либерал болон тоталитар философи хөгжих суурь дэвсгэр болж өгсөн.<sup>38</sup>

Хууль зүйн шинжлэх ухааны доктор Н.Лүндэндорж: Иргэний нийгэм бол төрийг хязгаарлах хүч, бололцоогоороо түүнтэй эн тэнцэхүйц нийгмийн жам ёсны хүч мөн. Төрийг Левиафан (далайн домгийн амьтны нэр) болгочихгүй сөрөн зогсож чаддаг цорын ганц хүч нь иргэний нийгэм юм. Нөгөө талаас, иргэний нийгэм өөрөө хувийн ашиг сонирхлын үндсэн орчин учраас хүмүүсийн байгалиас заяасан тэгш бус ашиг сонирхлын туйлшралаас ангид байж эс чадна. Энэ байдал хяналтгүй үргэлжилбэл нийгмийн үндэс эвдэрнэ. Иймд хувийн ашиг сонирхлын туйлшралаас сэргийлэн хамгаалах хүч нь төр бөгөөд энэ нь эрх зүйн аргаар зохицуулах цорын ганц зөвшөөрөгдсөн субъект юм. Иймээс төр, иргэний нийгэм нэгдэлтэй төдийгүй, зөрчилтэй оршдог сөрөг хүчин юм. Эдгээрийн хүч тэнцвэртэй нөхцөлд хувийн болон нийтлэг ашиг сонирхол зөв хосолж, нийгэм хөгжих хэвийн нөхцөл бүрэлдэнэ. Иргэний нийгмийн хүч хэт давамгайлбал нийгэм анархизмд, төр хэт хүчирхэгжвэл тоталитаризмд хүрнэ. Бие биеэ хуулийн хүрээнд харилцан хянах нь

<sup>36</sup> Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг, УБ., 2021 он, 451 дэх тал.

<sup>37</sup> Натаниел Смит, Чөлөөт нийгмийн зарчмууд, УБ., 2016 он, 32-33 дахь тал.

<sup>38</sup> Г.Чулуунбаатар, Ч.Ган-Өлзий, Иргэний нийгмийн судалгааны философи, арга зүйн асуудал, Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, УБ., 2013 он, 18 дахь тал.

хамгийн зохист зам юм.<sup>39</sup>

Нийгэмд төрийн бүтэц, зохион байгуулалт оршиж байдаг, энэ нь нийгмийн цор ганц бүтэц, зохион байгуулалт биш бөгөөд үүнтэй зэрэгцэн олон ургалч үзэл бодол, итгэл үнэмшилтэй иргэний нийгмийн бүтэц, ялгарал, зохион байгуулалт оршин байдаг. Иргэний нийгэм нь харилцан хяналт тавих, тэнцвэржүүлэх чиг үүрэг бүхий олон тооны оролцогчдоос бүрдэх бөгөөд иргэд, иргэний нийгмийн зүгээс төр засаг, шийдвэр гаргагчид өөрийн санал, гомдол, байр суурь, шаардлагаа илэрхийлэх гол арга механизм нь үзэл бодлоо илэрхийлэх эрх, тайван жагсаал, цуглаан хийх эрх юм.

Иргэний нийгмийн байгууллагын гол цөм нь сайн дурын үндсэн дээр бий болсон төр ба эдийн засгийн бус нэгдэл байх ба тэдгээр нь сүм хийд, соёлын нэгдэл, академи, бие даасан зуучлалын хэрэгсэл, чөлөөт цаг, спортын нэгдэл, шүүмжлэл маргааны идэвх санаачилгыг өөртөө багтааж улмаар эдгээр нь цаашлаад мэргэжлийн нэгдэл, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, мөн алтернатив институт болж үргэлжилдэг.<sup>40</sup> Ингэхлээр иргэний нийгмийн байгууллагын хүрээнд төрийн бус байгууллага, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, хэвлэл мэдээллийн байгууллага, шашны бүлгүүд, худалдаа, үйлдвэрлэлийн танхим, сууц өмчлөгчдийн холбоо, эрүүл мэнд, соёл урлаг, спорт, чөлөөт цаг гэх зэргээр бий болсон иргэдийн сайн дурын албан бус бүлгүүд буюу төрийн бус статустай бүхэн иргэний нийгмийн бүтцэд багтдаг байна.<sup>41</sup>

Германы Үндсэн хуулийн эрх зүйч Герхард Роберс “Үндсэн хэм хэмжээний ноён оргил нь Үндсэн хуулийн эхэнд бичигддэг хүний суурь эрх юм” гэжээ.<sup>42</sup> Германы Үндсэн хуульд “хэрэв өөр арга хэмжээ авах боломжгүй болсон бол Герман хүн бослого гаргах эрхтэй” гэсэн иргэний эрхийн заалтыг 1968 оны нэмэлт, өөрчлөлтөөр<sup>43</sup> оруулсан. Энэ зохицуулалт нь төр, иргэний нийгмийн тэнцвэрийг хангасан, төрийн эрх мэдлийн дарангуйллыг сөрөн зогсох иргэний нийгмийн хамгаалалт болж чаджээ.

Гэвч бодит байдал дээр өнөөдөр Монгол Улсад үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх Үндсэн хуулийн баталгаатай хэдий ч саад бэрхшээлтэй замыг туулсаар байна. Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн “Олон нийтийн санал бодлын судалгаа”<sup>44</sup> (2022.3-4 сар)-ны тайлангаас харахад “Манай улсад гарч буй шийдвэрүүдэд энгийн иргэд нөлөөлөх боломжийн магадлал хэр вэ?” асуултад судалгаанд оролцогчдын 59 хувь нь магадлал маш бага, 21 хувь нь зарим талаараа магадлал бага, 12 хувь нь зарим талаараа магадлалтай, 6 хувь нь их өндөр магадлалтай гэж хариулт өгсөн байна. Мөн “Таны бодлоор манай улсын насанд хүрсэн хүн амын бүх гишүүд улс төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцох нь хэр чухал вэ?, доорх бүлгүүдийг оролцуулах нь хэр чухал вэ ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 81 хувь нь залуучууд маш чухал гэж, 63 хувь эмэгтэйчүүд маш чухал хариулт өгсөн нь анхаарал татаж байна. Уг судалгааны дүн нь иргэний нийгмийн зүгээс шийдвэр гаргахад хэр нөлөөлж чадаж байгаа талаарх олон нийтийн санаа бодол юм. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх нь шийдвэр гаргахад оролцох нэг арга хэлбэр. Судалгааны дүнгээс харахад иргэд шийдвэр гаргахад оролцох нь өндөр ач холбогдолтой гэж үзсэн ч бодит амьдрал дээр шийдвэр гаргахад нөлөөлж чаддаггүй гэсэн ойлголттой байна. Энэ нь нэг талаар иргэд болон шийдвэр гаргагчийн дунд итгэлцэл суларч, хоорондын зааг их болж байгааг харуулж хэрэг, нөгөө талаар улс төрийн шийдвэр гаргахад иргэд оролцох ёстой гэсэн байр суурь хүчтэй байгааг илтгэж байна. Ардчилсан зарчмаар бол иргэдийн санал бодлыг сонсох, иргэдтэй зөвшилцөх нь чухал, ард иргэдийн санаа

<sup>39</sup> Н.Лүндэндорж, Төрийн онол, УБ., 2020 он, 218 дахь тал.

<sup>40</sup> Habermas J. “Strukturwandel der Öffentlichkeit” F.a. M., 1990. С.45

<sup>41</sup> Д.Баасансүрэн, Д.Болд-Эрдэнэ, Иргэний нийгэм дэх сонирхлын бүлэг ба улс төрийн нам, Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, УБ., 2013 он, 48 дахь тал.

<sup>42</sup> Ч.Өнөрбаяр, Үндсэн хууль ёсны хөгжил, түүний чиг хандлага, УБ., 2014 он, 58 дахь тал.

<sup>43</sup> Бодлогын судалгаа шинжилгээ XII боть, Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төв, (УБ., 2012), Мөнхийн үсэг хэвлэл үйлдвэр, 316 дахь тал.

<sup>44</sup> <https://www.iri.org/resources/public-opinion-poll-residents-of-mongolia-march-april-2022/>

бодол, гомдол, шаардлагад шийдвэр гаргагч хариу үйлдэл үзүүлдэг нийгмийн тогтолцоог хөгжүүлэхэд үзэл бодлоо илэрхийлэх эрх чухал юм. Шийдвэр гаргагчид иргэдийн санал, шаардлагыг сонсож чаддаг, үр дүнтэй хариу үйлдэл, арга хэмжээ авч чаддаг байхыг иргэд хүсч байгаа нь тодорхой харагдаж байна.

#### **Д. Үг хэлэх эрх ба түүний хүрээ хязгаар**

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хүрээнд нийгмийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал чухлаар хөндөгдөж байдаг, аливаа эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл Үндсэн хууль, Олон улсын гэрээ, пактаар зохицуулагдсан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3-т “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.” гэж заасан.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь нэн чухал боловч энэ нь бусдад сөргөөр нөлөөлж болох талтай учир үүнийг хүний эрхийн хэм хэмжээ анхааралдаа авч байдаг байна. Тиймээс хэвлэл мэдээллийн эрх чөлөөг бусдыг гүтгэн доромжлох боломж олгохоос, үг хэлэх эрх чөлөөг арьс, үндсээр ялгаварлан гадуурхагчид өөрсдийн балмад үйл ажиллагааныхаа бамбай болгон ашиглахаас сэргийлэх ёстой. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын гэрээний 19-р зүйлээр мөн ихэнх бүсийн хүний эрхийн хэм хэмжээгээр батлагдсан байдаг. Энэхүү 19 дэх зүйл ангийг зохиохдоо дээрх эрхэд хязгаар тогтоох нь зүйтэй болох хэд хэдэн нөхцөл байдлыг авч үзсэн. Доорх нөхцөл байдлуудыг үндэслэн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд хязгаарлалт тогтоосон байдаг. Үүнд:

1. Үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс нууцлагдан үлдвэл зохих зүйлсийг нийтэд мэдээлэхгүй байх шаардлагатай нөхцөлд;

2. Хүч хэрэглэн төрийн эргэлтийг хийхийг уриалан дуудах тохиолдолд;

3. Хүмүүсийг шууд гэмт хэрэг үйлдэх нөхцөл байдалд хүргэхээр уриалах тохиолдолд;

4. Хуулийн дагуу явагдаж буй үйл явдалд шударга бус хандах тохиолдолд;

5. Урлаг, уран зохиолын эрхийг боогдуулах үйл ажиллагаа явуулах тохиолдолд;

6. Олон нийтийн эрх ашгийн эсрэг аюул учруулах, заналхийлэх, бусдын нэр хүндэд бие хүн болон хуулийн этгээдийнх нь хувьд халдаж гүтгэн доромжлохыг завдсан тохиолдолд;

7. Төр, иргэд хоорондын найрсаг харьцааг эвдэх зорилгоо тодорхой зохион байгуулалтын дор цуурхал тараах тохиолдолд.

Дээрх жагсаалт нэмэгдэхийн хэрээр илүү ерөнхийд нь авч үзэх шаардлага гарав. Иймд шинээр 19-р зүйлийг батлахад уг зүйлийн 3-р заалтыг нэмж оруулжээ.

*Энэхүү зүйлийн хоёрт дурдсан үг хэлэх эрх чөлөө эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлагыг оногдуулна. Энэ нь гагцхүү хуулиар тогтоосон зарим хязгаарлалттай холбоотой бөгөөд тэдгээр нь:*

*а. бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх;*

*б. үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд буюу ёс зүйг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байна.*

Энэхүү 19-р зүйлийн 3-р заалт нь дээрх эрхээ хэрэгжүүлж байгаа хэн боловч “тусгай үүрэг хариуцлагын” талаар ямагт санаж байх хэрэгтэйг тодотгож өгсөн байдаг.<sup>45</sup>

## **ДҮГНЭЛТ**

Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх бол хүний оюун санааны хэрэгцээ шаардлагатай холбоотой жам ёсны эрх юм. Монгол Улсын Үндсэн хуульд үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан бөгөөд уг эрхийн агуулга, арга хэлбэр, үзэл санаа, мөн чанарыг иргэний нийгмийн үзэл санаа, зарчмын үүднээс

<sup>45</sup> Хүний эрхийн бодлогын олон улсын зөвлөл, Үүргийг чухалчлан үзэх нь: Хүний эрхийн Олон улсын хуулинд хувь хүний үүргийг тусгасан байдал, тайлбар, УБ., 2003 он, 44 дэх тал



тайлбарлан авч үзэв. Үзэл бодлын эрх чөлөө болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хоорондоо салшгүй холбоотой багц эрх чөлөөний бүрдэл бөгөөд иргэний нийгмийн үзэл бодлын илэрхийллийн тогтолцоо, системийн үүргийг гүйцэтгэдэг байна.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь төрийн эрх мэдэл, хяналт, цензур болон нийгмийн зүй бус дарамт, гадуурхалтаас “чөлөөтэй” байх зарчимтай. Энэ нь оюун санаа, ухамсрын хувьд хувь хүн бие даасан, бусдаас хараат бус байх баталгаа юм. Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь тайван арга, хэлбэртэй байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх бол хүчирхийлэл, албадлагын арга хэрэгсэл биш юм. Хүн өөрийн үзэл бодол, итгэл үнэмшилтэй байх эрхийн хамт түүнийгээ түгээх, илэрхийлэх замаар олон нийт, эрх баригч, бусдын оюун санаа, сэтгэл зүйд нөлөөлөх, дэмжлэг авах, хүлээн зөвшөөрөгдөх арга зам, боломж юм.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх бол нийгэмд оршиж байгаа дутагдал, хүний эрхийн зөрчил, эрх баригчийн алдаатай бодлого, шийдвэр, үйл ажиллагааг олон нийтийн өмнө шүүмжлэн ил болгох, эсэргүүцэл илэрхийлэх “нийгмийн сэрүүлэг”-ийн үүргийг гүйцэтгэдэг. Ардчилсан нийгэмд ийм механизм байхгүй бол олон нийтэд ямар ч мэдээлэл очихгүй, эрх баригч, шийдвэр гаргагчийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх ямар ч боломжгүй юм.

Орчин үеийн нээлттэй, иргэний нийгмийн оюун санааны үндэс суурь бол олон янзын чөлөөт үзэл бодол, итгэл үнэмшил зэрэгцэн орших, нээлттэй мэтгэлцээн, үзэл бодлын чөлөөт өрсөлдөөн, солилцоо, бодож сэтгэх, сэтгэлгээний эрх чөлөө, сонголт хийх, харилцан буулт хийх зарчим дээр тулгуурлаж байдаг. Энэ ардчилсан зарчим нь хувь хүн үзэл бодол, итгэл үнэмшлийн хувьд эрх мэдлийн дарамт, шахалтгүйгээр өөрийнхөөрөө чөлөөтэй оршин амьдрах боломж, нөхцөл болдог. Иймд ардчилсан улс орон нь нээлттэй, чөлөөт мэтгэлцээн, олон ургалч үзэл бодлыг хүлээн зөвшөөрч баталгаажуулдаг. Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх бол улс төрийн эрх, боломжоо эдлэх, шаардах арга зам юм. Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол хохирох, хөндөгдөх тохиолдолд иргэд өөрсдийн эрхээ хамгаалан үзэл бодлоо илэрхийлэх замаар тэмцэж эсэргүүцэл илэрхийлдэг, энэ утгаараа үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хүний эрх, иргэний эрхийн төлөөх тэмцлийн гол арга, баталгаа юм.

Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх бол ардчиллыг хөгжүүлэх, улс төрийн эрх мэдэлд хяналт тавих, шийдвэр гаргагчийг үнэлж дүгнэх, эрх баригчаас ардчилсан хариуцлага нэхэх, хүний хөгжих эрх, хамтын шийдвэр гаргах, олон ургалч үзлийг хөгжүүлэх, үзэл бодол, соёлын олон төрөл зүйл хөгжүүлэх, нийгэмд ажил хэрэгч хандлага, ил тод байдал, эрүүл саруул, шүүмжлэлт орчин бий болгох, шийдвэр гаргагчийн үзэл бодол, оюун санааны нөлөө үзүүлэх, иргэдээс зөрчигдсөн эрхийнхээ төлөө тэмцэх, эсэргүүцэл үзүүлэх зэрэг шинжээрээ нийгмийг төгөлдөржүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Өнөөдөр нэг талаар иргэд болон шийдвэр гаргагчийн дунд итгэлцэл суларч, хоорондын зааг их болж байгаа нь харагдаж байгаа, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн эсрэг төрийн эрх мэдлийг хэтрүүлэх хандлага гарсаар байгаа болно. Шийдвэр гаргагч нь иргэдийн санал бодлыг сонсох, иргэдтэй зөвшилцөх, харилцан буулт хийх чадвартай байх, төр нь иргэдийн санаа бодол, гомдол, шаардлагад эерэг хариу үйлдэл үзүүлдэг ардчилсан нийгмийн тогтолцоог хөгжүүлэхэд үзэл бодлоо илэрхийлэх эрх чухал юм.

## ЭХ СУРВАЛЖ

1. Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс, УБ., 2006 он.
2. Б.Чимид, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө.
3. Бернард Крик, Ардчиллын тухай, товч танилцуулга, УБ., 2019 он.
4. Бодлогын судалгаа шинжилгээ XII боть, Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төв, (УБ., 2012), Мөнхийн үсэг хэвлэх үйлдвэр.
5. Д.Гангабаатар, Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Үндсэн хуулиар хамгаалах нь, УБ., 2015 он.
6. Д.Чулуунжав, Нийгмийн философи, онол туршилт сургамж шүүмж, ШУА, УБ., 2014 он.
7. Д.Баасансүрэн, Д.Болд-Эрдэнэ, Иргэний нийгэм дэх сонирхлын бүлэг ба улс төрийн нам, Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, УБ., 2013 он.
8. Г.Чулуунбаатар, Ч.Ган-Өлзий, Иргэний нийгмийн судалгааны философи, арга зүйн асуудал, Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, УБ., 2013 он.
9. Ё.Довчин, Төр шашны харилцааны түүхэн хэлбэрүүд, МУИС-ын НШУС, Шашин судлалын тэнхим, Шашин шүтэх, эс шүтэх эрх, чөлөө, УБ хот, 2004 он.
10. Конрад-Аденауэр сан, Илүү сайн ардчилал. Төлөөллийн ардчиллын үндсэн зарчмууд, 2017 он.
11. Ж.Амарсанаа, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, Ханнс Зайделын сан, “Эргэцүүлэл”, №7, 2000 он.
12. “Сэтгүүлч ба хууль” цуврал, №03.
13. Натаниел Смит, Чөлөөт нийгмийн зарчмууд, УБ., 2016 он.
14. НҮБ, Шүүн таслах ажиллагаанд хүний эрхийг хангах нь, шүүгч, прокурор, өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага, УБ., 2005 он.
15. Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2009 он.
16. Н.Лүндэндорж, Төрийн онол, УБ., 2020 он.
17. О.Мөнхсайхан, Үндсэн хуульд ёс суртахууны тайлбар хийх нь, Эрх зүй сэтгүүл, УБ., 2016 он, №1 (33).
18. Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль.
19. Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг, УБ., 2021 он.
20. Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг, УБ., 2020 он.
21. Ж.Амарсанаа, Монгол Улс дахь иргэний нийгмийн судалгааны тойм, Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, УБ., 2013 он.
22. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, УБ., 2008 он.
23. Ч.Өнөрбаяр, Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага, УБ., 2014 он.



---

## THE RIGHT TO FREEDOM OF SPEECH OR EXPRESSION: ITS HISTORY AND ROLE IN A DEMOCRATIC SOCIETY

*Orosoo D.*

*Legal Information and Research Activities Society researcher,*

*Ph.D. candidate of School of Law, NUM*

### **ABSTRACT**

The Constitution of Mongolia guarantees the right to free speech and expression of opinion, and the contents, methods, ideals, and nature of these rights explain from the perspective of the ideals and principles of civil society. The right to express one's opinion is not a peaceful method or form of violence or coercion, but a way and opportunity for a person to influence the psychology of the authorities and the public by spreading their opinion to get support, acceptance, and consensus. Concluded that the foundation of a modern open and civil society is the diversity of free opinions and beliefs, the need for open debate, the exchange of ideas, and the role played by the right to freedom of expression in civil society. The right to free speech and expression is to control the authorities, demand democratic responsibility from the authorities, make collective decisions, develop a multi-faceted view of things, create a business-like attitude in society, to build a transparent, sane, and critical environment, which will help to improve the democratic society by fighting for the violated rights of the citizens.

### **Keywords**

Freedom of expression, Belief, Civil society, Fundamental rights

## АРИЛЖААНЫ ЭРХ ЗҮЙН АНТРОПОЛОГИ: ХУУЛЬ ЗҮЙН НЭР ТОМЬЁОНЫ АСУУДАЛ



*С.Номынбаясгалан*  
*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн*  
*докторант, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн*  
*докторант*

### ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүллийн сэдвийг “Арилжааны эрх зүйн антропологи” гэж томьёолон, агуулгыг хууль зүйн нэр томьёоны асуудлаар хязгаарлав. Антропологи бол бодит туршлагад суурилсан ухаан юм. Судлагдахуун нь гол төлөв урт хугацааны туршид зорилтот оролцогчдыг ажиглаж, бодит амьдрал дээрх зүйлсийг судлахад оршино. Өөрөөр хэлбэл антропологичид эртний болон өмнө судлагдаагүй зүйлсийг хамруулан аливаа юмс, үзэгдэл зэрэг олон хэлбэрээр орших нийгмийн үзэгдлийг судалдаг. Эрх зүйн антропологи бол антропологийн ухаанд XIX зууны дунд үеэс бий болсон ууган салбар бөгөөд эрх зүйн антропологи нь олон янзын нийгэм, соёлын онцлог ялгааг нэг талаас нийгэм, соёлын; нөгөө талаас эрх зүйн харилцааны үүднээс судалдаг.

### ТҮЛХҮҮР ҮГС:

Арилжааны төрөлжсөн хууль, Арилжааны эрх зүй, Эрх зүйн антропологи, Худалдаа, Арилжааны үнэт цаас, Арилжааны вексель, *lex mercatoria* (арилжааны хууль).

### I. Оршил

Хувийн эрх зүйн нэг гол салбар болсон худалдааны эрх зүйн нэр томьёо, суурь ойлголт нь Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан болон хууль тогтоомжид хэдийнээ тогтсон төдийгүй гагцхүү хүлээн зөвшөөрөх л үлдсэн талаар судлаачид<sup>1</sup> бичсээр ирэв. Монгол Улсын хувийн эрх зүйд тулгамдаж байгаа гол асуудлын нэг нь “**худалдааны эрх зүй буюу арилжааны эрх зүй, түүний хэм хэмжээ зохистой хэмжээнд бүрэлдэн бий болоогүй, системчлэгдээгүй байгаа явдал**”<sup>2</sup> гэж үзэж болохоор байна. Эдийн засгийн хөгжлийг дэмжихийн тулд арилжааны эрх зүйн кодификацийг нэмж батлах асуудал<sup>3</sup> нэн

<sup>1</sup> Б.Амарсанаа, Хувийн эрх зүйд аж ахуйн (худалдааны) эрх зүйн нэр томьёоны эзлэх байр суурь, Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2016, 137 дахь тал.

<sup>2</sup> Б.Амарсанаа, Иргэний ба худалдааны хууль тогтоомжийн цаашдын хандлага, хөгжүүлэх шаардлага, Монгол Улсын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг, Олон улсын симпозиумын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2019, 44 дэх тал.

<sup>3</sup> Б.Буянхшиг, Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт, УБ., 2021, 306 дахь тал.

ялангуяа, Арилжааны тухай хуулийн төслийг боловсруулах явцад “Иргэний хуулийн тусгай зохицуулалтыг өөртөө агуулсан бие даасан хуулийн нэршил ямар байх, энэ хууль үйлчлэх с УБъект, гэрээ хэлцлийг хэрхэн багцлан нэр оноох асуудал урган гарч, хуулийн төслийг боловсруулах хүртэлх хугацаанд олон нэр томъёог оноон хэрэглэж ирсэн”<sup>4</sup> байна. Энэхүү хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах талаарх (2019) судалгааны тайланд “. . . дийлэнх улсуудын хувьд бие даасан Арилжаа /Худалдаа/-ны хуулийг батлах замаар иргэн болон аж ахуй эрхлэгчийн харилцааны онцлогоос хамааран ялгамжтай зохицуулж байгаа тул манай улсын хувьд ч одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд иргэн болон аж ахуй эрхлэгчийн харилцааг ялгамжтайгаар зохицуулах шаардлага үүссэн . . .”<sup>5</sup> гэсэн дүгнэлтийг хийв. Харин Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ хэмээх (2021) судалгааны тайланд “. . . ямартай ч энэ тохиолдлыг сонгон авч манай улсад арилжааны хуулийг тусад нь батлах, шүүхийн практикт нэг мөр хэрэглээг бий болгох зайлшгүй шаардлага байгааг харуулж байна . . .”<sup>6</sup> гэсэн зөвлөмжийг гаргав. Энэ нь иргэний эрх зүйгээс бие даасан арилжааны салбар эрх зүйн асуудалд нэлээд анхаарал хандуулах болсныг харуулав. Арилжааны эрх зүй нь бие даасан салбар эрх зүй болох хүрээнд “арилжааны эрх зүйтэй зэрэгцэн оршдог бусад салбар эрх зүйн холбоо хамаарлыг хэрхэн ойлгох вэ” гэсэн асуулт хариултаа хүлээсээр байна. Тухайлбал, Арилжааны эрх зүй болон иргэний эрх зүй, хөдөлмөрийн эрх зүй зэргийн холбоо хамаарлыг тодорхойлж, арилжааны эрх зүйн онцлогийг хэрхэн авч үзэх асуудал чухлаар тавигдаж, анхаарал татсаар байна.<sup>7</sup> Энэ нь Монгол Улсад арилжааны хуулийн, эвсэл арилжааны эрх зүйн антропологийн судалгааг (арилжааны эрх зүйд хамаарах зохицуулалтыг зайлшгүй антропологичлох) хийх хэрэгцээ шаардлага бий болсныг харуулж байна.

Өнөө үед эрх зүйн ерөнхий онол нь дэлхийн улс орнуудад, ялангуяа эх газрын эрх зүйн тогтолцоотой улс оронд хууль зүйн цоо шинэ шинэ шинжлэх ухааны (эрх зүйн антропологи) шинэ мэдлэг, арга зүйн болон үзэл суртлын олон урьгалч хандлагад тулгуурлан хөгжиж байна.<sup>8</sup> Жишээлбэл, АНУ–ын олон улсын хувийн эрх зүйн хөгжил нь салбар дундын байдлаар буюу эдийн засаг, улс төр ба антропологийн ухааны чиг хандлагыг хослуулан хөгжсөөр байна.<sup>9</sup> Иймээс л дэлхийн улс орон бүр “өөрийн” гэсэн үндэсний эрх зүйн тогтолцоотой ба тэдгээр нь хүн амын амьдралын хэв маяг, зан заншил, эрх зүйн уламжлал, сэтгэлгээний хувьд өөр хоорондоо ихээхэн ялгаатай учраас энэхүү онцлог байдлыг харгалзан зохицуулах асуудал үндэсний эрх зүйн шинжлэх ухаан бүрийн өмнө зүй ёсоор тавигдаж ирэв. Бид ч гэсэн дэлхийн хөгжил, соёл иргэншлийн хандлага, эрх зүйн жишгээс хоцролгүй зэрэгцэн алхахыг эрмэлзэж ирсэн түүхтэй. Үүний нэг тод жишээ нь “БНМАУ–ын Худалдааны тухай хууль”<sup>10</sup> зэрэг болно. Мөн түүнчлэн хууль зүйн сургалтад аж ахуйн эрх зүй гэсэн хичээл орохын зэрэгцээ ийм нэр томъёо хэрэглэгдэж байсан нь арилжааны эрх зүй гэх нэр томъёотой хамааралтай эсэх зэргээр судалгааг хийх нь урт удаан хугацаанд энэ худалдаа, арилжаа, аж ахуй эрхлэх гэсэн ойлголтууд хэрхэн хувьсаж, өөрчлөгдөж ирсэн болохыг утгаар нь судлах боломжтой юм. Энэ байдлыг харгалзан эрх зүйн антропологийн ухааны үүднээс авч үзэх хэрэгцээ шаардлага монголын эрх зүйн тогтолцоонд үгүйлэгдэнэ. Энэ

<sup>4</sup> Амарсанаа Б., Арилжаа хэмээх нэр томъёог эргэцүүлэхүйд, Эрх зүйн дээд боловсрол ба хууль зүйн шинжлэх ухаан, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2021, 261 дэх тал.

<sup>5</sup> Арилжаа (худалдаа)–ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, (Судалгааны тайлан), УБ., 2019, 89 дэх тал [https://mongolia.hss.de/fileadmin/user\\_upload/Projects\\_HSS/Mongolia/Dokumente/2019/HGB\\_Studie.pdf](https://mongolia.hss.de/fileadmin/user_upload/Projects_HSS/Mongolia/Dokumente/2019/HGB_Studie.pdf) (Сүүлд үзсэн огноо: 2022.11.01)

<sup>6</sup> Шүүхийн ерөнхий зөвлөл, Hanns Seidel Stiftung., Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, (Судалгааны тайлан), УБ., 2021, 140 дэх тал.

<sup>7</sup> Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, Пүрэвбаатар П., Ганхүрэл Д., Арилжааны эрх зүй, (Анхны хэвлэл), УБ., 2022, 13 дахь тал.

<sup>8</sup> Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол, (Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал), Хоёр дахь хэвлэл, УБ., 2017, 44 дэх тал.

<sup>9</sup> Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй, (Орчин үеийн чиг хандлага), УБ., 2019, 48 дахь тал.

<sup>10</sup> Амарсанаа Ж., Чимид Б., ба бусад, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Гуравдугаар боть, (1926 VI сар – 1936 он), УБ., 2010, 625 – 628 дахь тал.

нь “*эрх зүйн антропологи*г Монгол Улсад хөгжүүлэх нэн таатай нөхцлийг бүрдүүлэхээс гадна антропологиин судалгааг дан ганц эрх зүйн онол, номлолын хүрээнд бус харин хууль зүйн хэрэглээ болгох үүднээс хувийн эрх зүйн хүрээнд, тэр дундаа арилжааны эрх зүйн чиглэлээр төрөлжүүлэн хийх” нөхцөл боломжийг бүрдүүлээд байна. Эрх зүй судлалын шинжлэх ухааны салбарууд болох нь “эрх зүйн философи, эрх зүйн онолын”<sup>11</sup> нэгэн адил эрх зүйн антропологи нь эрх зүйн судлалын шинжлэх ухааны нэг салбар”<sup>12</sup> гэж үзэж болох юм. Хувийн эрх зүй дэх худалдаа / арилжааны эрх зүйн нэр томьёоны нэршил, оноолтын асуудлыг антропологиин үүднээс авч үзэх нь хууль зүйн шинжлэх ухаанд, нэн ялангуяа антропологиин судалгааг арилжаа, арилжааны эрх зүй гэх нэр томьёонд хэрэглэх нь ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна. Энэ чиглэлээр төдийлөн судлаагүй, судалгааны бүтээл хомс байна. Иймд арилжааны хуулийн, эсвэл арилжааны эрх зүйн антропологиин тухай лавшруулан судлахаас өмнө нэн тэргүүнд нэр томьёог цэгцлэх жишээлбэл, гадаад хэлэн дэх “commerce”, “trade” хэмээх нэр томьёо, тэдгээрийн агуулга, хэрэглээ монгол хэлэн дэх арилжааны эрх зүй, мөн түүнчлэн “арилжааны эрх зүйн антропологи”, эсвэл “арилжааны хуулийн антропологи” хэмээх нэр томьёоны үзэл санаа, утга агуулгыг антропологиин ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны үүднээс хэрхэн зөв оноож хэвшүүлэн хэрэглэх вэ, эдгээр ухагдахуун хоорондоо хэрхэн зохицон нийцэх вэ, ухагдахуунуудыг ялгах зайлшгүй шаардлага бий юу гэсэн асуултууд зүй ёсоор тавигдаж байна.

Цаашлаад Монгол хэлний тухай хуульд “...эрдэм шинжилгээний ажилд шинжлэх ухааны нэр томьёог монгол хэлнээ орчуулан хэрэглэхийг эрхэмлэнэ...”<sup>13</sup> гэж заасныг харгалзан арилжааны хуулийн антропологи, эсвэл арилжааны эрх зүйн антропологи гэсэн гадаад нэр томьёогоор нэрлэн хэрэглэхээс илүүтэй цаашид монгол хэлэнд арилжааны хуулийн хүн судлал, эсвэл арилжааны эрх зүйн хүн судлал гэж буулгаж, нэрлэж хэвших нь зүйтэй юу гэдгийг авч үзэх хэрэгтэй байна. Учир нь эрх зүйн гүн ухаан гэхийн оронд дэлхий нийтээр хэл зүйн хувьд ижил хэрэглэдэг философи гэдэг нэр томьёогоор нь “эрх зүйн философи” гэж нэрлэдгийн адил антропологи гэсэн нэр томьёог монгол хэлэнд хөрвүүлэхгүй арилжааны эрх зүйн антропологи гэх нь зохистой байна уу эсвэл заавал орчуулж арилжааны эрх зүйн хүн судлал гэх нь оновчтой юу гэсэн асуултууд зүй ёсоор тавигдаж, хариултаа хүлээсээр байна. Жишээ болгон дурдвал доктор, профессор Б.Амарсанаа хувийн эрх зүй дэх нэр томьёо “хоорондоо давхцалтай, нэг зүйлийг 2 өөр нэр томьёогоор, 2 өөр зүйлийг нэг нэр томьёогоор илэрхийлсэн байгаа байдал ажиглагдав”<sup>14</sup> гэж дүгнэв. Тэрээр нэр томьёоны хувьд “англи хэлний sale гэсэн нэр томьёо бус commerce гэсэн үгээр худалдааны эрх зүйг илэрхийлэх нь оновчтой”<sup>15</sup> гэж бичиж байв. Эцэст нь “commercial law гэдгийг худалдааны эрх зүй бус арилжааны эрх зүй, commercial code гэдгийг худалдааны хууль бус арилжааны хууль гэх нь оновчтой”<sup>16</sup> гэж үзсэн байна. Зарим судлаачид “худалдааны эрх зүй гэсэн нэр томьёог commercial law гэсэн нэр томьёонд буулган”<sup>17</sup> хэрэглэж байна. Тэгвэл Эрх зүйн эх толь бичиг хэмээх (2008) бүтээлд “арилжааны эрх зүй гэсэн нэр томьёоны оронд худалдааны эрх зүй гэж нэрлэх нь адил

<sup>11</sup> Х.Сэлэнгэ, Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 151 дэх тал.

<sup>12</sup> С.Номынбаясгалан, Эрх зүйн антропологи /Эрх зүйн хүн судлал/, Эрх зүй сэтгүүл, УБ., 2022, №3

<sup>13</sup> Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 02 дугаар сарын 12–ны өдөр баталсан Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйл (**Монгол хэлнийг хэрэглэх**)–ийн 6.5 дахь хэсэгт “*Бүх шатны сургалт, эрдэм шинжилгээний ажилд шинжлэх ухааны нэр томьёог монгол хэлнээ орчуулан хэрэглэхийг эрхэмлэнэ*” гэж хуульчилсан байна.  
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=10932> (Сүүлд үзсэн: 2022.11.10)

<sup>14</sup> Б.Амарсанаа, Хувийн эрх зүйд аж ахуйн (худалдааны) эрх зүйн нэр томьёоны эзлэх байр суурь, Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2016, 136 дахь тал.

<sup>15</sup> Б.Амарсанаа, Иргэний ба худалдааны хууль тогтоомжийн цаашдын хандлага, хөгжүүлэх шаардлага, Монгол Улсын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг, Олон улсын симпозиумын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2019, 29 дэх тал.

<sup>16</sup> Б.Амарсанаа, Арилжаа хэмээх нэр томьёог эргэцүүлэхүйд, Эрх зүйн дээд боловсрол ба хууль зүйн шинжлэх ухаан, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2021, 273 дахь тал.

<sup>17</sup> Б.Буянхшиг, Худалдааны эрх зүйг иргэний эрх зүйгээс зааглах онолууд кодификацын асуудал болох нь, Эрх зүй сэтгүүл, УБ., 2017, №3, 161 – 176 дахь тал.

ойролцоо угтатай”<sup>18</sup> гэж тэмдэглэсэн байна. Иймд commercial law хэмээх ойлголтыг энэхүү өгүүлэлд арилжааны эрх зүй гэсэн нэршилээр хэрэглэхээр тогтов. Энэ байдлыг харгалзан энэхүү өгүүлэлээр нэр томьёоны нэршил, оноолтын талаар авч үзэхийг гол зорилгоо болгов. Энэ үндсэн дээр арилжааны эрх зүй, арилжааны эрх зүйн антропологи гэж юу болохыг тодорхойлох оролдлого хийв.

## II. Арилжааны эрх зүйн антропологийн ерөнхий ойлголт, судлах зүйл, нэр томьёо

Монголын эрх зүйн тогтолцоонд үнэт зүйлсийн томоохон өөрчлөлт явагдаж, шинэ суурь ойлголтууд Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиудаар дамжин орж ирсэн бөгөөд эдгээрийг үндсэнд нь хоёр багц байдлаар авч үзэж болохоор байна. Эхнийх нь бол хүний эрх, эрх чөлөө, либерал ардчилал, эрх зүйт төр, парламентын засаглал зэрэг төр оршин байх үндэстэй холбоотой асуудал байсан бол удаах багц өөрчлөлтөд хувийн өмч, хувь этгээд аж ахуй, худалдаа эрхлэх зэргээр ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах, газар хувьчлал буюу өмчлөл, байгалийн баялгийг хувийн этгээд олборлон ашиглах, гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих зэрэг улс оршин тогтнох эдийн засгийн үндэстэй хамаатай асуудал байв.<sup>19</sup> Энэхүү өгүүлэлээр хөндөн буй асуудал нь угтаа улс оршин тогтнох эдийн засгийн үндэстэй зарим талаар холбогдох юм. Арилжааны эрх зүйн антропологийн талаар нэр томьёоны тайлбарыг хийж байгаа бол мэдээж, түүний ойлголт, агуулга, судлах зүйлийг авч үзэх нь нэр томьёог илүү зөв, тодорхой болгоно гэж үзэж байна. Мөн түүнчлэн арилжааны хуулийн антропологи, эсвэл арилжааны эрх зүйн антропологи хэмээх ухагдахуунтай хэрхэн зохицон нийцэх тухай асуудлуудад хариулт өгөхийг оролдлоо. Эдгээр асуултуудын хариулт нь нэгэн зангилаа бөгөөд нэгнийх нь хариулт нөгөөгөө тодруулсаар төгсгөлд нь илэрхий тодорхой болно гэж үзэж байна. Хариултаа сүүлээс нь буюу нэр томьёоны утга агуулга, түүний хэрэглээний талаар авч үзье.

### A. Арилжаа хэмээх нэр томьёог эргэцүүлэх нь

Дэлхийн эрх зүйн түүх хэмээх (2020) орчуулгын бүтээлд “Lex Mercatoria” гэснийг Арилжааны хууль гэж орчуулсан байна.<sup>20</sup> Монгол хэлэнд ашгийн төлөө үйл ажиллагааг “худалдаа”, “арилжаа”, “бизнес” гэх мэтээр нэрлэж байна. Энэхүү ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн нэг гол шинж нь тэрхүү үйл ажиллагаагаа тогтвортой, үргэлжилсэн байдлаар, байнга эрхэлдэгт оршдог гээд энэ үүднээс авч үзвэл арилжааны эрх зүйн субъектэд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж, хувь хүртэх боломж бүхий хувь хүнээс хуулийн этгээд хүртэлх бүхий л этгээдийг хамааруулж, тийнхүү тайлбарлах боломж бий.<sup>21</sup> Харин Санхүүгийн философи: дэлхийн санхүүгийн түүх хэмээх (2017) бүтээлд “...олон тооны хууль, бодлого баталж ирсэн боловч хөрөнгийн захыг хөгжүүлэх дорвитой алхам хийж чадсангүй. Эдийн засгийн дэд бүтэц нь санхүүгийн зах юм...”<sup>22</sup> гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Монголын эдийн засгийн дэлгэрэнгүй тайлбар толь хэмээх (2021) бүтээлд “Худалдаа

<sup>18</sup> С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, Хоёр дахь хэвлэл, УБ., 2008, 40 дэх тал.

<sup>19</sup> Б.Амарсанаа, Иргэний ба худалдааны хууль тогтоомжийн цаашдын хандлага, хөгжүүлэх шаардлага, Монгол Улсын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг, Олон улсын симпозиумын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2019, 28 – 29 дэх тал.

<sup>20</sup> XIII зуунд, Сэргэн мандалт өмнөд Европоос эхлэн дэлгэрсээр худалдаа нэмэгдэж, ари лжаа цэцэглэв. Бизнесийн үйл ажиллагаа өргөн далайцтай болж, тэр хэрээр бизнес эрхлэгчид худалдааны заншил, практикт үндэслэсэн албан бус дүрмүүдийг баримтлах болжээ. Ийнхүү тогтсон удирдлага болон номлол дүрмүүдээ латинаар “*Lex Mercatoria*” буюу Арилжааны хууль гэж нэрлэн, гаргасан маргааныг худалдааны гол замуудын дагуу байгуулагдсан арилжааны шүүхүүдээр шийдвэрлэх үндэс болгожээ. Нэгдмэл хуулиуд нь гадаадын худалдаачид тухайн орон нутагт бизнес хийхэд тулгарч байсан тодорхойгүй байдлыг арилгасан зарчмын давуу талыг авчирсан байна. Lex Mercatoria нь хэдийгээр Европ даяар үүссэн боловч зарим талаар Магна Хартагийн ачаар худалдаа наймаа хөгжсөн Англид хурдтайгаар тархав. Магна Хартад шууд зааснаар бүх худалдаачид “Англид аюулгүй ирж Англиар аюулгүй оршин суух, аялах”, “хээл хахуулыг үйгээр худалдаж, худалдан авах” боломжтой байв.

Майкл Х.Роффэр., Дэлхийн эрх зүйн түүх, (Хаммурабигаас Олон улсын эрүүгийн шүүх хүртэлх эрх зүйн түүхийн 250 онцлох үйл явдал), УБ., 2022, 46 дахь тал.

<sup>21</sup> Б.Амарсанаа, Г.Давааням, С.Багбаяр, Н.Норовсамбуу, П.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, Арилжааны эрх зүй, (Анхны хэвлэл), УБ., 2022, 11 дэх тал.

<sup>22</sup> Ганзориг Ө., Санхүүгийн философи (Дэлхийн санхүүгийн түүх), УБ., 2017, 181 дэх тал.

гэсэн үгийг Trade гэж орчуулан буулгасан төдийгүй утга агуулгын тайлбарыг хийсэн<sup>23</sup> байв. Санхүүгийн философи хэмээх (2017) бүтээлд “...дэлхийн анхны хувьцааны арилжааны тухай ном болох “Confusion of confusions” буюу Төөрөгдлүүдийн төөрөгдөл...”<sup>24</sup> гэж хэлбэрт бус агуулгад ач холбогдол өгч орчуулсан болох нь харагдаж байна. Түүнчлэн санхүү удирдлага (менежмент)–ын бүтээлүүдэд “Санхүүгийн зах зээлд оролцогчдын хооронд шууд арилжаа гүйлгээ хийгддэг учраас аль аль талд хаана хөрөнгө оруулж, хаанаас хөрөнгө төвлөрүүлж байгаа нь тодорхой байдаг. Санхүүгийн зах зээлүүдийг арилжаалж буй санхүүгийн хэрэгслээс нь хамаараад хөрөнгийн, мөнгөний, гадаад валютын, уламжлагдсан зах зээл гэх мэтээр хэд хэдэн төрөлд ангилна.<sup>25</sup> Эдгээр нь үнэт цаасны төрөл, хамрах хүрээ, үйлчилгээний төрлөөрөө ялгаатай. Хөрөнгө оруулагч, зээл авагчдын хооронд явагдаж байгаа капиталын шилжилтийн хөдөлгөөн нь: шууд арилжаагаар, хөрөнгө оруулалтын банкаар зуучлуулах замаар, санхүүгийн зуучлагчдаар үйлчлүүлэх замаар хийгдэж байна”<sup>26</sup> гэж тэмдэглэсэн байна. Жишээ болгон дурдвал, арилжааны үнэт цаас (commercial paper)<sup>27</sup>, арилжааны вексель (commercial bill)<sup>28</sup>, арилжааны зардал (commerce cost)<sup>29</sup> гэх зэрэг нэр томъёог түгээмэл хэрэглэж байна. Эдийн засаг, санхүүгийн хүрээнд trade (худалдаа), commerce (арилжаа) гэсэн нэр томъёонуудыг ийнхүү ялгамжтай байдлаар буулган хэрэглэж буйг анхаарах зайлшгүй шаардлага байна.

Харин хууль зүйн үүднээс нэр томъёоны хувьд доктор, профессор Б.Амарсанаа Арилжаа хэмээх нэр томъёог эргэцүүлэхүйд (2021) хэмээх бүтээлд “Арилжаа (commerce), арилжааны үйл ажиллагаа, түүнийг эрхлэх гэсэн нэр томъёог ашиг олох зорилготойгоор эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх замаар иргэний гүйлгээнд оролцох буюу бараа, бүтээгдэхүүн худалдах, цааш худалдах зорилгоор эсхүл үйл ажиллагаанд хэрэглэх, ашиглах зорилгоор худалдан авах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, түрээслэх, солилцох, санхүүжүүлэх, тээвэрлэх, хадгалах, даатгах зэрэг үйл ажиллагаа, түүнийг эрхлэх явдал гэж ойлгох нь зүйтэй гээд commercial law гэдгийг худалдааны эрх зүй бус арилжааны эрх зүй, commercial code гэдгийг худалдааны хууль бус арилжааны хууль гэх нь оновчтой болно”<sup>30</sup> гэж үзэв. Харин Д.Авирмэд зэрэг судлаачид “commerce – худалдаа гэсэн латин үгнээс гаралтай”<sup>31</sup> гэж бичиж байв. Түүнчлэн доктор Б.Буянхишиг зэрэг судлаачид “худалдааны

<sup>23</sup> Худалдаа (Trade): Барааг худалдах, худалдан авах, солилцох, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн эдийн засгийн үйл ажиллагааны хэлбэр бөгөөд үүнд барааг худалдан авагчид хүргэх, бэлтгэх, хадгалах, мэдээллээр хангах зэрэг үйлчилгээг бас хамруулан ойлгоно. Явцуу утгаар авч үзвэл худалдах, худалдан авч талуудын хоорондын гэрээ, хэлэлцээр ч гэж хэлж болно. Худалдаа арилжааны үйл ажиллагаа нь мөнгөний тусламжтайгаар явагдана, зарим тохиолдолд бараануудын шууд солилцоо буюу бартерын хэлбэрээр мөнгөгүй хэлбэрээр ч хэрэгждэг. Аль ч улс орны хувьд худалдаа нь төсөв, татварын орлогын эх үүсвэрийг бүрдүүлэгч чухал салбар гэж тооцдог. Худалдаа нь аливаа бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээнд оролцдог, худалдагч болон худалдан авагчийг ойртуулагч завсрын үйлчилгээний хамгийн чухал үе шат мөн. Худалдааг чиглэл, орон зайгаар нь дотоод болон гадаад худалдаа; хамрах хүрээ, шинж чанараар нь бөөний ба жижиглэнгийн худалдаа гэж ангилна. Дотоод худалдаа нь нэг орны нутаг дэвсгэрийн дотор, харин гадаад худалдаа нь улс орнуудын хооронд явагдах бөгөөд үүнийг дотор нь импортын, экспортын ба дамжин өнгөрөх худалдаа гэж хуваана.

Монголын эдийн засгийн дэлгэрэнгүй тайлбар толь, (Анхдугаар хэвлэл), УБ., 2021, 791 дэх тал.

<sup>24</sup> Ө.Ганзориг, Санхүүгийн философи (Дэлхийн санхүүгийн түүх), УБ., 2017, 110 дахь тал.

<sup>25</sup> Б.Бүжинлхам, Санхүүгийн удирдлага, (Дөрөв дэх хэвлэл), УБ., 2012, 31 дэх тал.

<sup>26</sup> Л.Жаргал, Ж.Бат–Өлзий, Санхүүгийн менежмент, (Гурав дахь хэвлэл), УБ., 2008, 104 дэх тал.

<sup>27</sup> Арилжааны үнэт цаас (Commercial paper) – бизнесийн томоохон байгууллагууд богино хугацаагаар гаргадаг баталгаагүй өрийн бичиг, хүүнийхэмжээ нь суурь хүүнээс бага. Нэрлэсэн үнийг нь өндөр тогтоосон байдаг. Commercial paper – Арилжааны үнэт цаас гэж монгол хэлэнд буулгасан байна.

Л.Жаргал, Ж.Бат–Өлзий, Санхүүгийн менежмент, (Гурав дахь хэвлэл), УБ., 2008, 373 дахь тал болон 820 дахь тал

<sup>28</sup> Арилжааны вексель бол эх үүсвэр олж авах нэг арга зам бөгөөд төлбөрийн чадвар сайтай компаниас 3 – 270 хоногийн хугацаатай гаргадаг үнэт цаас юм. Арилжааны векселийн хүүгийн хэмжээ нь векселийн нэрлэсэн дүн, хугацаа зэргээс хамаарна. Арилжааны векселийг нэрлэсэн дүнгээс нь бууруулалт хийж худалдах ба хүүг үүнд оруулж тооцно.

Б.Бүжинлхам, Санхүүгийн удирдлага, (Дөрөв дэх хэвлэл), УБ., 2012, 480 дахь тал, ШУА, Монголын эдийн засгийн дэлгэрэнгүй тайлбар толь, (Анхдугаар хэвлэл), УБ., 2021, 49 дэх тал.

<sup>29</sup> ШУА, Монголын эдийн засгийн дэлгэрэнгүй тайлбар толь, (Анхдугаар хэвлэл), УБ., 2021, 49 дэх тал.

<sup>30</sup> Б.Амарсанаа, Арилжаа хэмээх нэр томъёог эргэцүүлэхүйд, Эрх зүйн дээд боловсрол ба хууль зүйн шинжлэх ухаан, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2021, 273 дахь тал.

<sup>31</sup> Д.Авирмэд, Худалдааны гэрээ ба түүний зарим төрлүүд, (Хоёр дахь хэвлэл), УБ., 2008, 7 дахь тал.



эрх зүйг commercial law гэсэн нэр томьёонд буулган<sup>32</sup> өргөнөөр хэрэглэж байна. Үүнтэй зэрэгцээд Д.Булган зэрэг судлаачид “арилжааны эрх зүй гэдгийг commercial law”<sup>33</sup> гэж орчуулан судалгаанд ашиглав. Академич С.Нарангэрэлийн Эрх зүйн эх толь бичиг хэмээх (2008) бүтээлд “Арилжааны эрх зүй (англи. Commercial law; орос. Коммерческое право)”<sup>34</sup>; “Худалдааны эрх зүй (латин. Jus mercatorum; англи. Commercial law; law merchant; орос. Торговое право)”<sup>35</sup> гэж тэмдэглэсэн байна. Эндээс авч үзвэл commercial law гэснийг арилжааны эрх зүй гэж орчуулахын зэрэгцээ худалдааны эрх зүй ч гэж буулгасан байна. Тэгвэл Арилжааны эрх зүй хэмээх (2022) бүтээлд “Арилжааны эрх зүй нь эхэн үед цэвэр худалдаа, наймааны харилцааны хүрээнд яригдаж байсан тул нэр томьёоны хувьд ч худалдаачин, худалдаачны хэлцэл гэх мэт худалдаа (trade) гэсэн язгууртай үгс түгээмэл хэрэглэгдэж байв. Улмаар энэ салбар эрх зүйн хөгжлийн явцад газар тариалан, уул уурхай зэрэг аж үйлдвэрийн анхдагч хэлбэрийн ашгийн төлөө үйл ажиллагааг арилжааны хуулиар зохицуулах болсноор арилжаа эрхлэгч, арилжааны хэлцэл гэх мэт (commerce) гэсэн агуулгын түвшинд авч үзэх боломжтой болсон”<sup>36</sup> гэж тодорхойлсон байв. Мөн Дэлхийн эрх зүйн түүх хэмээх (2020) орчуулгын бүтээлд “The Securities Exchange Act” гэснийг Үнэт цаасны арилжааны хууль<sup>37</sup> гэж, “The Interstate Commerce Act” гэснийг Муж улс хоорондын арилжааны хууль<sup>38</sup> гэж тус тус орчуулсан байна. Ө.Ганзориг Санхүүгийн философи: дэлхийн санхүүгийн түүх хэмээх (2017) бүтээлд “...дэлхийн анхны даатгалын сурах бичиг болох “Tractatus de assicuracionibus & sponsionibus mercatorum” – Арилжааны даатгалын эрх зүй...”<sup>39</sup> гэж монгол хэлэнд орчуулсан байна.

### **Б. Нэр томьёоны нэршил, оноолтын тухай цөөн үгээр**

Аливаа нэр томьёогоор илэрч буй ухагдахууны хүрээг харгалзах нь хувилбар нэр томьёо, давхцал, буруу оноолт зэрэг асуудлаас сэргийлэх ач холбогдолтой. Түүнээс гадна нэр томьёо нь шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийг тээгч болох тул зөвхөн хэлний тухай асуудал бус харин нийгмийн бүх салбарын нэгэн судлагдахуун байдаг онцлогтой болно.<sup>40</sup> Нэр томьёо, нэн ялангуяа мэргэжлийн үг хэллэгийг анхнаас нь зөв буулгаж хэрэглэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Анхнаасаа буруу нэрлэн хэрэглэгдээд заншчихвал дараа нь янз бүрийн хүндрэл гарах эрсдэлтэй. Хууль зүйн шинжлэх ухаанд нэр томьёо судлал чухал байр суурь эзэлдэг<sup>41</sup> бөгөөд хууль зүйн хэлний онцлог нь нэр томьёотой шууд холбоотой.<sup>42</sup> Гэхдээ нэгэнт тогтсон хууль зүйн нэр томьёог өөрчлөх гэхээсээ илүүтэй утга агуулга, үзэл санааг нь нэг мөр ойлгох нь чухал<sup>43</sup> гэж үзэж байна. Нийтээр хэвшсэн нэр томьёог аль болох хэвээр нь хэрэглэхийн зэрэгцээ антропологийн ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс хүлээн зөвшөөрөгдөхүйц байх нь зохимжтой байх ёстой. Энэ утгаар антропологи хэмээх нэр томьёог хууль зүйн салбарт, нэн ялангуяа арилжааны

<sup>32</sup> Б.Буянхшиг, Худалдааны эрх зүйг иргэний эрх зүйгээс зааглах онолууд кодификацын асуудал болох нь, Эрх зүй сэтгүүл, УБ., 2017, №3, 161 – 176 дахь тал.

<sup>33</sup> Д.Булган, Арилжааны эрх зүйд хамаарах (Commercial law) Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа, Магистрын ажил, УБ., 2017  
<https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-ISBDdetailbook.pl?biblionumber=126801> (Сүүлд үзсэн огноо: 2022.11.01)

<sup>34</sup> С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, Хоёр дахь хэвлэл, УБ., 2008, 40 дэх тал.

<sup>35</sup> С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, Хоёр дахь хэвлэл, УБ., 2008, 520 дахь тал.

<sup>36</sup> Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, Пүрэвбаатар П., Ганхүрэл Д., Арилжааны эрх зүй, (Анхны хэвлэл), УБ., 2022, 14 дэх тал.

<sup>37</sup> Майкл Х.Роффэр., Дэлхийн эрх зүйн түүх, (Хаммурабигаас Олон улсын эрүүгийн шүүх хүртэлх эрх зүйн түүхийн 250 онцлох үйл явдал), УБ., 2022, 246 дахь тал.

<sup>38</sup> Майкл Х.Роффэр., Дэлхийн эрх зүйн түүх, (Хаммурабигаас Олон улсын эрүүгийн шүүх хүртэлх эрх зүйн түүхийн 250 онцлох үйл явдал), УБ., 2022, 172 дахь тал.

<sup>39</sup> Ө.Ганзориг, Санхүүгийн философи (Дэлхийн санхүүгийн түүх), УБ., 2017, 50 дахь тал.

<sup>40</sup> Н.Мөнхцэцэг, Нэр томьёоны орчуулга судлал, УБ., 2020, 25 дахь тал.

<sup>41</sup> Б.Баярсайхан, Монгол Улсын Үндсэн хууль ёсны уламжлал, (БНМАУ-ын 1949 оны Үндсэн хуулийн эрх зүйн шинжилгээ), УБ., 2017, 32 дахь тал.

<sup>42</sup> О.Амархүү, Эрх зүйн онолын арван таван сэдэв, УБ., 2008, 52 дахь тал.

<sup>43</sup> “Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ” (Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл) УБ., 2016, 73 болон 77 дахь тал.



хуулийн антропологи гэсэн томъёог хэрэглэснээр “арилжааны эрх зүйн антропологийн агуулгыг хэт явцууруулан тодорхойлуулах” төдийгүй “эрх зүйн илрэн гарах хэлбэрийн тухай ойлголтыг эрх зүйн мөн чанарын тухай ойлголттой адилтган ойлгох” нөхцлийг бүрдүүлж байна. Тухайлбал, арилжааны хуулийн антропологи гэх зэргээр нэрлэх нь арилжааны эрх зүйн антропологиос агуулга, мөн чанарын хувьд эрс ялгаатай гэж үзэж байна. Түүнчлэн эрх зүйн онолын хувьд эрх зүй хуулиас ялгаатай төдийгүй илүү өргөн агуулгаар тодорхойлогддог<sup>44</sup> болохыг мартах учиргүй юм. Өөрөөр хэлбэл, эрх зүй судлал (эрх зүйг тогтолцооноос нь хальж, илүү өргөн хүрээтэй судалдаг) нь хууль зүй судлал (эрх зүйн тогтолцооны хүрээнд)–аас судалгааны онол, арга зүйн хувьд ялгаатай болно. Эрх зүй, түүний илрэн гарах хэлбэр болох хууль, тэдгээрийн ялгаа, харилцан хамаарлын тухай үзэл санаа нь эрх зүйн тухай үзэл санаатай зэрэгцэн нэн эртнээс үүссэн бөгөөд одоо ч гэсэн эрх зүйн танин мэдэхүйн анхаарлын төвд байсаар байна.<sup>45</sup> Энэ дээр үндэслэн эрх зүй, хуулийг агуулгын ялгаагүй гэж үзэж болохгүй, ялангуяа хууль нь агуулгаасаа гажсан тохиолдол бүр ч болохгүй юм. Харин хууль нь агуулгаасаа гажаагүй, эрх зүйд нийцсэн буюу эрх зүйт хуулийг эрх зүй гэж үзэж болох боловч өнөөг хүртэл хууль тогтоох явцад хууль нь агуулгаасаа гажиж байдаг тул эрх зүй, хууль хоёрыг ялгах хэрэгцээ шаардлага байгаа юм.<sup>46</sup> Тиймээс нэр томъёог хэрхэн оноож өгснөөс шалтгаалан хоёрдмол утгаар ойлгогдох үр дагавартай байна. Өөрөөр хэлбэл эрх зүйн онол, философийн үүднээс эрх зүйн хэлбэрийг агуулгатай адилтган авч үзэх эрсдэлтэй болж байна. Тийм учраас хууль эрх зүйт шинжийг бүрэн олоогүй байгаа тохиолдолд “эрх зүй”, “хуулийн” ялгааг сайтар ухаарах, судлах, хууль тогтоомж бүрийг эрх зүйн шалгуураар шалгах шаардлага зайлшгүй бий. Энэ бол эрх зүйт төр, хуультай болох нэн чухал угтвар нөхцөл<sup>47</sup> болохыг онолын хувьд бас санах учиртай.

Харин доктор, профессор Х.Сэлэнгэ “эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёонуудын үндэс, агуулгыг хэл шинжлэл, эрх зүйн сэтгэлгээ, эрх зүйн онолын үүднээс авч үзэхийн зэрэгцээ “эрх зүй” гэсэн нэр томъёоны оронд “хууль зүй” гэсэн нэр томъёог хэрэглэх нь үндэслэлтэй хийгээд зохистой юу? Эрх зүй гэсэн нэр томъёог хууль зүйн шинжлэх ухааны нэр томъёоноос хасах нь зөв үү? Энэ нь монголын хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд сайн нөлөөтэй юу гэсэн асуултууд тавиад, тэдгээрт эрх зүй гэсэн нэр томъёог хууль зүйн шинжлэх ухаанаас хасч, эрх зүй судлалыг үгүйсгэж, зөвхөн хууль зүй гэсэн нэр томъёог хэрэглэх нь хууль зүйн шинжлэх ухааны тулгуур ойлголтын мөн чанар, агуулгыг алдагдуулж, цаашлаад хууль зүйн шинжлэх ухааны зорилгоос ухарч, судалгааг хязгаарлаж байгаа явдал”<sup>48</sup> гэсэн маш үндэслэл бүхий нухацтай хариултыг өгөв. Эрх зүй гэдэг энэхүү монгол нэршил 1978 оноос албан ёсны нэр томъёо болж хэрэглэгдсээр өнөөг хүрсэн байна.<sup>49</sup> Эрх зүй гэсэн үгийн “зүй” гэсэн үг нь ч монголчуудын сэтгэлгээнд хожуу бий болсон бололтой.<sup>50</sup> Өмнө нь эрх гэсэн нэр томъёог хэрэглэн захиргааны эрх, эрүүгийн эрх гэж нэрлэж байв. Мөн түүнчлэн доктор, профессор О.Мөнхсайхан Эрх зүйн философи хэмээх (2022) бүтээлд “*Эрх зүй, түүний тодорхой ойлголтын тухай түгээмэл тодорхойлолт өгөх*

<sup>44</sup> Хууль нь эрх зүйн илрэх гадаад хэлбэр. Баярсайхан Д., Эрх зүйн онол, Тав дахь хэвлэл, УБ., 2018, 34 дэх тал.

Эрх зүйн ба хууль тогтоомжийн тогтолцооны харьцаа: эрх зүйн тогтолцоо ба хууль тогтоомжийн тогтолцоо бие даасан бөгөөд харилцан уялдаатай юм. Эдгээр нь өөр хоорондоо хэлбэр ба агуулгын харьцаатай байна. Эрх зүйн тогтолцоо бол агуулгыг илэрхийлэх бөгөөд нийгмийн харилцааг зохицуулах шинжид нийцсэн эрх зүйн дотоод бүтэц юм. Хууль тогтоомжийн тогтолцоо нь эрх зүйн эх сурвалжийн байгууламжийг илэрхийлдэг эрх зүйн гадаад хэлбэр өөрөөр хэлбэл хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын тогтолцоо. Эрх зүй нь хууль тогтоомжгүйгээр оршихгүй болохын хамт харин хууль тогтоомж нь өргөн хүрээтэй ойлгоцоор эрх зүй болно. Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001, 87 дахь тал

<sup>45</sup> Х.Сэлэнгэ, Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 150 дахь тал

<sup>46</sup> Мөн тэнд, 151 дэх тал.

<sup>47</sup> Н.Лүндэндорж, Jurisprudence // Эрх зүй судлал: Философи, онол, УБ., 2011, 26 дахь тал.

<sup>48</sup> Х.Сэлэнгэ, Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 151 – 152 дахь тал.

<sup>49</sup> Улсын нэр томъёоны комиссын мэдээ, Хууль зүйн нэр томъёо, №107–108 (*Тэргүүн дэвтэр*) УБ., 1978.

<sup>50</sup> Сэлэнгэ Х., Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1, 146 дахь тал.

оролдлогыг он удаан жил хийж ирсэн. Эрх, эрх чөлөө, үүрэг гэх мэт ойлголтын талаар нанин мэдэхгүйгээр эрх зүйн тухай ярихад хэцүү. Тэгвэл тодорхойлолтыг яаж гаргах вэ гэдэг талаар утга оноох; үгийн хэрэглээгээр тодорхойлох; гол шинжээр тодорхойлох гэсэн гурван арга зүй хөгжсөн. Эхнийхээр “үгийг утгажуулах буюу тодорхойлох нь түүний илэрхийлж буй зүйлийг нэрлэхтэй тэнцүү” гэх бол удаах нь үгийг хэрэглээгээр нь тодорхойлох боломжтой. Үгийг тодорхойлох гэдэг бол түүний илэрхийлж буй зүйлийг нэрлэж буй хэрэг биш, харин үгийн хэрхэн хэрэглэгдэж буйг буюу тэр үгийн гүйцэтгэж буй чиг үүргийг харуулах явдал гэжээ. Аливаа зүйлийг гол шинжээр тодорхойлох нь дараагийн арга зүй юм. Аливаа зүйлийг тухайн зүйл болгож байдаг хамгийн чухал шинжийг судалж гаргана гэсэн үг”<sup>51</sup> гэж бичсэнийг анхаарч үзэх зайлшгүй шаардлага байна.

Арилжааны эрх зүйг энгийнээр: Академич С.Нарангэрэл Эрх зүйн эх толь бичиг хэмээх (2008) бүтээлд “Арилжааны эрх зүй – бараа ба үйлчилгээг үйлдвэрлэгчээс хэрэглэгчид хүргэх, өөрөөр хэлбэл барааны гүйлгээний үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын асуудлаас агуулга нь бүрддэг эрх зүйн шинжлэх ухаан ба эрх зүйн сургалтын судлагдахууны салбар”<sup>52</sup> гэж тэмдэглэсэн байна. Онолын хувьд арилжааны эрх зүй нь өргөн болон явцуу утгаар илэрч болно. Өргөн утгаар Иргэний хуулийн ерөнхий зохицуулалтаас тусдаа боловч түүний тусгай зохицуулалтыг агуулахаас гадна бие даан системчлэгдэх боломжтой арилжаа эрхлэгч эсхүл арилжааны үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогцыг илэрхийлнэ. Харин явцуу утгаар арилжааны эрх зүй нь төрөлжсөн арилжааны хуулийг илэрхийлэх нь олонтаа. Гэвч төрөлжсөн арилжааны хууль нь арилжааны эрх зүйг дангаар төлөөлөхгүй бөгөөд иргэний хуулийн суурь зарчмууд, салбар хуулиудтай цогц байдлаар<sup>53</sup> тодорхойлогдож болохоор байна. Арилжааны эрх зүйн үндсэн элементийн нэг болох ашгийн төлөө байх шинжийг Иргэний хуульд шууд заагаагүй боловч ашгийн төлөө үйл ажиллагаа хэмээх ойлголтыг гэрээний төрөл тус бүрийн хувьд авч үзвэл агуулгын хувьд тодорхойлогдох боломжтой байна.<sup>54</sup> Арилжааны эрх зүй нь хувийн эрх зүйн төдийгүй нийтийн эрх зүйтэй нягт уялдаа холбоо бүхий салбар эрх зүй болно.<sup>55</sup> Тодруулбал арилжааны эрх зүй нь олон тооны, хамрах хүрээний хувьд өргөн цар хүрээтэй эх сурвалжтай (арилжааны эрх зүй нь олон тооны хуулийг эрх зүйн эх сурвалжаа болгодог онцлогтой) байдгаас гадна тэдгээр нь нийтийн эрх зүйн зарим салбар, институттэй нягт холбоо бүхий эх сурвалж байдгаараа хувийн хувийн эрх зүйн зарим салбар эрх зүйгээс ялгардаг.<sup>56</sup>

Иймд антропологи гэсэн нэршлээр хууль зүйн салбарт нэгэнт нийтээр хүлээн зөвшөөрч нэрлэж, цаашлаад хэрэглэж дадсан “дадна” гэж үзвэл салбар эрх зүй бүрт адил утгаар ойлгон хэрэглэгддэг нийтлэг нэр томьёо болгон хэвшүүлэх боломжтой гэж үзэж байна. Жишээлбэл, арилжааны эрх зүйн антропологи гэх мэт. Ийнхүү өгүүллээр авч үзэж буй нэр томьёоны нэршил, оноолтын тухайд антропологийн ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс арилжааны хуулийн антропологи гэж нэрлэхийн оронд арилжааны эрх зүйн антропологи гэсэн нэр томьёонд хэвшүүлэн нэрлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрч байна. Учир нь эрх зүй судлал нь эрх зүйг тогтолцооноос нь хальж, илүү өргөн хүрээтэй судалдаг байхад хууль зүй судлал эрх зүйн тогтолцооны хүрээнд авч үздэг онцлогтой байна. Тодруулбал эрх зүйн зохицуулалтаас цааш (дан ганц эрх зүйн онол,

<sup>51</sup> Мөнхсайхан О., Эрх зүйн философи, Анхны хэвлэл, УБ., 2022, 5 – 8 дахь тал.

<sup>52</sup> Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, Хоёр дахь хэвлэл, УБ., 2008, 40 дэх тал.

<sup>53</sup> Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, П.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, Арилжааны эрх зүй, (Анхны хэвлэл), УБ., 2022, 14 дэх тал.

<sup>54</sup> Д.Булган, Арилжааны эрх зүйд хамаарах (Commercial law) Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа, Магистрын ажил, УБ., 2017.

<https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-ISBDdetailbook.pl?biblionumber=126801> (Сүүлд үзсэн огноо: 2022.11.01)

<sup>55</sup> Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, П.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, Арилжааны эрх зүй, (Анхны хэвлэл), УБ., 2022, 20 дахь тал.

<sup>56</sup> Мөн тэнд, 30 дахь тал.

номлолын хүрээнд бус хууль зүйн хэрэглээний хүрээг хамаарах) өргөн утгаар нь хэрэглэх үед арилжааны эрх зүй гэсэн агуулгаар нь ойлгох нь оновчтой байна.

### **В. Арилжааны эрх зүйн антропологийн ойлголт, агуулгын талаарх эргэцүүлэл**

Эрх зүйн мөн чанарын тухай асуудал нь эрх зүй гэсэн үзэгдлийн дотоод талд хамаарагдах асуудал тул түүний уг сурвалжийг авч үзэхгүйгээр эрх зүйн мөн чанарыг тодорхойлох боломжгүй юм. Эрх зүйн уг сурвалж бол хүн. Иймд хүний мөн чанарыг танин мэдэхгүйгээр эрх зүйн мөн чанарыг ойлгож, түүний тухай ярих боломжгүй байна. Ер нь аливаа нийгмийн шинжлэх ухаан нь хүн судлалгүйгээр хөгжих боломжгүй<sup>57</sup> гэдгийг анхаарах учиртай. Өдгөө дэлхийн улс орнууд хөгжлийн асуудлыг дан ганц эдийн засгийн талаас нь бус харин түүх соёл, улс төр, нийгмийн болон улс төрийн философи, улс төрийн эдийн засаг, антропологийн талаас нь бүрэн гүйцэд судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн замналыг тодорхойлохыг оролдож байна.<sup>58</sup> Иймд арилжааны эрх зүй, арилжааны эрх зүйн антропологи, гэдгээрийн агуулгад юу хамаарах, хэрхэн тодорхойлох вэ гэдгийг антропологийн ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны үндэслэлтэй авч үзэх хэрэгцээ шаардлага үүсч байна. Монгол Улсад арилжааны эрх зүй хөгжих шаардлагыг нөхцөлдүүлж буй гол хүчин зүйл нь ашгийн төлөө үйл ажиллагаа тогтмол явуулдаг этгээдүүд бий болсон явдалтай<sup>59</sup> холбон үзэж болох юм. Аж ахуй, худалдаа наймааг өөрсдийн амьдралын хэв маяг, орлогын цорын ганц эх үүсвэр болгон амьдарч байгаа олон тооны хувь хүмүүс, нөхөрлөл, компаниуд Монгол Улсад олноор бий болсон байна. Дараагийн хүчин зүйлд бүгдийг нэг этгээд дангаар хийдэг, хариуцдаг хэлцлийн бүтцээс маш олон оролцогчтой хэлцлийн бүтэц рүү аж ахуй эрхлэгчид хэдийнээ шилжээд байна. Үүнийг бас хувийн эрх зүйн харилцаанд оролцогч этгээдүүдийн хэлцэл хийх бүтэц (contract structuring) ихээхэн өөрчлөгдсөн<sup>60</sup> гэж тодорхойлсон байна. Тэгвэл доктор, профессор Б.Амарсанаа “Монгол Улсын хувийн эрх зүйн харилцааг зохицуулсан суурь зохицуулалт иргэний хуульд (2002) туссан хэдий ч энэ нь үндсэндээ хэрэглэгчид буюу жирийн иргэд хооронд үүсэх аж ахуй бус харилцааг зохицуулахад голлон чиглэгдэж, ийм байдлаар боловсруулагдсан байна”<sup>61</sup> гэж товчхон дүгнэжээ. Энэ талаар доктор Б.Буянхишиг Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт хэмээх (2021) бүтээлд “Монгол Улсын Иргэний хууль арилжааны гэрээ хэлцлүүдийг өөртөө агуулснаараа эдийн засгийн агууламж давамгайлсан худалдааны эрх зүйн шинжтэй кодификац бөгөөд Иргэний хуулийн ерөнхий ангийн хувь этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлсон зохицуулалтууд нь дээрх гэрээг байгуулан үйл ажиллагаа явуулж байдаг арилжаа эрхлэгчийг тодорхойлоогүй, Иргэний хуулийн 26 дугаар зүйлд гагцхүү хуулийн этгээд л эрх зүйн чадвартай байхаар заасан нь Иргэний хуулийн 7 дугаар зүйлд тусгасан иргэний эрх зүйн бусад нэгдлийн эрх зүйн харилцаанд оролцох, дээрх гэрээний тал болох бодит боломжийг хязгаарласан сул талтай”<sup>62</sup> гэж бичсэн байна.

Арилжааны эрх зүйн антропологи тодорхойлохын тулд нэн тэргүүнд “эрх зүйн антропологи”-ийн талаар зайлшгүй авч үзэх шаардлагатай. Товчхондоо бол эрх зүйн антропологи гэдгийг нэг талаас нийгмийн олон талт харилцаа, соёл, ухамсарын ижилсэл, ондоошлыг; нөгөө талаас хүнийг эрх зүйн харилцааны объект болох талаас нь судалдаг антропологийн ухааны болон хууль зүйн шинжлэх ухааны салбар дундын бие даасан ухаан<sup>63</sup> гэж тодорхойлж болох юм. Энэ утгаараа антропологи бол бодит туршлагад суурилсан

<sup>57</sup> Х.Сэлэнгэ, Хүн ба эрх зүй, Эрх зүй сэтгүүл, УБ., 2000, №2 – 3, 97 дахь тал.

<sup>58</sup> <https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group14/01.pdf> (Сүүлд үзсэн огноо: 2022.11.10)

<sup>59</sup> Б.Амарсанаа, Иргэний ба худалдааны хууль тогтоомжийн цаашдын хандлага, хөгжүүлэх шаардлага, Монгол Улсын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг, Олон улсын симпозиумын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2019, 41 дэх тал.

<sup>60</sup> Мөн тэнд, 42 дахь тал.

<sup>61</sup> Мөн тэнд, 44 дэх тал.

<sup>62</sup> Б.Буянхишиг, Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт, УБ., 2021, 309 дэх тал.

<sup>63</sup> С.Номынбаясгалан, Г.Мөнх-Эрдэнэ, Б.Баатарцогт, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа (Хууль зүйн антропологийн судалгаа хийх судлаачдад зориулсан гарын авлага), УБ., 2021, 5 дахь тал.

ухаан бөгөөд түүний онцлог нь нийгэм, соёлын бүтээгдэхүүн болох эрх зүйн сэтгэлгээ, ухамсар, соёл, ёс, уламжлал, зан заншил, заншил (“арилжааны заншил”<sup>64</sup> гэх зэрэг), үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө болон тэдгээрийг тусгасан хэв хууль, ахуй, аж байдал зэрэгт ач холбогдол өгч, гол судлагдахуун болгон судалдаг. Тодруулбал эрх зүйн уламжлал нь эрх зүйн тогтолцоог тухайн соёлтой холбож илэрхийлдэг байна. Хөгжил бол эрх чөлөө хэмээх (2014) орчуулгын бүтээлд соёл ба хүний эрхийн асуудлыг тухайлан авч үзсэнээрээ ихээхэн онцлогтой.<sup>65</sup> Арилжааны эрх зүйн эх сурвалжийн онцлогоос гадна арилжааны эрх зүйг бусад салбар эрх зүйгээс ялгах хамгийн гол ялгаа нь заншлын гүйцэтгэх үүрэг ихээхэн өндөр байдагт оршино.<sup>66</sup> Жишээ болгон дурдвал 1952 онд батлагдсан АНУ-ын Арилжааны загвар хууль бараа, бүтээгдэхүүний бүх төрлийн гэрээ хэлэлцээртэй холбогдох харилцааг зохицуулж байгаагийн дотор талуудын хооронд байгуулсан гэрээг тодорхойлохдоо “ажил хэргийн хүрээнд тогтсон заншил, худалдааны заншил” зэрэг ойлголтыг “Lex Mercatoria”-аас шууд уламжлан авсан байна.<sup>67</sup> Орчин үеийн даяаршиж буй эдийн засаг дахь арилжааны гүйлгээний бүтэц судалдаг олон улсын эрх зүйн судлаачид “Lex Mercatoria”-г орчин үеийн хууль зүйн шинжлэх ухаанд одоо ч чухал үүрэгтэй гэж үнэлж байна. Ийм нөлөө нь олон улсын арилжааны үлгэрчилсэн гэрээ, UNIDROIT-ын зарчмуудад “Lex Mercatoria”-аас шууд эшлэл хийсэн байдгаас харагдана.<sup>68</sup>

Нийгмийн бүхий л харилцааг хуулиар зохицуулах боломжгүй. Тиймээс эрх зүйн харилцаанд нийтээр хүлээн зөвшөөрсөн зан заншил, ёс суртахууны хэм хэмжээг өргөнөөр хэрэглэдэг.<sup>69</sup> Заншлын хэм хэмжээ нь эрх зүйн эх сурвалж болох талаар олон улсын болон дотоодын эрх зүйн хэм хэмжээнд маш тодорхой заасан байх нь бий.<sup>70</sup> Олон улсын худалдааг ихэвчлэн заншлын хэм хэмжээгээр зохицуулж ирсэн байдаг.<sup>71</sup> Заншил бол олон улсын эрх зүйн болон ер нь эрх зүйн хамгийн эртний анхдагч эх сурвалж бөгөөд улс хоорондын харилцаанд практикт төлөвшин тогтсон, заавал биелүүлэх шинж чанарыг нь олон улсын эрх зүйн субъектууд хүлээн зөвшөөрсөн ёс журам<sup>72</sup> хэмээн тодорхойлж байна. Мөн түүнчлэн олон улсын худалдаа, төлбөр тооцоо, олон улсын тээвэрлэлт гэх мэт харилцаанд заншлын хэм хэмжээ өргөн хэрэглэгддэг.<sup>73</sup> Тухайлбал, Олон улсын худалдааны танхимаас гаргасан Инкотермс 2010 (International Commercial Terms) гэсэн баримт бичиг бол заншлын хэм хэмжээний тод жишээ бөгөөд энэ нь олон улсын гэрээ биш юм. Парисын олон улсын худалдааны танхимаас гаргасан баримт бичгүүд болох Аккредитив (Uniform Customs and Practice for Documentary Credits No 500/600), Инкасс (Uniform Rules for Collection No 522)-ийн тухай баримт бичгийг олон улс орны банк санхүүгийн байгууллага үйл ажиллагаандаа

<sup>64</sup> Б.Амарсанаа, Г.Давааням, С.Багбаяр, Н.Норовсамбуу, П.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, Арилжааны эрх зүй, (Анхны хэвлэл), УБ., 2022, 36 дахь тал.

<sup>65</sup> Амартия Сен., Хөгжил бол эрх чөлөө, (Орос хэлнээс орчуулсан: Энхбаатар А., Мөнхжаргал Э.), УБ., 2014, 209 – 226 дахь тал.

<sup>66</sup> Б.Амарсанаа, Г.Давааням, С.Багбаяр, Н.Норовсамбуу, П.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, Арилжааны эрх зүй, (Анхны хэвлэл), УБ., 2022, 30 дахь тал.

<sup>67</sup> Майкл Х.Роффэр., Дэлхийн эрх зүйн түүх, (Хаммурабигаас Олон улсын эрүүгийн шүүх хүртэлх эрх зүйн түүхийн 250 онцлох үйл явдал), УБ., 2022, 46 дахь тал.

<sup>68</sup> Мөн тэнд, 46 дахь тал.

<sup>69</sup> Тамир Б., Олон улсын хувийн эрх зүй, (Орчин үеийн чиг хандлага), УБ., 2019, 74 дэх тал.

<sup>70</sup> Энэ талаар НҮБ-ын Олон улсын шүүхийн дүрмийн 38 дугаар зүйлийн б-д “түгээмэл практикийн нотолгооны хувьд хууль зүйн хэм хэмжээ болон хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын хэв заншлыг баримтална” гэж, Олон улсын бараа худалдах, худалдан авах гэрээний тухай Венийн конвенцийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “олон улсын худалдааны өргөн дэлгэрсэн, талууд мэддэг буюу мэдэх ёстой заншлыг харгалзан үзнэ” гэж, Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “тухайн харилцааг иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна” гэж, 540 зүйлийн 1 дэх хэсэгт “. . . олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг хэрэглэж болно” гэж, Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт “. . .арбитрын бүрэлдэхүүн аливаа хуулийг хэрэглэхгүйгээр шударга гэж үзсэн ёс зүйн хэм хэмжээг баримтлан . . . маргааныг шийдвэрлэнэ” гэж, 40.5 дахь хэсэгт “арбитрын бүрэлдэхүүн талуудын хооронд байгуулсан гэрээний нөхцөлд үндэслэн тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзан маргааныг шийдвэрлэнэ” гэж зохицуулсан байна.

<sup>71</sup> М.Уянга, Олон улсын худалдааны эрх зүй ба дотоодын зах зээлийг хамгаалах арга хэмжээ, УБ., 2016, 10 дахь тал.

<sup>72</sup> М.Уянга, Олон улсын эдийн засгийн эрх зүй, (Хоёр дахь хэвлэл), УБ., 2014, 37 – 38 дахь тал.

<sup>73</sup> Тамир Б., Олон улсын хувийн эрх зүй, (Орчин үеийн чиг хандлага), УБ., 2019, 75 дахь тал.

өргөн хэрэглэж заншсан байна.<sup>74</sup>

Асуудлын гол нь заншил эрх зүйн эх сурвалжийн хүрээнд ямар байр суурь эзлэх вэ<sup>75</sup> гэдэгт байна. Иймд эрх зүйн гол уламжлалууд нь ихэвчлэн эдийн засаг, технологийн, эсвэл улс төрийн хувьд илүү нөлөөтэй улс орнуудаас бусад хөгжиж буй улс орнуудад түгэн дэлгэрсэн байдгаараа онцлогтой<sup>76</sup> гэж үздэг. Тэгэхлээр эрх зүйн антропологи нь эрх зүйн мөн чанарыг нийгмийн үзэгдэл талаас нь судална.<sup>77</sup> Тодруулбал эрх зүйн антропологи нь *байгаа* болон *байх ёстой* зүйлийн хүрээнд бус харин *байгаа* зүйлийн хүрээнд авч үздэгээрээ эрх зүйн философиос ялгаатай гэж үзэж болох юм. Энэ утгаар эрх зүйн антропологи нь эрх зүйн болон эрх зүйн тогтолцооны талаарх антропологи анализ юм. Тиймээс эрх зүйн антропологийн эх сурвалж нь хууль тогтоомж, шүүхийн шийдвэрээр хязгаарлагдахгүй ихээхэн өргөн хүрээтэй гэсэн үг. Эндээс аваад үзвэл арилжааны эрх зүйн антропологи гэдгийг энгийнээр бол (эдийн засгийн бүрэлдэхүүн нэг хэсэг болох антропологи орчин)<sup>78</sup> буюу эдийн засаг, санхүүгийн тодорхой асуудлыг нэг талаас нийгэм, соёлын гэх мэт; нөгөө талаас эрх зүйн үүднээс судалдаг гэж тодорхойлж болохоор байна.

### Г. Арилжааны эрх зүйн антропологийн хэрэгцээ шаардлага

Монгол Улсад үндсэндээ арилжааны эрх зүй нь 1990 оноос хойш үүсч хөгжсөн гэж хэлж болох бөгөөд зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш Аж ахуй нэгжийн тухай хууль (1991), Векселийн тухай хууль (1995) зэрэг арилжааны эрх зүйд хамаарах олон тооны хууль батлагдсан байна.<sup>79</sup> Ерөнхийд нь хууль тогтоомжийг батлахад хэнд хандаж, ямар харилцааг зохицуулах хэм хэмжээг бүтээх үү гэдэг нь гол асуудал боловч тухайн тохиолдолд хуулиар зохицуулагдах с УБьектэд зохицуулж бүтээх үү, эсвэл түүнийг зохицуулж буй харилцааг голчлох уу, түүнчлэн хуулиар зохицуулагдах с УБьект, харилцааг аль алиныг нь харгалзаж батлах уу гэх үндсэн аргачлалууд бий. Эдгээр нь хууль тогтоогч хуулийг батлахад аль аргачлалд нь илүүтэй ач холбогдол өгч, чухалчилсан байна вэ гэдгээр ялгагдана. Эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улс орнууд XIX зууны үеэс Арилжааны хуулийг батлахад өөр өөрсдийнхөө нийгмийн байдалд нийцсэн тодорхой аргачлал, шалгуурыг хэрэглэдэг байна.<sup>80</sup> Үүн дээр нэмээд доктор Б.Буянхшиг Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт хэмээх (2021) бүтээлд “Арилжааны кодекс батлахад эдийн засгийн анализ хийх шаардлагатай”<sup>81</sup> гэсэн саналыг гаргахын зэрэгцээ “2002 оны Иргэний хууль нь хувийн эрх зүйн харилцааг бүхэлд нь зохицуулах зорилго бүхий томоохон кодификац болж чадсан хэдий ч эдийн засгийн хөгжлийг дэмжихийн тулд арилжааны эрх зүйн кодификацийг нэмж батлах асуудал яригддаг. Ирээдүйн хувийн эрх зүйн салбарт нэгдмэл онолыг баримтлах эсвэл тодорхой салбарыг тусгаарлан кодификацжуулах эсэх нь энэ салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох тул уг асуудлыг зарчмын хувьд онцолж үзэх шаардлагатай. Хэрэв эдийн засгийн кодификацаас тусад нь ахин арилжааны хуулийг тусгаарлахаар шийдвэл Иргэний хуулийг иргэний кодекс хэвээр үлдээх буюу гэр бүлийн эрх зүй, хэрэглэгчийн эрх зүйг үүнд нэгтгэх нь зүйн хэрэг”<sup>82</sup> гэсэн дүгнэлтийг хийв.

<sup>74</sup> Мөн тэнд

<sup>75</sup> Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, П.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, Арилжааны эрх зүй, (Анхны хэвлэл), УБ., 2022, 37 дахь тал.

<sup>76</sup> Оюунтунгалаг Ж., Харьцуулсан иргэний эрх зүйы, УБ., 2013, 12 дахь тал.

<sup>77</sup> С.Номынбаясгалан, Эрх зүйн антропологи /Эрх зүйн хүн судлал/, Эрх зүй сэтгүүл, УБ., 2022, №3.

<sup>78</sup> Эдийн засгийн бүрэлдэхүүн хэсэгт нь хүний бий болгосон бүх зүйлс хамрагддаг антропологи гэж нэрлэгддэг орчин байх бөгөөд эдийн засгийн нэг хэсэг болох *антропологи орчин* нь хоёр хэсэгт хуваагдана. Тэдний нэг нь үйлдвэрлэлийн зориулалттай эд зүйлс буюу үйлдвэрлэлийн хэрэгсэл гэж нэрлэгддэг эд зүйлс. Тэдгээрийн тусламжтайгаар үйл ажиллагаа явагдаж эд зүйлс, бараа шууд үйлдвэрлэдэг болно. Эдийн засаг нь хүнтэй хамт үүсэж хүний төлөө хөгжиж ирсэн бөгөөд хүн, хамт олон, нийгэм хөгжихөд нөлөөлдөг.

Эдийн засаг: Соёмбо нэвтэрхий толь, УБ., 2020, 25 – 26 дахь тал.

<sup>79</sup> Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, П.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, Арилжааны эрх зүй, (Анхны хэвлэл), УБ., 2022, 13 дахь тал.

<sup>80</sup> Мөн тэнд, 15 дахь тал.

<sup>81</sup> Буянхшиг Б., Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт, УБ., 2021, 264 дэх тал.

<sup>82</sup> Мөн тэнд, 306 дахь тал.



Мөн түүнчлэн доктор Ж.Оюунтунгалаг Харьцуулсан иргэний эрх зүй хэмээх (2013) бүтээлд “...худалдааны эрх зүй нь одоо ч хувийн эрх зүйд иргэний эрх зүйтэй зэрэгцэн хөгжиж буй нэг салбар бөгөөд бизнесийн салбарын гол зохицуулалтуудын ихэнх нь чухамхүү худалдааны эрх зүйн зарчмаар тайлбарлагддаг...”<sup>83</sup> гэж бичсэн байна. Монгол Улсын хувьд арилжааны эрх зүйн асуудлыг нарийвчлан судалсан судалгаа хараахан байхгүй байгаа тул энэхүү асуудлыг нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага дан ганц антропологийн хүрээнд гэлтгүй хууль зүйн хүрээнд ч гэсэн байна<sup>84</sup> гэж үзэж болохоор байна.

Харин Монгол Улс, Япон Улсын хууль тогтоомжийн хөгжил: Худалдаа (арилжаа)–ны эрх зүй сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэлд (1) Иргэний эрх зүйн маргааныг шийдсэн шийдлийн үр дагавар, үр дүн ойлгомжгүй, зөвтгөж болохгүй байх тохиолдол цөөн биш, үүнийг хуулийн төвшинд бүрэн шийдвэрлээгүй; (2) Эрх зүйн үр дагавар ямар байх талаар зохицуулалт дутуугаас шүүх арилжааны маргааныг янз бүрээр шийдэхэд хүргэдэг. Энэ нь хууль болон шүүхэд итгэх үнэмшлийг буурж байгаа; (3) Талуудын тохироог гол болголтгүй, тэр тохироо нь хүчин төгөлдөр эсэхийг шалгахыг шаардаагүй байхад шүүх авч хэлэлцдэг зэрэг асуудлыг хуулийн төсөл боловсруулах болсон шалтгаан, нийгмийн хэрэгцээ шаардлага<sup>85</sup> гэж үзсэн байна. Арилжааны эрх зүйг арилжааны харилцааг зохицуулах хэм хэмжээний нийлбэр цогц хэмээн ойлгосон тохиолдолд иргэний эрх зүйн хэм хэмжээнээс ямар онцлог болох талаар авч үзэх шаардлага байсаар байна.<sup>86</sup> Цаашлаад нэгдсэн иргэний хууль үйлчлэх эсвэл худалдааны эрх зүйн хэм хэмжээг тусгаарлах аль ч тохиолдол нь кодификацжуулах үйл явцын үр дагавар бөгөөд холбогдох хуулийн кодекс, түүний бүтэц, тогтолцоо ба харилцан хамаарлыг онолын үүднээс тодорхойлох нь хуулийн хэрэгцээг тодорхойлох ач холбогдолтой болно.<sup>87</sup> Тэгвэл доктор Ж.Оюунтунгалаг Иргэний эрх зүй – I хэмээх (2020) бүтээлд “Өргөн удам нутаг дэвсгэртэй, нүүдлийн мал аж ахуйд суурилсан амьдралын хэв маяг, соёл бүхий манай улсад ч эд баялгийн солилцоо явагдсаар ирсэн боловч хот суурин газар хөгжиж ирсэн шиг худалдааны заншил, хэм хэмжээ түгээмэл хэрэглэгддэггүй байсан. Өөрөөр хэлбэл эдгээр төрлийн харилцааг зан заншил, ёс суртахууны хэм хэмжээгээр зохицуулж ирсэн. Жишээлбэл “Дорно этгээдэд долоон удаа” гэх номонд монгол хүмүүс өрөө төлөхөөр хөөж ирдэг байсан гэж бичжээ”<sup>88</sup> гэж тэмдэглэсэн байна. Эндээс авч үзвэл арилжааны хуулийн төслийг боловсруулахад дээрхи байдал өнөөдөр өөрчлөгдсөн эсэх, хэрэв өөрчлөгдсөн бол хэрхэн өөрчлөгдөв, ийнхүү өөрчлөгдөхөд юу нөлөөлөв, цаашлаад монгол орны өвөрмөц онцлог, үндэсний хэв маяг, бизнесийн тогтсон заншил, монгол хүний сэтгэлгээ, хандлагад нийцүүлэн монгол хөрсөнд буулгаж чадаж байгаа юу гэх мэт асуултууд түгээмэл тохиолдох боловч өнөөг хүртэл мэргэжлийн түвшинд хариултгүй байсаар байгаа нь арилжааны эрх зүйн антропологийн судалгаа хийх нийгмийн хэрэгцээ шаардлага үгүйлэгдэж байгааг харуулна. Өмнө нь аж ахуйн эрх зүй гэх нэр томьёо хэрэглэгдэж байсан нь арилжааны эрх зүй гэсэн нэр томьёотой хамааралтай эсэх гэх зэргээр судалгааг хийх нь урт удаан хугацаанд энэ худалдаа, арилжаа, аж ахуй эрхлэх гэсэн ойлголтууд хэрхэн хувьсаж, өөрчлөгдөж ирсэн болохыг бүрэн гүйцэд судлах боломжтой. Эдгээрт арилжааны эрх зүйн антропологийн тухайлсан судалгааг хийснээр зохих түвшинд хариулах боломжтой гэж үзэж байна.

<sup>83</sup> Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, УБ., 2013, 18 дахь тал

<sup>84</sup> Д.Булган, Арилжааны эрх зүйд хамаарах (Commercial law) Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа, Магистрын ажил, УБ., 2017  
<https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-ISBDdetailbook.pl?biblionumber=126801> (Сүүлд үзсэн огноо: 2022.11.01)

<sup>85</sup> Б.Амарсанаа, Худалдаа (арилжаа)–ны ерөнхий хууль (Commercial code)–ийн төслийн төсөөлөл, анхаарах асуудал, Монгол Улс, Япон Улсын хууль тогтоомжийн хөгжил: Худалдаа (арилжаа)–ны эрх зүй сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2017, 49 дэх тал

<sup>86</sup> Б.Амарсанаа, Г.Давааням, С.Багбаяр, Н.Норовсамбуу, П.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, Арилжааны эрх зүй, (Анхны хэвлэл), УБ., 2022, 23 дахь тал

<sup>87</sup> Б.Буянхшиг, Худалдааны эрх зүйг иргэний эрх зүйгээс зааглах онолууд кодификацын асуудал болох нь, Эрх зүй сэтгүүл, УБ., 2017, №3, 164 дэх тал

<sup>88</sup> Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүй – I, (Ерөнхий анги), УБ., 2020, 24 дэх тал

### III. ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Эдийн засгийн толь бичгүүдэд худалдаа гэсэн үгийг trade гэж нийтлэг байдлаар буулгаж байгаа бол санхүү удирдлагийн бүтээлд арилжаа гэх нэр томъёоны утгыг commerce гэсэн гадаад нэр томъёонд орчуулж байна. Жишээ болгон дурдвал, арилжааны үнэт цаас (commercial paper), арилжааны вексель (commercial bill), арилжааны зардал (commerce cost) гэх зэрэг нэр томъёог түгээмэл хэрэглэж байна. Иймд эдийн засаг, санхүүгийн хүрээнд дээрхи нэр томъёонуудыг ялгамжтай байдлаар буулган хэрэглэж байгааг анхаарах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Харин хууль зүйн толь бичгүүдэд commercial law гэснийг арилжааны эрх зүй гэж орчуулахын зэрэгцээ худалдааны эрх зүй ч гэж бас буулгасан байна. Иймд commercial law хэмээх ойлголтыг энэхүү өгүүлэлд арилжааны эрх зүй гэсэн нэршлээр хэрэглэв. Энэ үндсэн дээр commercial law гэдгийг худалдааны эрх зүй бус арилжааны эрх зүй гэсэн нэр томъёонд буулгах нь оновчтой гэж үзээд арилжаа, арилжааны үйл ажиллагаа, түүнийг эрхлэх гэсэн нэр томъёог ашиг олох зорилготойгоор эдийн засгийн үйл ажиллагаанууд явуулах гэсэн утга агуулгаар ойлгох нь зүйтэй болов уу гэж үзэж байна.

2. Хууль зүйн нэр томъёоны нэршил, оноолтын асуудлуудын зангилаа нь “арилжааны хуулийн антропологи, эсвэл арилжааны эрх зүйн антропологи хэмээх нэр томъёогоор дамжин илэрхийлэгдэх үзэл санаа, утга агуулгыг яаж ялган ойлгох вэ, тэдгээрт холбоо хамаарал байгаа юу, үзэл санаа, агуулгыг нь хэрхэн тодорхойлох вэ, хэрэглэх хүрээ нь ямар байх вэ” гэсэн асуултуудад байна гэж үзээд, антропологийн ухааны болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс авч үзвэл \*арилжааны хуулийн антропологи гэж оноон нэрлэхийн оронд \*\*арилжааны эрх зүйн антропологи гэсэн нэр томъёонд хэвшүүлэн нэрлэж, хэрэглэх нь зүйтэй болов уу гэж үзэж байна. Учир нь арилжааны хуулийн антропологи гэсэн томъёог хэрэглэснээр “арилжааны эрх зүйн антропологийн агуулгыг явцууруулан тодорхойлуулах төдийгүй эрх зүйн илрэн гарах хэлбэрийн тухай ойлголтыг эрх зүйн мөн чанарын тухай ойлголттой адилтган ойлгох” нөхцлийг бүрдүүлж байна. Жишээлбэл, арилжааны хуулийн антропологи гэх зэргээр нэрлэх нь арилжааны эрх зүйн антропологиос агуулга, мөн чанарын хувьд ялгаатай. Тодруулбал эрх зүйн зохицуулалтаас цааш (дан ганц эрх зүйн онол, номлолын хүрээнд бус хууль зүйн хэрэглээний хүрээг хамаарах) өргөн утгаар нь хэрэглэх үед арилжааны эрх зүй гэсэн агуулгаар нь ойлгох нь оновчтой байна

3. Эцэст нь тэмдэглэхэд, Монгол Улсын хувьд арилжааны эрх зүйн асуудлыг нарийвчлан судалсан судалгаа хараахан байхгүй байгаа тул энэхүү асуудлыг нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага дан ганц антропологийн хүрээнд гэлтгүй хууль зүйн хүрээнд ч гэсэн байна гэж үзэж болохоор байна. Ийнхүү антропологийн үзэл баримтлалыг ухагдахууны түвшинд тодорхойлох, эрх зүйн антропологийн онцлогийг эрх зүйн ерөнхий үзэл баримтлал болгон хөгжүүлэх нь арилжааны эрх зүйг хөгжүүлэх үндэс юм. Мөн түүнчлэн арилжааны эрх зүйн антропологи нь эдийн засаг, санхүүгийн (тодорхой) асуудлыг нэг талаас нийгэм, соёлын; нөгөө талаас эрх зүйн үүднээс судалдаг гэж энгийнээр тодорхойлж болох юм.

#### ЭХ СУРВАЛЖ

1. Б.Амарсанаа, Хувийн эрх зүйд аж ахуйн (худалдааны) эрх зүйн нэр томъёоны эзлэх байр суурь, Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2016
2. Б.Амарсанаа, Худалдаа (арилжаа)–ны ерөнхий хууль (Commercial code)–ийн төслийн төсөөлөл, анхаарах асуудал, Монгол Улс, Япон Улсын хууль тогтоомжийн хөгжил: Худалдаа (арилжаа)–ны эрх зүй сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2017



3. Б.Амарсанаа, Иргэний ба худалдааны хууль тогтоомжийн цаашдын хандлага, хөгжүүлэх шаардлага, Монгол Улсын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг, Олон улсын симпозиумын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2019
4. Б.Амарсанаа, Арилжаа хэмээх нэр томъёог эргэцүүлэхүйд, Эрх зүйн дээд боловсрол ба хууль зүйн шинжлэх ухаан, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2021
5. Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, П.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, Арилжааны эрх зүй, (Анхны хэвлэл), УБ., 2022
6. Ж.Амарсанаа, Б.Чимид ба бусад, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Гуравдугаар боть, (1926 VI сар – 1936 он), УБ., 2010
7. Л.Жаргал, Ж.Бат–Өлзий, Санхүүгийн менежмент, (Гурав дахь хэвлэл), УБ., 2008
8. Б.Буянхишиг, Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт, УБ., 2021
9. Ө.Ганзориг, Санхүүгийн философи (Дэлхийн санхүүгийн түүх), УБ., 2017
10. Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, УБ., 2013
11. Майкл Х.Роффэр, Дэлхийн эрх зүйн түүх, (Хаммурабигаас Олон улсын эрүүгийн шүүх хүртэлх эрх зүйн түүхийн 250 онцлох үйл явдал), УБ., 2022
12. С.Номынбаясгалан, Эрх зүйн хүн судлал, Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ., 2022, №3, (89)
13. Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол, (Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал), Хоёр дахь хэвлэл, УБ., 2017
14. Х.Сэлэнгэ, Эрх зүй ба Хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл, Эрх зүй сэтгүүл, УБ., 2014, №1
15. Ханнс Зайделийн сан ба бусад., Судалгааны тайлан: Арилжаа (Худалдаа)–ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судлах, УБ., 2019
16. Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй, (Орчин үеийн чиг хандлага), УБ., 2019
17. Д.Булган, Арилжааны эрх зүйд хамаарах (Commercial law) Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа, (Магистрын ажил), УБ., 2017

## ANTHROPOLOGY OF COMMERCIAL LAW: TERMINOLOGICAL ISSUES

*Nomynbayasgalan S.,  
Ph.D. candidate at the National University of Mongolia*


### ABSTRACT:

The article is named the “Anthropology of commercial law” and its content is conducted within legal issues on the translation of legal terminology. Anthropology is an empirically-grounded discipline. Its material is typically observed in the real world through long-term, focused participant observation. The anthropologist studies social forms as they exist in their variety, including ideas, physical activities, and what may be regarded as archaic or marginal. “Anthropology of law” is the first branch of anthropology to emerge from mid–the nineteenth century. The field studies different social and cultural differences in terms of social, cultural, and legal relations.

### KEYWORDS:

Commercial code, Anthropology of law, Trade, Commerce, Commercial paper, Commercial bill, Lex mercatoria.

## ЯАГААД ЯАРАЛТАЙ АРБИТРЧ МОНГОЛД ХЭРЭГТЭЙ ВЭ?



*М.Мөнхнаран  
БНТУ-ын Энергийн Маргааны арбитрын  
Япон улс дахь төлөөлөгч, Нагояа их сургуулийн  
Хууль зүйн сургуулийн докторант*

### **ТОВЧЛОЛ:**

Монгол Улсын тэргүүлэх арбитрын байгууллага, Монголын Олон Улсын Арбитр (МОУА) нь хэдий 2017 онд ЮНСИТРАЛ-ын Олон Улсын Арилжааны Арбитрын тухай Загвар Хуульд нийцсэн Арбитрын тухай хууль батлагдсаны дараагаар шинэ Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрмээ баталсан ч тус дүрмийг зөвхөн загвар хуулийн хүрээнд батлан, загвар хуульд тусгагдаагүй ч дэлхийн ихэнх орны арбитрын байгууллагуудын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмүүдэд тусгагдсан байдаг Яаралтай арбитрчийн талаарх зохицуулалтыг оруулаагүй байна. Яаралтай арбитрч нь 1990 оноос хойш арбитрын байгууллагууд өөрсдийн дүрэмдээ оруулан хэрэглэх болсон, арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө нэн яаралтай түр арга хэмжээ авхуулах шаардлагатай байгаа тал бүрэлдэхүүн бүрдэхийг хүлээлгүйгээр эсвэл шүүхэд хандан цаг алдалгүйгээр арбитрын байгууллагын удирдлагад хандан зөвхөн тухайн яаралтай түр арга хэмжээ авхуулах хүсэлтийг шийдвэрлэх нэг яаралтай арбитрчийг томилуулан түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтээ шийдвэрлүүлэх тогтолцоо юм. Тус зохицуулалтыг ихэнх олон улсын арбитрууд өөрсдийн дүрэмдээ тусгасан бөгөөд уг судалгааны нийтлэл Азийн (Хонг Конг, Япон, болон Солонгосын) арбитруудын энэ талаарх зохицуулалтыг судалсны үндсэн дээр МОУА-ын Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрэмд үлгэрлэн тусгаж болох яаралтай арбитрчийн талаарх хоёр ерөнхий зохицуулалтыг боловсруулан, тус заалтуудыг дүрэмд тусгахыг санал болголоо.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Арбитрын эрх зүй, Түр арга хэмжээ, ЮНСИТРАЛ-ын Олон улсын арилжааны арбитрын тухай загвар хууль, Монголын олон улсын арбитр

#### **1. Удиртгал: Яаралтай арбитрч гэж хэн бэ? Яагаад чухал ач холбогдолтой вэ?**

Манай оронд арбитрын байгууллага үүсэж хөгжөөд нэг жарныг үджээ. Хэдий социалист нийгмийн үед улсын *арбитраж*-ын талаарх зохицуулалттай, орчин цагийн арилжааны арбитраас өөр тогтолцоотой байсан ч ардчилсан хувьсгалаас хойш арбитрын ажиллагааны орчин цагийн хуулиудыг батлан улам боловсруулж, 1995 оны Гадаад

худалдааны арбитрын тухай хууль,<sup>1</sup> 2003 оны Арбитрын тухай хууль,<sup>2</sup> хамгийн сүүлд 2017 оны шинэ Арбитрын тухай хууль<sup>3</sup> буюу арбитрын эрх зүйн салбарт судалгаа хийдэг, мэргэшиж ажилладаг судлаач, хуульч нарын хэлж заншсанаар загвар хууль: ЮНСИТРАЛ-ын Олон Улсын Арилжааны Арбитрын тухай Загвар Хуулийг баталсан.

Гэвч арбитрын эрх зүй өөрөө зөвхөн хууль тогтоогчийн баталсан хуулиар хөгждөг салбар биш билээ. Хуулиас гадна Дүрэм гэж нэг том хөшүүрэг бас хөгжүүлэгч аль ч арбитрын институтэд байдаг. Аливаа арбитрын байгууллагын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм нь арбитрын тухай хуулиар зохицуулагдаагүй эсвэл ерөнхий зохицуулагдсан харилцааг задлан тухайн институт өөрийнхөөрөө зохицуулах боломжийг, түүнчлэн арбитрын маргаан шийдвэрлэх энэ том зах зээл дээр бусад арбитрын байгууллагуудтайгаа өөрийн өвөрмөц содон, маргааны талуудад ээлтэй, орчин цагийн дүрмээрээ өрсөлдөх боломжийг олгодог.

Манай орны хувьд нэг томоохон монополь арбитр нь Монголын Олон Улсын Арбитр (цаашид МОУА гэх) билээ. Хэдий 2017 онд Загвар хууль батлагдсаны дараагаар тус арбитр дүрмээ шинэчлэн Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх шинэ дүрэм баталсан ч тус дүрэмд одоог хүртэл тусгагдаагүй нэгэн чухал зохицуулалт нь яаралтай арбитрчийн талаарх зохицуулалт юм. Яаралтай арбитрч буюу олон улсад нэрлэж заншсанаар *emergency arbitrator*-ын талаарх зохицуулалт нь талууд нэн чухал шаардлагатай, яаралтай байгаа түр арга хэмжээ авхуулах хүсэлтээ арбитрт арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө гаргах зохицуулалт юм.<sup>4</sup> Энэ нь талууд түр арга хэмжээ авхуулах тухай нэн яаралтай хүсэлтээ гаргахын тулд арбитрын бүрэлдэхүүн бүрдэхийг хүлээлгүйгээр эсвэл шүүхэд хандалгүйгээр шууд арбитрын байгууллагадаа хандан арбитрын удирдлагын<sup>5</sup> шийдвэрээр томилогдсон яаралтай арбитрчаар хүсэлтээ шийдвэрлүүлэх тогтолцоо юм.<sup>6</sup>

Магадгүй зарим нэг судлаачид, арбитрчид Монгол Улс дахь арилжааны арбитрын ажиллагаа дотооддоо сайн хөгжиж байгаа, арбитраар шийдвэрлүүлэх маргааны тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа,<sup>7</sup> энэ мэт гадаадын арбитраудын зохицуулалт бидэнд хэрэггүй гээд орхиж болох ч Монголын арбитр цаашдаа олон улсын зах зээлд гаран Азидаа өрсөлдөх, түүнчлэн зориод шүүхээс илүүтэйгээр арбитрыг сонгон ирсэн дотоодын маргалдагч талуудын яаралтай тохиолдлуудад түр арга хэмжээгээ цаг алдалгүй арбитрын байгууллагуудаараа гаргуулж авч байх хэрэгцээ шаардлагыг бодолцох нь зүйтэй билээ.

Мөн түүнчлэн манай оронд арбитрын эрх зүйн талаар нарийн судалгаа хийдэг эрдэмтэн, судлаачид цөөхөн, түүнийгээ дагаад яаралтай арбитрчийн талаарх зохицуулалт зэрэг арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нарийвчилсан асуудлуудыг хөндсөн судалгааны бүтээл, туурвил тун хангалтгүй байна. Яаралтай арбитрчийн зохицуулалтын талаар судалж бичсэн, нийтэд хүрсэн өмнө нь хийгдэж байсан судалгааны ажил өнөөг хүртэл байхгүй байна.

Иймд зохиолч уг асуудлыг анхааран авч үзэж Монгол Улсын арбитрын томоохон байгууллага болох МОУА-д энэ талаарх зохицуулалт дутмаг байгааг онцлон, яаралтай арбитрчийн зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг хуульч, судлаачдад таниулахыг зорин мөн МОУА-ын Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрэмд тусгаж болох яаралтай

<sup>1</sup> Т.Мөнхжаргал, *Монгол дахь Арбитрын Шүүхийн Товч Түүх*, УБ, МҮХАҮТ-ын дэргэдэх Хэвлэх Үйлдвэр, 2015, 45 дахь тал

<sup>2</sup> Арбитрын тухай хууль, 2003 он; <https://legalinfo.mn/mn/detail/51> [Сүүлд үзсэн: 2022.11.14]

<sup>3</sup> Арбитрын тухай хууль, 2017 он; <https://legalinfo.mn/mn/detail/12456> [Сүүлд үзсэн: 2022.11.14]

<sup>4</sup> Marc J. Goldstein, "A Glance into History for the Emergency Arbitrator," *Fordham International Law Journal* 40, no. 3 (April 2017): 779-798.

<sup>5</sup> Ихэнх олон улсын арбитрын байгууллагуудад тухайн арбитрын дарга эсвэл ерөнхий нарийн бичгийн дарга яаралтай арбитрчийг томилдог.

<sup>6</sup> Ghaffari, Amir and Walters, Emmylou "Emergency Arbitrator: The Dawn of a New Age?", *Arbitration International*, Vol. 30, Issue 1 (2014): 153-168.

<sup>7</sup> Монголын Олон Улсын Арбитр, Бидний тухай, 2017-2019 онд Арбитраар шийдвэрлэгдсэн хэргийн тоо, <http://www.arbitr.mn/index.php/about-us> [Сүүлд үзсэн: 2022.12.12]

арбитрчийн талаарх боломжит загвар заалтуудыг боловсруулахыг эрмэлзэн энэхүү судалгааны нийтлэлийг бичлээ.

## **2. Монгол Улсын Арбитрын ажиллагаан дахь яаралтай арбитрагийн зохицуулалтын хэрэгцээ, шаардлага**

2017 онд ЮНСИТРАЛ-ын Олон Улсын Арилжааны Арбитрын тухай Загвар хуульд нийцсэн Арбитрын тухай шинэ хууль батлагдан хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Талууд өөрөөр тохиролцоогүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрагийн бүрэлдэхүүн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авч болно”<sup>8</sup> гэх шинэ зохицуулалт орж ирсэнээр шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ буюу түр арга хэмжээг авах шийдвэрийг арбитрагийн бүрэлдэхүүн гаргах боломжтой болсон. Энэхүү зохицуулалт нь өмнөх 2003 оны арбитрагийн тухай хуулийн 13 дугаар зүйлд “Арбитрагийн ажиллагаа эхлэхээс өмнө буюу арбитрагийн ажиллагааны явцад талууд арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авхуулахаар анхан шатны шүүхэд хүсэлт гаргаж болох бөгөөд шүүгч уг хүсэлтийн дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан арга хэмжээ авч болох ба үүнийг арбитрагийн хэлэлцээртэй зөрчилдсөн гэж үзэхгүй.”<sup>9</sup> гэж арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ буюу түр арга хэмжээг зөвхөн шүүхээс гаргах боломжтой, энэ талаарх хүсэлтийг шүүх дангаар шийдвэрлэдэг байсан тогтолцоог халан, шүүхээс гадна арбитрагийн бүрэлдэхүүнийг өөрөө талуудаас гаргасан түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтийг шийдвэрлэх боломжтой болсон шинэ тогтолцоог оруулж ирсэн юм.

Дэлхийн олон улс оронд талууд түр арга хэмжээ авах хүсэлтээ арбитрагийн бүрэлдэхүүн болон шүүхэд гаргаж болох уг тогтолцоог арбитрагийн тухай хуульдаа хуульчилсан байдаг.<sup>10</sup> Энэхүү олон улсад өргөнөөр ашиглагддаг түр арга хэмжээг шүүхээс гадна арбитрагийн бүрэлдэхүүн өөрөө гаргаж болох талаарх зохицуулалтыг оруулж ирсэн нь сайшаалтай. Гэвч зөвхөн орчин үеийн зохицуулалт хуульд тусгасан нь хангалттай биш билээ. Арбитрагийн эрх зүйн салбарын хөгжил хууль тогтоогчийн гаргасан хуулийн зохицуулалтаар биш арбитрагийн байгууллагуудын өөрсдийн гаргасан дүрмийн зохицуулалтаар мөн явагддаг. Арбитрагийн байгууллага өөрийг нь зориод маргаанаа шүүхийн бус журмаар шийдвэрлүүлэхээр ирсэн маргалдагч талуудыг хамгийн түргэн шуурхай, чанартай маргаан шийдвэрлэх үйлчилгээгээр хангах нь аль ч орны арбитрагийн салбарын хөгжилд чухал ач холбогдолтой байдаг. Харин арбитрагийн байгууллагуудын энэхүү чанартай маргаан шийдвэрлэх үйлчилгээгээр хангах чадвар нь тэдгээрийн арбитрагийн хэрэг хянан шийдвэрлэх дотоод дүрмүүдээс шалтгаалдаг. Тэгвэл түр арга хэмжээний талаарх зохицуулалт МОУА-ын дүрэмд хэр сайн зохицуулагдсан байна вэ?

МОУА-ын Арбитрагчдын зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 04 тоот тогтоолоор батлагдсан Арбитрагийн Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрмийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрагийн бүрэлдэхүүн аль нэг талын хүсэлтийг үндэслэн тухайн маргааны зүйлийн талаар зайлшгүй шаардлагатай гэж үзвэл шийдвэрийн биелэлтийг хангах хуульд нийцсэн арга хэмжээг авч болно.”<sup>11</sup> гэж мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Аль нэг тал тухайн маргаантай холбоотойгоор шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авах зорилгоор арбитрагийн ажиллагааны өмнө эсвэл арбитрагийн ажиллагааны явцад шүүхэд хүсэлт гаргаж болно. Энэ нь арбитрагийн хэлэлцээртэй

<sup>8</sup> 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, Арбитрагийн тухай хууль, 2017 он.

<sup>9</sup> 13 дугаар зүйл, Арбитрагийн тухай хууль, 2003 он.

<sup>10</sup> Загвар хуулийг баталсан ихэнх орнууд түр арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийг талууд арбитра болон шүүхийн аль алинд нь гаргах боломжтойгоор хуульчилсан байдаг.

<sup>11</sup> МОУА-ын Арбитрагчдын зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 04 тоот тогтоолоор батлагдсан Арбитрагийн Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрэм, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг; <http://www.arbitr.mn/index.php/law-rule-menu/2019-10-14-05-29-06> [Сүүлд үзсэн: 2022.11.14]

ямар нэг байдлаар зөрчилдсөн гэж үзэхгүй.”<sup>12</sup> гэж заасан байдаг. Хэдий уг зохицуулалтууд түр арга хэмжээ авхуулахаар талууд шүүхэд болон арбитрын бүрэлдэхүүнд хүсэлт гаргах боломжтой, шүүх болон арбитрын бүрэлдэхүүн энэ талаар шийдвэрлэх эрхтэйг тодотгосон ч тун ерөнхий байдлаар зохицуулсан байна.

Дээр дурдсанчлан Арбитрын тухай 2017 оны хууль түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтээ талууд шүүхээс гадна арбитрын бүрэлдэхүүнд гаргах бүрэн боломжтойгоор зохицуулсан ч МОУА-ын Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх 2017 оны Дүрэм энэ талаар ямарваа нэгэн нарийн зохицуулалт оруулж ирээгүй, зөвхөн арбитрын бүрэлдэхүүн түр арга хэмжээ хуульд заасан хүрээнд авах боломжтой талаар тэмдэглэсэн байх юм. Ингэхдээ хуульд дурдсан нэр томъёог (түр арга хэмжээ) бус хуучин нэршлийг (шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ) ашиглан уг ерөнхий зохицуулалтаа хийсэн байна.

Өнөөгийн байдлаар арбитрын маргааны талууд түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтээ арбитрын бүрэлдэхүүнд болон шүүхэд аль альд нь гаргаж байна. Хэдий дүрэм болон хуульд аль альд нь хүсэлтийг шүүхэд болон арбитрт гаргаж болохоор зохицуулсан, зохицуулалтууд хангалттай мэт харагдаж болох ч энэ харилцаанд хуульд нарийн тусгагдаагүй ч дүрмээр заавал зохицуулах шаардлагатай нэгэн чухал зохицуулалт дутуу байгаа юм. Энэ нь арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө нэн яаралтай байгаа түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлттэй байгаа талууд бүрэлдэхүүн бүрдэхийг хүлээлгүйгээр эсвэл шүүхэд хандалгүйгээр арбитрын байгууллагадаа хандан, арбитрын байгууллагаас томилогдсон арбитрч (яаралтай арбитрч) түр арга хэмжээ авах зохицуулалт юм.

Уг зохицуулалт яагаад хэрэгтэй вэ? гэвэл одоогийн тогтолцоогоор МОУА-т маргалдагч талууд арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө түр арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд хүсэлтээ шүүхэд гаргаж байна. Гэвч олон улсын бусад арбитрын байгууллагууд дахь энэ талаарх харилцааны зохицуулалтыг харвал талууд арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнөх нэн яаралтай түр арга хэмжээ авхуулах хүсэлтээ арбитрын байгууллагадаа гаргаж, арбитрын байгууллагын дарга эсвэл ерөнхий нарийн бичгийн дарга *emergency arbitrator* буюу яаралтай арбитрчийг томилон, тус арбитрч нь талуудын нэн яаралтай түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтийг шийдвэрлэх зохицуулалттай байгаа юм. Энэхүү зохицуулалтын онцлог, давуу тал нь талууд яаралтай түр арга хэмжээ авхуулахын тулд арбитрын бүрэлдэхүүн бүрдэхийг хүлээн цаг алдалгүйгээр эсвэл шүүхэд хандалгүйгээр арбитрын байгууллагадаа хандан хүсэлтээ шийдвэрлүүлэх явдал юм. Харин тус яаралтай арбитрчийн талаарх заалтууд нь бүгд арбитрын байгууллагуудын өөрсдийн дотоод дүрмээр гарч ирсэн зохицуулалтууд байх юм.<sup>13</sup>

Монгол Улсад яаралтай арбитрчийн зохицуулалт яагаад чухал шаардлагатай талаар хоёр үндсэн шалтгаан байгаа бөгөөд нэгдүгээрт, нэгэнт шүүхийг биш арбитрыг зориод ирсэн талууд түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтээ шүүхэд гарган хэргийн материалаа шүүхэд танилцуулахгүйгээр арбитрт хандсанаар маргааны нууцлалаа алдахгүй, хоёрдугаарт, яаралтай түр арга хэмжээ шаардлагатай нөхцөлд шүүхэд биш дотооддоо яаралтай арбитрчийн талаарх шуурхай зохицуулалттай арбитрын байгууллагадаа хандсанаар цаг хэмнэж авах түр арга хэмжээний үр дүн, чанарыг ихэсгэнэ.

Асуудлыг илүү нарийн ойлгохын тулд түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлт гаргасан талын хүсэлтийг арбитрын бүрэлдэхүүн хэр хугацаанд багтаан хянан хэлэлцэж байгаа талаар арбитрын шийдвэр бүхий кэйсүүдийг доорх хэсэгт судлан үзэх болно.

<sup>12</sup> МОУА-ын Арбитрчдын зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 04 тоот тогтоолоор батлагдсан Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрэм, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг; <http://www.arbitr.mn/index.php/law-rule-menu/2019-10-14-05-29-06> [Сүүлд үзсэн: 2022.11.14]

<sup>13</sup> Marc J. Goldstein, “A Glance into History for the Emergency Arbitrator,” *Fordham International Law Journal* 40, no. 3 (April 2017): 779-798.

***Түр арга хэмжээ авахтай холбоотой шийдвэр бүхий кэйсүүдэд хийсэн дүн шинжилгээ:***

*2018 оны 59/18 дугаартай “Ньюсиан” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Саян Майнинг” ХХК-д холбогдох хэрэг*<sup>14</sup>

2018 оны 59/18 дугаартай “Ньюсиан” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Саян Майнинг” ХХК-д холбогдох, талуудын хооронд байгуулагдсан төмрийн хүдрийн баяжмал нийлүүлэхтэй холбоотой гэрээнээс үүдэлтэй маргаанд нэхэмжлэгч “Ньюсиан” ХХК-иас 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Арбитрт гаргасан, хариуцагч “Саян Майнинг” ХХК-ийн хувьцаа болон Дархан-Уул аймгийн Хонгор суманд орших үйлдвэрийн байр болон үйлдвэрт орших төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэх тоног төхөөрөмжүүд мөн ажилчдын дотуур байр, гүний худгуудыг тус тус бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, барьцаалахыг хориглох, хязгаарлах, одоо байгаа нөхцөлд хэвээр хадгалахыг хариуцагчид даалгасан түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтийг гаргасан.

Гэвч тус хүсэлт гарснаас хойш арбитрын бүрэлдэхүүн хүсэлтийг хэлэлцэхийн тулд даруй 3 сар орчим хугацаанд талуудыг хүлээлгэн 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн урьдчилсан хуралдаанаар хүсэлтийг хэлэлцэн арбитрын бүрэлдэхүүний тус өдрийн 22 тоот шийдвэрээр хангаж шийдвэрлэсэн байна. Нэхэмжлэгч тал хүсэлт нэн чухал шаардлагатайг хүсэлтдээ дурдсан мөн удаа дараа арбитрын байгууллагад хандаж байсан ч шүүхэд хандах замыг сонгоогүй нөхцөлд арбитрын бүрэлдэхүүн бүрдэхийг хүлээхээс өөр аргагүй хууль болоод арбитрын дүрмийн зохицуулалт байгаа тул хүлээн хүсэлтээ гаргасан өдрөөс хойш нийт 88 хоногийн дараа шийдвэрлүүлсэн байна.

*2019 оны 41/19 дугаартай “Монголросцветмет” ТӨҮГ-ын нэхэмжлэлтэй “Ганболд металл” ХХК-д холбогдох хэрэг*<sup>15</sup>

2019 оны 41/19 дугаартай “Монголросцветмет” ТӨҮГ-ын нэхэмжлэлтэй “Ганболд металл” ХХК-д холбогдох, талуудын хооронд байгуулагдсан 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн “Төмрийн хүдэр нийлүүлэх гэрээ”-нээс үүдэлтэй маргаанд нэхэмжлэгч “Монголросцветмет” ТӨҮГ нь 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Арбитрт хандан түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлт буюу арбитрын үндсэн шийдвэрийн биелэлтийг хангахад шаардагдах хөрөнгийг хамгаалах зорилгоор нийт 38,940,301.62 төгрөгийн хэмжээнд хариуцагчийн Голомт банкны дансан дахь мөнгөн хөрөнгийг битүүмжлэх шийдвэр гаргуулах хүсэлтийг гаргасан.

Арбитрын бүрэлдэхүүн 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн урьдчилсан хуралдаанаар хянан хэлэлцэн тус хүсэлтийг шийдвэрлэсэн 306 тоот шийдвэрийг гаргасан. Хэдий тус шийдвэрээр арбитрын бүрэлдэхүүн түр арга хэмжээ авхуулах хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, хариуцагч “Ганболд металл” ХХК-ийн банкны дансан дахь мөнгөн хөрөнгийг битүүмжлэх түр арга хэмжээ аваагүй ч тус арга хэмжээг нэн яаралтай авах хэрэгцээ, шаардлага байгаа талаар нэхэмжлэгч тал хүсэлтэндээ дурдсаныг арбитрын бүрэлдэхүүн үл харгалзан хүсэлт гаргасан өдөр буюу 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс хойш даруй 23 хоногийн дараагаар 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн урьдчилсан хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

<sup>14</sup> 2018 оны 59/18 дугаартай “Ньюсиан” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Саян Майнинг” ХХК-д холбогдох хэргийн 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн урьдчилсан хуралдаанаар нэхэмжлэгч “Ньюсиан” ХХК-ийн гаргасан түр арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийг хэлэлцэн арбитрын бүрэлдэхүүний гаргасан 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 22 тоот шийдвэр. Тус хэргийн материалыг эрдэм шинжлэлгээний зорилгоор шинжлэн судлахад нээлттэй байх талаар талууд 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн урьдчилсан хуралдаанаар тохиролцсон тул талуудын нэрийг мэдээллэсэн. Гэвч зарим нэгэн объектын талаарх нарийн мэдээллийг талуудын хувийн мэдээллийн нууцлалыг хадгалах үүднээс оруулаагүй болно.

<sup>15</sup> 2019 оны 41/19 дугаартай “Монголросцветмет” ТӨҮГ-ын нэхэмжлэлтэй “Ганболд металл” ХХК-д холбогдох хэргийн 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн урьдчилсан хуралдаанаар нэхэмжлэгч “Монголросцветмет” ТӨҮГ-ын гаргасан түр арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийг хэлэлцэн арбитрын бүрэлдэхүүний гаргасан 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 306 тоот шийдвэр. Тус хэргийн материалыг эрдэм шинжлэлгээний зорилгоор шинжлэн судлахад нээлттэй байх талаар талууд 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн урьдчилсан хуралдаанаар тохиролцсон тул талуудын нэрийг мэдээллэсэн. Гэвч хариуцагчийн банкны дансны талаарх нарийн мэдээллийг талуудын хувийн мэдээллийн нууцлалыг хадгалах үүднээс оруулаагүй болно.



Дээрх хоёр кэйсээс үзэхэд арбитрын бүрэлдэхүүн түр арга хэмжээ авхуулах тухай нэн яаралтай хүсэлтүүдийг зарим тохиолдолд 3 сар, харин зарим тохиолдолд 20 орчим хоногт багтаан шийдвэрлэсэн байх юм. Түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтийг шийдвэрлэх хугацаа нь хэдий олон нөхцөл байдлаас шалтгаалж болох ч дээрх хоёр кэйсэд хоёр арбитрын бүрэлдэхүүн хоёулаа хүсэлтийг урьдчилсан хуралдааны үеэр хэлэлцэн шийдвэрлэсэн байдлаас үзвэл арбитрын бүрэлдэхүүн урьдчилсан хуралдаан хийх хүртлээ түр арга хэмжээ авхуулах тухай нэн яаралтай хүсэлтүүдийг хүлээлгэдэг нь харагдаж байж болохоор байна. Хэдий 20 орчим хоног их биш хугацаа байж болох ч нэн яаралтай түр арга хэмжээ шаардлагатай байгаа тохиолдлуудад хүсэлт гаргасан талд нэг хоногийг алдах ч түүнд эдийн болоод эдийн бус ихээхэн хохирлыг үүсгэж, ирээдүйд гарах арбитрын үндсэн шийдвэрийн гүйцэтгэлийг хүндрүүлэх боломжтой байдаг.

Харин 2018 оны 59/18 дугаартай “Ньюсиан” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Саян Майнинг” ХХК-д холбогдох хэргээс үзвэл зарим тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн бүрдэж хамгийн анхны урьдчилсан хуралдаанаа хийтэл 3 сар хүртэлх хугацаа хүртэл шаардагддаг байх тул түр арга хэмжээ авхуулах тухай нэн яаралтай хүсэлтүүдийг шийдвэрлэхийн тулд урьдчилсан хуралдаан хийхийг хүлээх зэрэг байдлаар арбитрын бүрэлдэхүүн цаг хугацаа алдагдуулан талуудыг хүлээлгэх нь төдийлөн хүсэлт гаргагч талуудад ээлтэй биш байгаа нь харагдаж байна. Гэвч одоогийн байгаа зохицуулалтаар хэрвээ түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлт гаргагч тал энэ талаар шүүхэд хандах замыг сонгоогүй бол арбитрын бүрэлдэхүүн бүрдэхийг хүлээн дараагаар нь арбитрын бүрэлдэхүүн урьдчилсан хуралдаан хийхийг хүлээхээс<sup>16</sup> өөр сонголтгүй байна. Иймд Монгол Улсын арбитрын ажиллагаанд яаралтай арбитрачийн зохицуулалтыг оруулж ирэх хэрэгцээ, шаардлага байна.

### **3. Яаралтай арбитрачийн талаарх Азийн бусад арбитражуудын зохицуулалт: Хонг Конг, Япон, Солонгосын арбитрын байгууллагуудын туршлагаас**

Хамгийн анхны яаралтай арбитрачийн зохицуулалт 1990 оноос эхлэлтэй. 1990 онд Олон Улсын Худалдааны Танхимын Арбитрын Комисс тухайн үеийн Францийн шүүхүүдэд хэрэглэгдэж байсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс өмнө шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авч болох тухай процедурыг жишиг болгон арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө түр арга хэмжээ авч болох талаарх дүрмийг баталсан нь өнөөгийн яаралтай арбитрачийн зохицуулалтын эх үндэс болсон юм.<sup>17</sup>

Яаралтай арбитрачийн талаарх бусад Азийн орнуудын арбитражуудын зохицуулалтыг судалвал, Хонг Конгийн Олон Улсын Арбитрын Төвийн 2018 оны Удирдагдсан Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрэм (Administered Arbitration Rules)-ийн 4 дүгээр Хавсралтын 1 дүгээр зүйлд “Арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө нэн яаралтай түр арга хэмжээ авхуулах шаардлагатай байгаа тал яаралтай арбитрач томилуулахаар Арбитраг хандаж болно.”<sup>18</sup> гэж заасан байдаг. Харин тус хавсралтын 4 дүгээр зүйлд Хонг Конгийн Олон Улсын Арбитрын Төв нь хүсэлтийг хүлээж авсан даруйдаа 24 цагийн дотор яаралтай арбитрачийг томилно гэж заасан байна.<sup>19</sup>

Харин Солонгосын Арбитраг буюу Солонгосын Арбитрагийн Зөвлөлийн 2016 оны Олон Улсын Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрмийн 3 дугаар Хавсралтын

<sup>16</sup> Зарим тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн урьдчилсан хуралдаан хийхээс өмнө түр арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийг шийдвэрлэх хуралдааныг тусад нь хийсэн кэйсүүд байхыг үгүйсгэхгүй.

<sup>17</sup> Jason Fry, “The Emergency Arbitrator - Flawed Fashion or Sensible Solution,” *Dispute Resolution International* 7, no. 2 (November 2013): 179-198 (at 181), see Articles 808 and 809 of the French Code of Civil Procedure, ICC Rules for Pre-Arbitral Referee Procedure (1990), Article 2.1.

<sup>18</sup> Schedule 4, HKIAC, “Administered Arbitration Rules”, see HKIAC, *Arbitration Rules & Practice Notes*, “Administered Arbitration Rules” (2018) see (Oct 13, 2022) <https://www.hkiac.org/arbitration/rules-practice-notes/administered-arbitration-rules/hkiac-administered-2018-2#S4>

<sup>19</sup> Schedule 4, HKIAC, “Administered Arbitration Rules”, see HKIAC, *Arbitration Rules & Practice Notes*, “Administered Arbitration Rules” (2018) see (Oct 13, 2022) <https://www.hkiac.org/arbitration/rules-practice-notes/administered-arbitration-rules/hkiac-administered-2018-2#S4>



1 дүгээр зүйлд “Арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө түр арга хэмжээ авхуулах шаардлагатай байгаа тал Арбитрын нарийн бичгийн даргын ажлын албанд яаралтай арбитрчаар түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтээ бичгээр гаргана. Солонгосын Арилжааны Арбитрын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга яаралтай арбитрч томилох нь зүйтэй гэж үзвэл хүсэлтийг хүлээн авснаас хойш хоёр ажлын өдрийн дотор нэг яаралтай арбитрчийг томилно.”<sup>20</sup> гэж зохицуулсан байна.

Тэгвэл Японы яаралтай арбитрчийн зохицуулалтын тухайд, Японы Арилжааны Арбитрын Холбооны 2021 оны Арилжааны Маргааны Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрмийн 75 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө эсвэл арбитрын бүрэлдэхүүний аль нэг арбитрч тодорхой шалтгааны улмаас бүрэлдэхүүнээс гарсан эсвэл арбитрчийн үүргээ биелүүлэх боломжгүй болсон, зогсоосон нөхцөлд нэн яаралтай түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлттэй байгаа тал яаралтай арбитрчаар түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтээ Японы Арилжааны Арбитрын Холбоонд бичгээр гаргаж болно.”<sup>21</sup> гэж заажээ. Харин мөн тус дүрмийн 76 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Японы Арилжааны Арбитрын Холбоо нь нэг яаралтай арбитрч томилоно.”<sup>22</sup> гэж заасан байна. Мөн Арбитрын байгууллага нь хүсэлтийг хүлээн авснаас хойш хоёр ажлын өдрийн дотор шийдвэрлэнэ гэж Солонгосын Арилжааны Арбитрын Зөвлөлийн зохицуулалттай адилаар зохицуулжээ.<sup>23</sup>

Харин томилогдсон яаралтай арбитрч хэрхэн ажиллах талаар ихэнх арбитрын байгууллагууд ойролцоо зохицуулалттай байх бөгөөд жишээ нь Солонгосын Арилжааны Арбитрын Зөвлөлийн 2016 оны Олон Улсын Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрмийн 3 дугаар Хавсралтын 3 дугаар зүйлд “Яаралтай арбитрч нь томилогдсоноос хойш хоёр ажлын өдрийн дотор түр арга хэмжээ авхуулах тухай талуудын хүсэлтийг шийдвэрлэх процесс ажиллагааны төлөвлөгөө, хуанли гаргана. Мөн шаардлагатай тохиолдолд хуралдаан явуулна. Яаралтай арбитрч нь яаралтай түр арга хэмжээ авхуулах тухай талуудын гаргасан хүсэлтийг томилогдсон өдрөөс хойш 15 хоногийн дотор шийдвэрлэнэ.”<sup>24</sup> гэж зохицуулжээ.

Үүнээс үзэхэд Азийн ихэнх арбитрын байгууллагууд яаралтай арбитрчийн талаарх зохицуулалттай байх бөгөөд нэг нэгнээсээ өрсөн илүү нарийн зохицуулалт оруулж ирэхээр дүрмээ цаг ямагт шинэчилдэг байна. Жишээ нь Японы Арилжааны Арбитрын Холбоо нь тогтмол дүрмээ өөрчлөн шинэчилдэг, 2019 онд шинэ дүрэм баталсан ч үүнийгээ дахин шинэчилэн 2021 онд дахин шинэ Арилжааны Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрэм баталсан.<sup>25</sup> Харин Япон Улсын Арбитрын тухай хууль 2003 онд батлагдсан цагаасаа хойш нэг ч шинэчлэн найруулагдаагүй, өөрчлөлт ороогүй байх юм.<sup>26</sup> Иймд зөвхөн яаралтай арбитрчийн асуудлаар бус арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хөгжилтэй холбоотой бусад асуудлаар ч “арбитрын ажиллагааны хөгжил хуулийн өөрчлөлт шинэчлэлтээр биш арбитрын байгууллагуудын дотоод дүрмүүдийн өөрчлөлт шинэчлэлтээр явагддаг” гэсэн ерөнхий нэг суурь зарчим ажиглагдаж байгааг манай орны хууль тогтоогчид, арбитрын байгууллагууд, судлаачид цаашид анхаарч үзэх нь зүйтэй байж болох юм.

<sup>20</sup> Paragraph 1 and 4 of Article 2, the Appendix 3 of KCAB “International Arbitration Rules”, (2016), see KCAB, “Rules and Law: KCAB International Arbitration Rules” (2016), (Oct 13, 2022) <http://www.kcabinternational.or.kr/main.do>

<sup>21</sup> JCAA Commercial Arbitration Rules, (2021); see JCAA, “Arbitration: Arbitration Rules”, (2021) (Oct 13, 2022) <https://www.jcaa.or.jp/en/arbitration/rules.html>

<sup>22</sup> JCAA Commercial Arbitration Rules, (2021); see JCAA, “Arbitration: Arbitration Rules”, (2021) (Oct 13, 2022) <https://www.jcaa.or.jp/en/arbitration/rules.html>

<sup>23</sup> Paragraph 4, Article 76, JCAA Commercial Arbitration Rules, (2021); see JCAA, “Arbitration: Arbitration Rules”, (2021) (Oct 13, 2022) <https://www.jcaa.or.jp/en/arbitration/rules.html>

<sup>24</sup> KCAB, “International Arbitration Rules”, Appendix 3 (2016), see KCAB, “Rules and Law: KCAB International Arbitration Rules” (2016), see (Oct 13, 2022) <http://www.kcabinternational.or.kr/main.do>

<sup>25</sup> JCAA Commercial Arbitration Rules, (2021), (2019) (Oct 13, 2022) <https://www.jcaa.or.jp/en/arbitration/rules.html>

<sup>26</sup> Arbitration Law of Japan, (2003), see (Nov 15, 2022) <https://japan.kantei.go.jp/policy/sihou/arbitrationlaw.pdf>

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Манай Улс 2017 онд ЮНСИТРАЛ-ын Олон Улсын Арилжааны Арбитрын тухай загвар хуульд нийцсэн Арбитрын тухай хуулийг батлан, өдгөө загвар хуулийг батласан нийт 118 харьяалал бүхий 85 улсын нэгд тооцогдож байна.<sup>27</sup> Хэдий орчин үеийн зохицуулалт бүхий стандарт хуулиудыг батлах нь сайн хэрэг ч дан ганц загвар хуулийг баталсан тул гадаадын бизнесийн байгууллага, хувь хүмүүс маргаанаа шийдвэрлүүлэхээр манай орныг шууд зориод ирэхгүй. Бидэнд хуулиас гадна арбитрын байгууллагын шинэлэг, бас талуудад ээлтэй зохицуулалт бүхий Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрэм (мөн олон улсын хэмжээн дэх сайн зар сурталчилгаа, болон шүүхийн дэмжлэг) хэрэгтэй. Аль ч арбитрын байгууллагад хуулийн дараах хамгийн чухал баримт бичиг нь тус институтын Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрэм нь байдаг. Хэдий МОУА-ын 2017 оны Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрэм хуулийн хүрээнд тодорхой зохицуулалтыг хийсэн ч хуульд тусгагдаагүй, талуудад ээлтэй, гадаад орнуудын арбитрын сайн туршлагаас мөн авч дүрэмдээ суурьшуулах шаардлагатай байна. Яаралтай арбитрчийн зохицуулалт бол хамгийн чухал яаралтай дүрэмд тусгах шаардлагатай байгаа зохицуулалтын нэг, МОУА цаашид дүрмээ сайжруулахаар нарийн анхаарч ажиллах шаардлагатай байна.

Түүнчлэн хэдий 2020 оны 7 дугаар сард МОУА-аас Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрмийг боловсронгуй болгох ажлын хэсэг мөн шинэ дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан хэлэлцүүлэхэд бэлтгэх 5 гишүүний бүрэлдэхүүнтэй дэд ажлын хэсгийг байгуулсан<sup>28</sup> ч өнөөг хүртэл (2022 оны 12 дугаар сарын байдлаар) боловсронгуй болсон шинэ дүрэм батлагдаагүй. Энд мөн нэгэн анхаарах асуудал нь хэтэрхий монополь байдлаар зах зээлээ дангаар эзэмшин хөгжиж байгаа арбитрын байгууллага дүрэм журмаа хөгжүүлэхэд төдийлөн өндөр өрсөлдөөн бүхий маргаан шийдвэрлэх зах зээлд үйл ажиллагаагаа явуулж буй арбитрын байгууллага мэт нарийн анхаарч ажиллахгүй байж болох явдал юм. Иймд энэ нь өнөөгийн шүүхийн байгууллагуудын ачаалал ихэссэн цаг үед дотоодын болон гадаадын арилжааны маргааныг чадварлагаар шийдвэрлэх өөр нэг шинэ арбитрын байгууллагууд төрөх цаг ч бас болсны дохио болж байна.

Эцэст нь яаралтай арбитрчтай холбоотой асуудлаар дүгнэхэд Хонг Конг, Солонгос болон Япон тэргүүтэй Азийн бусад улсын арбитрын байгууллагууд Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрэмдээ тусгасан яаралтай арбитрчийн талаарх зохицуулалтыг МОУА дүрэмдээ тусгах шаардлагатай байна. Энэхүү зохицуулалтыг МОУА дүрэмдээ тусгаснаар нэгэнт шүүхийг биш арбитрыг зориод ирсэн талууд түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтээ шүүхэд гарган хэргийн материалаа шүүхэд танилцуулахгүйгээр арбитрт хандан маргааны нууцлалаа алдахгүй байх нөхцөл бололцоо бүрдэнэ, мөн талууд яаралтай түр арга хэмжээ шаардлагатай нөхцөлд шүүхэд биш дотооддоо яаралтай арбитрчийн талаарх шуурхай зохицуулалттай арбитрын байгууллагад хандсанаар цаг хэмнэн авах түр арга хэмжээний үр дүн, чанарыг ихэсгэх ач холбогдолтой.

Уг судалгааны нийтлэл нь Хонг Конг, Солонгос болон Япон Улсын тэргүүлэх арбитрын байгууллагууд дахь яаралтай арбитрчийн зохицуулалтыг судалсны үндсэн дээр МОУА-ын 2017 оны Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрэмд доорх хоёр ерөнхий шинэ заалтыг нэмж оруулахыг санал болгож байна:

“Арбитрын бүрэлдэхүүн бүрдэхээс өмнө эсвэл арбитрын бүрэлдэхүүний аль нэг арбитрч тодорхой шалтгааны улмаас бүрэлдэхүүнээс гарсан эсвэл арбитрчийн үүргээ яаралтай биелүүлэх боломжгүй болсон үед нэн яаралтай түр арга хэмжээ шаардлагатай

<sup>27</sup> United Nations Commission on International Trade Law, “Status: UNCITRAL Model Law on International Commercial Arbitration (1985), with amendments as adopted in 2006” (November 14, 2022) [https://uncitral.un.org/en/texts/arbitration/modelaw/commercial\\_arbitration/status](https://uncitral.un.org/en/texts/arbitration/modelaw/commercial_arbitration/status)

<sup>28</sup> МОУА, “Монголын Олон Улсын Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрмийг Боловсронгуй Болгох Ажлын Хэсгийн Хурал Зохион Байгуулагдлаа”, 2020 оны 7 дугаар сарын 31, <http://www.arbitr.mn/index.php/2019-10-10-09-21-18/55-2020-08-12-01-44-28> [Сүүлд үзсэн: 2022.11.04]

байгаа тал Арбитрын Ерөнхий Нарийн Бичгийн Даргын Ажлын Албанд хандан яаралтай арбитрчаар түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтээ бичгээр гаргана. Монголын Олон Улсын Арбитрын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга яаралтай арбитрч томилох нь зүйтэй гэж үзвэл хүсэлтийг хүлээн авснаас хойш хоёр ажлын өдрийн дотор нэг яаралтай арбитрчийг тухайн хүсэлтийг шийдвэрлүүлэхээр томилно.”

“Яаралтай арбитрч нь томилогдсон өдрөөс хойш хоёр ажлын өдрийн дотор түр арга хэмжээ авхуулах тухай талуудын хүсэлтийг шийдвэрлэх процесс ажиллагааны төлөвлөгөө, хуанли гаргана. Мөн шаардлагатай тохиолдолд хуралдаан явуулна. Яаралтай арбитрч нь яаралтай түр арга хэмжээ авхуулах тухай талуудын гаргасан хүсэлтийг томилогдсон өдрөөс хойш 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.”

## ЭХ СУРВАЛЖ

Монгол эх сурвалж:

1. Арбитрын тухай хууль, 2003 он; <https://legalinfo.mn/mn/detail/51> [Сүүлд үзсэн: 2022.11.14]
2. Арбитрын тухай хууль, 2017 он; <https://legalinfo.mn/mn/detail/12456> [Сүүлд үзсэн: 2022.11.14]
3. МОУА-ын Арбитрчдын зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 04 тоот тогтоолоор батлагдсан Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрэм, <http://www.arbitr.mn/index.php/law-rule-menu/2019-10-14-05-29-06> [Сүүлд үзсэн: 2022.11.14]
4. МОУА, “Монголын Олон Улсын Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх Дүрмийг Боловсронгуй Болгох Ажлын Хэсгийн Хурал Зохион Байгуулагдлаа”, 2020 оны 7 дугаар сарын 31, <http://www.arbitr.mn/index.php/2019-10-10-09-21-18/55-2020-08-12-01-44-28> [Сүүлд үзсэн: 2022.11.14]
5. Т.Мөнхжаргал, Монгол дахь Арбитрын Шүүхийн Товч Түүх, УБ, МҮХАҮТ-ын дэргэдэх Хэвлэх Үйлдвэр, 2015

Гадаад эх сурвалж:

1. Appendix 3 of KCAB “International Arbitration Rules”, (2016), see KCAB, “Rules and Law: KCAB International Arbitration Rules” (2016), (Oct 13, 2022) <http://www.kcabinternational.or.kr/main.do>;
2. Ghaffari, Amir and Walters, Emmylou “Emergency Arbitrator: The Dawn of a New Age?”, *Arbitration International*, Vol. 30, Issue 1 (2014): 153-168;
3. Jason Fry, “The Emergency Arbitrator - Flawed Fashion or Sensible Solution,” *Dispute Resolution International* 7, no. 2 (November 2013): 179-198;
4. JCAA Commercial Arbitration Rules, (2021); see JCAA, “Arbitration: Arbitration Rules”, (2021) (Oct 13, 2022) <https://www.jcaa.or.jp/en/arbitration/rules.html>;
5. Marc J. Goldstein, “A Glance into History for the Emergency Arbitrator,” *Fordham International Law Journal* 40, no. 3 (April 2017): 779-798;
6. Schedule 4, HKIAC, “Administered Arbitration Rules”, see HKIAC, *Arbitration Rules & Practice Notes, “Administered Arbitration Rules”* (2018) see (Oct 13, 2022) <https://www.hkiac.org/arbitration/rules-practice-notes/administered-arbitration-rules/hkiac-administered-2018-2#S4>;
7. United Nations Commission on International Trade Law, “Status: UNCITRAL Model Law on International Commercial Arbitration (1985), with amendments as adopted in 2006” (November 14, 2022) [https://uncitral.un.org/en/texts/arbitration/modellaw/commercial\\_arbitration/status](https://uncitral.un.org/en/texts/arbitration/modellaw/commercial_arbitration/status).

## WHY MONGOLIA NEEDS EMERGENCY ARBITRATORS?

*Munkhnaran M.*

*Regional Representative for Japan at Energy Disputes Arbitration Center Turkey,  
Ph.D. candidate of School of Law, Nagoya University*

### **ABSTRACT:**

The leading arbitral institution in Mongolia, Mongolian International Arbitration Center (MIAC), revised and adopted its Arbitration rules in 2017 after the country adopted the UNCITRAL Model Law on International Commercial Arbitration. Nevertheless, the MIAC did not provide regulations for Emergency arbitrators in its 2017 Arbitration Rules. The provisions for emergency arbitrators are regulations not provided by the Model Law but are widely used by many international arbitral institutions in their arbitration rules. The emergency arbitrator provisions became popular among arbitral institutions since 1990. The primary notion of emergency measures is that before the constitution of the arbitral tribunals if the parties need urgent interim measures, they can ask for it from the institution without waiting for the complete constitution of arbitral tribunals or consuming their time for asking the national court. The institutions appoint emergency arbitrators who would decide on the application for emergency measures. Most international arbitral institutions have emergency arbitrator provisions on their arbitration rules. Based on the study on emergency arbitrators' regulations in Asian (Hong Kong, Japan, Korea) arbitral institutions, this research designed two general model provisions on emergency arbitrators and suggests MIAC reflect these provisions on its Arbitration Rules.

### **KEYWORDS:**

Arbitration law, Interim measures, UNCITRAL Model Law on International Commercial Arbitration, Mongolian International Arbitration Center

## LEX MERCATORIA-Г ХУДАЛДААНЫ АРБИТРТ ХЭРЭГЛЭХ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА МОНГОЛ УЛС, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



*М.Нямжаргал  
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирлын  
туслах*

### **ТОВЧЛОЛ:**

21 дүгээр зууны даяаршиж буй энэ дэлхий ертөнцийн түгээмэл хандлагын дагуу Монгол Улсын төр, хувь этгээд эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан зэрэг олон салбарт хамтран ажиллах, худалдаа наймаа хийх зэрэг гадаад улс оронтой олон төрлийн хэлбэрээр харилцаж байгаа бөгөөд үүний хирээр маргаан гарах тохиолдол ихсэж, олон улсын арбитраар тус маргаанаа шийдвэрлүүлэх сонирхол Монгол Улсаас гадна дэлхий нийтээр ихсэж байна. Гэтэл Монгол Улс олон улсын арбитрад өөрийн орны эрх ашгийг хангалттай хэмжээнд хамгаалж чаддаггүй. Жишээлбэл, Монгол Улсын Засгийн газар Канадын хөрөнгө оруулалттай Хан Ресурс компанийн уран хайх тусгай зөвшөөрлийг тус компани олон улсын арбитрад хандаж, арбитраын шийдвэрээр Монгол Улсын Засгийн газар тухайн компанийн олох ёстой байсан орлого, түүний алдангитай нийлээд 106 сая ам.долларыг төлөхөөр болсон. Үүнээс гадна “Алтан Дорнод Монгол”, “Алстом Пауэрт” зэрэг маргаануудыг ч дурдаж болно. Тэгээд маргааныг шийдвэрлэсэн олон улсын арбитраг харвал Лондонгийн арбитр байгаа юм<sup>1</sup>. Англо, Саксоны эрх зүйн бүл нь гэрээ, хуулийн заалтаас гадна тухайн нийгэмд тогтсон зан заншил, практикт ихээхэн ач холбогдол өгдөг. Үүнээс үзвэл, Монгол Улсад заншлын эрх зүй, бүр тодруулбал худалдааны заншлын эрх зүйн ойлголт сул байгаагаас шалтгаалан олон улсын арбитрад ялагдсан байх боломжтой гэж харж байгаа юм. Ийм учраас худалдааны заншлын эрх зүйн агуулга, түүний ойлголт, ач холбогдол, арбитрад хэрхэн хэрэглэдэг, эрх зүйд яаж тусгасан зэрэг мэдээллийг өгөхөд уг нийтлэлийн маань зорилго оршино.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Заншлын эрх зүй, олон улсын арбитр, худалдаа наймаа, нийтэд тогтсон хэв журам, lex mercatoria, хууль, дүрэм журам, ЮНСИТРАЛ, ИНКОТЕРМС, УНИДРУА, ius gentium

<sup>1</sup> “100 сая ам.долларын өр: Монголын Засгийн газар болон улсын арбитраын шүүхэд яагаад ялагдав” нийтлэл <https://www.24tsag.mn/a/74424>

## ҮНДСЭН ХЭСЭГ

### 1. Түүхэн уламжлал

Эртний эзэнт гүрэн, улс орнуудын худалдаачид өөр хоорондоо арилжаа наймаа хийж байсан бөгөөд тус харилцаанд аль газар нутагт байгаагаас хамааран нэг талдаа давуу тал бий болох хандлага ажиглагдаж эхэлсэн. Аль газар нутагт байгаагаас үл хамааран талуудын харилцааг тэгш байдлын үндсэн дээр явуулах үүднээс хамгийн анх Ромын эзэнт гүрэн *ius gentium*-г бий болгосон. Ингэснээр худалдаа наймаанд гадаадын иргэдийн эрх ашгийг хамгаалж эхэлсэн<sup>2</sup> нь улмаар худалдааны анхны соёлыг нэвтрүүлсэн.

Бүс нутгийн хооронд худалдаа арилжаа тэлэхийн хирээр бүс нутгуудад өөрсдийн гэсэн худалдааны заншил, практик тогтож эхэлсэн. Ийнхүү дундад зууны үед *lex mercatoria*-н ойлголт үүсэж, жинхэнэ утгаараа хөгжиж эхэлсэн гэж олон эрдэмтэд үздэг. 13 дугаар зууны үед Европт худалдаа эрчимтэй хөгжиж, тэр дундаа Итали Улс нь геополитикийн үүднээс дэлхийн соёлын болоод худалдаа арилжааны төв болж байсан гэдэг утгаараа *lex mercatoria* тус улсаас үүсэлтэй<sup>3</sup>. Тухайн үеийн *lex mercatoria* нь худалдаачдын нийгэмд эзлэх байр суурь, зэрэг дэв, давхаргаас шалтгаалан өөр өөр байдлаар үйлчилдэг байснаар онцлог шинжтэй<sup>4</sup> ба бүс нутгуудад болгонд харилцан адилгүй соёл үйлчилж байсан: Жишээлбэл, *Wisby* болон *Oleran*-н хууль европын хойд хэсэгт бүс нутгийн хууль, заншлын хэм хэмжээг орлуулж байсан бол европын өмнөд хэсгийг Барселоны хуулиар бүс нутгийн хууль, заншлын хэм хэмжээг хэрэглэж байсан. Ийнхүү бага багаар *lex mercatoria* нь бичмэл бус байдлаас бичгэн хэлбэрт шилжсээр Өмнөд Италид *Amalfi*-н *code* бий болсноор Англи, Голланд, Франц, Герман улсууд дотооддоо худалдааны хууль баталж эхэлсэн. Ингэснээр аль улсын иргэн байхаас үл хамааран иргэд чөлөөтэйгөөр худалдаа хийх, худалдааны шударга байдлын зарчим, шударга шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэх эрх зэрэг олон асуудлыг зохицуулсан байдаг<sup>5</sup>. Судлаач *Ralf Michaels* нь *lex mercatoria*-н хөгжлийг дараах байдлаар үндсэн 3-н хэсэгт авч үздэг. Үүнд:

- Эртний үеийн *lex mercatoria*
- Шинэ үеийн *lex mercatoria*
- Орчин үеийн *lex mercatoria*

Хуучин үеийн *lex mercatoria* нь дундад зуун хүртэлх үеийг ойлгодог бөгөөд улс хоорондын худалдаанаас үүсэж бий болсон үндэстэн дамнасан процессын зарчим, хэм хэмжээний багц юм.

Шинэ үеийн *lex mercatoria* нь 20 дугаар зуун хүртэлх үеийг ойлгодог бөгөөд албан бус, уян хатан шинжтэй дүрэм журам болон арбитрч олон улсын худалдааны эрх зүйг бүтээдэг болсноороо онцлогтой.

Орчин үеийн *lex mercatoria* нь эмх цэгцгүй, уян хатан эрх зүйгээс системчлэгдсэн хууль, эрх зүй болсон гэдгээрээ онцлог бөгөөд бие даасан, хараат бус шүүхийг бий болгодог<sup>6</sup>.

Судлаач *Sir John Davies* нь *lex mercatoria*-н хөгжилд Англи, Франц, Герман Улсууд онцгой үүрэг гүйцэтгэсэн гэж үзсэн<sup>7</sup>. Учир нь эдгээр гурван улс нь 17 дугаар зуунаас эхлүүлэн ихэнх улс орноос худалдааны хуулийг ялгаатай байдлаар онолын түвшинд системчилж, түүнийг хөгжүүлж, хууль болгон баталж байсан үйл явдалтай холбоотой.

<sup>2</sup> Б.Тамир, “Олон улсын хувийн эрх зүй”, 2019, УБ., 149 дэх тал.

<sup>3</sup> С.Должин, “Хувийн эрх зүйн тайлбар толь бичиг”, 2019, УБ., 218 дахь тал.

<sup>4</sup> Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, “Арилжааны эрх зүй”, 2022, УБ., 12 дахь тал

<sup>5</sup> William Mitchell, “An Essay on the early history of the law merchant: Being the Yorke Prize”, 2006, New Jersey., 3-6 дахь тал.

<sup>6</sup> Indiana University Press, “Indiana Journal of Global Legal studies- Vol.14, No.2, 2007, Indiana., 447-448, Ralf Michaels, “The true Lex Mercatoria: Law Beyond the state” нийтлэл

<sup>7</sup> William Mitchell, “An Essay on the early history of the law merchant: Being the Yorke Prize”, 2006, New Jersey, 1 дэх тал.



## 2. Lex mercatoria-н ойлголт, ерөнхий агуулга

Lex mercatoria /латин үг/ нь монгол хэл рүү орчуулбал “худалдааны эрх зүй, худалдаачны хууль” гэх мэт янзаар орчуулдаг бөгөөд англи хэлээр “commercial law, law merchant”, орос хэлээр “торговое право” гэсэн үг<sup>8</sup>.

Oxford-н толь бичгээс үзвэл, “lex mercatoria гэдэг нь хувийн этгээд хоорондын болон улс, хувийн этгээд хоорондын маргааныг шийдвэрлэх зорилгоор олон улсын худалдааны арбитраг хэрэглэгддэг эрх зүйн зарчим, практик, заншилд тулгуурласан улс хоорондын бизнесийн харилцаагаар хөгждөг хууль зүйн дүрэм журмын нэг салбар ойлголт юм” гэж тодорхойлсон<sup>9</sup>.

Үүнээс үзвэл, lex mercatoria нь дараах үндсэн асуултыг гаргаж ирж байна. Үүнд:

1. Хувийн эрх зүйд байдаг эсэх,
2. Олон улсын худалдааны арбитраас өөр арбитраг эрх зүйн эх сурвалж болох эсэх,
3. Олон улс хоорондын бизнесийн харилцаагаар хөгждөг бөгөөд аливаа нэг засаг төр, захиргаанаас баталдаг эсэх,
4. Эрх зүйн зарчим, заншлын эрх зүйн ойлголт мөн эсэх.

Нэгдүгээрт, lex mercatoria нь нийтийн эрх зүйд багтах боломжтой юу? гэх асуулт билээ. Энэ талаар ОХУ-ын судлаач Липовцев В.Н “lex mercatoria нь олон улсын төрийн бус шинжтэй байгууллагуудаас баталсан дүрэм журамтай холбоотой бөгөөд lex mercatoria-г төр, шүүхийн байгууллага хамгаалж, баталгаажуулдаггүй тул хувийн эрх зүйн эх сурвалж болно” гэж үзсэн. Үүнээс үзвэл, lex mercatoria-г төр захиргаанаас баталдаггүй, шүүх, хууль хүчний байгууллагаар баталгаажиж хамгаалагддаггүй бөгөөд хувийн олон улсын худалдаанд оролцогч хувь этгээдүүдийн харилцаанаас үүсэж бий болдог тул хувийн эрх зүйд багтахар байна. Мөн АНУ-ын судлаач Freidrich K.Juenger “lex mercatoria-д талууд хэрэглэгдэх хууль тогтоомж, конвенцыг сайн дурын үндсэн дээр өөрсдөө гэрээгээр сонгодог, талууд бие даасан бөгөөд гэрээ байгуулах эсэхээ өөрсдөө шийдэх зарчим үйлчилдэг тул олон улсын хувийн эрх зүйн маргаанд хамаарагдана гэжээ. Тэгэхээр lex mercatoria нь хувийн эрх зүйд багтахар байгаа ба нийтийн эрх зүйд хамааралгүй.

Хоёрдугаарт, lex mercatoria нь олон улсын худалдааны арбитраас өөр арбитраг хэрэглэгддэг эсэх гэсэн асуулт гарч ирнэ. Онолын хувьд зөвхөн худалдааны арбитраг хэрэглэгдэнэ гэсэн хатуу зарчим байхгүй бөгөөд практикт өөр төрлийн арбитраг хэрэглэх шаардлага барагтаа үүсдэггүй.

Гуравдугаарт, lex mercatoria хаанаас үүсдэг вэ? гэх асуулт ургана. Судлаач Henry Campbell Black “lex mercatoria гэдэг нь худалдагч болон худалдаачнаар хүлээн зөвшөөрөгдөж, батлагдсан нийтэд тогтсон хэв журам, заншлын эрх зүй болон дүрэм журмын систем ...” гэж үзсэн<sup>10</sup>. Худалдааны гол төлөөлөгчид нь худалдаачин, худалдагч гэж үзсэн бөгөөд тэд өөрийн барааг зарахын тулд худалдааны арга барилаа хөгжүүлэх нь худалдагч, худалдан авагч нь төлбөр төлөх арга хэлбэрээ өөрчилж байгаа lex mercatoria-н хөгжил явагддагтай холбоотой. Мөн энэ талаар судлаач Bryan A.Garner “худалдаачнаас гадна далайчид lex mercatoria-н хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулдаг” гэж үзсэн<sup>11</sup>. Энэ нь дундад зууны үед Европчууд далайн тэврээр худалдаа хийж байсантай холбоотой. Тэгэхээр lex mercatoria-г хөгжүүлдэг гол субъект нь зөвхөн олон улсын худалдааны харилцаанд оролцогч хувь этгээдүүд бүтээдэг болж таарч байна.

Дөрөвдүгээрт, lex mercatoria нь заншлын эрх зүй, эрх зүйн зарчмын нэг хэсэг мөн үү? гэдэг асуулт урган гарч ирж байна. Судлаач Henry Campbell Black-н дээрх тодорхойлолтоос үзвэл “lex mercatoria нь заншлын эрх зүй, эрх зүйн онолоос гадна нийтэд тогтсон хэв журам”

<sup>8</sup> С.Нарангэрэл, “Эрх зүйн эх сурвалж толь бичиг/Dictionary of Law- анхны хэвлэл”, 2007, УБ., 542 дахь тал.

<sup>9</sup> Oxford-н толь бичиг <https://opil.oup.com/view/10.1093/law:epil/9780199231690/law-9780199231690-e1534>

<sup>10</sup> Henry Campbell Black, “Black’s Law Dictionary”, 1968, Washington., 1138 дахь тал.

<sup>11</sup> Bryan A.Garner, “A dictionary of Modern Legal Usage:second edition”,

гэж үзсэнээрээ ялгаатай байна<sup>12</sup>. Миний хувьд, *lex mercatoria* нь эрх зүйн онол болон нийтэд тогтсон хэв журмын алинд ч багтахгүй гэж үзэж байна. Учир нь Италийн нэрт эрдэмтэн Guido Alpa “эрх зүйн зарчим нь хүмүүсийн харилцааны хэм хэмжээний хийсвэр зүйл” гэж үзсэн<sup>13</sup>. Гэтэл *lex mercatoria* нь бодит амьдралаас бий болж, бодитой зүйл тул хийсвэр зүйлд оруулах зохимжгүй. АНУ-ын эрдэмтэн William Hoffman-н үзсэнээр “нийтэд тогтсон хэв журам нь гэрээг хууль зүйн талаас тайлбарлахтай холбоотой ойлголт бол заншлын эрх зүй нь үндсэн стандарт хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хууль зүйн хариуцлага тооцох дүрэм журмын тухай ойлголт” гэж үзсэн<sup>14</sup>. Тэгэхээр *lex mercatoria* зөрчигдсөн тохиолдолд түүнд хууль зүйн үүднээс хариуцлага тооцох боломжтой байдаг тул заншлын эрх зүйн нэг хэсэг ба эрх зүйн зарчим, нийтэд тогтсон хэв журмын тухай ойлголт биш гэж үзэж байна.

Харин Монгол Улсад хэрхэн авч үздэг талаар харья. Академич С.Нарангэрэл “худалдааны эрх зүй гэдэг нь гадаадын олон улс оронд худалдаа ба ер нь аж ахуйн үйл ажиллагааг зохицуулдаг иргэний эрх зүйгээр нөхцөлдүүлсэн салбар бөгөөд хувийн эрх зүйн хэм хэмжээ нь худалдааны эргэлт, гүйлгээний хэмжээ хязгаарын хүрээнд үүсдэг нөхцөл байдалд хамаарах заалт” гэж тодорхойлсон<sup>15</sup>. Үүнээс үзвэл худалдааны эрх зүй гэдэг нь нэгдүгээрт, зөвхөн иргэний эрх зүйн ойлголт бөгөөд бусад салбар эрх зүйн ойлголтод хамаардаггүй, хоёрдугаарт хувийн эрх зүйн хэм хэмжээ гэсэн нь худалдааны эргэлт, гүйлгээний хэмжээ хязгаараас үүсдэг хууль тогтоомж, заншлын эрх зүй, эрх зүйн онол болоод шүүхийн практикийг багтааж байна гэж ойлгогдож байна. Тэгэхээр уг ойлголтыг олон улс оронтой харьцуулахад илүү өргөн хүрээнд авч үздэг болж таарч байна. Нөгөө талаараа судлаач Б.Тамир нь “*lex mercatoria* гэдэг нь худалдаачны заншлын эрх зүйг хэрэглэх явдал юм” гэж тодорхойлсон<sup>16</sup>. Тус тодорхойлолтоос харвал *lex mercatoria*-г зөвхөн заншлын эрх зүйд багтааснаараа ялгаатай байна.

Эцэст нь дүгнэхэд, *lex mercatoria* гэдэг нь олон улс хоорондын худалдааны практикаас үүсэж, худалдаачдын зуршлаар хүлээн зөвшөөрөгдөж батлагддаг олон улсын худалдааны арбитраг эх сурвалж болдог худалдааны заншлын эрх зүй юм.

### 3. *Lex mercatoria*-н эрх зүйн тогтолцоо

*lex mercatoria* нь худалдааны харилцаанд анхдагч эх сурвалж болохынхоо хувьд худалдааны эрх зүйн маргаанд олон улсын конвенц, хууль, дүрэм журмаар зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхэд эх сурвалж болдгоороо арбитраг ихээхэн ач холбогдолтой бөгөөд *lex mercatoria*-г дараах 3-н хандлагаар авч үздэг. Үүнд:

1. *Lex mercatoria* бол бие даасан эрх зүй
2. *Lex mercatoria* бол дүрэм журмын багц
3. *Lex mercatoria* бол хууль

#### *Lex mercatoria* бол бие даасан эрх зүй

Уг хандлагын гол төлөөлөгчдөөр Б.Голдман, К.Шмиттгроф, А.Голдштейн зэрэг эрдэмтэд багтдаг. Б.Голдман нь өөрийн дурдсан ишлэлдээ “худалдааны арбитраг хэргийг шийдвэрлэхдээ талуудын гэрээнд дурдсан холбогдох үндэсний хууль, дүрэм журмаар бус *lex mercatorio*-аар зохицуулах боломжтой” гэж дүгнэсэн. Учир нь *lex mercatoria*-н эх сурвалж нь бичмэл хууль, дүрэм журам биш бөгөөд олон улсын худалдаа, эдийн засгийн харилцаанд оролцогч талуудын сайн дурын үндсэн дээр бий болдог тул үндэсний хууль

<sup>12</sup> Henry Campbell Black, “Black’s Law Dictionary”, 1968, Washington., 1138 дахь тал.

<sup>13</sup> Guido Alpa “General Principles of Law” 1-3 дахь тал <https://digitalcommons.law.ggu.edu/cgi/viewcontent.cgi?article=1001&context=annlsurvey>

<sup>14</sup> William Hoffman “On the use and abuse of custom and usage in reinsurance contracts”, 9-11 дэх тал [https://www.jstor.org/stable/25763200?read-now=1&seq=11#page\\_scan\\_tab\\_contents](https://www.jstor.org/stable/25763200?read-now=1&seq=11#page_scan_tab_contents)

<sup>15</sup> С.Нарангэрэл, “Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг”, 2015, УБ., 525 дахь тал.

<sup>16</sup> Б.Тамир, “Олон улсын хувийн эрх зүй”, 2019, УБ., 149 дэх тал.

тогтоомжоос хамааралгүй бие даасан эрх зүйн систем гэж үздэг<sup>1718</sup>.

#### Lex mercatoria бол дүрэм журмын багц

Уг хандлагын гол төлөөлөгч нь А.Лоунфельд бөгөөд lex mercatoria нь олон улсын худалдааны харилцаанд оролцогчдын маргааныг бүхэлд нь зохицуулах боломжгүй. Харин худалдааны арбитр маргааныг шийдвэрлэхдээ гэрээнд тусгасан хууль тогтоомжоор шийдвэрлэх нь зөв. Хэрэв хууль тогтоомжоор шийдвэрлэх боломжгүй тохиолдолд үндэсний хууль тогтоомжийг орлуулах дүрэм журам байх ёстой гэж үздэг.

#### Lex mercatoria бол хууль

Энэ хандлага нь lex mercatoria-г бүхэлд нь үгүйсгэдэг. Өөрөөр хэлбэл, lex mercatoria нь олон улсын худалдааны харилцаанд оролцогчдын сайн дурын үндсэн дээр үүсдэг заншил, нийтэд тогтсон хэв журмын аль нь ч биш бөгөөд ийм зүйлээр худалдааны арбитр маргааныг шийдвэрлэх боломжгүй. Харин lex mercatoria-н эх сурвалж нь гэрээнд тусгасан үндэсний хууль тогтоомж юм гэж номлодог бөгөөд энэ утгаараа хууль болно<sup>1920</sup>.

Тус 3 онолууд нь lex mercatoria-н эх сурвалжийг аль талаас нь авч үзсэнээс шалтгаалан бие даасан, үндэсний хууль тогтоомжийн бүрэлдэхүүн, эсхүл бүрэн үгүйсгэсэн байна. Миний хувьд lex mercatoria нь “бие даасан эрх зүй” гэж авч үзсэн онолыг дэмжиж байна. Учир нь lex mercatoria нь олон улсын худалдааны харилцаанд оролцогчдоос үүсэж бий болдог. Үүнд ямар нэг төр засаг ордоггүй тул бие даасан эрх зүй гэж үзэх боломжтой.

#### **4. Lex mercatoria-н илрэх хэлбэр**

Заншлын эрх зүй нь бичмэл болон аман /бичгэн бус/ гэсэн 2 хэлбэртэй<sup>21</sup>. Хуучин цаг үед заншлын эрх зүй нь илүүтэй аман хэлбэрээр оршдог байсан. Жишээлбэл, дипломат төлөөлөгчийн газар халдашгүй байх, нээлттэй далайд бүх улс зорчих эрхтэй байх зэрэг асуудал байж болно. Дэлхий дахин даяаршихын зэрэгцээ улс орнууд хоорондоо худалдаа, арилжаа их хийх сонирхол ихсэж, түүнийг дагаад худалдаа наймааны салбар өргөжин тэлснээр<sup>22</sup> lex mercatoria хурдацтай хөгжиж байсан. Бичгэн бус хэлбэр нь талуудад ойлгомжгүй байдлыг бий болгож, учир дутагдалтай байсан тул нэг мөр ойлголтыг бий болгох зорилгоор бичгэн хэлбэрт орчин үед шилжүүлсээр байна. Үүний тод жишээ нь ЮНСИТРАЛ-ын загвар хуулиуд, ИНКОТЕРМС, УНИДРУА-н олон улсын худалдааны гэрээний зарчим багтана зэрэг багтана.

#### ЮНСИТРАЛ-н загвар хууль

Олон улсын худалдааны харилцааг зохицуулах үндэсний хууль тогтоомжууд хоорондоо зөрчилдөх, эрх зүйн хийдэлтэй байх зэрэг тэнд олон бэрхшээл байсан. Үүний улмаас улс хоорондын худалдааны харилцааг зохицуулах үүднээс олон улсын түвшинд нэгдсэн нэг стандарт, дүрэм журмыг бий болгох, улс хоорондын худалдааны арбитрын хуулийг ижилтгэх, уялдуулах, худалдааны арбитрын онцлогийг гаргах, нөгөөтээгүүр улс орнуудын худалдааны арбитрын тухай хуулийг сайжруулах, олон улсын худалдааны харилцааг зохицуулах арбитрын тухай хуулийг шинээр батлахад улс орнуудад жишиг болгох зорилгоор 1985 онд НУБ-ын Ерөнхий Ассемблей ЮНСИТРАЛ-ын худалдааны

<sup>17</sup> Mert Elcin, “Lex Mercatoria in international arbitration theory and practice Volume 1”, 2012, Florence., 30-49 дэх тал.

<sup>18</sup> “Ученые заметки ТОГУ” 2014, Том 5, №4, 879-886 дахь тал, Н.П.Зарубина, Н.О.Пустельникова, “Lex mercatoria как внешнегосударственное регулирование трансграничных сделок” нийтлэл, 204, 880 дахь тал.

<sup>19</sup> Максим Панасенко, “Возможность выбора ненационального права: lex mercatoria” нийтлэл, 1 дэх тал [https://elib.bsu.by/bitstream/123456789/29366/1/2001\\_3\\_JILIR\\_panasenko\\_r.pdf](https://elib.bsu.by/bitstream/123456789/29366/1/2001_3_JILIR_panasenko_r.pdf)

<sup>20</sup> “Ученые заметки ТОГУ” 2014, Том 5, №4, 879-886 дахь тал, Н.П.Зарубина, Н.О.Пустельникова, “Lex mercatoria как внешнегосударственное регулирование трансграничных сделок” нийтлэл, 204, 880 дахь тал.

<sup>21</sup> С.Нарангэрэл, “Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг: анхны хэвлэл”, 2021, УБ., 148 дахь тал.

<sup>22</sup> МУИС-ийн Хууль зүйн сургууль, “Эрх зүйн дээд боловсрол ба хууль зүйн шинжлэх ухаан”, 2021, УБ., 150-151 дэх тал, М.Уянга, “Монгол Улсын эрх зүйн тогтолцоо дахь олон улсын заншлын хэм хэмжээ ба түүний практик хэрэглээ”

арбитрын загвар хуулийг хүлээн зөвшөөрч, баталсан<sup>2324</sup>.

### ИНКОТЕРМС

1923 онд олон улсын бизнесийн байгууллага олон улсын худалдааны нэг стандартыг бий болгоход тус дөхөм үзүүлэх зорилгоор ICC-г баталсан. Анх 2000 онд олон улсын худалдааны FAS, DEQ төрөлд худалдааны эрх зүйд нийтлэг ашиглагддаг заншлыг дагаж мөрдөхийг тусгаснаар *lex mercatoria*-г олон төрөлд дагаж мөрдөхийг зөвшөөрсөн.<sup>25</sup> Тус нөхцөл нь олон улсын тээвэрлэлттэй холбоотой харилцааг зохицуулахад гол анхаарлаа өгдөг бөгөөд худалдагчаас худалдан авагчид барааг тээвэрлэх эрсдэл, зардлыг хариуцах талыг тодорхой болгох, эд хөрөнгийн даатгал, талуудын эрх, үүргийг тодорхойлоход оршино<sup>26</sup>.

### УНИДРУА-н олон улсын арилжааны гэрээний зарчим

УНИДРУА-н олон улсын арилжааны гэрээний зарчмын 1 дүгээр зүйлийн 1.9 дэх хэсэгт зааснаар “... талууд харилцан тохиролцсон худалдааны зан заншил болон гэдгээрийн хооронд тогтсон ажил хэргийн ёсыг баримтална. Талууд худалдааны зан заншил хэрэглэгдэхгүй худалдааны харилцаанаас бусад олон улсын худалдааны харилцаанд тогтмол дагаж мөрддөг буюу бүх нийтийн мэдэх худалдааны зан заншлыг дагаж мөрдөнө” гэж заасан байдаг бөгөөд тус заалт *lex mercatoria*-н гол эх сурвалж болдог. Тус зарчмын гол зорилго нь худалдааны гэрээний нийтлэг загварыг бий болгоход оршино.

### **5. *Lex mercatoria*-н талаарх гадаад улс орнуудын жишиг, Монгол Улс**

Энэхүү хэсэгт *lex mercatoria*-н талаар олон улс орнууд хэрхэн хуульд тусгасан талаар авч үзье. Жишээлбэл:

- ХБНГУ-ын Арбитрын тухай хуулийн 1051 дүгээр зүйлийн 1051.4 дэх хэсэгт зааснаар “... бүх тохиолдолд арбитр гэрээнд заасан нөхцөлөөр хэргийг шийдвэрлэх ба арилжаанд холбогдох худалдааны нийтэд тогтсон хэв журмыг хэрэглэх боломжтой” гэж заасан.
- БНФУ-ын Арбитрын тухай хуулийн 1511 дүгээр зүйлд зааснаар “...арбитр талуудын сонгосон эрх зүйд нийцсэн хуулийг хэрэглэж хэргийг шийдвэрлэх бөгөөд хэрэв талууд хэрэглэх хуулийг заагаагүй бол тохиромжтой гэж үзсэн эрх зүйд нийцсэн хуулийг хэрэглэнэ. Зарим тохиолдолд арбитр хэрэгт худалдааны нийтэд тогтсон хэв журмыг ашиглаж болно” гэж заасан.
- Япон Улсын Арбитрын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт “арбитрт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний хэргийн маргаантай холбоотой гэрээнд тусгасан нөхцөлийн дагуу хэргийг шийдвэрлэх бөгөөд тухайн хэрэгт холбоотой бол нийтэд тогтсон хэв журмыг хэрэглэх боломжтой” гэж заасан.
- ОХУ-ын Арбитрын процессын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт зааснаар “... арбитр холбооны улсын хууль тогтоомжид нийцсэн бизнесийн харилцаанд тогтсон заншлыг хэрэглэнэ” гэж заасан.

Дээрх улс орнуудын жишгээс харахад ХБНГУ, БНФУ болон Япон Улсуудын хуульд зааснаар “*trade usage*, *эсхүл usage of trade*” гэдэг үгийг хэрэглэсэн. Үүнээс үзвэл ихэнх улс орнууд хууль тогтоомждоо “заншил” гэдэг үгийн оронд “нийтэд тогтсон хэв журам” /*usage* гэдэг монгол хэл рүү олон янзаар орчуулдаг бөгөөд миний хувьд “нийтэд тогтсон дэг журам” гэдэг үгээр хэрэглэсэн/ гэдэг үгийг хэрэглэсэн ба талуудын маргааныг шийдвэрлэхэд хоёрдогч эх сурвалжаар тусгажээ.

<sup>23</sup> Debra Venter, “The UNCITRAL Model Law on International Commercial Arbitration as basis for International and Domestic Arbitration in South Africa”, 2010, 25-30 дахь тал.

<sup>24</sup> “UNCITRAL Model Law on International Commercial Arbitration (1985), with amendments as adopted in 2006” [https://uncitral.un.org/en/texts/arbitration/modellaw/commercial\\_arbitration](https://uncitral.un.org/en/texts/arbitration/modellaw/commercial_arbitration)

<sup>25</sup> “INCOTERMS rules history” нийтлэл <https://iccwbo.org/resources-for-business/incoterms-rules/incoterms-rules-history/>

<sup>26</sup> David Soler, “Practical guide to the rules Incoterms 2020 Rights and obligations on the goods in international trade”, 2022, 19-31 дэх тал.

Нийтэд тогтсон хэв журам нь хууль зүйн утгаараа нийт ард түмэн, эсхүл үндэстэнд тогтсон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зохистой үйлдлийн цогц ойлголт юм. Заншил гэдэг нь тогтсон хуулиар батлагддаг практик бөгөөд стандарт норм, хэм хэмжээний тухай ойлголт гэж тодорхойлжээ. Мөн судлаач William Hoffman нь заншил нь нийтэд тогтсон хэв журмыг нөхөх боломжгүй талаар дурджээ. Тодруулбал, заншил нь заншлын эрх зүй болон бүс нутгийн заншилтай холбоотой. Бүс нутгийн заншил нь нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх тохиолдол байдаг бөгөөд уг тохиолдолд арбитр шийдвэр гаргахдаа нийтэд тогтсон хэв журмыг харгалзаж шийдвэрээ гаргавал арбитрын шийдвэрээс улбаалан нийтийн ашиг сонирхол хөндөгдөхгүй гэж үзжээ.<sup>27</sup>

Харин ОХУ-ын хувьд “бизнесийн харилцаан дахь заншил” гэснээрээ бусад улсуудаас ялгаатай байна. Судлаач Joseph R.Nolan, Jacqueline M.Nolan-Haley нарын үзсэнээр “бизнес гэдэг нь амь залгуулах, давуу тал бий болгох болон ашиг олох зорилготой мэргэжил, ажил эрхлэлт болон худалдааны үйл ажиллагаа” гэсэн<sup>28</sup>. Харин “худалдаа гэдэг нь янз бүрийн бүтээгдэхүүн, бараа, хэрэгцээний зүйлийг солилцох, худалдах, худалдан авах үйл ажиллагаа” гэсэн<sup>29</sup>. Үүнээс харвал бизнес гэдэг нь худалдааг өөртөө багтаасан бөгөөд худалдааны ойлголттой харьцуулахад илүү өргөн хүрээний ойлголт болж таарч байна. ОХУ-ын хуулийн заалтыг харвал *lex mercatoria*-г худалдаанаас гадна бизнесийн хүрээнд ашиглах боломжийг олгосон нь худалдааны зан заншлын учир утгыг нь алдагдуулсан гэж харж байна.

Монгол Улсын Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсэгт зааснаар “Арбитрын бүрэлдэхүүн талуудын хооронд байгуулсан гэрээний нөхцөлд үндэслэн тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзан маргааныг шийдвэрлэнэ” гэж заасан. Тус нэр томъёог харвал олон улсын гэрээ, конвенцын үгийг шууд хуулбарлан хэрэглэсэн байгаа ба энэ нь олон улсын конвенцын үгийг давтаж хэрэглэсэн шинжийг агуулсан. Уг нь эрх зүйн онолын үүднээс олон улсын конвенцод дотоодын хуулийг нийцүүлэх үүрэг хүлээснээс хуулбарлах үүрэг хүлээгээгүй ба түүнийг дэлгэрүүлэн хуульд тусгаж болдог.

Иймд Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсэгт “худалдааны зан заншил” гэдгийг “худалдааны нийтэд тогтсон хэв журам” гэдэг үгээр орлуулбал тохиромжтой. Учир нь олон улсын жишгийн үндсэн дээр “худалдааны нийтэд тогтсон хэв журам” гэдэг үгээр орлуулбал арбитрын шийдвэр нийтийн ашиг сонирхол, нийтийн дэг журмыг хөндөхгүй байх эрх зүйн баталгаа болох юм.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Хамгийн анх Ромын эзэнт гүрний үед *ius gentium*-г баталснаар худалдааны харилцаанд гадаадын иргэдийн эрх тэгш байдлыг хангаж эхэлсэн. Улмаар улс орнуудын худалдаа арилжаа өргөжин тэлэхийн хирээр худалдааны соёл, практик бүс нутгийн онцлогоос хамааран өөр өөрөөр хөгжиж байсан. Хэдий худалдааны соёл, практик өөр өөрөөр хөгжиж байсан ч түүнээс үл хамааран түүнийг *lex mercatoria* гэж нэрлэдэг. Олон судлаачдын үзэж байгаагаар *lex mercatoria* нь дундад зууны үеэс эхлэн жинхэнэ утгаараа бүрэлдэж эхлэн, 17-18 дугаар зууны үед БНФУ, ХБНГУ зэрэг улсууд энэ талаарх ойлголтыг нэг мөр болгох үүднээс дотооддоо хуульчилж, онолын түвшинд системчилсэн нь эдгээр улсууд гол төлөөлөл болсон ба судлаач Ralf Michaels нь *lex mercatoria*-н хөгжлийг 3-н үе шатанд авч үзсэн.

<sup>27</sup> American Bar Association, “Tort&Insurance Law Journal”, Vol 33, No.1, 1-80 дахь тал.

<sup>28</sup> Joseph R.Nolan, Jacqueline M.Nolan-Haley, “Black’s Law Dictionary”, 1990, USA, 198-199 дэх тал.

<sup>29</sup> Joseph R.Nolan, Jacqueline M.Nolan-Haley, “Black’s Law Dictionary”, 1990, USA, 269 дэх тал.

Lex mercatoria гэдэг нь худалдааны эрх зүй гэсэн утгатай латин гаралтай үг ба дэлгэрүүлэн авч үзвэл, худалдаачдын өдөр тутмын худалдааны амьдралаас үүсэж, хөгжин олон улсын худалдааны арбитрт маргааныг шийдвэрлэхэд эх сурвалж болдог худалдааны зан заншил юм. Үүнээс үзвэл lex mercatoria нь аль нэг хууль тогтоогчийн баталсан хууль тогтоомжоос үүсдэггүй тул бие даасан эрх зүй юм. Орчин цагийн үед lex mercatoria-г дэлхий нийтэд нэгдсэн нэг ойлголтыг төрүүлэхийн тулд худалдааны зан заншлыг бичгэн хэлбэрт оруулж байна. Жишээлбэл, УНИДРУА, ИНКОТЕРМС, ЮНСИТРАЛ-ын загвар хуулийг нэрлэж болно.

Олон улсын жишгээс харвал Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсэгт зааснаар “худалдааны зан заншил” гэдэг үгийг “худалдааны нийтэд тогтсон хэв журам” гэдэг үгээр орлуулбал илүү зохимжтой. Учир нь олон улсын гэрээ конвенцод заасан “заншлын эрх зүй” гэдэг үгийг давтан хэрэглэх нь практикт ач холбогдолгүй бөгөөд худалдааны нийтэд тогтсон хэв журам гэдэг үгээр орлуулбал олон улсын гэрээ, конвенцын санааг дэлгэрүүлэн хэрэглэж байгаа арбитрын шийдвэр нийтийн ашиг сонирхол, нийтийн дэг журмыг хөндөхгүй байх баталгаа болно.

## APPLICATION OF LEX MERCATORIA IN COMMERCIAL ARBITRATION: SOME THEORETICAL ISSUES

*Nyamjargal Munkhbaatar /LL.B/  
Assistant of the dean of School of Law, NUM*

### ABSTRACT:

According to the popular trend of the 21<sup>st</sup>-century globalizing world, the government and individuals of Mongolia interact with foreign countries in various ways, such as cooperation and trade in many fields such as health, education, and science. Interest in settling disputes through international arbitration is increasing not only in Mongolia but worldwide. However, Mongolia cannot adequately protect its country's interests in international arbitration. For example, the government of Mongolia appealed to international arbitration for the special oil exploration license of the Canadian-invested company Khan Resources, and according to the arbitration decision, the government of Mongolia agreed to pay 106 million US dollars together with the income that the company should have earned and its debts. In addition, disputes such as “Altan Dornod Mongolia” and “Alstom Power” can be mentioned. And if you look at the international arbitration that resolved the dispute, there is the London arbitration. The Anglo-Saxon legal community places great importance on the customs and practices of the society in addition to the provisions of the contract and law. According to this, it is possible to lose in international arbitration due to the weak concept of customary law in Mongolia, or more specifically, the legal concept of commercial custom. Therefore, this article aims to provide information on the legal content of commercial customs, its understanding, and importance, how it is used in arbitration, and how it is reflected in law.

### KEYWORDS:

Custom, international arbitration, trade, public order, lex mercatoria, law, regulation, UNCITRAL, INCOTERMS, UNIDROIT, ius gentium



## ЭХ СУРВАЛЖ

### Монгол эх сурвалж

1. Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй, 2019
2. С.Должин, Хувийн эрх зүйн тайлбар толь бичиг
3. Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, Арилжааны эрх зүй
4. С.Нарангэрэл, Эрх зүйн эх сурвалж толь бичиг/Dictionary of Law- анхны хэвлэл
5. С.Нарангэрэл, Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг

### Гадаад эх сурвалж

1. William Mitchell, An Essay on the early history of the law merchant: Being the Yorke Prize
2. Indiana University Press, "Indiana Journal of Global Legal studies- Vol.14, No.2
3. Henry Campbell Black, Black's Law Dictionary
4. Bryan A.Garner, A Dictionary of Modern Legal Usage: second edition
5. William Hoffman's On the use and abuse of custom and usage in reinsurance contracts
6. Mert Elcin, Lex Mercatoria in international arbitration theory and practice Volume 1
7. Debra Venter, The UNCITRAL Model Law on International Commercial Arbitration as basis for International and Domestic Arbitration in South Africa
8. David Soler, Practical guide to the rules Incoterms 2020 Rights and obligations on the goods in international trade
9. American Bar Association, Tort & Insurance Law Journal, Vol 33, No.1
10. Joseph R.Nolan, Jacqueline M.Nolan-Haley, Black's Law Dictionary
11. "Ученые заметки ТОГУ" 2014, Том 5, №4
12. Максим Панасенко, "Возможность выбора ненационального права: lex mercatoria"

### Цахим эх сурвалж

1. [https://www.mongolbank.mn/documents/sudalгаа/Tovhimol\\_14\\_13.pdf](https://www.mongolbank.mn/documents/sudalгаа/Tovhimol_14_13.pdf) Монгол Банк "Экспортын бараа бүтээгдэхүүний тээврийн зардлын судалгаа", 2018 он, 6 дахь тал
2. <http://eagle.mn/r/40428> "Арбитр-т ялагдсан ХОЁР тохиолдол" нийтлэл
3. <https://www.24tsag.mn/a/74424> "100 сая ам.долларын өр: Монголын Засгийн газар болон улсын арбитрын шүүхэд яагаад ялагдав" нийтлэл
4. <https://opil.oupilaw.com/view/10.1093/law:epil/9780199231690/law-9780199231690-e1534>
5. <https://digitalcommons.law.ggu.edu/cgi/viewcontent.cgi?article=1001&context=annlsurvey> Guido Alpa "General Principles of Law" 1-3 дахь тал
6. [https://www.jstor.org/stable/25763200?readnow=1&seq=11#page\\_scan\\_tab\\_contents](https://www.jstor.org/stable/25763200?readnow=1&seq=11#page_scan_tab_contents) William Hoffman "On the use and abuse of custom and usage in reinsurance contracts", 9-11 дэх тал
7. [https://elib.bsu.by/bitstream/123456789/29366/1/2001\\_3\\_JILIR\\_panasenko\\_r.pdf](https://elib.bsu.by/bitstream/123456789/29366/1/2001_3_JILIR_panasenko_r.pdf) Максим Панасенко, "Возможность выбора ненационального права: lex mercatoria" нийтлэл, 1 дэх тал
8. [https://uncitral.un.org/en/texts/arbitration/modellaw/commercial\\_arbitration](https://uncitral.un.org/en/texts/arbitration/modellaw/commercial_arbitration) "UNCITRAL Model Law on International Commercial Arbitration (1985), with amendments as adopted in 2006
9. <https://iccwbo.org/resources-for-business/incoterms-rules/incoterms-rules-history/> "INCOTERMS rules history" нийтлэл

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЭРХ ЗҮЙН ХӨГЖИЛД ҮР НӨЛӨӨ БҮХИЙ ШИЙДВЭР ГАРГАХ ЧИГ ҮҮРЭГ БА ТҮҮНИЙ УЧИР ХОЛБОГДОЛ, ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



*Р.Оюундэлгэр  
Судлаач*

### ТОВЧЛОЛ:

Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэсний дотор 50.1.2 дахь хэсэгт “... хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх”, 50.1.4 дэх хэсэгт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” гэж тус тус заасан. Ийнхүү зохицуулсан нь Монгол Улсын Дээд шүүх хяналтын журмаар эрх зүйн маргааныг хянан хэлэлцэх замаар<sup>1</sup> нэг талаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээх, нөгөө талаар шүүхийн дээд байгууллага болохын хувьд хэрэг маргаан шийдвэрлэсэн тогтоол, албан ёсны тайлбараараа дамжуулан шүүхийн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах чиг үүрэгтэй болохыг Үндсэн хуулиар баталгаажуулжээ.

2021 онд батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь хэсэгт Дээд шүүхийн зорилгыг “хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах” гээд, түүнтэй холбогдуулан хяналтын журмаар гомдол гаргах “1) анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, 2) шүүх хуулийг улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр хэрэглэсэн, 3) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн” зэрэг үндэслэлийг хуульчилсан. Мөн тэдгээрийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар тусгасан.

Энэхүү судалгааны ажилд, Дээд шүүхийн Үндсэн хуульчлагдсан үүрэг, түүний онолын үзэл баримтлалыг хөндөж, 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулиар зохицуулсан Дээд шүүхийн зорилго, чиг үүрэг болон хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлүүд нь Дээд шүүхийн хуулийг хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах чиг үүргийг орхигдуулсан эсэх асуудлыг дэвшүүлнэ. Харьцуулсан судалгааны хэсэгт эх газрын эрх зүйн бүлийн томоохон төлөөлөгчид болох Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Австри Улс болон Бүгд Найрамдах Солонгос Улсуудын зохицуулалтыг харьцуулан, судалгааны дүгнэлт саналаа хүргүүлжээ.

<sup>1</sup> Б.Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал (Илтгэл, өгүүлэл, ярилцлага, дурсамж)*, УБ., 2002, 116 дахь тал

## ТҮЛХҮҮР ҮГС:

Дээд шүүхийн Үндсэн хуульчлагдсан үүрэг, Хуулийн нэгдмэл байдал, Хуулийг хөгжүүлэх, Гомдлын хязгаарлалт, Гомдол гаргах үндэслэл, Сонгох шалгуур, Шүүхийн активизм, Хууль тайлбарлах, Динамик тайлбар, Статик тайлбар

## УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын дээд шүүхийг “шүүхийн дээд байгууллага мөн” бөгөөд “хяналтын журмаар хянан үзэх”, “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” бүрэн эрхтэй гэж заасан. Онолын үүднээс Дээд шүүх хэрэг хянан шийдвэрлэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж,<sup>2</sup> хуулийг хөгжүүлэх буюу эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын хувьд 2021 онд батлагдсан Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь хэсэгт анх удаа Дээд шүүхийн зорилгыг “хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах” хэмээн зохицуулж, түүнд нийцсэн хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлүүдийг хуульчилсан. Гэвч Дээд шүүхийн “хуулийг хөгжүүлэх” буюу эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах, хуулийг боловсронгуй болгох чухал чиг үүргийг зохицуулаагүй орхигдуулсан бөгөөд тийнхүү хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлийг хуульчлаагүй байна. Иймээс энэхүү судалгааны ажилд, Дээд шүүхийн хуулийг хөгжүүлэх чиг үүргийг хуульчлаагүй буюу түүнтэй холбогдох хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл бүхий зохицуулалт байхгүй нь (1) Дээд шүүхийн эрх зүйг хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах боломж, (2) шүүхэд хандах эрх, (3) дээд шүүхийн хууль тайлбарлах эрхийг тус тус хязгаарласан зэрэгт асуудал дэвшүүлэх болно.

## ҮНДСЭН ХЭСЭГ

### I. ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Шүүх нь нийгэмд болсон маргаан зөрчилдөөнийг хянан үзэж, түүнд хуулийн мэргэжлийн үүднээс тайлбарлан хэрэглэж эрх зүйн шийдэл гаргадаг.<sup>3</sup> Шүүх оршдог, шүүхийн гол гавьяа нь үзэл санааны зөрөө гарах үед түүнээс зайлсхийх боломж олгох юм. Ноцтой асуудал үүсэхэд шүүх нь урд өмнө огт боломжгүй гэж үзэж байсан тэр чиглэлд анхны алхам хийх шаардлагатай болдог. Энэ механизм нь нийгмийн дэг журам, амгалан тайван байдлыг тогтооход зайлшгүй шаардлагатай.<sup>4</sup>

#### 1.1. Монгол Улсын Дээд шүүх шүүхийн дээд байгууллага болох нь

Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн” хэмээн заасан. Өмнө нь Улсын шүүн таслах дээд газар нь нийтлэг байдлаар “Бүгд гишүүдийн хурал” хэмээх зохион байгуулалтаар аливаа асуудлыг шийдвэрлэх, бусад шүүн таслах газруудын хэргийг хянах, улмаар захиргааны дээд байгууллагын хувьд шууд удирдах байдлаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ирсэн.<sup>5</sup> Харин өдгөө онолын үүднээс шүүх эрх мэдлийн дээд байгууллага гэх Дээд шүүхийн онцлогийг хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, шүүхийн тогтолцоонд эрх зүйн ач холбогдолтой маргааныг шийдвэрлэх замаар хуулийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой<sup>6</sup> этгээд гэдэгтэй шууд холбож үздэг.

<sup>2</sup> Хуулийн нэгдмэл хэрэглээ гэдэг нь хууль ямар ч тохиолдол ижил, тэгш үйлчлэх тухай ойлголт юм. Эрх зүйт төрд хууль ижил, төстэй тохиолдолд өмнөх шийдвэрийн адил үйлчилж, иргэд хуулийн үр дагаврыг урьдчилж таамаглах боломжтой болно. Цаашлаад иргэдийн шүүхэд сударгаар шүүлгэх, шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг. [Source: Ottavia Dora Lo Sardo, *The role of Supreme Courts in the uniform application of law*, p86]

<sup>3</sup> Б.Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал (Илтгэл, өгүүлэл, ярилцлага, дурсамж)*, 118 дахь тал.

<sup>4</sup> Чикагийн их сургуулийн профессор Леви Эдвардын хэлсэн үг. [Ж.Амарсанаа нар, Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959-2010), Хоёр дахь хэвлэлт (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2015)] 37 дахь тал.

<sup>5</sup> А.Бямбажаргал, *Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ*, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2020 оны №4 дугаар, 115 дахь тал.

<sup>6</sup> Jelena Ristik, *The role of the Supreme Court in ensuring uniformity of court practice in the Republic of Macedonia*, 2017, p.61

### 1.2. Монгол Улсын Дээд шүүхийн хянан шийдвэрлэх чиг үүрэг

Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 50.1.2 дахь хэсэгт Дээд шүүхийн бүрэн эрхийг тусгахдаа “... хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх” гэж заасан. Дээд шүүх хяналтын журмаар гомдол хянан хэлэлцэхдээ бүх гомдлыг хэлбэрэлтгүй хүлээн авах бус тодорхой үндэслэл, шалгуурт нийцсэн гомдлыг хүлээн авдаг болж хөгжжээ.<sup>7</sup> Ач холбогдолтой гомдлыг сонгон хянаж, шийдвэрлэх боломжийг хяналтын шүүлтүүр (filteration to the appeal)-ээр бүрдүүлж өгдөг.<sup>8</sup> Иймд улс орнууд Дээд шүүхийнхээ зорилготой уялдуулан хяналтын журмаар гаргах гомдлын үндэслэлийг хуульчилдаг. Ийнхүү бүх гомдлыг хянан хэлэлцэх бус хязгаарлалт тогтоож, ач холбогдолтой<sup>9</sup> гэж үзсэн гомдлыг хүлээн авч буй механизмын гол зорилго нь Дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх зорилгыг хэрэгжүүлэхтэй салшгүй холбоотой.<sup>10</sup> Иймд Монгол Улсын Дээд шүүхийн хувьд (1) Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх<sup>11</sup> буюу (2) хувь хэргүүдийг шийдвэрлэсэн шийдвэрүүдээрээ улсынхаа нутаг дэвсгэрт хэргийн эрх зүйн туйлбартай байдал,<sup>12</sup> хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах хосолмол чиг үүргийг хэрэгжүүлэх субъект юм.

### 1.3. Монгол Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбар

Хуулийн тайлбар нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актын хамт эрх зүйн эх сурвалж болохын зэрэгцээ хуульчдын онолын мэдлэгийг дээшлүүлэх, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, хууль зүйн боловсролын агуулгад ихээхэн хувь нэмэр<sup>13</sup> болдог. Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 50.1.4 дэх хэсэгт Дээд шүүхийн бүрэн эрхийг “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” гэж хуульчилсан. Түүхэн хөгжлийн явцад Монгол Улсын Дээд шүүх норматив тайлбарыг хийж ирсэн<sup>14</sup> бол 2012 онд багтагдсан “Монгол Улсын Шүүхийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх хэсэгт зааснаар Улсын Дээд шүүх “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх замаар гаргах ...” бүрэн эрхийг олгосон. Энэ нь хуулийг хэрэглэх явцад бус, харин хэрэглэхээс нь өмнө угтан тайлбарлаж, эрх зүйн харилцааг боловсронгуй болгох бус, харин хууль тогтоох эрх мэдлийн “дутууг дүүргэж, дундуурыг гүйцээдэг” мини парламентын өнөөгийн чиг үүргээс татгалзах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.<sup>15</sup> Гэвч Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 3 дугаар дүгнэлт, 7 дугаар тогтоол<sup>16</sup> гарч “Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Улсын дээд шүүхээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлээд гаргасан шийдвэрийг хэрхэн албан ёсны тайлбар болох нөхцөл бүрэн, агуулгын хувьд зөрчилдсөн шийдвэр гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй болж” хэмээнээс үүдэн тус заалтыг хүчингүй болгосон юм.

<sup>7</sup> Р.Оюундэлгэр, *Улсын Дээд шүүхийн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүрэг ба хяналтын журмаар гаргах гомдолд хязгаарлалт тавих асуудал, түүний учир холбогдол*, Шүүх эрх мэдэл эмхэтгэл, 2021 оны №3 дугаар, 142 дахь тал.

<sup>8</sup> Европын холбооны гишүүн улсуудын Дээд шүүхэд хяналтын журмаар гаргах гомдолд тавигдах шүүлтүүрийг дараах загварууд (model of filtering appeals) байдаг. Үүнд (1) The leave-to-appeal system: Их Британи, Ирланд, Норвеги, Дани, Швед улсуудад Дээд шүүхэд хяналтын гомдлыг хүлээн авахдаа сонгох (pre-selection) буюу сонгон шалгаруулах (selection principle) зарчмыг баримталдаг. Ийнхүү нийтийн зорилгыг хангах (a matter of general importance or the interests of justice) Дээд шүүхээр зайлшгүй хэлэлцүүлэгдэх ёстой асуудлыг хийсвэр шалгуураар (abstract prevaia) дамжуулан сонгож авдаг. (2) Stricto sensu: Франц, Бельги, Нидерланд, Эстони, Испани, Грек, Италид байдаг ба хяналтын гомдлыг хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн тусгай хууль гаргах ёстой. (3) Mixed model- Аль алиных нь шинжийг агуулсан холимог загвар.

<sup>9</sup> Maarten Feteris (President of the Supreme Court of the Netherlands), *Development of the Law by Supreme Court in Europe*, Utrecht Law Review Volume 13, Issue 1, 2017, p156

<sup>10</sup> Arnfinn Bardsen (The Norwegian Supreme Court Justice), *Deciding what to decide: The filtering mechanism in the Norwegian Supreme Court*, 2018, p4

<sup>11</sup> Г.Совд, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*, УБ., 2000, 217 дахь тал.

<sup>12</sup> Мөнхсайхан, *Шүүхийн тухай хуулийн төслийн хүрээнд шүүхийн хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь*, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2020 оны №4 дугаар, 96 дахь тал.

<sup>13</sup> Ж.Амарсанаа нар, *Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959-2010)*, Хоёр дахь хэвлэлт (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2015), 37 дахь тал.

<sup>14</sup> А.Бямбажаргал, *Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ*, 121 дэх тал.

<sup>15</sup> Ж.Амарсанаа нар, *Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959-2010)*, 37 дахь тал.

<sup>16</sup> ҮХЦ-ийн тогтоол, *МУ-ын шүүхийн тухай хуулийн 17 зүйлийн 17.3.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэх тухай /Дугаар 07-2015.10.30/*

Улмаар 2021 оны Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэгт Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар хэрэгжүүлэх бүрэн эрх гэсний дотор 25.8.4 дахь хэсэгт *“шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх”* гэж зохицуулсан. Шүүхийн хууль хэрэглээний практикийг судлах замаар тайлбар хийх нь зарим талаар шүүх хууль тогтоогч байхаас урьдчилан сэргийлэх нөхцөлийн нэг<sup>17</sup> хэдий ч нөгөө талаар Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг нийт шүүгчдийн хуралдаанаар гаргадаг хууч хамаарлыг бүрэн халж чадаагүй байгааг энд онцлох нь зүйтэй. Учир нь Улсын дээд шүүх буюу хяналтын шатны шүүх зөвхөн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй<sup>18</sup> тул албан ёсны тайлбарыг тус үүргээс салагид хэрэгжүүлж болохгүй. Нөгөө талаар Дээд шүүх нь танхимд хуваагддаг улсуудад Дээд шүүхийн нийт шүүгчид хуралдах зохион байгуулалт бүхий тогтолцоо үгүй<sup>19</sup> юм.

## II. АСУУДАЛ ДЭВШҮҮЛЭХ НЬ

Судалгааны энэ хэсэгт Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25.7.5 дугаар зүйлд тусгагдсан Дээд шүүхийн зорилго болон хяналтын гомдол гаргах үндэслэлд асуудал дэвшүүлж, тэдгээр нь (1) Дээд шүүхийн хууль хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах боломж, (2) шүүхэд хандах эрх, (3) дээд шүүхийн хууль тайлбарлах эрхийг хязгаарласан эсэх асуудлыг тус тус авч үзлээ.

### **2.1. Дээд шүүхийн хуулийг хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах боломж**

Дээд шүүх нь зорилгоо хэрэгжүүлэхдээ нийтийн (public)<sup>20</sup> ба хувийн (private)<sup>21</sup> хосолмол үүргийг (dual role) гүйцэтгэдэг.<sup>22</sup> Өөрөөр хэлбэл, Дээд шүүх нь хэргийн оролцогчдын эрхийг тухайлсан тохиолдолд хамгаалахын зэрэгцээ хуулийн нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх гэсэн нийтийн зорилгыг хэрэгжүүлдэг парадигмтай<sup>23</sup> ба хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд удаах үүрэг давамгайлдаг<sup>24</sup> болох нь улс орнуудын хяналтын гомдол гаргах шүүлтүүрээс тодорхой харагдана.<sup>25</sup>

Монгол Улсын хувьд 2021 оны Шүүхийн тухай хуульд анх удаа Улсын Дээд шүүхийн зорилгыг *“хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах”* хэмээн зохицуулж, түүнд үйлчлэх хяналтын журмаар гомдол гаргах *“1) анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, 2) шүүх хуулийг улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр хэрэглэсэн, 3) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн”* зэрэг үндэслэлүүдийг хуульчилсан. Эдгээрээс *“Анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн”* болон *“Шүүх хуулийг улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр хэрэглэсэн”* гэсэн үндэслэлүүд нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгод хамааралтай<sup>26</sup> бол удаах үндэслэл нь хэргийн оролцогчдын зөрчигдсөн эрхийг сэргээх зорилготой<sup>27</sup> бөгөөд Дээд шүүхийн

<sup>17</sup> А.Бямбажаргал, *Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ*, 124 дэх тал.

<sup>18</sup> О.Мөнхсайхан, *Шүүхийн тухай хуулийн төслийн хүрээнд шүүхийн хараат бус, хариуцлагатай байдлыг хангах* нь, 90 дэх тал

<sup>19</sup> А.Бямбажаргал, *Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ*, 122 дахь тал.

<sup>20</sup> Дээд шүүх нь хувийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ зөвхөн тухайн хэргийн оролцогчдын хүрээнд л маргааныг таслан шийддэг, зөрчигдсөн эрхийг сэргээдэг тул тус шийдвэр нь ирээдүйд гарах нжил, төстэй маргаанд жишиг тогтоох, хуулийн хөгжилд хувь нэмэр оруулахад төдийлөн ач холбогдолгүй байдаг.

<sup>21</sup> Дээд шүүх шийдвэрээр дамжуулан шүүхийн тогтолцоонд жишиг тогтоож, хуулийн нэгдмэл байдлыг хангаж, хөгжүүлж байдаг.

<sup>22</sup> Right of access to Supreme Courts in Light of the Guarantees under Article 6.1 of the Convention on Human Rights and Fundamental Freedoms (civil aspect), Croatian International Relations Review - CIRR XXIV (81) 2018, p72 [цаашид *“Right of access to Supreme Courts”* гэх]

<sup>23</sup> *The paradigm shift: The “Leave to Appeal System” and Guidance and Developing Law as the Prevailing Tasks of the Supreme Court*, p.296

<sup>24</sup> *Uniform Application of Law and Promotion of its Development as a New Role of Supreme Courts*, 310

<sup>25</sup> Right of access to Supreme Courts, p73

<sup>26</sup> Р.Оюундэлгэр, *Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123.2 дахь заалтын хэрэгжих боломж ба хүндрэл* (Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангуулах тухай), Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2021 оны №4 дугаар, 6 дахь тал.

<sup>27</sup> Мөн тэнд



хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх зорилгод төдийлөн ач холбогдолгүй байна. Ийнхүү хэдийгээр хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах үндэслэлийг хуульчилсан боловч, хуулийг хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргахад түлхэц үзүүлэх үндэслэл хуульчлагдаагүй гэж үзэх үндэслэлтэй. Тодруулбал, тодорхой нэг хуулийн чухал асуудлыг Дээд шүүх анх удаа хянан хэлэлцэж жишиг тогтоох гэтэл түүнд Дээд шүүхийн тайлбар байхгүй гэдэг үндэслэлээр хяналтын журмаар гаргасан гомдол тус зөвшөөрөгдөхгүй байх үр дагавар гарч болзошгүй.

Европын холбооны гишүүд улсуудад Дээд шүүхийн чиг үүрэг ба хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл дараах онцлогтой байдаг.

№	Улс	Онцлог зохицуулалт
1	Австри Улс	Иргэний хэрэгт Дээд шүүх тухайн шийдвэр нь хууль хэрэглээний нэгдмэл, тогтвортой байдал, хуулийн хөгжилд чухал ач холбогдолтой гэж үзвэл гомдлыг хүлээн авдаг.
2	Дани Улс	Хяналтын гомдол зөвшөөрөх зөвлөлөөс тухайн хэрэг, маргааны суурь асуудлыг шалгуур болгодог. Шалгуурт нь Дээд шүүхээс тухайн маргаанаар дамжуулан хуулийн практикийг бий болгох, баталгаажуулах, өөрчлөх эсхүл засах шаардлагатай нөхцөл байдлыг тооцдог.
3	Финлянд Улс	Дээд шүүхэд гомдол зөвшөөрөх анхдагч шалгуур нь шүүхийн шийдвэр хуулийг адил, төсөөтэй тохиолдолд хэрэглэх боломжтой байх.
4	ХБНГУ	Шүүх шийдвэрээрээ дамжуулан хуулийг хөгжүүлэх шаардлага тулгарсан үед Дээд шүүх иргэний хэрэгт гомдол хүлээн авдаг.
5	Швед Улс	Дээд шүүх гомдол хүлээн авах анхдагч шалгуур нь шийдвэр нь доод шатны шүүхүүдэд чиглэмж болох чухал асуудлыг хөндөх ёстой байдаг.
6	Нидерланд Улс	Тус улсад шүүлтүүр бүхий тогтолцоог хуульчлаагүй ч Дээд шүүх нь гомдол сонгох арга барилтай. 1988 оноос хойш ямар нэгэн үр дүнд хүрэхээргүй буюу шийдвэр нь хуулийн нэгдмэл байдал болон хуулийг хөгжилд хамааралгүй тохиолдолд л Дээд шүүх үндэслэлээ тайлбарлахгүйгээр татгалзах боломжтой.

*Хүснэгт 1: Дээд шүүхийн чиг үүрэг ба хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл, улсуудын зохицуулалтын онцлог*

## 2.2. Шүүхэд хандах эрх

Шүүхэд хандах эрх туйлын эрх (absolute right) биш тул Дээд шүүхэд хандах эрхийг хязгаарлахдаа улс орнууд загвар, процедураасаа хамааран өөр өөр хязгаарлалтыг тогтоодог.<sup>28</sup> Ингэхдээ шүүхэд хандах эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилго болон тэнцвэрийн зарчимд нийцсэн байх ёстой.<sup>29</sup> Хэрэв Дээд шүүхэд хандах боломжгүй байх эсхүл, хяналтын гомдол гаргах үндэслэлийг хэт өргөн хүрээнд хуульчлах нь Дээд шүүхээс доод шатны шүүхүүдэд практик тогтоох, хуулийн хууль тогтоомжийн хөгжилд нөлөөлөх үүргээ гүйцэтгэхэд саад болдог.<sup>30</sup> Тиймээс Дээд шүүх ач холбогдолтой маргааныг шийдвэрлэх замаар хуулийн нэгдмэл байдлыг хангах, эрх зүйг хөгжүүлэх чиг үүрэг бүрэн дүүрэн хэрэгжих боломжтой байх, гагцхүү энэ л зорилгоор шүүхэд хандах эрхийг зохистой хязгаарлах гэсэн тэнцэл (balance)-ийг бүрдүүлэх нь хууль тогтоогчийн үүрэг юм. Хэрэв тус хяналтын гомдол гаргах үндэслэлүүд нь Дээд шүүхийн чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжид түлхэц үзүүлж чадахгүй бол шүүхэд хандах эрхийг үндэслэлгүй хязгаарласан болно. Улсын Дээд шүүхийн танхимын нийт шүүгчдийн “Гомдлыг хяналтын журмаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх хуралдаан”<sup>31</sup>-ы шийдвэрээр 2021 оны 03 сарын 01-ээс 11 сарын 01-ныг хүртэлх хугацаанд нийт гаргасан гомдлоос иргэний хэрэгт 5.3 хувийг<sup>32</sup>,

<sup>28</sup> Rimvydas Norkus (President of the Supreme Court of Lithuania), *The Filtering of Appeals of the Supreme Courts, Network of the Presidents of the Supreme Judicial Courts in European Union*, Dublin Conference, 2015, p6

<sup>29</sup> Right of access to Supreme Courts, p85

<sup>30</sup> Right of access to Supreme Courts, p76

<sup>31</sup> <http://www.supremecourt.mn/>

<sup>32</sup> Нийт хяналтын журмаар 632 гомдол гаргаснаас Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхим 34 гомдлыг шийдвэрлэхээр хүлээн авсан байна.



эрүүгийн хэрэгт 14.8 хувийг<sup>33</sup>, захиргааны хэрэгт 10 хувийг<sup>34</sup> тус тус шийдвэрлэхээр хүлээн авсан байна.

Монгол Улсын хувьд Шүүхийн тухай хуулиар зөвхөн “*хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах*” зорилгыг хуульчлан зөвхөн нэгдмэл бус хэрэглээ бүхий маргааныг л Дээд шүүх хянан хэлэлцэх боломжтой байгаа нь Дээд шүүхийн хуулийг хөгжүүлэх, эрх зүйн хөгжилд үр нөлөө бүхий шийдвэр гаргах боломжийг орхигдуулжээ. Учир нь шүүх өөрийн санаачилгаар аливаа асуудлыг дэвшүүлж шийдвэрлэдэггүй, харин хэргийн оролцогчдын нэхэмжлэл, тайлбарт тусгагдсан асуудалд эрх зүйн дүгнэлт, хариулт өгдөг. Иймд ач холбогдолтой хэрэг маргааныг Дээд шүүхээр хэлэлцүүлэх боломжгүй бол дээд шүүхэд олгосон чиг үүрэг, хууль дээдлэх баталгаа бүрдэж чадахгүй<sup>35</sup> байх эрсдэлтэй.

### 2.3. Дээд шүүхийн хууль тайлбарлах эрх

Онолын үүднээс хэрэг маргаан шийдвэрлэх замаар албан ёсны тайлбар /казуаль тайлбар/ гаргадаг Дээд шүүхүүдийн хувьд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх чиг үүргийн хэрэгжилт нь албан ёсны тайлбараар илрэн гардаг. Өөрөөр хэлбэл, Дээд шүүх нь хэрэг маргааныг шийдвэрлэх явцдаа тухайн маргаанд хэрэглэж буй хуулийг тайлбарлах замаар ижил төсөвтэй хэрэг маргаанд тухайн хуулийг зөрүүтэй хэрэглэж буй байдлыг арилгах үүднээс нэг мөр тайлбар хийдэг. Ийнхүү хуулийг хэрхэн ойлгож, хэрэглэх талаар онолын тайлбар хийж буй явдал нь шүүхийн тогтолцоонд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бүрдүүлэхийн сацуу, эрх зүйн хөгжлийг дэмждэг бөгөөд хуулийн албан ёсны тайлбарын хүчин чадалтай байдаг. Иймд, дээд шүүх хууль тайлбарлаж байгаа нь эрх зүйн маргааныг шийдвэрлэх, шүүхийн нэгдсэн практик тогтоох зорилготой.<sup>36</sup> Дээд шүүхэд хууль тайлбарлах эрх чөлөө (freedom of interpretation) бүрэн олгогдсон байх нь Дээд шүүх чиг үүргээ хэрэгжүүлэх суурь болдог.<sup>37</sup>

Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн түвшинг эрх бүхий байгууллагын хууль тайлбарласан шийдвэрээр тодорхойлж болно.<sup>38</sup> Монгол Улсын Дээд шүүхээс 1973 оноос 2008 он хүртэл хууль тайлбарласан нийт 272 тогтоол<sup>39</sup>, 2008-2009 оны дуустал хугацаанд нийт 35 тогтоол<sup>40</sup> тус тус гарсан байна. Үүнээс хойш буюу 2010 оноос хойш Дээд шүүх хуулийн тайлбар хийх явдлаас аль болох татгалзаж харин тайлбараа зөвлөмж хэлбэрээр буюу заавал дагаж мөрдөх шинжтэй бус гаргах болсон.<sup>41</sup> Тиймээс өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй 600 гаруй хууль тогтоомжийн хувьд хууль хэрэглээ болон боловсронгуй болгох асуудалд Дээд шүүхийн идэвхтэй тайлбар маш чухал нөлөөтэй. Нөгөө талаас Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өдгөө тухайн хууль нь хүчингүй болсон, шинээр хууль, тогтоомж батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон зэрэг асуудалд өмнөх тайлбарыг ашиглахад хязгаарлагдмал байдлыг үүсгэх боломжтой. Нийгэм түүхэнд байгаагүйгээрээ хөгжиж буй<sup>42</sup> өнөө үед Дээд шүүх тайлбар шинээр гаргах ёстой болон, тайлбараа өөрчлөх шаардлага зүй ёсоор урган гарна. Түүнчлэн Монгол Улсын эрх зүйн түүхэн уламжлалаас үзвэл Дээд шүүхээс хууль тайлбарлах чиг үүргийг хэрэгжүүлэхэд анхнаас нь хийсвэрээр тайлбарлах хандлага давамгайлж ирсэн<sup>43</sup> тул сүүлийн үед тогтонги тайлбар (static interpretation) -аас илүүтэйгээр хувьсах тайлбар (dynamic interpretation)

<sup>33</sup> Нийт хяналтын журмаар 216 гомдол гаргаснаас Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхим 32 гомдлыг шийдвэрлэхээр хүлээн авсан байна.

<sup>34</sup> Нийт хяналтын журмаар 229 гомдол гаргаснаас Улсын дээд шүүх захиргааны хэргийн танхим 26 гомдлыг шийдвэрлэхээр хүлээн авсан байна.

<sup>35</sup> Right of access to Supreme Courts, p70

<sup>36</sup> Д.Гангабаатар, *Үндсэн хуулийн эрх зүй Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал*, УБ, 2017, 268 дахь тал

<sup>37</sup> Maarten Feteris (President of the Supreme Court of the Netherlands), *Development of the Law by Supreme Court in Europe*, Utrecht Law Review Volume 13, Issue 1, 2017, p158

<sup>38</sup> Ж.Амарсанаа нар, Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959-2010), Хоёр дахь хэвлэлт (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2015), 37 дахь тал

<sup>39</sup> Монгол Улсын Дээд шүүх, *Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл* /Тав дахь удаагийн хэвлэл/, УБ., 2010, 3 дахь тал.

<sup>40</sup> Мөн тэнд

<sup>41</sup> А.Базар, “Улсын Дээд шүүхээс хууль тайлбарлах, хуулийн нэг мөр, зөв хэрэглээг хангах асуудал”, УБ., 2014, 52 дахь тал.

<sup>42</sup> Ottavia Dora Lo Sardo, *The role of Supreme Courts in the uniform application of law*, p86

<sup>43</sup> А.Бямбажаргал, *Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ*, 123 дахь тал.

гаргах шаардлага, хэрэгцээ<sup>44</sup> зайлшгүй цаг үеийн шаардлагаар үүсжээ.<sup>45</sup>

Тиймээс Улсын Дээд шүүхээс ийм төрлийн эрх зүйн болон бусад олон талын ач холбогдолтой маргааныг шийдвэрлэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдал төдийгүй хуулийг хөгжүүлэх, доод шатны шүүхүүдэд жишиг шийдвэр тогтоох шаардлагатай.

### III. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Дээд шүүхээр хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэхэд чиглэсэн маргааныг сонгон хэлэлцүүлэхийн тулд улс орнууд хяналтын гомдол гаргах хязгаарлалтыг ХХ зуунаас эхлэн хуульчилж эхэлсэн. Гэвч бүхэл зуун дамжин хөгжихдөө<sup>46</sup> энэхүү үйл явц нь амар хялбар хэрэгжээгүй ба шүүхэд шударгаар шүүлгэх эрхийг үндэслэлгүй хязгаарласан, Дээд шүүх дур зоргоороо аашиллаа хэмээх шүүмжлэл, эсэргүүцэлтэй тулгарч байжээ.<sup>47</sup> Судалгааны энэхүү хэсэгт Дээд шүүхийг чиг үүргийг онолын үүднээс хөгжүүлж, хяналтын гомдол гаргах үндэслэлийг анхлан хуульчлан багалгаажуулсан эх газрын эрх зүйн бүлийн томоохон төлөөлөгчид болох ХБНГУ, Австри Улс мөн БНСУ-уудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судаллаа. Эдгээр улсуудын хувьд Дээд шүүхийг хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх үүрэгтэй гэж Үндсэн хуулиараа зохицуулаагүй, харин уг асуудлыг онолын үүднээс дэвшүүлж, хяналтын гомдол гаргах үндэслэлүүдийг тус зорилгод нийцүүлэн ердийн хууль тогтоомжид хуульчилсан байдаг.

#### 3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад Дээд шүүхийн хяналтын гомдолд тавигдах шүүлтүүрийн үндсэн зорилго нь хуулийн чухал асуудлыг (the importance of the legal questions)<sup>48</sup> хөндсөн маргааныг шийдвэрлэж, хуулийг тайлбарлах замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах (ensuring the uniform application and interpretation of law)<sup>49</sup>, хуулийг хөгжүүлэх явдал<sup>50</sup> бөгөөд энэ зарчим 1921- оноос хэрэгжиж эхэлсэн байна.<sup>51</sup>

ХБНГУ-д Дээд шүүхээс хууль тайлбарлах асуудал нь шүүхийн хууль хэрэглээтэй салшгүй холбоотой<sup>52</sup> ба маргааныг хянан шийдвэрлэх явцдаа хуулийг зөв хэрэглэх талаар шүүхийн нэгдсэн жишгийг өөрийн шийдвэрээр буюу шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэх замаар хэрэгжүүлж ирсэн.<sup>53</sup> Тухайлбал, Захиргааны хэргийн шүүхээс нь тодорхой хэрэг, маргаан хянан шийдвэрлэх явцад шүүхийн тайлбараар дамжуулан захиргааны байгууллагын баримтлах ёстой суурь зарчмуудыг хөгжүүлэх замаар одоогийн өндөр хөгжсөн захиргааны эрх зүйг бий болгож, Verwaltungsrecht буюу Захиргааны ерөнхий үйл ажиллагааны хуулиа баталсан байна.<sup>54</sup> Энэ бол шүүхийн тайлбараар дамжуулан эрх зүйг хөгжүүлсний тод жишээ билээ.<sup>55</sup> Үндсэн хуульдаа<sup>56</sup> Холбооны Шүүх, Холбооны Захиргааны шүүх, Холбооны Сангийн шүүх, Холбооны Хөдөлмөрийн шүүх, Холбооны Нийгмийн шүүхүүдийг Дээд шүүх болгон байгуулна гэж заасан. Эдгээр бие даасан Дээд шүүхүүд нь 1) хууль зүйн асуудлын язгуур ач холбогдол (fundamental significance), 2) хуулийн цаашдын хөгжил (the further development of the law) болон нэгдмэл байдлыг хангахад ач

<sup>44</sup> Maarteen Feteris (President of the Supreme Court of the Netherlands), *Development of the Law by Supreme Court in Europe*, Utrecht Law Review Volume 13, Issue 1, 2017, p157

<sup>45</sup> Ottavia Dora Lo Sardo, *The role of Supreme Courts in the uniform application of law*, p86

<sup>46</sup> What is an important case? *Admissibility of appeals to the Supreme Court in the German-speaking Jurisdiction?*, p278

<sup>47</sup> *The paradigm shift: The "Leave to Appeal System" and Guidance and Developing Law as the Prevailing Tasks of the Supreme Court*, p.298

<sup>48</sup> Krüger in MüKo ZPO 2012, § 543 marginal numbers 1 et seq.; W. Ball in Musielak 2013, § 543 marginal numbers 1 et seq.

<sup>49</sup> Dr. Carsten Günther-Judge at the Federal Administrative Court, *Administrative Justice in Europe – Report for Germany, Leipzig Administrative Justice in Europe*, p8

<sup>50</sup> Urs Kramer and Tim Hinrichsen, *German Law of Administrative Court Procedure: an Overview*, Journal of Siberian Federal University. Humanities & Social Sciences 10 (2015 8) 2050-206, p2058

<sup>51</sup> Krüger in MüKo ZPO 2012, § 543 marginal numbers 1 et seq.; W. Ball in Musielak 2013, § 543 marginal numbers 1 et seq.

<sup>52</sup> А.Бямбажаргал, *Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ*, 126 дахь тал.

<sup>53</sup> Мөн тэнд.

<sup>54</sup> Дам ишлэв. П.Соёл-Эрдэнэ, Шүүхийн шийдвэр ба хууль тайлбарлах арга, Шударга ёсны хэмжүүр сэтгүүл, 2012.06 сар №06 /006/, 31 дэх талаас; Хууль зүйн Үндэсний төв, Шүүх, эрх зүйн шинэчлэлт төсөл, Гадаад орнуудын захиргааны хэргийн шүүх, Цуврал 6, УБ хот, 2005 он, 8 дахь тал.

<sup>55</sup> А.Базар, "Улсын Дээд шүүхээс хууль тайлбарлах, хуулийн нэг мөр, зөв хэрэглээг хангах асуудал", УБ., 2014, 19 дэх тал.

<sup>56</sup> Art 95(1), Basic Law for the Federal Republic of Germany, 1949

холбогдолтой (the interests in ensuring uniform adjudication)<sup>57</sup> хуулийн асуудал (points of law) хөндсөн маргааныг хүлээн авдаг ба 3) тухайн маргаанд амжилт үзүүлэхээргүй бол хүлээн авахаас тагталздаг байна (the appeal manifestly has no chance of success).<sup>58</sup>

### 3.2. Австри Улс

Австри Улсын Дээд шүүх нь зөвхөн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоож (ensuring a uniform law practice), өндөр ач холбогдолтой маргааныг (cases that bring up a question of high importance) шийдвэрлэдэг тогтолцоог 1983 оноос нэвтрүүлсэн.<sup>59</sup> “Чухал ач холбогдол бүхий хууль, эрх зүйн асуудал”<sup>60</sup> (legal issue of essential importance) гэдэг нэр томъёог Холбооны Үндсэн хуулийн шүүхээс тухайн шийдвэр нь Дээд шүүхийн тогтоосон практикаас хазайсан, зохицуулсан хууль нь хүчингүй болсон, эсвэл хууль дээдлэх ёсыг зөрчсөн байдлаар шийдвэрлэсэн байдал гэж тодорхойлдог<sup>61</sup>. Австрийн Холбооны Үндсэн хуульд<sup>62</sup> Иргэний болон эрүүгийн хэрэг маргааныг эцсийн шат нь Дээд шүүх байна гэж зохицуулсан бөгөөд *процессын хуулиудаар* 1) Land-ын бие даасан захиргааны танхимын шийдвэр, бие даасан холбооны танхимын шийдвэр, эрх бүхий холбооны байгууллагын шийдвэрийг эсрэг хяналтын гомдол гаргаж буй бол; (2) шийдвэр нь олон нийтийн ач холбогдол бүхий хуулийн асуудалд хамаагүй бол; (3) шүүх харьяалан шийдвэрлэх хууль эрх зүйн акт байхгүй, эсвэл холбогдох хууль эрх зүйн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулаагүй бол гомдлыг хүлээн авахаас тагталзаж болно гэж зохицуулсан байдаг.

### 3.3. Бүгд Найрамдах Солонгос Улс

Хууль тогтоомж ба жишиг шийдвэр (case law)-ийн холбоо хамаарал нь Бүгд найрамдах Солонгос Улсын Дээд шүүхийн амин чухал асуудлын нэг бөгөөд түүний илрэл нь албан ёсны тайлбараар дамжин хэрэгждэг.<sup>63</sup> Шүүхийн анхдагч чиг үүрэг нь хуулийг тайлбарлаж хэрэглэх тул<sup>64</sup> шүүх хуулийг зөвхөн бичвэр, үгээс гадна батлагдах болсон зорилго, үзэл санаа, тус заалтын чиг үүргийг авч үзэн албан ёсны тайлбар гаргадаг.<sup>65</sup> Цаашлаад шүүхийн президент нь хууль тогтоох явцад чухал нөлөө үзүүлдэг.<sup>66</sup> Тодруулбал, албан ёсны тайлбар нь “нийгмийн өөрчлөлтөд нийцүүлэн, жишиг шийдвэрээр дамжуулан хууль тогтоомжийн хоосон орон зайг нөхөх, хууль тогтоох байгууллагыг чиг үүрэгт түлхэц өгөх буюу шүүхийн шийдвэр гарснаар хуулиа өөрчлөх, сайжруулах, шинээр баглах тохиолдол болон шүүх хууль тогтоомжийг цаг тухайд нь, үндэслэлтэй, бүтээлч эрх зүйн шийдлээр хангах”<sup>67</sup> эргээр илэрдэг.

Үндсэн хуульдаа<sup>68</sup> Дээд шүүх нь захиргааны тогтоол, журам, үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцсэн эсэх, хууль ёсны эсэхэд эцсийн хяналт хийх бүрэн эрхтэй гэж заасан ба Дээд шүүхэд маргаан хянан шийдвэрлэх тусгай журмын тухай хуульд<sup>69</sup> 1) Шүүх хууль, тушаал, дүрэм, захирамжийг Дээд шүүхийн тайлбараас өөрөөр тайлбарласан; 2) Аливаа хууль, тушаал, дүрэм, захирамжийг тайлбарласан Дээд шүүхийн тайлбар байхгүй; 3) Дээд шүүхийн тайлбарыг өөрчлөх шаардлагатай тохиолдлуудад хяналтын журмаар гаргасан гомдлын хүлээн авдаг байна.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

<sup>57</sup> Art 551(4)1, Civil Procedure Code of Germany

<sup>58</sup> Art 522(2), Civil Procedure Code of Germany

<sup>59</sup> What is an important case? Admissibility of appeals to the Supreme Court in the German-speaking Jurisdiction?, p279

<sup>60</sup> Tour to Europe Contribution of Austria, 05/11/2015, p16

<sup>61</sup> Tour to Europe Contribution of Austria, p6

<sup>62</sup> Art 92(1), The Federal Constitutional Law of Austria, 1920

<sup>63</sup> Jae Hyung Kim (Korean Supreme Court Justice), *Formulating the Korean Supreme Court's Stature and Roles: with a Focus on the Relationship Between Legislation and Presedens*, Conference of Chief Justices of Asia and the Pacific in Tokyo, 2017, p136 [цаашид “**Jae Hyung Kim (Korean Supreme Court Justice)**” гэх]

<sup>64</sup> Мөн тэнд, p138.

<sup>65</sup> хууль тайлбарлах **praeter legem** (бичвэрээс гадуур хуулийн тайлбар хийх аргыг хууль тогтоомжид эрх зүйн дутагдал, доголдол байгаа тохиолдолд уг хийдэл, дутагдлыг нөхөх), **contra legem** (бичвэрт суурилж хэлний тайлбар) гэсэн хоёр тайлбарын аргыг ашигладаг.

<sup>66</sup> Дээд шүүх нь хууль тогтоогчоос хууль тогтоомжийг сайжруулах, боловсронгуй болгохыг хүлээхийн оронд тайлбараар дамжуулан тус хуулийн текстын муу утга агуулгыг засаж, сайнаар хэрэглэдэг.

<sup>67</sup> Jae Hyung Kim (Korean Supreme Court Justice), p143-156

<sup>68</sup> Art 107(2), Constitution of Republic of Korea, 1948

<sup>69</sup> Act on special concerning procedure for trial by the Supreme court

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал ёсоор Улсын дээд шүүх нь “*шүүхийн дээд байгууллага мөн*” бөгөөд “*хяналтын журмаар хянан үзэх*”, “*Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах*” бүрэн эрхтэй. Энэ нь Дээд шүүхийн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх буюу эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах чиг үүргийг илэрхийлэх, Үндсэн хуулиар нээлттэй олгосон эрх зүйн боломж гэж үзэх үндэслэлтэй. 2021 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуульд Улсын Дээд шүүхийн зорилгыг гагцхүү “*хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах*” хэмээн зохицуулж тус зорилгод үйлчлэх хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлүүдийг хуульчилсан. Иргэнлэг эрх зүйн бүлийн улсуудад Дээд шүүхэд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахаас гадна, эрх зүйн хөгжлийг дэмжих хөшүүрэг бүхий хяналтын журмаар гомдол гаргах бие даасан үндэслэл хуульчлагдсан байдаг. Харин манай улсын хувьд Дээд шүүхийн эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий тайлбар гаргах, хууль хөгжүүлэх, эрх зүйг боловсронгуй чиг үүргийг орхигдуулсан гэж үзэх үндэслэлтэй байна. Тодруулбал, дээд шүүхийн эрх зүйн хөгжлийг дэмжих хяналтын журмаар гомдол гаргах бие даасан үндэслэл Шүүхийн тухай хуульд тусгагдаагүй байгаа нь үүний илрэл юм.

Тиймээс одоогийн Шүүхийн тухай хуулиар зохицуулсан хяналтын журмаар гаргах гомдлын үндэслэлүүдэд (1) хуулийг хөгжүүлэх боломж хязгаарлагдмал, (2) тодорхой нэг хуулийн чухал (тодруулбал, анхдагч хуульд тогтоомжоор зохицуулсан харилцаа) асуудлыг Дээд шүүх анх удаа хянан хэлэлцэж жишиг тогтоох гэтэл хяналтын журмаар гаргасан гомдол зөвшөөрөгдөхгүй байх, (3) шүүхэд хандах эрхийг хязгаарласан зэргээс үүдэн Дээд шүүх хуулийг хөгжүүлэх ач холбогдолтой маргааныг сонгон хянах боломжгүйд хүргэжээ.

Иймд Дээд шүүхийн эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах, хуулийг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:

Нэгдүгээрт, Дээд шүүхийн зорилгыг “*хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах*”, нэмэх нь “*эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах (эрх зүйг хөгжүүлэх)*” гэж хуульчлах;

Хоёрдугаарт, өдгөө хуульчлагдсан хяналтын журмаар гомдол гаргах гурван үндэслэл дээр нэмэх нь дараах үндэслэлийг хуульчлах шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- (1) Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар гаргах шаардлагатай нөхцөл,
- (2) Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг өөрчлөх шаардлагатай нөхцөл.

Дээрх үндэслэлүүд хуульчлагдсанаар Дээд шүүх хуулийн нэгдмэл байдлыг хангахын зэрэгцээ, шийдвэр, тогтоолоороо дамжуулан хуулийг боловсронгуй болгох, хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах, цаашид онолын шүүх болох эхлэл тавигдах учиртай.

## ЭХ СУРВАЛЖ

### Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2012
3. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2021
4. Basic Law for the Federal Republic of Germany, 1949
5. Civil Procedure Code of Germany
6. The Fedetal Constitutional Law of Austria, 1920
7. Constitution of Republic of Korea, 1948
8. Act on special concerning procedure for trial by the Supreme court
9. *ҮХЦ-ийн тогтоол, “МУ-ын шүүхийн тухай хуулийн 17.3.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэх тухай”* /Дугаар 07-2015.10.30/, <https://www.legalinfo.mn/law/details/11397>

### Ном бүтээл

10. Б.Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал (Илтгэл, өгүүлэл, ярилцлага, дурсамж)*, УБ., 2002
11. Г.Совд, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*, УБ., 2000
12. Ж.Амарсанаа нар, *Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959-2010)*, Хоёр дахь хэвлэлт (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2015)
13. А.Базар, “Улсын дээд шүүхээс хууль тайлбарлах, хуулийн нэг мөр, зөв хэрэглээг хангах асуудал (Бакалаврын төгсөлтийн ажил)”, <https://legaldata.mn/b/439>
14. А.Бямбажаргал, “Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2020 оны №4 дугаар
15. Д.Гангабаатар, *Үндсэн хуулийн эрх зүй Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал*, УБ, 2017
16. О.Мөнхсайхан, “Шүүхийн тухай хуулийн төслийн хүрээнд шүүхийн хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2020 оны №4 дугаар
17. Р.Оюундэлгэр, “Улсын дээд шүүхийн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүрэг ба хяналтын журмаар гаргах гомдолд хязгаарлалт тавих асуудал, түүний учир холбогдол”, <https://legaldata.mn/b/970>
18. Р.Оюундэлгэр, *Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123.2 дахь заалтын хэрэгжих боломж ба хүндрэл* (Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангуулах тухай), Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2021 оны №4 дугаар

### Гадаад эх сурвалж

19. Maarten Feteris (President of the Supreme Court of the Netherlands and Professor at Erasmus University Rotterdam), “Development of law by Supreme Court in Europe”, *Utrecht Law Review*, <https://www.utrechtlawreview.org/articles/abstract/10.18352/ulr.401/>
20. Jae Hyung Kim (Korean Supreme Court Justice), Formulating the Korean Supreme Court’s Stature and Roles: with a Focus on the Relationship Between Legislation and Presedens, Conference of Chief Justices of Asia and the Pacific in Tokyo, 2017, [https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract\\_id=3381963](https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=3381963)
21. Dr. Carsten Günther-Judge at the Federal Administrative Court, Administrative Justice in Europe – Report for Germany, Leipzig Administrative Justice in Europe, [https://www.aca-europe.eu/en/eurtour/i/countries/germany/germany\\_en.pdf](https://www.aca-europe.eu/en/eurtour/i/countries/germany/germany_en.pdf)
22. 24. Urs Kramer and Tim Hinrichsen, German Law of Administrative Court Procedure:

- an Overview, Journal of Siberian Federal University. Humanities & Social Sciences 10 (2015 8) 2050-206, [http://elib.sfu-kras.ru/bitstream/handle/2311/19824/06\\_Kramer.pdf;jsessionid=790424912C93F6BBF64A833473B2BC87?sequence=4](http://elib.sfu-kras.ru/bitstream/handle/2311/19824/06_Kramer.pdf;jsessionid=790424912C93F6BBF64A833473B2BC87?sequence=4)
23. Tour to Europe Contribution of Austria, 05/11/2015, 16 дахь тал, [https://www.aca-europe.eu/en/eurtour/i/countries/austria/austria\\_en.pdf](https://www.aca-europe.eu/en/eurtour/i/countries/austria/austria_en.pdf)
24. A. Uzelac and C.H. van Rhee, The Paradigm Shift: The ‘Leave to Appeal System’ and Guidance and Developing Law as the Prevailing Tasks of the Supreme Court, Nobody’s Perfect Comparative Essays on Appeals and other Means of Recourse against Judicial Decisions in Civil Matters, 2014, [https://www.academia.edu/34460915/Nobodys\\_Perfect\\_Comparative\\_Essays\\_on\\_Appeals\\_and\\_other\\_Means\\_of\\_Recourse\\_against\\_Judicial\\_Decisions\\_in\\_Civil\\_Matters](https://www.academia.edu/34460915/Nobodys_Perfect_Comparative_Essays_on_Appeals_and_other_Means_of_Recourse_against_Judicial_Decisions_in_Civil_Matters)
25. Rimvydas Norkus (President of the Supreme Court of Lithuania), The Filtering of Appeals of the Supreme Courts, Network of the Presidents of the Supreme Judicial Courts in European Union, Dublin Conference, 2015, <https://www.lat.lt/data/public/uploads/2018/01/introductory-report-the-filtering-of-appeals-to-supreme-courts-president-rimvydas-norkus.pdf>
26. Arnfinn Bardsen (The Norwegian Supreme Court Justice), Deciding what to decide: The filtering mechanism in the Norwegian Supreme Court, 2018, <https://www.domstol.no/globalassets/upload/hret/artikler-og-foredrag/deciding-what-to-decide---bardsen-23.02.2018.pdf>
27. A. Uzelac and C.H. van Rhee, Uniform Application of Law and Promotion of its Development as a New Role of Supreme Courts, Nobody’s Perfect Comparative Essays on Appeals and other Means of Recourse against Judicial Decisions in Civil Matters, 2014
28. Nikolina Katic, Matea Basic, Morana Briski, Right of Access to Supreme Courts in Light of the Guarantees under Article 6.1 of the Convention on Human Rights and Fundamental Freedoms (civil aspect), Croatia International Relations Review-CIRP, 2018, <https://hrcak.srce.hr/file/294499>
29. Ottavia Dora Lo Sardo, The role of Supreme Courts in the uniform application of law, <https://romatrepress.uniroma3.it/wp-content/uploads/2020/07/05.ther-otlosa.pdf>
30. Jelena Ristik, The role of the Supreme Court in ensuring uniformity of court practice in the Republic of Macedonia, 2017, <https://www.cceol.com/search/article-detail?id=848891>
31. Wydawnictwa Uniwersytetu, The functions of the Supreme Court – Issues of process and Administration of Justice, 2019, Warsaw, [http://wuw.pl/data/include/cms/Studia\\_luridica\\_81\\_2019.pdf](http://wuw.pl/data/include/cms/Studia_luridica_81_2019.pdf)



## **THE SUPREME COURT’S FUNCTION TO ADJUDICATE WITH CONSEQUENCES FOR LEGAL DEVELOPMENT: ITS SIGNIFICANCE AND CONSTITUTIONAL ORIGINS**

*Oyundelger Ravdanbyamba*  
*Researcher*

### **ABSTRACT:**

According to the Constitutional law of Mongolia, the ‘Mongolian Supreme Court is the highest judicial organ’ under article 50.1, it exercises the following powers: ‘to examine decisions of lower-instance courts through appeal and supervision; and ‘to provide official interpretations for correct application of all other laws except the Constitution’. On the one hand, these Constitutional provisions confirm that the Supreme shall protect human rights and restore violated human rights by reviewing the lower court’s decisions in the final appellate instance in the judicial system. On the other hand, the Supreme court shall be obligated to develop laws in the judicial system through its decisions, resolutions, and stature interpretations as being the highest judicial organ under the above-mentioned provisions.

The Supreme court’s function is to ensure the uniform application of the law under article 25.7.5 of Law on the Court of Mongolia which was adopted in 2021. In connection with its function, the Supreme court shall review appellate court decisions on the following selection criteria: “1) court of first instance court and appellate court have applied law differently, 2) court has applied law rather than stature interpretation of Supreme court, and 3) procedure grave violation has affected court decision”. Those criteria are also amended in Criminal procedure law, Civil procedure law, and Administrative procedure law on the date thereof.

In this paper, the author will compare the Constitutional role of the Supreme court and its theoretical perspective to the Supreme court function and the filtering of appeals mechanism set out in Law on Court. Also, will suggest that the Supreme court’s purpose which is to develop law is abandoned according to Law on Court. In the comparative study section, this paper will discuss the significance of civil law systems in countries on Supreme court reviewing mechanisms and its constitutional perspective, including Germany, Austria, and South Korea. Finally, a relevant conclusion and some suggestions will be delivered in this research.

### **KEYWORDS:**

The constitutional role of the Supreme court, Uniformity of law, Filtering of appeals, Selection criteria, Judicial activism, Stature interpretation, Dynamic interpretation, Static interpretation

## ПРОКУРОРЫН ДААЛГАВРЫН ХУУЛЬ ЗҮЙН АЧ ХОЛБОГДОЛ, МӨН ЧАНАР, ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ОНЦЛОГ



*Т.Батсүх  
Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь  
Сум дундын Прокурорын газрын ерөнхий  
прокурор, хууль зүйн магистр*

### ТОВЧЛОЛ:

Шүүхийн өмнөх шатан дахь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тавих прокурорын хяналтын үндсэн арга хэрэгслийн нэг нь зайлшгүй шаардлагатай нотлох баримт цуглуулах талаар мөрдөгчид бичгээр өгдөг заалт буюу прокурорын даалгавар байдаг. Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгчийн гаргасан процессийн алдааг зөвтгөж хуулийн заалтыг хангуулах, хуулийг зөв хэрэглэх, нотлох баримтыг бүрэн дүүрэн цуглуулах шаардлагатай гэж үзвэл прокурор даалгавар бичиж мөрдөгчид хүргүүлэх ба мөрдөгч уг даалгаврыг заавал биелүүлэх<sup>1</sup> үүрэгтэй байдаг.

### ТҮЛХҮҮР ҮГС:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, прокурорын даалгавар, прокурорын хяналт, прокурорын эрх зүйн актын төрөл.

### ОРШИЛ

1921 онд Ардын хувьсгал ялж шинэ цагийн Монгол улс оршин тогтнох эх үндсийг тавьсан билээ. Шинэ цагийн Монгол улсын нийгмийн хөгжлийн эхэн үед хүний эрхийг хамгаалах, хууль ёсыг сахиулахад прокурор хэмээх тусгай чиг үүрэг бүхий нэгэн институц шинээр бий болж хөгжлийнхөө 90 жилийн түүхийг бүтээсэн юм.

Монгол улсад прокурорын байгууллага үүсэн байгуулагдах эх үндсийг 1930 оны 4 сард хуралдсан БНМАУ-ын ҮИ Их хурлаар “Тус улсын прокурорын тушаалыг төв ба аймгуудын зэрэг газруудад үүсгэн байгуулж, хянан байцаах эрх хэмжээг тодорхойлон тогтоовол зохино.” гэсэн түүхэн шийдвэр гарснаар тодорхойлж улмаар мөн оны 8 дугаар сарын 14-нд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 25 дугаар Хурлын тогтоолоор “Улсын прокуроруудаас гүйцэтгэх эрх үүргүүдийн дүрэм”-ийг баталж төрийн нэрийн өмнөөс хуулийн биелэлтэд хяналт тавих өндөр хариуцлагатай, нэр хүндтэй үүргийг хүлээлгэжээ.<sup>2</sup>

<sup>1</sup> Прокурорын тухай хуулийн 33.4 дэх заалт. Төрийн мэдээлэл №24. УБ., 2017

<sup>2</sup> Прокурорын байгууллагын түүхэн товчоон. 1930-2020, УБ., 2020 он, 12 дах тал.

Уг дүрмээр прокурор нь ерөнхий хяналт, хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтад тавих хяналт, шүүхийн хяналт, ял эдлүүлэх хяналт гэсэн үндсэн дөрвөн хяналт тавьж гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг удирдаж явуулах<sup>3</sup> үүрэгтэй байхаар тогтоосон байна.

Орчин цагийн Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжид прокурор гэдэг албан тушаалтан оролцох талаар болон түүний үндсэн чиг үүргийг 1928 онд баталсан “Монгол улсын Улаан цэргийн шүүх таслах газрын дүрэм”-д анх удаа хуульчлан тусгасан байна. Уг дүрмийн Арван дөрөвдүгээр зүйлд “Нийтийн хууль ба цэргийн дүрмийг дагаж буй үгүйг хянах ба хэрэгтэнг урьдаар байцаах явдлыг хэрхэн гүйцэтгэж буйг, бас хэрэг тохиолдвол яллах явдлыг гүйцэтгэхийн тулд бүх цэргийн прокурорын тушаалыг байгуулна.”<sup>4</sup> гэж заажээ. Ингэснээр хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд ПРОКУРОР гэдэг тусгай эрх мэдэлтэй оролцогч байх шаардлагатай болохыг анхлан тодорхойлсон бөгөөд энэ нь прокурорын албан тушаал манай улсад шинээр бий болсон эх үндэс гэж үзэхээр байна. Мөн дээрх дүрмийн Арван долоодугаар зүйлд “... байцаагч нар... прокуророос даалгасан ёсоор хэргийг байцаах явдлыг гүйцэтгэнэ.” гэсэн байх бөгөөд прокурор нь мөрдөгчийг чиглүүлдэг, түүнд даалгаж мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэдэг үзэл санааг анх тодорхойлсон байна. Прокурорын байгууллага, албан тушаалтны хяналтын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг 1930-1976 он хүртэл 12 удаагийн дүрмээр<sup>5</sup>, 1976, 1993, 2002, 2017 оны нийт 4 удаагийн хуулиар тус тус зохицуулж ирсэн. Эдгээр эрх зүйн эх сурвалжуудад прокурор хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ үйлддэг эрх зүйн актуудын талаар тусгасан байна.

Прокурор нь эрүүгийн хрээг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн субъектын нэг болохын хувьд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг удирдан чиглүүлэх эрх хэмжээтэй. Энэхүү эрх хэмжээгээ хэрэгжүүлэхдээ мөрдөгчийн хууль зөрчсөн шийдвэр, ажиллагааг хүчингүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэх, түтгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, хугацааг сунгах, хэрэг, хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэл болон даалгавар өгч, биелэлтийг тооцож хяналт тавих, яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлэх, төрийн нэрийн өмнөөс яллах зэрэг бие даасан хараат бус үйл ажиллагаа явуулдаг.

Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагааг чиглүүлж, удирдах эрх хэмжээ нь прокурорын байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан анхны дүрмүүдэд ч тусгалаа олсон байна. Тухайлбал: 1930 онд баталсан Улсын Прокуроруудын тухай дүрэмд “...1. холбогдогчын хэргийг байцааж үзээд эрүүгийн хууль дүрмийн ёсоор байцаалган шийтгүүлэх явдлыг удирдан үүсгэж гүйцэтгүүлнэ. 2. Аливаа эрүүгийн хэргийг байцаах этгээдүүд ба цагдан сэргийлэх газруудын хэрэг явуулгыг хянах ба удирдах.”<sup>6</sup> гэж заажээ. Ийнхүү прокурор нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдаж, заалт чиглэл өгөх эрх хэмжээний талаар прокурорын байгууллагын үйл ажиллагааг журамласан дараа дараагийн дүрмүүдэд уламжлагдан тусгаж ирсэн байна<sup>7</sup>.

Процесс ажиллагааг удирдан чиглүүлэх эрх хэмжээтэйн хувьд прокурор нь гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг хүлээн авснаас эхлэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эрүүгийн хэрэг үүсгэж яллагчаар татах, яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлэх хүртэлх бүхий л үйл ажиллагааг тасралтгүй хянаж, мөрдөгчид амаар чиглэл өгч, бичгээр зааварлаж даалгавар хүргүүлж шуурхай удирдлагаар хангаж ажилладаг.

<sup>3</sup> Мөн тэнд. 13 дах тал.

<sup>4</sup> Монгол улсын Прокурорын байгууллагын хууль тогтоомжийн түүхэн эх сурвалж. Эмхтгэл. УБ., 2020 он, 20 дах тал.

<sup>5</sup> Улсын прокуроруудын тухай дүрэм, Монгол ард улсын шүүх явдлын яамны дүрэм 1930 он БНМАУ-ын Шүүх тамлах газар, Прокурор нар хийгээд байцаагч нарын газруудын дүрэм, БНМАУ-ын Шүүх явдлын яамны дүрэм 1932 он, Шүүх таслах ба Прокуроруудын газруудын дагаж явах дүрэм 1934 он, Монгол ард улсын Хувьсгалт цэргийн Прокуроруудын дүрэм 1939 он, БНМАУ-ын Прокурорын дүрэм 1941 он, 1945 он, БНМАУ-ын Прокурорын хяналтын дүрэм 1957 он.

<sup>6</sup> Монгол улсын Прокурорын байгууллагын хууль тогтоомжийн түүхэн эх сурвалж, УБ., 2020 он, 26 дах тал.

<sup>7</sup> 1931 онд баталсан БНМАУ-ын Шүүх таслах газар Прокурор нар хийгээд байцаагч нарын газруудын дүрэм “...аливаа хэргийг байцаах газруудын хэрэг явуулгыг ерөнхийлөн хянах ба удирдах.” гэж, 1934 оны Шүүх таслах ба Прокуроруудын газруудын дагаж явах дүрэмд “...мөрдөн байцаах явдлыг хэрхэн гүйцэтгэж байгаа зэргийг хянан харгалзах ба удирдах” гэж тус тус тусгажээ.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажилагааг шуурхай, тасралтгүй улирдлагаар хангахдаа прокурор нь тухайн үйл баримтыг нотлоход (эсхүл гэмт хэргийн шинжгүй болохыг тогтоох) чиглэсэн ямар ажиллагааг хийж гүйцэтгэхийг нарийвчлан заасан заалт<sup>8</sup> даалгаврыг бичгээр өгөх ба мөрдөгч нь уг даалгаврыг заавал биелүүлэх үүрэгтэй. Энэхүү өгүүллээр прокурорын даалгавар хэмээх прокурорын хяналтын эрх зүйн баримт бичгийн ойлголт, мөн чанар, үндсэн шинж, төрөл хэлбэр, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, үр дагавар, хууль зүйн ач холбогдол болон даалгавар хэрхэн бичих ур чадварын талаар тодруулахыг зорьсон болно. Ингэхдээ хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналтын явцад бичдэг даалгаврыг голлон авч үзлээ.

### **Прокурорын даалгаврын ойлголт, мөн чанар, үндсэн шинж**

Прокурорын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д зааснаар прокурор чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тодорхой ажиллагаа гүйцэтгүүлж, баримт, мэдээлэл цуглуулахаар бичгээр даалгавар өгнө. Хуулийн энэхүү заалтаас үзэхэд прокурор хяналтын бүхий л чиглэлээр бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ даалгавар өгөхөөр ойлгогдож байна. Прокурорын даалгавар гэх баримт бичиг нь прокурорын хяналтын үйл ажиллагааны түүхэн хөгжлийн явцад хэрхэн ямар агуулгаар анх хэрэглэж ирснийг цухас дурдах нь зүйтэй юм.

Прокурорын хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ямар шийдвэр гаргах, ямар эрх зүйн шинжтэй баримт бичиг үйлдэх нь эрүүгийн процессийн хуульд заасан хяналтын чиг үүрэг, эрх хэмжээтэй шууд хамааралтайгаар тодорхойлогддог. Учир нь хэрэг мөрдөн шалгах ажиллагааны үе шат бүрд прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ямар эрх хэмжээтэй байхыг процессын хуулиар журамлан зохицуулсан байдаг. Тухайлбал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.3 дугаар зүйлд зөвшөөрөл олгох, 4.1 дүгээр зүйлийн 2.15-д даалгавар өгөх, 30.10, 30.14, 30.17 дугаар зүйлд тогтоол үйлдэх, 29.6 дугаар зүйлд мэдэгдэл бичих, 38.1, 38.2 дугаар зүйлд эсэргүүцэл бичих талаар заасан нь прокурор хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гаргах шийдвэр, үйлдэх баримт бичгийн төрөл, хэлбэрийг тогтоосон эх сурвалж, үндэс нь болдог.

Манай улсын эрүүгийн процесс ажиллагааг зохицуулсан анхны дүрмүүд ба хуулийг Оросын хуулиас хуулбарлан загвар болгож боловсруулан баталж мөрдөж ирсэнтэй холбоотойгоор орос нэр томъёог шууд<sup>9</sup> болон орчуулж хэрэглэсэн нь элбэг байх бөгөөд 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд прокурор мөрдөх албан тушаалтанд заалт / указание/ өгөх талаар тусгасан байдаг.

1992 онд Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор төрөөс явуулсан эрх зүйн шинэтгэлийн хүрээнд эрүүгийн хууль тогтоомжуудад<sup>10</sup> үзэл баримтлалын шинжтэй томоохон өөрчлөлтүүдийг 1993-1994 онуудад хийсэн юм. 1994 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан зарчмын шинжтэй нэмэлт өөрчлөлтөөр ... тодорхой ажиллагааг гүйцэтгүүлэхээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид заалт өгөх гэж заасан<sup>11</sup> байна. Прокурорын байгууллага, прокурорын албан тушаалын талаар зохицуулсан анхны хууль болох 1976 онд баталсан БНМАУ-ын Прокурорын хяналтын тухай хуулийн 30 дугаар зүйлд "... хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын бусад ажиллагаа явуулах талаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаалт явуулах байгууллагад даалгавар, заалт өгөх", "... эрүүгийн хэргийг нөхөн мөрдүүлэхээр заалт өгч буцаах" гэж, 31 дүгээр зүйлд "... прокуророос

<sup>8</sup> Заалт өгөх гэдгийг 1928-1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад тусгаж байсан. Харин 2002 оны хуулиар даалгавар өгнө гэж шинэ нэршил хэрэглэсэн байдаг. Казахстан улс болон ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд "Указание" буюу заалт гэж хэрэглэдэг.

<sup>9</sup> 1931 онд баталсан Дүрэмийн дөчин наймдугаар зүйлд "...үл зөвшөөрөн протест гаргах..." гэж эсэргүүцэл бичих эрх хэмжээг анх тусгасан байна.

<sup>10</sup> Монгол Улсын Их хурал 1993 оны 02 дугаар сарын 15, 06 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуульд ардчилсан тогтолцоотой, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйт төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан.

<sup>11</sup> Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. (1911-2009) УБ., 2012, 341 дэх тал.

тэдний мөрдөж байгаа эрүүгийн хэргийн талаар өгсөн заалт, даалгаврыг<sup>12</sup> заавал биелүүлж хариу мэдэгдэнэ.<sup>13</sup> гэж тус тус заасан. Эндээс үзэхэд орос хэлнээс буулгасан заалт гэх нэршлийг “заалт, даалгавар” гэсэн хоршоо үгээр хэрэглэж эхэлсэн байна.

Прокурор хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ үйлддэг баримт бичиг /акт/-ийн талаар 1993 онд баталсан Прокурорын байгууллагын тухай хуулийн 21 дүгээр зүйлд “Эрх зүйн хэлбэрийн төрөл” гэсэн нэршлийг анх удаа хэрэглэж даалгавар, эсэргүүцэл, тогтоол, шаардлага, зөвшөөрөл гэсэн төрөлтэй байхаар<sup>14</sup> тусгасан нь 2002 оны Прокурорын байгууллагын тухай хууль, 2017 оны Прокурорын тухай хуулиудад хэвээр хадгалан тусгасан.

Прокурорын даалгавар нь мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын эрх зүйн хэлбэр үү эсхүл хяналтаа хэрэгжүүлэхдээ үйлддэг акт /баримт бичиг/ бус уу гэх асуулт тавигдана. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар “Хэрэг бүртгэх мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтын бүрэн эрх”-д хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байгаа хэргийг хянасны үндсэн дээр мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах даалгаврыг мөрдөгчид өгч биелэлтэд хяналт тавьж хангуулахаар зохицуулж ирсэн.<sup>15</sup> Эндээс бид прокурорын даалгавар гэх баримт бичгийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тухайн хэргийг нотлох ажиллагааг хуульд нийцүүлж нэг мөр бүрэн гүйцэт хийлгэх зорилгоор мөрдөгчөөр нөхөн гүйцэтгүүлэх ажиллагааны заалт, чиглэл гэж үзэхээр байна.

Прокурорын даалгаврыг эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад хэрэглэх эрх хэмжээний нэг хэлбэр гэх ойлголтыг 1976-2002 оны Прокурорын байгууллагын тухай хуулиудаар хэрэглэж ирсэн бол 2017 оны Прокурорын тухай хуульд зааснаар прокурор **чиг үүргээ хэрэгжүүлэхдээ** тодорхой ажиллагаа гүйцэтгүүлж баримт, мэдээлэл цуглуулахаар даалгаврыг бичгээр өгнө гэж өргөн утгаар хэрэглэсэн байна. Өргөн утгаар гэдэг нь эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаанаас гадна зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа, ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын **чиг үүргээ хэрэгжүүлэхдээ** тодорхой ажиллагааг гүйцэтгүүлэхээр прокурор /заалт, чиглэл/ даалгавар бичгээр өгөх эрх хэмжээтэй болсон гэсэн үг бөгөөд энэ нь прокурорын хяналтын чиг үүрэгт гарсан шинэлэг зохицуулалт юм.

Прокурор эрүүгийн хууль тогтоомжийн<sup>16</sup> хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эдлэх бүрэн эрхийн хүрээнд /үйлддэг баримт бичгийн нэг үндсэн төрөл/ тодорхой ажиллагаа хийлгэж процесс алдааг залруулах, дутуу байгаа баримт, мэдээллийг нөхөн цуглуулах зорилгоор бичгээр өгч буй чиглэл, заалтыг **даалгавар** гэж ойлгоно.

Прокурор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд прокурорын даалгавар онцгой үүрэг гүйцэтгэнэ.<sup>17</sup> Прокурор даалгавар бичих эрх хэмжээг процессийн хуулиар тогтоодог. Өөрөөр хэлбэл процессийн хуулиар түүнд оролцогчдын бүрэн эрхийн талаар эс зохицуулбаас материаллаг хуулиар, тухайлбал Прокурорын тухай хуулиар уг эрх хэмжээг эхлэн тогтоож процесс ажиллагаанд оролцуулах хууль зүйн хувьд боломжгүй байдаг.

<sup>12</sup> Даалгаврыг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас хуулийг илт зөрчсөн нь бага бус гэм хор учруулахаар бол уг зөрчлийг арилгуулахаар тухайн байгууллага албан тушаалтанд, эсхүл түүний дээд шатны байгууллага албан тушаалтанд бичиж байхаар уг хуулийн 23 дугаар зүйлд заасан байдаг.

<sup>13</sup> Монгол улсын Прокурорын байгууллагын хууль тогтоомжийн түүхэн эх сурвалж эмхэтгэл, УБ., 2020, 124, 125 дах тал.

<sup>14</sup> Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ эсэргүүцэл, мэдэгдэл, тогтоол, даалгавар, зөвшөөрөл, нэхэмжлэл гаргана. Тэдгээрийн загварыг Улсын ерөнхий прокурор батална. гэжээ.

<sup>15</sup> 1949 оны БНМАУ-ын Эрүүгийн байцан шийтгэх хуулийн 117, 135, 1963 оны БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 209, 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 193.1.4, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 2.15-д заасан байна.

<sup>16</sup> 2015-2017 оны хооронд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн баталснаар эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн билээ.

<sup>17</sup> Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар, УБ., /хэвлэгдсэн он тодорхойгүй/ 82 дах тал.

Прокурорын даалгавар нь түүнийг хүлээн авсан мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан заавал биелүүлэх ёстой, итператив шинжтэй баримт бичиг бөгөөд үүгээр даалгаврын үндсэн шинж тодорхойлогдоно. Энэ нь эрүүгийн эрх зүйн хууль ёсны зарчим, шударга ёсны зарчим, гэм буруугийн зарчмуудын хэрэгжилтийг хангуулахад даалгавар чухал ач холбогдолтой болохыг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл мөрдөгч, прокурор нь нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох, үүний тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтоох үүрэгтэй шууд холбоотой. Прокурор нь эрүүгийн процессын бүх үе шатанд оролцож хяналт тавьдаг хамгийн өргөн эрхийг хэрэгжүүлдэг цорын ганц<sup>18</sup> онцгой бүрэн эрхтэй субъектын хувьд процесс ажиллагааг удирдан чиглүүлэхээр түүний бичсэн даалгаврыг заавал биелүүлэх үүрэгтэй болохыг хуульчлан зохицуулсан байна.

Прокурор нь эрүүгийн /зөрчлийн/ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон ял эдлүүлэх ажиллагааны явцад тасралтгүй хяналт тавьж тухайн ажиллагаанд гарч буй процессын алдаа зөрчлийг засаж залруулах, арилгуулах зорилгоор бичгээр даалгавар өгч дутуу байгаа баримт, мэдээллийг нөхөн цуглуулж, тодорхой ажиллагаа гүйцэтгүүлж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын хүний халдашгүй байх, эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх, орон байрны халдашгүй байдлыг хангах, захидал харилцааны нууцыг хамгаалах, хууль шүүхийн өмнө тэгш байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах, гэм буруугийд тооцох, ашигтайгаар шийдвэрлэх зэрэг эрхийг хангах, зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээхэд чиглэдэг бөгөөд үүнд даалгаврын мөн чанар оршино. Прокурор нь мөрдөгч, эрх бүхий албан тушаалтнуудын хууль зөрчсөн үйл ажиллагааг хяналтаараа илрүүлж түүнийг арилгуулах, хэргийн бодит байдлыг тогтооход дутагдалтай байгаа нотлох баримтыг цуглуулах ажиллагааг заалт даалгавар өгч нөхөн гүйцэтгүүлэхгүй бол эрүүгийн хариуцлага<sup>19</sup> нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх шударга ёсны зарчмыг алдагдуулахад хүргэх хууль зүйн сөрөг үр дагавартай.

#### **Прокурорын даалгаврын төрөл, хэлбэр.**

Прокурорын хяналтын төрлөөр нь даалгаврыг дараахь байдлаар ангилж болно.

1. Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд бичих даалгавар
2. Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд бичих даалгавар
3. Ял эдлүүлэх ажиллагаанд бичих даалгавар
4. Гүйцэтгэх ажиллагаанд бичих даалгавар

Тухайн даалгавраар гүйцэтгүүлж буй ажиллагааны онцлогоос хамаарч:

1. Нотлох баримт цуглуулах буюу хэргийн бүрдлийг хангуулах зорилгоор бичих даалгавар
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмуудыг хангуулахаар<sup>20</sup> бичих даалгавар гэж ангилж болно.

Хэргийн бүрдэл хангуулахаар бичиж буй даалгаврын үндсэн агуулга нь нэмэлт нотлох баримтыг нөхөн цуглуулахад чиглэсэн заалтууд байна. Энэ төрлийн даалгаврыг дараахь 3 нөхцөл байдлыг тогтооход чиглүүлнэ. Үүнд:

<sup>18</sup> Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан, Прокурорын хяналт, УБ., 2009 он. 89 дэх тал.

<sup>19</sup> Зарим улсад зөрчлийг жижиг гэмт хэрэг гэж үздэг бөгөөд манай улсын гэмт хэрэг болон зөрчлийг хянан шийдвэрлэхэд баримтлах зарчим, оногдуулах ял, шийтгэл, албадлагын арга хэмжээ нь хэлбэрийн хувьд адил төстэй байдаг. Англиар crime, misdemeanour, offense гэх хүний хууль бус үйл ажиллагаа буюу гэмт явдлыг гэмт хэрэг, зөрчил хэмээн төрөлжүүлэн ял, шийтгэл оногдуулж төрийн албадлагын арга хэмжээг тус тусын хуулиар зохицуулан хэрэглэж байна. Хүний хууль бус зарим ижил үйлдлийг гэмт хэрэг болон зөрчлийн хуулиар салган ялгаж гэмт үйлдэлд тооцож байгаа. Тухайлбал бага хэмжээний хулгай, жижгээр танхайрах, авто осол гаргах г.м. Хууль тогтоогч 2017 онд баталсан Зөрчлийн тухай хуулиар зөрчлийг захиргааны эрх зүйн зөрчил бус харин нийгмийн аюулаар их биш гэмт хэрэгтэй адилтгаж үзсэн. Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 5, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1, 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үз.

<sup>20</sup> Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар, УБ., /хэвлэгдсэн он тодорхойгүй/ 82 дах тал



1. Тухайн үйл баримт /факт/ нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй эсэх, эсхүл иргэний болон бусад эрх зүйн харилцаанд хамаарах үйлдэл эсэхийг тогтоох, *Жишээ: Б-ийн үйлдэлд залилах гэмт хэргийн шинж байгаа эсэхийг эхнээс нь анхаарч шалгаагүйгээс мөрдөн шалгах ажиллагаа удааширч улмаар мухардалд орсон байна. Тодруулбал, хохирогч гэх Р нь “ЗШР” ХХК-д 12 сая төгрөг, 9 сая төгрөгийг уг компаниас дараа тооцоогоор авсан барааныхаа үнэд өгөх ёстой, тэгэхдээ дээрх компанийн борлуулагч Б-ийн дансаар дамжуулан төлбөрөө хийдэг практик тогтсон байсан учраас тухай тухайн сард нь 2 удаа шилжүүлсэн нь залилах гэмт хэргийн шинжтэй эсэх нь эргэлзээтэй байна. Иймд хохирогч Р нь борлуулагч Б-д барааны үнэ гэж 2 удаа мөнгө шилжүүлсэн үйлдэл нь Иргэний эрх зүйн зээлээр бараа худалдах худалдан авах харилцааны шинжтэй эсэх, Б нь дээрх мөнгийг “ЗШР” ХХК-даа тушааж тооцоо хийгээгүй үйлдэл нь хөдөлмөрийн хуульд заасан эд хөрөнгийн бүрэн хариуцлагатай холбоотой үйл баримт эсэх талаас нь шалгах шаардлагатай байх тул дараахь ажиллагаануудыг хийх...г.м*

2. Тухайн үйл баримт нь гэмт хэргийн шинжтэй нь тодорхой бол Эрүүгийн хуульд заасан төрлийн шинжээр ижил буюу нэг бүлэгт заасан бусад гэмт хэргийн шинжтэй эсэхийг тогтоох, *Жишээ нь: хулгайн хэрэгт сэрдэгдэж буй Ш нь “харих гээд унаа олдохгүй болохоор нь уг мотоциклийг түлхүүртэй байхаар нь асаагаад унаад явчихсан юм” гэснийг Эрүүгийн хуулийн 17.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжтэй эсэх талаас нь шалгаагүй байх тул түүнээс мотоциклийг авч явсан сэдэлт, санаа зорилгыг дахин асууж, хэрэв цаашид буцааж өгөхгүй байх, зарж борлуулах зорилгогүй байсан нь тогтоогдвол мөрдөн шалгах ажиллагааг зогсоож /хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул/ хэргийг шийдвэрлүүлэх г.м*

3. Хэргийг шийдвэрлэхэд /хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, эрүүгийн хэрэг үүсгэх, хэрэгсэхгүй болгох, яллах дүгнэлт үйлдэх/ эргэлзээ<sup>21</sup> үүсгэж буй нөхцөл байдлыг тодруулах буюу эргэлзээг арилгахад шаардлагатай нотлох баримтыг цуглуулах, яллах эсхүл цагаатгахад /гэмт хэрэгт тооцох эс тооцоход/ чиглэсэн үйл баримтыг сэргээн тогтооход тус тус чиглэнэ. Эдгээр үндсэн гурван нөхцөл байдлаас аль нэгийг дангаар эсхүл нэг болон гурав, эсхүл хоёр ба гурав дахь асуудлыг хамтад нь гүйцэтгүүлэхээр даалгаврыг боловсруулна.

Прокурорын практикт дээрх үндсэн гурван нөхцөл байдлаас ихэнхдээ гурав дахь нөхцөл байдлыг тогтооход чиглэсэн ажиллагаа хийлгэхээр даалгавар бичигдэж байна. Энэ хэсэгт дараах асуудлыг голлон шалгуулах нь ач холбогдолтой.

- Хэргийн оролцогч нарын мэдүүлгийн зөрүүг арилгах, дахин мэдүүлэг авах
- Хохирлыг бодитоор ямар нэг тоо, хэмжээ зөрүүгүйгээр тогтоох
- Шинжээчээс дүгнэлтийг нь тайлбарлуулах, ойлгомжгүй зүйлийг тодруулах
- Эд зүйлийн өмчлөгч эзэмшигчийг нотолсон болон бусад бичгийн нотлох баримтыг цуглуулах
- Туршилт хийх, таньж олуулах
- Нэмэлт болон дахин шинжилгээ хийлгэх
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох зэрэг нэмэлт ажиллагааг хийлгэхэд түлхүү бичигдэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмуудыг хангуулахаар бичих даалгаварт процессийн зөрчлүүдийг арилгаж, хуулийн заалтуудыг хангуулах, хуулийг зөв хэрэглэх<sup>22</sup>, хэргийн оролцогчийн зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн засан залруулах нэмэлт ажиллагааг гүйцэтгүүлдэг. Тухайлбал, хохирогчийг зөв тогтоох, түүний хууль ёсны төлөөлөгчийг тогтоох, солих, хохирлын хэмжээг зөв тогтоолгох, гэрч, хохирогчийг хамгаалалтад авахуулах, шинжээчийн дүгнэлтийг танилцуулах, бусад эрхийг тайлбарлаж мэдүүлэг авах, насанд хүрээгүй этгээдийн эрхийг хангуулах, өмгөөлүүлэх

<sup>21</sup> О.Мөнхцэцэг, Прокурорын тэмдэглэл, УБ., 2021 он, 31 дэх тал.

<sup>22</sup> Прокурорын байгууллагын тухай 1993 он, 2002 оны хуулиудад прокурорын даалгаврын хууль зүйн үндэслэлийг ингэж тодорхойлж байсан нь хуулийн техникийн хувьд 2015 оны хуулиас илүү ач холбогдолтой байсан гэж үзэхээр байна.

эрхээр хангуулах зэрэг мөрдөгчийн хууль зөрчсөн алдааг арилгуулахад чиглэсэн асуудлаар даалгавар бичиж гүйцэтгүүлэх нь түгээмэл. Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.6 дугаар зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Прокурорын даалгаврыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль шатанд үйлдэж байгаагаар нь:

1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад хэргийг хянаж бичсэн даалгавар буюу “ажиллагааны даалгавар”,

2. Мөрдөн шалгах ажиллагааг дуусгаж хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, хэргийг хаах, хэрэгсэхгүй болгох, яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлэх саналаар ирүүлсэн хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр бичсэн даалгавар буюу “нэмэлт ажиллагааны даалгавар”,

3. Эрэн сурвалжлах даалгавар гэж ангилж болно.

Ажиллагааны даалгаварт хэргийн бүрдэл хангуулахад чиглэсэн дээр дурдсан гурван нөхцөл байдлыг тогтоолгохоор холбогдох заалтуудыг бичиж гүйцэтгүүлдэг бол нэмэлт ажиллагааны даалгаварт голдуу процессийн зөрчлүүдийг арилгах, хэргийн оролцогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хуулийг зөв хэрэглэхэд чиглэсэн засан залруулах нэмэлт ажиллагааг гүйцэтгүүлдэг ба заавал бичих онцлогтой.

Харин эрэн сурвалжлах даалгаварт гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг олж тогтоох, гэмт хэргийн халдлагад өртсөн эд хөрөнгийг болон нуугдмал хөрөнгийг олж илрүүлэх, оргон зайлсан хоригдол, хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн бусад ялтныг олж баривчлахад чиглэсэн заалтуудыг бичнэ. Энэ төрлийн даалгаварт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэхэд чиглүүлсэн бөгөөд гэмт хэрэгтний хэв шинж судлал /**профайлинг**/-<sup>23</sup> түлхүү ашиглах шаардлагатай болдог. Тухайлбал орон байрны хулгай, малын хулгайн гэмт хэргүүдийн үйлдсэн цаг хугацаа, үйлдлийн арга барил, хулгайлсан эд зүйлийн нэр төрөл, хулгайд өртсөн объектын онцлог /зөвхөн айлын гэрт нэвтэрдэг, эсхүл малыг хашаанд нядалж махыг авч явдаг г.м/ байдлыг тогтооход гэмт хэрэгтний зан үйл судлал /криминологи/, гэмт хэргийн нотлох баримт судлал /шинжлэн магадлахуй/-д тулгуурлах хэрэгцээ гардаг бөгөөд үүнд нийцүүлэн даалгаврын заалтыг оновчтой, ойлгомжтой, тодорхой бичих ёстой.

Прокурорын тухай хуульд зааснаар даалгаврыг **бичгийн хэлбэрээр** өгч гүйцэтгэлийг тооцдог. Даалгаврыг бичгээр өгдөг учраас түүнд тавигдах шаардлагыг хуулиар тогтоож өгсөн байдаг. Прокурорын тухай хуульд даалгаврыг бичгээр өгнө гэж заасан хэдий ч хэрэгт тавих прокурорын хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх үүднээс прокурор нь хэргийн нотлох баримтыг цуглуулах ажиллагааны явцад мөрдөгчид амаар чиглэл, заалт өгөх нь хяналтын ажлын тогтсон хэвшил болсон байдаг. Амаар өгч буй чиглэл заалт нь хэргийн мөрдөн шалгах ямар ажиллагааг хэдий хугацаанд гүйцэтгэх, цаашид ямар ажиллагааг хийлгэх, тухайлбал шинжилгээ хийлгэх шаардлагатай эсэх гэх мэт ерөнхий шинжтэй заалтууд байдаг бол **бичгээр** өгч буй даалгаварт хэргийн оролцогч тус бүрээс асуух асуултаудыг илүү нарийвчлалтай, логик дараалалтай, тодорхой, ойлгомжтой, оновчтой байдлаар бичих, мөн тухайн ажиллагааны зорилгыг тодорхойлсон /*юуг нотлох*/, биелүүлэх хугацааг заасан байдгаараа ялгаатай.

### **Прокурорын даалгаврын шалгуур ба даалгавар бичих үр чадвар**

Нэгэн хяналтын прокурорын тэмдэглэснээр “Прокурорыг эрүүгийн процессын найруулагч, найрал хөгжмөөр бол удирдаач гэх нь бий. Чухам хэр санаачлагатай найруулагч, удирдаач вэ гэдгийг прокурорын даалгавар гэх баримт бичиг харуулдаг”<sup>24</sup>

<sup>23</sup> Бринт Е. Турвей Эрүүгийн профайлинг, УБ., 2022, 5 дахь тал

<sup>24</sup> О.Мөнхцэцэг. Прокурорын тэмдэглэл, УБ., 2021, 31 дэх тал

гэсэнтэй санал нэг байна.

Прокурорын даалгавар нь нотлох баримтад тулгуурласан, хууль зүйн үндэслэлтэй, хийж гүйцэтгэх ажиллагааг оновчтой, ойлгомжтой, гүйцэтгэх хугацааг тодорхой заасан<sup>25</sup> байна.

Даалгаврыг боловсруулж бичихэд дараахь хоёр **шалгуурыг** хангасан байна.

1. Даалгавраар гүйцэтгүүлж буй ажиллагаа нь тухайн хэрэгт ач холбогдолтой байх,
2. Даалгаврыг ойлгомжтой, оновчтой, тодорхой бичихээс гадна биелэх боломжтой байх гэсэн хуулийн шалгуур тавьдаг.

Энэхүү шалгууруудыг хэрхэн хангасан даалгавар бичихээс л тухайн прокурорын мэргэжлийн ур чадвар ихээхэн шалтгаална. 1928 онд баталсан “Монгол улсын Улаан цэргийн шүүх таслах газрын дүрэм”-ийн Арван долоодугаар зүйлд “... байцаагч нар... **прокуророос даалгасан ёсоор хэргийг байцаах явдлыг гүйцэтгэнэ.**” гэсэн анхны үзэл баримтлалын дагуу мөрдөн шалгах ажиллагааг прокурор удирдан чиглүүлж ажилладаг тул түүнээс мэргэжлийн өндөр ур чадвар, эрүүгийн эрх зүйн онолын мэдлэг, төсөөлөн бодох чадвар, санаачлага, идэвхи зүтгэл шаардана.

Дээрх хоёр шалгуурын аль нэгийг хангаагүй бол уг даалгавар хууль зүйн ач холбогдлоо алдах ба даалгаврын заалтыг бүрэн гүйцэтгэх боломжгүйд хүрнэ.

Хэрэгт ач холбогдолтой байх шалгуур нь гүйцэтгүүлэхээр өгч буй заалтууд тухайн хэрэгт хамааралтай байх, уг ажиллагааг нөхөн гүйцэтгэснээр хэргийн үйл баримтыг тодорхойлоход нотлох баримтын хүрэлцэхүйц байх шаардлагыг агуулсан байх ёстой юм.

Даалгаврыг **ойлгомжтой** бичих гэдэг шаардлагын агуулга нь тухайн даалгаварын заалтаар ямар ажиллагааг /шинээр нотлох баримт цуглуулах эсхүл мэдүүлгийн зөрүүг арилгах, эсхүл процессын зөрчлийг арилгах/ гүйцэтгэх, ингэснээр хэргийн аль шинжийг /объектив ба субъектив/ нотлох гэж байгааг харуулахад чиглэнэ. *Жишээлбэл: 1. Д-ээс дараахь асуултаар мэдүүлэг авч түүний сэдэлт, санаа зорилгыг тодорхойлох нь хэргийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой байна. Үүнд: -Танд иргэн Ц-ээс 2020-02-20-ний өдөр шилжүүлсэн 10 сая төгрөгөөр ямар төрлийн түүхий эд авч өгөхөөр тохиролцсон бэ? Ноолуур нийлүүлэхээр тохирсон уу? адууны дэл сүүл нийлүүлэх ёстой мөнгө байсан юм уу? гэх мэт.*

Энд дурдсан жишээнд тухайн этгээдээс асууж буй асуултууд нь чухам ямар зорилготой болохыг ойлгомжтой зааж өгсөн байна. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгт холбогдуулан шалгагдаж буй хүний сэдэлт, санаа зорилгыг тогтооход чиглэсэн асуулт тавьж улмаар энэ үйл баримт нь иргэний эрх зүйн харилцааны шинжтэй факт, эсхүл залилан мэхлэх гэмт хэргийн субъектив шинжийг хангасан гэмт үйлдэл эсэхийг тогтооход чиглэсэн нь мөрдөгчид ойлгомжтой байна.

Даалгаврыг хэт ерөнхий байдлаар бичих нь /*жишээ нь Б. Д. А нараас дахин мэдүүлэг авах г.м/* ойлгомжгүй байдалд хүргэхээс гадна яллагдагч, шинжээч, хохирогч, гэрчүүдээс мэдүүлэг авахад тавих асуултыг зөв тодорхойлох, эхлээд хэнээс нь мэдүүлэг авах, нэг хүнд тавих хэд хэдэн асуултуудыг нэг дор тавьж авах уу эсхүл нэг нэгээр нь тавьж хариултыг бичсэний дараа дараагийн асуултыг тавих байдлаар мэдүүлэг авах талаар зааж өгөх нь **оновчтой** байх шалгуурыг хангана. Жишээ нь: ... Яг яаж зодолдож байсан бэ? Машин дотор тэр хоёр маргалдаж хоорондоо зодолдоод байсан гэсэн тул яг ямар үг өгүүлбэр хэлж маргалдсан бэ, хэн нь уг маргааныг эхлүүлсэн бэ? яаж хоорондоо зодолдсон бэ? эхнэр нь нөхрөө яаж зодож ямар үйлдэл хийж гар хүрсэн бэ? нөхөр нь ямар үйлдэл хийж эхнэрээ яаж зодож байсан бэ? Таны ажигласнаар хэн нь хэнийгээ дийлж байсан бэ? маргааны сэдэв юу байсан бэ? тэр үед охин нь хэний өвөр дээр сууж явсан бэ? тэр охин уйлсан уу? Талийгаачийг хутгалах тэр үед охин нь хаана байсан бэ? Х нь хутгыг аваад түлхэж байх үед хутга орчих шиг болсон гэж мэдүүлсэн. Энэ талаар та яг мэдэж байгаа зүйлээ хэлнэ үү?

<sup>25</sup> Дотоод хэргийн их сургууль, Эрүүгийн процессын эрх зүй. Ерөнхий, тусгай анги, УБ., 2021, 389 дэх тал.

талийгаач Т нь гэр лүү орсон уу? Ороод гарч ирсний дараа араас нь Х гарч ирж ноцолдсон юм уу? та сайн санаж байгаад тодорхой хэлнэ үү. Та үйл явдлыг дэс дараатай сайн санаж хэлээрэй гэж зөвлөж аль болох тайван байлгаж яаралгүй, *асуулт бүрийг нэг нэгээр тавьж хариулсны дараа дараагийн асуултыг тавьж* мэдүүлэг авах хэрэгтэй.

Энэ жишээнд гэмт хэрэг үйлдэгдэх үед хажууд нь байсан гэрчид тавих асуултыг оновчтой тогтоож, яаж хэрхэн мэдүүлэг авахыг заасан нь ойлгомжтой, тодорхой бичих хуулийн шаардлагыг хангасан байна.

Хэрэгт хамааралтай нөхөн хийх ажиллагааг нэг бүрчлэн заасан байдал нь даалгаврын **тодорхой** байх шалгуурыг хангадаг. Жишээ нь: 2. Гэрч Б-ийн мэдүүлэгт 22 цаг 20 минутын орчимд УБ-аас АХ чиглэлд явж байгаа ачааны автомашины гэрэлд явган хүн гүйж явсан байдаг. Тэгэхээр хяналтын постоор 22 цаг 20 минутын орчмоос хойшхи нэвтэрсэн тээврийн хэрэгслүүдийг энэ хэрэгт холбогдуулан шалгах ба ингэхдээ 2 цагаан машиныг шалгах хэрэгтэй. Учир нь гэрч Б ... дугуй хагарч байгаа юм шиг хүчтэй тас хийсэн дуу гарсан, би тухайн үед уг 2 цагаан тэрэгний аль нэгнийх нь дугуй хагарлаа гэж бодож байтал тухайн 2 цагаан машин зогсолгүй шууд цааш явсан гэж мэдүүлсэн байх тул 22 цаг 20 минутаас хойш өнгөрсөн 2 цагаан өнгийн жижиг тээврийн хэрэгслийн аль нэг талийгаачийг дайрсан байх магадлал өндөртэйг анхаарч хэргийг шалга. г.м

Даалгавар нь **биелэх боломжтой** байх бөгөөд хийж гүйцэтгэх ажиллагааны цар хүрээ, орон зай,<sup>26</sup> техник технологийн болон цаг үеийн /цар тахалтай хөл хорио тогтоосон, эсхүл баяр наадмын өдрүүд таарсан г.м/ нөхцөл байдлыг харгалзан даалгаврыг биелүүлэх хугацааг тогтоож өгнө. Даалгаврыг биелэлтийг тооцохоор тогтоосон цаг хугацаандаа заалт нэг бүрээр тооцож тухайн даалгавраар тогтоогдсон нотлох баримтуудыг үнэлэх нь даалгавар бичихээсээ илүү ач холбогдолтой байдаг. Хэрэв даалгаврыг тогтоосон хугацаандаа заалт бүрээр тооцохгүй орхивол даалгавар бичсэний ач холбогдол, үр дагавар байхгүй болно.

Хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад бичиж буй “ажиллагааны” даалгаврыг мөрдөн шалгах ажиллагааны аль шатанд нь бичиж чиглүүлэх нь тухайн хэрэгт хяналт тавьж буй прокурорын туршлага, ур чадвараас ихээхэн хамаарна. Нөгөө талаар хэрэг шалгах арга тактиктэй ч холбоотой. Хэрэг бүртгэлтийн ажиллагааны явцад ямар ажиллагаа хийлгэх, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан даруйд нь заалт өгөх эсэх, мөрдөгчийн ур чадварыг бүрэн дайчилж мөрдөн шалгах ажиллагааг хийлгэсний дараа хэргийг татаж хянаад даалгавар бичих үү гэдгийг тухайн хэргийн үйл баримт, шинжээс хамаарч тодорхойлдог.

Мөрдөгчийн мэргэжлийн ур чадвар, туршлага, ажлын арга барил, хандлага зэргээс хамааралтайгаар хэдийд нь даалгавар буюу заалт өгөх вэ гэдгийг тодорхойлж болно. Зарим мөрдөгч даалгаврын дагуу шуурхай ажиллаж гүйцэтгэх ажиллагаануудыг бүрэн хийж байхад эсрэгээрээ даалгаврын заалтыг хангуулж чаддаггүй, хугацаа хэтрүүлдэг нь ч байдаг. Туршлагатай прокурорууд бичсэн даалгаврынхаа агуулга, ач холбогдлыг мөрдөгчид ойлгуулан тайлбарлаж, хэрхэн яаж гүйцэтгэх аргачлал, дараалал болон заалтын дагуу ажиллагаа хийх явцад гаргаж болох алдааг эхнээс нь анхааруулж өгдөг ба ингэснээр даалгавар бүрэн төгс биелэх нөхцөл бүрддэг. Үүнтэй холбоотойгоор туршлагатай прокурорын бичсэн хуулийн шаардлага хангасан даалгавар нь туршлага багатай, мөрдөх ур чадвар сул мөрдөгчийг ажил мэргэжилдээ дадлагажих, улмаар мөрдөн шалгах ажиллагааны ур чадварыг нь нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц өгдөг<sup>27</sup> ач холбогдолтой байдаг.

Прокурорын байгууллагын өнөөгийн практикт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад хянаж бичгээр даалгавар өгч мөрдөн шалгах ажиллагааг удирдан чиглүүлэх ажлыг

<sup>26</sup> Б. Амарбаясгалан, М. Мөнхбат. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /шүүхийн өмнөх болон шүүхийн шат/ сургалтын хэрэглэгдхүүн, УБ., 2018, 79 дэх тал.

<sup>27</sup> Мөрдөгч нараас авсан санал асуулгад “... мөрдөгчийн олж хараагүй зүйлийг илрүүлж, шинэ санаа өгч хэрэгт ач холбогдолтой нотлогоог бий болгодог учраас цаашид ч даалгавар бичүүлж ажиллахыг хүсэж байна” гэсэн санал давамгайлсан байна.

нэмэгдүүлэх эрмэлзлэлтэй байдаг нь зарим талаар чанаргүй олон даалгавар бичихэд хүргэж болзошгүй байдалд хүргэх сул талтай. Тухайн хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд ач холбогдол багатай нэмэлт ажиллагаа хийлгэхээр даалгавар бичиж хүргүүлснээр мөрдөгч нь даалгаврыг заавал биелүүлэх хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулж гэмт хэргийг шуурхай илрүүлж, хүний зөрчигдсөн эрхийг богино хуацаанд сэргээн тогтооход сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүсч болно.

Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоолыг мөрдөгчид хүргүүлэхдээ бичгээр даалгавар өгч хамт хүргүүлж байгаа нь прокурор мөрдөн шалгах ажиллагааг удирдан чиглүүлж байгааг харуулах боловч нөгөө талдаа мөрдөгч хэргийн нотлох ажиллагааг бие даан мэргэжлийн ур чадвараа дайчлан ажиллах идэвхи сонирхлыг бууруулах сөрөг талтай байж болно. Ялангуяа туршлагатай мөрдөгчийн хувьд тухайн хэрэгт ямар нотлох ажиллагаа явуулах талаар урьдчилан төлөвлөсөн байдаг бөгөөд прокурорын даалгавар бичсэн ч эс бичсэн ч хэргийг мөрдөн шалгах ажиллагааг тал бүрээс нь бүрэн бодтойгоор шалгаж, яллах болон цагаатгах талын нотлох баримтыг эргэлзээгүй тогтоох ур чадвартай байна. Тийм учраас прокурорын даалгаврыг хэрэг бүрт хавтгайруулан бичих биш, харин уг хэрэгт “зарим ажиллагаа хийлгэхээр заалт өгөх” гэсэн анхны агуулгаар нь хэрэглэх нь илүү ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад татаж хянах, хэргийг хаах, хэрэгсэхгүй болгох, шүүхэд шилжүүлэх саналаар ирүүлсэн үед хянаж бичгээр даалгавар өгөхөд зарим нэмэлт ажиллагаа хийх, ямар нотлох баримтыг нэмж цулуулж бэхжүүлэх талаар мөрдөгчийн олж хараагүйг харж, дутуу ажиллагааг гүйцэтгүүлэх нь даалгаврын үндсэн зорилгод нийцэх юм.

#### **Прокурорын даалгаврын онцлог**

Прокурор, мөрдөгч нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалар, зөрчигдсөн эрхийг сэргээх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зорилтыг хамтран хэрэгжүүлэх **эрх зүйн хэрэгсэл** нь болдогоороо прокурорын даалгаврын нэг онцлог илэрнэ. Мөрдөгч, прокурор нь нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодтойгоор нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтоох үүрэгтэй. Прокурор энэ үүргээ хэрэгжүүлэхдээ мөрдөгчид бичгээр даалгавар /заалт/ өгч мөрдөн шалгах ажиллагаанд хамтран оролцож чиглүүлж ажиллаж байна.

Прокурорын тухай хуульд зааснаар даалгаврыг эрүүгийн хэрэгт /зөрчлийн хэрэг, ялтны хувийн хэрэг/ хавсаргадаггүй. Хэрэгт процесс ажиллагааны явцад хуульд заасан журмаар цуглуулсан баримтат мэдээллийг хавсаргахаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулсан байна. Энэхүү баримтат мэдээлэл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 16.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мөрдөгчийн магадлагаа, гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, тэмдэглэл зэрэг уг хуульд заасан бусад баримтаар тогтоогдоно. Эдгээр баримтад мэдээллийг хэрхэн цуглуулж бэхжүүлэхийг зааж зааварласан, мөрдөгчид нотлох баримт хэрхэн цуглуулах талаар мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлсэн заалт бөгөөд нотлох баримтаар үнэлэгдэхгүй тул даалгаврыг **хэрэгт хавсаргадаггүй** онцлогтой баримт бичиг юм.

Прокурорын даалгаврын өөр нэг онцлог нь зарим тохиолдолд **заавал бичих** ёстой байх явдал юм. Мөрдөн шалгах ажиллагааг дуусгаж хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, хэргийг хаах, хэрэгсэхгүй болгох, яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлэх саналаар ирүүлсэн хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэргийг мөрдөх байгууллагад буцаасан тохиолдолд даалгаврыг заавал бичнэ. Хэрэг бүртгэлтийн хаасан хэргийг болон түдгэлзүүлсэн хэрэг, хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээсэн тохиолдолд даалгаврыг заавал бичнэ.



## ДҮГНЭЛТ

Дээр дурдсанаас үзэхэд прокурор эрүүгийн процессын зорилтыг хангуулахад прокурорын даалгавар онцгой үүрэгтэй баримт бичиг болох нь тодорхой байна. Эрүүгийн хэргийн нотлох баримт нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болдог бөгөөд нотлох баримтын хүрэлцээтэй байдал бүрдсэн тохиолдолд хэргийг хэлэлцэж, нотлох баримтын хангалттай байдалд үндэслэн хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн тогтоох нь шүүхээс хууль ёсны, үндэслэлтэй шийдвэр гаргахад чухал нөлөө үзүүлдэг. Чухам энэ нөхцлийг хангахын тулд прокурор шүүхийн өмнөх шатанд эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааг байнгын тасралтгүй хянаж, удирдан чиглүүлж, хуулийн заалтыг хангуулах, шаардлагатай ажиллагааг нөхөн гүйцэтгүүлэх зорилгоор даалгавар бичдэг ба энэ нь шүүхийн шийдвэр үндэслэл бүхий гарахад буюу хэргийн бодит байдлыг зөв тогтоож, шүүгдэгчийг гэмт буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэх урьдач нөхцлийг бүрдүүлдэг хууль зүйн чухал ач холбогдолтой баримт бичиг юм.

Прокурор нь эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааг бүх талаас нь бүрэн дүүрэн хянаж, нотлох баримт бүрийг зөв үнэлж чадсан эсэхийг тодорхойлох гол шалгуур нь даалгавраа хэрхэн чанартай оновчтой, ойлгомжтой, тодорхой, биелэх боломжтой байдлаар бичиж чадсан эсэхээс шууд хамааралтай байж болно. Ийм чадвар, туршлага, мэдлэг дутагдлаас тухайн хэрэг шүүхээс буцах үндэслэл болох бөгөөд прокурорын мэргэжлийн алдаанд тооцогдох ба ингэснээр хэргийн оролцогчийн эрх тодорхой хэмжээгээр зөрчигдөхөд хүрдэг.

Иймд даалгаврыг туйлын оновчтой бөгөөд тухайн ажиллагааг хийснээр шүүхийн өмнө төрийн өмнөөс яллах чиг үүргээ хэрэгжүүлэхэд өөрт хэрэгтэй бүхнийг хавтаст хэрэгт бүрэн бэхжүүлж авсан байхад чиглүүлэн хэргийн үйл баримттай нягт уялдаатай, логик дэс дараалал, хамааралтай байхаас гадна даалгаврын заалтыг биелүүлэхгүй байхын аргагүй байдлаар бичих ёстой. Тиймээс даалгавар бичих нь прокуророос мэргэжлийн ихээхэн өндөр ур чадвар шаардах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй даалгавар бичвэл мөрдөгч түүнийг биелүүлэх гэж сэтгэл гаргахгүй бөгөөд даалгаврын үр нөлөө, үнэ цэнэ нь буурахад хүргэнэ. Үүнтэй холбоотойгоор прокурор эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааг удирдан чиглүүлэх чиг үүрэг болон мөрдөгчийн бие даасан байдлын хоорондын харьцаанд даалгаврын үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг улсын хэмжээнд суурь байдлаар судалж үзэх нь онол практикийн олон талын ач холбогдолтой гэж үзэж байна. Ингэснээр мөрдөн шалгах ажиллагаан дахь салбарын амбиц давамгалж чанаргүй олон даалгавар бичиж мөрдөгчийн бие даасан, хараат бус байдалд сөргөөр нөлөөлж байгаа эсэхийг тодорхойлж даалгаврын хууль зүйн агуулга, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах боломжтой.

Цаашид Прокурорын тухай хуулийн 33 дугаар зүйлийг “... хуулийн заалтуудыг хангуулах талаар тодорхой ажиллагаа гүйцэтгүүлж, баримт, мэдээлэл цуглуулахаар” гэж өөрчлөн найруулах нь прокурорын хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилтод нийцнэ.



---

## ЭХ СУРВАЛЖ

1. Прокурорын байгууллагын түүхэн товчоон, 1930-2020, УБ., 2020 он.
2. Монгол улсын Прокурорын байгууллагын хууль тогтоомжийн түүхэн эх сурвалж. Эмхтгэл. УБ., 2020 он.
3. Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. (1911-2009) УБ., 2012 он.
4. Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар, УБ., / хэвлэгдсэн он тодорхойгүй/
5. Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан, Прокурорын хяналт, УБ., 2009 он, 89 дэх тал
6. О.Мөнхцэцэг, Прокурорын тэмдэглэл, УБ 2021 он.
7. Дотоод хэргийн их сургууль, Эрүүгийн процессын эрх зүй, Ерөнхий, тусгай анги, УБ., 2021 он.
8. Б.Амарбаясгалан, М.Мөнхбат, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа / шүүхийн өмнөх болон шүүхийн шат/ сургалтын хэрэглэгдхүүн, УБ., 2018 он.
9. Бринт Е. Турвей. Эрүүгийн профайлинг /орчуулгын бүтээл/, УБ., 2022 он.

## THE SIGNIFICANCE, NATURE, TYPES, FORMS, AND FEATURES OF PROSECUTORIAL INSTRUCTIONS

*Batsukh T. /LL.M./*

*Chief Prosecutor of the District Prosecutor's Office in Kharkhorin Sum,  
Uvurkhangai Province*

### **ABSTRACT:**

One of the primary means of prosecutorial control in pre-trial proceedings is the pursuit of facts related to supporting evidence. Investigative supervision of prosecutors is carried out to prevent errors in the operation of the process, to prevent the conduct of the investigation, and to monitor and gather evidence in full.

### **KEYWORDS:**

Criminal proceedings, Collection of evidence, supervision of the prosecutor, Types of organization of the prosecutor.

**МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТРЫН ГАДААД ГЭРЭЭНЭЭС  
ҮҮДЭЛТЭЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ,  
ДОТООДЫН АЖ АХУЙН НЭГЖИЙН МАРГААН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ  
ЭРХИЙГ ХАНГАХ АРГА ЗАМ**



*Б.Дэлгэржаргал  
“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хуульч,  
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант*

**ТОВЧЛОЛ:**

Уг өгүүлээр Монголын Олон Улсын Арбитрын маргаан шийдвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэхийн сацуу гадаад элемент оролцсон дотоодын аж ахуйн нэгжийн гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлүүлэх эрхийг хангах арга замуудыг судалж, танилцуулсан болно.

**ТҮЛХҮҮР ҮГС:**

Монголын Олон Улсын Арбитр, Дотоодын аж ахуйн нэгжийн маргаан шийдвэрлүүлэх эрхийн хамгаалалт, Маргааны харьяалал сонголт, ЮНИДРОЙТ-ын зарчим.

**ОРШИЛ**

Дотоодын аж ахуйн нэгжүүдийн хувьд гадаад гэрээний харилцаанаас үүдэлтэй маргаан шийдвэрлүүлэх эрхээ практикт эдэлж чадахгүй байх тохиолдол түгээмэл байна. Үүний улмаас эдийн засгийн хувьд хохирол хүлээхээс гадна Монголын Олон Улсын Арбитрын “боломжит” маргаан шийдвэрлэлтийн хувь хэмжээг нэлээд хэмжээгээр бууруулж байгаа юм. Энэ нь олон хүчин зүйлээс үүдэлтэй бөгөөд манай улсын хувьд зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлын нэг билээ. Учир нь аль нэг улсад байгуулагдсан “Олон улсын арбитр” нь үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэх эхлэлийн цэг нь дотоодын аж ахуйн нэгжийн гадаад гэрээний харилцаанаас үүдэлтэй маргаануудыг амжилттай шийдвэрлэх замаар маргаан шийдвэрлэлтийн хэмжээгээ нэмэгдүүлэх явдал байдаг.

Энэхүү практикт тулгамдаж буй асуудлыг шийдэх үндсэн арга зам нь харьцуулсан судалгааны үндсэн дээр онол, практикийн сайн туршлагыг олж авах, боломжит шийдлийг өөрсдийн онцлогт нийцсэн шинэ санаагаар баяжуулан сайтар нутагшуулах явдал гэж үзэж байна.

## ҮНДСЭН ХЭСЭГ

### 1. Дотоодын аж ахуйн нэгжүүдийн гадаад гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлүүлэх эрх хангагдахгүй байгаа шалтгаан

#### 1.1. Маргааны харьяалал сонголт

Манай компаниуд гадаадын аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулахдаа маргаан шийдвэрлүүлэх харьяаллын тухайд практикт хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байдлаар гэрээндээ тусгаж буй нь уг эрх хангагдахгүй байх үндсэн шалтгаан болж байна. Тухайлбал:

- Монгол Улсад салбар төлөөлөгчийн газаргүй аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээнд маргааны харьяаллыг Монгол Улсын шүүх шийдэхээр тохирох
- Талуудын сонгосон гадаадын олон улсын арбитрын зардал Монголын Олон Улсын Арбитрын зардалтай харьцуулахад өндөр<sup>1</sup>
- Гадаадын Олон Улсын Арбитрууд амьжиргааны өртөг өндөр хотуудад<sup>2</sup> байрладгийн улмаас томилолтын зардал өндөр
- Гадаадын арбитраар маргаан шийдвэрлүүлэхтэй холбоотой зөвлөх үйлчилгээ, өмгөөллийн хөлс өндөр
- Гадаадын арбитраар маргаан шийдвэрлүүлэх явцад бизнесийн үйл ажиллагаа доголдохоос сэргийлж маргах сонирхолгүй болох (аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа хүний нөөцтэй холбоотойгоор доголдох, эргэлтийн хөрөнгө тасалдах г.м санхүүгийн шалтгаанаар маргах боломжгүй болох)

#### 1.2. Маргааны харьяаллыг ашигтайгаар тогтоож чадахгүй байгаа шалтгаан

- *Гэрээний харилцаанд өөрийн эзэлж буй байр суурийг зөв үнэлэхгүй байх:* Жишээ нь, дотоодын аж ахуйн нэгжүүдийн хувьд дийлэнх нь импортын гэрээгээр гадаадаас бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг авч өртөг нэмж дотооддоо борлуулах байдлаар үйл ажиллагаа явуулдаг. Ийнхүү импортлогч тал атлаа маргааны харьяаллын талаар санал гаргахгүй, эсхүл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлэх санал гаргаж байгаа нь маргаан шийдвэрлүүлэх харьяаллыг тогтоох хэлэлцээрийг амжилтгүй болгож байна.
- *Маргааныг Монгол улсад олон улсын арбитраар шийдвэрлэх боломжтой талаар мэдлэг, мэдээлэлгүй байх;*
- *Хэлэлцээрийн явцад маргааныг шийдвэрлүүлэхээр Монголын Улсын хуулийг сонгох:* Энэ тохиолдолд нөгөө тал маргааныг шийдвэрлэх олон улсын арбитрыг сонгох эрхийг хариуд нь олж авч байна. Гэтэл бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ борлуулах гэрээг байгуулахдаа талууд гэрээний харилцааг маш дэлгэрэнгүй зохицуулсан нийтлэг эрх зүйн тогтолцоот орнуудад хэрэглэгддэг загвар гэрээ ашиглах нь түгээмэл байна. Тэрхүү загвар гэрээ нь заавал дагаж мөрдөх хэм хэмжээ (mandatory rule) ихээр агуулсан манай иргэний хуульд нийцэхгүйн улмаас хүчингүй болох эрсдэл ажиглагдаж байлаа. Энэ тохиолдолд маргаан шийдвэрлэх харьяалал сонгох эрхээ нөгөө талд шилжүүлж, маргаан шийдвэрлэх хуулийг өөрийн орны хуулиар сонгосон нь сул тал болж байгаа юм.

#### 1.3. Дотоодын аж ахуйн нэгжүүдийн гадаад гэрээний маргаан шийдвэрлэх харьяалал, хуулийг сонгосон бодит жишээ

Өгүүлэлд дурдагдаж буй дотоодын аж ахуйн нэгжүүдийн гэрээг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны явцад олж авсан (заримыг нь боловсруулж, байгуулах хэлцэлд оролцсон) бөгөөд нэрийг нь нийтлэхийг тухайн аж ахуйн нэгжүүд зөвшөөрөөгүй тул үсгээр орлуулж, нууцлав.

<sup>1</sup> Хонг Конгийн Олон Улсын Арбитрын төвийн байнгын арбитрын үндсэн зардал 50 мянган ам.долларын маргаан тутамд 2538,93 ам доллар байхад Монголын Олон Улсын Арбитрын үндсэн зардал 690 ам доллар байна.

<sup>2</sup> 2020 оны амьжиргааны өртөг хамгийн өндөр хотуудаар Хонг Конг №1, Сингапур №5, Бээжин №10, Москва №21 тус тус тодорчээ. Эх сурвалж: <https://www.mercer.com/newsroom/2020-cost-of-living.html>

№	ААН-ийн нэр	Гэрээний төрөл	Харилцагч ААН-ийн харьяалах улс	Маргаан шийдвэрлэх хууль	Маргаан шийдвэрлэх харьяалал
1	“А” ХХК /тоног төхөөрөмжийн худалдаа эрхэлдэг/	Худалдах худалдан авах	БНХАУ	Монгол Улсын Иргэний хууль	Хонг Конгийн Олон Улсын Арбитрын Төвийн байнгын арбитраж
2	“Б” ХХК / технологийн чиглэлээр/	Худалдах худалдан авах	БНХАУ /Үндэстэн дамнансан корпораци/	Бараа худалдах тухай гэрээний олон улсын Венийн конвенц (1980) /CISG/	Сингапур дахь Олон Улсын Арбитрын төв (SIAC)
3	“В” ХХК / Барилгын төсөл хэрэгжүүлэгч/	Ажил гүйцэтгэх гэрээ /Барилгын зураг төсөл/	БНХАУ	Монгол Улсын холбогдох хууль тогтоомжууд	Хонг Конгийн Олон Улсын Арбитрын Төвийн байнгын арбитраж
4	“Г” ХХК / Барилга угсралтын компани/	Худалдах худалдах авах	БНХАУ /Монгол Улсад салбар төлөөлөгчийн газаргүй компани/	Монгол Улсын холбогдох хууль тогтоомжууд	Монгол Улсын шүүх
5	“Д” ХХК / Гадаад худалдаа/	Худалдах худалдан авах	БНСУ	Гуравдагч этгээдийн хууль	Гуравдагч улсад байрлах Олон Улсын Арбитраж
6	“Е” ХХК	Түрээс	ОХУ-ын Ерөнхийлөгчийн хэрэг эрхлэх газрын дэргэдэх Хилийн чанад дахь Өмчийн газар	Монгол Улсын хууль тогтоомж	Москва дахь Олон Улсын Худалдааны Арбитрын шүүх (ICAC)

## 2. Дотоодын аж ахуйн нэгжүүдийн гадаад гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлүүлэх эрхийг хангах арга зам

### 2.1. Импортлогч талын давуу байдлыг эдэлж маргааны харьяаллыг сонгох

Импортлогч тал болохын хувьд дотоодын аж ахуйн нэгжүүд хэлэлцээрийн шатанд маргаан шийдвэрлүүлэх харьяаллын талаар эхэлж санал гаргахдаа Монголын Олон Улсын Арбитрыг сонговол зохино. Учир нь 2017 онд шинээр батлагдсан “Арбитрын тухай хууль” нь НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн хорооноос боловруулсан “Олон улсын худалдааны арбитражын загвар хууль”-д нийцсэн тул дэлхийн жишиг хууль гэж үзэж болно. Нөгөөтээгүүр манай орны гадаад худалдааны дийлэнх хэсгийг бүрдүүлдэг<sup>3</sup> улсуудын (БНХАУ, ОХУ) иргэншилтэй гадаад арбитражид Монголын Олон Улсын Арбитрын бүрэлдэхүүнд байдаг<sup>4</sup> тул арбитражын бүрэлдэхүүн тэнцвэртэй байх шалгуурыг бүрэн хангана.

2.2. Маргаан шийдвэрлэх хуулийг сонгохдоо харилцан ашигтай шийдлийг танилцуулах

В-2-В<sup>5</sup> гэрээний талууд гэрээний эрх чөлөөг хамгийн боломжит дээд хэмжээнд эдлэх хүсэлтэй байдаг. Учир нь аль аль нь ашгийн төлөө аж ахуйн нэгжүүд байх тул хоорондын харилцаагаа өөрсдийн тохиролцсон дүрмээр зохицуулахыг эрмэлзэх нь тодорхой. Гэтэл бизнесийн маргааныг аль нэг улсын хуулиар шийдвэрлүүлэх нь гэрээний эрх чөлөөг талуудын хүсээгүй хэмжээгээр хязгаарлах шалтгаан болдог. Иймд талуудын тохиролцоогоор өөрчлөх боломжгүй императив хэм хэмжээ ихтэй эх газрын эрх зүйт орны хуулийг талууд сонгох хүсэлгүй байдаг хэдий ч өөр бусад орны танил бус хуулиар маргаанаа шийдвэрлүүлснээс өөрийнхөөр шийдвэрлүүлэх нь дээр гэх хандлага нийтлэг

<sup>3</sup> Монгол улс 2020 онд БНХАУ-аас 35.8%, ОХУ-аас 26.4%, Японоос 7.7%, БНСУ –аас 4.5%-д тус тус ноогдох хувь хэмжээгээр импортлосон байна. Эх сурвалж: Гадаад харилцааны яамнаас гаргасан “Монгол Улсын худалдаа, эдийн засгийн тоон статистик 2020.”

<sup>4</sup> <https://arbitr.mn/index.php/about-us>

<sup>5</sup> Business-to-Business Аж ахуйн нэгж аж ахуйн нэгжтэй байгуулдаг гэрээ

байна.

Иймээс маргаан шийдвэрлэх хуулийг сонгоходоо гэрээний зохицуулалтууд онцгой давуу хүчинтэй байхаар тохиролцож, гагцхүү гэрээний заалтыг зайлшгүй тодруулах, тайлбарлах шаардлага тулгарсан нөхцөлд ЮНИДРОЙТ<sup>6</sup>-ийн зарчмуудыг хэрэглэхээр тохирох нь талуудын гэрээний эрх чөлөөт байдлыг хэрэгжүүлэх хүсэл зоригт бүрэн нийцнэ.

Өдгөө дэлхий нийтээрээ судлан, хөгжүүлж, хэрэглэж буй Soft Law буюу заавал дагаж мөрдөх шинжийг агуулдаггүй хэм хэмжээ бүхий зохицуулалтууд олон бий. Эдгээрээс ЮНИДРОЙТ-ийн зарчмуудыг онцолсон нь дараах шалтгаантай. Үүнд:

- Эрх зүйн тогтолцоо, улс төрийн дэглэм, чиг баримжаа үл хамааран гэрээний эрх зүйг ижилтгэх зорилгоор хамгийн түгээмэл шинжтэйгээр нийтлэг зохицуулалтуудыг эмхэтгэж зохиосон.
- Зарчмуудын бүтцийг эх газрын эрх зүйн хуулиудтай төсөөтэй байдлаар зохиосон нь манай хуульчдад хэрэглэхэд дөхөм байна.
- Зарчмуудын зүйл, заалт бүрээр тайлбар, жишээг бэлтгэж нийтэлсэн нь нэг мөр маргаангүй хэрэглэх боломжийг олгодог.

Үүнээс гадна авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа чухал арга хэмжээ нь Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас гишүүнчлэл бүхий аж ахуйн нэгжүүдэд бүтээгдэхүүн үйлчилгээний зэрэглэл хамаарахгүйгээр гадаад гэрээний арбитрын хэлэлцээрийн хэсэгт маргаан шийдвэрлэх хууль, болон харьяаллыг сонгох, ийнхүү сонгох хэлэлцээрт бэлтгэх талаар зөвлөгөө мэдээллийг агуулсан сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж, танилцуулах, санал болгох, сургалт зохион байгуулах нь дээр дурдсан бэрхшээлийг дотоодын аж ахуйн нэгжүүд амжилттай даван туулах боломжийг олгоно гэж үзэж байна.

### **3. Дотоодын аж ахуйн нэгж дундын компани ашиглах замаар маргаан шийдвэрлүүлэх эрхээ эрсдэлгүй хадгалах оролдлого (бодит кэйс)**

Дотоодын зарим аж ахуйн нэгжүүд гадаад гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэлтийг хөнгөвчлөх зорилгоор дундын компани (дотоодын аж ахуйн нэгж) ашиглах үзэгдэл ажиглагдаж байна. Дундын компани гадаадын аж ахуйн нэгжээс бараа, бүтээгдэхүүний өмчлөлийг шилжүүлэн авсны дараа анх захиалга өгсөн дотоодын аж ахуйн нэгжид өмчлөлийг шилжүүлдэг. Энэ нь өртөг нэмж бараа, бүтээгдэхүүн борлуулж буй ердийн үзэгдэл мэт санагдаж болох ч захиалга өгөхөөс эхлээд бараа, бүтээгдэхүүн хилийн чанадаас ачигдах бүх процесс дотоодын аж ахуйн нэгжийн хяналтад явагдаж буй юм. Үүнээс дүгнэвэл зуучлалын гэрээний шинжийг зарим талаар агуулж байх боловч өмчлөлөөс өмчлөлд шилжүүлж буй тул дундын компани нь зөрүү өртгөөс олж буй ашгаараа гадаадын аж ахуйн нэгжийн бараа, бүтээгдэхүүний доголдолтой холбоотой эрсдэлийг хүлээж байгаа юм.

Дотоодын аж ахуйн нэгж болон дундын компанийн хооронд бараа бүтээгдэхүүний доголдолтой холбоотой гэрээний үүргийн зөрчлийг шийдвэрлэх маргаан Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимд хэлэлцэхээр товлогдсон байгаа. Энэ тохиолдолд дотоодын аж ахуйн нэгж Монгол Улсын шүүхээр эрхээ хамгаалуулах ч дундын компанийн гадаадын олон улсын арбитраг хандах боломж дээр дурдсанчлан бэрхшээлтэй байх тул том зургаараа дотоодын аж ахуйн нэгжийн маргаан шийдвэрлүүлэх эрх хангагдахгүй байх үр дагавар хэвээр байна.

## **ХАРЬЦУУЛАЛТЫН ХЭСЭГ**

Энэ хэсэгт дотоодын аж ахуйн нэгжүүдтэй гэрээний харилцаанд хамгийн их орж байгаа хоёр улсыг сонгон авч тэдгээрийн гэрээний эрх зүйтэй холбоотой үндэсний хууль

<sup>6</sup> The International Institute for the Unification of Private Law буюу Хувийн эрх зүйг ижилтгэх зорилго бүхий олон улсын байгууллага

тогтоомж, дотоодын шүүх, арбитрагт ЮНИДРОЙТ-ийн зарчмууд ямар нөлөөтэй байгааг судлан тогтоох болно. Энэ нь үндсэн хэсэгт дурдсан маргаан шийдвэрлэх хуулийг сонгоход нөгөө тал нааштай хандах боломжтойг нотлох ач холбогдолтой юм.

1. БНХАУ дахь үндэсний хууль тогтоомж, шүүх, арбитрагт ЮНИДРОЙТ-ийн зарчмуудын эзлэх байр суурь, нөлөө

БНХАУ-ын Олон Улсын Эдийн засаг, Худалдааны Арбитрын Хорооны (СИЕТАС) хэд хэдэн шийдвэрт гэрээг зохицуулж буй дотоодын хууль тогтоомжтой зөрчилдөхгүй бөгөөд дотоодын хууль тогтоомжид гэрээний харилцааг шийдвэрлэх зохицуулалт дутсан тохиолдолд хил дамнасан шинжтэй хэлцлийг шийдэхдээ ЮНИДРОЙТ-ийн зарчмуудыг нөхөн хэрэглэх боломжтой хэмээн дурдсан байна<sup>7</sup>.

Дээрх тохиолдлууд нь талууд маргаан шийдвэрлэх хуулиар БНХАУ болон бусад улсын үндэсний хууль тогтоомжийг сонгосон маргаануудыг шийдвэрлэхэд илэрхийлсэн байр суурь юм. Тус арбитраар маргаан шийдвэрлүүлсэн талууд ихэнхдээ 1980 оны “Бараа худалдах худалдан авах тухай олон улсын гэрээний” Венийн конвенцийг сонгосон байв. Харин маргаан шийдвэрлэсэн бүрэлдэхүүн уг конвенцоор нарийвчлан зохицуулаагүй асуудлуудыг шийдвэрлэхдээ ЮНИДРОЙТ-ийн зарчмуудыг “худалдааны заншлын” шинжтэйгээр ашигласан нь түгээмэл байна. Энэ нь тухайн арбитрын маргаан шийдвэрлэх эх сурвалжийг хэрэглэх онцлог гэхээс илүүтэй олон улсын чиг хандлага юм.

Түүнчлэн үндэсний хууль тогтоомжид ЮНИДРОЙТ-ийн зарчмууд онцгой байр суурь эзэлдэг. Тухайлбал 1999 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Ардын үндэсний есдүгээр чуулганаар БНХАУ-ын шинэ нэгдмэл гэрээний хуулийг баталсан юм. Уг хуулийн төслийг бэлтгэхдээ 1994 оны ЮНИДРОЙТ-ийн зарчмуудтай ижилтгэх байдлаар үзэл баримтлалаас эхлээд суурь зарчмууд, гэрээний үр нөлөө, хэлбэр, гэрээ байгуулагдсанд тооцох, стандарт нөхцөл, үүргийн гүйцэтгэл, хариуцлага гэх мэт маш өргөн хүрээнд уг зарчмуудыг авч ашигласан байдаг.<sup>8</sup>

Ийнхүү БНХАУ-ын гэрээний эрх зүйн харилцааг зохицуулдаг үндсэн эх сурвалж болох 23 бүлэг 428 зүйлтэй уг хууль нь ЮНИДРОЙТ-ийн зарчимд тулгуурлаж боловсруулагдсан тул практикт хууль хийгээд тус зарчим зөрчилдөх тохиолдол төдийлөн гардаггүй байна.

2. ОХУ дахь үндэсний хууль тогтоомж, шүүх, арбитрагт ЮНИДРОЙТ-ийн зарчмуудын байр суурь, нөлөө

ЮНИДРОЙТ-ийн 1994 болон 2004 оны зарчмууд нийтлэгдсэн даруйдаа орос хэл рүү албан ёсоор орчуулагдаж байсан тул ОХУ-ын эрх зүй, бизнесийн хүрээнд эчнээ танил болсон байлаа.

Түүгээр зогсохгүй тухайн үеийн зах зээлийн эдийн засаг хөгжсөн орнуудын бизнесийн эрх зүйн зохицуулалтыг судалж, чиг баримжаа болгох гол эх сурвалж нь ОХУ-ын хувьд ЮНИДРОЙТ-ийн зарчмууд байв. Үүний нэг жишээ нь ОХУ-ын Иргэний хуульд тус зарчмын зохицуулалтууд нэлээдгүй орсон байдаг<sup>9</sup>.

Дотоодын шүүхүүд нь ЮНИДРОЙТ-ийн зарчмуудыг хэрэг маргаан шийдвэрлэх албан ёсны эх сурвалжаар хүлээн зөвшөөрдөггүй боловч хуулийг тайлбарлахдаа иш татан хэрэглэх явдал нэмэгдэж байна<sup>10</sup>.

ОХУ-ын Худалдаа Үйлдвэрлэлийн Танхимын дэргэдэх Олон Улсын Худалдааны Арбитрын шүүхээр (ICAC) шийдвэрлэгдсэн хэргүүдийн дийлэнхэд нь ЮНИДРОЙТ-ийн зарчмууд ямар нэгэн байдлаар ашиглагдсан байдаг.

<sup>7</sup> Alejandro Garro, Use of the UNIDROIT Principles to Interpret and Supplement Domestic Contract Law., 2021, Page number. 9.

<sup>8</sup> Zhang Yuqing. The New Chinese Contract Law and the Unidroit Principles: A Brief Comparison. Unif. L. Rev. 2000 – 3. page number. 430.

<sup>9</sup> Alexander S. Komarov. Reference to the UNIDROIT Principles in International Commercial Arbitration Practice in Russian Federation. Unif. L. Rev. 2011. page number. 657.

<sup>10</sup> Мөн тэнд.



Гэвч ОХУ-ын олон улсын арибтрт маргаан шийдвэрлэх хуулийн сонголтын хувьд 1980 оны Бараа худалдах худалдан авах тухай олон улсын гэрээний конвенц давамгайлах нөлөөтэй байсаар иржээ. Энэ нь конвенцид нэгдэн орсон улсуудын тоо, НҮБ-ийн нэр хүнд зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалдаг байна.

Гэсэн хэдий ч тус конвенцтой харьцуулахад ЮНИДРОЙТ-ийн зарчмууд нь зохицуулалтын хувьд илүү нарийвчилсан шинжтэй, боловсронгуй тул конвенцийн зохицуулалт дутагдсан газар ЮНИДРОЙТ-ийн зарчмыг нөхөн хэрэглэсээр иржээ. Энэ байдал цаг хугацааны явцад улам бүр нэмэгдсээр 1980 оны Венийн конвенцтой ЮНИДРОЙТ-ийн зарчим хамт хэрэглэгддэг жишиг ОХУ-ын олон улсын арибтрт нэгэнтээ төлөвшин тогтсон байна.

## ДҮГНЭЛТ

Манай улсын аж ахуйн нэгжүүдийн хувьд гадаадын арбитраар маргаанаа шийдвэрлүүлэхэд эрх зүйн мэдлэг, чадвар бүхий хүний нөөц дутмаг, арибтрын зардал, зөвлөх үйлчилгээ, өмгөөллийн хөлсийг урьдчилан төлж маргахын зэрэгцээ бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах санхүүгийн чадамж хязгаарлагдмал байгаатай холбоотойгоор гадаад гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлүүлэх эрхээ бодитоор хэрэгжүүлж чадахгүй байх тохиолдол түгээмэл байна.

Энэ нь арбитраар маргаан шийдвэрлүүлэх практикт тулгамдаж буй томоохон асуудал бөгөөд үүнийг амжилттай шийдсэнээр дотоодын аж ахуйн нэгжүүдийн маргаан шийдвэрлүүлэх эрхийг хангаад зогсохгүй, Монголын Олон Улсын Арибтрын маргаан шийдвэрлэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх боломжтой.

Судлаачийн зүгээс санал болгож буй шийдэл нь дотоодын аж ахуйн нэгжүүд арибтрын хэлэлцээрт оролцохдоо өөрсдийн байр суурийг (импортлогч) зөв үнэлж, Монголын Олон Улсын Арибтрын гадаад бүрэлдэхүүнийг сайтар судалж үзсэний үндсэн дээр маргааны харьяаллыг тогтоохдоо Монголын Олон Улсын Арибтрыг сонгох байр сууринд бат зогсох шаардлагатай байна. Түүнчлэн маргаан шийдвэрлэх хуулийг сонгохдоо гэрээний зохицуулалтыг давамгай байдлаар үйлчлэх тухай тодорхой зааж, зайлшгүй тайлбарлах шаардлагатай нөхцөлд ЮНИДРОЙТ-ийн зарчмуудыг хэрэглэхээр тусгах нь дотоодын аж ахуйн нэгжүүдтэй хамгийн өргөн хүрээнд гэрээний харилцаанд орж буй ОХУ, БНХАУ-ын хувьд нааштайгаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүлнэ. Учир нь дээрх улсуудын хувьд ЮНИДРОЙТ-ийн зарчим арибтрын шүүхийн хэрэглээнд нэвтрээд удсан төдийгүй үндэсний хууль тогтоомжид гүнзгий байр суурь эзэлдэг болохыг илтгэлийн харьцуулалтын хэсэгт тодорхой өгүүлсэн.

Иймд энэхүү шийдлийн талаар дэлгэрүүлэн судалж, сургалтын хэрэглэгдэхүүн болгон өргөжүүлж өөрийн гишүүн аж ахуйн нэгжүүддээ сурталчлан таниулах, санал болгох замаар бодитоор хэрэгжүүлэх арга хэмжээг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас авч хэрэгжүүлэх нь дээрх тулгамдсан асуудлыг түргэн шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх хамгийн бодитой арга зам хэмээн дүгнэж байна.

**ЭХ СУРВАЛЖ**

## Олон улсын конвенц

1. Бараа худалдах – худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ-ын конвенц
2. НҮБ-ын олон улсын худалдааны эрхийн комиссын олон улсын арилжааны загвар хууль

## Дотоодын хууль, дүрэм, журам

1. Арбитрын тухай хууль, 2017 он.
2. Арбитрын үндсэн зардал болон нэмэлт зардлын хэмжээг тооцох журам, 2014 он.
3. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, 2017 он.
4. МҮХАҮТанхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын дүрэм, 2019 он.

## Гадаад эх сурвалж

1. Alejandro Garro, Use of the UNIDROIT Principles to Interpret and Supplement Domestic Contract Law, 2021.
2. Alexander S. Komarov. Reference to the UNIDROIT Principles in International Commercial Arbitration Practice in Russian Federation. Unif. L. Rev. 2011.
3. Neil Andrews. Arbitration and Contract Law. Common Law Perspectives, 2016.
4. Zhang Yuqing. The New Chinese Contract Law and the Unidroit Principles: A Brief Comparison. Unif. L. Rev. 2000 – 3.

## Цахим эх сурвалж

1. <http://unilex.info/>
2. [https://mkas.tpprf.ru/en/#:~:text=The%20ICAC%20is%20the%20leading,\)%2C%20legislatively%20created%20in%201932.](https://mkas.tpprf.ru/en/#:~:text=The%20ICAC%20is%20the%20leading,)%2C%20legislatively%20created%20in%201932.)
3. <https://www.arbitr.mn/>
4. <https://www.hkiac.org/content/2018-schedule-fees>
5. <https://www.mongolchamber.mn/i/membership>
6. <https://www.unidroit.org/>

**IMPROVED DISPUTE RESOLUTION THROUGH ARBITRATION IN CONTRACT CASES INVOLVING FOREIGNERS AND REALIZATION OF THE RIGHT OF DOMESTIC ENTERPRISES TO DISPUTE RESOLUTION**

*Delgerjargal Batjargal*

*Lawyer at "Erdenes Tavantolgoi" JSC, LL.M candidate of School of Law, NUM*

**ABSTRACT:**

The article examines and presents ways to ensure the right to resolve disputes arising from agreements of domestic legal persons involving foreign elements while increasing the volume of cases at the Mongolian International Arbitration Center.

**KEYWORDS:**

Mongolian International Arbitration Center, Arbitration, Protection of rights to resolving the dispute, Selection of jurisdiction, The principles of UNIDROIT.

## ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭЭС АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ, ДАХИН ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР БУЦААХ ЗОХИЦУУЛАЛТ



*Б.Эрдэнэмөнх  
Өмгөөллийн Эм Жэй Эл Атторнейс ХХН-ийн  
гишүүн, өмгөөлөгч, МУИС-ийн Хууль зүйн  
сургуулийн магистрант,*

### **ТОВЧЛОЛ:**

Энэхүү судалгаагаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчлүүдээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.3.5-д заасан “шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэлийн талаар өгүүлнэ. Энэхүү үндэслэл нь процессын эрх зүйн зарчмуудад нийцэж байгаа эсэхэд болон шүүхийн практикт хэрэглэгдэж буй байдалд анализ хийсэн. Түүнчлэн ХБНГУ, Япон улсын энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг судлан харьцуулж, дүгнэлт, санал гаргахыг зорьсон.

“Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэл нь эрх зүйн зохицуулалтын шаардлага хангахгүй хэм хэмжээ буюу илүүдсэн зохицуулалт гэсэн ерөнхий дүгнэлтэд хүрсэн. “Шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх нөхцөлд чухам юуг ойлгох нь тодорхой зохицуулагдаагүй тул энэ нь анхан шатны шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр болох, хэрэг маргаан шуурхай шийдвэрлэгдэх байдалд сөргөөр нөлөөлж байна гэж үзсэн. Мөн шийдвэрийг хянаж буй шүүхийн хяналтын хүрээг үндэслэлгүйгээр өргөжүүлэх боломжтой байгаа зэрэг нь судалгааны үр дүнд тогтоогдсон гол асуудал болно.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Ноцтой зөрчил, Захиргааны процессын эрх зүйн зарчим, Шийдвэрийг өөрчлөх боломжгүй, Доод шатны шүүхийн алдааг хянах, Илэрхий алдаа дутагдал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Хяналтын хүрээ

## УДИРТГАЛ

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.3-т захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил<sup>1</sup> буюу анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүхэд буцаах үндэслэлүүдийг зохицуулсан. Энэхүү үндэслэлүүдээс “шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй”<sup>2</sup> гэх үндэслэл нь процессын эрх зүйн зарчмуудад нийцэж байгаа эсэхэд болон шүүхийн практикт хэрэглэгдэж буй байдалд анализ хийж, ХБНГУ, Японы улсын энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг судлан харьцуулж, дүгнэлт, санал гаргахыг зорин энэхүү өгүүллийг бичлээ.

Давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн дээд шатны байгууллага бус тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хянах /review/ чиг үүрэгтэй бөгөөд шүүн таслах ажиллагаан дахь алдааг залруулах үндсэн зорилготой гэж үзэж болно. Улс орнуудын хувьд давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээг хуульчилсан байдал нь харилцан адилгүй байх бөгөөд нийтлэг зорилго нь доод шатны шүүхийн шүүн таслах ажиллагаан дахь “алдааг залруулах” явдал байдаг.<sup>3</sup> Манай улсын хувьд доод шатны шүүхийн “алдаа” гэдэгт ерөнхийдөө хууль хэрэглээний асуудлаас гадна, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа процессын хуульд нийцэхгүй, үндэслэлгүй байх тухай хуульчилж, зарим судлаачид үүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “ноцтой зөрчил”<sup>4</sup> гэж судалгааны бүтээлүүддээ тэмдэглэсэн байна.

2021 оны 01 сарын 15 өдөр батлагдсан Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-нд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “ноцтой зөрчил” гэх нэршил албан ёсоор орж ирснээр процессын хуулиудын холбогдох хэсэг өөрчлөн найруулагдаж 2021 оны 03 сарын 01 өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Гэхдээ энэхүү нэршил нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хяналтын шатны шүүхэд гомдол гаргах зохицуулалтад байгаа ч тус хуулийн 121 дүгээр зүйлийн 121.3-т заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчлүүдийг ноцтой зөрчил гэж ойлгох боломжтой байна.<sup>5</sup>

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаах асуудлыг эрдэм шинжилгээний бүтээлүүдэд ерөнхий байдлаар, мэдээллийн шинжтэй дурдсан байх боловч тухайлан авч үзсэн судалгаа байхгүй байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “ноцтой зөрчил” гэх ойлголтыг тодорхойлох хүрээнд логик, хуулийн хэм хэмжээг норматив, шүүхийн практикийг прагматик, гадаад улс орны зохицуулалтыг харьцуулалтын аргаар судалсан.

Иймд энэхүү ноцтой зөрчилд хамаарч буй Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.3.5-д заасан “шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэл нь онол, зарчмын хүрээнд нийцэж байгаа эсэх, практик хэрэглээний ач холбогдлыг судлан дүн шинжилгээ хийлээ.

<sup>1</sup> Монголы Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.в, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.2-д тус тус “Ноцтой зөрчил” гэх нэр томъёог хуульчилсан. Энэхүү “Ноцтой зөрчил” гэдэгт ямар нөхцөл байдлыг ойлгох вэ гэхээр түүний дэлгэрэнгүй зохицуулалт нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.3 дахь хэсэгт заасан долоон нөхцлийг логикын хувьд ойлгохоор байна.

<sup>2</sup> Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.3.5 дахь хэсэг

<sup>3</sup> Ц.Цогт, Захиргааны хэргийн шүүх /Administrative court/, УБ, МУИС Пресс төв, 2019, 35 дахь тал.

<sup>4</sup> Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, УБ, Мөнхийн үсэг, 2019, 346 дахь тал “...хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “ноцтой зөрчил” гаргасан зэрэг үндэслэлээр гомдол гаргасан бол давж заалдах шатны шүүх өөрийн бүрэн эрхийн хүрээнд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй. Үүнд дараах үндэслэл хамаарна ЗХШХШТХ-н 121.3”

<sup>5</sup> Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, УБ, Мөнхийн үсэг, 2019, 355 дахь тал “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын зөрчил гэдэгт ЗХШХШТХ-н 121.3-т заасан үндэслэлүүд хамаарна. ... хяналтын шатны шүүх ...зөрчил тогтоогдвол шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаана”

## ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ЗАРЧМЫН ХҮРЭЭНИЙ НИЙЦЭЛ

Захиргааны процессын хуулиар захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчлүүд хэмээн тогтоосон нь “мэтгэлцэх”, “шүүхэд сонсгох” зарчим /ЗХШХШТХ-ын 121.3.1/, “шүүх хууль дээдлэх, гагцхүү хуульд захирагдах зарчим” /ЗХШХШТХ-ын 121.3.2, 121.3.3, 121.3.6/, “шүүх нотлох зарчим” /ЗХШХШТХ-ын 121.3.4/, “албаны зарчим” /ЗХШХШТХ-ын 121.3.7/ зэрэг шүүхэд хамаарах үндсэн хуулийн болон процессын эрх зүйн нийтлэг, захиргааны процессын эрх зүйн тусгай зарчмуудын хүрээнд нийцэж байна. Эдгээр ноцтой зөрчлүүдийн нийтлэг шинж нь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэж буй үйл ажиллагаатай холбоотой байна. Харин “шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” үндэслэл нь процессын эрх зүйн “хууль хэрэглэх зарчим”-тай холбогдож болох ч хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах ноцтой зөрчил гэж үзэхэд учир дутагдалтай байна гэж үзлээ. Учир нь давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн хууль хэрэглээний асуудалтай холбоотойгоор ЗХШХШТХ-ын 121 дүгээр зүйлийн 121.2-т заасны дагуу давж заалдах шатны шүүх хэргийг буцаахгүйгээр шийдвэрийг хүчингүй болгож нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох, нэхэмжлэлийн шаардлагыг хангах, хуулийн 120 дугаар зүйлийн 120.3-д заасны дагуу шийдвэрийг өөрчлөх эрх хэмжээтэй. Өөрөөр хэлбэл, давж заалдах шатны шүүх процессын бус материаллаг эрх зүйн талаас нь хянаж хэргийг цааш явуулах<sup>6</sup> боломжтой байгаа юм.

Дээрх байдлаас харвал ЗХШХШТХ-н 121.3.5 дахь хэсэгт заасан үндэслэл нь ЗХШХШТХ-н 120.3 болон 121.2-т заасан үндэслэлүүдтэй агуулгын хувьд давхардсан шинжтэй ч өөр үр дагавар үүсгэж байна. Өөр үр дагавар үүсгэж байгаа шалтгаан нь “шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх нөхцөлтэй холбоотой. Тэгвэл “шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх нөхцөлд юуг хамааруулж ойлгох вэ гэхээр судлаачын хувьд дараах тохиолдлуудыг ойлгох боломжтой гэж үзэж байна. Үүнд:

1. Шүүх шаардлагатай нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн
2. Хуулийн шаардлага хангаагүй нотлох баримтыг шийдвэрийн үндэслэл болгосон
3. Нэхэмжлэгчийн болон гуравдагч этгээдийн шаардлагад дүгнэлт өгөөгүй, шийдвэрлэлгүй орхигдуулсан

Уг гурван үндэслэлийг хамааруулж байгаа учир нь тухайн хэрэг маргааныг шийдвэрлэсэн шийдвэр хууль зүйн үндэслэлтэй эсэхээс үл хамааран хэргийн нөхцөл байдлыг хуульд заасан шаардлагын дагуу бүрэн тогтоож дүгнэлт өгөөгүйн улмаас шийдвэрт өөрчлөлт оруулах, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох, нэхэмжлэлийг хангах, хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийн аль нэгийг гаргах **боломжгүй нөхцөл байдал** юм. Гэвч дээрх гурван үндэслэл нь ЗХШХШТХ-н 121 дүгээр зүйлийн 121.3.4, 121.3.7 дахь хэсгүүдэд зохицуулагдсан. “Шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх нөхцөлд чухам юуг ойлгох нь тодорхой зохицуулагдаагүй тул энэ нь анхан шатны шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр болох, хэрэг маргаан шуурхай шийдвэрлэгдэх байдалд сөргөөр нөлөөлж болох юм.

## ШҮҮХИЙН ПРАКТИК

“Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэлийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх ямар агуулгаар хэрхэн тайлбарлан хэрэглэж байгааг шүүхийн шийдвэрийн

<sup>6</sup> “хэргийг цааш явуулах” гэсэн санаа нь давж заалдах шатны шүүх буцаахгүйгээр шийдвэрийг өөрчлөх, анхан шатны шүүх нэхэмжлэлийг хангасан бол хангахгүй орхиж өөрчилсөн, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон бол нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хангасан тохиолдлыг хэлж байгаа болно.

цахим сан<sup>7</sup>-гаас 2019-2020 оны 2 жилийн хугацааны 400 орчим шүүхийн магадлалаас шүүж үзэхэд уг үндэслэлийг хэрэглэсэн тохиолдол байгаагүй. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн архивын 2020 оны шүүхийн магадлалаас шүүж үзэхэд хэрэглэсэн 2 тохиолдол байсан. Шүүхийн шийдвэрийн цахим сангийн хайлтын дүнд 2017-2018 оны магадлалуудаас 2018 онд 1, 2017 онд 3 магадлалд ЗХШХШТХ-н 121 дүгээр зүйлийн 121.3.5 дахь хэсгийг хэрэглэж хэргийг анхан шатны шүүхэд буцаасан тохиолдол байна.

Гэвч ЗХШХШТХ-н 121.3.5-д заасан үндэслэл нь дангаар хэрэглэгдээгүй 121.3-т заасан бусад үндэслэлүүдийн хамт хэрэглэгдсэн байна. Түүнчлэн, “Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэлээр шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхэд буцаах болсон гол шалтгаан болоогүй, ЗХШХШТХ-н 121.3-т заасан бусад үндэслэлээр хэргийг буцаасан байна. Хуулийн 121.1.1 дэх хэсэгт заасан “шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох” зохицуулалтын хамт хэрэглэсэн тохиолдол ч байна. Хуулийн 121.3.5-д заасан үндэслэл нь магадлалын хянавал хэсэгт товч дурдагдах байдлаар хэрэглэгджээ.

**Жишээ 1:** Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал<sup>8</sup>-аар “НХ” ХХК-ийн нэхэмжлэлтэй ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад холбогдох тус яамнаас олгодог хөнгөлөлттэй зээлийг хүчингүй болгосон нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэхтэй холбоотой маргааныг хянажээ. Тус магадлалын хянавал хэсгээс үзвэл ЗХШХШТХ-н 121.3.4 дэх хэсэгт зааснаар шүүх шаардлагатай нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн гэх шалтгаанаар хэргийг буцаасан байна. Давж заалдах шатны шүүх хуулийн 121.3.5 дахь хэсгийг дээрх үндэслэлийн хамт хэрэглэхдээ “маргаан бүхий акт гарах үед хүчин төгөлдөр болоогүй байсан хуулийг хэрэглэсэн нь буруу” гэсэн тайлбарыг хянавал хэсэгтээ дурдсан ч үүний улмаас хуулийн 121.3.5-д заасан “... шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх нөхцөл байдал юу байсан болохыг тайлбарлаагүй байна.

**Жишээ 2:** “Эрдэнийн гүн говь” ХХК-ийн гомдолтой Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн ТУБ-д холбогдох хэргийг хянасан давж заалдах шүүхийн магадлал<sup>9</sup>-аар хуулийн 121.1.1 дэх хэсгийг хэрэглэж нэхэмжлэлийг хангасан анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон боловч магадлалын тогтоох хэсэгтээ 121.3.5 дахь хэсгийг хамт хэрэглэжээ. Энэ нь 2 өөр үр дагавар үүсгэх зохицуулалтуудыг зэргэцүүлэн хэрэглэсэн тохиолдол юм.

**Жишээ 3:** Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 магадлал<sup>10</sup>-аар “О ш” НҮТББ-ын нэхэмжлэлтэй Үндэсний аудитын газарт холбогдох хэргийг анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэхдээ ЗХШХШТХ-н 121.3.4, 121.3.5-д заасан үндэслэлүүдийг хамт хэрэглэсэн. Ингэхдээ хуулийн 121.3.5 хэсэгт заасан үндэслэлийг хянавал хэсэгт тайлбарлахдаа “... нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл зөрөөтэй” байхад анхан шатны шүүх түүнийг тодруулаагүй гэжээ. Үүнээс үзвэл, “...шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэдэгт нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл зөрөөтэй бөгөөд түүнийг анхан шатны шүүх тодруулаагүй гэх тохиолдлыг давж заалдах шатны шүүх хамааруулжээ гэж үзэх боломжтой байна<sup>11</sup>. Гэвч энэ тохиолдол нь шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнээс хэтэрсэн дүгнэлт хийхгүй байх<sup>12</sup>, давж заалдах шатны шүүх гомдлын хүрээнд хянах<sup>13</sup> диспозитив зарчимтай зөрчилдөнө. Диспозитив зарчмыг тодорхойлох нэг

<sup>7</sup> [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)

<sup>8</sup> Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 07 сарын 18 өдрийн 0509 дугаартай “НХ” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийг хянасан магадлал

<sup>9</sup> Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 02 сарын 28 өдрийн 157 дугаартай магадлал

<sup>10</sup> Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 11 сарын 22 өдрийн 0605 дугаартай “О ш” НҮТББ-ын нэхэмжлэлтэй Үндэсний аудитын газарт холбогдох хэргийг хянасан магадлал

<sup>11</sup> Практикт “нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл зөрүүтэй” гэх шалтгаанаар шийдвэрийг хүчингүй болгож буцаах тохиолдол байдагч Хуулийн 121.3.5-г хэрэглээгүй тохиолдол бий.

<sup>12</sup> ЗХШХШТХ-н 106 дугаар зүйлийн 106.5

<sup>13</sup> ЗХШХШТХ-н 118 дугаар зүйлийн 118.3



агуулга бол “шүүх нэхэмжлэлийн **шаардлагыг** дагах” юм. Энэ нь шүүх нэхэмжлэлийн **шаардлагаар** тодорхойлогдсон маргааны зүйлийг шийдвэрлэх ... гэж ойлговол зохино.<sup>14</sup> Нөгөө талаараа давж заалдах шатны шүүх магадлан шалгах чиг үүргээ хэтрүүлж анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх эрх хэмжээ рүү орсон гэж үзэх боломжтой гэж судлаачийн зүгээс үзэж байна. Илэрхий алдаа дутагдал /Reversible error/ байгаа нөхцөл байдлыг тодорхойлохоос бусдаар анхан шатны шүүхийн тогтоосон нөхцөл байдлыг үгүйсгэж болохгүй юм.<sup>15</sup>

## ТҮҮХ БА ИРГЭНИЙ ПРОЦЕССЫН ХАМААРАЛ

“Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэл нь одоогоос 19 жилийн өмнөөс буюу 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсанаар үйлчилж эхэлсэн байдаг. Шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхэд буцаах үндэслэлүүд нь 2002 оны 01 сарын 10 өдөр батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 168 дугаар зүйлийн 168.1-д тусгагдсан байдаг бөгөөд эдгээр зохицуулалт нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.3-д үг үсгийн зөрөөгүй хуулбарлагдан орсон гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, иргэний хэрэгт гарч болох нэхэмжлэлийн шаардлагуудыг тодорхой тоочин жагсааж болохгүй учир төдий хэмжээгээр “шийдвэрийг өөрчлөх боломжгүй” нөхцөл байдал олонтой тохиолдохыг үгүйсгэхгүй юм. Иймд захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд зохимжгүй бөгөөд энэ нь захиргааны шүүхийн практикт төдийлөн хэрэглэгдэхгүй, хэрэглэгдсэн ч дангаар хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэхгүй байгаагаар харагдаж байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт тохирсон журмыг тухайлсан хуульд бүрэн тусгаж, иргэний процессын хуулиас хамааралтай байдлыг халах<sup>16</sup> талаар судлаачид эрдэм шинжилгээний ажлуудаараа илэрхийлсээр иржээ. Түүнчлэн, анхан шатны шүүхэд буцаах зөрчил нь хууль хэрэглээтэй холбоогүй, хуулиар тогтоосон шүүхийн процесстэй холбоотой ноцтой зөрчлийг ойлгох ёстой байна. Тухайлбал, иргэний процессын эрх зүйн судлаачдын зүгээс заавал хүчингүй болгож, анхан шатны шүүхэд буцаах үндэслэлүүдийг цэвэр процессын зөрчлүүд байхаар судалгааны саналдаа өгүүлжээ.<sup>17</sup> Энэ нь “Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэл иргэний процесст ч тохиромжтой эсэх нь эргэлзээтэй болохыг харуулж байгаа юм.

## ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

ХБНГУ-ын Захиргааны шүүхийн процессын хууль, Япон улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>18</sup>-уудад зааснаас үзвэл анхан шатны шүүхийн шийдвэрийг дахин хэлэлцүүлэхээр шилжүүлэх “ноцтой алдаа” гэж үзэх нөхцлийг хэргийн оролцогчийн давж заалдах гомдлын хязгаарлалт болгон зохицуулсан байдаг. Харин манай улсын хувьд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар хэргийн

<sup>14</sup> Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, 2019 он, 64 дэх тал.

<sup>15</sup> Katherine A. Currier, Thomas E. Eimermann, Marisa Campbell, Introduction to law. A Critical Thinking Approach. Seventh edition. x.146

<sup>16</sup> М.Батсуурь, Монгол Улс дахь дагнасан шүүхийн тогтолцоо: Үр нөлөө, анхаарах зарим асуудал өгүүлэл. Хууль дээдлэх ёс сэтгүүл. Цуврал 44, (2013), 51 дэх тал.

<sup>17</sup> Д.Хуяг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгох зарим асуудал өгүүлэл. Хууль дээдлэх ёс сэтгүүл. Цуврал 28, (2010), 52 дах тал.

<sup>18</sup> Япон улсын хувьд захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо байдаггүй бөгөөд захиргааны хэрэг маргааныг ерөнхий харьяаллын шүүх шийдвэрлэдэг. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиудад заасны дагуу явагддаг.

оролцогчийн гомдлын хязгаарлалт байдлаар бус шүүх шийдвэрлэхдээ удирдлага болгох байдлаар хуульчилжээ.

Герман улсын хувьд 2 төрлийн гомдол гаргахыг зөвшөөрдөг. Нэгдүгээрт, “маргааны үйл баримт болон хууль хэрэглээний талаар аль алинд нь”, Хоёрдугаарт, “зөвхөн хууль хэрэглээний асуудлаар” гэсэн гомдол гаргаж болно.<sup>19</sup> Эдгээр үндэслэлүүдийг ХБНГУ-ын Захиргааны процессын хуулийн 124, 132 дугаар зүйлүүдээр зохицуулсан. Маргааны үйл баримт болон хууль хэрэглээний талаар аль алинд нь гомдол гаргах үндэслэлүүд нь:

1. Шүүхийн шийдвэрийн үнэн зөв, алдаагүй байдалтай холбоотой үндэслэл бүхий ноцтой эргэлзээ байгаа бол,
2. Маргааны зүйл, хэрэг нь онцгой үйл баримттай холбоотой эсхүл хууль зүйн хэрэглээний хувьд нарийн төвөгтэй бол,
3. Маргааны зүйл, хэрэг нь үндсэн суурь ач холбогдолтой бол<sup>20</sup>,
4. Шүүхийн шийдвэр нь Захиргааны дээд шүүх, Холбооны Захиргааны хэргийн шүүх, Холбооны дээд шүүхүүдийн нэгдсэн танхим эсвэл Холбооны Үндсэн хуулийн шүүхийн нэгдсэн танхим зэргээс гаргасан шийдвэрүүдийн эсрэг, эсхүл тэдгээрийг дордуулсан шийдвэр байвал, эсхүл иймэрхүү байдлаар дордуулсан шүүхийн шийдвэрийг үндэслэж шийдвэр гаргасан бол,

Зөвхөн хууль хэрэглээний асуудлаар гомдол гаргах үндэслэлүүд нь:

1. Маргааны зүйл, хэрэг нь үндсэн суурь чухал ач холбогдолтой,
2. Шийдвэр нь Холбооны Захиргааны хэргийн шүүх, Холбооны дээд шүүхүүдийн нэгдсэн хуралдаан эсвэл Холбооны Үндсэн хуулийн цэцийн тогтоолоос зөрчсөн эсхүл ийнхүү зөрчсөн шийдвэрийг үндэслэн гарсан шийдвэр бол,
3. Шийдвэрийн үндэслэл болсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь алдаа, дутагдалтай бол

Япон улсын хувьд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 312 дугаар зүйлээр гомдол гаргах үндэслэлийг зохицуулсан байна. Давж заалдах гомдол гаргахад нарийн шалгуур байхгүй ч Дээд шүүхэд гомдол гаргахад хатуу шалгууртай. Гагцхүү Үндсэн хууль зөрчигдсөн гэх нөхцөл, эсвэл доод шатны шүүхүүдийн процесс нь Иргэний процессын хуулийг ноцтой зөрчсөн тохиолдолд гомдлыг зөвшөөрдөг.<sup>21</sup> Энэхүү үндэслэлүүдийг агуулгаар нь товчилбол:

1. Шүүх бүрэлдэхүүн хуульд заасан журмын дагуу бүрдээгүй,
2. Хэргийг хянан хэлэлцэхэд орж болохгүй шүүгч хэргийг хянан шийдвэрлэж, шүүхийн шийдвэр гаргахад оролцсон,
3. Япон улсын шүүхийн онцгой харьяаллыг зөрчсөн бол,
4. Хэргийн харьяаллын тухай холбогдох заалтыг зөрчсөн бол,
5. Итгэмжлэл, төлөөлөл нь хууль зөрчсөн
6. Олон нийтэд аман тайлбар \мэтгэлцээн\ явуулах тухай хуулийн заалтыг зөрчсөн бол, \нээлттэй шүүх хурал\
7. Шүүхийн шийдвэр гаргах болсон үндэслэл тодорхойгүй, эсхүл шүүхийн шийдвэр гаргасан үндэслэлүүд нь хоорондоо зөрчилдөөнтэй бол,

Дээрх 2 улсын хувьд хуульд заасан давж заалдах гомдол гаргах үндэслэлд хамаарч байгаа эсэхийг шалгаж гомдлыг хүлээн авах эсэхээ шийдвэрлэдэг. Хуульд заасан үндэслэлд хамаарна гэж үзээд гомдлыг хэлэлцсэн бол хэргийг шилжүүлэх /буцаах/ үү эсвэл өөр байдлаар шийдвэрлэх үү гэдэг нь хянаж буй шүүхийн сонголтын асуудал байдаг байна.

Манай улсынхаас ялгаатай тал нь дээрх үндэслэлүүдээр давж заалдах гомдлын хязгаарлалт тогтоож байгаа ч нөгөө талаараа хэргийн оролцогчид эрх олгож байгаа /эсхүл

<sup>19</sup> Ц.Цогт, Захиргааны хэргийн шүүх /Administrative court/, УБ, МУИС Пресс төв, 2019, 129 дэх тал.

<sup>20</sup> Тухайлбал шинэ жишиг тогтоохуйц онцгой ач холбогдолтой гэж ойлгогдохоор орчуулагдаж байна.

<sup>21</sup> Ц.Цогт, Захиргааны хэргийн шүүх /Administrative court/, УБ, МУИС Пресс төв, 2019, 132 дахь тал.

эрхийг нь баталгаажуулж байгаа/ гэдэг утгаараа иргэн, хуулийн этгээд /хэргийн оролцогч/-ийн гомдлын шаардлага, хүсэлтийнх үндсэн дээр, түүнд нь тулгуурлаж байгаа явдал юм. Энэ нь шүүхийн шийдвэрийг хянаж буй шүүхийн шийдлийн хүлээн зөвшөөрөгдөх байдалд эерэг нөлөөтэй. Манай улсын хувьд гомдол гаргахдаа баримтлах хэргийн оролцогчид эрх олгосон тусгайлсан зохицуулалт байхгүй.

Хэргийн оролцогчийн гомдол гаргах хязгаарлалт байдлаар зохицуулсан нь захиргааны эрх зүй харьцангуй төлөвлөсөн, хөгжсөн улсуудын хувьд тохиромжтой гэж үзэж байна. Харин манай улсын хувьд ЗХШХШТХ-ын 121 дүгээр зүйлийн 121.3-т шүүх буюу төрийн байгууллагад эрх хэмжээ олгосон байдлаар зохицуулагдсан байгаа нь шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаах үндэслэлүүдийг хуулиар нарийн тодорхой зохицуулах шаардлагыг бий болгож байна.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Хуулийн алдаа нь хууль зүйн нөлөөлөл үл шаардах харилцааг зохицуулах, эрх зүйн зохицуулалтын шаардлага хангахгүй хэм хэмжээг батлан гаргах гэх зэргээр илэрнэ.<sup>22</sup> Иймд энэхүү өгүүллийн эцэст “Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэл эрх зүйн зохицуулалтын шаардлага хангахгүй хэм хэмжээ буюу илүүдсэн зохицуулалт гэж үзэж байгаа тул дараах дүгнэлт, саналыг гаргаж байна. Үүнд:

- I. Манай улсын зохицуулалтаар ЗХШХШТХ-н 121 дүгээр зүйлийн 121.3-т заасан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах үндэслэлүүдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “ноцтой зөрчил” гэж томъёолж болохоор байна. Энэхүү зохицуулалтыг манай улсын хувьд шүүхийн удирдлага болгох, төрд олгосон эрх хэмжээ байдлаар зохицуулсан байна.
- II. “Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” үндэслэл нь ЗХШХШТХ-н 120.3 болон 121.2-т заасан үндэслэлүүдтэй агуулгын хувьд давхардсан шинжтэй ч түүнээсээ өөр үр дагавар үүсгэж байна. Энэ нь процессын эрх зүйн нийтлэг болон захиргааны процессын эрх зүйн тусгай зарчмуудад нийцэхгүй байна. /Диспозитив зарчим/
- III. “Шүүхийн шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх нөхцөл нь тодорхойгүйн улмаас шүүхийн практикт бараг хэрэглэгдэхгүй, хэрэглэгдсэн цөөн тохиолдолд өөр өөр агуулгаар хэрэглэгдэж байна. Түүнчлэн, уг нөхцөл нь дангаараа хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах үр давагварыг үүсгэхгүй, бусад үндэслэлүүдийн хамт, товч дурдагдах байдлаар хэрэгжиж байна.
- IV. “Шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх нөхцөлд чухам юуг ойлгох нь тодорхой зохицуулагдаагүй тул энэ нь анхан шатны шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр болох, хэрэг маргаан шуурхай шийдвэрлэгдэх байдалд сөргөөр нөлөөлөх, шийдвэрийг хянаж буй шүүхийн хяналтын хүрээг тодорхойгүй байдлаар өргөжүүлэх боломжтой байна.
- V. “Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” үндэслэл нь иргэний хэргийн процессын зохицуулалтаас хуулбарласан, захиргааны процессын эрх зүйд тохиромжтой эсэх нь эргэлзээтэй байна.
- VI. ХБНГУ, Япон улсын эрх зүйн зохицуулалтын хувьд анхан шатны шүүхийн шийдвэрийг дахин хэлэлцүүлэхээр шилжүүлэх “ноцтой алдаа” гэж үзэх нөхцлийг хэргийн оролцогчийн давж заалдах гомдлын хязгаарлалт болгон, нөгөө талаараа хэргийн оролцогчид эрх олгосон байдлаар зохицуулсан нь оновчтой

<sup>22</sup> Ч.Нямсүрэн, Эрх зүй, төрийн ерөнхий онол. УБ, 2004, 304 дэх тал.

байна. Манай улсын хувьд захиргааны процессын эрх зүй онол, практикийн түвшинд харьцангуй төлөвшиж байгаа тул цаашид дээрх улсуудын жишгээр зохицуулж, шүүхэд олгосон эрх хэмжээний жагсаалтын зохицуулалтаас татгалзах шаардлагатай.

VII. Захиргааны процессын эрх зүйн онол, практик хангалттай төлөвшөөгүй гэж үзвэл “Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэлийг тодорхой ойлгомжтой байдлаар зохицуулах, эсхүл хуулийн энэхүү хэсгийг хүчингүй болгох шаардлагатай.

Энэхүү өгүүллээр зөвхөн “Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй” гэх үндэслэлийг судлан үзсэн тул цаашид ЗХШХШгХ-н 121.3-г заасан үндэслэлүүд тус бүрд нь онол, практикийн дүн шинжилгээ хийж үзэх шаардлагатай.

## ЭХ СУРВАЛЖ

### Ном товхимол

1. Ц.Цогт, Захиргааны хэргийн шүүх /Administrative court/, 2019 он.
2. Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, 2019 он.
3. Ч.Нямсүрэн, Эрх зүй, төрийн ерөнхий онол, УБ., 2004 он.
4. Introduction to law. A Critical Thinking Approach. Seventh edition. Katherine A. Currier, Thomas E. Eimermann, Marisa Campbell. 2019

### Сэтгүүл

1. Хууль дээдлэх ёс сэтгүүл, Цуврал 44. 2013 он.
2. Хууль дээдлэх ёс сэтгүүл, Цуврал 28. 2010 он.
3. Эрх зүй сэтгүүл 2013 №1 (23)

### Шүүхийн магадлал

1. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017.07.18 өдрийн 0509 дугаартай магадлал
2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017.06.30 өдрийн 0480 дугаартай магадлал
3. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017.08.02 өдрийн 0548 дугаартай магадлал
4. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.11.22 өдрийн 0605 дугаартай магадлал
5. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019.12.25 өдрийн 07 дугаартай магадлал
6. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020.02.28 өдрийн 157 дугаартай магадлал

### Сайт

1. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
2. [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)
3. <https://admincourt2.gov.mn/>
4. [www.legaldata.mn](http://www.legaldata.mn)

**RULES GOVERNING APPELLATE COURT’S STRIKING LOWER COURT JUDGEMENTS AND REMANDING CASES FOR RETRIAL IN ADMINISTRATIVE DISPUTES**

*Erdenemunkh B.*

*Attorney and partner of MJL Attorneys LLP, LL.M. candidate of School of law, NUM*

**ABSTRACT:**

This study examines one of the serious violations of administrative proceedings which is a ground stated in Article 121.3.5 “Court used the law not applicable, has applied incorrect interpretation of relevant law and the decision cannot be changed” of the Law on the procedure for administrative cases. I have analyzed its compliance with the principles of administrative procedure and the application of this regulation in court practice. In addition, aimed to study and compare the legal regulations of Germany and Japan, and made conclusions and suggestions.

A general conclusion has been reached that the group that “Court used the law not applicable, has applied incorrect interpretation of relevant law and the decision cannot be changed” is a norm that does not meet the requirements of legal regulation or legal gaps. Because the law does not clearly define what is meant by the term “the decision cannot be changed”, It was considered that this negatively affects the validity of the decision of the first instance court and the speedy disposition of cases. Also, the possibility of expanding the scope of the judicial review of the decision uncertainly is the main problem identified by the results of the research.

**KEYWORDS:**

A serious violation, Principles of the administrative procedure, a decision can’t be changed, Review of legal errors made by lower courts, Obvious error, The Administrative court of appeal, Scope of review.

## ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААРХ ТУЛГАМДСАН АСУУДАЛ<sup>1</sup>



*С.Мягмарсүрэн  
Хууль зүйн үндэсний хүрээлэгийн  
Эрдэм шинжилгээний ажилтан,  
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант*

### **ТОВЧЛОЛ:**

Өмгөөлөгчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан Ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрх, эрх чөлөө хамгаалах гол хэмжүүр бол өргөн хүрээний мэдлэг, баялаг туршлага хуримтлуулан, мэргэжлийн ёс зүй, хуулийг сахин биелүүлэх, хууль хэрэглэх ур чадварыг эзэмших явдал мөн билээ. 2019 онд батлагдсан Өмгөөллийн тухай хуулиар өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж байна. Тодруулбал өмгөөлөгчийн ёс зүйн асуудал нь суурь асуудал бөгөөд өмгөөлөгчид хүлээлгэх ёс зүйн хариуцлага нь тодорхой, оновчтой, заавал биелэгдэх шинжтэй байх зайлшгүй шаардлагатай тул өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээлгэхтэй холбогдох эрх зүйн хэм хэмжээ, практикийг судлан хариуцлагын төрөл болон хариуцлага хүлээлгэх бүрэлдэхүүний талаар өөрийн санал дүгнэлтийг боловсруулахыг зорилоо.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Өмгөөлөгчийн ёс зүй, өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа

### **УДИРТГАЛ**

Сэдэв сонгох болсон үндэслэл:

Ёс суртахууны харилцаа нарийсан хөгжиж, оюун ухаан, соёл, боловсрол, ялангуяа ёс суртахууны онол хөгжих явцад ёс суртахууны ухамсрын ойлголтууд улам баялаг агуулгатай болсон хэдий ч ёс зүйн үндсэн ойлголтуудын үндсэн агуулга харьцангуй тогтвортой, өөрөөр хэлбэл үндсээрээ өөрчлөгдөөгүй билээ. Ёс суртахууны тухай асуудал нь дан ганц философийн тухай судлагдахуун бус олон шинжлэх ухааны уулзварт судлагдах хүмүүний мөн чанарын тухай ухаан юм. Ёс суртахуун хэмээх нэр томъёо нь аливаа хүмүүний “ухамсар”, “сэтгэл”, “хүн чанар”, “удамшил”, “хүмүүжил”, “итгэл үнэмшил”, “сүсэг бишрэл”, “хэм хэмжээ”, “үнэлэмж”, “зарчим” зэрэг олон янзын тодорхойлолттой боловч энэ нь хүмүүний сайн амин чанарын цогц бөгөөд Монгол хэлний толь бичигт “мэргэжлийн ёс суртахууны хэм хэмжээний цогц” гэж судлаач С.Нарангэрэл тайлбарласан байна.

<sup>1</sup> Академич Ж.Амарсанаагийн нэрэмжит “Өмгөөллийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний шилдэг илтгэлийн уралдааны гуравдугаар байрын бүтээл



Ардчилсан улсын хувьд ёс суртахууны хувьд харьцангуй өндөр шаардлага тавьж ажиллах ёстой цөөн хэдэн мэргэжлийн нэг нь хуульчийн мэргэжил байдаг. Иймд хуульч нь мэргэжлийн ёс зүйн талаар мэдэх шаардлагатай бөгөөд энэ нь заавал сахин мөрдөгдөх шинжтэй байвал зохистой. Үүнд мэргэжлийн үүрэг, үнэ цэнэ, шударга ёс, нэр төр гэх мэтчилэн ойлголтуудын хамааруулан авч үзэж болно.

Хуульч гэдгийг ерөнхий байдлаар шүүгч, прокурор, өмгөөлөгч болон бусад хуульч гэж ангилж болно. Үүнээс өмгөөллийн үйл ажиллагаа гэдэгт үйлчлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцаа үйлчилгээг ойлгодог. Өмгөөлөгчийн ёс зүйн асуудал нь хууль зүйн шинжлэх ухаан тэр дундаа хуульчийн ёс зүйн хувьд суурь асуудал буюу өмгөөлөгчид хүлээлгэх ёс зүйн хариуцлага нь тодорхой, оновчтой, заавал биелэгдэх шинжтэй байх зайлшгүй шаардлагатай тул өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээлгэхтэй холбогдох эрх зүйн хэм хэмжээ, практикыг судлан хариуцлагын төрөл болон хариуцлага хүлээлгэх бүрэлдэхүүний талаар өөрийн санал дүгнэлтийг боловсруулахыг зорилоо.

Сэдвийн судлагдсан байдал:

Монгол Улсын анхны хуульчлагдсан Өмгөөллийн тухай хууль 1995 оны хоёрдугаар сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш өмгөөлөгчийн ёс зүйн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл хийгдсээр ирсэн. Эдгээрээс зарим томоохон бүтээлүүдийг дурдвал хууль зүйн шинжлэх ухааны доктор, ШУА-ийн гишүүн, академич, профессор цолтой, Монголын хуульч, улс төрч С.Нарангэрэлийн 1998 онд хэвлүүлсэн “Хүний эрх, өмгөөлөл”, Т.Сэнгэдоржийн 2004 онд хэвлүүлсэн “Хуульчийн мэргэжил”, 2010 онд хэвлүүлсэн “Хуульч мэргэжил ёс зүйн асуудал”, 1998 онд хэвлүүлсэн “Хуульчийн ёс зүй”. 2007 онд орчуулан хэвлэсэн Моригива Ясутомогийн “Хуульчийн ёс зүй” П.Долгорын 1976 онд хэвлүүлсэн “Өмгөөлөгч” болон 2005 онд хэвлүүлсэн “Монголын өмгөөлөгчийн байгууллага ба өмгөөлөл”, 1998 онд хэвлэгдсэн “Эрүүгийн хэрэгт өмгөөлөгч оролцох нь”. Ш.Дуламсүрэнгийн 2007 онд хэвлүүлсэн “Хуульч мэргэжлийн ёс зүй”, Д.Булганы 2013 онд хэвлэсэн “Хууль зүйн мэргэжлийн удиртгал” О.Мөнхсайхан докторын Өмгөөлөгчийн ёс зүйн талаарх нэг сэдэвт бүтээлүүд юм.

Дээрх бүтээлүүд нь өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа болон баримтлах ёс зүйд хамаарна. Харин 2019 онд батлагдсан Өмгөөллийн тухай хуулийн Мэргэжлийн хариуцлагын хорооны үйл ажиллагааны талаар тусгасан тодорхой судалгаа шинжилгээний ажил одоогоор хараахан алга байна.

Өмгөөллийн тухай хуулийг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр УИХ-аас батлан гаргаж өдгөө хүчин төгөлдөр үйлчилж байна. Тус хуульд өмгөөлөгчийн ёс зүйтэй холбоотой хариуцлага нь Өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх Мэргэжлийн хариуцлагын хороонд шийдвэрлэгдэхээр зохицуулсан байгаа нь хэр оновчтой талаар болон 2002 оны Өмгөөлөгчийн тухай хууль, 2012 онд баталсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар тус тус өмгөөлөгчийн ёс зүйтэй холбоотой харилцааг зохицуулж байсантай харьцуулж, дэвшилтэт тал байгаа эсэхийг дүгнэн үзэх, хариуцлагын төрөлд дүн шинжилгээ хийх нь уг судалгааны ажлын шинэлэг тал юм.

## ҮНДСЭН ХЭСЭГ

### Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлага, түүнтэй холбоотой маргааныг шийдвэрлэх бүрэлдэхүүн

#### 1. Өмгөөллийн үйл ажиллагаа ба ёс зүйн асуудал

##### *Өмгөөлөгчийн үйл ажиллагаа:*

Өмгөөлөгч гэдэг нь /латинаар advocates-тусламж үзүүлэхийг гуйх гэсэн үг бөгөөд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт ба шүүхийн бүх үе шатанд сэжигтэн, яллагдагч, хохирогч, шүүгдэгчийн хууль ёсны эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж тэдний үйлдэл, эс үйлдэхүйд үнэлэлт дүгнэлт хийж зөвлөгөө өгөх, шүүх хуралдаанд төлөөлөн оролцох зэргээр хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлдэг эрх зүйн мэргэжилтэн юм.<sup>2</sup>

<sup>2</sup> П.Долгор, Монголын өмгөөлөгчдийн байгууллага ба өмгөөлөл, УБ., 2005 он, 9 дэх тал.

Манай улсад /1928 оноос 1994 он хүртэл/ шүүн таслах явдлын тухай олон ардад тусламж үзүүлэх бүлгэмээс эхлэн өмгөөлөгчдийг эгнээндээ нэгтгэсэн өмгөөлөгчдийн коллиги, аймаг, хотуудад хууль зүйн зөвлөгөө өгөх газар байгуулагдсан байна.<sup>3</sup>

Анх Улсын Их Хурлаас “Өмгөөллийн тухай хууль” 1995 оны хоёрдугаар сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн болон Монгол Улсын Их хурлын баталсан 18 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Монгол улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт: “Иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх болон нотариатын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, хувийн хэвшлийн хууль зүйн зөвлөгөө өгөх байгууллагын сүлжээг бүрдүүлэх үндсийг хуулиар тогтооно. Эрүү, иргэний ба захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд явагдах өмгөөллийн үйл ажиллагааны болон өмгөөлөх байгууллагын талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох” гэж заасан нь 1992 онд ардчилсан Үндсэн хуультай болсноос хойш өмгөөллийн үйл ажиллагаа болон өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг анхлан хуульчилсан явдал байсан.

Урьд нь өмгөөллийн үйл ажиллагаа гэдэгт Өмгөөлөгчдийн холбоонд бүртгэлтэй өмгөөлөгчийн зүгээс иргэн болон хуулийн этгээдэд эрх зүйн талаарх асуудал, маргаанд зөвлөгөө өгөх, тайлбарлах, албан бичиг гаргаж эхлэх хэлцэл байгуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчээ төлөөлөн оролцох гэх мэтчилэн үйл ажиллагааг ойлгодог байсан. Харин орчин үед өмгөөллийн үйл ажиллагааг хувь хүмүүс болон хуулийн этгээдэд эрх зүйн зөвлөгөө өгөх замаар өмгөөллийг зохион байгуулах ба иргэн, арбитрч, захиргааны ба эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалж төлөөлөн оролцохоос гадна хуульд заасан туслалцааны бусад төрлүүдээр мэргэжлийн үндсэн дээр үзүүлсэн хууль зүйн туслалцаагаар өмгөөлөгчийн үйл ажиллагаа илэрнэ гэжээ.

Шинэ<sup>4</sup> Өмгөөллийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-г: “өмгөөллийн үйл ажиллагаа” гэж өмгөөлөгчөөс үйлчлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн туслалцаа, үйлчилгээг ойлгоно гэж заасан.

#### *Өмгөөлөгчийн ёс зүйн асуудал:*

Өмгөөлөгч нь өмгөөллийн үйл ажиллагаагаа эрхлэх явцад баримтлах ёс зүйг шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд авч үзэн өмгөөлөгчийн мэргэжлийн мөн чанартай холбогдох, үйлчлүүлэгчидтэй харьцах, бусад өмгөөлөгчдөд хандах, бусад хуульчидтай харьцах гэсэн хэсэгт ангилж болох юм. Өмгөөлөгчийн мэргэжлийн мөн чанартай холбогдох ёс зүйн хэм хэмжээ гэх ойлголтод өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааны мөн чанарыг алдагдуулахгүй байлгахад чухал ач холбогдолтой. Хүний эрхийг хамгаалах, нийгмийн шударга ёсыг хэрэгжүүлэх, мэргэжлийнхээ нэр хүндийг дээшлүүлэх гол хүчин зүйл нь өмгөөлөгч ёс зүйн хэм хэмжээгээ баримтлах явдал байдаг.<sup>5</sup>

Өмгөөлөгчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан Ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрх, эрх чөлөө хамгаалах гол хэмжүүр бол өргөн хүрээний мэдлэг, баялаг туршлага хуримтлуулан, мэргэжлийн ёс зүй, хуулийг сахин биелүүлэх, хууль хэрэглэх ур чадварыг эзэмших явдал мөн билээ. Хуульч мэргэжил эзэмшиж өмгөөлөгч болсны хувьд бусадтай харилцахдаа мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг хатуу сахих учиртай болдог<sup>6</sup>. Эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдлыг өмгөөлөгчийн ёс зүйн дүрмээ зөрчлөө гэж үздэгээс биш ёс зүйн хувьд баримтлах ёстой үнэлэмж байдаггүй, өөрөөр хэлбэл ямар өмгөөлөгчийг ёс зүйтэй өмгөөлөгч гэх эрх зүйн тодорхойлолт одоогоор алга байна.

#### *Өмгөөлөгчийн баримтлах хэм хэмжээ*

Аливаа нэг өмгөөлөгч нь өмгөөлөгчийн эрх зүйн баталгааг аль нэг байгууллага байгуулах эсхүл тусгайлан хууль батлагдсанаар хэрэгжинэ гэж ойлгодог. Гэтэл Хуульч мэргэжилтний эрх зүйн баталгаа нь зөвхөн нэг хууль буюу тухайлбал Өмгөөллийн тухай хууль батлах байдлаар хэрэгжихгүй нь дээр дурдсанаар Хуульчийн мэргэжлийн эрх зүй олон төрлийн хэм хэмжээ бүрдүүлж буйгаас тодорхой харах боломжтой байдаг.

Өмгөөлөгчийн ёс зүйн шаардлагыг Монгол Улсын Үндсэн хууль<sup>7</sup>, Хуульчдын эрх зүйн

<sup>3</sup> Мөн тэнд, 11 дэх тал.

<sup>4</sup> 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан.

<sup>5</sup> С.Нарангэрэл, “Хүний эрх, өмгөөлөл” УБ, 1998 он, 9 дэх тал.

<sup>6</sup> Н.Сосорбарам, “Өмгөөлөгчийн ёс зүйн зарчим” *Хууль дээдлэх ёс сэтгүүл*, №03(2004), 36-37 дах тал.

<sup>7</sup> Төрийн мэдээлэл сонин, 1992 он, №1

байдлын тухай хууль<sup>8</sup>, Өмгөөллийн тухай хууль<sup>9</sup>, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм болон өмгөөллийн үйл ажиллагааны талаарх асуудлыг зохицуулсан хуулиуд тухайлбал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль<sup>10</sup>, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>11</sup>, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>12</sup>, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль<sup>13</sup>, мөн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Их Хурлаар 2020 оны 10 дугаар сарын 03-нд баталсан “Өмгөөлөгчдийн мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ээр зохицуулахаар шийдвэрлэсэн бөгөөд дараах зарчмыг тодорхойлсон.

## 2. Өмгөөлөгчийн мэргэжлийн хариуцлага хүлээлгэх үндэслэл

Өмгөөлөгчдийн хувьд мэргэжлийн дүрмээ хэлбэрэлтгүй мөрдөх нь дараах хоёр шалтгаантай байж болно. Нэгдүгээрт, мэргэжлийн дүрэм нь өмгөөлөгчийн баримтлах нийтлэг зарчим, ёс зүйн хэм хэмжээ, өмгөөлөгчийн тусгайлсан үүрэг, мэргэжлийн зарчимч байдлыг тусгаж, өмгөөлөгчийн нэр хүнд, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн байдаг. Хоёрдугаарт, өмгөөлөгч мэргэжлийн дүрмээ зөрчсөн үйлдэл буюу мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд Өмгөөллийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг.

Хуульчийн ёс зүйн зөрчил нь угтаа хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомж зөрчсөн гэж зааснаараа эрх зүйн зөрчлөөс ялгагдах аргагүй байдалд хүргэжээ. Харин “Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм”-д өмгөөлөгчийн ёс зүйн зөрчлийг “хууль болон энэ дүрэмд заасан үүрэг, шаардлагыг зөрчсөн өмгөөлөгчийн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчилд тооцно” гэж тодорхойлсон байдаг бөгөөд өмгөөлөгчид сануулах, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нэгээс гурван жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хугацаагүй түдгэлзүүлэх гэсэн шийтгэлээс оногдуулдаг.

Сахилгын зөрчил гэдэгт тодорхой этгээд эрх зүйн хэм хэмжээ болон захиргааны хэм хэмжээний актад сахилгын хариуцлага хүлээлгэхээр заасан албаны болон бусад үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэм буруутай, хууль зөрчсөн үйлдлийг ойлгоно. Сахилгын зөрчил нь хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалтны буюу албан ажлын журамд заасан хөдөлмөрлөх үүргийг зөрчсөн, дээд шатны байгууллага, албан тушаалтны хууль ёсны захирамжийг биелүүлээгүй зэргээр илэрнэ. Сахилгын зөрчилд холбогдох хууль тогтоомж (жишээлбэл, хөдөлмөрийн тухай хууль, төрийн албаны тухай хууль зэрэг), сахилгын хариуцлагыг зохицуулсан захиргааны хэм хэмжээний актын дагуу сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

Өмгөөлөгчийн ёс зүйг зөв тодорхойлоогүй түүнчлэн ёс зүйн зөрчлийг сахилгын зөрчлөөс шинжлэх ухааны үндэстэй зааглан ялгаж чадаагүйн улмаас сахилгын зөрчил болон хуульчийн ёс зүйд хамааралгүй зүйлийг ёс зүйн зөрчил хэмээн үзсэн явдал манай улсад ихээхэн газар авсан гэж харч байна.

Сахилгын зөрчил болон ёс зүйн зөрчил хоёрыг хооронд нь зааглахад зөрчил гэж үзэн хариуцлага хүлээлгэх үндэслэл болгож байгаа эрх зүйн зохицуулалтын хувьд өөр байгаа бөгөөд ёс зүйн зөрчилд мэргэжлийн алдаа багтах боломжтой байдаг бол сахилгын зөрчил гэдэг нь тухайн өмгөөлөгчийн хөдөлмөрийн гэрээ болон хууль, дүрмийн дагуу гүйцэтгэх ёстой ажил, үүргээ зөрчсөн болон биелүүлээгүй үйлдлийг ойлгоно.

## 3.1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар (2012) ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн байдал

Хуульчдын Анхдугаар Их Хурлаас “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийг баталсан бөгөөд тус дүрэм нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, ер нь хуульчийн гэрчилгээтэй хэн бүхэн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд үйлчлэх зохицуулалтыг агуулсан байдаг. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар “Хуульчийн мэргэжлийн дүрэм”-д зааснаар мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гаргасан эсэхийг

<sup>8</sup> Төрийн мэдээлэл сонин, 2012 он, №11

<sup>9</sup> Төрийн мэдээлэл сонин, 2019 он, №49

<sup>10</sup> Төрийн мэдээлэл сонин, 2017 он, №23

<sup>11</sup> Төрийн мэдээлэл сонин, 2002 он, №8

<sup>12</sup> Төрийн мэдээлэл сонин, 2016 он, №9

<sup>13</sup> Төрийн мэдээлэл сонин, 2017 он, №24

хянан шийдвэрлэх чиг үүрэгтэйгээр Мэргэжлийн хариуцлагын хороог байгуулсан.<sup>14</sup>

Мэргэжлийн хариуцлагын хороо нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил, сахилга, ёс зүйн байдал Хуульчдын холбооны хүсэлтээр дүгнэлт гаргах, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн эсэх болон хуульчийн мэргэжил, ур чадварын төвшинд эргэлзсэн тухай маргааныг гомдлын дагуу хянан шийдвэрлэж, хуульд заасан хариуцлага хүлээлгэх<sup>15</sup> чиг үүрэгтэй байдаг бөгөөд 30 гишүүний бүрэлдэхүүнтэй байдгаас хорооны бүрэлдэхүүнд шүүгчдийн төлөөлөл 18, прокурор, өмгөөлөгчдийн төлөөлөл тус бүр 6 байхаар хуульчилсан байдаг. Дараах субъектүүдээс ирсэн хүсэлт, гомдлын дагуу маргаан үүсгэх эрхтэй. Үүнд:

- Өмгөөлөгч болон үйлчлүүлэгч хооронд үүссэн маргааныг үйлчлүүлэгчийн гомдлоор;
- Шүүгч, прокурор, нотариатч, өмгөөлөгчийн Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн тухай болон хуульчийн мэргэжил, ур чадварын төвшинд эргэлзсэнтэй холбоотой үүссэн маргааныг шүүгч, прокурор, өмгөөлөгчийн гомдлоор;
- Хуульч Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг болон Хуульчдын холбооны хууль ёсны шийдвэр, үүрэг даалгаврыг зөрчсөнтэй холбоотой маргааныг Хуульчдын холбооны хүсэлтийг тус тус хүлээн авдаг.
- Мэргэжлийн хариуцлагын хороо дор дурдсан хариуцлагын төрлүүдээс хүлээлгэхээр хуульчилсан. Үүнд:
  - Хаалттай болон нээлттэй сануулах;
  - Шүүхэд төлөөлөх эрхийг хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх;
  - Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх;
  - Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй хүчингүй болгох.

Мөн Мэргэжлийн хариуцлагын хорооны “Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам”-ын 2.6 дугаар зүйлийн 1-д “Хариуцагчийн гаргасан зөрчлийн шинж чанар, хир хэмжээнээс хамаарч бүрэлдэхүүн ёс зүйн болон нөлөөллийн сургалтад албадан суулгах нэмэгдэл шийтгэлийг нөлөөллийн арга хэмжээ болгон хэрэглэж болно” гэсэн нэмэгдэл шийтгэл оногдуулахаар зохицуулсан байна. Одоогийн байдлаар ёс зүйн болон нөлөөллийн сургалтад албадан суулгах нэмэгдэл шийтгэл хүлээлгэсэн тохиолдол нэг байна. Мэргэжлийн хариуцлагын хороо нь 2014-оноос 2019 оны хооронд 1219 гомдол, хүсэлтийг хүлээн авсан бөгөөд 442 хэрэг маргаан үүсгэж 127 хуульчдад сахилгын шийтгэл оногдуулсан байна.<sup>16</sup>

*Хүснэгт 1.*

Он	Гомдолд холбогдсон субъект				Нийт
	Өмгөөлөгч	Шүүгч	Прокурор	Бусад хуульч	
2014	146	49	10	-	205
2015	193	30	6	-	229
2016	213	36	1	-	250
2017	199	47	3	-	249
2018	158	16	3	5	182
2019	88	9	7	-	104
<b>Нийт</b>	997	187	30	5	1219
<b>Эзлэх хувь</b>	81.78%	15.34%	2.46%	0.41%	100%

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012)-д Шүүгчийн ёс зүйн хороо, Прокурорын тухай хууль (2017)-д “Прокурорын мэргэжлийн болон ёс зүйн зөвлөлтэй байна” гэж тус тус хуульчилснаас үзвэл шүүгч, прокурорт хариуцлага хүлээлгэх тогтолцоог тус тусын байгууллагад хамаарахаар харагдаж байна. Иймд Мэргэжлийн хариуцлагын хороо

<sup>14</sup> 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсон.

<sup>15</sup> Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1

<sup>16</sup> Энэ хэсэгт бичсэн тоон мэдээллүүдийг “Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийн эмтгэл”-ээс авсан болно.

нь бусад хуульчид, ялангуяа өмгөөлөгчтэй холбоотой асуудлыг голчлон шийдвэрлэдэг байсан нь дээрх хүснэгтэн мэдээллээс харагдаж байна.

### 3.2. Өмгөөллийн тухай хуулиар (2019) ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдан хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш тус хуулийн өмгөөллийн үйл ажиллагаатай холбогдох зохицуулалтын талаарх саналууд ирсээр байсан. Улмаар Монголын Хуульчдын Холбооноос 2015 онд нийт өмгөөлөгчдийн дунд судалгаа явуулсан бөгөөд тус судалгааны үр дүнд өмгөөлөгчдийн 62,5 хувь нь Хуульчийн эрх зүйн байдлыг хуулийг шинэчлэн найруулах болон Өмгөөллийн тухай хуулийг дэмжсэн бөгөөд 37,5 хувь нь Өмгөөллийн тухай бие даасан хуультай болсноор өмгөөлөгчийн эрх зүйн байдал сайжирч, өмгөөлөгчийн нэр хүнд, мэргэжлийн ур чадвар өснө гэж үзжээ. Түүнчлэн дээрхи судалгаан дээр нэмээд Монголын Өмгөөлөгчдийн холбоо ТББ-аас 2016 онд явуулсан санал асуулгад оролцогчдын 91,9 хувь нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг бүрэн тодорхойлж чадахгүй гэж тус тус хариулсан байна.

2002 онд батлан хэрэгжиж эхлэсэн хуучин Өмгөөллийн тухай хуулийг хүчингүй болгосноор өмгөөлөгчдийн мэргэжлийн удирдлага, зохион байгуулалт, өмгөөллийн үйл ажиллагааны бие даасан байдал, өмгөөлөгчийн хараат бус байдал алдагдаж, мэргэжлийн ёс зүй, хариуцлага суларч, тус хуульд заасан өмгөөлөгчийн эдлэх нийтлэг бүрэн эрх байхгүй болж, өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг бүрэн хамгаалж чадахгүй байх нөхцөл байдал үүссэн хэмээн мэргэжлийн судлаачид дүгнээд байна. Түүнчлэн, хууль сахиулах болон прокурорын байгууллагад ажиллаж байсан хуульчид ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан, огцорсны дараа ямар нэгэн хяналт, хязгаарлалтгүйгээр шүүхэд төлөөлөх эрх авч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх болсон нь хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг алдагдуулах, өмгөөлөгчийн мэргэшлийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөхөөр байна. Дээрх судалгаануудын үр дүн болон энэ талаар судалгаа явуулдаг судлаачдын байр суурийг харахад Өмгөөллийн тухай хуулийг батлах бодит хэрэгцээ шаардлага нийгэмд үүссэн гэж дүгнэж болохоор байна.

Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх явцдаа алдаа гаргасан гэж үзэн Мэргэжлийн хариуцлагын хороо Өмгөөллийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-г зааснаар Мэргэжлийн хариуцлагын хороо өөрийн санаачилгаар, Өмгөөлөгчдийн Холбооны Удирдах зөвлөл, Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгчийн хүсэлт, эсхүл шүүгч, прокурор, хүн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийн дагуу маргаан үүсгэнэ. Ийнхүү маргаан үүсгэхээр хүсэлт, гомдол, мэдээлэл ирүүлэхдээ дараахи мэдээллийг тусгасан байна.<sup>17</sup> Үүнд:

- хүсэлт, гомдол, мэдээллийг ирүүлсэн хүн, хуулийн этгээд, албан тушаалтан, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн нэр, холбоо барих мэдээлэл;
- хүсэлт, гомдол, мэдээлэлд холбогдох өмгөөлөгчийн нэр, холбоо барих мэдээлэл, харьяалах өмгөөллийн хуулийн этгээдийн нэр, хаяг;
- холбогдох хууль, Ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн талаарх мэдээлэл;
- холбогдох хууль, ёс зүйн дүрэм зөрчсөн гэж үзсэн үзсэн үндэслэл, түүнийг нотлох баримт сэлт, мэдээлэл байдаг.

Өмгөөллийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-г Мэргэжлийн хариуцлагын хорооны чиг үүргийг өмгөөлөгч Өмгөөллийн тухай хууль болон Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, энэ хууль болон Ёс зүйн дүрмийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах гэж хуульчилсан байдаг. Өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх Мэргэжлийн хариуцлагын хорооны олонх гишүүн нь буюу 11 гишүүнээс 7 нь өмгөөлөгч байна гэж хуульд заасан нь нэг ёсондоо өмгөөлөгчийн ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргавал хариуцлага хүлээлгэх субъектүүдийн ихэнх нь өмгөөлөгч, тодруулбал мэргэжил нэгт нөхөр нь байна гэсэн үг юм. Эцэстээ шүүгч шүүгчийнхээ асуудлыг, прокурор прокурорынхоо асуудлыг, өмгөөлөгч өмгөөлөгчийнхөө асуудлыг шийддэг өмнөх тогтолцоо руугаа шилжих магадлалтай. Мөн ихэнх нь буюу талаас илүү хувь нь өмгөөлөгчөөс бүрдсэн Өмгөөлөгчийн холбооны

<sup>17</sup> Өмгөөллийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дугаар заалт



дэргэдэх Мэргэжлийн хариуцлагын хороог байгуулбал одоогийн Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо шиг хараат бус, бие даасан, үр нөлөөтэй байж чадах эсэх нь эргэлзээтэй байна.

Мэргэжлийн хариуцлагын хороо нь хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авч 30 хоногт багтаан шийдвэрлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл энэ хугацааг нэг удаа сунгах боломжтой байдаг. Ийнхүү шийдвэрлэхдээ Мэргэжлийн хариуцлагын хорооны нийт гишүүдийн дийлэнх олонхын ирцтэйгээр оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болж шийдвэрээ оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар гаргахаар заасан нь хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд байгаа өмгөөлөгчдийн саналын үнэ цэнийг харуулж болох юм.

Тухайн өмгөөлөгч нь хууль болон өмгөөлөгчдийн ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд дараах сахилгын шийтгэл оногдуулахаар зохицуулжээ. Үүнд:

3.2.1. сануулах,

3.2.2. өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нэгээс гурван жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх,

3.2.3. өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох

Өмгөөллийн тухай хууль шинээр батлагдан Өмгөөлөгчдийн холбооны дэргэд Мэргэжлийн хариуцлагын хороо байгуулагдсанаас хойш өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдол, мэдээллийг авж эхэлсэн эсэх талаар тус байгууллагаас утсаар холбогдон лавлахад одоогийн байдлаар олон нийтэд хэвлэгдээгүй гэсэн тайлбар мэдээллийг өгсөн.

Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйтэй холбогдох харилцааг эрх зүйн хөгжлийн явцад холбогдох хууль тогтоомжоор зохицуулж ирсэн бөгөөд одоогийн байдлаар 2019 онд батлагдсан Өмгөөллийн тухай хуулиар зохицуулж байна. Тухайн үеийн эрх зүйн зохицуулалтаар өмгөөлөгчид хүлээлгэж байсан хариуцлагын төрөл болон хариуцлага хүлээлгэх байгууллагыг харьцуулан авч үзье.

*Хүснэгт 2.*

	2002 оны Өмгөөллийн тухай хууль	2012 оны Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль	2019 оны Өмгөөллийн тухай хууль
<b>Хариуцлагын төрөл</b>	1. сануулах, 2. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах	1. Хаалттай болон нээлттэй сануулах 2. Шүүхэд төлөөлөх эрхийг хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх 3. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх 4. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй хүчингүй болгох.	1. сануулах 2. өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нэгээс гурван жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх 3. өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох
<b>Хариуцлага хүлээлгэх байгууллага</b>	Сахилгын хороо-5 гишүүнтэй байна.	Мэргэжлийн хариуцлагын хороо-30 гишүүнтэй: Шүүгч 18 Прокурор 6 Өмгөөлөгч 6	Мэргэжлийн хариуцлагын хороо- 11 гишүүнтэй: Шүүгч 1 Прокурор 1 Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 1 Иргэдийн төлөөлөл 1 Өмгөөлөгч 7

4. Гадаад орны зохицуулалт

Өмгөөллийн тухай хуулиар өмгөөлөгч хууль болон ёс зүйн дүрэмд заасан зөрчил гаргасан эсэх маргааныг Өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх Мэргэжлийн хариуцлагын хорооны шийддэг. Тус хорооноос гаргасан шийдвэр хараат бус байх шинжийг хангаж



чадах эсэх асуудал дээр эргэлзээ төрүүлж байгаа тул бусад орны өмгөөлөгчид мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээлгэх механизмын талаар хууль эрх зүйн зохицуулалтыг авч үзье.

4.1. Бүгд Найрамдах Солонгос улсын өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйд хариуцлага хүлээлгэх механизм

БНСУ-ын өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой сахилгын шийтгэл ногдуулах тухай Өмгөөлөгчийн тухай болон Прокурорын тухай хуулиудаар тус тус зохицуулдаг бөгөөд сахилгын хэргийг дараах субъектүүдийн өргөдлийн дагуу үүсгэдэг<sup>18</sup>:

- Дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор;
- Орон нутгийн өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч;
- Өмгөөлөгчийн холбооны ерөнхийлөгч;
- Үйлчлүүлэгч болон бусад хууль ёсны төлөөлөгчид;

Өмгөөлөгчийн тухай өргөдлийг орон нутгийн Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгчид гаргах бөгөөд хэрэв тухайн орон нутгийн Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч хүсэлтийг эс зөвшөөрөн эсвэл бүрэн хэмжээнийхээ хүрээнд арга хэмжээ авахгүй эс үйлдэхүй гаргавал тухайн өргөдлөө дахин гаргах эрхтэй байдаг.

Хуульчдын холбоо болон Хууль зүйн яам аль аль нь сахилгын хороотой бөгөөд Прокурорын сахилгын шийтгэлийн журамд заасан журмын дагуу сахилгын шийтгэл ногдуулах шийдвэр гаргадаг. Хэрэв Хуульчдын холбооны Прокурорын сахилгын хорооноос гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байвал сахилгын шийтгэл ногдуулсан этгээд Хууль зүйн яамны сахилгын хороонд гомдол гаргаж болно.

Тухайн гомдол гаргагч өмгөөлөгчид хүлээлгэсэн сахилгын шийтгэлийг эс зөвшөөрсөн тохиолдолд Захиргааны хэргийн шүүхэд шийтгэлийн талаар мэдсэнээс хойш 90 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй байдаг. Дараах таван төрлийн сахилгын шийтгэлийг ногдуулдаг. Үүнд:<sup>19</sup>

- Шүүхэд төлөөлөх эрхийг хугацаагүй хасах;
- Шүүхэд төлөөлөх эрхийг хугацаатайгаар хасах;
- Гурван жил ба түүнээс доош хугацаагаар өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх;
- 30 сая вонн хүртэл торгууль ногдуулах;
- Сануулах зэрэг хамаардаг.

Өмгөөлөгчийн тухай хуулийг зөрчсөн, Өмгөөлөгчдийн холбоо буюу орон нутгийн өмгөөлөгчдийн холбооны дүрмийг зөрчсөн, өмгөөлөгчийн нэр төрд халдсан гэх мэт үйлдэлд сахилгын шийтгэл ногдуулдаг байна. Шүүхэд төлөөлөх эрхийг хугацаагүй хасах тухай шийтгэл нь ховор тохиолддог бөгөөд 2018 онд анх удаа тус шийтгэлийг ногдуулсан.

Өмгөөлөгчийн ёс зүйн дүрмийг 1958 оны 09 дүгээр сард батлан 1962 оны 06 дугаар сарын 30-наас хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд 1962 оны хувилбар нь оршил, зургаан бүлэг, тавин хоёр зүйлтэй байсан. 1962 оны Өмгөөлөгчийн ёс зүйн дүрмийн зорилго нь<sup>20</sup>:

- Өмгөөлөгч нь шударга ёсыг ухамсарлаж, эрх чөлөөний төлөө ажиллана.
- Өмгөөлөгч нь үнэнийг эрэлхийлж, ёс зүйг хүндэтгэнэ.
- Өмгөөлөгч нь Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг хүндэтгэж, Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн эсрэг үйлдэл хийхийг тэвчдэггүй.
- Өмгөөлөгч нь эрх мэдлээ хэтрүүлэн эрх мэдэлд шунаж болохгүй.
- Өмгөөлөгчид өөрийгөө байнга хөгжүүлж, улс орондоо хувь нэмэр оруулахыг хичээнэ гэж заасан байдаг

2000 онд Ёс зүйн дүрмийг<sup>21</sup> Өмгөөлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн шинэчлэн баталсан бөгөөд агуулгын хувьд томоохон өөрчлөлт оруулсан байдаг. Хуулийн тогтолцооны өөрчлөлттэй илүү уялдсан нэмэлт, өөрчлөлт оруулсан Ёс зүйн дүрэм нь хүний үндсэн эрх ашгийг хамгаалагч өмгөөлөгчдийг дэмжиж, нийгмийн шударга ёсны хэрэгжилтийг эрхэм зорилго болгосон байдаг.

<sup>18</sup> Бүгд Найрамдах Солонгос улсын Өмгөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2000 он

<sup>19</sup> Бүгд Найрамдах Солонгос улсын Өмгөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2000 он

<sup>20</sup> Мөн тэнд.

<sup>21</sup> Бүгд Найрамдах Солонгос улсын Өмгөөлөгчийн ёс зүйн дүрэм. 2000 он

Өмгөөлөгчид мэргэжлийн хариуцлага ногдуулахдаа прокуророос бүрдсэн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэдэг бөгөөд энэ нь хараат бус байдлыг хангахад дөхөм болдог гэж үздэг байна.

#### 4.2. Япон улсын өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйд хариуцлага хүлээлгэх механизм

Япон улсын Өмгөөлөгчийн тухай хуульд өмгөөлөгчийн эрхэм зорилгыг “Хүний үндсэн эрхийг хамгаалах, нийгмийн шударга ёсыг тогтоох” гэж заасан байдаг.

Өмгөөлөгчийн тухай хуульд<sup>22</sup> зааснаар Японы Өмгөөлөгчдийн Холбоо нь өмгөөлөгчийн нэгдлээс бүрддэг. Японы Өмгөөлөгчдийн Холбооны зорилго нь өмгөөлөгчийн мэргэжлийн эрхэм зорилго, үүргийг харгалзан өмгөөлөгчийн харилцаа холбоо, хяналт шалгалттай холбоотой асуудлыг удирддагаар хангах, нэр хүндийг хадгалахад оршино. Тус холбоо нь өмгөөлөгчийн баримтлах дүрмийг батлах эрх хэмжээтэй байдаг бөгөөд тус дүрэмд өмгөөлөгчийн ёс зүйн хариуцлагатай холбоотой асуудлыг зохицуулсан байдаг. Өмгөөлөгч нь мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулдаг бөгөөд Японы Өмгөөлөгчдийн Холбоо нь шийдвэр гаргадаг байна.

Дараах дөрвөн төрлийн хариуцлага хүлээлгэдэг<sup>23</sup>:

1. Сануулах;
2. Шүүхэд төлөөлөх эрхийг хоёр жилээс илүүгүй хугацаагаар түдгэлзүүлэх;
3. Өмгөөлөгчдийн холбооны гишүүнээс хасах;
4. Шүүхэд төлөөлөх эрхийг хүчингүй болгох гэсэн байдаг.

Японы Өмгөөлөгчдийн Холбоо нь тухайн өмгөөлөгчийн харьяалагдах өмгөөллийн хуулийн этгээдэд хүсэлт өгөх замаар өмгөөлөгчид хариуцлага хүлээлгэх боломж бас байдаг бөгөөд халах хүртэлх сахилгын шийтгэлийг ногдуулдаг. Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагыг Сахилгын шийтгэлийн хороо ногдуулдаг бөгөөд дөрөв буюу түүнээс дээш тооны гишүүдээс бүрддэг. Үүнд өмгөөлөгч, шүүгч, прокурор, эрдэм шинжилгээний шинжээч хамаардаг.

#### 4.3. Оросын Холбооны Улсын өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйд хариуцлага хүлээлгэх механизм

Оросын Холбооны Улсын Өмгөөллийн тухай хуульд<sup>24</sup> зааснаар хуульд заасан журмаар өмгөөлөгчийн эрхээ авсан хүн, хуулийн этгээдийг өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд гэж авч үздэг. Тухайн өмгөөлөгч хууль болон холбогдох ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх хүртэлх хариуцлагыг ногдуулдаг. Тус хуулийн дагуу өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагатай холбогдох асуудлыг бүтцийн хувьд Мэргэшлийн комисс болон Ёс зүй ба стандартын комиссын бүрэн эрхэд тус тус хамаарахаар байна. Мэргэшлийн комисс нь манай улсын Мэргэжлийн хариуцлагын хороотой ижил төстэй бүрэн эрхтэй байдаг. Мэргэшлийн комиссын бүрэлдэхүүн дараах 13 субъектүүдээс бүрддэг бөгөөд хоёр жилийн хугацаанд бүрэн эрхээ хэрэгжүүлдэг. Үүнд:<sup>25</sup>

- Өмгөөлөгчийн холбооноос 7 өмгөөлөгч;
- Тухайн нутаг дэвсгэрийн шударга ёсны байгууллагаас хоёр төлөөлөгч;
- Оросын Холбооны Улсын хууль тогтоох байгууллагаас хоёр төлөөлөгч;
- Шүүх байгууллагаас нэг шүүгч;
- Арбитрын шүүхээс нэг шүүгчээс тус тус бүрддэг бөгөөд Мэргэшлийн комиссын даргыг гишүүдийн олонхоор сонгодог.

Аливаа нэг гомдол, мэдээллийг хянан хэлэлцэж шийдвэр гаргахдаа нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн ирцтэй тохиолдолд хүчин төгөлдөрт тооцох бөгөөд зөрүүтэй санал гаргасан гишүүн дүгнэлт бичиж шийдвэрт хавсаргахаар хуульчилсан байдаг. Онцлог нэг зохицуулалт нь өмгөөлөгчид холбогдуулах гомдол гаргаж байгаа этгээд тус гомдлыг хэлэлцэхэд өмгөөлөгч авах эрхтэй байдаг.

<sup>22</sup> [https://www.nichibenren.or.jp/en/about/judicial\\_system/attorney\\_system.html](https://www.nichibenren.or.jp/en/about/judicial_system/attorney_system.html) Сүүлд 2022.11.02-нд үзсэн

<sup>23</sup> Мөн тэнд.

<sup>24</sup> <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3636> Сүүлд 2022.11.24-нд үзсэн

<sup>25</sup> [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_36945/81790fedaabbd21edcc8421d627f79200eadb39/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_36945/81790fedaabbd21edcc8421d627f79200eadb39/) Сүүлд 2022.11.02-нд үзсэн

## ДУГНЭЛТ, САНАЛ

Одоогийн байдлаар өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйтэй холбогдох харилцааг 2019 онд батлагдсан Өмгөөллийн тухай хуулиар зохицуулж байна. Тус хуулиар Өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх Мэргэжлийн хариуцлагын хорооны олонх гишүүн нь буюу 11 гишүүнээс 7 нь өмгөөлөгч байна гэж хуульд заасан нь өмгөөлөгчийн ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргавал хариуцлага хүлээлгэх субъектүүдийн ихэнх нь өмгөөлөгч байгаа нь тус хорооны хараат бус байдалд итгэх итгэлд нөлөөлж байна.

Өмгөөлөгчид мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээлгэж байгаа байгууллага бусад оронд ямар бүрэлдэхүүнтэй байдаг талаар авч үзсэн. Ингэхэд Япон улс болон ОХУ нэлээд өргөн хэмжээний бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр хуульчилсан бол БНСУ-ын хувьд ганц прокуророос бүрдэж байгаа нь нэг талаас хараат бус байдлаар шийдвэрлэх боломжийг олгодог гэж харж байна.

Өмгөөлөгчид мэргэжлийн ёс зүйн хариуцлагад холбогдох асуудлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Өмгөөлөгчид мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг олон нийтэд нээлттэй байдлаар хэвлэн нийтэлдэг болох;
- Өмгөөлөгч мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг Мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэлдэхүүний тэгш оролцоог хангах хүрээнд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар болон гадаад улсын сайн жишгээс өөрийн улсад тохирох байдлаар холбогдох эрх зүйн зохицуулалтад тусгах.

### COMPOSITION OF THE DISCIPLINARY COMMITTEE OF THE ASSOCIATION OF ATTORNEYS: PRESSING ISSUES

*Myagmarsuren S.*

*Researcher at the National Legal Institute of Mongolia,  
LL.M. candidate of School of Law, NUM*

#### **ABSTRACT:**

As an attorney, the main measure of protecting the human right and protecting freedom, which are the values of a democratic society declared in the Constitution of Mongolia, is to acquire a wide range of knowledge and rich experience, professional ethics, law enforcement, and the ability to apply the law. The Law on Advocacy approved in 2019 regulates the relations of professional activities. Specifically, the ethical issue of an attorney is fundamental, and the ethical responsibility must be imposed on the attorney to be clear, rational, and mandatory. The aim of the study is to the legal norms and practices related to the professional ethical responsibility of the attorney and made his opinion about the type of responsibility and the composition of the responsibility

#### **Keywords:**

Ethics of attorney, Attorney's professional activity

**ЭХ СУРВАЛЖ****I. Монгол эх сурвалж**

1. П.Долгор, Монголын өмгөөлөгчдийн байгууллага ба өмгөөлөл, УБ., 2005 он.
2. П.Долгор, Өмгөөлөгч, УБ., 1976 он.
3. Ш.Дуламсүрэн, Хуульчийн мэргэжлийн ёс зүй, УБ., 2007 он.
4. Монголын хуульчдын холбоо, С.Нарангэрэл, Монголын хуульчийн ёс зүйн онол – практикийн зангилаа асуудал, Монголын хуульчдын ёс (тулгамдсан асуудал), УБ., 2019 он.
5. Моригива Ясүтомо, Хуульчийн ёс зүй, УБ., 2007 он.
6. С.Нарангэрэл, Хүний эрх, өмгөөлөл, УБ., 1998 он.
7. Н.Сосорбарам, Өмгөөлөгчийн ёс зүйн зарчим, Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ., 2004 он.
8. Т.Сэнгэдорж, Хуульч мэргэжлийн ёс зүйн асуудал, УБ., 2010 он.
9. Хууль зүйн яам, Хуульчийн ёс зүй гарын авлага, УБ., 2013 он.
10. Хүний эрхийн үндэсний комисс, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл, УБ., 2002 он.

**II. Эрх зүйн эх сурвалж**

1. Бүгд Найрамдах Солонгос улсын Өмгөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2000 он.
2. Бүгд Найрамдах Солонгос улсын Өмгөөлөгчийн ёс зүйн дүрэм, 2000 он.
3. Монгол улсын Үндсэн хууль, 1992 он.
4. Оросын Холбооны улсын Өмгөөлөгчийн тухай хууль, 2002 он.
5. Өмгөөллийн тухай хууль, 1994 он.
6. Өмгөөллийн тухай хууль, 2002 он.
7. Өмгөөллийн тухай хууль, 2019 он.
8. Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, 2020 он.
9. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012 он.
10. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд бармтлах дүрэм, 2013 он.
11. Япон улсын Өмгөөлөгчийн тухай хууль, 1949 он.

**III. Цахим эх сурвалж**

1. <https://www.24tsag.mn/a/177913>
2. <https://ikon.mn/opinion/1feq>
3. <https://jargaldefacto.com/article/mongol-uls-dakhi-khuulich-umguulugchiin-kharaat-bus-baidal>
4. [https://www.nichibenren.or.jp/en/about/judicial\\_system/attorney\\_system.html](https://www.nichibenren.or.jp/en/about/judicial_system/attorney_system.html)

## 2019 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ БА УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ЗЭРЭГЛЭЛТЭЙ ХОТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



*Р.Хатансайхан  
ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан,  
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант*

### **ТОВЧЛОЛ:**

2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хот, тосгоны эрх зүйн хүрээнд чухал хоёр зохицуулалтыг Үндсэн хуульд оруулсан. Нэгдүгээрт, Үндсэн хуульд Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн статусыг оруулах, хоёрдугаарт улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотод засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг шилжүүлэх эрх олгосон хэм хэмжээ юм. 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй зэрэгцэн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль” болон “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 02 дугаар тогтоол батлагдсан. 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр үйлчилж эхлээд 2 жил 6 сарын хугацаа өнгөрсөн. Уг 2 жил 6 сарын хугацаанд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль” болон “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын Дугаар 02 тогтоолын хот, тосгоны эрх зүйд хамаарах зүйл заалт хэрхэн хэрэгжсэн болон хэрэгжиж буй талаар судалсан судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл ажил байхгүй. Иймд тус 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон түүнд холбогдох гарсан эрх зүйн баримт бичгийн нутгийн удирдлага, хот, тосгонд хамаарах зүйл заалтыг хэрэгжилтийг судлах шаардлагатай бөгөөд эл шаардлагад үндэслэн тус өгүүллийг бичлээ.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Үндсэн хууль, хот, тосгон, нэмэлт, өөрчлөлт, хууль тогтоомж

### **ҮНДСЭН ХЭСЭГ**

Судалгааны зорилго, зорилт, арга зүй

Эл өгүүллийн зорилго нь 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон түүнд холбогдон гарсан эрх зүйн баримт бичгийн нутгийн удирдлага, хот, тосгонд

хамаарах зүйл заалтыг хэрэгжилтийг судлах оршино. Энэ ч утгаараа дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

1. 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон түүнд холбогдон гарсан заасан эрх зүйн баримт бичгийг судлах;

2. Уг эрх зүйн баримт бичгийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 02 дугаар тогтоолтой харьцуулах;

3. Уг эрх зүйн баримт бичгийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуультай харьцуулах;

Судалгааны явцад Монгол Улсын Үндсэн хууль болон судлаачдын үзэл баримтлал, ном, сурах бичиг, өгүүллэг, судалгааны материал болон хууль тогтоомжуудыг харьцуулан судлах, задлан шинжлэх, индукци, дедукци, синтез зэрэг аргыг ашиглав.

### **1. 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн хот, тосгоны эрх зүй зохицуулалт ба 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт**

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлгээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын эрх үндсийг тогтоожээ. Тодруулбал, тавин долдугаар зүйлээс жаран гуравдугаар зүйл хүртэл 7 зүйл, 21 заалтаар “Монгол Улсын засаг захиргааны нэгж”, “нэгж дэх хот, тосгон”, “нэгжийг удирдлага”, “нутгийн өөрөө удирдах байгууллага”, “төрийн удирдлага”-ын эрх зүйн үндсийг бэхжүүлсэн.<sup>1</sup>

Түүнчлэн, Монгол Улсын их цаазын /үндсэн хууль/ төслийг хэлэлцэх үеэр буюу 1991 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн “Монгол улсын их цаазын /үндсэн хууль/ төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай” илтгэлийн зургаа дахь хэсэгт засаг захиргааны нэгж, түүний удирдлагын бүтцийн талаарх зарим асуудлын талаар ийнхүү өгүүлжээ. “...Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, түүний нэгж нутгийн захиргааны тогтолцоог зөв тодорхойлох явдал Үндсэн хууль, төрийн байгууламжийн язгуур асуудлын нэг юм. Улсын Бага Хурал Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комисс Монголын түүх, төр ёсны уламжлал, улсын эдийн засаг, газарзүй, хүн ам, үндэстний байршил, экологи зэрэг онцлогийг тал бүрээс нь харгалзан үзэж зохих байгууллагуудаас гаргасан судалгаа, санал дүгнэлтийг үндэслэн нутгийн захиргааны удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааных нь үндсэн чиглэлд зарчмын өөрчлөлт оруулахаар Их цаазад тусгалаа.

Тус улсад олон зуун жил төлөвшин тогтож, өөрчлөгдсөн шинэчлэгдэж ирсэн манай улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэвшсэн хуваарийг 1930-аад оноос өөрчилжээ. Үндсэндээ 1940-өөд онд бүрэлдэж одоо хүртэл мөрдөж байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь нь байгаль, эдийн засгийн дотоод нөөцийн хувьд хязгаарлагдмал, аж ахуйн уялдаа холбоо сул, аж ахуйн нэгжийг дагуулж байгуулсан засаг захиргааны олон жижиг нэгжтэй болсон учир бүх асуудлыг үндсэнд нь төвөөс шийдвэрлэдэг, орон нутгийн бие даасан байдлыг хангах эдийн засаг, нутаг дэвсгэрийн оновчтой, харилцаа уялдаатай холбоотой цогцолборуудыг бүрэлдүүлэн хөгжүүлэх боломжгүй байгаа юм.<sup>2</sup> гэжээ. Өөрөөр хэлбэл, 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийг эцэслэн баталсны дараа Дархан, Эрдэнэт, Чойр хотуудыг аймгийн статустай болгосноос бусдаар Монгол Улсын нутаг дэвсгэрийн нэгжийн тогтолцоо нь үндсэндээ социализмын үеийн чанарыг хадгалан үлдсэн.<sup>3</sup>

Түүнчлэн, Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээгээр “...Хөдөө орон нутагт тохируулан боловсруулсан захиргааны тогтолцоо

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, УБ., <https://bpo.gov.mn/uploads/files/2019/06/12/a7789c41fdb4af0f5be3dce261aa490a.doc> Сүүлд үзсэн огноо 2021.11.20

<sup>2</sup> 1991.XI.13, Ерөнхийлөгч П.Очирбатын Ардын их хурал, Улсын бага хурал, Засгийн газрын гишүүдэд хэлсэн үг, Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж, боть 4, УБ., 2022 он, 234 дэх тал.

<sup>3</sup> Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ., 2016 он, 157 дахь тал.



хотын асуудлыг шийдвэрлэхэд тохиромжгүй тул нийслэл хотоос гадна хотуудын ангиллыг бий болгох шаардлага тулгарч байна хэмээгээд “Нийслэлээс гадна зарим нутаг дэвсгэрийн нэгжийг хот гэж хүлээн зөвшөөрөх шаардлага байгааг харгалзан Үндсэн хуульд “хот”-ын ангиллыг нэмж тусгах шаардлагатай гэсэн зөвлөмжийг гаргасан.<sup>4</sup>

Ийнхүү 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн гуравдугаар зүйлийн 15 дахь заалтаар 57 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 16 дахь заалтаар 59 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус өөрчлөн найруулсан<sup>5</sup>. Уг нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлт нь үндсэн хуулийг тодруулах чиглэлийн зүйл заалтыг оруулсан. Өөрөөр хэлбэл 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн IV бүлэг болох “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага”-г орсон 2 зүйл, 3 заалт бүхий нэмэлт, өөрчлөлт нь бүхэлдээ тус бүлэг дэх 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалыг тодруулах зорилгоор хийгдсэн хэмээн үзэж болно<sup>6</sup>.

Монгол Улсын 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гол агуулга нь нэгдүгээрт, тодорхой чиг үүрэг шилжүүлэх асуудал, хоёрдугаарт хот, тосгоны эрх зүйн байдал, гуравдугаарт орон нутгийн өмчид хамаарна. Судлаачид 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг “...Ердийн хуулийн түвшин зохицуулахад бэрхшээлтэй асуудлын, суурийг үндсэн хуулийн түвшин шийдвэрлэх ач холбогдолтой...”<sup>7</sup> хэмээн тодотгосон.

1992 оны Үндсэн хууль, 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг харьцуулбал:

№	Хуулийн нэр	Зүйл заалт	Тайлбар
1.	1992 оны Монгол Улсын Үндсэн хууль	1. 57.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.	
2.	2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт	1. 57.2. Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсийг хуулиар тогтооно. 2. Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.	1. “улсын болон орон зэрэглэлтэй хотын түүнчлэн, тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалт” гэснийг шинээр нэмсэн. 2. Уг заалтын агуулгыг бүхэлд шинээр нэмсэн.

## 2. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дэх заалтын эхний өгүүлбэрийн тухайд

*(Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсийг хуулиар тогтооно)*

2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд батлагдах органик хууль бол “хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга юм. Монгол Улсын Их Хурлын “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2020 оны 01 дүгээр сарын 09 –ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийлүүлэх хуваарь”-ийг баталсан.

Тус хуваарийн дөрөвт “Нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлт”-ийн

<sup>4</sup> Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ., 2016 он 150 дахь тал.

<sup>5</sup> Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Үндсэн хууль эмхэтгэл, 2020 он, УБ., 62-74 дэх тал.

<sup>6</sup> А.Бямбажаргал, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт ба засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн шинэтгэл, 1 дэх тал.

<sup>7</sup> Д.Ганзориг, Нутгийн удирдлагын шинэ хуулийн талаар, [https://www.youtube.com/watch?v=33LUNmMXy\\_A](https://www.youtube.com/watch?v=33LUNmMXy_A) дэлгэрэнгүй үзнэ үү.

хуваарийг тусгасан. Ингэхдээ 4.1. Хот тосгоны эрх зүйн байдлыг тодорхой болгох нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална: 4.1.1. "...улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгоны эрх зүйн үндэс, тэдгээрийн өөрийн удирдлагын болон засаг захиргааны зохион байгуулалтын зарчмыг хуулиар тогтоож, эдийн засгийн хувьд хот, тосгон харьцангуй бие даан хөгжих боломжийг бүрдүүлэх" гэж заажээ.<sup>8</sup> Энэ нь чиглэл нь "хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн үзэл баримтлал болох учиртай.

"Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгыг батлах хугацааг "Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар 2020 он байхаар тогтоожээ. Уг тогтоолоор зөвхөн "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга гэлтгүй "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга, "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгыг 2020 онд батлахаар тусгасан<sup>9</sup>

Гэвч цаг үеийн шаардлага (Коронавируст цар тахал) болон бусад шалтгаанаас улмаас "Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталж<sup>10</sup>, хууль хүчин төгөлдөр болох хугацааг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр байхаар<sup>11</sup>, "Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж, хууль хүчин төгөлдөр болох хугацааг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр байхаар тус тус хуульчилсан.<sup>12</sup> Харин "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгыг батлаагүй.

Өөрөөр хэлбэл, 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд нэгдүгээрт, "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга, хоёрдугаарт, "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга, гуравдугаарт, "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгыг батлах ёстой. "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийг 2020 онд буюу Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд заасан хугацаанд баталсан бол Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгыг 2021 онд буюу Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд заасан хугацаанаас 1 жилийн дараа баталжээ. Гэвч "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд заасан хугацаанаас 2 жил өнгөрсөн хэдий ч батлаагүй.

2021 оны 9 дүгээр сард УИХ-ын төрийн байгуулалтын байнгын хорооноос "хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төслийг Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгийн удирдлагууд болон сумдын Засаг даргын Тамгын газар, хот, тосгодын захирагчид, хуулийн төслийг боловсруулах ажлын дэд багийн гишүүд зэрэг нийт 70 гаруй төлөөлөл оролцуулан цахимаар зохион байгуулсан.<sup>13</sup> Улмаар Монгол Улсын Их Хурлын 2022 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн "Монгол Улсын Их Хурлын 2022 оны

<sup>8</sup> Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Үндсэн хууль эмхэтгэл, 2020 он, УБ., 104 дэх тал.

<sup>9</sup> Мөн тэнд.

<sup>10</sup> Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2020 он, УБ., <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801> Сүүлд үзсэн огноо 2022.11.21

<sup>11</sup> Мөн тэнд.

<sup>12</sup> Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, , 2021 он, УБ., [https://legalinfo.mn/mn/detail/16230779072091?fbclid=IwAR3dy7hJi\\_i0vuGujuVatSnUFiXJWqX8R7pAFq3kvggQ1eWoplMhaw4jWqw](https://legalinfo.mn/mn/detail/16230779072091?fbclid=IwAR3dy7hJi_i0vuGujuVatSnUFiXJWqX8R7pAFq3kvggQ1eWoplMhaw4jWqw) Сүүлд үзсэн огноо 2022.11.21

<sup>13</sup> Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэг, УБ., 2021 он, <https://montsame.mn/mn/read/276409> Сүүлд үзсэн огноо 2022.11.21

хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Дугаар 08 тогтоолын 1.43/-д “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэхээр заасан”<sup>14</sup>.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” 52 дугаар тогтоолд “Хот, тосгоны эрх зүй байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл тусгагдаагүй<sup>15</sup>. Түүнчлэн цахим хэлбэрээр “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн төслийг олоогүй. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын цахим сайт Parliament.mn цахим хуудаснаас “Хот, тосгоны эрх зүйн байдал” гэсэн шүүлт хийхэд 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль” болон 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулсан” илэрч гарсан.<sup>16</sup> Харин D.Parliament.mn цахим хуудасны “өргөн мэдүүлсэн” болон “боловсруулж буй төслүүд” хэсгээс шүүлт хийхэд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн төсөл байгаагүй.<sup>17</sup>

2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль”-ийн 2 дугаар зүйлд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг 2020 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлэх, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2,3 дахь хэсэгт заасны дагуу бусад хот, дүүрэг, тосгоны өөрийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах тэдгээрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг тус тус судлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ” гэж хуульчилсан.

Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох “Монгол Улсын Их Хурлын тогтоол”-ын төслийг тэртээ 2012 онд хэлэлцэн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж байсан хэдий ч гишүүдийн олонхын дэмжлэг аваагүй юм. Гишүүдийн олонхын дэмжлэг аваагүй шалтгаан нь удирдлагын болон нэршлийн хувьд давхардал үүснэ. Тухайлбал, сумын Тамгын газар, аймгийн Тамгын газар, хотын захирагчийн алба гэсэн 3 өөр удирдах албан тушаалтан нэг нутаг дэвсгэр дээр бий болно гэсэн үндэслэлээр Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжээгүй. Тухайн үед “Дархан, Эрдэнэтийг улсын чанартай хот болгосноор Улаанбаатар хот дахь хүн амын төвлөрөл саарч, тэр хэрээр томоохон хотууд хөгжих бололцоог бий болгоно” гэсэн үндэслэлийг дэвшүүлсэн гишүүд ч байсан.<sup>18</sup>

Үүнээс үзвэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Хот, тосгоны эрх зүй байдлын тухай хуулийн хүрээнд “Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй” хот болгох эрх зүйн орчин дутмаг бөгөөд, хот, тосгоны эрх зүйн орчныг сайжруулан үндсэн дээр “2019 оны Монгол Улсын Үндсэн хууль”-ийн нэмэлт өөрчлөлтөд үндэслэн “Хот, тосгоны эрх зүйн хэм хэмжээг сайжруулах буюу шинэчлэхийг зорьсон. Уг хот, тосгоны эрх зүйн шинэчлэл хийгдээгүй тул Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох “Монгол Улсын Их Хурлын Тогтоол” батлагдаагүй.

Түүнчлэн, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад үндэслэн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр “Татварын ерөнхий хууль”-д нэмэлт өөрчлөлт орсон. Уг нэмэлт өөрчлөлтөд хотын эрх зүйн

<sup>14</sup> Монгол Улсын Их Хурлын тогтоол, УБ., 2022 он, Дугаар 08, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390150786561> Сүүлд үзсэн огноо 2022.11.21

<sup>15</sup> Монгол Улсын Их Хурлын тогтоол, УБ., 2022 он, Дугаар 52, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530825973761> Сүүлд үзсэн огноо 2022.11.21

<sup>16</sup> Монгол Улсын Их Хурлын цахим сайт, <https://www.parliament.mn/laws/?lang=&tid=&cid=&sort=&keywords=%D1%85%D0%BE%D1%82%2C+%D1%82%D0%BE%D1%81%D0%B3%D0%BE%D0%BD&submit=Submit> Сүүлд үзсэн огноо 2022.11.21

<sup>17</sup> <https://d.parliament.mn/m/ac2562ac-f9a6-42b1-a110-25845cf5785d?page=1&limit=12&tsid=all&tlid=6101970e-2fb0-4394-8113-db13d7374fb6&q=undefined&az=undefined> Сүүлд үзсэн огноо 2022.11.21

<sup>18</sup> Дархан, Эрдэнэтийг хот болгох тухай хэлэлцэв, <https://news.mn/tr/95785/> Сүүлд үзсэн огноо 2022.11.21

хөгжлийн цаашдын чиг хандлагад томоохон хэмжээний эерэг өөрчлөлтийг бий болгох боломжтой. Тодруулбал, Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.25, 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, 8.4, 8.5, 46 дугаар зүйлийн 46.3, 46.5.1, 46.9, 47 дугаар зүйлийн 47.5.1-д заасан хэм хэмжээнд хотыг дурдсан. Эдгээр заалт нь татварын эрх зүйн харилцаанд улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот тодорхой байр суурь эзлэхийг илтгэнэ.

Ялангуяа “Татварын ерөнхий хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д “8.1.Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын Зөвлөл хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно”, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д “8.3.Энэ хуулийн 7.2.13, 7.2.14, 7.2.16, 7.2.17, 7.2.20, 7.2.21, 7.2.24, 7.2.26, 7.2.28, 7.2.29-д заасан татварын хувь, хэмжээг тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгосон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын Зөвлөл тогтоож болно” тус зүйлийн 8 дугаар зүйлийн 8.5-д “8.5.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг Засгийн газар, мөн хуулийн 6.3-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тус тус тогтооно”<sup>19</sup> зэрэг эрх олгосон хэм хэмжээ нь цаашдын улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан.

### **3. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дэх заалтын хоёрдахь өгүүлбэрийн тухай**

*“Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ”*

2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн тавин долдугаар зүйлийн 2 дэх заалтын хоёрдахь өгүүлбэр зохицуулсан харилцааг “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгаар нарийвчлан хуульчилсан.

Тодруулбал, “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын 2 дугаар зүйлийн 2.3-д “Хот, тосгоны өөрийн удирдлагад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж хуульчилсан.<sup>20</sup>

Улмаар тус хуулийн дөрөвдүгээр бүлэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим чиг үүргийг хот, тосгонд шилжүүлэх” хэм хэмжээг хуульчилсан. Энэхүү бүлгээр зохицуулагдаж буй харилцаа нь бүхэлдээ Монгол Улсын эрх зүйн хөгжлийн түүхэнд өмнө зохицуулагдаж байгаагүй цоо шинэ харилцааны үндсийг тавьж байна. 2019 оны Монгол Улсын нэмэлт, өөрчлөлтөд тулгуурласан уг өөрчлөлт нь 1992 оны Үндсэн хуульд байсан хот, тосгоны утга санааг тодруулж, бид цаашид 30 жилд төсөөлж байсан хот, тосгоны талаарх ойлголтыг өөрчлөх цаашид засаг захиргааны нэгжийн шинэтгэл хийх боломжийг бүрдүүлж байна.<sup>21</sup>

Тус хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Улсын зэрэглэлтэй хот, түүний үндсэн нэгжид энэ хуулийн 21, 22, 23 дугаар зүйлд заасан аймаг, сум, багийн зарим чиг үүргийг шилжүүлнэ”, 69 дүгээр зүйлийн 69.2-д “69.2.Орон нутгийн зэрэглэлтэй хот, түүний үндсэн нэгжид энэ хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан сум, багийн зарим чиг үүргийг шилжүүлнэ”

<sup>19</sup> Татварын ерөнхий хууль, УБ., 2019 он, <https://legalinfo.mn/mn/detail/14403> Сүүлд үзсэн огноо 2022.11.21

<sup>20</sup> Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2020 он, УБ., <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801> Сүүлд үзсэн огноо 2022.11.21

<sup>21</sup> Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тайлбар, 2022 он, УБ., 217 дахь тал

гэжээ.<sup>22</sup>

Уг заалтаар хотын зэрэглэлд үндэслэн тухайн хотын өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг, түүнчлэн нэгж гүйцэтгэдэг орон нутгийн чиг үүргүүдийг шилжүүлэн авах замаар иргэдэд үйлчилгээ үзүүлэх шаардлага бий болно. Энэ шалтгааны улмаас улсын зэрэглэлтэй хот болон орон нутгийн зэрэглэлтэй хот засаг захиргааны ямар чиг үүргийг хэрэгжүүлэх нь харилцах адилгүй байх учир тэдгээрт шилжүүлэн гүйцэтгүүлэх чиг үүргийг дээрх онцлогт нийцүүлэх агуулгыг дээрх зохицуулалт өөртөө агуулж буй юм.<sup>23</sup> Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуулийн тавин долдугаар зүйлийн 2 дэх заалтыг хэм хэмжээг нарийвчлан хуульчилсан.

## ДҮГНЭЛТ

Монгол улсын Их цаазын /үндсэн хууль/ төслийг хэлэлцэх хот, тосгоны гэхээс илүүтэй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг асуудлыг хөндсөн бөгөөд 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд хот, тосгоны эрх зүйг зохицуулалтыг нарийвчлан хуульчлаагүй. Улмаар 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хот, тосгоны эрх зүйд хамаарах хоёр агуулгыг оруулжээ. Нэгдүгээрт, улсын болон орон нутгийн зэрэгтэй хотын эрх зүйн үндсийг органик хуулийн түвшинд өөрчлөн найруулсан. Ингэснээр 1993 оны “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийг шинэчлэн найруулах шаардлага бий болсон. Уг шаардлагын дагуу 2020 онд багтаан “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийг шинэчлэн найруулгыг батлахаар 2020 оны 01 дүгээр сарын 09 –ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийлүүлэх хуваарьд тусгасан.

2020 онд “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг батлаагүй бөгөөд 2021 оны 9 дүгээр сард УИХ-ын төрийн байгуулалтын байнгын хорооноос “хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг цахимаар зохион байгуулан, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Дугаар 08 тогтоолын 1.43/-д “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн төслийг хэлэлцэхээр заасан. Гэвч 2022 оны 11 сарын байдлаар “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын батлагдаагүй бөгөөд хуулийн төсөл цахим орчинд байхгүй.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга батлагдсанаар улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн байдал тодорхой болж, 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль”-ийн 2 дугаар зүйлд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг багтаан шийдвэрлэх боломж бүрдэнэ.

Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын статусыг өөртөө багтаасан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга батлагдаагүй нь 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг тавин долдугаар 2 дахь заалтын үйлчлэлийг зогсонги байдал оруулсан. Хэдийгээр Монгол Улсын засаг захирга, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга, Татварын ерөнхий хуулийн 2020 оны 12 дугаар 24-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотод тодорхой эрхийн олгосон. Гэвч улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот гэдэг юуг ойлгох нь тодорхой болоогүй. Иймд Монгол Улсын засаг захирга, нутаг дэвсгэрийн нэгж

<sup>22</sup> Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2020 он <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801> Сүүлд үзсэн огноо 2022.11.21

<sup>23</sup> Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тайлбар, 2022 он, УБ., 221 дэх тал



түүний удирдлагын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга, Татварын ерөнхий хуулийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн нэмэлт, өөрчлөлт хэрэгжих боломжгүй.

Харин хоёр дахь томоохон агуулга Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын дөрөвдүгээр бүлгээр нарийвчлан хуульчилсан.

2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хот, тосгоны эрх зүйд хамаарах хоёр өгүүлбэрийг оруулсан. Эхний өгүүлбэр буюу Монгол Улсын Үндсэн хуулийн тавин долдугаар зүйлийн 2 дэх заалтын эхний өгүүлбэрийн хувьд хэрэгжилт зогсонгүй байдалтай, харин хоёр дахь өгүүлбэр буюу Монгол Улсын Үндсэн хуулийн тавин долдугаар зүйлийн 2 дэх заалтын хоёр дахь өгүүлбэрийн хэрэгжилт хангалттай хэрэгжсэн.

### ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, УБ., <https://bpo.gov.mn/uploads/files/2019/06/12/a7789c41fdb4af0f5be3dce261aa490a.doc>
2. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, 2016 он.
3. Татварын ерөнхий хууль, УБ., 2019 он, <https://legalinfo.mn/mn/detail/14403>
4. А.Бямбажаргал, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт ба засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн шинэтгэл.
5. Д.Ганзориг, Нутгийн удирдлагын шинэ хуулийн талаар, [https://www.youtube.com/watch?v=33LUnmMXu\\_A](https://www.youtube.com/watch?v=33LUnmMXu_A)
6. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Үндсэн хууль эмхэтгэл, 2020 он.
7. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2020 он, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801>
8. Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, 2021 он.
9. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэг, УБ., 2021 он, <https://montsame.mn/mn/read/276409>
10. Монгол Улсын Их Хурлын тогтоол, 2022 он, Дугаар 08, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390150786561>
11. Монгол Улсын Их Хурлын тогтоол, 2022 он, Дугаар 52, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530825973761>
12. Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж, боть 4, УБ., 2022 он [https://legalinfo.mn/mn/detail/16230779072091?fbclid=IwAR3dy7hJi\\_i0vuGujuVatSnUFiXJWqX8R7pAFq3kvggQ1eWopImHaw4jWqw](https://legalinfo.mn/mn/detail/16230779072091?fbclid=IwAR3dy7hJi_i0vuGujuVatSnUFiXJWqX8R7pAFq3kvggQ1eWopImHaw4jWqw)
13. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тайлбар, 2022 он.
14. Монгол Улсын Их Хурлын цахим сайт, <https://www.parliament.mn/laws?lang=&tid=&cid=&sort=&keywords=%D1%85%D0%BE%D1%82%2C+%D1%82%D0%BE%D1%81%D0%B3%D0%BE%D0%BD&submit=Submit>
15. <https://d.parliament.mn/m/ac2562ac-f9a6-42b1-a110-25845cf5785d?page=1&limit=12&tscid=all&tlid=6101970e-2fb0-4394-8113-db13d7374fb6&q=undefined&az=undefined>
16. Дархан, Эрдэнэтийг хот болгох тухай хэлэлцэв, <https://news.mn/r/95785/> Сүүлд үзсэн огноо 2022.11.21



## 2019 CONSTITUTIONAL AMENDMENTS AND CITIES OF NATIONAL OR LOCAL SIGNIFICANCE

*Khatansaikhan R.*

*Researcher at the National Legal Institute of Mongolia,  
LL.M. candidate of School of Law, NUM*

### **ABSTRACT:**

By amending the Constitution of Mongolia in 2019, two important regulations in the legal framework of cities and villages were included in the Constitution. Firstly, the legal status of state and local cities has been added to the Constitution, and secondly, the amendment authorized the transfer of functions of administrative and territorial units to state and local cities. Based on these amendments, Resolution No. 02 of the Great Khural of Mongolia was approved: “The Law on the Procedure for Transitioning to Compliance with the Amendments to the Constitution of Mongolia” and “On the Compliance of Legislation with the Amendments and Amendments to the Constitution of Mongolia”. Since the amendment to the Constitution of Mongolia came into the effect, 2 years and 6 months have passed. During that period, no research or academic work has been conducted on how the provisions of the mentioned legal documents related to the law of cities and villages were implemented and are being implemented. Therefore, the implementation of the amendments to the 2019 Constitution of Mongolia and related regulations related to local administration, cities, and villages has been studied in this article.

### **KEYWORDS:**

Constitution, City, Village, Law amendment

**ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГАД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН  
ШАЛТГААН НӨХЦӨЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ  
(ЭРҮҮГИЙН ХЭРЭГ, БАРИМТЫН ШИНЖИЛГЭЭ)**



*Ц.Мөнхбат*

*Улсын ерөнхий прокурорын газрын  
дэргэдэх Сургалт, судалгааны  
хүрээлэнгийн хяналтын прокурор,  
Хууль зүйн ухааны доктор*



*Д.Нямбат*

*Улсын ерөнхий прокурорын газрын  
дэргэдэх Сургалт, судалгааны  
хүрээлэнгийн хяналтын прокурор,  
ДХИС-ийн докторант*

**ТОВЧЛОЛ:**

Цэргийн албаны тухай болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиуд, “Цэргийн нийтлэг дүрэм” -ээр цэргийн алба хаагч нь амь нас, эрүүл мэндээрээ хохирох, амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь гутаан доромжилсон харьцаанаас хамгаалуулах эрхтэй болохыг тодорхойлсон хэдий ч цэргийн анги байгууллагад үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн гаралт жил ирэх тусам өсч байна.

Иймд прокурорын байгууллагаас 2011-2021 оны хооронд цэргийн анги байгууллагад үйлдэгдсэн 468 гэмт хэрэг, зөрчлийн хавтаст хэрэг, материал, шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийж гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, улмаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж дэвшүүлээ.

**ТҮЛХҮҮР ҮГС:**

Эрүүгийн хууль, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг, зөрчил, хугацаат цэргийн алба хаагч, хүний эрхийн зөрчил, ял шийтгэл, дүрмийн бус харьцаа, хүнлэг бус харьцах, захирах захирагдах ёс, тушаал, зэвсэгт хүчин, яллагдагч, шүүгдэгч

**1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ**

**1.1 Судалгааны үндэслэл**

Монгол Улсын иргэн нь Үндсэн хуульд зааснаар “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” үндсэн үүрэгтэй.<sup>1</sup> Монгол Улсын төрийн цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрддэг.<sup>2</sup> Харин “цэргийн алба” гэдэгт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэг

<sup>2</sup> Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1 дэх хэсэг

үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг ойлгодог.<sup>3</sup>



Зэвсэгт хүчин, хилийн дотоодын, онцгой байдлын алба нь тухайн албадын онцлогоос шалтгаалан цэргийн алба хаагчийн эрхийн хязгаарлалт нь цэргийн анги, байгууллагын журмыг чандлан сахих, улс төрийн төвийг сахисан бодлого баримтлах, байлдааны үйл ажиллагааны үр ашигт байдлыг хангах, төрийн болон албаны нууц мэдээллийг хамгаалах, тушаал биелүүлэх, цэргийн байгууллагын шатлан захирах бүтцийг хадгалахтай холбоотой байдаг.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй цэргийн албатай холбоотой 50 орчим хууль тогтоомж, зарлиг, тогтоол, дүрэм, журам, заавар зэрэг 200 гаруй баримт бичиг байна.<sup>4</sup>

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан хүний амьд явах эрх, халдашгүй чөлөөтэй байх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас хамгаалагдах эрх нь цэргийн алба хаагчид ч гэсэн хамааралтай заалт юм. Өөрөөр хэлбэл цэргийн алба хаагч нь амь нас, эрүүл мэндээрээ хохирох, амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь гутаан доромжилсон харьцаанаас хамгаалуулах эрхтэй болохыг Цэргийн албаны тухай болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиуд, “Цэргийн нийтлэг дүрэм”<sup>5</sup>-ээр тодорхойлсон хэдий ч цэргийн анги байгууллагад үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурахгүй байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд цэргийн анги, байгууллагад 468 гэмт хэрэг, сахилгын зөрчил бүртгэгдсэний 242 нь Зэвсэгт хүчний, 217 нь Хилийн цэргийн, 9 нь Дотоодын цэргийн анги байгууллагад хамааралтай байна. Зэвсэгт хүчний хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн 242 зөрчлийн 144 нь гэмт хэргийн шинжтэй, 98 нь сахилгын зөрчил байна. Эдгээрээс хугацаат цэргийн алба хаагчийн амь нас хохирсон 7 тохиолдлын 3 нь усанд живсэн, 2 нь хөдөлмөр хамгааллын аюулгүй байдал алдагдсанаас, 1 нь хүнийг алах гэмт хэргийн улмаас, 1 нь амиа хорлосон байна. Харин 27 хугацаат цэргийн алба хаагч гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирчээ. Дээр дурдсан 98 сахилгын зөрчлийн 41 буюу 41.8 хувь нь дүрмийн бус харьцаа, 24 буюу 24.4 хувь нь хугацаат цэргийн албанаас

<sup>3</sup> Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг

<sup>4</sup> [www.Legalinfo.mn](http://www.Legalinfo.mn)

<sup>5</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 17 дугаар зарлигаар “Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийг баталсан. Үүнд: Цэргийн дотоод албаны дүрэм, Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм, Цэргийн жагсаалын дүрэм, Цэргийн сахилгын дүрэм хамаарна.

оргон зайлсан зөрчил байна.<sup>6</sup>

Цэргийн анги, байгууллага дахь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлоход цэргийн алба хаагчийн амь нас, эрүүл мэнд хохирсон, түүнчлэн хүнлэг бус харьцаатай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх нэгдсэн тогтолцоо чухал үүрэгтэй юм. Гэвч эдгээрийг нэгтгэн харуулсан мэдээллийн сан одоогоор аль ч цэргийн анги, байгууллагад байхгүй байгаа нь нөхцөл байдлыг бодитойгоор тодорхойлоход хүндрэл учруулж байна.

Иймд цэргийн анги, байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг шүүхээс эцэслэн шийдвэрлэсэн болон прокурорын байгууллагаас мөрдөн байцаалтын хэргийг хэрэгсэхгүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан хавтаст хэргийг судалж тодорхойлох, улмаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж дэвшүүлэхийг зорилоо.

#### 1.2 Судалгааны зорилго, зорилт

Цэргийн анги, байгууллагад ажиллаж, амьдарч байгаа офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчдын хоорондын дүрмийн бус харьцааны улмаас гарч буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлан дүгнэж, тодорхойлон үнэлгээ өгөх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Зэвсэгт хүчний, Хилийн цэргийн, Дотоодын цэргийн анги, байгууллагуудад санал, зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны ажлын зорилго чиглэнэ. Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллалаа. Үүнд:

1. Цэргийн анги, байгууллагад 2011-2021 оны хооронд гарсан гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрүүгийн хэрэгт дүн шинжилгээ хийх;
2. Шүүхийн шийтгэх тогтоолыг судалж, шалтгаан нөхцөлийг тодорхойлох;
3. Цэргийн гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл, хэмжээг шинжлэн судлах;
4. Судалгааны дүнг үндэслэн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр холбогдох санал, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

#### 1.3 Судлагдсан байдал:

Хууль зүй, дотоод хэргийн яам болон бусад байгууллагаас хил хамгаалах байгууллагын хэмжээнд гарсан гэмт хэрэг, сахилгын ноцтой зөрчил, түүний шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх ажлыг сүүлийн 10 жилийн хугацаанд 4 удаа хийсэн байна. Үүнд:

- Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2010 онд “Хил хамгаалах байгууллагад үйлдэж байгаа онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөл” судалгаа;
- Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2013 онд “Хилийн зарим отряд, анги, заставт алба хааж буй хугацаат цэргийн алба хаагч нарын дунд хийсэн хөндлөнгийн судалгаа”;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Дотоод хэргийн их сургууль хамтран 2020 онд “Монгол улсын зэвсэгт хүчин, хилийн цэргийн анги, байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг” судалгаа;
- Хууль зүй, дотоод хэргийн яам, Дотоод хэргийн их сургууль хамтран 2022 онд “Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хүчин зүйлс” судалгаа.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2010 онд “Хил хамгаалах байгууллагад үйлдэгдэж байгаа онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөл” сэдвээр криминологи судалгаа хийж, Монгол Улсын Хил хамгаалах байгууллагад гарч буй гэмт явдал, түүний дотор хүнд, онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлан дүгнэж, офицер, ахлагч, цэргийн хугацаат албан хаагчийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хилийн анги, хилийн салбарт зохион байгуулах талаар санал, зөвлөмж боловсруулж, холбогдох шатанд танилцуулж

<sup>6</sup> ЗХЖШ-ын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 1/2937 дугаар албан бичиг, УЕПГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/1991 дүгээр албан бичиг.

байжээ.

Цэргийн анги, байгууллага, объектод үйлдэгдсэн нийт гэмт хэрэг, түүний криминологи шинж, мөн цэргийн алба хаагчдаас гэмт хэрэгт холбогдсон, түүний шалтгаан нөхцөлийн талаар тусгайлан судалсан судалгааны ажил, эрдэм шинжилгээний бүтээл төдийлөн хийгдээгүй байна. Учир нь энэ асуудал нь албаны нууцлалд хамаарах учир эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэнд хараахан сайн ороогүй байна гэж үзэж болохоор байв.

#### 1.4 Судалгааны арга зүй

Судалгааны хүрээнд 2011-2021 онд шүүхээс эцэслэн шийдвэрлэсэн, прокуророос мөрдөн байцаалтын хэргийг хэрэгсэхгүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан хэргийг хамруулав. Эдгээр эрүүгийн хэрэг, баримттай танилцаж, түүвэрлэн судалж, нэгтгэн дүгнэх, харьцуулалт судалж задлан шинжилгээ хийх арга, арга зүйг ашиглан дүгнэлт хийлээ. Мөн судалгааны хүрээнд цэргийн алба хаагчтай холбоотой хууль тогтоомж, дүрэм журамд дүн шинжилгээ хийж, статистик мэдээллийг харьцуулан судалж, дүгнэлт хийсэн.

#### 1.5 Судалгааны хамрах хүрээ

Улсын ерөнхий прокурорын газрын цахим санд өнгөрсөн 10 жилийн хугацаанд цэргийн албан хаагчтай холбоотой нийт 496 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 336 буюу 86,7 хувийг шүүхэд шилжүүлсэн, 149 буюу 30 хувийг прокурорын шатанд хэрэгсэхгүй болгосон буюу хаасан, 1 буюу 0,2 хувь түдгэлзүүлсэн байна.

Эдгээр гэмт хэргээс цэргийн анги, байгууллагад цэргийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийг ялган судалгаанд оруулсан боловч зарим хэрэг шүүхийн шатанд болон хэрэг хадгалах хугацаа дууссан зэрэг үндэслэлээр устгагдсан байна. Иймд судалгаанд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн эрүүгийн 68, прокурорын хяналтын шатанд мөрдөн байцаалт явуулж хэрэгсэхгүй болгосон 27, хэрэг бүртгэлт явуулж хаасан 23 хэргийг, түүнчлэн прокурорын 10 яллах дүгнэлт, хэрэгсэхгүй болгосон 7, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан 1 тогтоол, нийт 136 эрүүгийн хэрэг, баримтыг хамрууллаа.

#### 1.6 Мэдээлэл цуглуулах үйл явц

Судалгаанд ашиглах статистик мэдээллийг цуглуулахад улсын хэмжээний нэгдсэн тоо баримт байхгүй, шүүхийн шатанд байгаа хэргийг авч судлах боломжгүй зэрэг нөхцөл байдлаас үүдэн судалгааны түүврийн хэмжээ багассан боловч аль болох олон эрүүгийн хэрэг, баримтыг авч судалгаандаа ашиглахыг зорьсон. Тухайлбал зарим хэргийн хадгалах хугацаа дууссанаас Улсын Ерөнхий прокурор, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/1834, А/31 дүгээр тушаалаар баталсан “Эрүүгийн болон зөрчлийн хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох баримтыг архивт хадгалах заавар”-г зааснаар устгалд орсон тул зөвхөн яллах дүгнэлт, прокурорын хэрэгсэхгүй болгосон буюу хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тогтоол архивт байсныг авч судлан дүн шинжилгээ хийв. Мөн Улсын ерөнхий прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн гаргасан цэргийн албан хаагчдын үйлдсэн зөрчлийн судалгаа болон зарим цэргийн салбарын мэдээллийг харьцуулан судаллаа.

## **2. ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГАД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ**

Энэ бүлэгт судалгаанд хамруулсан нийт 136 эрүүгийн хэрэг, баримтыг 3 дэд хэсэгт ангилан тус бүрд нь задлан шинжилгээ хийж, цэргийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойллоо. Судалгааны тайлангийн 2.1-2.10 дэд хэсэгт Улсын ерөнхий прокурорын газрын цахим санд бүртгэгдсэн 496, 3.1-3.4 дэд хэсэгт шүүхээс эцэслэн шийдвэрлэсэн 68, 4.1-4.4 дэд хэсэгт прокурорын шатанд хэрэгсэхгүй болгосон, хаасан, түдгэлзүүлсэн 68 эрүүгийн хэрэг, баримт гэж ангилан үзэж, дүн шинжилгээ хийж гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодорхойллоо.

### 2.1. Нийт гэмт хэрэг болон цэргийн албаны эсрэг гэмт хэргийн харьцуулалт

Эрүүгийн хуулийн тусгай ангид нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг тодорхойлсон 220 төрлийн гэмт хэргийг хуульчилсан байдаг бөгөөд үүний 19 буюу 8,6 хувь нь цэргийн албаны эсрэг гэмт хэрэг байхаар заажээ. Тус хуулийн 28.1 дүгээр зүйлийн тайлбарт “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг гэж Монгол Улсын зэвсэгт хүчин, хилийн цэргийн бие бүрэлдэхүүнд цэргийн жинхэнэ алба хааж байгаа Монгол Улсын иргэн, цэргийн дайчилгаа, сургууль, цугларалтад байгаа цэргийн үүрэгтэн энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэнийг ойлгоно” гэжээ.<sup>7</sup> Үүнд дотоодын цэргийн алба хаагчийн талаар дурдалгүй орхигдуулж тайлбар хийсэн байна.

Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсад алба хааж байхдаа гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын цэргийн алба хаагчдад Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэдэг.<sup>8</sup>


Цэргийн алба хаагч, хууль сахиулагч дээд шатны албан тушаалтны бичгээр, амаар өгсөн заавал биелүүлэх тушаал, даалгаврыг хууль бус болохыг мэдэх боломжгүй, мэдэлгүйгээр биелүүлж Эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй. Хууль бус тушаал, даалгавар өгсөн албан тушаалтныг уг гэмт хэргийг үйлдсэн гүйцэтгэгчид тооцно. Мөн Эрүүгийн хуульд заасан илэрхий гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг хийлгэхээр өгсөн илт хууль бус тушаал, шийдвэр нь цэргийн алба хаагч, хууль сахиулагч өөрөө бие даан шийдвэрлэх ёстой албаны үүрэг, эрх мэдэлд хамаарахаар байтал уг даалгаврыг зориуд биелүүлсэн бол тухайн цэргийн алба хаагч, хууль сахиулагчийг уг гэмт хэргийг үйлдсэн гүйцэтгэгчид, тушаал, даалгавар өгсөн албан тушаалтныг бусдыг ашиглан гэмт хэрэг үйлдсэн гүйцэтгэгчид тооцно.<sup>9</sup>

Мөн Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэгт цэргийн албаны эсрэг 19 төрлийн гэмт хэргийн талаар зүйлчилсэн ба гэмт хэргийн шинж болон ямар үйлдэл, эс үйлдэл гэмт хэрэгт тооцож тэдгээрт ямар төрлийн эрүүгийн хариуцлага оногдуулах тухай тусгасан.

Монгол Улсын хэмжээнд 2011-2020 онд нийт 340,631 эрүүгийн хэрэг бүртгэгдсэнээс 496 буюу 0.1 хувь нь цэргийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг эзэлж байна. Үүнд Эрүүгийн хуульд тусгайлан бүлэг болгон хуульчилсан цэргийн албаны эсрэг гэмт хэргээс гадна алба хаагчийн үйлдсэн авилга, замын хөдөлгөөний аюулгүй байдал, хүний эрүүл мэндэд хохирол (гэмтэл) учруулах болон бусад төрлийн гэмт хэрэг багтаж байна.

### 2.2 Цэргийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэрэг

Цэргийн албан хаагчдын 2011-2020 онуудад үйлдэгдсэн 496 гэмт хэргийг гаралт дараах байдалтай байна. Үүнд:



Үүнээс үзэхэд 2002 оны Эрүүгийн хууль, 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчлэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйлчлэх цаг хугацаанд цэргийн гэмт хэрэг жил бүр өссөн үзүүлэлттэй байна. 2002 оны Эрүүгийн хуульд 22 төрлийн гэмт хэргийг цэргийн гэмт хэрэг гэж тодорхойлсон бол 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчлэн найруулгаар 19 төрлийн гэмт хэрэг болгон бууруулсан хэдий ч гэмт хэргийн гаралтад нөлөөлөөгүй, эрүүгийн хэргийн гаралт өссөн байна. Мөн цэргийн алба хаагчид Эрүүгийн хуульд заасан бүх төрлийн гэмт хэргийг үйлддэггүй, дайны үед мөрдөгдөх зарим гэмт

<sup>7</sup> Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 28.1 дүгээр зүйлийн тайлбар.

<sup>8</sup> Эрүүгийн хуулийн 1.6 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.

<sup>9</sup> Эрүүгийн хуулийн 4.6 дүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсэг.




хэрэг бүртгэгдэхгүй учраас тодорхой цөөн төрлийн гэмт хэрэг үйлдэгддэг байна.

Цэргийн алба хаагчдын үйлдсэн эрүүгийн хэргийн 80,7 хувь нь хүний амьд явах, эрүүл мэндийн халдашгүй байдал, бусдын эрх, эрх чөлөөнд халдсан болон цэргийн албанаас оргон зайлах гэмт хэрэг эзэлж<sup>10</sup> байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй байсантай холбоотой гэж үзэхээр байна. Харин 2020 онд цэргийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэрэг буурсан байна. хугацаат цэргийн алба хаагчдын хууль эрх зүй, хүний эрхийн мэдлэг, ойлголт, хандлагад гарсан өөрчлөлт, цэргийн албаны сургалт, дотоод хяналт, шалгалтын үр нөлөөтэй байдал, түүнчлэн энэ төрлийн зөрчлийн шинж байдал нь залхаан цээрлүүлсэн, далд нуугдмал байдалд шилжсэнтэй холбоотой эсэхийг энэхүү судалгаагаар тогтоох боломжгүй юм.

### 2.3 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Цэргийн албан хаагчдын гэмт хэргийн 305 буюу 61.4 хувь нь анги, байрлалд, 191 буюу 38.5 хувь бусад газарт үйлдэгдсэн байна. Тухайлбал 3 гэмт хэрэг бүрийн 2 нь цэргийн анги, байгууллагад үйлдэгдсэн байна. Харин түр чөлөө авсан, эмнэлэгт хэвтсэн, бусад газарт үүрэг гүйцэтгэх үедээ гэмт хэрэг үйлдэж байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь удирдлагын хяналт сулардаг, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн дунд биеэ зүй зохистой авч явах сэтгэл зүйн бэлтгэлгүй, сургалт нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол авч хэрэгжүүлдэггүй зэрэг шалтгаантай холбоотой байж болзошгүй юм. Иймээс цэргийн алба хаагчийг цэргийн анги, байгууллагаас түр хугацаагаар гарч олон нийтийн дунд орох үед хэрхэн биеэ зөв зохистой авч явах болон сэтгэл зүйн бэлтгэлийг хангахад анхаарах шаардлагатай байна.

### 2.4 Цэргийн алба хаагч үйлдсэн гэмт хэргийн төрөл



Үүнээс үзэхэд 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар 220 төрлийн гэмт хэргийг хуульчилсан байгаагаас цэргийн алба хаагчид нь цөөн төрлийн тодорхой гэмт хэргийг үйлдэж байна. Тодруулбал цэргийн албаны эсрэг 2002 оны Эрүүгийн хуульд заасан 11<sup>11</sup>, 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад заасан 15 төрлийн гэмт хэрэг<sup>12</sup> бүртгэгддэггүй байна.

<p>Тохиолдол</p> <p>...Зэвсэгт хүчний ... дугаар анги "...чөлөөгөөр гарах үед захирагч нь өөрийн гар утасны батарей, микрофоныг засуулаад ир гээд утсаа өссөн. Түүнийг засуулах 80000 төгрөг байхгүй тул чадаагүй, зодуулахаас айсан учраас ангийн байрлалд эргэн ирээгүй явсан.... улмаар 2015 оны...дүгээр сарын...-ны өдөр сургуулиас компьютер хулгай хийсэн гэмт хэрэгт холбогджээ.</p> <p style="text-align: right;">(Сум дундын ... дугаар шүүхийн шийтгэх тогтоол)</p>
--

<sup>10</sup> УЕПГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/1991 дүгээр албан бичиг.

<sup>11</sup> 2002 оны Эрүүгийн хуулийн 126, 125, 108, 112, 135, 136, 142, 107, 89, 187, 251 дүгээр зүйлүүд.

<sup>12</sup> 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад заасан 12.1, 12.2, 13.2, 13.3, 13.5, 13.8, 13.10, 13.11, 13.13, 14.1, 14.4, 15.2, 19.14, 20.6, 21.12 дугаар зүйлүүд.

Цэргийн алба хаагчид цөөн төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа нь тэднийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс тагталзуулах, эмээлгэх, үүнээс урьдчилан сэргийлэх ажил үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой гэдгийг илэрхийлж буй нэг үзүүлэлт юм. Тухайлбал хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, авилгын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаар олон тооны судалгаа шинжилгээний ажил байдаг бөгөөд түүний үр дүнгээс дэвшүүлсэн санал, зөвлөмжийг эдгээр гэмт хэргийн гаралтыг бууруулах арга туршлага болгон цэргийн анги, байгууллагад хэрэгжүүлэх боломжтой юм.

Үүний зэрэгцээ хугацаат цэргийн албанд татагдан ирж байгаа иргэдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хувь хүний төлөвшил, эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал нь зарим тохиолдолд дүрмийн бус харьцааны зөрчил гаргахад нөлөөлж байна. Иймд цэргийн анги, байгууллагад ажиллаж байгаа офицер ахлагч, хугацаат цэргийн алба хаагчийн урьд өмнө ял шийтгэл эдэлж байсан эсэх, ямар төрлийн зөрчилд холбогдож байсан, боловсролын төвшин зэрэг хувийн байдлыг судалж, дүн шинжилгээ хийн, цэргийн алба хаагчдад тохирсон сургалтын сэдэв, агуулга, заах арга зүйг тодорхойлж, ашиглах нь зүйтэй байна.

#### 2.5 Гэмт хэрэгт холбогдсон цэргийн алба хаагчийн нас

Цэргийн алба хаасан иргэдийн 2011-2021 оны байдлаар 18 настай 26.99, 19 настай 32.24, 20 настай 18, 21 нас, 9.94, 22 нас 6.4, 23 нас 3.91, 24 нас 1.85, 25 нас 0.91 хувьтай байна.<sup>13</sup>

Гэмт хэрэгт холбогдсон цэргийн алба хаагчдын насны байдлыг авч үзвэл 47 хувь нь 18-25, 32 хувь нь 26-35, 12.1 хувь нь 36-45, 1 буюу 0.6 хувь 46-гаас дээш настай байна. Хэдэн настай байхаас үл шалтгаалж бүхий л насныхан гэмт хэрэг үйлдсэн байгаа боловч нас ахих тусам гэмт хэрэг үйлдэх эрсдэл буурсан үзүүлэлттэй байна. Харин 18-35 насны цэргийн алба хаагчид 82 хувийг эзэлж байгаа нь Цэргийн албаны тухай хуульд<sup>14</sup> зааснаар цэргийн албыг 18-27 насны иргэн хаах үүрэгтэй байдагтай холбоотойгоос гадна биологийн хувьд залуучууд нь бусад насныхантай харьцуулбал бие махбод, сэтгэл санаа, ёс суртахууны хувьд бүрэн төлөвшөөгүй байдаг гэж үздэгтэй холбоотой юм. Иймд цэргийн алба хаагчийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг 18-35 насныханд чиглүүлэн тэдгээрийн онцлог, шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх нь чухал байна.

#### 2.6 Гэмт хэрэг үйлдсэн цэргийн алба хаагчийн боловсролын төвшин, мэргэжил

Цэргийн алба хаагчдын хамгийн их гэмт хэрэг үйлдсэн 41.8 хувь нь бүрэн дунд боловсролтой, 31 хувь нь дээд боловсролтой, 18.9 хувь нь тусгай дунд боловсролтой байна. Үүнээс үзэхэд боловсролын төвшин бага байх тусам гэмт хэрэг үйлдэх эрсдэл багатай, харин мэргэжил, боловсролын төвшин нэмэгдэх тусам гэмт хэрэг, зөрчил үйлдэх эрсдэл нэмэгдэж байна. Түүнчлэн боловсрол, мэргэжилтэй, ажилтай орлоготой байх тусам гэмт хэрэг үйлдэх эрсдэл бага байдаг. Гэтэл цэргийн алба хаагчдын хувьд эсрэг үзүүлэлттэй байна.

#### 2.7 Гэмт хэрэг үйлдсэн цэргийн алба хаагчийн төрөл


Гэмт хэрэг үйлдсэн 147 цэргийн алба хаагчийг албан тушаалаар ангилж үзэхэд гэмт хэрэг үйлдсэн цэргийн алба хаагчдын 37,8 хувь нь ахлагчид байна. Гэхдээ цэргийн алба хаагчдын хооронд үйлдэгдэж буй гэмт хэргийн нэг шалтгаан нөхцөл нь дүрмийн бус харьцаанаас үүдэлтэйн зэрэгцээ бүх албан тушаалтнуудад нийтлэг илэрч байна.

Тухайлбал цэргийн анги, байгууллагын захирагч, шууд удирдах албан тушаалтан, офицер, ахлагчдын мэргэжлийн ёс зүй, харилцааны соёл, ажлын байрны дарамт, шахалт, ялгаварлан гадуурхалтаас болж цэргийн алба хаагчид дарамт стресст орох, түүнээс шалтгаалсан гэр бүлийн таагүй уур амьсгал нь цэргийн дүрмийн бус зөрчил үйлдэгдэх хүчин зүйл болж байна.

<sup>13</sup> ЗХЖШ-аас ирүүлсэн мэдээлэл.

<sup>14</sup> Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.8, 3.1.10, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.4 дэх хэсгүүд.

## 2.8 Урьд ял шийтгүүлсэн цэргийн алба хаагч гэмт хэрэг үйлдсэн байдал



Урьд ял шийтгүүлсэн алба хаагчдаас 1 удаа ял шийтгүүлсэн 10, 2 удаа ял шийтгүүлсэн 2, 3 удаа ял шийтгүүлсэн 1 алба хаагч байна. Иймд цэргийн алба хаагчдын хувийн байдал, зан чанарын онцлогийг сайтар судлан, нэгдсэн мэдээллийн санг үүсгэн ямар төрлийн гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэлийг тооцоолох, энэхүү эрсдэлийг үнэлж, цаашид авах арга хэмжээг тодорхойлсны үндсэн дээр бие даан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадварыг хөгжүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай.

### 2.9 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа

Цэргийн алба хаагчидтай холбоотой шүүхээс шийдвэрлэсэн 68 эрүүгийн хэргийн үйлдэгдсэн цаг хугацаанд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. Үүнд:




Цэргийн анги, байгууллага нь тушаалаар, байнгын, тасралтгүй үйл ажиллагаа нь хэрэгждэг, дээд цолтой албан тушаалтны удирдлага дор цэргийн үүргийг биелүүлж, сахилга, дэг журам сахиулсан орчин нөхцөлд ажиллаж, амьдардаг онцлогтой. Энэхүү онцлог, шинж байдлаас хамаарч хугацаат цэргийн алба хаагчдын иргэний тодорхой эрхүүд нь хязгаарлагддаг хэдий ч тэдний ажиллах, амьдрах орчин нь хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, айлган сүрдүүлэлт зэргээс ангид байж, хууль бус зохисгүй шийтгэл, дүрмийн бус харьцаанаас хамгаалагдаж, сэргийлэгдэх ёстой.

Гэвч цэргийн анги, байгууллагад ихэвчлэн өдрийн цагаар гэмт хэрэг үйлдэгдсэн байгаа нь анхаарал татаж байна. Харин шөнийн цагаар үйлдэгдэж буй гэмт хэргийн хувьд анги, байгууллагын удирдлагын хараа хяналт сулардагтай холбоотой байж болох юм. Иймд шөнийн цагаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийг бууруулах чиглэлээр үр дүнд суурилсан хяналт шалгалт, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

### 2.10 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол (гэмтэл)

Цэргийн алба хаагчийн эрүүл мэндэд учирсан хохирлыг ангилж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:




Цэргийн алба хаагчдын эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 46,9 хувь, амь насыг хохироох гэмт хэрэг 22,9 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Тухайн гэмт хэрэг нь боловсрол, мэргэжлийн ялгаатай байдал гэхээс илүүтэй хувь хүний харилцаа, хандлага, хүмүүжил, төлөвшил, бусдыг ялгаварлах, дээрэлхэх зан чанар, бие бялдрын онцлог зэргээс шалтгаалж үйлдэгддэг. Тухайлбал цэргийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэрэг шалтгаан нөхцөл нь бие биедээ хүндэтгэлгүй хандах, зохисгүй харилцаа, хандлага гаргах, дүрмийн бусаар харьцах, ахуйн хүрээний маргаан үүсгэх, архи дан согтуурах, захирагч нь захирагдагчаа дээрэлхэх, доромжлох, айлган сүрдүүлэх, захирагдагч нь тушаал биелүүлэхгүй байх, үл захирагдах байдал гаргах зэргээс үүдэлтэй байна.

Иймд энэ төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дотоод хяналтын үйл ажиллагааны үр нөлөөтэй байдал, сургалтын хөтөлбөрийн агуулга болон сэтгэл зүйн хангалтын үйлчилгээнд сайжруулах нь чухал байна.

### 3. ШҮҮХЭЭР ЭЦЭСЛЭН ШИЙДВЭРЛЭГДСЭН ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Цэргийн албан хаагчтай холбоотой 496 гэмт хэргийн 336 буюу 86,7 хувийг шүүхэд шилжүүлсэн байна. Эдгээр эрүүгийн хэргийн шүүгдэгчид шүүхээс ял оногдуулсан байдлыг авч үзвэл дараах байдалтай байна.

Шүүхээс оногдуулсан ял шийтгэл



Хүний амьд явах эрхийн эсрэг амь нас хохирсон 5 (үүнээс амиа хорлосон 1), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 20, цэргийн албаны эсрэг 43 нийт 68 эрүүгийн хэрэг, баримтад дүн шинжилгээ хийв. Эдгээр 68 эрүүгийн хэрэгт 79 цэргийн алба хаагч холбогдсон, 64 цэргийн алба хаагч хохирсон байна. Зарим гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн байна. Тухайн 68 эрүүгийн хэргийн шүүгдэгчийг салбараар нь авч үзвэл 25 буюу 36,7 хувь нь Хилийн цэргийн, 43 буюу 63,2 хувь нь Зэвсэгт хүчний харьяалалтай байна.

Шүүхээс 79 цэргийн алба хаагчдад оногдуулсан ял шийтгэл дараах байдалтай байна. Үүнд:



Түүнчлэн 136 эрүүгийн хэрэг, баримтад дүн шинжилгээ хийхэд торгох болон тэнссэн тохиолдол дийлэнх буюу 50,6-68,4 хувийг эзэлж байна. Харин хорих ял оногдуулсан тохиолдол бага байна. Энэ нь Эрүүгийн хуулийн хуулийн шинэчилсэн найруулгад заасан цэргийн албаны эсрэг 19 төрлийн гэмт хэргийн 17 нь хөнгөн гэмт хэргийн ангилалд хамаарах бөгөөд үүний 12 гэмт хэрэг нь хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн байсан ч мөн адил хөнгөн гэмт хэргийн ангилалд хамаарч байгаагаас шалтгаалан хорих ял оногдуулах тохиолдол нь бага хувийг эзэлж байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад гэмт хэргийг “хөнгөн”, “хүнд” гэсэн хоёр ангилалтай байхаар тусгасан. Мөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлд “тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа гэмт хэрэг үйлдсэн; гэмт хэрэг үйлдсэний дараа хохирогчид шууд эмнэлгийн, бусад туслалцаа үзүүлсэн, учруулсан хохирлыг төлсөн, бие махбодын, сэтгэл санааны албадлагын, эд хөрөнгийн, албан тушаалын, бусад байдлаар эрхшээлд орсны улмаас гэмт хэрэг үйлдсэн, хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдсэн; өөрийгөө илчилсэн, бусдын үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг олоход тусалсан, нөхцөл байдлыг буруугаар төсөөлж андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн, байнгын хүчирхийлэл, дарамтад өртсөний улмаас өөрийгөө хамгаалах зорилгоор хохирогчид халдаж гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлнэ”, мөн хуулийн 6.7 дугаар зүйлд “гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх дараах байдлаар хорих ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно” гэж тус тус заасан. Энэ зохицуулалтын хүрээнд гэмт хэрэг үйлдсэн цэргийн алба хаагчид хэрэглэх боломжтой байдаг тул торгох болон тэнсэх тохиолдол нь нийтлэг байна.

Цэргийн алба хаасан иргэдийн 2011-2021 оны байдлаар дээд боловсролтой 5,34, тусгай дунд 13,28, бүрэн дунд 53,97, бүрэн бус дунд 21,23, бага боловсролтой 5,83, бичиг үсэг үл мэдэгч 0,52 байна.<sup>15</sup>

Шүүхээс ял оногдуулсан 79 цэргийн алба хаагчийн боловсролын төвшинг үзэхэд бүрэн дунд болон дээд боловсролтой цэргийн алба хаагчдын ял шийтгүүлсэн байдал нь их байна.

Түүнчлэн энэ судалгаанд хамруулсан 496 эрүүгийн хэрэг, баримтын яллагдагч, шүүгдэгчийн боловсролын төвшинг шүүхээс ял шийтгүүлсэн 79 шүүгдэгчийн боловсролын төвшинтэй харьцуулахад ижил үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл шийдвэр гаргах, захиран тушаах албан тушаал хашиж буй бүрэн дунд болон дээд боловсролтой цэргийн алба хаагчид гэмт хэрэг үйлдэх өндөр эрсдэлтэй байна. Харин бүрэн дундаас доош боловсролтой цэргийн алба хаагчид гэмт хэрэг үйлдэх эрсдэл бага байна.

### 3.1 Хүний амь нас хохирсон гэмт хэрэг

2002 оны Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлд заасан хүний санаатай алах 2, 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 10.1 дүгээр зүйлд заасан хүнийг алах 1 нийт 3 эрүүгийн хэрэгт яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлснийг шүүх хянан хэлэлцээд дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчиж хүний амь нас хохироосон 1 эрүүгийн хэргийг согтуугаар болгоомжгүйгээр үйлдсэн гэж дүгнэн, Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хөнгөрүүлэн зүйлчилж ял оногдуулсан;
- Ёс бус бэлгийн харьцаанаас улмаас санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидан бусдыг санаатай алсан гэж дүгнэн 1 эрүүгийн хэргийг Эрүүгийн хуулийн 93 дугаар зүйлээр хөнгөрүүлэн зүйлчилж ял оногдуулсан;

<sup>15</sup> ЗХЖШ-аас ирүүлсэн мэдээлэл.

- 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн 10.1-1, 28.5-1, 28.7-2, 28.8-1, 28.15-1 зүйлд зааснаар 1 эрүүгийн хэргийн зүйлчлэл хэвээр үлдээж, шүүгдэгчид ял оногдуулсан.

Тохиолдол

*...Хилийн цэрэг... намайг хониндоо яв "П" минь, түлш оруул, хоол хий гэж байнга зодоод байсан. Тэгээд орой болгон миний эм болно шүү гээд намайг тонгой гээд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангадаг байсан... 22:00 цагийн үед...*

*(Сум дундын ... дугаар шүүхийн шийтгэх тогтоол)*

Эдгээр гэмт хэргийн шалтгаан нь архиан согтуурах, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, удирдах албан тушаалтны дарамт шахалт түүнээс үүдсэн дүрмийн бус “дэглэлт”-ийн хуучин арга хэлбэр өнөөг хүртэл арилагүй байгаатай холбоотой байна. Энэ байдал нь хүний амь нас, цэргийн албанаас оргон зайлах болон цэргийн албаны эсрэг ноцтой гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд хүргэж байна.

### 3.2 Амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 10.4 дүгээр зүйлд заасан хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 1 гэмт хэрэгт үйлдэгдсэн нь Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад гарчээ. Энэ нь энхийг сахиулах ажиллагааны үүрэг гүйцэтгэж байсан баг, ротын захирагч, сургагч ахлагчид нь хохирогчийг ар гэртээ утсаар хов зөөсөн гэж бие бүрэлдэхүүний өмнө буруутгаж, нэр хүндийг гутааж доромжилсноор амиа хорлох нөхцөл байдалд хүргэжээ. Үүний шалтгаан нь цэргийн багийн удирдах бүрэлдэхүүний дүрмийн бус харьцаа, удирдахуйн ухааны арга барил, туршлага хангалтгүй байсантай холбоотой байна.

Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй бие бүрэлдэхүүнийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэх, хүний эрхийн хэм хэмжээг ажил хэрэг болгохыг шаарддаг. Ялангуяа энэ ажиллагаанд оролцож, үүрэг гүйцэтгэж буй офицер, ахлагчдыг зөвхөн цэргийн мэргэжил, мэргэшлийн ур чадвараас гадна олон улсын хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйн мэдлэг ойлголттой болгох, удирдлагын манлайлал, багаар ажиллах, асуудал шийдвэрлэх, үүрэг, хариуцлагаа ухамсарлах гэх мэт мэдлэг, ур чадвартай болсоноор удирдлагад байгаа албан хаагчдынхаа хувьд үлгэрлэл, манлайллыг бүрдүүлэх нэг нөхцөл нь болдог байна. Иймд энхийг дэмжих ажиллагаанд явж буй баг бүрэлдэхүүний удирдах албан тушаалтанд сонгон шалгаруулалтад хүний эрхэд суурилсан хандлага арга зүйг удирдлага болгох, удирдлагын манлайлал, ур чадвар, хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйн сургалтыг тогтмолжуулах нь чухал байна.

### 3.3 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг

2002 оны Эрүүгийн хуулийн 96, 97, 98 дүгээр зүйлүүд, 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 11.4, 11.6 дүгээр зүйлүүдэд заасан хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 20 эрүүгийн хэргийг шүүхээс шийдвэрлэсэн нь дараах байдалтай байна. Үүнд:

- 2002 оны Эрүүгийн хуулийн 96.1 дүгээр зүйлд заасан бусдын бие махбодод хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 2;
- 2002 оны Эрүүгийн хуулийн 97.1 дүгээр зүйлд заасан бусдын бие махбодод хүнд гэмтэл болгоомжгүй учруулах гэмт хэрэг 1;
- 2002 оны Эрүүгийн хуулийн 98.1 дүгээр зүйлд заасан бусдын бие махбодод хүндэвтэр гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 4;
- 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 11.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг 1;
- 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 11.6 дугаар зүйлд заасан хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг 13 байна.



## Тохиолдол

*...Зэвсэгт хүчинд ... Цэргүүдийг жагсаалаас хоцорсон, тамхи татахгүй газар тамхи татсан, цэвэрлэгээ муу хийсэн, цэргүүд хоорондоо муудалцсан зэрэг шалтгаанаар алгадах, шанаа, цээжинд цохих, ус уулгах, сунилгах зэргээр дүрмийн бусаар харьцаж шийтгэсэн ...*

*(Сум дундын ... дугаар шүүхийн шийтгэх тогтоол)*

Гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөл нь нэг талаас тогтоосон цагийн хуваарийг мөрдөж хэвшээгүйгээс ажлын цаг ашиглалт суларч, цэргийн алба, сахилга дэг журам зөрчигдөх, архидан согтуурах, удирдах албан тушаалтны зүгээс дарамт шахалт үзүүлэх, хүнлэг бус хандах, хугацаат цэргийн алба хаагчид тушаал биелүүлэхгүй, үл захирагдах байдал гаргаж байгаагаас дүрмийн бус харьцах зэрэгтэй холбоотой байна. Нөгөө талаас цэргийн албаны үйл ажиллагааны доголдол, хяналт шалгалт тогтолцоо сул, урьдчилан сэргийлэх ажил үр нөлөө багатай, хугацаат цэргийн албанд татагдан ирж байгаа иргэдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хувь хүний төлөвшил, хандлага нөлөөлж байна.

#### 3.4 Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг

2002 оны Эрүүгийн хуулийн 277, 279, 280, 278, 283.1, 288 дугаар зүйлүүд, 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 28.3, 28.5, 28.7 дугаар зүйлүүдэд заасан цэргийн албаны эсрэг 43 эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байна. Үүнд: 2002 оны Эрүүгийн хуулийн 277 дугаар зүйлд заасан захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх гэмт хэрэг 6, 278 дугаар зүйлд заасан бие биедээ захирагдахгүй цэргийн албан хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих гэмт хэрэг 8, 279 дүгээр зүйлд заасан цэргийн албанаас оргон зайлах 8, 280 дугаар зүйлд заасан биедээ гэмтэл учруулах буюу өөр бусад аргаар цэргийн албанаас зайлсхийх гэмт хэрэг 1, 283 дугаар зүйлд заасан байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих гэмт хэрэг 3, 288 дугаар зүйлд заасан харуулын албаны журам зөрчих гэмт хэрэг 1 тус тус шийдэрлэгдсэн байна.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 28.3 дугаар зүйлд заасан дарга захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх гэмт хэрэг 4, 28.5 дугаар зүйлд заасан цэргийн албанаас оргон зайлах гэмт хэрэг 7, 28.7 дугаар зүйлд заасан цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших гэмт хэрэг 2 байна.

Эдгээр гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь галт зэвсэгтэй харьцах журам зөрчих, цэргийн алба хаагчдын эд зүйлс хулгайлах, байлдааны сум завших, архидан согтуурах, хугацаат цэргийн алба хаагчид удирдах албан тушаалтанд илтгээгүй, рапорт өгөөгүй, харуулын үүргийг зөрчиж унтсан зэргээс дүрмийн бус шийтгэл хүлээх, хоол унд таарахгүй байх, гэр бүлээ санах, монгол хэл мэдэхгүйгээс ялгаварлан гадуурхагдах, зодуулах, чөлөөгөөр яваад ангид эргэж ирэхгүй байх, дур зоргоор хандах зэрэг болно.

## Тохиолдол

*...Шүүгдэгчийн өгсөн мэдүүлгээс "...миний гар урд өдөр нь хавдсан байсан" ...харуулын даргад "... дарга миний гар өвдөөд байна би застав руу буцъя, та засташаас бүлэг дуудаад өг, миний бие болохгүй байна..." гэж хэлсэн. Дарга тэрийг сонсоод уурлаж харуулын байрны том өрөөнд хоёр АКМ маркийн буу ил байдаг байсан тэрийг аваад намайг гал тогооны өрөөнд оруулж зодсон. Бууны бөгсөөр цээжин тус газар хэд хэдэн удаа цохисон, ташаан толгой руу цохисон. Тэгээд би өвдөөд уйлсан. Хамгийн сүүлд миний идээлсэн гар луу цохисон ... нэг магазин сум өгсөн... би хоёр бай буудаж үзсэн... айгаад намайг зодох нь гэж бодсон... нэг мэдэхэд хүний аминд хүрсэн байсан..."*

*.... Хугацаат цэргийн алба хаагчидтай дүрмийн бусаар харьцаж зоддог, дарамтталдаг, дэглэдэг байсан нь тогтоогдсон тул хөнгөрүүлж үзэх үндэслэлтэй...*

*(Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ... дугаар шийтгэх тогтоолоос)*

Түүнчлэн цэргийн албанд захирах, захирагдах ёс, цэргийн ажил хөдөлмөрт сургах нэрийн дор хугацаат цэргийн алба хаагчидтай дүрмийн бус харьцах, тэдний эрх чөлөөнд халддаг явдлыг байх ёстой үзэгдэл мэтээр ойлгож, уламжлагдан ирсэн зохисгүй хандлага байсаар байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байна.

#### 4. ПРОКУРОРЫН ХЯНАЛТАД ХЭРЭГСЭХГҮЙ БОЛСОН, ХААСАН, ТҮДГЭЛЗҮҮЛСЭН ХЭРЭГТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Прокурорын хяналтын шатанд мөрдөн байцаалтын хэрэг хэрэгсэхгүй болсон, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, түдгэлзүүлсэн эрүүгийн 40 хэргийг судалж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Хүний амьд явах эрхийн эсрэг амь нас хохирсон 8 (үүнээс амиа хорлосон 6);
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 8;
- Цэргийн албаны эсрэг 22;
- Бусад гэмт хэрэг 2 байна.

Эдгээр эрүүгийн хэрэгт 46 холбогдогч, 52 хохирогчтой байгаа бөгөөд үүнээс 18-35 насныхан гэмт хэрэг үйлдэх эрсдэл өндөртэй байна. Энэ нь Улсын ерөнхий прокурорын газрын цахим санд бүртгэгдсэн 496 гэмт хэрэгт холбогдсон цэргийн алба хаагчийн насны ангилалтай таарч байна. Өөрөөр хэлбэл нас залуу байх тусам гэмт хэрэг, зөрчил үйлдэх эрсдэл их бөгөөд нас ахих тусам уг эрсдэл буурч байна.

Судалгаанд хамрагдсан 46 холбогдогчийн дийлэнх нь буюу 47,8 хувь нь бүрэн дунд боловсролтой, 28,2 хувь нь дээд боловсролтой байна. Энэ нь Улсын ерөнхий прокурорын газрын цахим санд бүртгэгдсэн 496 гэмт хэрэгт холбогдсон цэргийн алба хаагчдын боловсролын ангилалтай ижил үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл бүрэн дундаас доош боловсролтой цэргийн алба хаагчдын гэмт хэрэг, зөрчил үйлдэх эрсдэл бага байдаг гэж үзэхээр байна.

Харин бүрэн дунд, дээд боловсролтой, тусгай мэргэжил эзэмшсэн цэргийн алба хаагчдад зориулан Цэргийн нийтлэг дүрмүүд, сахилгын шийтгэл хүлээх хууль зүйн үндэслэл, төрөл хэлбэр, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалахад чиглэгдсэн сургалт, мэдээллийн чанарт ахиц гаргах шаардлагатай байна. Түүнчлэн офицер, ахлагчид нь хугацаат цэргийн алба хаагч нартай харьцах үед өдөр тутам сургагч багшийн үүрэг гүйцэтгэж байдаг тул сурган хүмүүжүүлэх ухааны арга барилд сургах нь чухал байна.

##### 4.1 Хүний амь нас хохирсон гэмт хэрэг

2015 оны Эрүүгийн хуулийн 10.6 дугаар зүйлд заасан хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг 2 гарсныг хэрэгсэхгүй болгожээ. Үүнд:

- Зэвсэгт хүчний ...дугаар ангийн хээрийн сургуулилын явцад ангийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр цэргийн алба хаагчаар сургалтын нэгдсэн төвийн буудлагын талбайгаас гранат авчруулснаар дэлбэрэлтэд өртөж 2 хүн нас барж, 11 хүнд гэмтэл учирсан.
- Хилийн цэргийн ...дугаар ангийн тусгай бэлтгэлийн хашаанд хугацаат цэргийн алба хаагч нь машин түрж яваад газарт унан, дугуйн дор орж, амь нас нь эрсдсэн.

Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлд эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч яллагдагч гэм буруутай эсэх, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэнэ гэснийг удирдлага болгон мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад зааснаар гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болсон байна.

Хэдийгээр гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон нь хууль зүйн хувьд үндэслэлтэй боловч энэ нь сахилга хариуцлага, дэг журамтай холбоотой тул цаашид болгоомжгүйгээр хүний амь нас хохироох, гэмтээх үйлдлүүд гарахыг үгүйсгэхгүй юм. Иймд цэргийн анги, байгууллагын удирдлагууд осол, гэмтэл гарахыг урьдаас тооцоолох чадвартай, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч байх нь зүйтэй байна.

##### 4.2 Амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг

2002 оны Эрүүгийн хуулийн 95 дугаар зүйлд заасан бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 1, 2015 оны Эрүүгийн хуулийн 10.4 дүгээр зүйлд заасан хүнийг амиа хорлох

нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 5 гарчээ. Үүнээс 4 хэргийг хэрэг бүртгэлтэд хаасан, 1 хэрэгт мөрдөн байцаалт явуулж гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон байна. Амиа хорлосон тохиолдлын 3 нь хугацаат цэрэг, 2 нь офицер, 1 нь ахлагч байжээ. Үүнээс өөрийгөө боомилсон 3, буудсан 1, усанд живсэн 2 тохиолдол байна.

Түүнчлэн 2019 онд Хилийн цэргийн ...дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч нь модноос өөрийгөө дүүжилж, амиа хорлосон гэж хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан мөртлөө “ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ ослын улмаас амь насаа алдсан тул түүний ар гэрт 5 жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж 43.197.000 төгрөг”-ийн тэтгэмж олгосон нь үндэслэлгүй юм.

Амиа хорлосон гэмт хэргүүдийн шалтгаан нөхцөлийг судалж үзэхэд сэтгэцийн эмгэг оноштой, нутаг оронд шилжих хүсэлтийг хүлээж аваагүй, нойр хүрдэггүй, цагаан мах гарч, шулуун гэдэснээс цус гарах байдлаар бие нь өвддөг, хугацаат цэргийн албанаас шантарсан, гэр бүлийн таарамжгүй харьцаа зэрэг шалтгаантай байна.

Тохиолдол
<i>...Хилийн цэргийн ... дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч нь 2015 оны ...дүгээр сарын 06-ны өдрийн өглөө ангийн цэргийн бие засах газар мяндсан утсаар өөрийгөө боомилж нас барсан. ... Тангаргийн баяраар аав ээж ирсэнгүй, хал цэрэг ах нар суниа гээд дээрэлхээд байна ... бичиг үсэг мэдэхгүй, гэрээ санаад байна гэдэг... (Прокурорын ... дугаар тогтоол)</i>

Цэргийн алба хаагчид үүрэг гүйцэтгэх сэтгэл зүйн бэлэн байдал, сахилга бат, дэг журам, цэргийн бэлтгэл хийх, тэвчээр хатуужил, хүлээцтэй байх зан чанарыг бий болгохдоо дан ганц захирах, захирагдах ёс, дүрэм журмаар зохицуулах боломжгүй юм.

Тохиолдол
<i>...2019 оны ... дугаар.-ны өдөр Хилийн цэргийн ... дугаар ангийн ... дугаар заставт ..... гэх газарт хугацаат цэрэг модноос боож нас барсан гэмт хэрэг гарсан. ...гэрчийн мэдүүлгээр “Цэргийн албанд хэрэггүй иржээ, ард амьдралаар амьдрах юмсан, би ямар газар ирчихвээ, ард байхад эрх чөлөөтэй сайхан байжээ, нуугаад яахав үнэхээр шантарч байна.” гэж ярьж байсан..... (Прокурорын ... дугаар тогтоол)</i>

Иймээс цэргийн анги, байгууллагад байнгын сэтгэл зүйч ажиллуулж, нөхцөл байдлын үнэлгээ хийх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн анализ, зураглал хийх сургалтуудыг тогтмол зохион байгуулж, хэрвээ боломжгүй тохиолдолд 24 цагийн ажиллагаатай утсаар болон цахимаар холбогдон сэтгэл зүйн зөвлөгөө авах боломжоор хангах нь чухал байна. Энэ нь хугацаат цэргийн алба хаагчдад урам зориг өгөх, бүтээлч оролцоо, идэвхийг сэргээн арвижуулахад дэмжлэг болох юм.

#### 4.3 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг

2002 оны Эрүүгийн хуулийн 96, 97, 98, 99 дүгээр зүйлүүд болон 2015 оны Эрүүгийн хуулийн 11.1-11.6 дугаар зүйлүүдэд заасан хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн 8 гэмт хэрэг байна. Үүнд 2002 оны Эрүүгийн хуулийн 99.1 дүгээр зүйлд заасан бусдын бие махбодод хүндэвтэр гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 4, 2015 оны Эрүүгийн хуулийн 11.3 дугаар зүйлд заасан хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах гэмт хэрэг 1, 11.4 дүгээр зүйлд заасан хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг 1, 11.6 дугаар зүйлд заасан хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг 2 байна.

Эдгээрээс 4-ийг нь хэрэг бүртгэлтийн шатанд хааж, 4-ийг нь мөрдөн байцаалтын шатанд хэрэгсэхгүй болгожээ. Эдгээр гэмт хэрэг нь жагсаалын бэлтгэл хийхэд толгой хөдөлгөсөн, үүрэг даалгавар биелүүлээгүй, архи дан согтуурсан, хувийн таарамжгүй харьцаа, захирагдах албан хаагчид дээрэнгүй хандах, хуучин, шинэ цэргийн ялгаа гаргах, дарамтлах, аюулгүй ажиллагааны заавар зөрчсөн зэрэг шалтгааны улмаас үйлдэгдсэн байна.

#### 4.4 Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг

2002 оны Эрүүгийн хуулийн 187, 277, 283.1, 288 дугаар зүйлүүд, 2015 оны Эрүүгийн хуулийн 28.3, 28.4, 28.5, 28.6, 28.9 дүгээр зүйлүүдэд заасан цэргийн албаны эсрэг үйлдэгдсэн 24 гэмт **хэрэг нь байна. Үүнд** 2002 оны Эрүүгийн хуулийн 187 дугаар зүйлд заасан галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хамгаалах үүрэгт ажилдаа хайнга хандах гэмт хэрэг 1, 277 дугаар зүйлд заасан захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх гэмт хэрэг 11, 283 дугаар зүйлд заасан байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих гэмт хэрэг 1, 288 дугаар зүйлд заасан харуулын албаны журам зөрчих гэмт хэрэг 1 байна.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 28.3 дугаар зүйлд заасан дарга захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх гэмт хэрэг 1, 28.4 дүгээр зүйлд заасан бие биедээ захирагдахгүй цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих гэмт хэрэг 1, 28.5 дугаар зүйлд заасан цэргийн албанаас оргон зайлах гэмт хэрэг 6, 28.6 дугаар зүйлд заасан биедээ гэмтэл учруулах, өөр бусад аргаар цэргийн албанаас зайлсхийх гэмт хэрэг 1, 28.9 дүгээр зүйлд заасан байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих гэмт хэрэг 1 байна.

Эдгээр хэргээс хэрэг бүртгэлийн хаасан 13, хэрэгсэхгүй болгосон 9 эрүүгийн хэрэг байна. Гэмт хэрэг гарах болсон шалтгаан нөхцөл нь галт хэрэгсэлтэй зөв харьцах, аюулгүй ажиллагааны зааварчлагыг мөрдөөгүй, захирагчийн үүргийг биелүүлээгүй, цэргийн дүрмийн бус харьцаа, архидан согтуурсан, ахлах даргаа хүндлээгүй, галт зэвсэгтэй харьцах журам зөрсөн, зөвшөөрөлгүй дэлгүүр явсан зэрэгтэй холбоотой байна.

Түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримт цуглуулах ажиллагаа хангалттай явагддаггүй учраас гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгох, хааж байгаа нь мөрдөх байгууллага болох прокурорын байгууллагаас энэ төрлийн гэмт хэргийг мөрдөх, хянах арга, туршлага багатай байна гэж үзэхээр байна. Иймд дагнасан мөрдөгч эсхүл дагнасан прокурор бий болгох, мэргэшүүлэх шаардлагатай юм.

### ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Цэргийн алба хаагчид Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэдийн эрх, үндсэн эрх чөлөөг эдэлдэг хэдий ч цэргийн тусгай чиг үүрэгтэй холбогдуулан цэргийн албан хаагчдын эрхийг салбарын хууль тогтоомжоор хязгаарладаг байна. Учир нь цэргийн алба хаагчийн хувьд хүлээх үүрэгт нууц баримт бичигтэй танилцах эрхтэй байдаг тул үг хэлэх эрх чөлөө, аюулгүй байдлын бэлэн байдлыг хангах үүднээс шилжилт хөдөлгөөн үйлдэх эрх чөлөө, мөн улс төрийн албан тушаалд сонгогдох эрх чөлөө нь тодорхой хэмжээгээр тус тус хязгаарлагддаг.

Дүрмийн бус харьцаа нь цэргийн анги байгууллага дахь хүний эрхийн ноцтой зөрчил бөгөөд ямар ч тохиолдолд зөвтгөхгүй. Энэ нь хууль ёсны харьцаа, хууль тогтоомжоор заасан шийтгэлийн хэлбэрээс давсан, үргэлжилсэн, төлөвлөсөн шинжтэй, бие махбод, сэтгэл санааны шаналал үүсгэдэг. Ялангуяа хүнлэг бус, гутаан доромжилсон харьцаа болдоггүй тодорхой үйлдэл хэр хэмжээ хэтрэх, удаан хугацаанд сунжирч үргэлжлэн, хүчирхийлсэн, заналхийлсэн байдлаар тодорхой хязгаарыг давсан харьцаа нь хүнлэг бус, гутаан доромжилсон харьцаа болж байна.

Цэргийн алба хаагчдын харьцааны зөрчил тэр дундаа байлдагч, түрүүч зэрэг бага тушаалын алба хаагчтай дүрмийн бусаар харьцах, удирдах албан тушаалтны зүгээс дарамтлах, дэглэх, хүч хэрэглэх, бие махбодод гэмтэл учруулах, нэр төрийг нь гутаан доромжлох зэрэг зөрчлийг хүний эрхийн ноцтой зөрчилд тооцдог. Хүний эрхийн ийм зөрчлийг ямар ч тохиолдолд нуун далдалж, өөгшүүлэн дэмжиж, захирах, захирагдах ёсны үзэл санааны дор цагаатгаж болохгүй юм.

Олон улсын эрх зүйгээр энэ суурь хүний эрхийг цэргийн үүргийн шаардлагын улмаас ч гэсэн хязгаарлахыг зөвшөөрдөггүй. Тодруулбал цэргийн алба хаагч амь нас, эрүүл мэндээрээ хохирдог, амиа хорлоход хүргэдэг үйлдэл, хүнлэг бус, гутаан доромжилсон харьцаанаас хамгаалуулах эрхтэй бөгөөд эдгээр эрхүүд цэргийн үүргийн шаардлагын улмаас ч хязгаарлагдах ёсгүй байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх заалтад амьд явах эрхтэй..., мөн зүйлийн 13 дахь заалтад “хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй...” гэж Монгол Улсын иргэн эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 3 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг баталгаажуулсан байдаг. “Халдашгүй, чөлөөтэй байх” гэдгийг Хүний эрхийн хорооны 2014 оны 35 дугаар Ерөнхий зөвлөмжид “чөлөөтэй байх” нь чөлөөтэй ямарваа нэгэн үйлдэл хийхээс илүүтэйгээр бие махбодын хувьд хорих, цагдахаас ангид байхыг илтгэх, “халдашгүй байх” нь бие махбод болон оюун санааны хувьд бүрэн бүтэн, ямар нэг халдлага, дайралтаас ангид байхыг илэрхийлжээ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй”, 7 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно...” гэж тус тус заасан. Хүний эрхийн хорооны 1982 оны 6 дугаар Ерөнхий зөвлөмжийн 3 дахь хэсэгт “Хүний амийг төрийн эрх барих байгууллага хороох нь хамгийн ноцтой хүнд гэмт хэрэг юм. Иймээс эрх барих байгууллага хүний амийг хороож болзошгүй нөхцөл байдлыг хуулиар хатуу хянан хязгаарлах ёстой” гэжээ. Түүнчлэн Хүний эрхийн хорооны 1982 оны 7 дугаар Ерөнхий зөвлөмжийн 1 дэх хэсэгт “...зүй бусаар харьцах буюу доромжлохыг хориглох... ямарваа нэгэн хяналтын механизм нэвтрүүлэн үр дүнтэй хамгаалалт бий болгох ёстой” хэмээн тайлбарласан байна.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ 1 дүгээр зүйлд тодорхойлсон эрүү шүүлтэд тооцогдохгүй төрийн албан тушаалтан буюу албаны үүрэг гүйцэтгэж буй бусад этгээд, тэдгээрийн өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр үйлдэгдэх хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх бусад үйлдлээс сэргийлэх үүрэг хүлээн...” гэж заасан.

Цэргийн албан хаагчдын дагаж биелүүлэх үүрэгтэй тушаалын цар хүрээг цэргийн албаны хууль тогтоомжид тодорхойлсон. Тухайлбал Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Захирагч, даргын гаргасан тушаал, шийдвэрийг цэргийн алба хаагч үг дуугүй биелүүлэх үүрэгтэй”, мөн зүйлийн 6.3 дахь хэсэгт “Захирагч, даргын тушаал, шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна” гэжээ. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасны дагуу цэргийн алба хаагч нь төрийн бодлого, хууль тогтоомж, захирагч, даргын тушаалыг эсэргүүцэх, биелүүлэхээс татгалзахыг хориглоно гэжээ.

Цэргийн дотоод албаны дүрмийн 16-28 дугаар хэсэгт зааснаар “Цэргийн алба хаагч нь албан тушаал, цолны эрэмбээр нэг нь нөгөөдөө захирагч буюу захирагдагч байх бөгөөд захирагчаас захирагдагч нарт хандан, тодорхой ажиллагааг заавал биелүүлэхийг шаардсан тушаалыг амаар, бичгээр өгнө. Захирагч өгсөн тушаалын хариуцлагыг хуулийн өмнө биечлэн хариуцна. Тушаал ойлгомжтой, тодорхой, биелэгдэх үндэслэлтэй байна. Тушаал биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол сахилгын шийтгэл оногдуулна. Цэргийн алба хаагч нь захирагчийн өгсөн тушаалыг цаг хугацаанд нь заавал биелүүлж,

илтгэдэг” байна.<sup>16</sup>

Цэргийн анги, байгууллагын захирагч, удирдах албан тушаалтан тушаал өгөхдөө хууль ёсыг дээдэлж, хуульд нийцсэн тушаалыг амаар болон бичгээр шаардах бөгөөд цэргийн албан хаагчид хууль бус тушаалыг биелүүлэхгүй байх эрхтэй. Хэрвээ хууль бус тушаалыг гүйцэтгэсэн тохиолдолд тухайн тушаал нь өөрийгөө зөвтгөх үндэслэл болохгүй, хийсэн үйлдлийнхээ төлөө өөрсдөө хариуцлага хүлээдэг. Иймд удирдах албан тушаалтан, захирагчид нь хугацаат цэргийн алба хаагчдын эрхийг хүндэтгэх, хамгаалах нэн тэргүүний үүргийг хүлээдэг тул тэдний хүний эрхийн хэрэгжилтийг үр дүнтэй, үр нөлөөтэй хангах явдлыг бодлого тогтолцоо, ёс зүй, хариуцлага, манлайлал, ур чадварын түвшинд хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйгээр нэвтрүүлэх, хэрэгжүүлэх нь чухал байна.

Иймд судалгааны үр дүнг үндэслэн дараах **санал, зөвлөмжийг** дэвшүүлж байна. Үүнд:

- Цэргийн албаны болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцааг хориглосон зохицуулалтыг тусгах;
- Цэргийн албаны болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд цэргийн анги, байгууллага дахь дүрмийн бус харьцаа, гэмт хэрэг, зөрчлийг мэдээлсэн цэргийн алба хаагч ямар нэгэн дарамт шахалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид бий болгох;
- Эрүүгийн хуулийн тусгай 28 дугаар бүлэгт цэргийн албаны эсрэг гэмт хэргийг тайлбарласан хэсэгт “Монгол Улсын зэвсэгт хүчин, хилийн цэргийн бие бүрэлдэхүүнд цэргийн жинхэнэ алба хааж байгаа...” гэсэн хэсэгт “дотоодын цэрэг”-ийг нэмж тусгах;
- Батлан хамгаалах сайдын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/31 дугаар «Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам»-ын 3.14-т хүний эрхийн агуулгыг шинээр нэмж тусган, сонгон шалгаруулалтын шалгалтын төрлийн заасан “хууль эрх зүйн бэлтгэлийн шалгалт” гэснийг “хүний эрх, хууль эрх зүйн бэлтгэлийн шалгалт” гэж өөрчлөх;
- Цэргийн нийтлэг дүрэм бусад эрх зүйн актуудыг хүний эрхийн зарчим хэм хэмжээнд нийцүүлэн шинэчлэх, эдгээр актыг код, стандарттай болгож хэрэгжүүлэх;
- Цэргийн анги байгууллагад үйлдэгдэж байгаа дүрмийн бус харьцаа, гэмт хэрэг, зөрчлийг хянах, илрүүлэхэд чиглэгдсэн хяналт шалгалт, мониторингийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх;
- Цэргийн мэргэжлийн болон эрх зүйн сургалтын хөтөлбөр, энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний сургалтын агуулгыг үнэлэх, хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйн хичээлийн агуулгыг нэмж, оролцооны аргад тулгуурлан шинэчлэн боловсруулах замаар цэргийн мэргэжлийн алба хаагчийг бэлтгэх, давтан сургах бодлого, тогтолцоог боловсронгуй болгох;
- Цэргийн анги байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх аргачлалыг боловсруулж нэвтрүүлэх;
- Цэргийн анги, байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг, цэргийн алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчил, осол, сахилгын зөрчилд холбогдсон тохиолдлыг бүртгэх тогтолцоо шинэчлэх, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, хуулийн байгууллагатай харилцан мэдээлэл солилцох ажлыг хэвшүүлэх;
- Цэргийн анги, байгууллага, объектод үйлдэгдсэн, офицер, ахлагч, гэрээт, хугацаат цэргийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн талаарх мэдээллийн нэгдмэл байдлыг хангуулж, энэ талын нэгдмэл, бодит мэдээллийг холбогдох шатанд танилцуулж, БХЯ, ЗХЖШ, ХХЕГ, цагдаа, прокурор, шүүхийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг сайжруулах, бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, түүнд үндэслэн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

<sup>16</sup> Цэргийн дотоод албаны дүрмийн 16-28 дахь хэсгүүдэд заасан.



- Цэргийн алба хаагчидтай холбогдох хэргийг мөрдөн шалган ажиллагааг аймаг орон нутагт харилцан адилгүй өөр өөр байдлаар хэрэгжүүлж байгаа тул цэргийн албаны эсрэг гэмт хэргийг мөрдөх дагнасан мөрдөгч, дагнасан прокурор бий болгох, мэрэгшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Цэргийн алба хаагчдад үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;
- Цэргийн анги, байгууллагад байнгын сэтгэл зүйч ажиллуулах боломжгүй тохиолдолд 24 цагийн ажиллагаатай утсаар болон цахимаар холбогдон сэтгэл зүйн зөвлөгөө авах боломжоор хангах.

## ЭХ СУРВАЛЖ

Монгол Улсын хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
2. Эрүүгийн хууль (2002)
3. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль (2002)
4. Эрүүгийн хууль (2015)
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)
6. Цэргийн албаны тухай хууль (2016)
7. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль (2016)

Олон улсын хэм хэмжээ

1. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал (1948)
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1968)

Бусад эх сурвалж

1. Улсын Ерөнхий прокурорын газрын 2010-2011 оны мэдээ, тайлан.
2. Эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг (2010-2021)
3. Прокурорын хяналтын шатанд мөрдөн байцаалт явуулсан хэргийг хэрэгсэхгүй болгосон болон хэрэг бүртгэлтийн хаасан хэргүүд (2010-2021)
4. Прокурорын үйлдсэн яллах дүгнэлт, хэрэгсэхгүй болгосон, хаасан тогтоолын хувь (2020-2021)
5. ЗХЖШ-ын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 1/2937 дугаар албан бичиг.
6. УЕПГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/1991 дүгээр албан бичиг.
7. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол (гэмт хэргийн тухай сургаал), I боть, УБ., 2009.
8. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол (ялын сургаал), II боть, УБ., 2014.
9. Б.Бат-Ерөөлт, Б.Нямдорж, Цэргийн гэмт хэрэг, Гарын авлага, УБ., 2007.
10. Л.Батжав, Монгол Улсын Цэргийн эрх зүй, УБ., 2005.
11. Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Хил хамгаалах байгууллагад үйлдэгдэж байгаа онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөл” сэдвээр криминологи судалгааны тайлан, УБ., 2010.
12. Б.Мөнхдорж (Судалгааны багийн ахлагч), Г.Эрдэнэбат (Судалгааны багийн зөвлөх), ДХИС, МКХ-ны судалгааны баг, Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном-2016, Суурь судалгааны тайлан, УБ., 2017.
13. Б.Мөнхдорж (Судалгааны багийн ахлагч), Г.Эрдэнэбат (Судалгааны багийн зөвлөх), ДХИС, МКХ-ны судалгааны баг, Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан

- ном-2017, Суурь судалгааны тайлан, УБ., 2018.
14. Ж.Өвгөнбүргэд, Б.Эрдэнэбат, Б.Даяадан-Эрмэд нар, “Цэргийн албанд үйлдэж болзошгүй гэмт хэрэг” сэдэвт гарын авлага, УБ., 2019.
  15. Б.Мөнхдорж (Судалгааны багийн ахлагч), Г.Эрдэнэбат (Судалгааны багийн зөвлөх), ДХИС, МКХ-ны судалгааны баг, Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном-2018, Суурь судалгааны тайлан, УБ., 2019.
  16. Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүйн тусгай анги, Сурах бичиг, УБ., 2020.

Цахим эх сурвалж

1. Авлигатай тэмцэх газар. <http://www.iaac.mn/>
2. Батлан хамгаалах яам. <http://www.mod.gov.mn/>
3. Зэвсэгт хүчний жанжин штаб. <https://www.gsmf.gov.mn/>
4. Улсын ерөнхий прокурорын газар. <http://prokuror.mn/>
5. Улсын дээд шүүх. [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn)
6. Үндэсний статистикийн хороо. [www.nso.mn](http://www.nso.mn), [www.1212.mn](http://www.1212.mn)
7. Хил хамгаалах ерөнхий газар. <https://bpo.gov.mn/>
8. Хууль зүй, дотоод хэргийн яам. [www.mojha.gov.mn](http://www.mojha.gov.mn)
9. Дотоод хэргийн их сургууль. [www.uia.gov.mn](http://www.uia.gov.mn)
10. Шүүхийн ерөнхий зөвлөл. [www.judcouncil.mn](http://www.judcouncil.mn)
11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. [www.cd.gov.mn](http://www.cd.gov.mn)
12. Шүүхийн цахим мэдээллийн сан. <http://www.shuukh.mn/>
13. Цагдаагийн ерөнхий газар. [www.police.gov.mn](http://www.police.gov.mn)
14. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

**CAUSES AND CIRCUMSTANCES OF CRIMES COMMITTED WITHIN THE  
CONFINES OF MILITARY DIVISIONS OR AUTHORITIES: AN ANALYSIS  
(OF CASES AND FACTS)**

*Munkhbat Ts. /Ph.D./*

*Public prosecutor for Training and research institute under  
The Prosecutor General's office of Mongolia*

*Nyambat D.*

*Public prosecutor for Training and research institute under  
The Prosecutor General's office of Mongolia,  
Ph.D. candidate of University of Internal Affairs*

**ABSTRACT:**

According to the Law on Military Service, the Laws on the Legal Status of Military Servicemen, and the “General Rules of the Military”, military servicemen are protected from health, life, suicide, human rights, and illegal and inhuman treatment. Unfortunately, the number of crimes and violations committed in military units is increasing year by year.

As a result, the prosecutor's office analyzed 468 cases of crimes and violations committed by the military unit between 2011 and 2021 including criminal files, documents, and court rulings to determine the causes and conditions of the crimes, then make suggestions and recommendations for improving legal regulations and how to stopping and preventing this type of crimes.

**KEYWORDS:** Criminal law, Crimes against military service, Violations, Conscripts, Human rights violations, Illegal and inhuman treatment, Subordination, Orders, Armed forces, Accused, Defendant

## ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙГ ДАВХАР ХУДАЛДСАН ТОХИОЛДЛЫН ТАЛААР ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ: ШҮҮХИЙН ПРАКТИК БА ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



*Р.Пүрэвбаатар  
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн  
Хувийн эрх зүйн тэнхимийн багш,  
Хууль зүйн магистр*

### **ТОВЧЛОЛ:**

Тус өгүүллийн хүрээнд судлаач Монгол улсын Иргэний хууль дахь үл хөдлөх эд хөрөнгийг давхар худалдах тохиолдлын талаар зохицуулсан хэм хэмжээний түүхэн онцлогийг судалж, дараагаар нь шүүхээс тухайн асуудлын талаар шийдвэрлэсэн онцлох шүүхийн шийдвэрт дүгнэлт хийж, өөрийн орны зохицуулалттай адил төстэй зохицуулалт, практик бүхий Серб, Гүрж улсын талаар харьцуулан судалсны үндсэн дээр Иргэний хуулийн 250-р зүйлийг хэрхэн тайлбарлах, эхэлж гэрээ байгуулсан худалдан авагч болон дараа нь гэрээ байгуулсан худалдан авагч нарын эрх, ашиг сонирхлыг хэрхэн тэнцвэржүүлэх талаар өөрийн саналыг илэрхийлсэн болно.

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Зөвшилцлийн загвар, шилжүүлгийн загвар, өмчлөх эрх

## **I. УДИРТГАЛ**

Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг нэг этгээдээс өөр этгээдэд гэрээ байгуулснаар шилжүүлэхэд холбогдох Иргэний хуулийн зохицуулалт нь улс орон бүрийн хувьд ихээхэн маргаан дагуулдаг асуудлын нэг гэж хэлж болно. Манай улсын хувьд ч нэгэн адил нөхцөл байдал байна.

Онолын сурах бичиг, ном товхимолуудад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг гэрээний үндсэн дээр шилжүүлэхтэй холбоотой Иргэний хуулийн зохицуулалтын талаар тайлбарласан агуулга нь шүүхийн практиктай нийцэхгүйн дээр өөр хоорондоо зөрчилтэй байгааг бид төвөггүйхэн олж харж болно. Түүний нэг жишээ нь үл хөдлөх эд хөрөнгийг давхар худалдах буюу нэг үл хөдлөх эд хөрөнгийн хувьд хоёроос дээш этгээдтэй худалдах, худалдан авах гэрээг давхар байгуулах тохиолдлын талаар зохицуулсан Иргэний хуулийн зохицуулалт болон түүний талаарх онолын тайлбар, шүүхийн практик хоорондын зөрчилтэй нөхцөл байдал юм.

Манай улсын хувьд 1926 оны Иргэний хуулиас 1963 оны Иргэний хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байх хооронд онолын хувьд болоод практикийн хувьд нэгдмэл нэг үзэл баримтлалыг мөрддөг байсан гэхэд хилсдэхгүй. Харин 1994 оны Иргэний

хуулийн шинэчилсэн найруулгаас эхлэн шинэ үзэл баримтлалын дор Иргэний хуулийн зохицуулалтыг боловсруулах эхлэл тавигдсан. Гэвч өмнөх хуулиудын үзэл баримтлал, хуулийн бүтэц, системчлэлийн онцлогийг сайтар судлах, одоогийн хууль хоорондын уялдаа холбоо, харьцуулсан эрх зүйн онцлогийг бүрэн харгалзан үзээгүйгээс зөрчилдөөнтэй асуудал үүсэх нэгэн нөхцөл бүрдсэн гэж болно. Үүний нэг жишээ нь 2002 оны Иргэний хуулийн 250-р зүйл юм.

Зохиогчийн хувьд тус өгүүллээрээ одоогийн Иргэний хуулийн 250-р зүйлийн зохицуулалтын талаарх шүүхийн практикийг судалж, тус зохицуулалттай адил агуулга бүхий хэм хэмжээг хуульчилсан оронтой харьцуулсан судалгааг хийх замаар тодорхой дүгнэлт хийхийг зорьсон болно. Гэвч тус судалгааг хэрэгжүүлэх хүрээ хязгаарлагдмал тул манай улсын Иргэний хуулийн өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбогдох зохицуулалтын харьцуулсан эрх зүйн онцлог, онолын асуудлыг дараагийн судалгаагаар илүү дэлгэрүүлэн судлахаар төлөвлөж байна. Энэхүү өгүүллийн хүрээнд юун түрүүнд өмнөх Иргэний хуулиуд дахь холбогдох зохицуулалтын онцлог, онолын тайлбарыг судалж, одоогийн Иргэний хуулийн зохицуулалттай харьцуулж, дараагаар нь 2002 оны Иргэний хуулийн 250-р зүйлийг хэрэглэж шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн хоёр онцлох тогтоолд дүгнэлт хийх болно. Дараагаар нь өөрийн орны холбогдох зохицуулалттай адил төстэй хэм хэмжээг ашигладаг орнууд болох Бүгд Найрамдах Серб улс болон Гүрж улсын талаар харьцуулан судалж, энэхүү өгүүллийн гол судлагдахуун болсон асуудлын талаар зохиогч өөрийн зүгээс тодорхой дүгнэлтийг өгөхийг зорино.

## II. МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ШҮҮХИЙН ПРАКТИК

### 2.1. Иргэний хуулийн зохицуулалт, түүхчилсэн судалгаа

Манай улсын хувьд үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг нэг этгээдээс нөгөө этгээдэд шилжүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулахдаа хуучин Зөвлөлт холбоот улс (цаашид “ЗХУ” гэх)-ын онолын хандлагыг удаан хугацаанд дагаж ирсэн байдаг. ЗХУ-ын хувьд 1920-иод оны эхэнд анхны Иргэний хуулиа батлахдаа Францын зөвшилцлийн загвар (*system of consensus*)-ыг баримталсан<sup>1</sup>. Энэ нь ЗХУ-ын 1960-аад оны эхэнд баталсан Иргэний хууль хүчин төгөлдөр мөрдөгдөх хүртэл хэрэглэгдсэн байна. Манай улсын хувьд жишээ нь 1952 оны Иргэний хуулийн 47-р зүйлд “Хувийн чанараар тодорхойлогдох онцгой юмыг өмчлөх эрх нь гэрээ хийсэн үеэс үүсэх ба харин нэр төрлийн (тоо хүнд хөнгөн хэмжээ) тэмдгээр тодорхойлогдох зүйлс бол тэдгээрийг шилжүүлж өгсөн үеэс эхлэнэ” гэж хуульчилснаас энэхүү рецепц нь тодорхой харагдана. ЗХУ-ын хувьд тус зөвшилцлийн загварыг императив буюу захирмал хэм хэмжээнд тооцдог байсан бөгөөд талууд гэрээнд өөр байдлаар тохиролцох замаар өөрчлөх боломжгүй байжээ<sup>2</sup>.

Харин 1960-аад оны эхэнд ЗХУ нь Иргэний хуулиа шинээр батлахдаа Францын загварыг халж харин түүний оронд Германы *traditio* буюу шилжүүлгийн загвар (хэлбэрийн эсхүл формаль загвар гэх утгаар бусад хэлэнд орчуулагдах нь бий. *Traditio* нь латин хэлэнд шилжүүлэг гэх утгыг илтгэдэг байсан тул “шилжүүлгийн загвар” гэж буулгалаа)-ыг нэвтрүүлсэн байдаг<sup>3</sup>. Уг загварын дагуу бол жишээ нь манай улсын 1952 оны Иргэний хуульд заасан шиг “хувийн чанараар тодорхойлогдох онцгой юм” уу, эсхүл “нэр төрлийн тэмдгээр тодорхойлогдох зүйлс” үү гэдгийг харгалзан үзэхгүйгээр бүх тохиолдолд тухайн хөрөнгийг бусад шилжүүлсэн үеэс өмчлөх эрх нь нэг этгээдээс нөгөөд шилжинэ гэж тайлбарладаг байна. Тус шилжүүлгийн загварыг ашигласан 1964 оны ЗХУ-ын Иргэний хуулийн гол зохицуулалт нь 135-р зүйл болно. Тус 135-р зүйлд “Хууль эсхүл гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээгээр эд зүйлийг олж авсан этгээдэд тухайн эд зүйлийг шилжүүлсэн цагаас эхлэн өмчлөх (эсхүл улсын байгууллага бол удирдан хэрэгжүүлэх эрх) эрх үүснэ.”

<sup>1</sup> OLIMPIAD S.IOFFE, SOVIET CIVIL LAW, MARTINUS NIJHOFF PUBLISHERS 130, (1988)

<sup>2</sup> *Ibid.*

<sup>3</sup> *Ibid.*

гэж заасан байжээ<sup>4</sup>. ЗХУ дахь энэхүү томоохон өөрчлөлт нь манай улсын 1963 оны Иргэний хуульд нөлөө үзүүлсэн байх бөгөөд БНМАУ-ын 1963 оны Иргэний хуулийн 93-р зүйлд “Хууль, гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээгээр эд хогшил олж авсан этгээдэд уул эд хогшлыг шилжүүлсэн цагаас эхлэн өмчлөх (улсын байгууллагад бол энэ хуулийн 63 дугаар зүйлийн 2 дахь ангид зааснаар эзэмших, ашиглах, захиран зарцуулах) эрх үүснэ.” гэж хуульчилснаас энэ нь тодорхой харагдана.

Өмнө дурдсан ЗХУ-ын 1964 оны Иргэний хуулийн 135-р зүйлийн зохицуулалт нь өмчлөх эрх хэнд шилжсэн болохыг тодорхой зохицуулж чадсан уу гэх өнцгөөс дүгнэвэл дутагдалтай гэгдэж байсан ч дараах давуу талтай гэж судлаачид үнэлж байжээ. Учир нь тус зохицуулалт диспозитив буюу зөвшмөл хэм хэмжээнд тооцогдох учраас гэрээний талууд өөрөөр тохиролцоо замаар өмчлөх эрхийг шилжүүлэх үеийг өөрчлөх боломжтой байсан байна. Тиймээс хэрвээ гэрээ нь цуцлагдсан тохиолдолд тухайн эд зүйл (үл хөдлөх эд хөрөнгө нэгэн адил) нь өөр этгээдэд шилжээгүй байсан ч тухайн эд зүйлийн хувьд өмчлөх эрхээ алдсан болохоо, мөн өөрт нь аль хэдийн эзэмшил нь шилжиж ирсэн байлаа ч өмчлөх эрхийг хараахан олж аваагүй байгаа болохоо тус тус өмчлөгч байсан этгээд өөрөө нотлох үүрэг хүлээдэг байжээ<sup>5</sup>. Хэрвээ ийм нотолгоо хийгдээгүй бол тухайн эд хөрөнгийг эзэмшиж байгаа этгээдэд эд хөрөнгийн өмчлөх эрх харъяалагдаж байгаа гэсэн таамаглал үйлчилдэг байв<sup>6</sup>.

Харин Монгол Улсын 2002 оны Иргэний хуулийн хувьд өмнөх хуулиудаас ялгаатай зохицуулалт хуульчлагдсан байдаг. Жишээ нь тус Иргэний хуулийн 111-р зүйлийн зохицуулалт нь ХБНГУ-ын Иргэний хуулийн 929-р зүйл (111.1, 111.2.2), 930-р зүйл (энэ зүйлийг рецепц хийсэн эсэх асуудал маргаантай байх бөгөөд 111.2.1 дэх хэсгийн хувьд хэрвээ шууд бус эзэмшлийг шилжүүлэх явдлыг өөртөө багтаасан гэж тайлбарлавал рецепц хийгдсэн гэж дүгнэх боломжтой. Гэвч фидуцийн гэрээний хувьд уг зохицуулалтыг рецепц хийлгүйгээр ашиглагдах боломжгүйг анхаарах шаардлагатай), 931-р зүйл (111.2.3)-ийг загвар болгон ашигласан байгааг төвөггүйхэн харж болно. Харин ХБНГУ-ын хувьд үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрх үүсэх асуудлын талаар дараах байдлаар зохицуулсан байдаг. Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг олж авах урьдчилсан нөхцлийг ХБНГУ-ын Иргэний хуулийн 925-р зүйл болон түүнтэй холбоотойгоор хэрэглэгддэг 873-р зүйлийн дагуу тодорхойлдог<sup>7</sup>. Урьдчилсан нөхцлийн хувьд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх хэлцэл (auflassung) болон улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлага тавигдана<sup>8</sup>. 873-р зүйлд заасан хэлцлийг “өмчийн хэлцэл” гэж тайлбарлах бөгөөд 925-р зүйлд тус хэлцлийн хэлбэрийн шаардлагын талаар “холбогдох эрх бүхий байгууллагын өмнө талууд биечлэн, нэгэн зэрэг илэрхийлнэ” гэх байдлаар тусгайлан хуульчилсан байдаг<sup>9</sup>.

Харин манай улсын хувьд Иргэний хуульдаа ХБНГУ-тай адил байдлаар өмчийн хэлцлийн бие даасан байдлыг хүлээн зөвшөөрсөн эсэх нь эргэлзээ үүсгэдэг. Жишээ нь судлаач Б.Буянхишигийн хувьд “... хийсвэрлэх зарчим тусгагдсан эсэх талаар ихээхэн маргаантай байдаг ч аливаа үүрэг үүсгэхэд чиглэсэн хэлцэл, өмч шилжүүлдэг хэлцэл хоёрыг салгаж авч үзэхээр шийдсэнийг тус тусдаа байршсан өмчийн эрх зүйн заалтууд болон гэрээний зохицуулалтаас харж болно” гээд зөвхөн Франц улсын solo consensus буюу зөвшилцлийн зарчимтай харьцуулж дүгнэлт хийсэн байдаг<sup>10</sup>. Гэхдээ шилжүүлгийн зарчим (traditionsprinzip)-д суурилсан улс болгон хийсвэрлэх зарчим (abstraktionsprinzip), тусгаарлах зарчим (Trennungsprinzip)-ыг хүлээн зөвшөөрдөггүй болохыг анхаарах зайлшгүй шаардлагатай төдийгүй, өмчийн эрх зүйн зохицуулалт болон гэрээний зохицуулалт тус тусдаа байршсан байгаа нь дангаараа дүгнэлт хийхэд хангалттай биш юм.

<sup>4</sup> A.K.R.KIRALFY, THE CIVIL CODE AND THE CODE OF CIVIL PROCEDURE OF THE RSFSR 1964, A.W.SIJTHOFF-LEYDEN 46 (1966)

<sup>5</sup> O.Ioffe, *supra* note 1, at 131

<sup>6</sup> *Ibid.*

<sup>7</sup> Dieter Leibold, Bürgerliches Gesetzbuch (BGB) I Einführung und Allgemeiner Teil. 3 Aufl. Mohr Siebeck, 2013. S.69

<sup>8</sup> *Ebd.*

<sup>9</sup> *Ebd.*

<sup>10</sup> Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал I, УБ, 2012 он, 120 дахь тал.



Сонирхолтой нь манай улсын Иргэний хуулийн бүтэцтэй маш адил бүтэцтэй Гүрж улсын Иргэний хуулийн 183-р зүйл (манай улсын Иргэний хуулийн 109.2 дахь хэсэгтэй төстэй зохицуулалт. Гэхдээ үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх гэрээг бичгээр байгуулахыг шаардсан байдаг онцлогтой.), 186-р зүйл (Хөдлөх эд хөрөнгийн талаар зохицуулсан зохицуулалт бөгөөд манай улсын Иргэний хуулийн 111-р зүйлийн зохицуулалттай адил чиг үүрэгтэй. Ялгаа нь 111.2.2 дахь хэсэгтэй адил агуулгыг хуульчлаагүй онцлогтой.)-ийн талаар тухайн улсын судлаачид “ХБНГУ-ын Иргэний хуулийн зохицуулалтыг рецепц хийхдээ тухайн үеийн Гүржийн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн зөвлөх профессор Рольф Книйпер хийсвэрлэх зарчмыг рецепц хийхийг хүлээн зөвшөөрөөгүй байдаг” гээд “тиймээс жишээ нь Иргэний хуулийн 186-р зүйлийн хувьд шалтгаант хэлцэл байгуулах болон тухайн эд хөрөнгийг шилжүүлэх (traditio) гэсэн урьдчилсан нөхцлийг л шаарддаг” гэжээ.<sup>11</sup>

Харин 2002 оны Иргэний хуулийн 250-р зүйлийн зохицуулалт нь Гүрж улсын Иргэний хуулийн 485-р зүйлийн зохицуулалттай яг адил агуулгатай байгаа нь санамсаргүй тохиолдол биш бөгөөд тус улсын хувьд манай улсад хэрэгжиж байсантай адил төсөл цаг хугацааны хувьд өмнө нь хэрэгжсэнтэй холбоотойгоор манай улсын төслийн багийнхан Гүрж улсын Иргэний хуулийн зохицуулалтыг тодорхой хэмжээнд загвар болгон ашигласан байхыг үгүйсгэхгүй.

## 2.2. Шүүхийн онцлох практик

А. Улсын дээд шүүхийн 2020 оны 11 сарын 05-ны өдрийн Дугаар 00773 тогтоол (цаашид “А хэрэг” гэх)

Хэргийн агуулга:

Нэхэмжлэгч Т.М нь сонгинохайрхан дүүрэгт байрлах 1 өрөө байрны өмчлөгч болох Д.Л-тэй 2017 оны 12 сарын 04-ний өдөр тухайн 20.5 м.кв талбайтай 1 өрөө орон сууцыг 15 сая төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээг байгуулсан бөгөөд мөн өдрөө улсын бүртгэлд бүртгүүлж тухайн орон сууцны өмчлөгч болсон. Т.М болон Д.Л нар нь тухайн орон сууц нь банкны барьцаанд тавигдсан байсан тул уг барьцаанаас чөлөөлж, дараа нь тус худалдах, худалдан авах гэрээг байгуулсан.

Харин хариуцагч Ц.Э нь мөн сонгинохайрхан дүүрэгт байрлах 20.5 м.кв талбайтай тус 1 өрөө орон сууцны өмчлөгч болох Д.Л-ээс 25 сая төгрөгөөр худалдан авахаар тохиролцож улмаар 15 сая төгрөгийг бэлнээр төлж, үлдэгдэл 10 сая төгрөгийг нийт 33 сард хуваан төлөхөөр тохиролцсон байдаг. Ингэхдээ 2016 оны 03 сарын 28-ны өдөр орон сууц зээлээр худалдах, худалдан авах гэрээг байгуулсан гэж Улсын Дээд шүүхээс тогтоосон байх (хариуцагчийн тайлбар өөр байдаг боловч тогтоолын хянах хэсэгт ийм байдлаар тогтоосон байгааг анхаарах) бөгөөд Ц.Э нь 2018 оны 10-р сард Д.Л-ийн эхнэр болох М.С-рүү утасдаж одоо нийт 24 сая төгрөгийг төлж дуусгасан, үлдэгдэл 1 сая төгрөгийг байрны улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх нэрийг миний нэр дээр шилжүүлэх үед төлье гэсэн хүсэлт гаргаж улмаар энэ байдлаар тохиролцсон байна. Гэтэл нэхэмжлэгч Т.М нь өөрийн эхнэрийн хамт 2018 оны 12-р сард Ц.Э-тэй ирж уулзсан бөгөөд Д.Л-ээс байрыг худалдан авсан тул чөлөөлж өгөхийг шаардсан байна. Ц.Э ч Д.Л-ээс лизингээр худалдан авсан (лизинг гэх ойлголтод хамаарахгүй агуулгатай гэрээг байгуулсан байх боловч хариуцагч ийм байдлаар тайлбартаа онцолсон. Зээлээр худалдах, худалдан авах гэрээг ч байгуулсан гэж дүгнэх боломжгүй) гээд орон сууцыг чөлөөлж өгөхгүй гэжээ.

Хариуцагч Ц.Э-д Д.Л нь орон сууцны улсын бүртгэл дээрх нэрийг 2016 оны 06 сар гэхэд шилжүүлнэ гэж хэлж байсан бөгөөд Ц.Э нь байр банкны барьцаанд тавигдсан байсан тул анх гэрээг байгуулах үед улсын бүртгэлд бүртгүүлэх боломжгүй байсан гэж тайлбарласан. Мөн Т.М нь Д.Л-д мөнгө зээлдүүлж улмаар зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор тус байрыг барьцаалж улсын бүртгэлд бүртгүүлсэн болохыг хариуцагч Ц.Э нь 2017 оны 01-р сарын 20-ны өдөр анх мэдсэн гэж тайлбарласан байдаг.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн агуулга:

Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 92 дугаар зүйлийн 92.1-д заасныг баримтлан нэхэмжлэгч Т.М-ийн холбогдох Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ... хаягт

<sup>11</sup> Giorgi Rusiashvili, *The principle of separation in Georgian Civil Code*, GEORGIAN AND GERMAN COMPARATIVE LAW JOURNAL 20 (2019)

байршилтай 20.5 м.кв талбайтай 1 өрөө орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн улсын ... дугаартай үл хөдлөх эд хөрөнгийг хариуцагч Ц.Э-ын хууль бус эзэмшлээс чөлөөлүүлэх тухай нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүхийн магадлалын агуулга:

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн.

Улсын дээд шүүхийн тогтоолын агуулга:

Д.Л нь нэхэмжлэгч Т.М-тэй 2017 оны 12-р сарын 04-ний өдөр тухайн орон сууцны талаар худалдах, худалдан авах гэрээ байгуулж, хариуцагч Ц.Э-тэй 2016 оны 03 сарын 28-ны өдөр орон сууц зээлээр худалдах, худалдан авах гэрээг тус тус байгуулсан байна. Өөрөөр хэлбэл Д.Л нь нэхэмжлэгч Т.М болон хариуцагч Ц.Э нартай үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг давхар байгуулжээ. Иргэний хуулийн 250 дугаар зүйлийн 250.1 дэх хэсэгт “Худалдагч нэг эд хөрөнгийг хэд хэдэн этгээдэд худалдсан бол уг эд хөрөнгийг хамгийн түрүүнд эзэмшилдээ авсан худалдан авагч, хэрэв эд хөрөнгө хэний ч эзэмшилд шилжээгүй байвал түрүүлж гэрээ хийсэн этгээд эзэмшилдээ шилжүүлэн авах давуу эрхтэй” гэж заасны дагуу хариуцагч Ц.Э орон сууцыг эзэмшилдээ байлгах давуу эрхтэй юм.

Анхан шатны шүүх хэргийн нөхцөл байдлын талаар үндэслэл бүхий дүгнэлт хийж Т.М- нэхэмжлэлийг хангах үндэслэл тогтоогдоогүй гэж дүгнэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 92, 106 зүйлийн холбогдох заалтыг зөв тайлбарлан хэрэглэжээ. Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

Б. Улсын дээд шүүхийн 2022 оны 04 сарын 28-ны өдрийн Дугаар 00542 тогтоол (цаашид “Б хэрэг” гэх)

Хэргийн агуулга:

Нэхэмжлэгч Ж.Э нь төрийн албанд ажилладаг бөгөөд тухайн байгууллагаас ажилчиддаа олгосон байрны квотод багтаж улмаар нийслэлийн өмчийн харилцааны газраас захиалан “И М” ХХК-иар гүйцэтгүүлж бариулахаар болсон байрнаас 79,97 м.кв 3 өрөө орон сууцыг худалдан авахаар болж барилгыг бариулах захиалагч талын дэргэд барилгын төсөл хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий “Б Б” НҮТББ байгуулагдсан тул уг байгууллагатай 2015 оны 03 сарын 11-ний өдөр орон сууц захиалах, захиалгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.

Улмаар “И М” ХХК нь 2019 оны 1-р сард барилгыг ашиглалтад оруулж, улсын комисст хүлээлгэн өгөх үед нэхэмжлэгч Ж.Э нь орон сууцны үнэд 40,461,030 төгрөг төлсөн ба улмаар “Б Б” НҮТББ-аас “И М” ХХК-д хүргүүлсэн албан бичгийн дагуу тус компанитай орон сууц худалдах, худалдан авах гэрээг байгуулж, үлдэгдэл төлбөрийг банкны орон сууцны зээлд хамрагдан төлөхөөр тохиролцсон.

Харин “Б Б” НҮТББ нь тухайн орон сууцны хувьд гуравдагч этгээд Б.Э-тэй 2016 оны 06 сарын 13-ны өдөр худалдах, худалдан авах гэрээг байгуулсан ба уг гэрээний дагуу орон сууцны үнийг төлсөн тул “Б Б” НҮТББ нь “И М” ХХК-д албан бичиг хүргүүлж улмаар “И М” ХХК нь гуравдагч этгээд Б.Э-тэй худалдах, худалдан авах гэрээг байгуулсан.

Ж.Э нь төлбөрөө хугацаандаа төлөөгүй тул “Б Б” НҮТББ нь Ж.Э-тэй байгуулсан гэрээгээ цуцлах талаар 2016 оны 05 сарын 09-ний өдөр хуралдаж шийдвэрлэсэн боловч, тус төрийн бус байгууллагын дүрмийн 12-р зүйлийн 12.1-д заасны дагуу удирдах зөвлөлийн шийдвэр болох тогтоолыг хүчин төгөлдөр байдлаар гаргах шаардлагатай байсан. “Б Б” НҮТББ нь гэрээг цуцлах тухай тогтоолыг огт гаргаагүй байдаг. Нэхэмжлэгч Ж.Э болон гуравдагч этгээд Б.Э нарын хэн аль нь уг байрыг эзэмшилдээ аваагүй.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн агуулга:

“Б Б” НҮТББ нь өмнөх этгээдтэй байгуулсан гэрээг хуульд заасан журмын дагуу цуцлаагүй үндэслэл тогтоогдож байх тул гуравдагч этгээд Б.Э-тэй байгуулсан 2016 оны 06 сарын 13-ны өдрийн Орон сууц захиалах, захиалга гүйцэтгэх гэрээ болон “И М” ХХК-тай байгуулсан гэрээнүүд хэрэгжих боломжгүйн дээр эдгээр гэрээнүүд нь Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д заасан хууль зөрчиж хийсэн ...хүчин төгөлдөр бус байх хэлцэл

байна. Өөрөөр хэлбэл Б.Э-тэй гэрээ байгуулснаар өмнөх этгээд Ж.Э-ын гэрээний дагуу үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөлдөө авах, улсын бүртгэлд бүртгүүлэх зэрэг хүсэл зоригийг зөрчжээ.

Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1, 56 дугаар зүйлийн 56.1.1, 56.5 дахь хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч Ж.Э-ын хариуцагч “Б Б” НҮТББ болон Б.Э нарын хооронд 2016 оны 06 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан орон сууц захиалах, захиалга гүйцэтгэх гэрээ, “И М” ХХК болон Б.Э нарын хооронд 2016 оны 06 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан орон сууц захиалах, захиалга гүйцэтгэх гэрээг тус тус хүчин төгөлдөр бус байх хэлцэлд тооцож, нэхэмжлэлийн шаардлагын хариуцагч “И М” ХХК, “Б Б” НҮТББ нартай байгуулсан 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн орон сууц захиалах, захиалга гүйцэтгэх гэрээгээр захиалсан орон сууцны өмчлөх эрхийн гэрчилгээг захиалагч Ж.Э-ын нэр дээр гаргуулахыг даалгах шаардлагыг, Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд Б.Э-ын Хан-Уул дүүрэгт байрлах 79.97 м.кв талбай бүхий 3 өрөө орон сууцны үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг Б.Э-ын нэр дээр гаргуулан авах, тус үл хөдлөх эд хөрөнгийг банкны барьцаанаас чөлөөлөхийг хариуцагч нарт даалгах тухай нэхэмжлэлийн шаардлагыг тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүхийн магадлалын агуулга:

Шүүх хуралдаанд Ж.Э, Б.Э нарын хэн аль нь маргааны зүйл болох орон сууцыг бодитойгоор эзэмшилдээ аваагүй гэж тайлбарлаж байх тул хуульд нийцүүлэн хэн түрүүлж гэрээ байгуулсныг харгалзан үзэх учиртай.

Гуравдагч этгээд Б.Э хэдийгээр орон сууцны үнийг бүхэлд нь төлсөн боловч уг худалдах, худалдан авах гэрээг худалдагч нь хоёр этгээдтэй байгуулсан ба нэхэмжлэгч Ж.Э нь худалдах худалдан авах гэрээг түрүүлж байгуулсан байна. Иймд Б.Э Иргэний хуулийн 250 дугаар зүйлийн 250.1 дэх хэсэгт зааснаар давуу эрхтэйгээр маргааны зүйл болох орон сууцны өмчлөх эрхийг өөрийн нэр дээр шилжүүлж авахтай холбоотой баримт бичгүүдийг гаргуулахаар шаардах эрх үүсээгүй тул уг 3 өрөө орон сууцны үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг Б.Э-ийн нэр дээр гаргуулах тухай шаардлагыг анхан шатны шүүх хэрэгсэхгүй болгосон нь зөв байна гээд улмаар анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг өөрчлөн найруулж бусад хэсгийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Улсын дээд шүүхийн тогтоолын агуулга:

Хоёр этгээдэд нэг орон сууцыг давхар худалдсан нь Иргэний хуулийн 56-р зүйлийн 56.1.1 дэх заалтад заасан “хуулиар хориглосон” гэх хэсэгт хамаарахгүй. Шүүхээс Иргэний хуулийн 250 дугаар зүйлийн 250.1-д заасан “худалдагч нэг эд хөрөнгийг хэд хэдэн этгээдэд худалдсан бол уг эд хөрөнгийг хамгийн түрүүнд эзэмшилдээ авсан худалдан авагч, хэрэв эд хөрөнгө хэний ч эзэмшилд шилжээгүй байвал түрүүлж гэрээ хийсэн этгээд эзэмшилдээ шилжүүлэн авах давуу эрхтэй” гэсний дагуу нэхэмжлэгч Ж.Э, гуравдагч этгээд Б.Э нарын аль нь давуу эрхтэй болохыг тогтоох учиртай. Хэргийн баримтаас үзэхэд Ж.Э, Б.Э нарын хэн аль нь маргааны зүйл болсон орон сууцыг эзэмшилдээ аваагүй тул түрүүлж гэрээ байгуулснаараа нэхэмжлэгч Ж.Э-д худалдан авах давуу эрх үүссэн гэж үзнэ.

Нэхэмжлэгч Ж.Э-тэй байгуулсан гэрээний 3.1-д “захиалагч нь энэхүү гэрээний 2.1, 2.2-т заасан төлбөрийг 100 хувь төлж барагдуулан гүйцэтгэгчтэй тооцоо дуусгаснаар түлхүүр хүлээн авах ба үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авах эрх үүснэ” гэж заасан байх тул Ж.Э нь үнийг бүрэн төлснөөр “И М” ХХК нь өмчлөх эрхийг шилжүүлэх, улмаар улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой бичиг баримтыг шилжүүлэх үүргийг хүлээхээр байна.

Гуравдагч этгээд Б.Э нь орон сууцыг худалдан авахаар гэрээ байгуулсан, уг гэрээ хүчин төгөлдөр, гэрээний үүргээ биелүүлж үнийг төлсөн байх хэдий ч түүнд гэрээний зүйлийг шаардах давуу эрх үүсээгүй тул түүний “ИМ” ХХК-д холбогдуулан орон сууцны өмчлөх эрхийн гэрчилгээг өөрийн нэр дээр гаргуулах, тус үл хөдлөх эд хөрөнгийг “Төрийн банк” ХХК-ийн барьцаанаас чөлөөлөхийг даалгах бие даасан шаардлагыг хэрэгсэхгүй болгох нь Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1, 250 дугаар зүйлийн 250.1-д заасантай нийцнэ, энэ талаар давж заалдах шатны шүүх зөв дүгнэжээ гээд давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

### В. Дүгнэлт

Тус хоёр хэргийг өөр хооронд нь харьцуулан үзвэл А хэргийн хувьд үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчтэй эхэлж гэрээ байгуулсан хариуцагч Ц.Э нь үл хөдлөх хөрөнгө нь банкны барьцаанд тавигдсан байсантай холбоотойгоор өөрийн өмчлөлдөө шилжүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байсан (тухайн үеийн Иргэний хуулийн зохицуулалтаас хамааралтайгаар) бол Б хэргийн хувьд түрүүлж гэрээ байгуулсан Ж.Э нь шинээр баригдаж байгаа барилгаас орон сууц худалдан авах гэрээг байгуулсан бөгөөд тодорхой урьдчилгааг төлж, үлдэгдэл төлбөрийг банкны зээлээр төлөх, төлбөрийг бүрэн төлж барагдуулснаар гэрчилгээ авах эрх нь үүсэхээр хариуцагч талтай тохиролцсон байгаа нь аль аль хэргийн хувьд түрүүлж гэрээ байгуулсан этгээдүүд нь шууд улсын бүртгэлд бүртгүүлэх боломжгүй тохиолдлууд байжээ.

А хэргийн хувьд Ц.Э-ээс цаг хугацааны хувьд хожуу гэрээ байгуулсан Т.М-ийн тайлбараар бол Ц.Э-г худалдан авсан гэж ойлгоогүй, харин орон сууцны өмчлөгч Д.Л-ийн хамаатан түр сууж байгаа гэж ойлгосон. Ц.Э нь 2016 оны 03 сарын 28-ны өдөр гэрээ байгуулсан байдаг боловч 2017 оны 01-р сарын 20-ны өдөр анх Т.М байрыг барьцаалсан болохыг мэдсэн болохоос түүнтэй худалдах, худалдан авах гэрээ давхар байгуулсан болохыг мэдээгүй байдаг. Өөрөр хэлбэл аль аль гэрээ байгуулсан этгээдүүд гэрээ байгуулах үедээ шударга (bona fide) байсан гэж дүгнэж болохоор байна.

Харин Б хэргийн хувьд худалдагч тал болох “Б Б” НҮТББ-ын хувьд нэхэмжлэгч Ж.Э нь төлбөрөө хугацаандаа төлөөгүй тул гэрээг цуцлах арга хэмжээг авахаар болсон боловч хүчин төгөлдөр тогтоол гаргаж шийдвэрээ баталгаажуулаагүйгээс гэрээг цуцлах эрх зүйн үр дагавар үүсээгүй гэж шүүхээс дүгнэсэн. “Б Б” НҮТББ нь цуцалсан учраас бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд болох Б.Э-тэй худалдах, худалдан авах гэрээг байгуулсан байдаг. Иймд аль аль талын хувьд шударга байсан гэж дүгнэж бас болох юм.

Шүүхээс Иргэний хуулийн 250-р зүйлийг хэрэглэсэн байдлыг харьцуулан үзвэл А хэргийн хувьд Ц.Э-ийн эзэмшилд орон сууцыг шилжүүлсэн байгаа боловч Улсын дээд шүүхээс 250.1 дэх хэсгийг түрүүлж гэрээ байгуулсан нь Ц.Э учраас гэх байдлаар тайлбарлан хэрэглэсэн гэж ойлгогдохоор байна. Улсын дээд шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байх боловч анхан шатны шүүхээс 106.1, 92.1 хэсгийг хэрэглэн нэхэмжлэгч Т.М-ийн 106.1-ийн дагуу гаргасан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Гэтэл 92.1 дэх хэсгийн хувьд “шударга эзэмшигч”-д хамаарах зохицуулалт бөгөөд манай улсын хувьд хууль бус эзэмшигчийг дотор нь шударга болон шударга бус гэж ангилах уу, эсвэл 92.1 дэх хэсгийг 90.3-тай хамаатуулан ойлгох болон 92.1 дэх хэсгийн шаардах эрхийг 93.1-т заасан хууль ёсны эзэмшигчид л зөвхөн зөвшөөрөх үү гэсэн онолын асуулт үүсдэг. Нөгөөтэйгүүр 92.1-д заасан “саадыг арилгуулахаар шаардах эрх” нь 106.2-т заасан эрхтэй төстэй бөгөөд аль хэдийн өмчлөх эрхийг олж авсан этгээдийн үйлдлийг үгүйсгэх үр нөлөөг үзүүлэх эсэх нь эргэлзээтэй. Шүүхээс энэ асуудлын талаар огт дүгнэлт хийгээгүй байна. Түүнчлэн Ц.Э нь өөртэй нь гэрээ байгуулсан Д.Л-ийн хувьд л хууль ёсны эзэмшигч байх боловч, гуравдагч этгээд болох Т.М-ийн хувьд хууль ёсны эзэмшигчид тооцогдохгүй. Өөрөөр хэлбэл түүний эзэмшил нь хууль бус гэж тооцогдоно. Учир нь Ц.Э-ийн эзэмшил нь худалдах, худалдан авах гэрээний дагуу үүссэн тул харьцангуй шинжтэй.

Харин Б хэргийн хувьд Улсын дээд шүүхийн зүгээс нэхэмжлэгч Ж.Э болон бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд болох Б.Э нарын хэн нь ч орон сууцыг эзэмшилдээ аваагүй гэдгийг онцлоод Иргэний хуулийн 250-р зүйлийн дагуу түрүүлж гэрээ байгуулсан Ж.Э нь эзэмшилдээ авах давуу эрхтэй гэж тайлбарласан байна. Гэвч хэрвээ “Б Б” НҮТББ болон “И М” ХХК нь Ж.Э-тэй байгуулсан гэрээгээ тус шүүхийн шийдвэр гарснаас хойш хуульд нийцүүлэн цуцалвал түүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй үлдэж байна. Өөрөөр хэлбэл 250.1 дэх хэсгийн дагуу эзэмшилдээ авах давуу эрхтэй гэдэг нь өмчлөх эрхийг шилжүүлэхийг бусад этгээдээс түрүүнд шаардах эрхтэй гэсэн утга агуулгыг илэрхийлэх үү гэдэг нь тодорхойгүй байна.

### III. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

#### 3.1. Бүгд Найрамдах Серби улс

Бүгд Найрамдах Серби улсын хувьд үл хөдлөх эд хөрөнгийн шилжүүлэгтэй холбоотой асуудлыг нэг кодификациар шийдвэрлэдэггүй онцлогтой. Тус улсын хувьд энэхүү харилцааг юун түрүүд 1980 онд батлагдаж дараа нь 2005 шинэчлэгдсэн Өмчлөх эрхийн үндсэн харилцааны тухай хууль (*Zakon o osnovama svojinskopравnih odnosa*, no.115/2005)-иар зохицуулдаг бөгөөд зохицуулалт нь 1811 оны Австрийн Иргэний хуулийн 380-р зүйлийн зохицуулалтыг рецепц хийсэн гэж тайлбарлагддаг (Өмчлөх эрхийн үндсэн харилцааны тухай хуулийн 33-р зүйл)<sup>12</sup>. Ийм учраас үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг гэрээний дагуу шилжүүлэхэд худалдагч нь өмчлөгч байх, хүчин төгөлдөр гэрээ байгуулагдсан байх, улсын бүртгэлд бүртгүүлсэн байх шаардлагатай<sup>13</sup>. Гэхдээ Австрийн Иргэний хуулийн 440-р зүйлд “Хэрвээ өмчлөгч нь нэг үл хөдлөх эд хөрөнгийг хоёр өөр этгээдэд өгөхөөр болсон бол энэ нь тэдгээрийн хэн түрүүлж бүртгэл хийлгэсэнд очно” гэж заасан байх бөгөөд үүнтэй адил агуулгатай зохицуулалт Сербийн хууль тогтоомжид тусгагдаагүй аж<sup>14</sup>.

Харин Өмчлөх эрхийн үндсэн харилцааны тухай хуулийн 35-р зүйлд хөдлөх эд хөрөнгийн хувьд хэд хэдэн этгээдтэй гэрээ байгуулсан бол түрүүлж эзэмшлийг шилжүүлж авсан этгээд нь өмчлөх эрхийг олж авахаар зохицуулжээ<sup>15</sup>. Тус зохицуулалтын талаарх судлаачдын тайлбарт эзэмшлийг олж авсан этгээд нь шударга байх ёстой буюу өмнө өөр этгээдтэй гэрээ байгуулсан болохыг мэдээгүй байх шаардлагатай гэж үзсэн байдаг онцлогтой<sup>16</sup>.

Харин үл хөдлөх эд хөрөнгийг хэд хэдэн этгээдэд давхар худалдсан тохиолдолд 1987 онд гарсан шүүхийн жишиг одоо ч шүүхийн практикт *de facto* нөлөөтэй болохыг судлаачид дурджээ<sup>17</sup>. Тус шүүхийн жишгээр бол “Хэрвээ нэг болон адил үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг олж авах зорилгоор хэд хэдэн субъект тодорхой хэлцэл байгуулсан бол шүүхээс хэн давуу эрхтэй эсэхийг шийдвэрлэхдээ социалист ёс суртахуун, автономит нийгэм, шударга байдал, үнэнч байдал, хуулийг буруу хэрэглэх явдлыг хориглох зарчим зэргийг удирдлага болгон шийдвэрлэнэ. Бүх худалдан авагч нар шударга байсан бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийг хэнийх нь ч эзэмшилд шилжүүлээгүй бол, мөн хэн нь ч улсын бүртгэлд бүртгэл хийлгээгүй байгаа бол, давуу эрхийг эхэлж гэрээ байгуулсан этгээдэд олгоно. Бүх худалдан авагч нар шударга байсан бол давуу эрхийг бүртгэлд бүртгүүлсэн этгээдэд олгоно. Харин хэн нь ч бүртгүүлээгүй бол эзэмшлийг олж авсан этгээдэд давуу эрхийг олгоно.” гэх байдлаар шийдвэрлэдэг бөгөөд судлаачдын үзэж байгаагаар худалдан авагч нь үл хөдлөх эд хөрөнгийг хэний нэр дээр бүртгэгдсэн болох, эзэмшил нь одоо хэнд байгаа болохыг шалгах шаардлагатай ба өмнө хэн нэгэн гэрээ байгуулсан болохыг мэдэж байсан бол түрүүлж гэрээ байгуулсан шударга этгээдтэй харьцуулахад сул эрхтэй болно гэсэн үг. Энэ нь улсын бүртгэлд бүртгэгдсэнээр үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилждэг зарчмыг бодит байдал дээр шууд өөрчилсөнтэй ялгаагүй практик болж түрүүнд гэрээ байгуулсан этгээд нь ямар ч тохиолдолд шударга гэж тооцогдох сонирхолтой шийдэлд хүргэнэ гэжээ<sup>18</sup>.

Харин Сербийн “Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх тухай хууль (*Zakon o prometu nepokretnosti*, 6/2015)”-д 2009 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр шинээр хуульчлагдсан 4а зүйлээр тухайн үл хөдлөх эд хөрөнгийн оршин байгаа газрыг харьяалах шүүхээр үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх гэрээг баталгаажуулахыг худалдагчид үүрэг болгосон байдаг. Улмаар нэг этгээд өөрийн үл хөдлөх эд хөрөнгийг өөр этгээдэд дахин худалдахаар гэрээ байгуулахыг шүүхээс хориглох үр дагавар үүсэх бөгөөд хэрвээ шүүхээр

<sup>12</sup> Milos Zivkovic, *Acquisition of ownership of real property by contract in Serbian law – departing from the titulus-modus system?*, ANNALS BLR, 119 (2015)

<sup>13</sup> *Ibid.*

<sup>14</sup> [www.ris.bka.gov.at](http://www.ris.bka.gov.at) [Сүүлд үзсэн: 2022.11.11]

<sup>15</sup> [www.mpravde.gov.rs](http://www.mpravde.gov.rs) [Сүүлд үзсэн: 2022.11.11]

<sup>16</sup> Milos Zivkovic, *supra* note 12, at 121

<sup>17</sup> *Ibid.*

<sup>18</sup> Milos Zivkovic, *supra* note 12, at 122



баталгаажуулалт хийлгээгүй бол тухайн гэрээг хүчин төгөлдөр бус гэж шийдвэрлэдэг байсан байна<sup>19</sup>.

Тус зохицуулалт нь өмчлөгчийн эрхийг хязгаарласан агуулгатай байсан тул 2014 онд тус зохицуулалтыг дараах байдлаар өөрчилжээ.

#### 4b дугаар зүйл

Нотариатч нь үл хөдлөх эд хөрөнгийн талаар байгуулагдсан гэрээний талаарх тусгай бүртгэлийг шалгах зорилгоор үл хөдлөх эд хөрөнгийн талаар байгуулсан гэрээний гарын үсэг нь шүүхэд өмнө нь бүртгэгдсэн эсэх, нотариатын байгууллага болон шүүхэд үл хөдлөх эд хөрөнгийг худалдах гэрээ байгуулсан талаар нотариатын үйлчилгээ авсан талаарх бүртгэл өмнө нь хийгдсэн эсэх, үл хөдлөх эд хөрөнгийг худалдах гэрээг өмнө нь нотариатч ёсчилсон эсэх болон худалдагч нь нэг этгээд эсэхийг тус тус тогтоож, гэрээний талуудад энэ талаар анхааруулах, нотариатын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн дагуу анхааруулгад хамруулах, хэрвээ гэрээний талууд тус анхааруулгад хамрагдахыг хүлээн зөвшөөрсөн бол нотариатч нь тэдний нотариатын үйл ажиллагааг авах хүсэлтээс татгалзана.

Эндээс үзвэл Серби улсын хувьд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой асуудлыг үүргийн эрх зүйн тухай хуулиасаа тусдаа нарийвчилсан зохицуулалттай хуулиар шийдвэрлэдэг байх бөгөөд шүүхийн жишигт давамгайл ашиглагддаг үзэл баримтлал нь манай улсын Иргэний хуулийн 250-р зүйл болон өмнө дурдсан хоёр шүүхийн шийдвэрийн агуулгатай ихээхэн төстэй байна. Манай улсын хувьд шүүхийн шийдвэрүүдэд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх гэрээг нотариатаар гэрчлүүлэх эсэх, гэрчлүүлээгүй бол хүчин төгөлдөр бус гэж дүгнэх эсэх дээр харилцан адилгүй шийдвэр гаргадаг бөгөөд Серби улсын хувьд нотариатч нь үл хөдлөх эд хөрөнгийг давхар худалдах тохиолдлоос урьдчилан сэргийлэх чиг үүргийг гүйцэтгэдэг онцлогтой нь манай улсын хувьд ч анхаарч үзэх практик гэж хэлж болно.

#### 3.2. Гүрж улс

Гүрж улсын хувьд өмнө дурдсанчлан манай улсын 2002 оны Иргэний хуулийг батлах үед хэрэгжиж байсан төсөлтэй адил төслийн дагуу өөрийн орны Иргэний хуулийг боловсруулан баталсан байх бөгөөд манай улсын тухайн үеийн ажлын хэсгийнхэн Гүрж улсын Иргэний хуулийн зохицуулалтыг өргөн хүрээнд загвар болгон ашигласан байдаг. Тийм ч учраас Гүрж улсын Иргэний хуулийн 485-р зүйлтэй яг адил агуулга, найруулга бүхий зохицуулалт манай улсын Иргэний хуулийн 250-р зүйлд хуульчлагджээ. Тиймээс тус улсын хувьд энэхүү 485-р зүйлийн зохицуулалтыг хэрхэн хэрэглэж байгаа болох хэрхэн тайлбарлаж байгаа талаар судлах нь манай улсын хувьд маш чухал ач холбогдолтой юм.

Гүрж улсын хувьд “Гүржийн залуу хуульчдын холбоо (GYLA)” гэх байгууллага байдаг бөгөөд энэхүү холбооноос 2020 оны 03 сарын 31-ний өдөр Иргэний хуулийн 485-р зүйлийг хэрэглэсэн шүүхийн шийдвэртэй холбоотойгоор Тбилис хотын давж заалдах шатны шүүхэд өөрсдийн саналыг хүргүүлсэн байна<sup>20</sup>. Энэхүү маргаан нь нэг үл хөдлөх эд хөрөнгийг хэд хэдэн этгээдэд худалдсан тохиолдол бөгөөд зохигчид хэн нь үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч эсэхийг шүүхээр шийдүүлэхээр хандсан байдаг. Тбилис хотын давж заалдах шатны шүүхээс Иргэний хуулийн 485-р зүйлийг хэрэглэж хэргийг шийдвэрлэсэн ба хариуцагч нь улсын бүртгэлд бүртгэгдсэн байсан ч нэхэмжлэгчийг тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчөөр тогтоож шийдвэрлэсэн байна. Гүржийн залуу хуульчдын холбооноос Иргэний хуулийн 485-р зүйл нь тухайн зохицуулалтыг үгчлэн тайлбарлавал хөдлөх эд хөрөнгийн хувьд үйлчилнэ гээд системчилсэн тайлбарын хувьд бол Иргэний хуулийн 158-р зүйлд “Эд хөрөнгийн эзэмшигч нь тухайн эд хөрөнгийн өмчлөгч гэж тооцогдоно” гэж, 186-р зүйлд “Хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэхэд хүчин төгөлдөр эрхийн дагуу өмчлөгч нь тухайн хөдлөх эд хөрөнгийн эзэмшлийг өмчлөх эрхийг олж авч байгаа этгээдэд шилжүүлсэн байх шаардлагатай” гэж хуульчилсан байгаатай шууд холбоотойгоор тайлбарлах боломжтой байна. Үл хөдлөх эд хөрөнгийн хувьд улсын бүртгэлд

<sup>19</sup> Milos Zivkovic, *supra* note 12, at 124

<sup>20</sup> www.gyla.ge [Сүүлд үзсэн: 2022.11.09]



бүртгүүлсэн байх шаардлагатай тул 485-р зүйлийг хэрэглэх боломжгүй. Харин шүүхээс тус зохицуулалтыг шууд эсхүл төсөөтэй хэрэглэх замаар үл хөдлөх эд хөрөнгийн хувьд ч хэрэглэж болно гэж үзжээ. Үл хөдлөх эд хөрөнгийн хувьд улсын бүртгэлд бүртгэгдсэн этгээд л өмчлөх эрхийг олж авна гэсэн саналыг хүргүүлсэн байна<sup>21</sup>.

Өмнө дурдсанчлан Гүрж улсын хувьд хийсвэрлэх зарчмыг хуулийн төслийг боловсруулахдаа нэвтрүүлэхээс татгалзсан бөгөөд харин тусгаарлах зарчмыг хэрэгжүүлдэг эсэх дээр харилцан адилгүй байр суурийг судлаачид нь илэрхийлдэг<sup>22</sup>. Тийм ч учраас *traditio* буюу шилжүүлгийн загварыг ашигласан гэж судлаачид нь дүгнэдэг бөгөөд хуулийн зохицуулалтыг дүгнэн үзвэл тусгаарлах зарчмыг рецепц хийсэн эсхүл өмчийн хэлцлийн бие даасан байдлыг хүлээн зөвшөөрөх ямар ч боломжгүй гэж тайлбарлах нь түгээмэл<sup>23</sup>. Тийм учраас тус улсын хувьд улсын бүртгэлд бүртгэгдэж байж л үл хөдлөх эд хөрөнгийн хувьд өмчлөгч болох боломжтой байна. Хөдлөх эд хөрөнгийн хувьд харин эзэмшилдээ шилжүүлснээр өмчлөх эрх шилжих тул 485-р зүйлийг хэрэглэсэн ч ерөнхий ангийн зохицуулалттай зөрчилдөөн үүсгэхгүй байх боломжтой гэж болох юм. Гэвч хэнд ч эзэмшлийг шилжүүлээгүй бол түрүүлж гэрээ байгуулсан тал нь хөдлөх эд хөрөнгийн хувьд эзэмшлийг өөртөө шилжүүлэх давуу эрхтэй болсноор яг ямар эрх зүйн үр дагавар үүсэх эсэх нь тайлбарын хувьд тодорхойгүй хэвээр байгаа гэж хэлж болох юм.

## ДҮГНЭЛТ

Тус өгүүллийн эхэнд дурдсанчлан энэхүү судалгааны хувьд зөвхөн Иргэний хуулийн 250-р зүйлийг үл хөдлөх эд хөрөнгийг хэд хэдэн этгээдэд худалдсан тохиолдолд хэрэглэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх, одоогийн Иргэний хуулийн зохицуулалтыг түүхчилсэн байдлаар судалж, дараагаар нь манай улстай адил зохицуулалт, эсхүл шүүхийн практик, жишиг бүхий улс орнуудтай харьцуулан судлах замаар дүгнэлт хийхийг зорьсон. Өмчлөх эрхийг шилжүүлэхэд холбогдох ерөнхий асуудлын талаар дараа дараачийн судалгаагаар тодруулахаар төлөвлөж байна.

Юун түрүүнд түүхчилсэн судалгааны явцад манай улсын хувьд Францын зөвшилцлийн загварыг ЗХУ-ын хуулийг рецепц хийх замаар шууд бус байдлаар хүлээн авсан байх бол 1963 оны Иргэний хуулийг батлахдаа мөн л ЗХУ дахь онолын тайлбар өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Германы шилжүүлгийн загварыг хүлээж авсан болохыг тодорхойлсон. Гэвч тухайн үед орон сууц гэх мэт үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг иргэдэд олгоогүй байсантай холбоотойгоор одоогийнх шиг нөхцөл байдал үүсээгүй байсныг анхаарч үзэх шаардлагатай.

Харин дараагаар нь одоогийн Иргэний хуулийн 250-р зүйлийн зохицуулалт нь Гүрж улсын Иргэний хуулийн 485-р зүйл, Серби улсын хувьд мөрдөж байсан хуучин Югославын үеийн шүүхийн жишигтэй адил байгааг тодорхойллоо.

Манай улсын шүүхийн практикт шийдвэрлэгдсэн онцлох хоёр хэргийн хувьд аль аль нь түрүүлж гэрээ байгуулсан этгээд нь шууд улсын бүртгэлд бүртгүүлэх боломжгүй тохиолдол байсан бөгөөд аль аль этгээдүүдийн хувьд шударга байсан гэж дүгнэх боломжтой тохиолдол байлаа. Улсын дээд шүүхийн зүгээс түрүүлж гэрээ байгуулсан этгээд нь эзэмшилдээ авах давуу эрхтэй гэх байдлаар шийдвэрлэсэн байх боловч тухайн давуу эрхийг олгосноор яг ямар эрх зүйн үр дагавар үүсэх эсэх талаар тодорхой дүгнэлт хийсэнгүй. Хэрвээ давуу эрхийг олж авсан этгээд нь худалдагчаас өмчлөх эрхийг шилжүүлэхийг бусдаас тэргүүн ээлжинд шаардах эрхтэй гэж дүгнэх болвол өмчлөх эрхийг түрүүлж гэрээ байгуулсан этгээдэд олгосонтой ялгаагүй үр дагаварт хүрэх болно. Энэ нь манай улсын хувьд *traditio* буюу шилжүүлгийн загварыг ашигласан хэдий ч зөвшилцлийн загвард суурилсантай ялгаагүй нөхцөл байдлыг үүсгэнэ. Зарим улсын хувьд худалдах, худалдах авах гэрээг сүүлд байгуулсан худалдан авагч нь өөрөө эхний худалдах, худалдан авах гэрээний талаар мэдсэн тохиолдолд түрүүлж гэрээ хийсэн этгээдийг хамгаалахыг санал болгох нь бий. Гэвч Серби улсын жишгээс үзвэл ямагт түрүүлж гэрээ байгуулсан этгээд нь шударга гэж тооцогдох

<sup>21</sup> Мөн тэнд

<sup>22</sup> Giorgi Rusiashvili, *supra* note 11, at 21

<sup>23</sup> Giorgi Rusiashvili, *supra* note 11, at 22

болно.

Нөгөөтэйгүүр манай улстай яг адил зохицуулалт бүхий Гүрж улсын Иргэний хуулийн 485-р зүйлийн хувьд зөвхөн хөдлөх эд хөрөнгийн хувьд л хэрэглэгдэх боломжтой зохицуулалт гэх байдлаар тайлбарлах явдал хүчтэй дэвшигдэж байгааг зайлшгүй онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Иймд манай улсын хувьд хэн түрүүлж бүртгэлд бүртгүүлсэн нь үл хөдлөх эд хөрөнгийн хувьд өмчлөх эрхийг олж авах боловч түрүүлж худалдах, худалдан авах гэрээ байгуулсан этгээдийн худалдагчаас өмчлөх эрхийг шилжүүлэхийг шаардах эрхийг тухайн түрүүлж бүртгэлд бүртгүүлсэн этгээд (цаг хугацааны хувьд дараа нь гэрээ байгуулсан этгээд) зөрчсөн тохиолдолд гэм хор учруулснаас үүсэх үүргийн эрх зүйн хүрээнд хохирол нөхөн төлөхийг шаардах байдлаар шийдвэрлэх боломжтой эсэхийг судлах зайлшгүй шаардлага үүснэ. Манай улсын сурах бичгүүдэд 497-р зүйлийн 497.1 дэх хэсгийн “бусдын эрх” гэх нөхцлийг ХБНГУ-ын тайлбартай адил байдлаар “497 нь өмчлөх эрх зэрэг бүх хүн анхаарвал зохих туйлын эрхийг хамгаалах тул “бусад эрх” нь мөн ийм туйлын шинжтэй байх ёстой. Үгүй бол энэхүү зохицуулалтын зорилгод үл нийцнэ” гэж тайлбарлах нь бий<sup>24</sup>. Гэвч ХБНГУ-ын Иргэний хууль дахь гэм хор учруулснаас үүсэх үүргийн эрх зүйн зохицуулалт нь 823.1, 823.2, 826-р зүйлийг хамтад нь ерөнхий зохицуулалт гэж дүгнэдэг тул зөвхөн 823.1 дэх хэсгийн талаарх онолын тайлбарыг 497.1 дэх хэсгийг тайлбарлахад хэрэглэх нь зохимжгүй. Иймд түрүүлж гэрээ байгуулсан этгээдийн шаардах эрхийг санаатайгаар зөрчсөн тохиолдолд тодорхой шалгуурыг үндэслэн дараа нь гэрээ байгуулсан боловч улсын бүртгэлд бүртгүүлж өмчлөх эрхийг олж авсан этгээдээс хохирлоо шаардах боломжийг олгох нь зохистой биз ээ.

#### ЭХ СУРВАЛЖ

1. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ, 2010 он,
2. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал I, УБ, 2012 он,
3. Улсын дээд шүүхийн 2020 оны 11 сарын 05-ны өдрийн Дугаар 00773 тогтоол
4. Улсын дээд шүүхийн 2022 оны 04 сарын 28-ны өдрийн Дугаар 00542 тогтоол
5. OLIMPIAD S.IOFFE, SOVIET CIVIL LAW, MARTINUS NIJHOFF PUBLISHERS (1988)
6. A.K.R.KIRALFY, THE CIVIL CODE AND THE CODE OF CIVIL PROCEDURE OF THE RSFSR 1964, A.W.SIJTHOFF-LEYDEN (1966)
7. Dieter Leipold, Bürgerliches Gesetzbuch (BGB) I Einführung und Allgemeiner Teil. 3 Aufl. Mohr Siebeck, 2013
8. Giorgi Rusiashvili, The principle of separation in Georgian Civil Code, GEORGIAN AND GERMAN COMPARATIVE LAW JOURNAL (2019)
9. Milos Zivkovic, *Acquisition of ownership of real property by contract in Serbian law – departing from the titulus-modus system?*, ANNALS BLR, (2015)
10. [www.ris.bka.gv.at](http://www.ris.bka.gv.at)
11. [www.gyla.ge](http://www.gyla.ge)
12. [www.mpravde.gov.rs](http://www.mpravde.gov.rs)

<sup>24</sup> Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ, 2010 он, 340 дэх тал.

## **REFLECTIONS ON DOUBLE SALE OF IMMOVABLE PROPERTY: COURTS AND COMPARISONS**

*Purevbaatar R. /LL.M./  
Lecturer of Private Law Department, School of Law, NUM*

### **ABSTRACT:**

In this article the author aims to clarify the historical background of the regulations of double sale of immovable property in Civil code of Mongolia, then analyses landmark court decisions in that respect, and explores perspectives of two countries (Serbia and Georgia) which are strongly connected to the regulations of the Civil code of Mongolia. Finally, the author expresses his own opinion on how to interpret article 250 of the Civil code of Mongolia and how to balance rights and interests of earlier buyers and subsequent buyers.

### **KEYWORDS:**

System of consensus, System of traditio, Right of ownership

## МОНГОЛ УЛС БА ХБНГУ, ЯПОН УЛС, ТАЙВАНЬ ОРНЫ НАСАНД ХҮРСЭН ЭТГЭЭДИЙН АСРАН ХАМГААЛАХ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



*Б.Бөхөө  
МУИС-ийн ХЗС-ийн докторант*

### ТОВЧЛОЛ:

Монгол Улсын асран хамгаалах, харгалзан дэмжих харилцааг 2002 оны Иргэний хууль ба 1999 оны Гэр бүлийн хуулиар зохицуулсаар ирсэн ба өнөөг хүртэл Гэр бүлийн тухай хууль дахь насанд хүрсэн этгээдийн асран хамгаалах, харгалзан дэмжих зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. Монгол Улсад асран хамгаалах, харгалзан дэмжих ухаагдахуун, хүсэл зоригийг хэрхэн тодорхойлох, асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллага, хяналтын байгууллагыг хэрхэн тогтоох, хяналтыг хэрхэн чангатгах зэрэг тулгамдсан асуудал оршиж байна. Эх газрын эрх зүйн системийн оронд насанд хүрсэн этгээдийн асран хамгаалах, харгалзан дэмжих тогтолцоог ойрын жилүүдэд шинэчлэн өөрчлөв. Үүнд эх газрын эрх зүйн системийн ХБНГУ, Япон Улс, Тайвань улсын насанд хүрсэн этгээдийн асран хамгаалах, харгалзан дэмжих тогтолцоог харьцуулсан судалгаа хийгдээгүй байх ба цаашид судлах шаардлагатай гэж үзэж байна. Тус өгүүлэлд Эх газрын эрх зүйн гурван оронтой харьцуулан судалж, Монгол Улсын насанд хүрсэн этгээдийн асран хамгаалах, харгалзан дэмжих зохицуулалтыг боловсруулах санал дэвшүүлэв.

### ТҮЛХҮҮР ҮГС:

Насанд хүрсэн этгээд, Асран хамгаалах, Харгалзан дэмжих, Хяналт

### I. УДИРТГАЛ

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд 1999 оноос өнөөг хүртэл нэмэлт өөрчлөлт орлуулаагүй байна. Насанд хүрсэн этгээдийн асран хамгаалах, харгалзан дэмжих тухайн судалгаа мөн ч хангалтгүй түвшинд байгаа. Тухайлбал, насанд хүрсэн этгээдийн асран хамгаалах, харгалзан дэмжих сэдвээр судалгаа хийсэн бүтээл, эрдэм шинжилгээний ажил олдсонгүй<sup>1</sup>. Гагцхүү судлаач А.Дугармаа өөрийн бүтээлүүддээ ОХУ-ын асран хамгаалах,

<sup>1</sup> Т.Мөнхжаргал, *Гэр бүлийн эрх зүй*, УБ., 1995 он, 53- 54 дэх тал; Т.Мөнхжаргал, *Монгол улсын иргэний эрх зүй (Ерөнхий анги)*, УБ., 2000 он, 81-82 дахь тал; А.Дугармаа, *Монгол улсын гэр бүлийн эрх зүй*, УБ., 2005 он, 98- 99 дэх тал; Ч.Отгонбаяр, *Гэр бүлийн эрх зүй*, УБ., 2006 он, 74-75 дахь тал; А.Дугармаа, *Монгол улсын гэр бүлийн эрх зүй: Онол, бодлого, сорил, нэр томъёо*, УБ., 2016 он, 146-147 дахь тал.

<https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-search.pl?idx>. [Сүүлд үзсэн: 2022.09.28]

<http://122.201.23.45/cgi-bin/koha/opac-search.pl?idx=ti%2Cphr%2Ckw&q>. [Сүүлд үзсэн: 2022.09.28]

харгалзан дэмжих зохицуулалтыг танилцуулж, ОХУ-ын зохицуулалтууд нь агуулгын хувьд Монгол улстай бараг адил тухай, түүнчлэн Франц улсад гэр бүлийн зөвлөл, ХБНГУ болон Швейцар улсад асран хамгаалах хэрэг хянан шийдвэрлэх шүүх, Англи, АНУ-д шүүх нь асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллага болох ба хяналтын үүрэг гүйцэтгэж байх тухай дурджээ.<sup>2</sup> Ийнхүү Монгол Улсад Насанд хүрсэн этгээдийн асран хамгаалах, харгалзан дэмжих тогтолцоог гадаад улс оронтой харьцуулан судалгаа одоогийн байдлаар хийгдээгүй байна. Монгол Улс бол Эх газрын эрх зүйн системийн оронд харьяалагдах тул ХБНГУ, Япон Улс, Тайвань орны насанд хүрсэн этгээдийн асран хамгаалах, харгалзан дэмжих тогтолцоог Монгол Улстай харьцуулсан судалгаа хийх шаардлагатай гэж үзэж байна. Энэхүү харьцуулсан судалгааны суурин дээр Монгол Улсын насанд хүрсэн этгээдийн асран хамгаалах, харгалзан дэмжих талаарх тулгамдсан асуудал, сул талд хандуулан боловсруулах санал дэвшүүлнэ. Үүнд асран хамгаалах, харгалзан дэмжих ухаагдахууныг хүсэл зоригор тодорхойлох, гэр бүлийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх шүүхээр асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллага, хяналтын байгууллага зэргийг дагнуулах, эд хөрөнгийн бус ба эд хөрөнгийн хэргийг шийдэхдээ шүүхээс урьдчилан зөвшөөрөл авах, хяналт тавих этгээдийг оруулан хянуулах зэрэг санал багтана.

## II. МОНГОЛ УЛСЫН НАСАНД ХҮРСЭН ЭТГЭЭДИЙН АСРАН ХАМГААЛАХ, ХАРГАЛЗАН ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Арсан хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдсон харилцааг гэр бүл, иргэн, захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж байдаг учраас дээрх салбар эрх зүйн иж бүрдэл шинжийг агуулсан эрх зүйн институт гэж үзэж болно.<sup>3</sup>

### 2.1. 2002 оны Иргэний хууль

**Эрх зүйн чадамжгүй иргэнд тооцох ба түүний үр дагавар.** Монгол Улсын Иргэний хуулийн §18.2-т сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй этгээдийг эрх зүйн чадамжгүйд тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно. §18.3-т иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч хэлцэл хийнэ. Тухайн хүн эрх зүйн чадамжгүй тул өөрөө хийсэн хэлцэл нь хүчин төгөлдөр бус байдаг.

**Эрх зүйн чадамжийг хязгаарлах ба түүний үр дагавар.** Иргэний хуулийн §19.1-д сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэж, гэр бүлээ эдийн засгийн талаар хүнд байдалд оруулсан насанд хүрсэн этгээдийг холбогдох этгээдийн хүсэлтээр, шүүх хуулиар тогтоосон журмаар хязгаарлаж, харгалзан дэмжигч томилно. Иргэний хуулийн 19.2-т харгалзан дэмжихийн үр дагавар нь харгалзан дэмжлэгт буй этгээд хязгаарлагдаагүй хүрээнд харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр хэлцэл хийнэ.

### 2.2. 1999 оны Гэр бүлийн тухай хууль

**Асран хамгаалалтад байх этгээд.** Дөрвөн төрөл байдаг: ГБТХ-ийн §63.1.1. бага насны /14 нас хүрээгүй/ бүтэн өнчин хүүхэд; §63.1.2.эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний бага насны хүүхэд; §63.1.3. эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний бага насны хүүхэд; §63.1.4.сэтгэцийн өвчний улмаас шүүхээс иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон хүн.

*Засаг заргын захирамжаар асран хамгаалагч тогтоосон жишээ:<sup>4</sup>*

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 9-р хороонд оршин суух Ц нь 2005 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр нас нөгчиж, түүний хүү 3 сартай Т бүтэн өнчин үлдсэн тул эмэг эх 50 настай Р нь өөрийгөө хүүгийн асран хамгаалагчаар тогтоолгохоор хүсэлт гаргажээ. Хүсэлтийг хүлээн авсан Сүхбаатар дүүргийн Засаг дарга нас барсан Ц нь гэрлэж байгаагүй, түүний хүү Т-г асарч хамгаалах өөр хүнгүй, эмэг эх нь хүүг асран хамгаалах бүрэн боломжтой

<sup>2</sup> А.Дугармаа, *Монгол улсын гэр бүлийн эрх зүй*, УБ., 2005 он, 104 дэх тал.

<sup>3</sup> А.Дугармаа, *Монгол улсын гэр бүлийн эрх зүй*, УБ., 2005 он, 98 дахь тал.

<sup>4</sup> А.Дугармаа, *Монгол улсын гэр бүлийн эрх зүй*, УБ., 2005 он, 99 дэх тал.

хүн гэдгийг шалган, Т-гийн асран хамгаалагчаар Р-ийг тогтоож захирамж гаргасан байна.

**Харгалзан дэмжвэл зохих хүн.** ГБТХ-ийн §64.1-д таван төрлийн этгээдийг харгалзан дэмжих тухай тогтоосон. Үүнд: §64.1.1.насанд хүрээгүй /14-өөс 18 хүртэлх насны/ бүтэн өнчин хүүхэд; §64.1.2.эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний насанд хүрээгүй хүүхэд; §64.1.3.эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа буюу хорих газарт ял эдэлж байгаа зэрэг аргагүй шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний насанд хүрээгүй хүүхэд; §64.1.4.согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэсний улмаас иргэний эрх зүйн эрхийн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүн; §64.1.5.эрүүл мэндийн байдал болон өндөр настай болсны улмаас иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон хүн.

*Засаг даргын захирамжаар харгалзан дэмжигч тогтоосон жишээ:<sup>5</sup>*

Нийслэлийн БГД-ийн 1-р хороонд оршин суудаг, эдийн засагч мэргэжилтэй, нягтлан бодогч ажилтай байсан, 48 настай Э нь сэтгэц мэдрэлийн шизофрения өвчтэй. Түүний харгалзан дэмжигчээр Э-гийн төрсөн дүү 36 настай Б-г тогтоож, БГД-ийн Засаг дарга захирамж гаргахдаа Гэр бүлийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.5 дахь заалтыг үндэслэсэн нь Э-г эрүүл мэндийн улмаас иргэний эрх, үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон хүн буюу харгалзан дэмжлэгт байх хүн гэж үзсэнтэй тохирч байна.

**Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилх.** ГБТХ-ийн §67.1-д асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг дор дурдсан журмаар тогтооно: §67.1.1.эд хөрөнгийн зохих бололцоотой төрөл, садан буюу төрөл, садан бус хүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг нь үндэслэн сум, дүүргийн Засаг дарга асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоох; §67.1.2.асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдоогүй бол хүүхдийг нас, эрүүл мэндийн байдлыг нь харгалзан хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх; §67.1.3.харгалзан дэмжигч тогтоогдоогүй бол өндөр настан, тахир дутуу хүнийг асрамжийн газарт шилжүүлэх; §67.1.4.сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүнийг сэтгэл мэдрэлийн эмнэлэгт болон холбогдох байгууллагад шилжүүлэх. §68.1-д **асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоож болохгүй хүн:** §68.1.1.эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан; 68.1.2.өөрөө асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа; §68.1.3.мансууруулах бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдэг; 68.1.4.хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн; §68.1.5.үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн.

**Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг.** ГБТХ-ийн §69.1.Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь дараах үүрэг хүлээнэ: §69.1.1.асрамж, дэмжлэгтээ байгаа хүнийг хоол, хүнс, орон сууцаар хангах, **асран сувилах**; §69.1.2.асрамж, дэмжлэгтээ байгаа хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах; §69.1.3.асрамж, дэмжлэгтээ байгаа хүний мөнгөн хөрөнгө, үнэт зүйл, үнэт цаас, бусад баримт бичгийг банканд хадгалуулах; §69.1.4.асрамж, дэмжлэгтээ байгаа хүний үл хөдлөх эд хөрөнгө, мал, банканд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг өөрт нь зориулан захиран зарцуулах, орон сууц хөлслөх гэрээг цуцлах, асрамж, дэмжлэгтээ байгаа хүний нэрийн өмнөөс шинээр аж ахуй эрхлэх, эрхэлж байгаа аж ахуйн ажлыг зогсоохдоо тухайн сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авах; §69.1.5.хүлээсэн үүргийнхээ талаар тухайн сум, дүүргийн Засаг даргад жил бүр тайлагнах. §69.2. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь энэ зүйлд заасан үүргээ биелүүлэхдээ асрамж, дэмжлэгтээ байгаа /бага насны хүүхэд, сэтгэцийн өвчтэйгөөс бусад/ хүний саналыг харгалзана. **Асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хориглох зүйл:** ГБТХ-ийн §70.1.1.асрамж, дэмжлэгтээ байгаа хүнтэй хэлцэл хийх; §70.1.2.асрамж, дэмжлэгтээ байгаа хүний нэрийн өмнөөс өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл, садны хүнтэй хэлцэл хийх; §70.1.3.асрамж, дэмжлэгтээ байгаа хүн болон өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл, садны хүний хооронд үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлэхэд уг хүнийг төлөөлөх; §70.1.4.асрамж, дэмжлэгтээ байгаа хүний үл хөдлөх эд хөрөнгө, мал, мөнгөн

<sup>5</sup> А.Дугармаа, Монгол улсын гэр бүлийн эрх зүй, УБ., 2005 он, 100 дахь тал.



хадгаламж, үнэт цаас, үнэт зүйлийг бэлэглэх, өөрт нь зориулахаас бусад тохиолдолд худалдах, арилжих, барьцаалах, дэнчин тавих болон бусад хэлбэрээр захиран зарцуулах; §70.1.5.сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрөлгүйгээр орон сууц хөлслөх гэрээг цуцлах, асрамж, дэмжлэгтэй байгаа хүний нэрийн өмнөөс шинээр аж ахуй эрхлэх, эрхэлж байгаа аж ахуйн ажлыг зогсоох.

**Засаг даргын эрх, үүрэг. 1) Асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллага:** ГБТХ-ийн §66.1.Энэ хуулийн 63, 64 дүгээр зүйлд заасан хүнийг судлан тогтоох, түүнд хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилох, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх үүргийг сум, дүүргийн Засаг дарга хэрэгжүүлнэ; **2) Засаг даргын зөвшөөрлөөр асран хамгаалагч, харгалзан дэмжигч хийх үйлдэл:** §70.1.5.сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрөлгүйгээр орон сууц хөлслөх гэрээг цуцлах, асрамж, дэмжлэгтэй байгаа хүний нэрийн өмнөөс шинээр аж ахуй эрхлэх, эрхэлж байгаа аж ахуйн ажлыг зогсоох; **3) Засаг даргын эдлэх эрх:** §71.1.Сум, дүүргийн Засаг дарга асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагааны талаар дараах эрх эдэлнэ: §71.1.1.асран хамгаалах, харгалзан дэмжвэл зохих хүний талаарх мэдээллийг хүлээн авч, нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр холбогдох материал бүрдүүлж асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох, өөрчлөх тухай шийдвэр гаргах; §71.1.2.асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдоогүй хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад, өндөр настан, тахир дутуу хүнийг асрамжийн газарт шилжүүлэх шийдвэр гаргах; §71.1.3.асрамж, дэмжлэгт байгаа хүн нэг бүрд хувийн хэрэг нээж хөтлөх; §71.1.4.хувийн хэрэгт асрамж, дэмжлэг тогтоосон тухай шийдвэр, эрүүл мэндийн талаарх эмнэлгийн байгууллагын магадалгаа, төрсний гэрчилгээ, эсхүл нас тогтоосон баримт бичиг, оршин суугаа газрын хаяг, төрөл, садны хүний тухай мэдээлэл, эд хөрөнгийн жагсаалт, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хийсэн гэрээ болон шаардлагатай бусад материалыг хавсаргах; §71.1.5.асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй гэрээ байгуулж, биелэлтийг нь шалгах; §71.1.6.асрамж, дэмжлэгт байгаа хүний эрх, ашиг сонирхолд хохирол учирч болзошгүй бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс тодорхой хэлцэл хийхийг хориглох; §71.1.7.асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн буруутай үйл ажиллагаанаас асрамж, дэмжлэгт байгаа хүний эд хөрөнгөд хохирол учирсан нөхцөлд хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах; **4) Засаг дарга хяналт тавих:** §72.1.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаанд сум, дүүргийн Засаг дарга дор дурдсан журмаар хяналт тавина: §72.1.1.асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаа, түүнтэй холбогдсон баримт бичигтэй танилцах; §72.1.2.асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн мэдэлд байгаа эд хөрөнгийн данс бүртгэлийг гаргуулж, түүний бүрэн бүтэн байдал, асрамж, дэмжлэгт байгаа хүний нэрийн өмнөөс эрхэлж буй аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцлийг шалгах. §72.2. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаатай холбогдуулан аливаа байгууллага, иргэн нь сум, дүүргийн Засаг даргад гомдол гаргах, мэдээлэл өгөх эрхтэй.

### III. МОНГОЛ УЛС БА БУСАД УЛС, ОРНЫ НАСАНД ХҮРСЭН ЭТГЭЭДИЙН АСРАН ХАМГААЛАХ ТОГТОЛЦООНЫ ХАРЬЦУУЛАЛТ

ХБНГУ, Тайвань орон, Япон Улс зэрэг улс, орнуудын насанд хүрсэн этгээдийн асран хамгаалалтын уламжлалт зохицуулалт: эрх зүйн чадамжгүй болон эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай иргэн хэмээн тооцуулах заалтыг хасаж, шинэ төрлийн буюу харгалзан дэмжих, тусламж үзүүлэх маягийн хамгаалалт тогтоох.

#### 3.1. ХБНГУ-ын нэг төрөлт хамгаалалт: Харгалзан дэмжих

ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуулийн §1896-д харгалзан дэмжвэл зохих хүний бодитой хүсэл зоригийн илэрхийллийг үндэслэн харгалзан дэмжигч тогтоохоор заасан байдаг. Энэ нь харгалзан дэмжлэгт байгаа хүний хүсэл зоригийг хүндэтгэдэг утгаараа хувь хүнд илүү тохирсон хамгаалалтын хэлбэр юм. Дэмжлэгт байгаа хүн хэдийгээр харгалзан дэмжлэг тогтоолгосон ч иргэний эрх зүйн чадамжаа алдахгүй юм. Хэрэв дэмжлэгт байгаа хүн бодит үйл ажиллагаанд хүсэл зоригоо илэрхийлэх чадвар хангалтгүй гэж үзсэн, мөн түүнийг хүнд ноцтой аюулаас сэргийлэхийн тулд шүүх шийдвэр гаргаж харгалзан

дэмжигчийн зөвшөөрлийг авахаар шийдвэр гаргана. ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуулийн §1903 дугаар зүйлд насанд хүрсэн этгээдийн хувь хүний<sup>6</sup> болон эд хөрөнгийг харгалзан дэмжих хамгаалалтыг нарийвчлан тогтоожээ<sup>7</sup>. ХБНГУ-ын шүүх бол хяналт тавих эрх бүхий байгууллага мөн бөгөөд хяналтын үүрэг гүйцэтгэх хувь хүн буюу хяналтын тавих этгээд тогтоож, хоёулаа хянах үүрэг гүйцэтгэж байдаг<sup>8</sup>.

### **3.2. Тайвань орны хоёр төрлийн хамгаалалт:**

#### **Асран хамгаалалт ба харгалзан дэмжих**

Тайвань орны Иргэний хуулийн 15-т Тайвань орны асран хамгаалалт гэж хүсэл зоригоо илэрхийлэх боломжгүй, өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй этгээдэд хэрэглэх хамгаалалт, энэ утгаар эрх зүйн чадамжгүй, Тайвань орны Иргэний хуулийн §15.2.1-т харгалзан дэмжих гэж Тайвань оронд шинэ нэмэгдсэн хамгаалалт бөгөөд асрамжид байх хүн эрх зүйн чадамжтай тул түүний хүсэл зоригийг хүндэтгэж байхыг харуулж<sup>9</sup>, харгалзан дэмжлэгт буй этгээд долоон төрлийн үйл ажиллагаа хийхдээ харгалзан дэмжигчийн зөвшөөрлийг авах хэрэгтэй<sup>10</sup>.

### **3.3. Японы гурван төрлийн хамгаалалт:**

#### **Асран хамгаалах, харгалзан дэмжих, тусламж үзүүлэх**

Асран хамгаалалт гэдэг нь сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлээ *бүрэн ухамсарлах чадваргүй* этгээдэд өгөх хамгаалалт юм<sup>11</sup>. Энэ нь Монгол Улсын асран хамгаалалттай адилхан, харин харгалзан дэмжих болон тусламж үзүүлэх нь Монголын харгалзан дэмжих зохицуулалтыг хоёр хэсэгт хувааснаар ойлгож болно. Харгалзан дэмжих нь сэтгэцийн буюу оюуны хомсдолын улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг *илт бүрэн ойлгохгүйг* хэлдэг бол тусламж үзүүлэх гэдэг нь сэтгэцийн буюу оюуны хөнгөхөн хомсдолын улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг *ойлгох чадвар хангалтгүйг* заадаг<sup>12</sup>. Японы харгалзан дэмжих болон тусламж үзүүлэх хамгаалалт нь тэр чигээрээ тухайн хүний хүсэл зоригийг хүндэтгэх зорилгоор оруулсан шинэ төрлийн хамгаалалт болно. Үүнээс гадна асран хамгаалалтын бүртгэлийн хуулийг шинэчилсэн бөгөөд асрамжид байх хүний мэдээллийн аюулгүй байдал, эрх ашгийг нь хамгаалав.

### **3.4. Асран хамгаалах ажиллагаан дахь хяналтын тогтолцоо**

ХБНГУ, Япон Улсын хуульд хяналтын байгууллага ба хяналтын тавих хөндлөнгийн этгээд хэмээх хоёр шатлалт тогтолцоог ашигладаг. Тайвань оронд хяналт тавих этгээдийг тусгаагүй. Япон Улс болон Тайвань орны асран хамгаалалтын хяналтын тогтолцоо нь ХБНГУ-тай төстэй бол Монгол Улсын хяналтын байгууллага нь сум, дүүргийн Засаг дарга байна. ХБНГУ-ын хуулийн ялгарах зүйл нь хувь хүний асран хамгаалалт болон эд хөрөнгийг удирдах тухай нарийвчлан тогтоосон явдал юм. ХБНГУ-ын Иргэний хуулийн §1837-д хяналтын байгууллага нь гэр бүлийн хэргийн шүүх бөгөөд харгалзан дэмжигч, хяналт тавих этгээдийг хянаж, тэдгээр нь үүргээ биелүүлээгүй болон зөрчсөн тохиолдолд энэ талаар бүрэн эрхийг хязгаарлах, шийтгэл, хориг тавих зэрэг шийдвэр гаргана. Харгалзан дэмжигч нь эд хөрөнгийн жагсаалт гаргаж, эд хөрөнгийг удирдах,

<sup>6</sup> Хувь хүний асран хамгаалалт: асран хамгаалагчийн чиг үүргийн хүрээнд тухайн этгээдийн амь нас, бие махбодь, эрүүл мэнд, эмчилгээ, асаргаа сувилгаа зэрэг асуудлыг зохицуулах.

<sup>7</sup> ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуулийн 1799-1843-т.

<sup>8</sup> ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуулийн 1799-т.

<sup>9</sup> 林秀雄, “论我台湾地区修正之成年监护制度,” 法学时事法论 №1. 2009 он, 149 дэх тал.

<sup>10</sup> Тайвань орны Иргэний хуулийн §15.2-т харгалзан дэмжлэгт буй этгээд дараах үйлдэл хийхдээ харгалзан дэмжигчээр зөвшөөрүүлэх хэрэгтэй, гэвч үүрэг хариуцлага хүлээхгүй цул ашигт хүртэх эрх зүйн давуу байдал, өдөр тутмын амьдралд шаардлагатай ялимгүй үйлдэл хамрахгүй: 1) ганцаар хувьцаа эзэмших компани байгуулах, хамтран ажиллах аж ахуйн ажиллагаа эрхлэх ба хуулийн этгээдийн удирдлага болох; 2) хэрэглээний зээл, хэрэглээний хадгалалт, батлан даалт, бэлэглэл, итгэмжлэл; 3) нэхэмжлэл гарах; 4) эвлэрэх, шүүхээр эвлэрүүлэх, зуучлан зохицуулах, арбитрын гэрээ байгуулах; 5) үл хөдлөх хөрөнгө, усан онгоц, нисэх онгоц, автомашин, бусад чухал эд хөрөнгийг захиран зарцуулах, үүрэг хүлээх, худалдах худалдан авах ба зээлэн хэрэглэх; 6) өв хуваах, гэрээслэлээр бэлэглэх, өв залгамжлал, бусад эрхийг чөлөөлөх; 7) шүүх дээрх заалтын дагуу холбогдох этгээд ба харгалзан дэмжигчийн хүсэлтээр захирамжлан шийдсэн бусад үйлдэл.

<sup>11</sup> Японы Иргэний хуулийн 7-д: Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлээ бүрэн ухамсарлах чадваргүй этгээдэд Гэр бүлийн шүүхээс сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх асран хамгаалалтыг тогтооно.

<sup>12</sup> Японы Иргэний хуулийн 11-д: сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг илтэд бүрэн ойлгох чадваргүй этгээдэд гэр бүлийн шүүх сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх харгалзан дэмжигчийг тогтоож болно.

15-т: сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг бүрэн ойлгох чадамжгүй болсон этгээдэд сонирхогч этгээдийн хүсэлтээр туслагчийг тогтооно.

хөрөнгө оруулалт, эмчлэн сувилах, асрамжид байх хүнийг албадан эмчлүүлэх, амьдран суух зорилготой түрээсэлсэн байрыг цуцлах зэрэг үйлдлийг шүүх буюу хяналтын хүнээр зөвшөөрүүлэх бөгөөд шүүх хяналт тавих этгээдийн зөвшөөрлийг хянаана. Хяналт тавих этгээд өдөр тутмын үйл ажиллагаа, асаргаа сувилгаанд хяналт тавих үүрэг гүйцэтгэж, шүүхэд мэдүүлэг, санхүүгийн тайлан өгөх үүрэгтэй<sup>13</sup>.

Гадаад орны урьдчилан зөвшөөрөн хянах тогтолцоо. Асрамжид байх хүний хувьд онцгой ач холбогдол бүхий хувь хүний ба эд хөрөнгийн үйл ажиллагаанд зайлшгүй хяналтын байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авах үүрэгтэй. ХБНГУ-ын хуулийнд биеийн эрүүл мэндэд ноцтой бөгөөд урт хугацааны хохирол учруулахуйц аюултай эмчилгээ, үрийн суваг боох, албадан эмчлүүлэх, биеийн эрх чөлөөг хязгаарлах зэрэг багтдаг.

Чухал ач холбогдолтой эд хөрөнгийг захиран зарцуулах: ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуульд шүүхийн урьдчилсан зөвшөөрөл авах тухай нарийвчлан тогтоожээ. Үүнд, амьдран суух зорилготой түрээсэлсэн орон сууцыг захиран зарцуулах, түрээслүүлэх, ашиглах; бэлэглэл эсвэл шинээр аж ахуйн ажиллагаа эрхлэх; үл хөдлөх хөрөнгө, хөлөг онгоц ба харгалзан дэмжлэгт буй этгээдийн бүх хөрөнгийг захиран зарцуулах; өв залгамжлах эрхээс татгалзах ба түүнтэй холбогдох шаардах эрхийг захиран зарцуулах; 1 жилээс дээш хугацааны бизнес эрхлэх, хөлсөөр ажиллах, түрээслэх гэрээ байгуулах; эвлэрэх болон арбитрын хэлцэл; хэрэглээний зээл, үнэт цаас ба батлан даалтын гэрээ зэрэг үйл ажиллагааг хяналтын байгууллагаар зөвшөөрүүлнэ.

## ДҮГНЭЛТ

1. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох ажиллагаанд оршиж байх сул тал

Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр томилогдох этгээдийн хүрээ хэт бага байх. Гэр бүлийн хуулийн §67.1.1-т эд хөрөнгийн зохих бололцоотой төрөл садан ба төрөл садан бус хүнийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр томилж болно гэв. Дээрхээс гадна сум, дүүргийн Засаг дарга, нийгмийн халамжийн байгууллага, прокурор зэрэг бусад этгээдийг оруулж болох эсэх, тухайлбал хамтран амьдрагч, албаны асран хамгаалагчийг хуульчлаагүй.

Асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилоход харгалзан үзэх нөхцөл байдал тодорхой биш байх. Гэр бүлийн тухай хуулийн §71.1.1-д холбогдох материалыг бүрдүүлж нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоож, өөрчилнө. Нөхцөл байдлыг судална гэж заасан боловч ямар ямар нөхцөл байдлыг судлах тухай бодитой заагаагүй. Тухайлбал тухайн хүний бие, сэтгэц, эд хөрөнгө, түүний гэр бүлийн гишүүн ба хамтран амьдрагчийн хоорондын хувийн харилцаа, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр томилогдох этгээдийн ажил төрөл, амьдралын хэвшил, санал ба ашиг сонирхлын харилцаа, хуулийн этгээд бол эрхэлж байх үйл ажиллагаа, тухайн хүнтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх.

Гэр бүлийн тухай хуулийн §71.1.1-д нөхцөл байдлыг судлан асран хамгаалагчийг өөрчилнө гэв, гэтэл өөрчлөх нөхцөлийг тодорхой тогтоосонгүй. Ердөө асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тухайн хүний ашиг сонирхолд нийцэхгүй эсвэл илт асран хамгаалж, харгалзан дэмжиж чадахгүй тохиолдол гарвал өөрчилдөг. Гэхдээ практикт бодитой нөхцөлийг судалж шийднэ, тухайлбал асран хамгаалагч нас ахиад асран хамгаалах, харгалзан дэмжих үүргийг биелүүлж чадахгүй, эсвэл гадаад оронд урт хугацаа орогнож үүргээ гүйцэтгэж чадахгүй байх гэх мэт.

2. Асран хамгаалах, харгалзан дэмжих нөхцөлийг эрх зүйн чадамжаар тодорхойлж байх

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийж, дүгнэлт гаргах бөгөөд тус дүгнэлтийн дагуу шүүхээс иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тогтоох боловч тухайн хүн нь ямар ямар хүсэл зоригтой, ямар ямар хүсэл зориггүй гэж бодитой тодорхойлдоггүй. Хүсэл зориг илэрхийлэх чадвар гэж иргэний тухайн цаг мөчийн бодит үйл ажиллагааг ухамсарлах

<sup>13</sup> ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуулийн 1799-1843-т.

чадварыг хэлдэг, адил бус цаг мөчид адил бус ухамсарлах чадвартай байдаг. Тухайн хүн тэрхүү цаг мөчөөс шалтгаалан хүсэл зориг нь янз бүр байдаг.

### 3. Насанд хүрсэн этгээдийн асран хамгаалалтын төрөл

Бусад улс, орны насанд хүрсэн этгээдийн асран хамгаалах тогтолцоонд харгалзан дэмжих хамгаалалтыг илүү онцолсон байдаг. ХБНГУ-ын нэг төрлийн хамгаалалт: харгалзан дэмжих; Япон Улсын гурван төрлийн хамгаалалт: асрах хамгаалалт, харгалзан дэмжих, тусламж үзүүлэх; Тайвань орны хоёр төрлийн хамгаалалт: асран хамгаалалт болон харгалзан дэмжих. Нэг төрлийн хамгаалалтын хууль хэрэгжүүлэх өөрийн өртөг их, бас нийгмийн дэмжлэг, засаг захиргааны дэмжлэг үзүүлэх тогтолцоо маш сайн байх ёстой. Гурван төрлийн хамгаалалтын тухайд Иргэний хууль, Гэр бүлийн хуультай ялгаа, зөрөө их, адилгүй тул нутагшуулах өртөг өндөр бөгөөд гурван төрлийн хамгаалалтыг ялган салгах, практикт хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байдаг. Иргэний хуульд насанд хүрсэн этгээдийг иргэний эрх зүйн чадамжгүй болон иргэний эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай хэмээн хоёр төрөлд хуваав. Тайвань орны хоёр төрлийн хамгаалалт нь Монгол Улсын Иргэний хуулийн хоёр төрөлт тогтолцоотой илүү зохицолдон, асран хамгаалах болон харгалзан дэмжих ухагдахууныг хүсэл зоргоор тодорхойлон хэрэгжүүлэхэд хялбар, хэрэгжүүлэх өртөг харьцангуй бага байдаг болохоор Тайвань орны хоёр төлийн тогтолцоог дуурайн нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзлээ.

### 4. Гэр бүлийн хуулийн асран хамгаалах харгалзан дэмжих эрх бүхий байгууллагыг Засаг дарга хэрэгжүүлж байх үндэслэл хангалтгүй

ХБНГУ, Япон Улсын хяналтын үүргийг асран хамгаалах хэргийг хянан шийдвэрлэх шүүх ба хяналт тавих этгээд хамтдаа хэрэгжүүлж байдаг. Тайвань оронд гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх хяналтын үүрэг гүйцэтгэж байдаг, харин хяналт тавих хөндлөнгийн этгээдийг хуульчлаагүй. Шүүх, засаг захиргааны хяналт хэрэгжүүлэх төр засгийн төсөв өндөр тул улсын эдийн засагт хүндрэл, ачаалал авчирдаг. Иймээс хяналт тавих хөндлөнгийн этгээд оруулан, амьдралын нөхцөл сайн гэр бүлээс хяналт тавих этгээдэд зохих хэмжээний хөлс олгон тэнцвэржүүлбэл хяналт нэн үр бүтээмжтэй хэрэгжинэ. Үүнээс гадна Швейцар, Англи, АНУ-д шүүхээс асран хамгаалах үйл ажиллагаандаа хяналт тавьдаг<sup>14</sup>. Дээрх орны хууль тогтоомжоос харвал шүүхээс хяналтын үүрэг гүйцэж байгаа арга хэлбэр нь одоогийн голлох хөгжлийн хандлага болж байгаа.

Гэр бүлийн хууль бол хувийн эрх зүй мөн. Гэр бүлийн эрх зүйн асран хамгаалах харгалзан дэмжих ажиллагааг Засаг даргаас хяналтын үүрэг хэрэгжүүлэх нь хувийн эрх зүйн үндсэн зарчимтай нийцэхгүй юм. Засаг даргын хариуцдаг захиргааны эрх, үүргийг гэр бүлийн тухай хуулиас салган захиргааны хуульд оруулж, гэр бүлийн хуулийн асуудыг иргэний хэрэг хянан шийдвэрлэх шүүх эсвэл гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүхээс хариуцвал зүйтэй юм.

Асран хамгаалагч, харгалзан дэмжигч хяналтын байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авах үйлдлийн хүрээ бага байх. Асран хамгаалагч орон сууц хөлсөх гэрээг цуцлах, шинээр аж ахуй эрхлэх, эрхэлж байгаа аж ахуйн ажиллагааг зогсоох хяналтын байгууллагын зөвшөөрлийг авдаг. Гэтэл тухайн хүний эрүүл мэндэд өндөр эрсдэлтэй эмчилгээ, амь насанд аюултай эмчилгээ, үрийн суваг боох, албадан эмчлэх, тухайн хүний оршин суугаа орон сууц ба газарт барилга байгууламж барих эрхийг худалдах, худалдан авах, түрээслүүлэх, барьцаалах, захиран зарцуулах, үнэт эд хөрөнгийг захиран зарцуулах үед хяналтын байгууллагын зөвшөөрлийг авах тухай хуульчлаагүй байна.

## САНАЛ

Монгол Улсын хүн амын хөгшрөл, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалахын тулд асран хамгаалах тогтолцоог шинэчлэн өөрчлөх шаардлагатай болов. Тус судалгаанд асран хамгаалах ба харгалзан дэмжих унагдахууныг хүсэл зоргоор тодорхойлох, асран хамгаалах, харгалзан дэмжих гэж тооцуулах хүсэлт гаргах этгээдийн хүрээг өргөтгөх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүрээг ихэсгэх, хяналтыг

<sup>14</sup> А.Дугармаа, *Монгол улсын гэр бүлийн эрх зүй*, УБ., 2005 он, 104 дэх тал.

чангатгах санал дэвшүүлэв.

### 1. Өндөр наслалтын улмаас үүссэн зайлшгүй шаардлага

Монгол Улсын хүн амын дундаж наслалт өндөр болж байгаа тул ахмад настанд тохирсон асран хамгаалах тогтолцоог хуульчлах шаардлагатай байна. Тодруулбал 2020 оны Монгол Улсын Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн үзүүлэлтээр 60-64 өндөр настны хүн амын тоо 106145, 65-69 өндөр настны хүн амын тоо 58377, 70-аас дээш өндөр настны хүн амын тоо 85319<sup>15</sup> буюу 60-аас дээш өндөр настан нийт хүн амын 7.44% хувийг эзэлж байна. Мөн тус мэдээллийн сангийн 2020-2050 оны хүн амын тоо, хүйс, насны бүлэг, дунд хувилбар 1Б тоо бүртгэлээр<sup>16</sup> барагцаалбал 2026 онд 60-аас дээш өндөр настан нийт хүн амын 10%-г эзлэх болно. Монгол Улсын хүн ам барагцаалснаар 2030 оноос эхлэн хөгшрөл лүү хандаж цаашид нэн хурдасна. Монгол Улсын хүн амын хэтийн тооцоогоор хүн ам зүйн ачаалал 2015 онд 48.6% байсан бол 2045 онд 64.9% болж нэмэгдэж, хүүхэд, хөгшдийн ачаалал аль аль нь өсөхөөр байна. Ахмад настан нэмэгдэхийг дагалдан тэдний хүсэл зоригийг хүндэтгэх харгалзан дэмжих, тусламж үзүүлэх хамгаалалтыг хангаж өгөх шаардлагатай болжээ.

### 2. Асран хамгаалах, харгалзан дэмжих ухагдахууныг хүсэл зоригоор тодорхойлох

Асран хамгаалах тогтолцооны үндсэн зарчим гэвэл тухайн хүний хүсэл зоригийг хүндэтгэх явдал мөн. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй этгээдийн хүсэл зоригоо илэрхийлэх чадвар муудаж түүний эрх ашгийг хамгаалахын тул асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоодог. Хэдийгээр тухайн хүний хүсэл зоригийн илэрхийлэл муудсан ч гэсэн түүний санал бодол, хүсэл зоригийг хүндэтгэх ёстой. Хүсэл зоригоо илэрхийлэх чадварыг шалган тогтоох, сэтгэцийн өвчний хэмжээ, сэтгэцийн өвчин нь хүсэл зоригоо илэрхийлэх чадварт нөлөөлсөн эсэх, хэр зэрэг нөлөөлсөн болон нөлөөлөх болсон шалтгаан, хэмжээг бодитой шинжин тодорхойлно. Үүнд эмч, сэтгэцийн шинжээч болон шүүх байгууллагууд хамтран оролцож, эцэст нь шүүхээс тухайн хүн ямар, ямар хүсэл зоригоо алдсан, ямар хүсэл зориг байгаа эсэхийг тодорхойлон шийднэ.<sup>17</sup> Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь чиг үүргээ гүйцэтгэх, хяналт хийх бүртгээ тухайн хүний өөрийн хүсэл зоригийн дагуу асуудлыг шийдсэнээр түүний эрх ашиг хамгаалагддаг. Хэрэв хүсэл зоригоо илэрхийлж чадахгүй бол тухайн хүний ашиг сонирхолд хамгаас тааламжтай байдлаар асуудлыг шийдвэрлэнэ.

#### 2.1. Асран хамгаалалт

Сэтгэцийн өвчний улмаас хүсэл зоригоо байнга илэрхийлж чадахгүй этгээдийг өөрийн болон холбогдох этгээдийн хүсэлтээр шүүхээс асран хамгаалалт тогтооно. Насанд хүрсэн этгээдэд асран хамгаалалт тогтоовол эрх зүйн чадамжгүйд тооцогдоно. Гэтэл өдөр тутмын амьдралын хэрэгцээнд шаардагдах ялимгүй, түүнд хохирол учруулахгүй үйлдэл зэргийг зөвшөөрч, нийгэмд эрх тэгш оролцуулах нь түүний нийгмийн харилцаа, хувийн эрх ашигт сайн тул хүчингүй болгох нь зохисгүй. Хэрэв асрамжид байх хүн ямар нэгэн үйл ажиллагааг ухамсарлах чадваргүй бол асран хамгаалагч асрамжид байх хүний хувь хүний байдал, дур сонирхол, хүсэл зоригийг харгалзан үзэж асран хамгаалах үүргээ гүйцэтгэнэ. Үүнд:

2.1.1. асран хамгаалагчид төлөөлөх эрх олгох: хууль тогтоомжоор төлөөлөх эрх олгох ба бодит хэргийн дунд шүүх хуралдаанаар асрамжид байх хүний байдлыг харгалзан асран хамгаалагчид төлөөлөх эрх олгож болох бөгөөд эрхийн хязгаарыг тогтоох захирамж гаргана.

2.1.2. эд хөрөнгө удирдах эрх: асран хамгаалагч асрамжид байх хүний эд хөрөнгийг удирдаж, цаг тухайд нь эд хөрөнгийн жагсаалт гаргах үүрэгтэй бөгөөд хяналтын байгууллага болон хяналт тавих этгээдийн шаардлагаар мэдэгдэх ба тайлан гаргах үүрэгтэй, шаардлагатай үед шалгаж хянана. Зөвхөн асрамжид байх хүний эрх, ашгийн тулд түүний эд хөрөнгийг захиран зарцуулах үүрэгтэй байна.

<sup>15</sup> [https://www.1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NS0\\_0300\\_071V3&Group\\_select\\_all=0&GroupSingleSelect= 1\\_115\\_114\\_113&Sex\\_select\\_all=0&SexSingleSelect=&YearY\\_select\\_all=0&YearYSingleSelect= 2020&viewtype=table](https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0300_071V3&Group_select_all=0&GroupSingleSelect= 1_115_114_113&Sex_select_all=0&SexSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect= 2020&viewtype=table) [Сүүлд үзсэн: 2021.12.28]

<sup>16</sup> [https://www.1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NS0\\_0300\\_076V12&Group\\_select\\_all=0&GroupSingleSelect= 1\\_74\\_80\\_86\\_92\\_98\\_104&Sex\\_select\\_all=0&SexSingleSelect=&YearY\\_select\\_all=0&YearYSingleSelect= 2021\\_2022\\_2023\\_2024\\_2025\\_2026\\_2027\\_2028\\_2029\\_2030&viewtype=table](https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0300_076V12&Group_select_all=0&GroupSingleSelect= 1_74_80_86_92_98_104&Sex_select_all=0&SexSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect= 2021_2022_2023_2024_2025_2026_2027_2028_2029_2030&viewtype=table) [Сүүлд үзсэн: 2022.09.28]

<sup>17</sup> 高一书, “成年监护之意思能力判定,” 法学研究报告, 2015 он, №47, 727-731 дэх тал.



2.1.3. хувь хүний асран хамгаалалт: асрамжид байх хүний биеийн эрүүл мэнд, асаргаа сувилгаа, эмчилгээ, албадан эмчлэх, үрийн суваг боох зэрэг асуудалд асрамжид байх хүн өөрөө шийдэж хэрэв хүсэл зоригоо илэрхийлэх чадамжгүй бол шүүхийн зөвшөөрлийг авах шаардлагатай.

## 2.2. Харгалзан дэмжих

Харгалзан дэмжих гэдэг нь харгалзан дэмжүүлэг тооцуулж буй этгээд хүсэл зоригоо хангалттай илэрхийлж чадахгүй этгээдэд сонирхогч этгээдийн хүсэлтээр харгалзан дэмжлэг тогтооно. Харин хүсэл зоригоо илэрхийлэх чадвартай үйлдлийг өөрөө шийднэ. Иймээс асрамжид байх хүний эрх зүйн чадамжийг бүрмөсөн хасахгүйгээр түүний санал бодол, хүсэл зоригийг хүндэтгэх хэрэгтэй юм. Иймд дараах харгалзан дэмжигчийн зөвшөөрөх эрх ба төлөөлөх эрхийг авч үзье.

2.2.1. зөвшөөрөх эрх: харгалзан дэмжлэгт буй этгээдийг харгалзан дэмжих шаардлагатай гэж тооцвол, өөрөө зарим үйл ажиллагаа үйлдэхэд харгалзан дэмжигчээр зөвшөөрүүлэх шаардлагатай, харгалзан дэмжигч зөвшөөрөөгүй бол тухайн үйлдэл хүчингүй. Зөвшөөрөх эрхийн хүрээ хязгаарыг хуулиар тогтоох ба бодит хэрэг ба асрамжид байх хүний хүсэл зоригийг харгалзан тогтооно; үүнд Тайвань орон ба Япон Улсын хууль тогтоомжийг нутагшуулж болно.

2.2.2. хууль ёсны төлөөлөх эрх олгох: харгалзан дэмжлэгт буй этгээдийн хүсэл зоригийн бодит байдлыг үндэслэн шүүхээс хүсэл зоригийг тодорхойлж харгалзан дэмжигчид төлөөлөх эрх олгож, харгалзан дэмжигчийн төлөөлөх бүрэн эрхийн хүрээг тодорхойлох хэрэгтэй. Мөн шүүхээс харгалзан дэмжигчийн бүрэн эрхийг хязгаарлан багасгах буюу тодорхой үйлдэл хийхийг хориглох шийдвэр гаргаж болно.

2.2.3. Эд хөрөнгийн бус үүрэг: эрсдэлтэй эмчилгээ, албадан эмчилгээ, хорин байршуулах зэрэг шийдвэр харгахад харгалзан дэмжигч хяналт тавих байгууллагын зөвшөөрлийг авна.

## 3. Асран хамгаалах, харгалзан дэмжих хүсэлт гаргах этгээдийг өргөтгөх

Иргэний хууль ба Гэр бүлийн тухай хуульд асран хамгаалах, харгалзан дэмжлэг тогтоох хүсэлт гаргах этгээдийг хуульчлаагүй. Харин Иргэний хэрэг хянан шүүх хуульд гэр бүлийн гишүүн ба бусад сонирхогч этгээд хүсэл гаргана гэсэн нь зохисгүй байна. Иймд Гэр бүлийн тухай хуульд тодорхой зааж өгөх шаардлагатай: тухайн хүн өөрөө, гэр бүлийн гишүүн, ойрын 1 жилд хамтран амьдрагч, садан төрөл, садан төрөл бус хүн, прокурор, сум дүүргийн засаг дарга, нийгмийн халамжийн байгууллагаас хүсэлт гаргана. Харин сонгуулийн хороо, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчээс хүсэлт гаргах субъектээс хасна.

4. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр томилогдох этгээдийн шалгуурыг өргөтгөх

Гэр бүлийн тухай хуулийн §67.1.1-д эд хөрөнгийн бололцоотой төрөл садан ба төрөл садан бус хүнийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр томилно гэж зааснаар томилогдох этгээдийн хүрээ хэт бага байна. Учир нь практикт голдуу эмэгтэй гэр бүлийн гишүүн асран хамгаалагч, харгалзан дэмжигч болдог ба цөөн тохиолдолд төрөл садан бус хүн томилогддог. Иймээс асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр томилогдох этгээдийн шалгуурыг илүү өргөн хүрээнд байлгаж, мөн холбогдох эрх бүхий байгууллагыг оруулах шаардлагатай байна.

## 5. Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх байгуулах

Гэр бүлийн тухай хууль дахь харилцаанд зориулан тусгай гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байгуулж, гэр бүлийн гишүүдийн хувийн болон эд хөрөнгийн харилцаа, мөн асран хамгаалах, харгалзан дэмжих хэргийг хянан шийдвэрлүүлж байх шаардлагатай. Түүнчлэн шүүгч болон шүүгчийн туслах гэх мэт албан хаагчдын орон тоог зохистой зохион байгуулж, бусад суурь тогтолцоог хангаж өгөхгүй бол ганцхан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад хэрэгжиж чадахгүй юм.

### 5.1. Гэр бүлийн хэрэг хянах шүүхийн хяналт тавих үүрэг

Хяналтын байгууллага нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хяналт тавих этгээдийн аливаа үйл ажиллагааг хянах ба дараах үүргийг хүлээнэ. Үүнд: асран хамгаалагч хөрөнгийн удирдлагын тухай мэдэгдэх үүрэгтэй; асрамжид байх хүний амь нас, эрүүл



мэндэд ноцтой аюул учруулах эмчилгээг зөвшөөрөх; Асран хамгаалагч нь асрамжид байх хүний хөдлөх, үл хөдлөх хөрөнгө болон бусад хөрөнгийг захиран зарцуулахад хяналтын байгууллагаас зөвшөөрөл авах; Асран хамгаалагч болон асрамжид байх хүний ашиг сонирхлын зөрчилтэй үйл ажиллагаа явуулах тохиолдолд хяналтын байгууллагаас зөвшөөрөл авах гэх мэт.

Хяналтын байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авах тухай. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт буй этгээдийн биеийн асаргаа сувилгаа болон эд хөрөнгийн чухал ач холбогдолтой үйлдэлд хяналтын байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авна. Асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт буй этгээд ердийн үйл ажиллагаанд хүсэл зоригоо илэрхийлэх чадвартай бол өөрөө шийдэж, хэрэв хүсэл зоригоо илэрхийлэх чадваргүй бол асран хамгаалагч, харгалзан дэмжигч шийдэж, хяналтын байгууллага болон хяналт тавих этгээд түүнд хяналт тавьдаг.

#### 5.2. Хяналт тавих этгээдийг оруулах ба түүний үүрэг

Хяналт тавих этгээд нь хяналт тавих чадвартай бөгөөд асран хамгаалагчийн ойрын төрөл, түүнтэй ашиг сонирхлын зөрчилдөөнтэй этгээд байж болохгүй. Хэрэв тухайн хүний эд хөрөнгийг удирдах шаардлагатай бол хяналтын хүнийг тогтооно.

Хяналт тавих этгээдийн үүрэг: хяналт тавих этгээд асран хамгаалагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, асран хамгаалагч үүргээ биелүүлж байгаа эсэхийг хянана. Асран хамгаалагч үүрэг хариуцлагаа биелүүлэхгүй, асрамжид байх хүний эрх, ашиг сонирхолд гэм хор учруулсан бол хяналт тавих этгээд нь шүүхэд мэдэгдэх, эсхүл асран хамгаалагчийг солих, чөлөөлөх тухай хүсэлт гаргана; Асран хамгаалагч болох зохих хүн олдохгүй үед хяналт тавих этгээд асран хамгаалагчийг томилуулахаар хяналтын байгууллагад хандана; Асран хамгаалагч, хяналт тавих этгээд хамтран эд хөрөнгийн жагсаалтыг гаргах бөгөөд жагсаалтын үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг батална. Шаардлагатай гэж үзвэл асран хамгаалагчаар эд хөрөнгийн тайлан гаргуулах, мөн шүүхээр шалгуулах захирамж гаргуулна; тухайн хүн болон асран хамгаалагч ашиг сонирхлын зөрчилтэй үед тухайн хүнийг төлөөлнө. Нэн яаралтай нөхцөл байдалд хяналт тавих этгээд шаардлагатай арга хэмжээг авч тухайн хүний эрх ашгийг хамгаалах; хяналтын үүргээ гүйцэтгэхдээ ердийн анхааран болгоомжлох үүрэг хүлээнэ; хянах үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөхөн төлбөр төлөх үүрэг хүлээж, хэрэв асран хамгаалагч болон хяналт тавих этгээд хамтран гэм хор учруулсан бол гэм хорыг хамтран арилгах үүрэг хүлээнэ.

#### 5.3. Засаг захиргаанаас шүүхийн хяналтад тусламж, дэмжлэг үзүүлэг үүрэг

Одоогийн байдлаар Монгол улсын 1999 оны Гэр бүлийн тухай хуулийн §72-т сум, дүүргийн Засаг дарга хяналтын үүргийг гүйцэтгэж байна. Захиргааны байгууллага хэдийгээр хяналтын үүрэг гүйцэтгэж болох боловч түүний хамгийн гол чиг үүрэг нь нийгмийн халамж, тэтгэлэг, тусламж үзүүлэх үүрэг юм. Асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт буй этгээдийг асран хамгаалах хүн олдохгүй үед захиргааны байгууллага асран хамгаалагч буюу харгалзан дэмжигч болох, тухайн хүнд яаралтай тусламж үзүүлэх, амьдралын боломжгүй этгээдэд халамжийн үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн өвчтэй иргэдийг эмчлүүлэх, өндөр настны эрх ашгийг хамгаалах, тухайн хүний тухай хэрэг нээн хөтлөх зэргээр бодит байдлыг ойлгох юм. Засаг захиргааны байгууллага нь шүүх байгууллага шиг хууль зүйн мэдлэггүй бөгөөд эрх зүйн асуудлыг зохистой шийдвэрлэж боломжгүй. Иймд насанд хүрсэн этгээдийн асран хамгаалах, харгалзан дэмжих бүхий хяналтын чиг үүргийг шүүхээр гүйцэтгүүлэх нь зүйтэй. Сум, дүүргийн, хороо, багийн Засаг дарга, нийгмийн ажилтан зэрэг нь гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх байгууллагыг дэмжин хяналт хийвэл нэн үр дүнтэй. Үүнээс гадна хяналт хийх хавсрах арга хэрэгсэл ашиглаж болдог; тухайлбал хэд хэдэн асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилон тэдний хооронд нь харилцан хянуулж шалгуулах эсхүл асран хамгаалагч харгалзан дэмжигчийг өөрчлөн сольсноор мөн хяналт чангатгах боломжтой.

**ЭХ СУРВАЛЖ****I. Монгол эх сурвалж:**

1. Б.Буянхишиг, ХБНГУ-ын Иргэний хууль, УБ., 2017 он.
2. А.Дугармаа, Монгол улсын гэр бүлийн эрх зүй: Онол, бодлого, сорил, нэр томьёо, УБ., 2016 он.
3. Б.Урангоо, Япон улсын иргэний хуулийн орчуулга, УБ., 2018 он.

**II. Гадаад эх сурвалж:**

1. 陈棋炎. 民法亲属新论. 三民书局出版社. 2011 он.
2. 迪特尔·施瓦布. 德国家庭法. 法律出版社. 2010 он.
3. 陈自强. 债法现代化. 北京大学出版社. 2018.
4. 王爱群. 日本民法典. 法律出版社. 2014 он.
5. 孙犀铭. “民法典语境下成年监护改革的拐点与转进.” 法学家 .2018. 4.
6. 李霞. “成年监护制度的现代转向.” 中国法学. 2015. 2.
7. 王竹青. “成年监护类型解析. 法学研究 2018.2.
8. 林秀雄. “论我国修正之成年监护制度.” 时事法论. 2009. № 1.

**A COMPARATIVE STUDY INTO ADULT GUARDIANSHIP SYSTEMS  
IN MONGOLIA, GERMANY, JAPAN, AND TAIWAN**

*BaoBuhe*

*Ph.D. candidate of School of Law, NUM*


**ABSTRACT:**

Contents of Mongolia's adult guardianship and assistance have been regulated by the Civil Law of 2002 and the Family Law of 1999, and until now, no additional changes have been made to the regulation of adult guardianship and assistance in the Family Law. In Mongolia, there are pressing issues such as how to define the concept of guardianship and assistance, how to determine the will, how to establish a guardianship and assistance organization, supervision organization, and how to supervise. Instead of the mainland legal system, the adult guardianship and assistance system has been reformed in the coming years. In this regard, there has been no comparative study of the guardianship and assistance systems of the mainland legal system of Germany, Japan, and Taiwan region in Mongolia, and it is necessary to study further. This article is compared with the three mainland legal countries/regions, and proposals are made to develop the regulation of guardianship and assistance of adults in Mongolia.

**KEYWORDS:**

Adult, Guardianship, Assistant, Reasonable support, Supervision

## МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ КРИМНОЛОГИ АСУУДАЛ



*Р.Жамбалсүрэн  
ДХИС-ийн Эрх зүйн нийгмийн ухааны сургуулийн  
магистрант*

### **ТОВЧЛОЛ:**

Монгол Улсад ардчилал нь хүний эрх, эрх чөлөө жинхэнэ утгаараа биелэлээ олох чиглэлд ойртсоор байгаа хэдий ч эрх, эрх чөлөөг нийгмийн сөрөг үзэгдэлийг бамбай болгон гэмт хэрэг, зөрчил нэмэгдэж цаашдаа ч нэмэгдэх хандлагатай байгаа нь анхаарал татсан асуудал байгаа юм. Юу хэрэглэх нь миний эрх, Юу сонгох энэ ч миний эрх гэж хүссэнээр орилох өнөөгийн залуучууд дунд “Миний эрх бусдын эрхээр хязгаарлагдагддаг” гэдгийг ойлгодог, ухамсарладаг хүн бага байгаа нь харамсалтай. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргүүд ихэнхдээ нууц, далд байдлаар явагддаг бөгөөд жил ирэх тусам мансууруулах бодисын төрөл нэмэгдэж өөрчлөгдөж түүнийгээ даган нийгмийн залуу үеийнхэн лүү чиглэж, бага залуу үеийнхнээс энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдэж байгаа нь хүн ам цөөтэй мөн хүн амын 75%-ийг залуучууд эзэлдэг Монгол улсын хувьд үндэсний аюулгүй байдлын асуудал юм. Хэн нэгэнд үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө байдаг ч гагцхүү тухайн эрх, эрх чөлөө гэмт хэрэг, нийгмийн гаж үзэгдлийг өөгшүүлэнэ гэсэн үг биш юм. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх явдал нь бие хүн төдийгүй, бүхэл бүтэн улс үндэстий эрүүл мэнд, аюулгүй байдал, хойч үеийн хөгжил, хүмүүжилд хор хөнөөл учруулдаг учраас аливаа төрийн үндэсний аюулгүй байдлалд байнга заналхийлэх бодит хүчин зүйл болдог билээ.<sup>1</sup>

### **ТҮЛХҮҮР ҮГС:**

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодис, өсвөр насны хүүхдүүд, аюулгүй байдал, ахуйн газ хэрэглээ, худалдааны хяналт

### **ҮНДСЭН ХЭСЭГ**

**1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай ойлголт ба гэмт хэрэг-кримнологи шинж**

#### **1.1 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай**

Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодис гэдгийг хууль зүй, анагаах ухаан,

<sup>1</sup> Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг

нийгэм, химийн шинжлэх ухааны үүднээс дараах байдлаар тодорхойлсон байдаг. Анагаах ухаан болон химийн шинжлэх ухааны үүднээс уг бодисыг хэрэглэсэн хүний уураг тархинд давамгайлан нөлөөлж, эсвэл төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг цочроож, тайвшруулах, сэтгэлийн түгшүүрийг арилгах, сэтгэлийн хөөрөл, хий үзэгдэл эсвэл төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг дарангуйлж саатуулах булчин сулруулах, нойр хүргэх, мэдрэл тайвшруулах, сэтгэлийн гишүүрийг номхотгох зэрэг үйлчлэлийг үзүүлэх чадварыг өөртөө шингээсэн хийгээд эмнэлгийн бус зориулалтаар тогтмол хэрэглэвээс байн байн хүртэхийг шаардсан эмгэг хэрэгцээг хүсэж буй болгож “сэтгэлийг баясгах буюу мэдрэлийг тайвшруулан мансууруулах” хэлбэрээр хүний бие сэтгэцийг эрхшээлдээ оруулах чадавхийг өөртөө агуулсан эм бодисуудыг сэтгэц идэвхит бодис гэж тооцно. Харин нийгэмд үзүүлэх нөлөөллөөс авч үзвэл мансууруулах бодисыг хэрэглэсэн хэний ч сэтгэцэд нөлөөлөн зан үйл, ёс суртахууныг хянах чадваргүй болсноор гэмт хэрэг үйлдэх, нийгэмд эмх замбараагүй байдлыг үүсгэх зэрэг улс оронд асар их хохирол учруулах боломжтой бодис болон түүнийг агуулсан эм бэлдмэлүүдийг сэтгэцэд нөлөөлөх бодис гэж болно.

**Онцлох тэмдэглэл:**

Баянгол дүүргийн 28 дугаар сургуулийн 11 дүгээр ангийн сурагч (эмэгтэй): Нэг удаа өвс татаж үзсэн. Хэрэглэхэд толгой эргээд манарсан. Яг тэр үеийн юмаа санадаггүй, мөнгөлөг цаас болон ундааны сав ашиглаж сордог юм байна лээ.

Чингэлтэй дүүргийн 50 дугаар сургуулийн 11 дүгээр ангийн сурагч (эрэгтэй): Нэг удаа сонирхоод газ үнэрлэж үзсэн.

Дээрх тодорхойлолтуудыг нэгтгэвэл, хараа хяналтгүй хэрэглээнээс үүдэн эрүүл мэнд болон улмаар нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаварыг харгалзан үзэж сэтгэцэд нөлөөлөх, мансууруулах үйлчилгээтэй болохыг нь эрх бүхий байгууллагаас тогтоож, хяналтаас гадуур (эмнэлэг, судалгаа шинжилгээний бус зорилгоор) худалдаалах, хэрэглэхийг нь хуулиар хориглож, тусгай жагсаалтад оруулсан бодис, эм бэлдмэлүүдийг мансууруулах буюу сэтгэцэд нөлөөт бодис хэмээн тооцож болно.

**Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын төрөл, тархац:**

Сүүлийн жилүүдэд БНХАУ, ОХУ болон Зүүн өмнөд Азийн орноос амфетамин, метамфетамин төрлийн болон мансууруулах ургамлын гаралтай бодисыг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан гэмт хэрэг, зөрчлийн тоо ихсэх болсон бөгөөд цагдаа, хил, гаалийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээс үзэхэд БНХАУ-аас ихэвчлэн амфетамин, метамфетамин төрлийн мөс (ICE) болон мансууруулах ургамлын гаралтай шавар (Hashish), ОХУ-аас сэтгэцэд нөлөөт анданте зэрэг эм хууль бусаар нийлүүлэх болжээ.<sup>2</sup>

**Онцлох тэмдэглэл:**

Манай орны зарим нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах болон донтуулах үйлчилгээтэй бодис бүхий ургамал болох намуу, зэрлэг олс, зээргэнэ, лантанз зэрэг 9 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйл ургамал нь манай улсын 14 аймгийн 49 гаруй сумын нутаг дэвсгэрт 15,000 орчим га талбайд ургадаг гэсэн судалгаа байдаг бөгөөд түүнийг механик аргаар устгахад 1 га талбайд гарах зардлыг 53,300 төгрөг, химийн аргаар устгахад 40,300 төгрөг тус тус байхаар холбогдох мэргэжлийн байгууллагаас тооцон гаргасан боловч төсөв, санхүүгийн байдлаас шалтгаалан дээрх төрлийн ургамлыг устгах ажил хангалтгүй хийгдэж ирсэн.

Хар тамхины төрлийн мансууруулах бодис нь хүний биеийн бодисын солилцоонд орж эхэлснээр янз бүрийн хариу үйлдэл үзүүлэх бөгөөд тайвшрах, баяр баясал, сэтгэл хөөрөл зэргийг бий болгодог нь маш богино хугацаанд бие махбодь болоод сэтгэл зүйгээрээ хараат болох үндсэн шалтгаан болдог нь хэрэглэгч дээрх мэдрэмжийг дахин дахин мэдрэхийг

хүссэнээр мансууруулах бодисноос хараат болсны илрэл болдог.

Хэрэглэгч нь эрүүл ухаанаар сэтгэн бодох чадваргүй болж мансууруулах эм, бодис хэрэглэхгүйгээр энгийн хүн шиг байх боломжгүй мэт сэтгэгдэл төрөхийг сэтгэцийн хараат байдал гэж хэлдэг бол бие махбодын хараат байдлыг тухайн бие махбодод сэтгэл санаа хямрах, айх, бусдаас өөрийгөө тусгаарлах, амиа бодох, өөртөө итгэлгүй болох, хүсэл мөрөөдөлгүй болох гэх мэт зөвхөн мансууруулах эм, бодисыг хэрэглэхийг бие махбод шаарддаг байна.

## 1.2 Мансууруулх эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт, хэрэглээ нийгэмд үзүүлэх нөлөө

Манай улсын хувьд цахим хэрэглээ, хэвлэл мэдээллийн хараа хяналт сул байдгаас аливааг бүрэн гүйцэт шүүн тунгаах насанд хүрээгүй өсвөр насны хүүхдүүд нийгмийн гаж үзэгдэл болох мансууруулах эм бодис, ургамлыг сонирхон хэрэглэж үзэх, түүндээ донтох цаашлаад амь насаа алдах, буруу хүмүүсийн гарт орох зэрэг өөрийгөө аюул луу хөтлөх тортигтой замын нэг нь цахим хэрэглээ гэж үзэж байгаа юм.

Манай орны хувьд цөөн хүн амтай бөгөөд өсвөр насны хүүхдүүд болоод залуучууд хүн амын дийлэнхийг эзэлдэг бөгөөд энэ төрлийн гэмт хэргийг өөгшүүлж эсхүл хатуу урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүй бол цаашлаад монгол улсын аюулгүй байдалд ноцтой хор уршиг учруулах юм.

Мөн түүнлэн сүүлийн жилүүдэд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой сошиал мэдээлэл их байгаа нь хүүхдүүдийн сонирхлыг ихэд татаж байгаа юм. Хүүхэд өсвөр насныханы дунд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, эрсдэлийн талаарх ойлголт мэдлэг, урьдчилан сэргийлэх арга замын талаарх мэдлэгтэй хүүхдийн тоо их боловч түүнийг танин мэдэх болоод өөрийгөө хамгаалах талаар ойлголт нь дутмаг байгаа юм.

Та мансууруулах бодисын талаарх мэдээллийг хаанаас авсан бэ?




График: 2

Өсвөр насны хүүхдүүдийн дунд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой мэдээллийг хаанаас авдаг талаар холбогдох байгууллагын ЕБС-ийн сурагчдаас авсан судалгаанаас харвал:

Судалгаанд оролцогчдын хувьд энэ төрлийн бодисын талаар ер нь сонсдог 37%, заримдаа сонсдог 41%, маш их сонсдог 18% бол огт сонсоогүй 4% байна. ЕБС-ийн сурагчдын 96% нь мансууруулах бодисын талаар мэдээлэлтэй байна /График 3/. Судалгаанд оролцогчдын 28% нь мансууруулах бодисын талаарх мэдээллийг телевиз, киноноос, 27% нь интернэт, 15% сонин сэтгүүл, 10% нь гэр бүл хамаатан садан, 12% нь найз нөхдөөс мэдээлэл

авсан гэсэн бол 4% нь энэ талаарх мэдээлэл огт аваагүй байна.

Таны бодлоор хүүхэд, өсвөр үеийнхний дунд энэ төрлийн бодисын хэрэглээ ямар түвшинд байдаг гэж үзэж байна вэ?




График: 3

Судалгаанд оролцогчдын 41% нь мансууруулах бодисын хэрэглээ өсвөр үеийнхний дунд түгээмэл байдаг, 15% нь маш түгээмэл, 20% нь мэдэхгүй, 13% нь бага, 5% нь маш бага, 6% нь түгээмэл бус байдаг гэж үзжээ.<sup>2</sup>

Энэ хоёр судалгааны дүнгээс харвал ерөнхий боловсролын сурагчид ихэнх мэдээллийг өөрт хамаарал бус цахим сүлжээ, хэвлэл мэдээлэл, бусдын дам ярианаас сонсдог бөгөөд энэ төрлийн бодис хэрэглэйн хэрэглээ 41% буюу маш түгээмэл байна гэдэг маш том аюулын улаан гэрэл болоод байгаа юм. Ерөнхий боловсролын

<sup>2</sup> “Хүүхэд, өсвөр насныхны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист автах эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” криминологи судалгааны тайлан.

сургуульд энэ талаар мэдлэг олгодог, урьдчилан сэргийлэх арга замын талаар заах сургах боловсролын систем байхгүй бөгөөд энэ нь бусдын буруу ятгалаганд орох нэг нөхцөл байдлыг бий болгож өгч байна гэж үзэж байна.

### **1.3 Өсвөр үе, залуусын ирээдүйг бүрхэж буй бараан сүүдэр ба газ үнэртэх гаж зуршил**

Ахуйн газ, будаг шингэлэгч зэрэг дэгдэмхий уусгагч бодист донтох тохиолдол нэмэгдсээр буй. Бидний дэргэд оршдог ч тэр бүр өнгийж харж, ойлгохыг хүсдэггүй, том болсон гэж бодон яриаг нь сонсолгүй өнгөрөөдөг өсвөр насныхан энэ төрлийн гаж зуршилд автах нь элбэг аж.

Өсвөр үеийн хүүхэд, залуус газ үнэрлэж байгаад түлэгдэж Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн Түлэнхийн тасагт гүн шархаа эмчлүүлж, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд донтох эмгэгээ гэж ядан тийчлэн нойргүй хонож, Цагдаагийн байгууллагад “нас барсан” хэмээн бүртгэгдэх шалтгаан нь ердөө л ахуйн газ. Энэ бол хийсвэрлэл биш. Бодит байдал. Өнгийгөөд нэг харъя. Дэлхийг цочроосон коронавирусийн улмаас нэг ч хүн нас барсан тохиолдол Монголд гараагүй байна. Харин ахуйн газ үнэрлэж байгаад амь насаа алдсан гашуун тохиолдол жил бүр чих дэлссээр буй.

Газ үнэрлэх нь сэтгэц болон бие махбодид ямар нөлөө үзүүлдэг бол?

Энэ төрлийн бодис хэрэглэх нь сэтгэц болон бие махбодид маш их хор хөнөөлтэй. Газ үнэрлэсэн хүүхэд түр зуур сэтгэл хөөрсөн жаргалтай мэдрэмжийг авдаг. Хэсэг хугацааны дараа хэвийн байдалд ордог ч дахин сэтгэл санаа нь хямрахад өмнөх сайхан мэдрэмжээ авч тайвшрах зорилгоор хэрэглэхийг хүснэ. Донтолт ингэж эхэлдэг.

Дэгдэмхий уусгагч бодисыг олон дахин хэрэглэснээр сэтгэцийн хараат байдал үүсдэг. Үүнээс гадна бие махбодь маш хүчтэй хордлогод орно. Дэгдэмхий уусгагч бодис амьсгалын төвийг дарангуйлдаг. Хүүхэд тэр дороо амьсгалж чадахгүй болно. Энэ шалтгаанаас болж нэлээд хэдэн хүүхэд хорвоогийн мөнх бусыг үзсэн тохиолдлууд ч бий.<sup>3</sup>

Гэр бүлийн орлогын түвшинг хүүхдүүдийн донтолын хувьтай харьцуулсан нарийн судалгаа байхгүй ч ерөнхийд нь харвал дундаж болон дунджаас доогуур түвшиний амьдралтай хүүхдүүд энэ төрлийн бодист донтох нь элбэг байдаг. Газ хямд үнэтэй, олдоч ихтэй байдаг. 18-аас доош насны хүүхдэд газ худалдаалахгүй гэх шийдвэр байдаг ч хэрэгждэг эсэх нь тодорхойгүй. Томоохон худалдааны төвүүд хүүхдэд газ худалддаггүй. Хариуцлагатай хандаж байгаа харагддаг. Харин захын хорооллын хүнсний дэлгүүрүүд бол хяналтгүй зардаг. Ашиг олох гэсэн жижиг зүйлд төвлөрөлгүйгээр Монголын ирээдүй хойч болсон хүүхдүүдээ чин сэтгэлээсээ анхаарал тавьж хандах хэрэгтэй.<sup>4</sup>

#### ***НЭГ ЗҮЙЛД ДОНТВОЛ ӨӨР ОЛОН ЗҮЙЛД ДОНТОХ ЭРСДЭЛ НЭМЭГДДЭГ***

Энэ төрлийн бодисыг хэрэглэж эхэлснээр хэрэглэгч нь борлуулагч болох боломжтой бөгөөд их хэмжээгээр олон хүнд худалдах, олсон ашиг орлогоороо хэмжээг дахин нэмэгдүүлэн худалдан авах, зарах, тухайн хүн өөрөө хэрэглэх цаашлаад мансууруулах бодисын бүрэн хамааралтай болсноор хэрэглэхээ больж чадахгүй байх бөгөөд бага хэмжээгээр ч хамаагүй худалдан авахын тул эд хөрөнгөө зарах, өр зээл тавих, дээрэм хийх гэх мэт юу ч хийхээс буцахгүй болдог байна.

#### **Онцлох тэмдэглэл:**

Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж буй гэмт хэргийн статистик мэдээллээс харахад өсвөр насныхан, залуучууд энэ төрлийн гэмт хэрэгт ихээхэн холбогдож байна. Нийт шалгагдаж байгаа хүмүүсийн 90 орчим хувийг 18-35 насны хүмүүс эзэлж байна.

Шалтгаан нөхцөлийг судлахад өсвөр насны хүүхэд залуучууд бусдыгаа даган дуурайж, найз нөхдийн хүрээлэл дунд гадуурхагдахаас эмээж, зугаа цэнгэлийн үед сэтгэл хөдлөлдөө автаж, нэг нь нөгөөгөө ятгаж хамгийн анх хар тамхи хэрэглэсэн байгаа юм.

<sup>3</sup> <https://ncmh.gov.mn/>

<sup>4</sup> Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн эмч Л. Цэрэндолгор



Хар тамхины төрлийн бодисууд харилцан адилгүй үнэ, ханштай байдаг. Мэдээж тэр бол хар зах зээлийн үнэ ханш. Хар тамхитай тэмцэх газарт бүртгэгдэж байгаа гэмт хэргүүдэд судалгаа хийж үзэхэд нийгмийн янз бүрийн давхаргын хүмүүс энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж байна. Хар тамхи бол баячуудын хэрэглээ гэсэн ойлголт ард хоцорсон.<sup>5</sup>

Энэ жил бүртгэгдсэн нийт холбогдогч нарын 62 орчим хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс эзэлж байна.<sup>6</sup> Хар тамхины наймааг бизнес гэж хэлж болохгүй, аливаа бизнес нийгэм, олон түмэнд тодорхой үр өгөөжтэй, ач тусаа өгдөг байх ёстой гэж боддог. Хар тамхины наймаа бол амин хувиа хичээсэн хүмүүсийн улс үндэстнийхээ эсрэг явуулж буй үйл ажиллагаа гэж ойлгох хэрэгтэй юм шиг.

Газны худалдаа ба тусгай зөвшөөрөл хяналт шалгалт: МХЕГ-аас газны худалдаанд ямар хяналт тавьдаг талаар лавлахад “Дэлгүүр худалдааны төвд борлуулж байгаа газны бүрэн бүтэн, аюулгүй байдалд хяналт тавьдаг. Түүнээс газ худалдаалах тусгай зөвшөөрөл байдаггүй. Бүх салбарт ашигладаг газ буюу шингэрүүлсэн шатдаг хийний тоног төхөөрөмж, хадгалах нөхцлийг иргэдийн гар дээр очихоос өмнө төлөвлөгөөт юм уу, төлөвлөгөөт бус шалгалт хийдэг”<sup>7</sup> гэсэн байх бөгөөд өнөөдөр 2021 онд ч бага насны, өсвөр насны хүүхдэд газ худалдаалахыг хоринлосон тухай 2012 оны НИТХ-ын “Худалдаа үйлчилгээний нийтлэг журам”-д тусгасан боловч бодит амьдрал дээр “Би 9 настай дүүгээ газ аваад ир гээд дэлгүүр оруулахад хэсэг хугацааны дараа гартаа газ барьсаар дэлгүүрээс гарч ирж байна.” Бидний хэлдэгчлэн цаасан дээрх эрэн бичиг, эрэн бичиг биш амьдрал дээр хэрэгжиж эхлэх үед хууль болдог гэдэг. Нөгөө талаас энэ төрлийн хариуцлагагүй ашиг бодсон худалдааны байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлах хариуцлага оруулах эсхүл торгуулийн арга хэмжээ авдаг ч юм уу энэ байдлаар хүлээлгэх хариуцлагыг чанга гэхээсээ илүүтэйгээр тасралтгүй хяналттай байвал цаасан дээрх хэм хэмжээний зохицуулалт биеллээ олж өсвөр насныхаа хүүхэд багачуудыг энэ төрлийн гэмт хэрэгт ирээдүйд өртөхгүй, автахгүй, донтохгүй байх нэг алхамыг хийж байгаа мэт санагдах байна.

## **2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг Монгол улс дахь эрх зүйн орчин**

### **2.1 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн талаарх эрх зүйн орчин**

Онцлох тэмдэглэл:

Өнөөдрийн байдлаар дэлхийн 58 улс цаазын ялтай байгаа бөгөөд тэдгээрээс 32 улс нь хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргүүдэд цаазаар авах ял шийтгэл оногдуулж байна.<sup>8</sup>

Монгол Улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн сүүлийн үеийн статистик тоон судалгаанаас үзэхэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан “Цагаан тахал” хэмээн нэрлэгддэг Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоо урьд оныхоос 78 хувиар өсч, холбогдсон этгээдүүдийн 50-иас дээш хувийг 16-35 насны хүмүүс эзэлж, энэ гэмт хэрэг, зөрчилд өсвөр насны хүүхэд, оюутан, сурагчид нэлээдгүй өртөж байгаа нь манай нийгэмд тулгамдсан асуудлын нэг болоод байгаа билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор баталсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах хүрээнд Прокурорын байгууллага “..Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх ажилд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан удирдан зохион

<sup>5</sup> <https://dnn.mn>

<sup>6</sup> ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын Эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Мандухайтайгийн ярилцлага

<sup>7</sup> <https://gogo.mn/r/70noy>

байгуулах” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа билээ.

Нийслэлийн прокурорын газраас 2019-2020 он гараад Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах” гэмт хэрэгт холбогдсон нийт 63 хүнд холбогдох 43 эрүүгийн хэрэгт прокурорын яллах дүгнэлт үйлдэн, шүүхэд шилжүүлжээ. тооцохгүй.<sup>8</sup>

Мансууруулах бодис сэтгэцэд нөлөөт бодистой холбоотойгоор олон улсын гэрээ конвенц хууль эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрэлдсэн байх боловч практик бодит амьдрал дээр биелэл ээ олох тал дээр асуудал тулгарч байгаа юм шиг. Жишээлбэл, Хэн нэгэн А гэх нөлөө бүхий этгээд хил хамгаалах гаальд ажилладаг бөгөөд түүний ар гэрийн асуудал мөнгөний асуудалд тулгарсан энэ үед тэрээр Б, Ө, У гэх хэсэг бүлэг хүмүүсийн хар тамхи дамнуулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэж өгч их хэмжээний мөнгө авна. Ихэнх энгийн иргэдийн мансууруулах бодис хил дамнан орж ирж байгаа шалтгааныг ийнхүү төсөөлдөг бөгөөд зарим нэг талаараа үндэслэлтэй таамаглал юм. Иймд эрх зүйн орчны хүрээнд хэрэглэгчид гэхээсээ илүүтэйгээр нийлүүлэгчид лүү чиглэсэн хяналт тавих хэрэгцээ байна.

Бага насны хүүхдүүдэд ахуйн хэрэглээний газ, асаагуур, чүдэнз гэх мэт мансууруулагч агуулсан эд зүйлийг зарж болохгүй гэсэн НИТХ-ийн 2012оны НИТХ-ын тогтоол байдаг боловч нөгөө л орлого оо бодсон аминч үзлийн ард тухайн бөгөөд иргэний хуулиар бага насны хүүхэд ахуйн чанартай жижиг хэлцэл хийж болно хэмээн заасан байдаг гэхдээ тэдэнд юуг зарж болохгүй зүйл гэвэл зөвхөн алкохолыг л ойлгодог. Энэ нь маш буруу юм. Иймд энэ талаар нэмэн тусгах нь зүйтэй болов уу.

### **3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал криминологи асуудал**

#### **3.1 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлж буй төрийн бодлого**

Хар тамхины гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл нь:

Хар тамхины гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцлийг дараах хэд хэдэн шалтгаантай гэж үзэв. Үүнд:

Цахим орчинд мэдээ мэдээллийн утга, агуулга, хэнд, ямар зорилгоор хүргэж байгаа тухай аль шатны хяналт тавьж байгууллага байхгүй байгаа нь цахим орчин цацагдаж буй худал, хууль бус мэдээ мэдээлэл, зар сурталчилгаа зэрэг нь өсвөр үеийнхний оюун санаа, зан төлөвт сөргөөр нөлөөлөх болсон нь энэ төрлийн гэмт хэрэг гарах шалтгаан болж байна.

Урлаг, соёл, спортын одуудын дунд хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх замаар урлагийн тоглолт, спорт, соёлын арга хэмжээний үеэр бие махбодь, сэтгэл зүйн өндөр ачаалалтай ажилладгаас хүчээ сэлбэх, онгодоо дэвэргэх зорилгоор хар тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг болох нь нэгэнт тогтоогдсон зүйл юм.

#### **Онцлох тэмдэглэл:**

Сэлэнгэ аймгийн 12 дугаар ангийн сурагчийн нэмэлт ярилцлагын тэмдэглэлээс: (эрэгтэй) Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумаас 9 км зайд ургадаг. Хүмүүс түүж аваад кг нь 12000-аар зардаг. Сумын төвөөс хол цагдаа байдаггүй учраас хүмүүс түүж зарах нь элбэг байдаг. Хатаасан өвс нь илүү үнэтэй байдаг. Мөн үндсээр нь авч зардаг.

Ажилгүйдэл, ядуурлаас шалтгаалан амьдралын эх үүсвэргүй манай зарим залуучууд амар хялбар аргаар мөнгө олох, хуримтлуулах зорилгын үүднээс гадаадын хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой хэд хэдэн улсын хил дамнасан үйл ажиллагаа явуулдаг зохион байгуулалттай бүлэглэл гэдгийг мэдсээр байж тэдний сүлжээнд орж, ялангуяа хил дамжуулан зөөвөрлөх үйл ажиллагааны идэвхтэй гар хөл

<sup>8</sup> Эрүүгийн хуулийн 20-р бүлэг “Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг”-ийн 20.7 дугаар зүйл.

болж ашиглагдах, өөрсдийн энэ хууль бус ажиллагаанд гадаадад ажиллаж сурч буй иргэд, биеэ үнэлэгч нарыг татан оруулах явдал энэ төрлийн гэмт хэрэг даамжрах нэг шалтгаан болж байна.

Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийг төрөөс хянах, илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх үйл ажиллагааны дутагдал, энэ сөрөг үзэгдэлтэй хийх тэмцлийг зохицуулж буй хууль тогтоомжийн хийдэл, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг зүйлчлэх ажиллагааны дутагдал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх мэргэшсэн байгууллагын бүтэц, алба хаагчгүй явж ирсэн бодит байдал, түүнчлэн хар тамхи, мансууруулах бодист хяналт тавих, тухайлбал, шинжлэн илрүүлэх байгууллагуудын техник, тоног төхөөрөмжийн хангалт муу, хүчин чадал нь өнөөгийн шаардлагаас хоцрогдсон зэрэг нь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, зарим талаар нөлөөлж буй нөхцөл юм.<sup>9</sup> Эдгээрийн дотроос Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн хийдэл, хэрэглэх явцад учирч буй хүндрэлийг тусгайлан авч үзэх шаардлагатай.

Байгалийн жамаар ургаж байгаа каннабисыг их бага янз бүрийн хэмжээгээр түүж аваад, цайруулж, ургамлаас нь мансууруулах хүч ихтэй цэцэг, давирхайг нь салгаж аваад, дараа нь өөр төрлийн эм, химийн бодистой хольж үнэрлэх, тамхинд хольж утааг уушиглан сороход бэлтгэсэн үйлдлүүдийг бэлтгэх, үйлдвэрлэх гэж 2 обьектив шинжээр нь салгаж эрүүгийн хуулинд хуульчлаагүй нь энэ төрлийн гэмт хэргийг байгалийн жамаар ургаж байгаа ургамлыг олж авсан гэдгээр зүйлчилж, гэмт этгээдэд ял завшуулах, улмаар гэмт хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаагаар шийдвэрлэхэд шууд ба шууд бусаар сөрөг нөлөө үзүүлж байна.<sup>10</sup>

Манай орны төвийн болон баруун бүсийн аймгууд, тухайлбал, Сэлэнгэ, Дархан-Уул, Эрдэнэт, Завхан, Ховд аймгуудад олсны /каннабисын/ зэрлэг ургамал ургадаг нь судалгаагаар нэгэнт тогтоогдоод байхад хууль сахиулах болон мэргэжлийн хяналтын байгууллагаас эдгээр бүс нугийг хяналтдаа авах, ийм ургамлыг зохион байгуулалттайгаар устгах ажиллагаа хийдэггүй, нэг үгээр хэлбэл, зөнд нь орхисон явдал энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан юм.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг нэвтрүүлэх хил боомтыг тогтоож, шинжилгээ судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт, тэдгээрийг ашиглах журам, байгууллагын жагсаалт, зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгах журмыг Засгийн газрын тогтоолоор батлан мөрдүүлж байгаа боловч тэдгээрийн хэрэгжилтэнд тавих хяналт суларсныг далимдуулан сүүлийн үед иргэд ямар ч хяналтгүйгээр охид бүсгүйчүүдийн турах, галбиржих гэсэн сонирхол дээр дөрөөлөн ОХУ, БНХАУ-аас хар тамхины найрлагатай эмийг оруулж ирэн, хар зах дээр гар дээрээс хямд үнээр борлуулж байгаа нь мансуурч донтогчдыг бий болгож байна. Эм борлуулах байгууллага, эмийн сангууд болон эм борлуулах ажиллагааг төрийн хяналтаас гаргасан улс орон аажимдаа хар тамхи, мансууруулах бодисын далайд живж сүйрдэгийг амьдрал харуулсаар байна.

Манайд эм бэлдмэлийг иргэдэд хууль бусаар борлуулдаг, үйлчилдэг эмч, эмийн сангуудын холбоо бүлэглэл үүсч, ашиг орлого олох, нэмэгдүүлэх эх сурвалж болсоор удаж байна. Жишээ нь, Манай төрийн мэдлийн болон хувийн эмэгтэйчүүдийн зарим эмч нар өвчин эмгэгийг оношлоод эмийн жор бичээд, тодорхой эмийн сангаас авахыг зөвлөдөг. Нэг ёсны сүлжээ бий болсон нь нууц биш юм.

Мансууруулах болон сэтгэцэд идэвхт эм бодисын хууль бус хэрэглээнээс сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагаанд нийгэм, хамт олны оролцоо

<sup>9</sup> <https://customs.gov.mn/2012-03-14-03-21-37/2014-03-24-06-25-31/2015-02-04-06-28-11/902-2017-10-18-04-40-07>

<sup>10</sup> <https://mojha.gov.mn/newmojha/?p=1486>

туйлын хангалтгүй, донтогчид, мансуурагчдын оношлогоо эмчилгээ, хяналт, нөхөн сэргээлт, хөдөлмөр зохицуулалт нийгмийн халамжийн үйлчилгээ хөрөнгө мөнгөний гачаалаас болоод бүрэн шийдэгдээгүй, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, нэгдсэн зохицуулалтгүй явж ирсэн бодит байдал нь энэ төрлийн гэмт хэрэг ихсэх шалтгаан юм.<sup>11</sup>

#### 4. Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис хууль бус эргэлтийн хяналт

##### 4.1 Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн гаралт

2020-2021 он бол Монгол төдийгүй дэлхий дахинд маш хүндхэн цаг үеүүд байгаа бөгөөд Ковид-19 халдварт цар тахал өвчин гарсантай холбогдуулан нийгмийн бүхий л салбарт өөрчлөлт шинэчлэлт гарсан бөгөөд эрүүгийн салбарт зарим төрлийн гэмт хэрэг буурсан бол гэр бүлийн хүчирхийлэл, залилангийн гэмт хэргийн гаралт ихэссэн байна.

Үүний мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт, хэргийн гаралт багассан боловч хөл хориотой үед 3 сарын хугацаанд улсын хэмжээнд 28 гэмт хэрэгт анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэж ял шийтгэл авсан байна. /Хүснэгт: 1/

Хүснэгт: 1 Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөлөх эм, бэлдмэл бодистой холбоотой хэргийн судалгаа /2021/1/1- 2021/4/1

№	Он, сар	Зүйл, анги	Аймаг, дүүрэг	Хүний тоо	Оноосон шийтгэл
1.	2021 он, 1 сар	20.7.1	Баянзүрх дүүрэг	1	1 жил тэнсэн
2.	2021 он, 1 сар	20.7.1	Баянзүрх дүүрэг	2	1 жил хорих 1 жил 6 сар хорих
3	2021 он, 1 сар	20.7.1	Чингэлтэй дүүрэг	1	1 жил 6 сар хорих
4	2021 он, 1 сар	20.7.1	Баянзүрх дүүрэг	1	1 жил 6 сар хорих
5	2021 он, 1 сар	20.7.1	Баянзүрх дүүрэг	1	2 жил хорих
6	2021 он, 1 сар	20.7.1	Сонгинохайрхан дүүрэг	1	1 жил хорих
7	2021 он, 1 сар	20.7.1	Баянгол дүүрэг	2	1 жил хорих
8	2021 он, 1 сар	20.7.1	Баянгол дүүрэг	1	1 жил хорих
9	2021 он, 1 сар	20.7.3.3	Сүхбаатар дүүрэг	2	3 жил, 7 сар хорих
10	2021 он, 1 сар	20.7.1	Төв аймаг	4	1 жил хорих 1 жил 6 сар хорих
11	2021 он, 1 сар	20.7.1	Дорнод аймаг	3	2 жил тэнсэн
12	2021 он, 1 сар	20.7.1	Баянзүрх дүүрэг	1	1 жил 6 сар хорих
13	2021 он, 1 сар	20.7.1	Хан-Уул дүүрэг	2	1 жил хорих
14	2021 он, 1 сар	20.7.1	Сонгинохайрхан дүүрэг	1	1 жил хорих
15	2021 он, 1 сар	20.7.1	Сонгинохайрхан дүүрэг	1	1 жил хорих
16	2021 он, 2 сар	20.7.1	Хан-Уул дүүрэг	1	1 жил 2 сар
17	2021 он, 2 сар	20.7.1	Сонгинохайрхан дүүрэг	1	1 жил 3 сар
18	2021 он, 2 сар	20.7.1	Баянгол дүүрэг	2	1 жил хорих 2 жил хорих
19	2021 он, 2 сар	20.7.1	Сонгинохайрхан дүүрэг	1	1 жил хорих
20	2021 он, 2 сар	20.7.1	Хан-Уул дүүрэг	1	1 жил хорих
21	2021 он, 2 сар	20.7.1	Баянзүрх дүүрэг	2	1 жил хорих
22	2021 он, 2 сар	20.7.1	Баянгол дүүрэг	1	2 жил хорих
23	2021 он, 2 сар	20.7.1	Баянзүрх дүүрэг	1	1 жил хорих
24	2021 он, 3 сар	20.7.1	Сүхбаатар дүүрэг	4	3 жил зорчих эрхийг хязгаарлах 2 жил 6 сар тэнсэн
25	2021 он, 3 сар	20.7.1	Баянзүрх дүүрэг	1	1 жил 6 сар хорих
26	2021 он, 3 сар	20.7.1	Баянгол дүүрэг	1	1 жил тэнсэн
27	2021 он, 3 сар	20.7.1	Баянгол дүүрэг	1	1 жил 1 сар хорих

<sup>11</sup> <https://docs.google.com/presentation/d/1Ck1YFIU-UHbBVqaknVMoMoHx8dNBTji72IXz1EtVIRw/htmlpresent>

28	2021 он, 3 сар	20.7.1	Хан-Уул дүүрэг	2	1 жил хорих
----	----------------	--------	----------------	---	-------------

Дээрх хүснэгтээс харвал: 2021 он гарснаас хойших 3 сарын хугацаанд 2, гэмт хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэж тэдний 28 хэрэгт нийт 43 хүн холбогдож ял шийтгэл авсан байна. Үүний 26 хэрэг нь нийслэлд гарсан бөгөөд үүнээс БЗД-8 хэрэгт 10 хүн, СХД-5 хэрэгт 5хүн, БГД-6 хэрэгт 8 хүн, ХУД-4 хэрэгт 6 хүн, СБД-2 хэрэгт 6 хүн, ЧД-1 хэрэгт 1хүн холбогдсон бол хөдөө орон нутагт буюу аймгуудаас Дорнод аймаг- 1 хэрэгт 4 хүн, Төв аймаг- 1 хэрэгт 3 хүн холбогдсон байна.

Ял шийтгэл оногдуулсан байдлыг харвал тэнсэн- 3; 1 жил түүнээс дээш хугацаагаар хорих ял оноосон 21; 2 жил түүнээс дээш хугацаагаар хорих ял оноосон нь 5 байна.

#### **4.1 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

Мансууруулах бодисын хэрэглээ болон түүнээс үүдэн гарах гэмт хэрэг гаралт ноцтой хэмжээнд байгааг хүлээн зөвшөөрч нийгмийн тулгамдаж буй асуудлуудын нэг гэж үзэх шаардлагатай байгаа бөгөөд дан ганц ял шийтгэл, арга хэмжээ авах биш төр түүний бодлогыг хэрэгжүүлэгч агентлаг судалгаа, бодлогыг боловсруулан оновчтой шийдвэр гаргаж, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэний оролцоог бийг болгон хамтран ажиллах нь чухал юм. Дэлхий нийт цахим сүлжээг түлхүү ашигладаг болсон энэ үед манай улсад цахим орчинд мансуурах бодис түүний хэрэглээ бие болоод сэтгэцэд үзүүлэх нөлөө түүнээс үүдэн гарах эрсдлүүдэг насны ангилалд зориулсан сэрэмжлүүлэг, зөвлөгөө мэдээллийг контент, комик гэх мэт янз бүрийн төрлөөр таниулах бүрэн боломжтой байна.

Манай улсад ихэнх тохиолдолд ахуйн хэрэглээнээс мансуурах, сэтгэцэд нөлөөлөх газ, цавуу үнэрлэх нь өсвөр насныхны дунд их байгаа бөгөөд энэ байдлыг зогсоохын тулд хяналттай худалдан авалт, худалдааг хийх шаардлагатай байна. Бага насны хүүхдэд газ худалдаалахгүй байх, үүнийг бодит хяналтаар баталгаажуулж худалдаа хийсэн тохиолдолд ААН-ийг холбогдох хуулиар торгох, үйл ажиллагаа явуулах эрхийг цуцлах зэргээр шийдвэрлэх боломжтой бөгөөд нөгөө талаас эцэг эхийн хараа хяналтыг нэмэгдүүлж, анхааруулах сургууль, эцэг эх, сурагчийн гуравласан гэрээнд эцэг эх, сургуулийн үүргийг нэмэгдүүлж сургалтаар дамжуулан урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Мөн мансууруулах төрлийн бодис, сэтгэцэт нөлөөт эм бэлдмэлийн түүхий эд болдог ургамлын төрлүүд ургадаг бүс нутгийн захиргаа анхаарал хандуулж, ургамал өвсийн ургалтыг зогсоох, устгах тал дээр арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй. Түүнчлэн тухайн ургамалын ургалтын талбайнаас мансууруулах төрлийн ургамлын олборлолт буюу өвс, ургамлыг түүж, бэлтгэж байгаа иргэдийг илрүүлэх тал дээр ажиллаж, тарьж ургуулж түүхгүй байх тал дээр хараа хяналт тавих тухайн бүс нутаг талбайг хяналтанд авах, камержуулах, тухайн ургамлыг үндсээр нь устгах гэх мэт аргуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

## **ДҮГНЭЛТ**

Энэ төрлийн гэмт хэрэгт оноох ялын хэмжээ бага байх бөгөөд ихэнх нийгмийн хандлагаас харвал хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт хүмүүс бага ял оноход дургүйцэх хандлага их байдаг. Гэтэл энэ төрлийн гэмт хэрэг бусдыг өөртөө урвуулан нэгдүүлэх, бусдыг уруу татаж гэмт хэргийн гаралтыг ихэсгэх хандлагатай мөн ирээдүй болсон хүүхэд багачуудад буруу үлгэр дууриалал болсон нийгмийн хор аюул ихтэй гэмт хэрэг юм.

Хүний эрх, эрх чөлөөг тууштай хамгаалах явдал нь юуны өмнө хүний эрх зөрчигдсөн тухай асуудлыг шалгаж, шийдвэрлэхдээ зөрчигдсөн эрхийг бүрэн дүүрэн сэргээн эдлүүлэх хамгийн үр дүнтэй арга замыг тодорхойлж, ажиллахыг хэлдэг. Хууль тогтоогч, бодлого

боловсруулагчид гаргаж буй шийдвэрийнхээ үр дагаврыг бүх талаас нь сайтар нягталж, хэлбэрийн төдий бус, асуудлыг аль болох бүрэн төгс шийдвэрлэх боломжтой шийдлийг олох нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх хамгийн том хүчин зүйлс болно. Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд заасан хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг боловсронгуй болгосноор хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх арга зам тодорхой болно гэж үзэж байна.

### ЭХ СУРВАЛЖ

1. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
2. УБ 2013 он, “Монгол улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл” судалгааны тайлан
3. “Хүүхэд, өсвөр насныхны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист автах эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” Кримнологи судалгааны тайлан
4. Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн эмч Л. Цэрэндолгор
5. ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын Эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Мандухайтайгийн ярилцлага
6. Эрүүгийн хууль
7. <https://docs.google.com/presentation/d/1Ck1YFIU-UHbBVqaknVMoMoHx8dNBTji72IXz1EtVIRw/htmlpresent>
8. <https://ncmh.gov.mn/>
9. <https://gogo.mn/r/70noy>
10. <http://www.vienna.embassy.mn/index.php?moduls=15>
11. <https://www.facebook.com/CriminologyMN/photos/a.448543415543965/1046199729111661/>
12. [https://shuukh.mn/single\\_case/](https://shuukh.mn/single_case/)
13. <https://mojha.gov.mn/newmojha/?p=1486>



## ILLEGAL CIRCULATION OF NARCOTIC DRUGS AND PSYCHOTROPIC SUBSTANCES: A CRIMINOLOGICAL PERSPECTIVE

*Jambalsuren R.*

*LL.M. candidate of, School of Legal and Social Sciences,  
University of Internal Affairs of Mongolia*

### **ABSTRACT:**

Although democracy in Mongolia is moving closer to the realization of human rights and freedom in the true sense, it is a crime to use rights and freedom as a shield against negative social phenomena and there is an issue of concern that the conflict is increasing and will continue to increase. Unfortunately, few people understand and realize that “My rights are limited by the rights of others” among today’s youth who shout that what they use is my right and what they choose is my right.

Crimes related to narcotic drugs and psychoactive substances are often carried out secretly and covertly. Over the years, the types of drugs are increasing and changing, and they are directed toward the younger generation of society. It is a matter of national security for Mongolia, where youth make up 75% of Individuals has rights and freedoms granted by the constitution, but it does not mean that those rights and freedoms encourage crime and social anomalies.

The use of drugs and psychoactive substances is a real threat to the national security of any country because it harms the health, safety, development and upbringing of not only individuals, but also it is a concern for the entire nation.

### **KEYWORDS:**

Drug, Psychotropic, Teenagers, National security, Household gas for use and sale

## NULLUM CRIMEN SINE LEGE ЗАРЧМЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ТУСГАГДСАН БАЙДАЛ, ШҮҮХИЙН ПРАКТИК: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



Б.Батбаяр  
УДШ-ийн дэргэдэх ШССМХ-ийн Эрүүгийн эрх  
зүйн секторын судлаач

### ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүллээр *Nullum Crimen Sine Lege* зарчим нь дэлхийн улс орнуудын Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх үндсэн эх сурвалжуудад хэрхэн тусгагдсан болохыг харьцуулан судалж, улмаар тус зарчмын шүүхийн практикт хэрэглэгдэж буй байдлыг иргэнлэг болон нийтлэг эрх зүйн бүлийн төлөөлөл болох хоёр орны шүүхийн шийдвэрүүдэд тулгуурлан дүгнэж, танилцуулсан болно.

### ТҮЛХҮҮР ҮГС:

Хууль ёсны зарчим, Бичмэл хууль, Эрүүгийн хууль буцаан хэрэглэхгүй байх, Эрүүгийн хуулийг явцуу утгаар тайлбарлах, Эрх зүйн тодорхой байдал

### УДИРТГАЛ

Манай улсын Эрүүгийн хуулиудад “хууль ёсны зарчим” хэмээн хуульчлагдсаар ирсэн эрх зүйн сургаалийн онолын суурь нь *Nullum Crimen Sine Lege*, *Nullum Poena Sine Lege* гэх ихэр зарчмууд юм. Хуульчлагдсан зарчим болохын хувьд салбар эрх зүйн хүрээнд эдгээр зарчмууд багагүй судлагдсан ч тус бүрд нь агуулгыг нь нэг бүрчлэн уудалж, шүүхийн практиктай уялдуулан судалсан бүтээлтэй хараахан тааралдсангүй. Нөгөөтээгүүр энэхүү өгүүлэлд зөвхөн эхний зарчмын хүрээнд хамаарах асуудлуудыг товч, тодорхой байдлаар танилцуулахдаа хууль тогтоомж, шүүхийн практикт тулгуурлан хууль хэрэглээний төлөв байдлыг нь хөндөж, харуулахыг зорьсон. Ингэхдээ тус зарчмуудын амин сүнснийг хууль хэрэглээнд чадварлаг амилуулсан дотоодын шүүхийн шийдвэрүүдийг гадаадын сонгодог шийдвэртэй харьцуулах замаар дүгнэж, сурталчлах нь үндэсний эрх зүйн тогтолцоон дахь хууль хэрэглэх арга, зарчмыг боловсронгуй болгон хөгжүүлэхэд жишиг болон үлдэх чухал ач холбогдолтой хэмээн үзсэн болно.

### ҮНДСЭН ХЭСЭГ

#### I. *Nullum Crimen Sine Lege* зарчмын товч агуулга

*Nullum Crimen Sine Lege* зарчим нь Ромын эрх зүй, Грекийн хот улсуудын хууль тогтоомжид тусгагдах замаар аажим хөгжиж, улмаар Сэргэн мандалтын үеийн үзэл санааг

шингээн өнөө цагийн эрүүгийн эрх зүйн суурь зарчмуудын нэг болжээ<sup>1</sup>. Тус зарчим нь НҮБ-ын нийт гишүүн улсуудын 4/5-ийнх нь Үндсэн хуульд бэхжсэн аж<sup>2</sup>. Энэ утгаараа уг зарчмын улс орнуудын эрх зүйн тогтолцоон дахь нөлөө улам өргөжин тэлэх нь тодорхой байгаа юм. Харин дээрх зарчмыг дотоодын эрх зүйн тогтолцоондоо нутагшуулаагүй НҮБ-ын гишүүн 2 улс байгаа нь Бутан, Бруней юм. Энэхүү зарчмын үндсэн агуулга нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хамгаалахад чиглэдэг. Хүний эрх бодитоор хамгаалагдах баталгаа нь тодорхой хүнд холбогдох эрүүгийн хэргийг шүүхээс шударгаар шийдвэрлэх явдал байдаг. Шударгаар шүүх хуралдааныг явуулахын тулд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд уг зарчмын дагуу дараах 4 баталгааг хангуулах ёстой гэж үздэг.<sup>3</sup> Эдгээр баталгаа бүр нь илэрхийлж буй агуулгаараа хүний эрхийг хамгаалахад чиглэсэн амин чухал ойлголтуудыг агуулдаг тул эдгээрийг тусад нь бие даасан зарчим хэмээн үзэж, судалсан бүтээлүүд цөөнгүй байдаг. Гэвч эдгээр 4 баталгаа нь *Nullum Crimen Sine Lege* зарчмын бүрэлдэхүүн хэсгүүд болох тул түүнд үйлчлэх дэд зарчмууд гэж үзэх нь зүйтэй юм.

*Nullum Crimen Sine Lege* зарчмын дэд зарчмууд:

- *Nullum crimen sine lege praeva* гэх дэд зарчим хууль буцаан хэрэглэх явдлыг хориглосон буюу гэмт хэрэг үйлдэгдэх үед түүнийг зүйлчлэх гэмт хэрэг нь маш тодорхой байдлаар эрүүгийн хуульд урьдчилан бичигдсэн байх ёстой гэх агуулгаар илэрдэг.
- *Nullum crimen sine lege stricta* нь эрүүгийн хуулийг өргөжүүлж, төсөөтэй хэрэглэхийг хориглох тухай агуулгатай бөгөөд шүүгчийг эрүүгийн хуулийн тодорхой хэм хэмжээг өргөжүүлэх замаар өөрийнхөө хийдэл гэж үзсэн асуудлыг шийдэх ёсгүй гэж үздэг. Өөрөөр хэлбэл энэ зарчмын дагуу эрүүгийн хуулийг явцуу утгаар нь тайлбарлах шаардлагатай юм.
- *Nullum crimen sine lege certa* нь хүнд оногдуулах ял, шийтгэл нь туйлын тодорхой хуульчлагдсан байхыг шаарддаг. Энэ нь хүмүүст тодорхой гэмт хэрэг үйлдвэл ямар ял шийтгэл хүлээхийг урьдчилан мэдэх боломж олгож байдаг.
- *Nullum crimen sine lege scripta* нь хэрэглэгдэх хууль буюу эрүүгийн хууль зөвхөн бичмэл хэлбэртэй байх бөгөөд заншлын хэм хэмжээ гэх мэт аливаа бичмэл бус хэм хэмжээ нь эрүүгийн хэрэг шийдвэрлэх эх сурвалж болохгүй гэх агуулгатай.

## II. *Nullum Crimen Sine Lege* зарчмын Үндэсний Эрүүгийн хуулиудад тусгагдсан байдал

### Монгол Улс

Эрүүгийн хуулийн (2002) 3 дугаар зүйлд “Хууль ёсны зарчим”-ыг хуульчилсан. Тус зүйлийн 3.1 дэх хэсэгт “Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн энэ хуулиар тодорхойлно”, 3.2 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглоно”. Мөн хуулийн 10 дугаар зүйлд “Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл”-ийг хуульчилж, 10.1-д “Энэ хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулсан хэрэг үйлдэгдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно” хэмээжээ.

Эрүүгийн хуулийн (2015) 1.2 дугаар зүйл “Хууль ёсны зарчим”-ыг хуульчилсан. Тус зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно.” Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй”, 3 дахь хэсэгт “Үйлдэл, эс үйлдэхүйг шинээр гэмт хэрэгт тооцсон, шинээр эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тогтоосон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль энэ хуулийн бүрэлдэхүүн хэсэг болно.” 1.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт шинээр тооцсон, оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх

<sup>1</sup> J.Hall, *Nulla Poena Sine lege*, Volume 47 Yale Law Journal (1937), p.165.

<sup>2</sup> K.S.Gallant, *The Principle of Legality in International and Comparative Law*, (2009), 2nd edition, p.241.

<sup>3</sup> Th.Rauter, *Judicial Practice, Customary International Criminal law and Nullum Crimen Sine Lege*, (2017), p.20.

зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй” хэмээн хуульчилжээ.

#### ХБНГУ<sup>4</sup>

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн (1998)<sup>5</sup> 1 дүгээр зүйлд “Хууль үгүй бол ял үгүй” гэх зарчмыг хуульчилсан. Тухайлбал “тодорхой үйлдлийг зөвхөн үйлдэгдэхээс өмнө хуулиар эрүүжүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” хэмээн тусгажээ.

#### БНФУ<sup>6</sup>

БНФУ-ын Эрүүгийн хуулийн (1992)<sup>7</sup> 111-3 дугаар зүйлд “Хуулиар гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүнийг тодорхойлоогүй бол хэнийг ч гэмт хэрэгт ял шийтгэж үл болно.” “Хуульд заагаагүй гэмт хэрэгт хэнийг ч ял шийтгэж үл болно.(Зөрчлийн тухайд журамд заагаагүй бол зөрчилд хэнд ч хариуцлага тооцож үл болно.)” Мөн хуулийн 111-4 дүгээр зүйлд “Эрүүгийн хууль тогтоомжийг явцуу утгаар тайлбарлаж хэрэглэнэ” хэмээн тус тус заажээ.

#### ОХУ<sup>8</sup>

ОХУ-ын Эрүүгийн хуулийн (1996)<sup>9</sup> 3 дугаар зүйлд “Хууль ёсны зарчим”-ыг хуульчилсан. Тус зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага болон бусад эрх зүйн үр дагавруудыг зөвхөн энэ хуулиар тодорхойлно”. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй.” Тус хуулийн 8 дугаар зүйлд “Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл”-ийг “Энэ хуульд заасан үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бүрэн хангаснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно” хэмээн тусгасан бол 10 дугаар зүйлд “Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх” тухайд “...үйлдэл, эс үйлдэхүйг шинээр гэмт хэрэгт тооцсон, хүнд оногдуулах ялыг ихэсгэсэн, эрх зүйн байдлыг нь дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй” гэж хуульчилжээ.

#### ИБУИНХУ<sup>10</sup>

ИБУИНХУ нь нийтлэг эрх зүйн өлгий билээ. Энэ утгаараа уг зарчмын нөлөө нь тус улсын үндэсний эрх зүйн тогтолцоонд бага туссан гэж үзэх нь бий ч тэртээ 1215 оны Магна Хартын 39 дүгээр зүйлд “Чөлөөт иргэнийг тухайн газрын хууль юм уу үйлдлийг нь хянан магадласан эрх зүйн үр дагавар бүхий шийдвэргүйгээр аливаа эрхийг нь хасаж үл болно”<sup>11</sup> хэмээн уг зарчмын амин сүнснийг тунхагласан байдаг. Лордуудын Танхим 1973 онд шүүхүүдийг “нийтлэг эрх зүйн” гэмт хэргийг шинээр боловсруулах явдлыг албан ёсоор халснаар хуулиар бус шүүхийн шийдвэрээр тодорхойлогдож ирсэн гэмт хэргүүдийг тухайн төрлийн гэмт хэргийн талаар зохицуулсан хуулиар тодорхойлох явдал хурдассан<sup>12</sup>. Өөрөөр хэлбэл тухайн үед зарим гэмт хэргүүд хуулиар тодорхойлогдож байхад бусад нь шүүхийн жишгээр тодорхойлогдож байсан. Мөн бүх төрлийн гэмт хэргийг нэгтгэсэн төрөлжсөн эрүүгийн хууль үгүй тул дээрх зарчмуудыг хуульд шууд тусгаагүй ч хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх үндсэн эх сурвалж нь материаллаг хууль болсон гэдэг утгаараа уг зарчмыг зарим талаар хүлээн зөвшөөрч буй гэж үзэх боломжтой бөгөөд энэ нь тус улсын шүүхийн практикаас харагдаж буй юм.

<i>Nullum crimen sine lege praeva</i>	Монгол Улс, ОХУ,
<i>Nullum crimen sine lege stricta</i>	Монгол Улс (хагас), БНФУ, ОХУ
<i>Nullum crimen sine lege certa</i>	Монгол Улс, ХБНГУ, БНФУ, ОХУ
<i>Nullum crimen sine lege scripta</i>	Монгол Улс, ХБНГУ, БНФУ, ОХУ

<sup>4</sup> Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

<sup>5</sup> ХБНГУ-ын Эрүүгийн хууль, (1998) [German Criminal Code \(Strafgesetzbuch – StGB\) \(gesetze-im-internet.de\)](http://www.gesetze-im-internet.de) [Сүүлд үзсэн: 2022.11.09]

<sup>6</sup> Бүгд Найрамдах Франц Улс

<sup>7</sup> БНФУ-ын Эрүүгийн хууль, (1992) [french penal code.pdf \(unodc.org\)](http://www.unodc.org/french_penal_code.pdf) [Сүүлд үзсэн: 2022.11.09]

<sup>8</sup> Оросын Холбооны Улс

<sup>9</sup> ОХУ-ын Эрүүгийн хууль, (1996) [The Tasks and Principles of the Criminal Code of the Russian Federation \(russian-criminal-code.com\)](http://www.russian-criminal-code.com) [Сүүлд үзсэн: 2022.11.09]

<sup>10</sup> Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

<sup>11</sup> Max Planck Institute for Comparative Public Law and International Law, *Max Planck Encyclopedia of Public International Law*, (2010), p. 3.

<sup>12</sup> Мөн тэнд.

Уг хүснэгтээр уг зарчмуудыг хуульдаа шууд тусгах байдлаар бэхжүүлсэн байдлыг үндэслэж ангилсан төдий бөгөөд энэ нь шүүхийн практикт уг зарчмыг хэрэглэдэггүй гэх санааг илэрхийлээгүй болно.

### **III. Үндэсний шүүхүүдийн практик дахь уг зарчмын хэрэглээ**

#### **Монгол Улс**

#### **Иргэн Т-д холбогдох хэрэг (2011)<sup>13</sup>**

**Шийдсэн шүүх:** Улсын дээд шүүх

**Хэргийн үйл баримт:** Иргэн Т нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ өөрийн нөхөр Б-тэй маргалдсаны улмаас Б нь Т-ийн эсрэг бэлгийн шинжтэй хүчирхийлэл үйлдэж эхлэсэнээр Т нь Б-ийн цээжин тус газар 2 удаа хугталж, хүнд гэмтэл учруулсан.

**Анхан болон давж заалдах шатны журмаар хэргийг шийдвэрлэсэн байдал:** Эрүүгийн хуулийн (2002) 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Т-г “Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон.

**Хяналтын журмаар хэргийг шийдвэрлэх гол асуудал:** Шүүгдэгчийн Т-ийн өмгөөлөгчийн зүгээс түүнийг уг гэмт хэрэгт гэм буруугүй гэж үзсэн. Учир нь хохирогч Б-ийн хийсэн бэлгийн шинжтэй хүчирхийлэл нь Т-д “санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчдах” нөхцөл байдалд оруулсны улмаас уг гэмт хэрэг үйлдэгдсэн бөгөөд Эрүүгийн хуульд (2002) “Санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчдаж хүний бие махбодид хүнд гэмтэл учруулах” гэмт хэрэг байхгүй тул уг хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэх байр суурийг баримталсан. Ингэснээр шүүх Т-ийн санаа сэтгэл хүчтэй цочрон давчдах үедээ тус гэмт хэргийг үйлдсэн бол ийм тохиолдлыг эрүүжүүлсэн эсэх асуудлыг шийдэх шаардлагатай болсон.

#### **Шүүхийн шийдэл ба үндэслэл:**

Шинжээчийн дүгнэлтээр шүүгдэгч Т гэмт хэрэг үйлдэх үед санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчдаагүй байсан гэх дүгнэлт хийсэн боловч шүүхээс шүүгдэгчийн сэтгэлзүйн байдлыг хэрэгт цугласан нотлох баримтыг үндэслэн цочрон давчдах үедээ гэмт хэрэгт үйлдсэн гэж дүгнэсэн. Учир нь санаа сэтгэл хүчтэй цочрон давчдах тухай ойлголт нь хууль зүйн ойлголт учир шүүх шийдвэрлэх эрхтэй гэж үзсэн. Иймээс өмгөөлөгчийн дурдсанчлан Эрүүгийн хуульд (2002) “Санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчдаж хүний бие махбодид хүнд гэмтэл учруулах” гэмт хэрэг байхгүй тул “хууль ёсны зарчим”-ын дагуу шүүгдэгчийг цагаатгаж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдсэн.

#### **Иргэн Р, Л, Э нарт холбогдох хэрэг (2022)<sup>14</sup>**

**Шийдсэн шүүх:** Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

**Хэргийн үйл баримт:** Амь хохирогч нь Р, Л нарын удирдлага дор хамтран ажилладаг бөгөөд согтууруулах ундааны зүйл их хэмжээгээр хэрэглэж биеэ хянах чадваргүй болох үед Л, Р нар нь мөн удирдлагад нь ажилладаг Э-г дуудаж гэрт хүргэхийг даалгасан. Энэ дагуу Э амь хохирогчийг гэрт нь хүргэсэн ч гэрт нь хүн байгаагүй. Мөн хохирогчид гэрийн түлхүүр нь байгаагүй тул Э машиндаа суулган сэргэхийг нь хүлээж байтал хохирогчийн амьсгалын зам нь ходоодны агууламжаар бөглөрч, механикаар амьсгал нь бүтэж нас барсан.

**Анхан шатны журмаар хэргийг шийдвэрлэсэн байдал:** Хэргийг хэрэгсэхгүй болгон шүүгдэгчдийг цагаатгахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “эргэлзээтэй тохиолдолд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг” үндэслэсэн.

**Давж заалдах журмаар хэргийн хянан шийдвэрлэх гол асуудал:** Шүүгдэгчдийн хувьд Эрүүгийн хуулийн (2015) 15.2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт гэм буруутай эсэх, гэм буруу нь тогтоогдоход ямар нэгэн эргэлзээ үүссэн эсэхийг шийдвэрлэх шаардлагатай болсон.

**Шүүхийн шийдэл ба үндэслэл:** Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх гэмт хэргийн объектив тал нь “бага насны хүүхэд, өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй, бэртэл гэмтэлтэй, өвчний улмаас бусдын туслалцаа, асрамж шаардлагатай хүний амь нас, эрүүл мэндэд аюул учирсан нөхцөлд хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны

<sup>13</sup> Иргэн Т-д холбогдох хэрэг (2011) [Монгол Улсын шүүхийн шийдвэрийн сан \(shuukh.mn\)](http://monkh.gov.mn/shuukh) [Сүүлд үзсэн: 2022.11.09]

<sup>14</sup> Иргэн Р,Л,Э нарт холбогдох хэрэг: [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан \(shuukh.mn\)](http://monkh.gov.mn/shuukh) [Сүүлд үзсэн: 2022.11.09]

хэм хэмжээний акт, хэлцэл, эсхүл харилцан итгэлцлээр хүлээсэн тусламж үзүүлэх, асран хамгаалах үүргээ зориуд биелүүлээгүй орхисны улмаас ... хохирогч нас барсан” байх талаар тодорхой зааж өгсөн. Амь хохирогчийн хувьд дээр дурдсан субъектэд хамаарахгүй буюу “..*архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсний улмаас хүчтэй согтож, өөрийнхөө төлөө анхаарал халамж тавих боломжгүй болсон хүмүүсийн амь нас, эрүүл мэндийг хууль тогтоогч тухайлан эрүүгийн хуулийн энэ зүйлд хамааруулаагүй байна*” гэж шүүхээс дүгнэсэн. Энэ нь нэг талаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг бүрэн хангасан байх ёстой гэх 2002 оны Эрүүгийн хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зарчмын шинжтэй зохицуулалт мэт боловч “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй” буюу *Nullum Crimen Sine Lege Stricta* зарчмын агуулгын хүрээнд хийгдсэн тайлбар гэж мөн дүгнэх боломжтой. Иймд Эрүүгийн хуулийн дээрх заалтыг хэрэглэхэд ямар нэгэн эргэлзээ төрөхгүй байх тул ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтлах ёсгүй гэж үзсэн.

### **ИБУИНХУ**

#### **Криттэндэнийн (Crittenden) эсрэг Партриджийн (Partridge) хэрэг (1968)**

**Шийдсэн шүүх:** Англи, Вельсийн Дээд шүүхийн дэргэдэх Хатан хааны Бенчийн шүүхийн Хэсгийн шүүх.

**Хэргийн үйл баримт:** Шүүгдэгч нь 1967 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр “шувуу сонирхогчдын” улирал тутмын сэтгүүлд Британийн “Брамблэфинч” гэх зүйлийн олон тооны шувуу болон дэгдээхийг нэг бүрийн 25 шиллингээр гэх зар тавьсан. Гэвч уг зард “худалдана” гэх ямар нэгэн үг ороогүй. Зарын дагуу нэгэн эр түүнд шуудангаар шувууг торлоод, хөлийг бөгжин хэлбэртэй түгжээгээр бэхлээд өөрт нь илгээ гэх захидлыг дугтуйлсан 30 шиллингийн хамт илгээсэн. Шүүгдэгч захидлыг уншаад ёсоор болгосон бөгөөд захидал илгээсэн эр шувууг ямар нэгэн гэмтэлгүйгээр тор болон түгжээнээс салган авчээ.

**Анхан шатны журмаар хэргийг шийдсэн байдал:** Улмаар Амьтанд хэрцгий хандхаас сэргийлэх эзэн хааны нийгэмлэгийг<sup>15</sup> төлөөлөн Криттэндэн шүүгдэгчийг Шувуу хамгаалах тухай 1954 оны хуулийн<sup>16</sup> 4 дүгээр бүлгийн 6 (1) дүгээр зүйлийг зөрчиж, торонд түгжиж тэжээх зориулалтгүй байгалийн зэрлэг шувууг “худалдахаар санал болгосон” гэм буруутай гэж үзэхэд Магистратын шүүх энэ зүйлчлэлийг зөвшөөрч шийдсэн. Шүүгдэгч үүнийг үл зөвшөөрч давж заалджээ.

**Хэрэглэгдэх хууль:** 6(1) -д Аливаа хүн торонд тэжээж гаршуулаагүй Британийн байгальд буй зэрлэг шувууг худалдсан, худалдахаар санал болгосон бол уг гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай гэж үзнэ.

**Тайлбар:** Брамблэфинч зүйлийн шувууг торонд тэжээж гаршуулж, хөлийг нь бөгжин түгжээгээр түгжиж дасгах замаар үржүүлсэн бол уг заалт хамаарахгүй.

**Давж заалдах журмаар хэргийг шийдвэрлэх гол асуудал:** Энэ нь сонинд тавьсан зар зэрлэг шувууг худалдахаар санал болгосон хэрэг мөн эсэх болон хөлнөөс нь бөгжин түгжээг салгах боломжтой бол шувууг гаршуулсан гэж үзэх эсэх тухай байсан юм.

**Шүүхийн шийдэл ба үндэслэл:** Шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан. Учир нь сэтгүүлд тавьсан зар нь аливаа этгээдийг гэрээнд оролцохыг урьж буй саналын дуудлага<sup>17</sup> болохоос санал биш гэж үзсэн<sup>18</sup>. Мөн шувууг ямар замаар үржүүлсэн болохыг шалган тогтоох боломжгүй байсан тул торонд тэжээж гаршуулж, хөлийг нь бөгжин түгжээгээр түгжих замаар үржүүлээгүй гэж нотлох боломжгүй гэж үзжээ.

Англи, Вельсийн Дээд шүүхийн дэргэдэх Хатан хааны Бенчийн шүүхийн Хэсгийн шүүх нь *Nullum crimen sine lege stricta* зарчмыг хэрэглэсэн буюу эрүүжүүлсэн үйлдлийг бичигдсэн явцуу утгаар нь тайлбарлаж, гэрээ байгуулах санал болон саналын дуудлагыг ялгасан нь өдгөө бүхий л улс орнуудын хуульд тусгагдсан өндөр ач холбогдолтой эрх зүйн зарчим болж үлдсэн.

<sup>15</sup> The Royal Society for the Prevention of Cruelty to Animals

<sup>16</sup> Protection of Birds Act 1954

<sup>17</sup> Иргэний хуулийн 195.4-ийг харах.

<sup>18</sup> E.Finch, S.Fafinski, Contract Law, 5th edition, (2017), p.7



## ДҮГНЭЛТ

*Nullum Crimen Sine Lege* зарчмын хэрэглээ манай улсын шүүхийн практикт идэвхтэй хэрэглэгдэж ирсэн бөгөөд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга батлагдах бүрийд тус зарчмууд ямар байдлаар хэрхэн өөрчлөгдөн хуульчлагдаж буйг нэг бүрчлэн дүгнэж, тодорхойлох нь хууль хэрэглээний чухал ач холбогдолтой юм. Тухайлбал “Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл” гэх зохицуулалт 2015 оны Эрүүгийн хуульд тусгагдаагүй байдаг. Тус зохицуулалтыг *Nullum Crimen Sine Lege* зарчмын аль дэд зарчимд хамаарах талаар эргэцүүлж үзвэл *Nullum Crimen Sine Lege Stricta* байх боломжтой. Учир нь тус дэд зарчим нь эрүүгийн хуульд тодорхой тусгагдсан гэмт хэргийг ямар нэгэн байдлаар өргөжүүлэхгүйгээр явцуу бичигдсэн байдлаар нь хэрэглэх тухай сургааль бөгөөд нэгэнт хуульчлагдсан тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүн нь бичигдсэн байдлаараа хангагдаж байж гэмээн хариуцлага хүлээнэ гэсэн агуулгатай байна. Өдгөө шүүхээс гэмт хэрэг зүйлчлэхдээ гэмт хэргийн бүрэлдэхүүнд тулгуурлаж байгааг шүүхийн практикаас бэлхэн харж болно. Үүнээс дүгнэвэл *Nullum Crimen Sine Lege Stricta* дэд зарчмыг хууль тогтоогч “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй” гэх агуулгаар бүрэн илэрхийлэх боломжтой гэж үзсэн тул аливаа давхардлыг хууль зүйн техникийн хувьд арилгах зорилгоор хасаж хуульчилсан байх боломжтой байна.

Манай улс, ОХУ зэрэг орнуудад “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй” гэх нэр томьёог ашиглаж байгаа бол БНФУ-д “Эрүүгийн хууль тогтоомжийг явцуу утгаар тайлбарлаж хэрэглэнэ” хэмээн *Nullum Crimen Sine Lege Stricta* зарчмыг бичигдсэн байдлаар нь шууд буулгажээ. Өдгөө манай улсын шүүхийн практикт бэхжин тогтсон хууль хэрэглээний төлөвшсөн байдлаас харвал дээрх дэд зарчмын агуулга нь олон хувилбараар илэрч, эдгээр нь цөм хүлээн зөвшөөрөгдөж байна.

Гэвч манай улсын хүн ам, үйлдэгдсэн хэргийн тоо, тэдгээрт хэрэглэсэн тус дэд зарчмын хэрэглээ харьцангуй цөөн тул дээр өгүүлж буй хууль тогтоомж, шүүхийн практикын талаарх дүгнэлт нь таамагласан шинжтэй. Иймээс гагцхүү шүүхийн практикт өнө удаан жил тогтвортойгоор бэхжиж, хэрэглэгдэж байж тус таамаглал батлагдах тул “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй” гэх зохицуулалтын агуулгын хүрээнд хууль хэрэглээнд түгээмэл хэрэглэгдэх бүхий л тохиолдлуудыг шүүхийн практикаар дамжуулан судлан тогтоож УДШ-ээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүргийнхээ хүрээнд тайлбар, зөвлөмж гаргах байдлаар хууль хэрэглээний хүрээнд уг зарчмын агуулгыг явцууруулж хүний эрхэд ноцтойгоор халдаж болзошгүй эрсдлээс сэргийлж болох юм. Нөгөөтээгүүр Эрүүгийн хууль өөрөө явцуу утгаар тайлбарлагдаж хэрэглэгдэх онцлогийг нь харгалзан зарчмын шинжтэй зохицуулалтын хувьд практикаар шалгагдаж, илэрсэн тодорхой байгаа хувилбаруудыг нэг бүрчлэн хуульчлах нь цаашид аливаа зөрчилдөөнтэй асуудал үүсэхээс сэргийлэх давуу талтай гэх саналыг судлаачийн зүгээс дэвшүүлж байна.

**ЭХ СУРВАЛЖ****I. Эрх зүйн эх сурвалж**

1. Эрүүгийн хууль (2002)
2. Эрүүгийн хууль (2015)
3. ХБНГУ-ын Эрүүгийн хууль (1998)
4. БНФУ-ын Эрүүгийн хууль (1992)
5. ОХУ-ын Эрүүгийн хууль (1996)

**II. Гадаад эх сурвалж**

1. K.S.Gallant, *The Principle of Legality in International and Comparative Law*, (2009), 2<sup>nd</sup> edition
2. Th.Rauter, *Judicial Practice, Customary International Criminal law and Nullum Crimen Sine Lege*, (2017)
3. Max Planck Institute for Comparative Public Law and International Law, *Max Planck Encyclopedia of Public International law*, (2010)
4. E.Finch, S.Fafinski, *Contract Law*, 5<sup>th</sup> edition, (2017)
5. J.Hall, *Nulla Poena Sine lege*, Volume 47 Yale Law Journal (1937)

**III. Шүүхийн шийдвэр**

1. 2011.05.25 – Дугаар 251 – УДШ-ийн тогтоол
2. 2022.01.28 – Дугаар 2022/ДШМ/08 – Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
3. Криттэндэнийн (Crittenden) эсрэг Партриджийн (Partridge) хэрэг (1968)

**NULLUM CRIMEN SINE LEGE AS ENSHRINED IN THE CRIMINAL CODE AND AS APPLIED BY THE COURTS: A COMPARISON**

*Batbayar B.*

*Researcher, Criminal law sector, Judicial Training, Research, and Information Institute under the Supreme Court of Mongolia*

**ABSTRACT:**

The article has studied the state of the Nullum Crimen Sine Lege maxim enshrined in the Criminal Codes of some countries, and for Common law countries, other legal sources such as Magna Carta, statutes, and judicial precedents. Furthermore, the application of the legal maxim in judicial practice has been presented by analyzing some cases of different legal families like Common law and Civil law.

**KEYWORDS:**

Principle of legality, Written law, Prohibition of retroactivity in criminal law, Criminal code is to be construed strictly, Legal certainty.

## **“МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЙЛБАР” НОМЫГ ТАНИЛЦУУЛАХ ӨДӨРЛӨГ БОЛЛОО**



Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын ажлыг хэсгийн гишүүд “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тайлбар” ном туурвиж, нийтийн хүртээл болголоо. Бүтээлийг танилцуулах өдөрлөг 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд боллоо.

Танилцуулах өдөрлөгийг нээж, Монгол Улсын Гавьяат хуульч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан, номын редактор Монгол Улсын Сайд, Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

Номын зохиогч болох нэгжийн хуулийн дэд ажлын хэсгийн ахлагч Д.Ганзориг, Улсын Бага Хурал, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн нар тус номыг гаргах болсон үндэслэл, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн үзэл баримтлал, цаашид түүнийг дагаж мөрдөхөд өөрчлөгдөх асуудлуудыг хөндөж, санал солилцлоо.

Номын танилцуулах өдөрлөгт номын зохиогч, Монгол Улсын Гавьяат хуульч Н.Лувсанжав, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, доктор Х.Эрдэм-Ундрах, Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор С.Сүхбаатар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар, хууль зүйн их, дээд сургуулиудын төлөөлөл, хуульч, судлаачид зэрэг хүндэт зочид, төлөөлөгчид оролцлоо.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ БАЙЦААГЧ, БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ, ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧ НАРЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хууль зүйн үндэсний хүрээлэн нь ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч, экологийн цагдаагийн алба хаагч нарыг байгаль орчны хууль, эрх зүйн чиглэлээр чадавхжуулах сургалт”-ыг 09 дүгээр сарын 30-ны өдөр Сэлэнгэ аймагт зохион байгууллаа.

Сургалтыг ХЗҮХ-ийн захирал Х.Эрдэм-Ундрах, Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Н.Феликс Гленк, Ханнс-Зайделийн сангийн Зүүн хойд болон төв Азийн хэлтсийн дарга Дебора Тидекс-Жоу, Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын орчуулга хариуцсан менежер Б.Үнэнбаяр нар нээж, үг хэллээ. Сургалтад Хууль зүйн ухааны доктор /PhD/, профессор Э.Батбаяр, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор А.Алтанзул, Ахлах багш С.Ганцэцэг, ХЗҮХ-ийн сургалт хариуцсан мэргэжилтэн П.Аззаяа нар хичээл заасан бөгөөд нийт 73 алба хаагч хамрагдсан байна.

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДАД “ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” СЭДВЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хууль зүйн үндэсний хүрээлэн нь “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сурагчдад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр цуврал сургалт зохион байгуулдаг. 2022 оны 09 дүгээр сард зохион байгуулсан сургалтад 25 дугаар тусгай сургуулийн ахлах ангийн 20 гаруй, Налайх дүүргийн 103, 119, 109, Эрдмийн оргил цогцолбор сургууль, Голомт цогцолбор сургуулийн ахлах ангийн 320 сурагчдыг хамрууллаа. Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн арга зүйч багш Д.Цэцэгдарь, сургалт хариуцсан мэргэжилтэн П.Аззаяа нар хичээл заав.

Сургалтаар:

- Зөв хандлага төлөвшүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /хулгай, дээрэм, танхайрах гэмт хэрэг, мансууруулах бодисын хор хөнөөл/-ийн ойлголт;
- Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэдвээр анхан шатны ойлголт, мэдээллийг тус тус хүргэлээ.



## ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ БЭЛТГЭХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагаас Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” (2019-2023) төслийн хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон Монголын Хуульчдын Холбоотой хамтран “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эрх зүйн туслалцаа үзүүлэх нь” сэдвээр төвийн бүсийн мэргэжилтэн бэлтгэх сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 18, 19, 20, 21-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгууллаа. Тус сургалтад Архангай, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн 53 эрх зүйн хөтөч хамрагдлаа.

Сургалтыг “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ” гарын авлагад суурилан мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх төслийн хүрээнд бэлтгэгдсэн сургагч багш нар болон төслийн зөвлөхүүд удирдаж явууллаа.

Сургалтад тус хүрээлэнгийн арга зүйч багш Цэцэгдарь эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), [www.e-khutuch.mn](http://www.e-khutuch.mn) цахим хуудасны талаар мэдээлэл өгч, Эрх зүйн хөтчийн сургалтын гарын авлага, “Малчин танд” гарын авлага, [www.e-khutuch.mn](http://www.e-khutuch.mn) цахим хуудасны танилцуулга, Хөдөлмөрийн тухай хуулийн нугалбар хуудас болон бусад сургалтын материалаар оролцогчдыг хангав.



## ЯПОН УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХАРЬЯА СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНТЭЙ ХАМТАРЧ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хууль зүйн үндэсний хүрээлэн Япон улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр “Өсвөр насны хүнд холбогдох эрүүгийн процессын ажиллагаа ба эрүүгийн хариуцлагын тогтолцоо: Япон ба Монгол Улсын харьцуулалт” сэдвээр эрдэм шинжилгээний семинар зохион байгуулав.

Тус семинарт Сургалт, судалгааны хүрээлэнгийн Олон улсын хамтын ажиллагааны газрын профессор Минако Шожи “Япон улсын өсвөр насны хүнд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба өсвөр насны хүнд оногдуулах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ” сэдвээр, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах “Монгол Улс дахь өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” сэдвээр, МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш Х.Болормаа “Монгол Улс дахь өсвөр насны сэжигтэн яллагдагч, шүүгдэгчид холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлээ.

Хэлэлцүүлэгт, талуудын төлөөлөл танхимаар оролцсоноос гадна Сургалт, судалгааны хүрээлэнгийн хамт олон, НҮБ-ын Ази, Алс Дорнодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээлэн (UNAFEI)-ийн албан хаагчид цахимаар оролцсон. Мөн Сургалт, судалгааны хүрээлэнгийн төлөөлөгчид тус хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцаж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцов.


## ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦЫН ТАЛААР ӨМГӨӨЛӨГЧ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцын талаар өмгөөлөгч нарт зориулсан сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр ХЗҮХ-ийн Хуульчдын танхимд зохион байгууллаа. Сургалтад ХЭҮК-ын гишүүн, Хууль зүйн ухааны доктор Д.Сүнжид, ХЭҮК-ын гишүүн, Хууль зүйн ухааны доктор Г.Нарантуяа нар хичээл заав.

Сургалтад нийт 40 өмгөөлөгч хамрагдсан бөгөөд уг сургалтад хамрагдсанаар өмгөөлөгч нар мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Олон Улсын холбогдох гэрээ, конвенцыг ашиглах үндэсний хууль тогтоомж дахь зохих зүйл заалт, зохицуулалтыг эдгээртэй уялдуулж хэрэглэх талаар зохих ойлголт, мэдлэгтэй болох юм.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хууль зүйн үндэсний хүрээлэн нь ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Байгаль орчны хууль, эрх зүйн чиглэлээр эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалт”-ыг Сэлэнгэ аймагт 09 дүгээр сарын 29-ний өдөр, Өвөрхангай аймагт 11 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад Хууль зүйн ухааны доктор /PhD/, профессор Э.Батбаяр, Хууль зүйн ухааны доктор /PhD/, дэд профессор А.Алтанзул, Ахлах багш С.Ганцэцэг, ХЗҮХ-ийн сургалт хариуцсан мэргэжилтэн П.Азаяа нар хичээл заасан бөгөөд Сэлэнгэ аймагт 45, Өвөрхангай аймагт 50 эрх зүйн хөтөч хамрагдсан байна.

Мөн цахимаар 11 дүгээр сарын 23 болон 12 дүгээр сарын 07-ны өдөр өдөр зохион байгууллаа. Тус сургалтад Хууль зүйн ухааны доктор профессор Э.Батбаяр, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор А.Алтанзул, Ахлах багш С.Ганцэцэг, ХЗҮХ-ийн Арга зүйч багш Д.Цэцэгдарь нар хичээл заасан ба Нийслэлийн 122, Баянхонгор аймгийн 100 эрх зүйн хөтөч хамрагдсан байна.

Хууль зүйн ухааны доктор /PhD/, профессор Э.Батбаяр, Хууль зүйн ухааны доктор /PhD/, дэд профессор А.Алтанзул, Ахлах багш С.Ганцэцэг, ХЗҮХ-ийн сургалт хариуцсан мэргэжилтэн П.Азаяа нар Хөвсгөл аймагт “Байгаль орчны хууль, эрх зүйн чиглэлээр эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалт”-ыг 12 дүгээр сарын 13-ны өдөр тус тус зохион байгууллаа. Сургалтад Хөвсгөл аймгийн 50 эрх зүйн хөтөч хамрагдсан байна.

## ХУУЛЬ ЗҮЙН АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТЫГ 10 ДАХЬ ЖИЛДЭЭ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хууль зүйн үндэсний хүрээлэн хуульчдад хууль зүйн англи хэлний бичгийн болон бусад чадвараа хөгжүүлэхэд нь түлхэц үзүүлэх, арга барилаа олоход нь чиглэл өгөх зорилгоор 2012 оноос эхлэн Хууль зүйн англи хэлний сургалтыг зохион байгуулж байна. Энэ удаагийн сургалтыг 2022 оны 11-р сарын 1-нээс 29-ний өдрийг дуустал зохион байгуулсан ба 42 хүн хамрагдаж, хууль зүйн бичлэг (Legal writing)-ийн хэв маяг, арга техникийн үндсэн ойлголтыг авч, англи хэлний хууль зүйн нэр томъёоны хэрэглээ, орчуулах арга зүйд суралцлаа.

ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор С.Сүхбаатар, МУИС-ийн ХЗС-ийн багш, Э.Туулайхүү нар тус сургалтын багшаар ажиллаж, Хууль зүйн англи хэлний онцлог, хууль зүйн орчуулга хийх техникүүд, Хууль, гэрээ зэрэг эрх зүйн албан ёсны баримт бичиг болон эрх зүйн бусад бичвэр орчуулах арга зүй, Гэрээний эрх зүй, Компанийн эрх зүй, Олон улсын худалдааны эрх зүй, Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй, Маргаан шийдвэрлэх, Өмчийн дүрэм, Хариуцлагын дүрэм зэрэг сэдвээр эрчимжүүлсэн сургалт явуулав.

2022 оны 11 сарын 29-ний өдөр тус сургалтад амжилттай хамрагдсан суралцагчдад СЕРТИФИКАТ гардууллаа.



**“ХУУЛЬЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ-2022” БОЛЛОО**

“Ди Би энд Жи Ти Эс” ХХН-ийн санаачлагаар хуульч, эрх зүйчдийг ажлын байранд зуучлах, хууль эрх зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг танилцуулах зорилготой “Хуульчийн ажлын байрны үзэсгэлэн яармаг-2022” 2022 оны 12-р сарын 02-ны өдөр зохион байгуулагдлаа. Тус үзэсгэлэн яармагт 20 гаруй байгууллага оролцож, үйл ажиллагаагаа танилцуулахын зэрэгцээ ажлын байрны онцлог, тавигдах шаардлагын талаар хуулийн сургуулийн төгсөх ангийн оюутнууд болон эрх зүйч, хуульч, өмгөөлөгчдөд мэдээлэл өгчээ.

“Хуульчийн ажлын байрны үзэсгэлэн яармаг-2022”-т Хууль зүйн үндэсний хүрээлэн оролцож нээлттэй зарлагдсан ажлын байр болон тухайн ажлын байранд тавигдах шаардлагын талаар оролцогчдод мэдээлэл өглөө.

Энэхүү үзэсгэлэн яармагийн хамтран зохион байгуулагчаар Монголын Хуульчдын холбоо ажилласан байна.

## “ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХААЛТЫН АРГА ХЭМЖЭЭ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 2012-2022 онд хэрэгжүүлсэн “Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр”-ийн хаалтын арга хэмжээ болж үр дүнгийн хэлэлцүүлэг хийлээ. Хөтөлбөрийн хүрээнд **Хотын засаглалыг сайжруулах, Төвлөрлийг сааруулах, Иргэдийн оролцоог хангах** гэсэн үндсэн 3 чиглэлд анхаарч төсөл хэрэгжүүлсэн.

Төслийн хаалтын үйл ажиллагааны үеэр салбар төслүүд өөрсдийн үйл ажиллагааны үр дүнг танилцуулж, сургамж, туршлагаа хуваалцаж, цаашид үр дүнгийн тогтвортой байдлыг хэрхэн хангах талаар хэлэлцлээ.

Уг хөтөлбөрийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран “Иргэдийн оролцоо” төслийг 2015-2022 оны хугацаанд хэрэгжүүлж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэн тус хөтөлбөрийн хүрээнд “Иргэдийн оролцоо” төсөлтэй хамтран хэрэгжүүлсэн ажил, эрхлэн гаргасан ном гарын авлагын тайлан зэргийг дэлгэн танилцууллаа.



## ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ БҮТЭЭЛ, ИЛТГЭЛ, ГРАНТ ОЛГОХ ТӨСЛИЙН УРАЛДААНЫ ШИЛДГҮҮДЭД ШАГНАЛ ГАРДУУЛЛАА



Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит эрдэм шинжилгээний шилдэг бүтээл, илтгэл, грант олгох төслийн уралдааны шилдгүүдэд шагнал гардуулах ёслол өнөөдөр боллоо. Тус уралдааныг Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар 2021 оноос зохион байгуулж эхэлсэн бөгөөд Хууль зүйн үндэсний хүрээлэн, Дотоод хэргийн их сургууль хамтран ажиллав.

Шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаанд Монгол Улсын Их Хурал, Засгийн Газрын гишүүн, ХЗДХ-ийн сайд Х.Нямбаатар, ХЗДХ-ийн сайдын зөвлөх, Монгол Улсын Төрийн соёрхолт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хууль зүйн шинжлэх ухааны доктор, академич, МУИС-ийн эмерит профессор, С.Нарангэрэл, ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, ХЗДХЯ-ны газар, хэлтсийн дарга нар, уралдааныг зохион байгуулагч ДХИС, ХЗҮХ-ийн удирдлага, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн, судлаач, сонсогч, оюутнууд оролцлоо.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар уралдааны шагнал гардуулах ёслолын арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Хууль зүйн шинжлэх ухаан, аюулгүй байдал, хууль зүй, дотоод хэргийн салбарын эрдэм шинжилгээ, инновацыг хөгжүүлэх, онол, практикт тулгамдсан асуудлыг судалгаанд үндэслэн оновчтой, үр дүнтэй шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2021 онд энэхүү уралдааныг зохион байгуулж эхэлсэн. Уралдаанд ирүүлж байгаа судалгааны бүтээлүүд салбарын цаашдын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна гэж найдаж байна” хэмээв.

Тус уралдаанд шилдэг бүтээлийн төрөлд 25, шилдэг илтгэлийн төрөлд 75, грант олгох төсөлд 32, нийт 132 бүтээл ирүүлснээс шилдгүүдээ тодруулсан байна.

### **ШИЛДЭГ БҮТЭЭЛ**

**1 дүгээр байр:** ДХИС-ийн Удирдлагын академийн доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Д.Булган, Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч Б.Хулан нарын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил” нэг сэдэвт бүтээл

**2 дугаар байр:** МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш Д.Ганхүрэл, С.Батбаяр, Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар, доктор Б.Амарсанаа, Г.Давааням нарын “**Арилжааны эрх зүй**” сурах бичиг

**3 дугаар байр:** ДХИС-ийн Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн эрхлэгч, доктор, дэд хурандаа Б.Энхтүвшин нарын “**Гал түймэр унтраах үйл ажиллагааны удирдлага**” сурах бичиг

**Тусгай байр:** Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор, профессор Ц.Ганболд, Д.Нямдорж нарын “**Хил судлал**” нэг сэдэвт бүтээл

Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк их сургуулийн докторант Д.Түмэндэлгэрийн “**Монгол Улсын соёлын өв (палентологийн олдвор)-ыг хамгаалах эрх зүйн зохицуулалт**” сэдэвт импакт фактор бүхий сэтгүүлд нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл

Б.Буянтер, Э.Болормаа, Д.Энх-Амгалан, Б.Жавхланцогт, Ч.Наранмөнх, Б.Батхуяг /Цагдаагийн ерөнхий газрын Гэрч хохирогчийг хамгаалах хэлтэс/ нарын “**Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтот бүлэгт чиглэсэн гарын авлага**” сургалтын гарын авлага



### **ШИЛДЭГ ИЛТГЭЛ**

**1 дүгээр байр:** МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5 дугаар түвшний оюутан Т.Лхагважаргалын “**Үндсэн хуулийн үзэл баримтлал дахь хуваарилалтын шударга ёс: Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар**”

**2 дугаар байр:** МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5 дугаар түвшний оюутан Б.Ариунзаяагийн “**Үндсэн хуулийн Цэцийн тогтоол болон Улсын Дээд шүүхийн тайлбарын зөрчилдөөн: Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолох журмын мөн чанар**”

**3 дугаар байр:** МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5 дугаар түвшний оюутан М.Аминагийн “**Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотойгоор гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох зохицуулалтын тулгамдсан асуудал**”

**Тусгай байр:** ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн 2 дугаар дамжааны оюутан С.Энхням, 4 дүгээр дамжааны оюутан Б.Солонго нарын “**Эрх**”

зүйн ухамсрыг тодорхойлох замаар хуулийн хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх нь”

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5 дугаар түвшний оюутан З.Янжиндуламын “**Органик хуулийг Үндсэн хуулиар тусгайлан зохицуулах хэрэгцээ, шаардлага**”

Хууль зүйн сургуулийн 5 дугаар түвшний оюутан Б.Билгүүний “**Ne bis idem зарчим ба Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт, хэрэгжилт**”


### **ГРАНТ ОЛГОХ ТӨСӨЛ**

**Суурь судалгааны төсөл:** ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Б.Мөнхдоржийн “**Хууль зүйн статистикийн онол, арга зүй, хэрэглээ**”

**Хавсарга судалгааны төсөл:** ДХИС-ийн Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн эрхлэгч, доктор, дэд хурандаа Б.Энхтүвшингийн “**Монгол Улсын гэмт хэргийн эрсдэлийг тодорхойлох математик загвар**”

**Инновацийн төсөл:** ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Инновацийн төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хурандаа Б.Зулбадрахын “**Сумны хонгиог дахин цэнэглэх аргаар сум үйлдвэрлэх, үйлдвэрлэсэн сумыг буудлагын сургалтад ашиглах**”

## ШИНЭ НОМЫН МЭДЭЭ



### **Хуульчийн мэргэжлийн шалгалтын жишиг сорилгын хураамж. УБ., 2022 /Монголын хуульчдын холбоо/**

Хууль зүйн салбарт ажиллахаар сонголтоо хийж, хуульчийн шалгалтад бэлтгэж буй хүн бүрт зориулан Монголын Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооноос “Хуульчийн мэргэжлийн шалгалтын жишиг сорилгын хураамж” номыг 2022 оны зургадугаар сарын 01-ний байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын хуулиудын хүрээнд боловсруулан, хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцогчийн эрх зүйн ерөнхий мэдлэг, ур чадварыг сорих агуулгыг багтаан шинэчлэн хэвлүүлжээ.



### **Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтот бүлэгт чиглэсэн гарын авлага. УБ., 2022 /Цагдаагийн ерөнхий газар, Гэрч хохирогчийг хамгаалах хэлтэс/**

Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг зохицуулсан хуулиуд, Засгийн газрын 2015 оны 346 дугаар тушаалаар батлагдсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 5.1.3-т гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх зорилгоор шаардлагатай журам, зааврыг шинээр боловсруулан баталж, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор тусгай стандарт, маягт, сургалтын модуль, хөтөлбөр боловсруулж

нэвтрүүлэх... ажлын гүйцэтгэлийг хангах хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/250 тоот тушаалаар Дотоод хэргийн их сургуультай хамтран Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтот бүлэгт чиглэсэн мэдлэг, хандлага, дадлын үнэлгээ, зохион байгуулах сургалтын модуль, хөтөлбөр боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулан ХЗДХЯ-ны дэмжлэгтэйгээр энэхүү сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэвлүүлжээ.